

Б.Шүүгэрцэцэг

ᠪᠤᠰᠢᠭᠦᠷᠴᠡᠴᠡᠭ



ДОМОТТ АНУ ХАТАН  
ТҮҮХЭН РОМАН

**Б.Шүүдэрцэцэг**

**Домогт Ану хатан**

*Зуун зууны турш исгэрэн үлээсэн монгол нутгийн хөх салхинд Зуун модны шаргал элс бидэртэн, их ойгоосоо тасран ургасан хэдхэн шинэс модод намуухан шуугих нь харийн дайсантай амь үл хайрлан тулалдахын билгэдэл арван хоёр салаа эвэрт бугын баг мориндоо зүүн манжийн цэрэгтэй байлдаж яваад энд насан эцэслэсэн Ану хатны домгийг хүүрнэх мэт...*

*Эдүгээгээс гурван зуун арван дөрвөн жилийн өмнө, арванхоёрдугаар жарны баригч хэмээх эр гал хулгана жил буюу аргын тооллоор 1696 онд Тэрэлжийн Зуун модонд Монголын тусгаар тогтнолын төлөө Манжийн эсрэг хүч тэнцвэргүй тулаанд эрэлхэгээр амь эрсэдсэн, хайр сэтгэлдээ үнэнч, халуун эх оронч монгол бүсгүй Ану хатны домог оршивой.*

## Нэгдүгээр бүлэг

Арваннэгдүгээр жарны тийн ялгуусан хэмээгч харагчин усан могой жилийн хаврын адаг сар. “Эрдэнэ Баатар хунтайж тэнгэр болжээ” гэсэн сураг Ойрадын уудам нутгийн уул, талаар харвах сум мэт агшин зуур тархан түглээ. \Энэ нь аргын 1653 он бөлгөө\

Алшаа дахь Хошуудын Очирт цэцэн ханы өргөө хөл үймээн ихтэй байлаа. Хаврын адаг сар гарч ногоо нүдлэн яргуй цухуйсан дэлгэр сайхан цаг. Уул тал ялдамхнаар ногоорон хавар авхай үзэсгэлэнт ногоон нөмрөг нөмөрсөн залуу гоо бүсгүй мишээх мэт, гол горхины хоржигнох, нялх төлийн майлалдах дуунд хорвоо дэлхий бүхэлдээ уяран байлаа. Олон сараар есөн ес наян нэгэн хоног үргэлжилдэг төв Азийн хахир хатуу өвлийг мал нь цас малтаж борог өвс олж идэн, элчилгүй уудам нутагт цөөн цөөн гэрээр өвөлжин бардаг нүүдэлчин монголчуудын хувьд хавартай энх золгоно гэдэг амьдралын төлөөх хүнд хүчир нэгэн тулаанд ялсантай адил хэрэг юм. Нутаг хошуу алгасан яргуй амталсан гөрөөсний авд гарахаар эрчүүд нь сайн морио хантайран, зэр зэвсгээ хангир жингэр хийлгэн, эхнэр хүүхнүүд авд мордогсдын аяганы хийц бэлтгэн зав чөлөөгүй хөлхөлдөн байх цагаар Баатар хунтайжийн өргөөнөөс зарсан элч эл мэдээг дуулгаар давхин ирж билээ.

Аяны хөнгөн хуяг агсаад бичгийн гэрээсээ гарч явсан Очирт цэцэн хан Эрдэнэ баатар хунтайжийн элч Галсангааг хайвга хайвга хийсэн шалмаг алхаагаар нь холоос таниад өтгөн хөмсөг атируулан зогсосхийснээ ёслолын өргөө тийшээгээ алхлаа.

Нас сүүдэр тавь гарч яваа Очирт цэцэн хан бичгийн гэрээсээ ёслолын өргөө хүртэлх дөчин алхмын газар “За байз.Элчийн байдал төрх, царай зүс нь аяншин зүдэрсэн, баргар буйг үзэхүл яавч сайн мэдээ авчраагүй болов уу. Баатар хунтайжийн өргөөнөөс эл хүртэлх хэдэн өдөрчийн газар үзвээс зогсолтгүй довтолгох элч зарсныг бодохул муугаар ёрловол дөрвөн Ойрадын чуулганы тэргүүн Эрдэнэ баатар хунтайж таалал болоогүй байгаа даа...” хэмээн бодож амжлаа.

“Хорвоогийн амьдрал мөнх бус.Хүн нэгэн өдөр эхийн хэвлийгээс өтөг бууцан дээр чарлан унаад, нөгөө нэгэн өдөр зэвг суманд харвуулах буюу үйлт өвчинд ээрэгдэх, аль эсхүл өтөл насны жамаар дээр гэрэлтэгч наран, доор хөхрөгч газрыг орхин одох буй за.” Шадар хиа Цанжид нь түүнд хоёр хавтаст улаан модон хаалгыг нээж өгөх тэрхэн агшинд ийм бодол харван орж иржээ.

-Элчийг оруул!

-Жаа.

-Эрхэм дээд Очирт цэцэн хан та амар амгалан морилж байна уу?

-Амгалаан.Чи замдаа сайн явж ирэв үү?

-Жаа,дээдсийн өршөөлөөр замдаа сааталгүй сайн явж ирлээ.Таны таалалд Цэцэн тайжаас илгээсэн захидал...

Очирт цэцэн хан алтан зүмбэрт мэлхий ширээний цаанаас Галсангаагийн хоёр гардан сарвайсан захидлыг авахдаа “Цэцэн тайжаас...” гэнгүүт нь өөрийнхөө таамаг оносныг мэдэрч зүрх нь эвгүйхэн ёгхийлээ. Эрдэнэ баатар хунтайж анд нь байхад Цэцэн тайж хүүгээс нь түүнд хандан бичих ёсгүй хэрэг билээ.

Эрдэнэбаатар хунтайжийн өөрийн гараар мутарласан таталган бичгийн хэвийг тэр дэндүү сайн мэдэх учир тод үсгийн ацаг шүд нь гаргац сайтай боловч хайнгадуухан үл таних бичгийн хэвийг анзааран хяламхийгээд муутуу цаасан дугтуйг нээлээ.

“Миний эцэг Дөрвөн Ойрадын чуулганы тэргүүн Эрдэнэ Баатар хунтайж могой жилийн хаврын адаг сарын нохой өдрийн морин цагт тэнгэр болсныг Хошуудын Очирт цэцэн хан андад ину дуулган айлтгахын учир элч илгээмой...”

-Тийм байдаг байж. Ум ма ни бад мэ хум. Эрдэнэ баатар хунтайж сайн төрөл олох болтугай! Танай өргөөний хэргийг өдгөө хэн ахалж байна? гэж түүнийг асуухад айргийн тос самарсан өтгөн сайхан цайнд самнаа боов хөшиглөөд хөлс асгаруулан оочилж суусан элч давхийснээ:

-Эзний минь сүнсийг хөх тэнгэр өршөөг! Цэцэн тайж хойдхи ажлыг толгой мэдэн гүйцэлдүүлж байна даа, дээдэс минь гэлээ.

“Хөх тэнгэр халх Ойрадын ноёдод халтай байх чинь.Өнгөрсөн жилийн өдийд Сэцэн хан Шолой үл мэдэгдэх суулга өвчнөөр таалал болж, хойдын буяныг нь хурааж гүйцээгүй шахам байхад Халх Ойрадын эв эеийн төлөө цохилох зүрхтэй явсан Засагт хан Сувдаа мориноос унаад ухаан оролгүй байсаар бүрлээч болсон. Одоо баатар хунтайж тэнгэрт хальж Дөрвөн Ойрадын чуулганы нэгэн тэргүүний ор онгойж үлдэх нь. Дөчин ес хоног буян хураасны хойно Ойрадын ноёдын чуулган зарлах буй заа...” хэмээн агшин зуур элдвийг эргэцүүлэн цэгнэж амжаад олон жил Баатар хунтайжийн хэл болж нааш цааш давхисан үнэнч барлаг Галсангаагийн уй гашуу, аяны тоос шороонд дарагдсан хүрэн царай руу хяламхийх зуур харц нь эгшнээ зөөлөрч, алтан луу ороосон мөнгөн хонхоо авч жингэнүүлэн хиагаа дуудаад:

-Элчид хонь гарган шүүс барь гэж тэргүүн замд айлтга хэмээгээд өндийтөл нь хоргой дээлийн хормойн шүрчигнэх, зүүлт чимэглэлийн бяцхан жингэнэх чимээ гарч эсгий үүд сөхөгдөн дунд хатан Доржравдан нь орж ирэхэд гарахаа больж зүүн хөмсгөө өргөсхийлээ. Тэрбээр ямар нэгэн юманд эргэлзэх, тодорхойгүй байдалд орохдоо ийнхүү зүүн хөмсгөө өргөдөг зуршилтай ажээ.

Элч ч ханд мэхэсхийгээд араараа ухарсаар гарч одов.

-Би танд үнхэлцэгт хонины борц хийж тавьсан. Халхаас авчирсан сайхан борц үлдээсэн байсан юм аа.Хантан та юун баргар чилүүр царайтай байхын?Авд мордохоо хойшлууллаа гэж үнэн үү? хэмээн эрхлэнгүй дуугараад цэнхэр хоргой цэгдэгний задгай энгэрийг түрэн цондойх их гэдсээ хоёр гараараа энхрийлэн тэврэх мэт хөдлөв.

-Борцоо хадгал даа.Хэрэг болуужин.Бие лагшин тунгалаг уу?

-Миний бие сайн. Эрдэнэ баатар хунтайжийн элч Галсангаа ямар мэдээ авчраав?Таны наад

царай?

-Баатар хунтайж тэнгэрт хальжээ.

-Ээ хөх тэнгэр! Ум ма ни бад мэ хум...

-Бие тулгар чи минь ингэж өргөө хооронд яваад юуны хэрэг! Хэвлий дэх үрээ бодоод өргөөндөө тавтай морилно уу даа хө. Өнгөрсөн жилийн бага хатных шиг осолтой явдал болуужин .Би Баатар хунтайжийн хойдын буяны хэргээр өнөөдөртөө багтан өргөө рүү нь мордох байх. Чиний хөнгөрөх хугацаа хэдийгээр билээ?

-Болоогүй ээ. Зуны дунд сард л болов уу. Тэр үеэр та минь өргөөндөө морилж байна биз дээ? гэж хатан эрхлэнгүй хэлэхдээ эгээтэй л хошуу цорволзуулсангүй. Ижил мөрний тэртээх торгууд угсааны Доржравдан бүсгүй Очирт цэцэн ханы хоёр дахь хатан билээ. Нас сүүдэр гуч хол гарсан ч хасын цагаахан царайны нь гоо үзэсгэлэн өчүүхэн ч гандаагүй, нүд хөмсөг нь хоорондоо ойрхон зурагсан, өндөрдүүхэн тэгш хамартай, хацар нь сүү мэт булбарай өнгөлөг хэвээр буй энэ хатандаа хантан хамгийн хайртай ажгуу.

-Цагийн байдлыг харзая. Чамайгаа хөнгөрөхөд хажууд

тань байхыг бодолгүй яахав дээ.

-Би өнөө шөнө дахиад л тэнгэрийн солонгоноос нэгэн бяцхан үр тасран хэвлийд минь орж байна хэмээн зүүдэллээ. Лавтай Галдмаа шиг мянган тохой зайд алдалгүй харвадаг эрхий мэргэн, ид хавт баатар хөвгүүн мэндлэх буй за. Хантан та юу гэж бодно?

-Дандаа л солонго зүүдлээд байгаа нь сайны билэг болов уу? Миний хувьд хүү, охин алин боловч ялгаа юун. Тавь шүргэх насанд минь хөх тэнгэрээс үр хайрлаж байгаа нь юутай сайхан гэж бодох юм. Гагцхүү цаг төр тайван байгаасай л хэмээн сэтгэл чилүүрдэнэ. Орчлонгийн уудамд хүмүүний амьдрал ялааны нас мэт юутай охорхон гэдгийг андын үхлээр улам ухаан бодож сууна даа.

Ханы зүүн эгмийг нь налан сууж асан хатан эл үгэнд цочин амгалан мишээсэн царайд нь сүүдэр бууж:

-Та юу айлднав? Баатар хунтайж тэнгэрт хальснаар Ойрад халхын хооронд эв эвдрэлцэн дайн тулаан гарах юм биш биз дээ?

Нас биед хүрч яваа хүүтэй эх хүний хувьд ч, эр нөхрөө энх тунх байгаасай хэмээн сүслэн залбирагч эхнэр хатан хүний хувьд ч алив нэгэн дайн тулаан болох вий, тэр дайны хөлд хайртай эрхэм хүмүүсээ эгнэгт алдах вий гэсэн мөнхийн айдас сэтгэлд нь хургаатай байдаг монгол бүсгүйн ёсоор хатны зүрх түгшин эрийнхээ царай руу харахдаа “Үгүй ээ, тийм юм болохгүй. Халх, Зүүнгар түмэн гар газар, хөл хөсөр байх болноо” хэмээсэн үг хүлээж байлаа.

Хатныхаа шанхны сувдан чимэг зүүлтийг оролдонгоо гүн бодолд орж, өтгөн хар хөмсгөө зангидан суусан хан шүүрс алдаад:

-Бие тулгар чи минь сэтгэлээ бүү чилээгтүн. Одоо өргөөндөө морилбол зүй. Эх нь сэтгэл чилүүр байх юм бол хэвлий дэх үр тань мөн тайван бус байх болно. Отгон үрийг минь эсэн энх төрүүлэхээ хичээ дээ гээд шанхны үсийг нь зөөлхөн илбэлээ. Энэ хариултаас бүсгүй өөрийнхөө хүсэн хүлээсэн үгийг сонсч чадсангүй. Энэ нь цаашдын өдөр халх, Ойрадын хооронд юу болохыг хар толгойтон хэн ч өдгөө хэлж үл чадна гэсэн үг гэдгийг хатан ойлгоод сэтгэлийн түгшүүрийг инээмсэглэлээрээ хаацалж сурснаараа жижигхэн хар нүдээрээ исгэх мэт шилбүүрдсэнээ аяндаа харц нь тунаран зөөлөрч:

-Та отгон гэдгийг нь хэрхэн мэдээ вэ? Та бас л идэр чийраг хэвээрээ л байна бус уу?Таны залуу хатан Нуранд тань удахгүй үр заяах ч юм бил үү?

-Мэдэж байнаа. Үрсийн минь отгоныг чи л төрүүлэх юм шиг бодогдоод байна. Хавь ойрд бага хатны өргөөнд морилохгүй байгааг чи мэднэ шүү дээ хэмээн аргадав. Хатан энэ дулаан үгэнд нь баярлан хоромхоноо хацарт нь ягаан туяа татаж танан шүд яралзуулан инээвхийлээд:

-Та аян замдаа сайн яваад үтэр түргэн харьж ирээрэй! Юм-Агас хатанд миний халуун сэтгэлийн мэндийг дамжуулаад сэтгэлийг нь сэргээх сайхан үг хэлээрэй! Эрээ алдаад хөөрхий хэчнээн хэцүү байгаа бол доо?

-Тэгнээ. Хунтайжийн өргөөнд ч юм юм болж л байгаа болов уу даа гээд зүүн хөмсгөө өргөснөө хатныхаа зүүн хацар дээр үнсэхдээ бодол нь хэдийнээ алсад одсон байлаа. Долоон сартай хөл хүнд хатан шивэгчнээ дагуулан гарахдаа зүрх нь юунд ч юм түгшин хөндүүрлэсээр буйг мэдэрлээ. Ер нь ч тэгээд эр нөхрөө иймэрхүү бодолд дарагдсан, өөрийнх нь ухаж ойлгоход түвэгтэй, ээдрээт үйл явдлыг тунгааж эр хүний ертөнцдөө байх ахуйд хатад хүүхнүүд холхон одох нь дээр гэдгийг тэр мэдэхийн цаагуур мэдэх билээ. Нэн ялангуяа сар жилийн уртад нөхөрлөсөн андыгаа алдах шиг хүнд гарз эр хүнд үгүй. Эрдэнэ баатар хунтайж үгүй болно гэдэг бол дөрвөн Ойрадын хувь тавиланг нуруундаа үүрч асан хос баганын нэг нь үгүй болов гэсэн үг. Мөнх бусын орчлонд анд нөхрийн онгойсон хоосон орыг хэн ч үл нөхнө. Анд нөхрөөсөө хагацна гэдэг гагцхүү эрчүүдэд л тохиолддог хүнд зовлон. Үүнийг бүсгүй хүн төгс ухаж ойлгоход түвэгтэй. Учир нь бүсгүй хүн эцгийн голомтонд төрж, харийн голомтонд бэрлэн очоод, үр хүүхэд төрүүлэн эрээ халамжилсаар үеийн үед насаа элээж ирснээс бус эр хүн шиг нэг зорилгын төлөө санаа сэтгэл нийлэн зүтгэж, хэрэгтэй цаг дор нэгийнхээ өмнөөс амиа ч өргөж чадах үнэнч анд бололцож ирсэнгүй. Ертөнцийн жам ийм ажгуу.

Гэвчиг бүсгүйчүүдэд ч бас эр хүн хэзээ ч үл тайлах далдын далд нууц олон буй. Тэр нь зөн билгийн нүд болой. Хэвлийдээ буй үрээ анирдан, амь орж тийчлэхийг нь мэдрэхийн гайхамшгийг бурхан гагцхүү бүсгүй хүнд заяасантайгаа ижилхэн амраг хань, алаг үрдээ тохиосон гамшгийн чимээг жигүүртэн цуцах алсаас ч анирдан мэдэх зөн билгийн нүд эм хүнд л буй. Тэртээ хэдэн жилийн өмнө Очир цэцэн ханыг хасагийн хантай тулалдахаар одоход эрүүл энх эргэн ирнэ гэдгийг түүнд тэр л зөн билэг нь хэлээд байж билээ. Гэвчиг эр нөхрөө, гар нь ганзаганд хөл нь дөрөөнд хүрсэн хүүгээ аян дайн,алсын замд үднэ гэдэг хүсмээр ч юм биш.

Эр нөхрөө аян зам, ав хоморго, алалдах тулааны алинд ч үдэж мордуулах нь эхнэр, хатдад ямагт сэтгэл дэнсэлсэн мөч байдаг агаад эрүүл эсэн эргэж ирэхийг нь хүртэл өдөртөө хараа чилтэл алсын зам харуулдан, үдэш нь морин туурайн газар бөмбөрдөх чимээг анирдан

хүлээдэг билээ. “Хантан минь түргэн эргэж ирээсэй билээ “ хэмээн тэр бодсоор өргөөнийхөө зүг аажуухан алхалж байлаа.

\* \* \*

Очирт цэцэг хан Алшаагийн их говийг туулан наснаас нөхцсөн андынхаа орд өргөөнд ойртон ирэвэй. Хэдэн өдөрчийн зайтай алс газар Ховог сайрын тийш нутаглаж буй Баатар хунтайжийн өргөөний бараа алсад бараантан үзэгдэхэд үсээ задалсан хатад эмсийн охилог уйлах, хорвоогийн мөнх бусыг үзсэн андын хоосон ор онгойн угтах, олон хатдаас төрсөн хөвгүүдийнх нь эцгийн суудал булаалдан тэмцэлдэх зэргийг үзэхээс зүрхшин ухаан бодлоо эмхлэхээр заваа залам намируулсан овоо индэртэй онь хөтөл дээр хэсэгхэн зуур саатав.

Таван өнгийн бөс залам намируулсан овооны дэргэд завилан сууж, алсад униартах хөндлөн хөх уулсын бэлд буй андынхаа орд өргөөг хараачлан ширтэхдээ “Тэнгэрт одсон хунтайжийн арван нэгэн хөвгүүнээс Лхаст шавилан сууж, номд нэвтрэн гэгээрэхээр одсон Галдан хүүгээс бусад нь л хан ор суухын тулд тэмцэлдэх вий. Ахмад хөвүүн Цэцэн тайж надаас дэмжлэг гуйваас хэрхэх нь зөв бол доо? Дүү Зодов тайж нь хаа очиж эцгийн суудлыг булаалдахгүй нь лав. Зодов бол Цэцэнгийнхээ сүүдэр нь л гэсэн үг. Ядахнаа миний дүү Аблайг бодохноо хэн гэдгээ мэддэг нь яамай. Гэвч тэр хоёрын ард төрүүлсэн нуган үрээ хан ор суулгахыг л үзвэл амьдын жаргал хэмээн тус бүрдээ мэрийх таван хатан буй... Дарь-Увсалжийн хоёр хөвүүн Сэнгэтэй ор булаалдахааргүй балчир байгаа нь бас аз. Анд минь тэр таван хатнаас Шүхэр дайчины охин

Юм-Агаст хамгаас илүү хайртай байсан даа. Юм-Агасаас төрсөн хоёр хөвгүүний ууган Сэнгэ л хунтайжийн орыг залгах учиртай.. Өдгөө би Сэнгийг хан ор суухад хамжваас хожмоо хүчин мөхөсдөх цаг дор дүү Аблай тайш дахин надад дайсагнавал миний найдвартай хамжаа болох юм сан. Цоросынхон болоод манай хошууд угсааныхан хэзээний худ ургийн барилдлагатай явж ирсэн. Хэрэв би өнөөдөр насанд хүрсэн охинтойсон бол Сэнгэтэй ураг барилдвал худын холбоогоор хамжаа түшиг нь багжих юм сан даа...” хэмээн эргэцүүлээд бослоо. Ханы луун хээтэй цагаан торгон дээлийн хормой хэсэгхэн газар нялх ногооны шүүсэнд будагдсаныг тэр ажигласан ч үгүй.

Ховог сайрын газарт байх Очирт цэцэг ханы орд өргөө хүртэлх хэдэн өдөрчийн газарт гуравхан удаа морио юүлж, мухлаг тэрэгт тухлалгүй давхисаар бүрлээчийнд очив. Анд нөхрийнх нь амьддаа бариулсан шавар хэрмээр хүрээлэгдсэн олон орд өргөө, алтан ганжир гялалзуулсан сүм хийд, үзэсгэлэнт цэцэрлэг, цэцэгсийн хүрээлэн, дугариг цэнхэр цөөрөм бүхий балгад нь санаа дагаад ч тэр үү уй гашууд дарагдан харласан мэт цаанаа л нэг гунигтай бараантан угтав. Наснаас нөхчигч хунтайжийн орд балгадын толгойн харуулууд Очирт цэцэг ханыг барааны газраас тосон угтаад нарийн бүрээ үлээн хэрэмний их дааман хаалга нээхэд бэлтгэх дохио өгчилгөөд хэрэм хүртэл хүндэтгэн дагаж ирцгээгээд их дааман хаалганы дэргэдээс буцав. Дөрвөн Ойрадын төр улсын их сүлд хийморь болсон эзэн хунтайжаа алдсан цэрэг эрсийн хөрслөг бор царай мөн л баргар. Дөрвөн хасаг тэрэг зөрөөд гарч орж болох уужуу тавиу их дааман хаалга Очирт цэцэг ханы өмнө цэлсхийн нээгдэхэд Алшаагийн их говийг хөндлөн гулд довтолгон Эрчис мөрний эх, Ховог сайр хүртэлх хэдэн зуун бээр алсын аянд агсдаагүй түүний зүс царай андынхаа үхэл, орчлонгийн мөнх бусын өмнө хүчин мөхөсдсөнөө сая л бүрнээ ухаарч, үүлэн сүүдэр дайрах мэт улам барайчихыг хажуугаас нь



салдаггүй шадар хамгаалагч солгой Лувсанхайдав, мянганы ноён Чимбай жанжин хоёр нь соргогоор ажиглаад хоорондоо сэмхэн харц солилцов. Очирт цэцэн хан мориноосоо буугаад их дааман хаалганаас бүрлээчийн ёслолын дотоод ордон өргөө хүртэл чулуу шигтгэсэн замаар явгалан алхахдаа анд нөхрийн хамт инээж хөхөрч, цаг төрийн байдлыг хэлэлцэн, манж, халх, оростой харилцах Ойрадын төрийн бодлогыг хэлэлцэн, алалдах дайсан нэгтэй явснаа санан дурсаж цээжин доторхи зүрх өнчирсөн мэт уй гашууд дарагдан байвай.

Талийгчийн орд өргөөний зүүн этгээдэд шавааралдан буусан бор гэрүүд, орос, нанхиад мужаан урьж авчран бариулсан гурван давхар дотоод ордон, алтан ганжирт сүм тэргүүтэн багахан суурин болон өргөжөөд, өдгөө тохиож буй энэ гашуудалт өдрүүдэд үүлэн сүүдэрт дайруулж нэг л навсайн гуньсан эмгэн хүн мэт үзэгдэнэ.

Өрхийг нь буулгасан өргөө гэрүүдийн зүгээс хонх дамрын дуу сонсогдон бүрлээчийн хойдын номыг айлдах лам нарын уншлага дүнгэнэх нь чих дэлсэнэ.

Үхлийн сүүдэрт барайсан энэ орд өргөөний гол дунд тэнгэрийг тольдон мэлтийх дугуй толь мэт гурван цөөрөм л уулын сэрүүн салхинд чимээгүйхэн бидэртэн долгиж байх ажээ.

Арваад жилийн өмнө бил үү, анд нь “Энэ цөөрмийг Ховогийн голоос шуудуу татан дөрвөн сарын турш олзны таван зуун барлагийн хөлс, хүчээр хийлгэлээ. Санаагаа бие минь гүйцэх бол хол ойрын зочин гийчдийн өмнө нүүр улайхааргүй хот балгад байгуулах сан “ хэмээн ярингаа өтгөн ширвээ сахлаа имэрч зогссон сон.

Түүнийг бүрлээчийн ёслолын их өргөөний үүдэнд эрээ алдан гашуудлын далайд унасан олон хатад, хөвгүүд хиа дагалдагсдын хамт угтав. Очирт цэцэн ханы эмээж байснаар эртний заншлаар гашуудал зарлан үсээ задалсан эмс үзэгдсэнгүй. Учрыг тунгаавал тавь шүүрч яваа их хатан торгууд угсааны Насангаас эхлээд хошуудын Цэвээндарь, буруд Дарабалж, Хоо өрлөгийн охин Дарь-Увсалж, Шүхэр Дайчины Юм-Агас, Гүүш ханы охин Аминдара бүгдээр эрийнхээ хойноос гашуудан хорвоогийн элдэв явдлаас татгалзсаны тэмдэг болгон сахил хүртэж, гээг үсээ хуу хусуулсан байлаа.

Эр хүний хийморь сүлд бүсэндээ байдаг бол эм хүний гоо үзэсгэлэн, сүр хүч үс гэзгэндээ байдаг бололтой. Сахил хүртэн үс гэзгээ хусуулсан тэр эмс хатдын дундаас тэнгэрт одогчийн хамгийн хайртай хатан Юм-Агасыг үзээд хан хирдхийн цочив. Эр нөхрөө амьд сэрүүнд Дөрвөн Ойрадын чуулган, Майдар эргэх зэрэгт олонтаа дагалдан явж, өөрийнх нь Доржравдан хатантай мэнд устай байдаг Юм-Агас хатан сахил хүртээд нүд халтирмаар болжээ. Энэ жил дөч шүргэж буй ч хацрынх нь булбарай ягаан өнгө анхил залуу бүсгүйнх мэт хэвээрээ, хараацайн даль мэт нарийхан хөмсөг доор давхраа үгүй ч жоготой хурц хар нүд нь асах мэт оч хаялан дүрэлзэж, хөх туяа ойсон хилэн хар үс нь цэнхэр цэгдэг дээрээ хурцаар ялгаран намираад нүд булаам бүсгүй сэн. Одоо хатан хүний ёслолын малгай доороос үсийг нь хуссан цагаан хуйх нь цухалзаад өнөө оч хаялсан жижигхэн нүд нь бүлцийн хавдаад унтарч буй дэн шиг сүүмийн, уй гашууд дарагдсан нь эгээ л малын хөлд гишгэлэгдсэн яргуй цэцэг мэт болжээ. Харин Юм-Агас хатны урдуур хөндөлсөх буруд угсааны Дарабалжи хатан, хөвгүүдийн ууган Цэцэн тайжийг төрүүлсэн эх нь би мөн тул хунтайж тэнгэрт хальснаар хүү минь ширээ залгамжилж, би энэ өргөөний хатан эх болох нь нэгэнт тодорхой гэдгийг доогуур шагайвч үе үе дээрэнгүй бардмаар гялалзах том алаг нүдний харц, уй гашуутай болон

харагдах хэмээн хичээвч сэтгэлийн гүндээ дэврэн буй эрх мэдэлд тэмүүлэх шуналаа барьж үл тэвчих төрх байдлаараа илтэд харуулаад байлаа. Буруд хүүхэн гэж...Залуудаа өтгөн хөмсөг, алаг нүдээрээ гайхуулсан сайхан хүүхэн явсан. Яг л персийн солонгорсон алаг хивс шиг хурц тод зүстэй. Одоо ч нэлээд тарган шалхгар, бас дээд уруулынхаа захаар сахалтай мэт шар үс нь сөрвөлзсөн бүдүүн авгай болж дээ. Гэхдээ хөвүүнээ хунтайжийн суудалд суулгахын тулд яахаас ч буцахгүй нь илт үзэгдэнэ. Харин Хоо Өрлөгийн охин Дарь-Увсалж гэх шингэн хөмсөгтэй, хөнхөр бор хүүхэн сахил хүртээд гэзэг үсгүй болж, уй гашууд төдийлөн авгаагүй ч, болж байгаа энэ бүхэн зүүд биш гэж үү? хэмээн одоо хүртэл учраа үл олох шиг эргэлзсээр буй бололтой. Тэдний арханд газар шагайн зогсох бусад хоёр хатныг нь харин сайн харсан ч үгүй. Хүн насан элсэн газраар оршдог уй гашуу, нөгөө ертөнцийн гэмээр битүү айдас хүйдэс, бүрлээчийн сүнс хаа нэгтэйгээс ажиглаад байх шиг нуруу хүйт оргиулсан үгээр илэрхийлэмгүй учир битүүлэг байдал, чимээгүйхэн хөл хөсөөнтэй зэрэгцэн, эрх мэдлийн төлөөх далд тэмцэл талийгч хунтайжийн орд өргөөнд бугшжээ.

-Хан ах та холын аянд сайн явж ирэв үү? хэмээн хөвгүүдийн ахмад Цэцэн тайж хоолой шахан өндөр дуугаар амрыг айлтгаад хэдэн жилийн өмнө нанхиад урчуудыг залан авчирч бариулсан ёслолын чулуун ордонд морилохыг урихдаа хатдын дунд зогсоо эх рүүгээ сэмхэн хяламхийхийг Очирт цэцэн ханы гярхай нүд ажиглаж амжлаа.

-Амар сайн явж ирлээ. Хатдын лагшин тунгалаг буй за! гэхдээ Юм-Агас хатан руу зөөлөн харц илгээлээ.

Хунтайжийн ёслолын чулуун ордны их танхимын хоймор эзнээ үгүйлсэн мэт эзгүйрч даль жигүүрээ дэлгэн нисэх зоригт шонхрын сийлбэртэй зандан ширээ, перс газрын алаг хивсэн олбогт уужим суудал руу нь Очирт цэцэн хан хяламхийгээд нүд буруулж, аягач бүсгүйн хоёр гардан барьсан аагтай цайг тосч авлаа.

-Эцэг маань нохой өдөр гэнэт ухаан алдаад сэхэлгүй байсаар хөх тэнгэрт заларлаа даа.Нас сүүдэр 61 хүрсэн. Би Зая Бандид багшийг залахаар хүн хөсөг явуулсан. Хатдад сахил хүртээн, хойдын ном хуруулж бай гэсэн хэл ирээд байна. Лхаст шавилан суугаа Галдан дүүдээ хэл өгөх элч довтолгосон. Ээж болон бусад хатад бүрлээчийн хойдын буяныг бодож өчигдөрхөн сахил хүртэцгээлээ. Эцгийн оронд өргөө гэр, цаашлаад овог, аймаг элкэн, Зүүнгар улсаа хэрхэн авч явах нь мунхаг миний толгой ухаад ухаад ухааршгүй...

Буруд гаралтай эхээ дуурайн нүд хөмсөг болсон ширүүн төрхтэй, аливаад овжин атал бусдын үгэнд баахан автамхай Цэцэн тайжийн харц, "...Эцгийн оронд өргөө гэр, цаашлаад овог аймаг, элкэн, Зүүнгар улсаа хэрхэн авч явах нь мунхаг миний толгой ухаад ухаад баршгүй..." гэсэн үгнээс цаад санааг нь төвөггүй уншчихаад байсан ч Очирт цэцэн хан найрсаг ёсыг бодон гангар гунгар ярьж л суулаа.

Үдэш нь Юм-Агас хатан түүний буусан гэрт шивэгчнээ илгээн өргөөндөө цай уухыг урилаа.

Хаврын оройн сэрүү унаж, цагаан гэгээ тасраагүй нам гүмхэн үдэш. Зүүнтэйх энгэрээр өргөөнийхний ойр зуур унадаг зуугаад тооны агт морь идээшлэн хааяа нэг тургилах нь дуулдаж, цэлмэг тэнгэрт одод түгжээ.

Хунтайжийн номын өргөөний зүүн талд барьсан Юм-Агас хатны найман ханатай, улаан халзтай гэрийн зүг Очирт цэцэн хан гурвын зэрэг шадар баатраа дагуулан аажуухан алхаж явахдаа өдрийн үзсэн хатдын өрөвдөлт царайг нүдэндээ санасаар байлаа.

Ёслолын өргөөнөөс баруун тийш Дарабалжи болон бусад хатдын өргөө гэрүүд цайвалзан үзэгдэх нь гаднаа дэндүү амгалан тайван ч одоо энэ өргөөнд хунтайжийн суудлын төлөөх цусгүй тэмцэл хэдийнээ эхлээд байгааг тэр мэдэрч байлаа.

Хатны шадар хамгаалагч Буянтөмөр, Юм-Агас хатны өргөөний ширмэл эсгий үүдийг өргөж өгөхөд өөдөөс нь өдрийн уруу дорой байдлаасаа тэс өөр шийдмэг харцтай хатан мэхэсхийхэд, олон зул өргөж өдөр шиг гэрэлтэй гял цал буусан гэр рүү алхан орлоо.

-Хантан та дээшээ морил! Асралт аа, хүү минь нааш нь Сэнгэ агийг дуудуул. Цай идээ түргэл! хэмээн хатан ар араас нь тушаал буулган аягач, шивэгчингүүдээ захирах нь эрхгүй л Шүхэр Дайчины охинд баймаар эрмэг зоримог төрх харагдах аж.

Гэрийн зүүн хойморт байх танан хөвөөтэй хятад нарийн хийцтэй том босоо толийг хар бөсөөр бүтээсэн нь хүн бүрлээч болсон айлд сахидаг эртний ёс.

Хатан ёслолын малгайгаа тайлж сувдан чимэглэлтэй хөнгөн тоорцог тавьсан нь мулзан толгойг нь бүрэн далдаж чадсангүй.

Үе үе зүрхээр хатгууллаа гэдэг байсан нь олон хоногийн ав хомрогын дараа гэнэт архаг хуучийг нь хөдөлгөн тэнгэрийн оронд авч одсон болов уу хэмээн эр нөхрийнхөө зуурдын үхлийн шалтгааныг болгоож буйгаа хатан хуучлаад бие тулгар Доржравдан болон бусад хатад авхай нарын амрыг эрэн, хавартаа төл бүрэн, онд мэнд сайхан орж, дэлгэр зунтай золгож байгаа тухайгаа энгүүн хүүрнэж, сэтгэлийн гүн дэх зовлон зүдгүүрийг цээжний цаана чадмаг нууж чадаж буйг нь хан дотроо их л ойшоож байв.

Эр нөхрийнхөө андыг айргийн тос самарч, хууч ядаргаанд сайн хэмээн хушганы идээгээр хийцэлсэн сайхан цай, үзэмтэй будаагаар дайлан хэдий уй гашуу тохиосон ч билэг ерөөлийг бодон сайн сайхны тухай хуучилж байсан Юм –Агас хүүгээ ойртож яваа хөлийн чимээнээр ханд ярих гэсэн чухаг сэдвээ хөндөв.

-Хантан таныг эр нөхөр минь хамгаас дотнын анд, энэ Ойрад түмний түших хос баганы нэг нь хэмээн амьсгал тасартал итгэж явсныг би мэднэ. Хунтайж таалал болохын өмнөхөн хэсэгхэн ухаан орохдоо зургадугаар хөвгүүн Сэнгэд ор залгамжлуулаарай хэмээгээд хас тамгаа мөхөс надад хадгалуулсан билээ. Өдгөө Хан таны дэм тус хүүд минь хэрэгтэй байна. Миний төрүүлсэн ооны эвэр шиг хоёрхон хүүгийн нэг Галдан нь даанч нас балчир, тэгээд ч түмэн бээрийн алсад шавилан суугааг та мэднэ. Чоно борооноор гэдэг шиг лал шүтлэгт Дарабалжи хатан хүүгээрээ хунтайжийн орыг залгуулах завшаан тохиолдов гэсэн шиг өдөртөө гурван удаа аллахтаа мөргөн, холын нутгаас мулла дуудуулан, хойдын буяны хэргийг ахмад хүүгээр шийдүүлэх нэрээр Цоросын хэргийг гартаа авах санаатай байна хэмээн ярилаа.

Энэ үеэр хатны шадар шивэгчин Асралт хэмээх нуруулаг бүсгүй эсгий үүдийг сэмхэн сөхөхөд

цаанаас нь эхийнхээ хурц хар нүдийг өвчсөн мэт дуурайсан залуу агь Сэнгэ орж ирэн ханы доохон талд завилан суулаа.

-Хэдийвээр Цэцэн тайж өнөөхөндөө гуч шахаж, бяр ухаан тэгширсэн, эцгийн ууган хүү мөн ч аллах шүтлэгт буруд хатнаас мэндэлсэн нь энэ Цорос аймийг захирахад өлзий бус хэмээн хунтайж амьддаа хэлдэг байсан билээ хэмээн Юм-Агас хэллээ.

-Хан ах та эцгийн ор сууж цоросыг захирахад надад хамжаа болбол энэ насаараа ачийг тань би мартаггүй цавчих илдний тань ир, харвах сумны тань зэв болж явья гэж Сэнгийн хэлэхэд түүрүүнээс хойш эх хүү хоёрын яриаг чагнан наад цаадхийг эргэцүүлэн бодож суусан хан суудлаа засаад:

-Манай Хошууд, Цорос хоёр элхэн цагийн уртад хоорондоо хань тулгуур болж, ураг садан болсоор ирсэн. Миний хувьд тэнгэрт одсон андынхаа тааллыг биелүүлэх нь нэр хүндийн хэрэг хэмээн бодно хэмээлээ.

Маргааш нь Ойрад түмний шашны тэргүүн Зая бандида Намхайжамц биеэр хунтайжийн өргөөнд морилон ирж, Дөрвөн Ойрадын чуулганы нэгэн тэргүүн Очирт цэцэн ханы хамтаар тэнгэрт хальсан Эрдэнэбаатар хунтайжийн орыг зургадугаар хөвгүүн Сэнгэд өгснийг тунхаглан зарлавай.

-Хүүг минь хунтайжийн ор суулгахад таны хүргэсэн ачийг үеийн үед мартаггүй. Таныг хөх тэнгэр ивээг! хэмээн Юм-Агас хатан түүнийг үдэхдээ хэлж билээ.

-Энэ бол тэнгэрт хальсан андынхаа өмнө хүлээсэн үүрэг минь. Тэгтэл их талархан ач санахын хэрэг юун. Харин хүүгийнхээ төр барих их хэрэгт нь цэцэн ухаанаараа дэм болж, энэ биеэ хайрлаж яваарай гэж Очирт цэцэн хан хөөрхий бэлбэсэн хатанд хэлэхдээ чимэг зүүлтээ авсан, дан малгай дороос өнөөх л үсээ хусуулсан нүцгэн хөх хуйх нь цухалзахыг дальдчилгүй харж төвдсөнгүй ээ.

-Энэ биеэ хайрлах гэнээ гэж бүсгүй хэлээд гүнзгий санаа алдаж:

-Эр нөхөртөө л гэж энэ биеэ хайрлаж, гоёж гоодож явлаа. Одоо тэр минь эгнэгт үгүй болсон болохоор хэндээ ч гэж энэ биеэ бодох билээ. Сахилаа сахин, эрихээ эргүүлэн, энэ хорвоогийн элдэв нүглийг тэвчин, хоёр хүүгийнхээ төлөө л амьдрах боллоо доо. Харин хийморилон сүрлэг хан та өдий насандаа үрийн зулай үнэрлэх гэж байгаа нь хөх тэнгэрийн өгөөмөр их буян шүү. Тэнгэртээ залбирч яваарай. Доржравдан ахайданд эсэн мэнд амаржин үрээ тэврэхийн ерөөл айлтгасныг минь дамжуулаарай! гэсэн сэн. Тэгэхэд нь:

-Хатан та зүс гоо, нас залуугаараа атал юунд сахил хүртээ вэ? Бүсгүй хүний зүсний чимэг сайхан хар үсээ хусуулаад хэмээн зэмлэх аядахад:

-Сахил үл хүртлээ гээд сайхан үсээр ч яах юм билээ. Их сайндаа л асраху ёс дагаж Цөхүр увшийн долдугаар хатан болох юм биз дээ? Тэрэн дорхноо хунтайжийгаа дурсан маань уншин, буян хурааж явья даа гэж билээ.

Очирт цэцэн хан тэндээсээ Эрдэнэ баатар хунтайжийн дүү Цөхүр увшийн өргөө рүү хүлгийн жолоо заллаа. Хэдийгээр Хойдын Сайн хиаг хорлоход энэ эр оролцсон гэгдэн, Ойрад түмний дотор нэр хүнд муутай байдаг ч Зүүнгарын төрийг бараглан эзэгнэж асан ах нь тэнгэрт халин одсоноор эрхий мэргэн харваач, хурд сайт агт морьдоороо цуутай энэ эрийн нэр нөлөө хулс мод шөнөдөө сөөм сөөмөөр ургадаг шиг л аяндаа өсч буй тул түүнтэй уулзан шинэ хунтайж Сэнгийг дэмжүүлэх, Дөрвөн Ойрадын чуулган дахь өөрийнхөө байр суурийг бэхжүүлэх тухай хэлэлцэх чухал хэрэг түүнд байлаа. Ханыг дагалдан яваа шадар хиа, агтчин, зам, хэвгүүлүүдийн морьдын хөлөөр боссон их тоос тэнгэрт хөшиглөхийг хараад саяхан л ав хомрогод мордон эмээл дээрээ эрвэлзэн явсан их андынх нь цогцсыг хайлан шүтээн овоонд нь цацсаныг санан түүнээс өдгөө энэхэн тоосны хэртэй ч юм үлдсэнгүй дээ хэмээн харуусан халаглах сэтгэл төрнө.

Ийнхүү дурсамж, харуусал, ирэх цагийн тухай бодол ээлжлэн элдвийг эргэцүүлэн явтал нөгөө л Юм-Агас хатны үсий нь хуссан нүцгэн хуйх, “энэ биеэ хэндээ ч гэж бодох билээ” хэмээн харц доошлуулан зүрх зүсэм гунигтай хэлснийг нь эрхгүй санагалзан “Энэ ертөнцөд морин дэл дээр эрвэлзсэн эр хүн болгож төрүүлсэн хөх тэнгэрт талархая. Хатад эмс шиг нэгэн эрийн эрхэнд өдөр хоногийг гэр өргөө сахин өнгөрүүлсээр бэлбэсрэн хоцрохдоо нэг бол Юм-Агас шиг сахил хүртэн үсээ хусуулж, эм хүний тооноос хасагдах, нэг бол асрамжлах ёс даган эр нөхрийнхөө ах, аль эсвэл дүүгийн эхнэр болж хаяаг нь бараадах гэдэг юутай бачуухан тавилан бэ?” хэмээн бодож явлаа.

Нартай борооны дараа солонго давхарлан татаж өнөө их тоос дарагдан, хурын үнэр үнэртэн, байгаль дэлхий “нүүрээ угаасан” өнгө үзэсгэлэн залуу бүсгүйн гоо царай мэт жавхлан төгс үзэгдмүй. Тэнгэрт татсан хос солонгыг үзээд тэрбээр бие давхар хоцорсон Доржравдан хатнаа санагалзав. Тавь гарсан надад хаанаас ямар үйлийн үрээр үр болон заяаж байгаа амьтан юм бол доо? Эхийнхээ зүүдэнд тэнгэрийн солонгоос тасран хэвлийд нь оршиж буйгаар дандаа ороод байгааг бодвол эгэл бус хувь заяатай хүүхэд юм болов уу? Яадаг ч байсан хатан минь амар мэнд хоёр яс хагацвал гүйцэх нь тэр хэмээн бодоод Цөхүр увшийн өргөө хүртэл нэгэн өдөрчийн зайтай тул ачаа хөсөг буулган үдлэхийг зарлигдав. Олон хоногийн аяны замыг морин дэл дээр өнгөрүүлсний учир хэдий идэр чийраг биетэй ч аргагүй агсагадан аяншжээ.

-Хан та ямар зоог барих сан бол? хэмээн зам \тогооч\ Лхасран нэртэй, эр дунд насны намхан хөх хүн асуугаад мэхэсхийв.

Аяны хөх торгон асартаа нарийхан хоргой дэр дэрлэн зүүрмэглэж асан хан сэрж :

-Мөөгтэй, шорлож шарсан мах гэлээ.

Хан мөөгтэй хоолонд дуртай тул намрын эхэн сард бороошоод эхлэхээр Хөх нуур тийш хатад, албатуудтайгаа очин талын цагаан, хар мөөг түүлгэн хатааж, жилийн турш хоол амталдаг бөлгөө. Ижил мөрний зүгт нүүдэллэн одсон торгууд угсааны хатан нь ч бага залуудаа орос авхай нартай үерхэн, гэртээ орос шивэгчин зарж байсан тул мөөг дарж амтлах аргыг гаргуун сурсан ажээ.

Түүнийг аяны уртаас гэртээ яаран яаран харьж явтал өргөөнийх нь өмнөд дэх овоо-индэрийн

онгон сахиус болтой хадган дээлтэй эмгэн гэнэт үзэгдэн “Хан таны гэрт хааны хатан болох хувьтай охин төрнө. Тэр охин хатан болсны хойно тэнгэрээс оноосон насаа гүйцэд элээлгүй хатгалдах дайсны халуун суманд өртөн амь тасарч, шастир түүхэнд нэрээ үүрд үлдээх болно.Охиндоо Ану нэрийг өгөгтүн” хэмээгээд овооны заламд шингэн алга болов хэмээн зүүдлээд цочин сэрвэл мөөгтэй шарсан махны сайхан үнэр асар дүүрэн хорхой хүрэм ханхалж байлуга.

Хан хоромхон зуурын нойрондоо үзсэн тодоос тод зүүдээ эргэн санаж хэсэгтээ л хоолны сайхан үнэрийг анзаарсангүй. ”Ану гэсэн үү? Чихэнд сонсголонтой л нэр юм.Доржравдан хатнаас минь охин төрөх юм байх даа?Сэнгэд өгөх насанд хүрсэн охинтой ч болоосой хэмээн бодсоныг минь тэнгэр болгоосон юм шиг. Хатгалдах дайсны халуун суманд өртөн амь эрдэнэ гэж юу гэсэн үг вэ?Бүсгүй хүн байтлаа дайсны суманд амиа өгнө гэдэг?Ө мнө этгээдээс манж нар өнгөлзөөр буй энэ цаг дор хүү ч бай охин ч бай энхрий үр чамайгаа би харвах эрдэмд мэргэн, хатгалдах сэлэмд гарамгай хүн болгон сургах болно. Насны бөгсөнд надад заяасан энэ үр яавч эгэл бус хувь тавилантай хүн болох буй за гэж бодсоноо зоог тавьсан аяны намхан ширээ рүү өндөсхийн дөхөв.

Зам ямар ч аягач бүсгүйчүүдээс дутахгүй шалмагаар ам арчих цагаан алчуур, ир нь гялалзсан хутга, ваартай сархад,жүнз тэргүүтнийг нямбайлан өрсөн байлаа. Хан хутга авснаа баруун талдаа байх хүрэл хонхыг нэг дуугаргаад шадар хиагаа асар руу цухуймагц:

-Илдэнг дууд! хэмээн тушаав.

Илдэн бол түүний хэвгүүл зуутын дарга шаламгай баатар эр бөлгөө.

Очирт цэцэн шадар баатрын хамт зоог барингаа Цөхүр увшийн тухай ярилцав.

-Тэр жилийн үрс гаргах баяраар чи Цөхүр увшийн хүү Багабандитай ирүүлд тулалдлуу яалаа,хө?

-Тэгсэн эзэнтээн. Би Багабандийн зүүн шанаанд сэлэмдсэний ул мөр тал саран тамга шиг сорви үлдсэн шүү дээ.

-Хонин жилийн Хасагийн хантай хийсэн тулалдаанд\* Цөхүр увшийн Цагаач мэргэн шалгарч байж билээ. Халхын Засагт хан Омбо-Эрдэнэ ирж хүч хавсраад л Монгол-Ойрадын цаазыг тэр жилийнх шиг сахих юм бол бид Манж нараас аюух хэрэг юун билээ. Тэр тулаанд Хасагийн ханыг дийлээгүй ч Баатар хунтайжтай хос багана шиг л хамтдаа дөрөө харшуулан тулалдаж, хоёр биенээ хазайхад нь түшиж явсан сайхан цаг байж дээ.

-Одоо ингээд “хоёр тайж” гэж цууд гарч явсан та хоёрын маань нэг нь байхгүй боллоо.Ум ма ни бад ми хум гэж.Хунтайж сайн төрөл орох болтугай.

-Анд сайн нөхрийн минь дурсгалыг бодон наад жүнзтэйгээ тогтоочих. Нас дөч хэвийж буй өргөн саруул магнай, хөмсөг сийрэг ч давхраа ихтэй гярхай нүдтэй Илдэн баатар хуруувчин жүнзтэй хар архийг эзнийхээ гараас авахдаа харц нь хатуу ундаанд дуртай хүний шинжээр гэрэлтэх мэт болсон ч дууны өнгөө өөрчилсөн ч үгүй :

-Жаа эзэнтээн гэж буурьтай гэгч хэлэн хөнтөрчихөөд чихэр бурам амтлах бяцхан жаал шиг амандаа үлдсэн архины аагийг амтлах мэт уруулаа шилэмдэн хорхойсов.

Маргааш нь үдийн нар голлож байхад Очирт цэцэн хан Цөхүр увшийн өргөөнд хүрч ирэв.

Эх өөртэйгөөс тэр юм уутэнгэрт хальсан ах Баатар хунтайжийгаа бодвол биеэр давжаа, гүйлгэнэсэн тогтворгүй нүдтэй Цөхүр увш өдгөө Дөрвөн Ойрадын чуулганыг ганцаар тэргүүлэн хоцорсон Очирт цэцэн ханыг ер бусын найрсаг зочломтгойгоор угтан, их хаадад өргөдөг байсан хүндэтгэлийн зоог бүтэн хонины зумаар шүүс барьж хөл алдав.

-Ах минь өвчин хууч гэж дуулдаа ч үгүй л байснаа “явчих” юм даа. Олон том хөвүүд, хоорондоо хагаралдсан хатад нь аминд нь хүрчихэв үү? ч гэж мунхаглах юм. Алдсан хүн арван тамтай гэгч үнэн үг юм. Юм-Агас хатан ч их хөвгүүнээ ор суулгахын тулд хазахаас бусдыг хийх хүн дээ гэхчлэн Цөхүр увш гаднаа наснаас нөхчсөн ахын хойноос харуусч буй дүр үзүүлэвч цаанаа өөрийнх нь хүслээр ахынх нь орыг Цэцэн тайж залгаагүйд дургүйцлээ нууж үл чадах аж.

Ер нь нүүрэн дээрээ хэнд ч тал үл алдах атал, тувт далдуур хутган үймүүлж явдаг энэ эрд итгэхэд хэцүү гэдгийг Очирт цэцэн хан мэдэж л байсан ч өнөөхөндөө шинэ тулгар хан Сэнгэд авга ахын хүч нөлөө юунаас ч илүү хэрэгтэй үед цаашаа харж хөмсөг зангидан,наашаа харж найртай үг илгээхээс өөр арга зам үгүйд хавчигдан аль болох ая эвийг олохыг хичээж байлаа.

-Юутай ч халхын байдал найдваргүй, төлдөрхөн Халхын Бундир ноён манжид дагаар орсон байна. Ийм цаг дор Ойрадад эв эе юунаас ч илүү чухаг байгааг та надаар хэлүүлэх юун хэмээн Очирт цэцэн хан өөртэй нь харц тулгарахаас ямагт зайцан булгах Цөхүр Увшийн нүд рүү цоргин харах зуур хэллээ.

-Тэр ч тийм ээ. Халхууд уван цуван манжид дагаар ороод дуусах нь шиг байна. Таныг хүндлэн барьж буй идээ шүүсийг таалан зооглогтуй хэмээн Цөхүр увш ширээн дээрх зумыг заангаа ханы ярианы үндсэн санааг дүйвүүлэн булгах аж.

-Сэнгийг их ор суулгах нь ахын тань гэрээс байсан. Иймээс хэдийгээр Цэцэн ууган хүү ч шүтлэг буруу хатнаас төрсөн,нөгөөтэйгүүр ор залгамжлуулах эцгийн тааллыг хүртээгүй тул өдгөө нэгэнт Баатар хунтайжийн орыг залгасан Сэнгэ хунтайжид бид бүгдээр хүчин хамжих нь зайлшгүй гэдгийг Та надаар хэлүүлэх юун гэж хан хэлээд манан иштэй хутгаараа нас гүйцсэн тарган иргэний зумаас ташуулдан урт нарийхан зүсч амандаа хийгээд хурц цагаан шүдээрээ тас тас зажлан идэхийг Цөхүр увш сэм сэмхэн ажиглан дуугүй толгой дохих авч “Аблай тайж бидэн хоёрт эцгийн ууган хүү болон төрөх хувь дутсанаас хэн хэн нь ах нарынхаа доор эрэмбэлэгдэж, эд хөрөнгийн үлдэгдлийг , эрх мэдлийн татууг эдэлсээр энэ насыг элээх нь. Гэтэл Цэцэн тайж ач минь ахын ууган хүү атал эцгийн ор залгаж чадсангүй. Өдгөө санаа буруу Сэнгэ надад төдийлөн нүүр тал өгөхгүй нь илт атал эцгийнхээ андыг нааш нь илгээж хүний гараар могой бариулах санаатай. Барын зулзагыг бага дээр нь гэдэг сэн...” хэмээн элдвийг эргэцүүлж суусан нь долоон жилийн хойно Аблай тайж, Далай тайш нартай хүч хавсран дайн өдүүлэхийн үрийг сэтгэлд нь соёлуулсан ажгуу.Очирт цэцэн хан Цөхүр увшийнхаас мордохдоо :

-Тэр жил хасагийн хантай байлдахад Хошуудын хөндлөн Увш,Дөрвөдийн Дайчин хошууч нар хамжаа бололгүй дотоодын зөрчилдөө идэгдсэнээс бид хасгуудыг дарж чадаагүй. Үүний уршгаар өдгөө Ойрад түмэнд баруун хойд зүгээс хасагийн аюул өмнө зүгийн Манжийн заналтай зэрэгцэн оршоор үлдсэнийг умартаж үл болно. Иймд Цорос аймгийн хамгийн ахмад ихэсийн нэг Та Сэнгэ хунтайжийг хазайхад нь дэмнэж, халтирахад нь түшиж явах цаг болжээ гээд халирамхай хүнийг далдиртал ширтдэг ширүүн хар нүдээрээ цоо ширтэж билээ.

Хошуудын нутаг. Үдшийн цагаан гэгээ тасарчээ.Очирт цэцэн ханы өргөө эзгүйрсэн мэт нам гүмхэн. Их хатан Цэвээний гэр нэлээд захад.Ханы хамгийн хайртай дунд хатан Доржравдангийн өргөө ханы ёслолын болон бичгийн гэрийн хажууханд байхад, Хамийн тэндээс буулгаж ирсэн хотон угсааны хазгай хэлтэй Нуран гэдэг залуухан бага хатны гэр их хатныхаас ч захдуу байрлах ажээ.

Самаркандаас нөхрийнхөө авчирч бэлэглэсэн хүрэл толинд сэвхтсэн нүүрээ тольдон царайгаа цайруулах гэж цагаан мөөг хийж хонуулсан элгэн таргаар бигнүүр тавих Доржравдан хатан Үзмээ хэмээх залуухан шивэгчнээ дуудан авчраад:

-Цаад Нуран чинь юу хийж байна?Хан ойр мөдөд тэрний гэрт хоноогүй гэж үнэн үү? хэмээн асуулаа.

-Тийм ээ,ахайтаан. Шивэгчин нь тэгж ярьж байна лээ. Хантанг өөрийнх нь өргөөнд саатан хоноглохгүй болохоор бага хатан цагаан алчуур гаргаж хоймроо дэвсээд л өдөртөө гурван удаа аллах тэнгэртээ мөргөөд байдаг гэнэ . Буруу номтон болохоор нь тэр юм уу эзэнтэн барагтайд тэднийд морилдоггүй шүү дээ ахайтаан.Та л харин энэ өргөөний хамгийн нэр төртэй хатан нь бус уу?

-Тэр чинь манай хантны хатан болж ирээд шүтлэгээ сольж бурханы шашинтан болсон биз дээ?Тэгээд юугаа хийгээд буруу номын мөргөлөө хийгээд байдаг байнаа?

-Нуган үр хайрлаач гэж л аллах тэнгэрээсээ гуйдаг юм гэсэн.

-Манай ханд өдгөө дөрвөн нуган үр байхад тэр буруу номтноос унасан хүү л дутаж гэнэ.Чи Равданг Жаал бариач руу мордуул. Би өнөөдөр бие чилээрхүү байна.Бас муу зүүд үзлээ.

-Жаа, ахайтаан.

Шивэгчнээ гармагц хатан толио тавиад урьд шөнийн билэггүй гэмээр атал бас тий ч муу гэмээргүй сонин зүүдээ эргэн саналаа.

Өргөөний өмнөд этгээдэд байх тахилгат овоо-индэрийн тэндээс салмарсан харь хувцас хунартай эмгэн алхсаар ирээд түүний гэдсэнд гараа хүргэснээ”Хатан ахайтан таны тээж яваа үр хэтдээ хааны хатан болох заяатай юм байна. Урт наслахгүй ч хатгалдах дайсны суманд өртөн амь эрсдэж ,түүх шастирт мөнхрөн үлдэх хувьтай охин юм” гээд агшнаа замхран алга болох юм..

Усан хулгана болтлоо хөлөрсөн хатан арай ядан нойрноос сэрээд хэвлий дээрээ гараа тавин



чагнахад үр нь нойрсч байсан юм уу хөдөлсөн ч үгүй, харин хаврын анхны зөөлөн бороо гэрийн эсгий туургыг бүүвэйлэх мэт зөөлхөн дэлдэн шивэрч байж билээ.

Хаврын анхны бороотой хамт зүүдэнд нь айлчилсан зөнч эмгэн юу өчив? Гучин зургаан насанд нь тэнгэр бурханаас хайрласан энэ үрээ охин бүү байгаасай гэж сахиусандаа залбиран гуйсан бус уу? Доржравдан одоогоос таван жилийн өмнө, хөлд ороод тоодон цэнхэр баривчтайгаа тэнтэр тунтар алхаж явсан хөөрхөн охиноо алдсанаас хойш дахин охин үртэй болохоос зүрхшин цэрвэдэг ч болсных. Бас хорвоогийн хаврыг гучин зургаан удаа угтаж, холын холд хоцорсон суугуул Ижил мөрөн, элгэн садан, эцэг эхээ голоосоо санан гуних тусам ижилдэн дассан нутаг, ус ижий ааваан орхиж хүний нутагт бэрлэн оддог бүсгүй заяатай охин үртэй болохгүй юм сан гэж тэнгэрт залбирах болжээ.

Гэтэл хоёр жилийн өмнө хантны бага хатан болгон буулгаж ирсэн холын хотон бүсгүйн тээсэн үр нь өнгөрсөн жил зулбаж, тэр чөлөөгөөр нь залуу хатнаас өрсөн тэнгэрээс хайрласан энэ үр нь охин байдаг...Энэ зүүд худал байгаасай. Очирваань сахиус минь авралдаа багтааж нуган үр хайрлаач хэмээн залбиртал хэвлий дэх үр нь ээждээ гомдон ундууцах мэт хүчтэй тийрэх нь тэр. Бүсгүй хэвлийд хөдлөн тийчлэх үрээ чагнан залбирлаа зогсоолоо. “Нэгэнт олсон үр минь чи охин юм бол ижий нь одоо голохгүй ээ.Ижийгээ өршөө. Хан эцэг нь өөрөө охин, хүү нь хамаагүй гэсэн байтал мунхаг би заяасан үрээ голж сэтгэлийн нүгэл хураах нь. Бүсгүй заяагаа даган хүний хүн болон одох хүртэл чинь ижий нь чамайгаа тоостой газар үл суулгаж, тостой гар үл хүргэж энхрийлэн өсгөнөө.Ижийдээ эсэн мэнд л ирээрэй.” хэмээн бодлоороо үрээ аргадан цондойн томорсон гэдсээ аяархан илэн хэвтэх зуур “Энэ зүүднийхээ тухай хантанд ярих уу,эсбол чимээгүй өнгөрүүлэх үү?” хэмээн тээнэгэлзэн байлаа.

Эр нөхөртөө хэлэх хэлэхгүй үг гэж бийг Доржравдан мэдэхийн цаагуур мэддэг хар ухаантай бүсгүй. Анх арван найман жилийн өмнө Очирт цэцэн тайжийн хоёрдугаар хатан болж, их хөлийн найр хуримтайгаар ирж байхдаа ч их хатан Ордосын Цэвээнтэй ядаж наанаа эе эвтэй байж, эр нөхөртөө элдэв ховын үг дуулгахгүй байхыг хичээсээр ирснийх өдгөө хамгийн хайртай хатан нь болж чадсан билээ.

Гэхдээ ил өнгөн дээрээ л эр нөхөртөө тийн эв найртай, эрхэм уужим мэт харагдахаас бус далдуур бол энэ өргөөнд өмнүүрээ хэнд ч зайгаа тавьж үл болно хэмээн тэр бодно. Тиймдээ ч бага хатан Нуран бүсгүйн хүүхдээ алдахын өмнөхөн Доржравдан ураг зулбуулдаг гэлцдэг хатаасан юмдүүжин хольсон цайг Бээжингээс авчирсан ядаргаа тайлах цэцгийн цай хэмээн шивэгчнээрээ өгүүлснээс болж үр нь осолдсон хэмээх дамын үг зарц шивэгчдийн дунд хэсэг тэнэж яваад эцэстээ тэдгээр илүү хошуутнууд, дунд хатны хилэнт гэсгээлээс эмээсний хүчинд нэг л мэдэхэд нам дарагдсан билээ. Тэр ховын үгийг хэнээс улбаатайг Равдан хиагаар мөшгүүлэн байцаасаар Нурангийн өргөөний галчийн эхнэр Норсон гаргасныг олж, нуруунд нь тав чавчиргадан шийтгэснээр өргөөний элдэвт хошуу урттай эхнэрүүд дунд ахайтнаас сүнсээ зайлтал эмээх болсон аж. Хан хүний л өргөө хойно хөгшин залуу, их бага хатдын жөтөөрхөл, тэдний дунд тал олох гэсэн зарц шивэгчингүүдийн арцалдаан гэхчлэн үеийн үед ордонд шүглэсээр ирсэн атаа хорсол, хов жив цөм энд бий. Тэр бүгдийг эр нөхөртөө ховлон алтан хошуу өргөх биш, зарц шивэгчидтэй тунгий нь тааруулан харьцаж, шийтгэхийг нь шийтгээд, эд юмсаар амыг нь хаахыг нь хаагаад, толгой даан тоглож чаддагийн хүчинд тулга

тойрсон ховоор хөөцөлддөггүй хэмээн Доржравдангийн нэрийг Очирт цэцэн ханы өмнө өндөрт өргөж, барлаг боолуудын зүрхийг үхүүлж чаддаг билээ.

-Тийм ээ.Энэ зүүдний тухай багш ламтнаас асуухаас өмнө ханд хэлэхгүй нь дээр. “Хоёр тайж” гэж цууд гартлаа Дөрвөн Ойрадын чуулганыг мөр зэрэгцэн тэргүүлж явсан их андаа алдаад энэ дөрвөн ойрад Халхын адил Манжид хэрхэн эс идүүлэх вэ? хэмээн гишгэх газаргүй болсон шатрын ноён мэт гацаанд ороод байхад өчүүхэн би элдэв хоёрын зүүд зөнгөө ярьж эр нөхрийнхөө сэтгэл санааг үймүүлээд дэмий юм байна хэмээн бодоод шивэгчнээ дууддаг мөнгөн хонхоо шүүрэн авч билээ.

Тийнхүү Үзмээг бариач залах ажилд явуулаад өөрийнхөө Ижил мөрний тэндэх нутгаас дагуулан ирсэн шадар шивэгчин Жангараг бүсгүйг дуудлаа.

Эцгийн өргөөнд байх цагаасаа ижилдэн дассан энэ бүсгүйг тэр шивэгчин гэхээс илүү элгэн төрөл садан шигээ үздэг болсон тул хэдэн жилийн өмнө өргөө хамгаалах аравтын дарга хүдэр чийрэг эртэй суулган ёсолж, хөрөнгө таслан өгсөн тул ойр зуурын ажилд үл зарна.

-Ахайтан амгалан нойрсов уу? гэсээр Жангараг орж ирэн мэхэсхийв.

-Амгалан л гэхээс дээ.Амны билгийг бодож.Зүүдэнд элдэв сонин юм үзэгдээд.Миний тээж яваа үр хэтийн заяандаа хаан хүний хатан болох охин гэж нэг удган эмгэн хэлэв хэмээн зүүдэллээ.

-Та исгэлэн чихэрлэгт их дурлаад байгаа. Хөх нуурын цаадтай явсан худалдаачнаас захиж авчруулсан хатаасан илжгэн чих бүүр дуусах гээд уутных нь ёроол гарсан байна лээ.Охин л төрүүлэх нь дээ ахайтаан.

-Өө тийм үү?Хар багадаа Ижил мөрний тэртээх нутагт аавынхаа өргөөнд байхдаа шүүслэг шинэхэн улаан алим идэх дуртай байж билээ. Гэхдээ яахав, хатаасан жимс ч бас сайхан шүү.Би тэгж их исгэлэн юманд дурлаад байгаагаа анзаарсангүй юм байна. Жангаа, тэр зүүдэнд үзэгдсэн эмгэн удган юм уу гэтэл бас биш ээ.Харь маягийн навсгар хар хувцастай байсан. Одоо бодоход монголоор ч яриагүй мэт бодогдох юм.

-Ахайтаан, таныг 15 хүрэхэд бүгдээр Астрахань явсныг санаж байна уу?Тэгэхэд үнэн алдартны цогчин сүмийн өмнөх талбайд цыган омгийнхон гэж навсгар тэнэмэл улсын дундаас нэг хижээл эмэгтэй гүйж ирээд таны алганы хээг хараад “Холын холд бэр болон одож, олон малтай язгуур угсаа өндөр хүний хатан болно” гэж байтал таны эх ахайтан ирээд сэжиглэн цээрлэж “зоос өгөөд явуул” гэж тушаагаад явуулсан шүү дээ. Харь хувцастай гэвэл тийм мэргэч цыган эмгэн л байх аа даа.

-Энэ тэгээд сайны билэг үү, муугийн ёр уу?

-Та хоёр ч сайхан нуган үр төрүүлсэн хүн.Одоо охинтой болоход юуны муу гэж? Тан шиг сайхан охин төрнө байлгүй дээ.Аль эсвэл тэр жил алдсан охин тань ижийдээ эргэж заяасан ч юм бил үү?

-Тийм ч юм уу? Охин минь нээрээ л ижидээ эргэж төрж байгаа байх нь гээд хатгамаллаж байсан тамхины уугаа авлаа.

-Ахайтаан, та юм оёхоо багасга даа. Ууц нуруугаар тань чилнэ.

-За тийм дээ. Агтны тэндээс хөвгүүдээс минь хэл чимээ байна уу?

-Байгаа. Галдмаа хүү тань эмнэг цаламдахдаа агтны эрсийг хэдийнээ ардаа орхиж урдуураа улаан хөлтөн гишгүүлэхгүй байгаа гэнэ. Удахгүй Ойрад даяар шуугиулсан баатар болох бий дээ. Харж байгаарай хэмээхэд нь Доржравдан жавжиндаа бардам инээмсэглэл тодруулан шанхны зүүлтээ оролдлоо.

Түүнийг хатан болж ирэхээс өмнө их хатан Цэвээн хоёр хүү төрүүлсэн ч, Гартангомбо бие сул дорой, нөгөө Эрдэнэ тайж нь цэргийн эрдэмд муугүй ч номын ухаанд мөхөс билээ. Тэгвэл азаар Доржравдангийн төрүүлсэн ууган хүү Галдамаа хүү өдгөө дөнгөж нас арван наймтай ч ухаан хурц, эр зориг баатарлагаараа хавь ойрд цууд гараад байгаа билээ.

## Хоёрдугаар бүлэг

Очирт цэцэн хан аянд явахдаа хатантайгаа нэгэн ижил зүүд үзсэнээс хойш даруй хоёр сарын хугацаа нисэх мэт өнгөрч Хөх нуурын тийш Дөрвөн Ойрадын ноёдын их чуулганд мордсон эзгүй үеэр нь Доржравдан хатан нярайлахаар өвдлөө.

Энэ өргөөний хатад, эхнэрүүдийн хөнгөрөхдөө домнодог үс нь халцарсан баавгайн сарвууг хараад инээж суусан хан Түшээт ханы нутаг руу захиж байж аварга том маахайн бүтэн арьс авчруулж хайртай хатандаа баруун сарвууг нь өгчилгөсөн билээ. Доржравдан нөхрөө чуулганд мордохынх нь урьд орой хар, цагаан мөөг дэвтгээж амтлан хонины гуя хярж хийсэн сайхан хар шөл хийлгэж өгөөд, цээжинд нь муур мэт эрхлэн наалдаад:

-Та намайг амаржихад дэргэд байхгүй нь юутай тоогүй хэрэг вэ! Гэсэн ч Ойрадын чуулганы тэргүүн талбих төрийн чухал хэргийг хэрхэн хойшлуулах билээ? Таныгаа дэргэд байгаа хэмээн бодож, авчруулсан баавгайн сарвуугаар тань хэвлийгээ домнон байж эсэн мэнд амаржаад мантгар цагаан хүү тэврээд хүлээж байя даа гэснээ:

-Та минь одоо Нурангийн өргөөнд морилж хоно доо. Бие давхар надтай удаан саатаад юун хэмээн “хэрсүү” аашлахаа умартсангүй.

-Чи минь ийм л ухаан сийрэг, эелдэг наалинхай болохоор яахин чамайгаа гомдоох билээ? гэж хантан уяран хэлээд урт сайхан гээгнийх нь үзүүр дэх жингэнэсэн мөнгөн оосроор оролдон:

-Би нас ахисан хүн. Өнөөхөн бага хатны өргөөнд хоноглох хүсэл үнэндээ алга. Бага залуу үеийнх шиг үүл борооны явдлаар хэрхэн өдөр өнжилгүй хөөцөлдөх билээ? гэв.

-Гэхдээ л та чинь эр хүн шүү дээ. Ингэхэд би бүдүүрээд муухай болж байна уу?

-Яалаа гэж дээ. Миний үрийг тээж буй болохоор улам л өнгөлөг харагдаж байна. Хөнгөрснийхөө дараа хэдхэн сар болоод л хоёр гараар атгаж болом тасам нарийхан бэлхүүстэй болдог шүү дээ чи минь.

-Та надаас охин, хүү аль нь төрнө гэж бодно?

-Охин төрвөл Ану гэж нэрлэнэ дээ.

-Хэн гэнээ? Та охин гэж яаж мэдээ вэ?

-Тэр нууц аа хэмээгээд хүд хүд инээв.

-Мандухай цэцэн хатан Батмөнх даян хаанд биеэ тушаахдаа эзэн Чингисийн найман цагаан ордны өмнө даатгаж залбираад үрийн хутаг гуйхдаа:

Эрхт хаан эцэг минь

Эш хатан эх минь

Дотоод энгэрт минь

Долоон хөвгүүн төрүүл

Гадаад энгэрт минь

Ганц охин төрүүл

Доорд хатан надад

Долоон нуган заяаваас

Долууланд нь Болд нэр өгч

Гал голомтыг тань сахиулья

Газар нутгийг тань эзлүүлье гэсэн юм гэнэ лээ.

Түүн шиг би танд хоёр хүү, ганц сайхан охин төрүүлж өгье гэж Очирваань сахиусандаа залбирсан юм аа гээд жиг жигхийн инээлээ.

Энэ үгийг сонсоод Очирт цэцэн хан дотроо “Хөвгүүд олон байх нь хүчирхэг сайхан ч, эцэст нь эцгийн ор булаалдан тэмцэлдэх нь хэцүү юм даа” гэж бодохдоо хоёрхон сарын өмнө очоод эгж ирсэн Баатар хунтайжийн орд өргөөн дэх хатад, хөвгүүдийн сөргөлдөөнийг санан дурсаж билээ.

Гучин долооны жилдээ хөнгөрөх гэж буй хайртай хатандаа санаа зовон зовон Дөрвөн Ойрадын чуулганд мордсон Очирт цэцэн ханыг явснаас хойш Доржравдан өдөр өдрөөр томрох гэдсэндээ түүртэн хүүхдээ бушуу төрөөсэй хэмээн хоног тоолон хүлээж байлаа.

Шөнө бүр зүүдэнд нь хан эцгээ өвчсөн мэт жирэвгэр хар хөмсөг, эргэлдсэн алаг нүдтэй хар даахьтай бяцхан охин саамшин чинэрсэн хөхөө амлаж байгаагаар үзэгдэнэ. Тэгээд шөнө дунд, үүр цүүрээр сэрэх бүрдээ нөгөө чуулган нь хурдан дуусаад амраг хар хүн нь ирж явах вий дээ хэмээн морин туурай чагнан сэрвэлзэнэ.

Гэвч хэдэн өртөө хол газар ноёдын чуулганд одсон эр нөхөр нь ирж амжсангүй.

Хатныг зуны дунд сарын дундуур дуншина хэмээн таамагласан Жаал хэмээх эмгэн бариачийн хэлснээр болж тэр л хугацаандаа бага үдэд нярайлахаар өвджээ. Доржравдан хатан гэдэс нь урьд урьдынхаас илүү томроод хөдөлгөөн багадаад байх шиг санагдахаар нь саахалтын зайд буусан үхэрчин хэдэн өрхөөр орж хэнз тугал өхөөрдөж зогстол нуруугаар нь хатган дуншиж эхэлжээ. Ер нь хатантан төрөх дөхөх тусмаа сэтгэл зөөлрөн нялх хурга, тугал ч өхөөрдөм санагдан, урьд загнаж зандарч байсан зарц шивэгчингүүдэд өглөг хайрлан, өргөөний барлаг айлуудын хүүхэд багачуулд чихэртэй хурууд, самнаа боов атгаар нь тарааж, хийснийг нь ихэвчлэн голж байдаг Үзмээ шивэгчиндээ ч урмын үг хэлэх болоод байсан билээ.

Дунд ахайтан нярайлахаар өвдөв хэмээн дуулмагц эр нөхөртэйгээ нэгэн оронд орохоо болино,

хорвоогийн явдлаас ангижраад сахил хүртээгүй л болохоос хуучны ховор эдлэл мэт болж өргөөндөө эрхий эргүүлэн суудаг болсон их хатан Цэвээн эрхбиш сандран зарц шивэгчдийг “бушуу бушуу” хэмээн зандран хөл болов. Харин тугал хар нүд эргэлдүүлсэн бага хатан Нуран Доржравдангийн өргөөний үүдэнд ирж “Яаж байна? Амар жимэр хөнгөрөөсэй билээ” хэмээн хамар дороо шивнээд гэр рүүгээ буцав.

Доржравдангийн найман ханат уужим саруул өргөөний зүүн орыг гэрээс гарган зайчилж өтөг бууц дэвсэн хоёр том сэгс\* дунд суулган чихнээс нь хүнд алтан ээмэг, гарынх нь олон бөгжнүүд, хоёр бугуйнд нь байдаг могойн толгойт алтан бугуйвчнуудыг тайлан авч, Жангараг шивэгчин араас нь тэврэн суухдаа хантаны өгсөн баавгайн сарвуугаар хэвлийг нь домнон байлаа. Монгол ёсонд хуруу, бугуй, чихэнд зүүсэн ээмэг, бөгж нь хүүхдийн доошлох замд эхийн цусыг нь боодог гэж үздэг билээ. Бага хатан өнгөрсөн жил нь ураг зулбаснаас санаа аван насны эцэст олдсон үрээ алдахаас эмээн болгоомжлохдоо хатантан сүүлийн хоёр сар өргөөнөөсөө барагтай гараагүйгээс болж хүүхэд нь хэвлийдээ их мяраалсан бололтой.

Туршлагатай эх баригч Жаал эмгэн хэвлийг нь доош нь илэн булчингуудыг нь сулруулангаа:

-Ахайтан минь, өргөөнийхөө ойр зуур хөдөлж л байхгүй дээ. Хүүхэд тань хэвлийдээ их мяраалсан байна. Амьсгаагаа гүнзгийхэн аваад эцээхэн дүлээрэй. Ураг бүтэх вий хэмээн аргадангуй ярина.

Зуны дунд сарын арваны нохой гаслам халуун өдөр таарчээ. Хаяа нь шуулттай гэрт пүү гэх салхи ч үл орно. Гадаа гэртгүй хаваржин шуурч, хавийн элс, шороог тэнгэрт гартал үлээдэг улаан галзуу салхи нь хаачив? гэмээр.

Салхи илүү нэвтрэх буй за хэмээн Жангараг бүсгүйн эзэн ахайтандаа өмсгөсөн нимгэн дурдан лавшиг нэвтэртэл хөлөрсөн хатан чимээгүйхэн ёолон гиншинэ. Гэрийн үүдэнд дээс татан хөл хориод бариач эмгэн, Жангараг шивэгчнээс бусад хэнийг ч үл ойртуулна.

-Сайн дүлээрэй ахайтан минь! Ганц ёо гэх хүчээ ч гамнан дүлж үз хэмээн бариач шавдуулна.

Хатны хоёр салаа гэзэг нь эзэнгүй мэт мөрөн дээгүүрээ унжаад, өргөн духыг нь дагаж хөлсөн дусал ар араасаа бөнжигнөн урсаж, хуруугаа хөдөлгөх тамиргүй болсон ч хар багаасаа морин дэл дээр хийсэн давхисан монгол бүсгүйн өгүүлшгүй их тэвчээр зааж хөмхий зуун дүлсээр байлаа.

-Ахтайтанд уух юм өг! гэсэн эх баригч эмгэний захирангуй дуунаар өргөөний тоос шороог арчин нааш цааш хөлхөж асан Жангараг цочин ухасхийж хүйтэн чигээ хийж өглөө.

Түрүүхэн л хуруугаа ч хөдөлгөх тэнхээгүй мэт тамир дорой үзэгдэж байсан хатан дунд гарын мөнгөн тагштай чигээг нэгэн амьсгаагаар залгилаад:

-Жаал эгч минь, одоо хоёр яс салах ойртож байна уу? хэмээн цовоолгоор асуулаа. Бариач эмгэн:

-Юмгүй дээ. Ахайтан минь, хүүхдийн толгой хариугүй цухуйх гээд байна. Одоо ганцхан сайн

дүлчихвэл хэмээн түмэн үрчлээт нүүрэндээ эелдэг дулаан инээмсэглэл тодруулан хэлээд малын өтөг бууц, хөрзөн арилгах хар бор ажлын хаагуур нь өнгөрснийг нь гайхмаар эвдрээгүй, жижигхэн атал бядтай гараар хэвлийг нь эвлэгхэн илж өгч байлаа. Хорвоод ирэх хэмээн яаран зүтгэлэх нялх үр эхийнхээ амин голыг тэмтчин туулах мэт тэсэхийн эрхгүй өвтгөсөөр байлаа. Эцсийн мөч ирэв бололтой. Хатан, хэвлийг нь баавгайн савраар илэн домнож зогссон Үзмээ шивэгчнийхээ нарийхан цагаан бугуйнаас хурц хумстай савхан хуруунуудаараа тас зуурч:

-Хөх тэнгэр! хэмээн уулга алдтал:

Эх баригчийн гар дээр тас хар даахьтай бяцхан амьтан сарвалзан ойчоод эрдүү хонгор дуугаар часхийн чарлахад эх нь хөлсөнд норсон толгойгоо том араг налуулан унаад шивэгчнийхээ бугуйг тавьж, нүдээ анингаа:

-Буга намнагч уу, булга зүйгээч үү? гэж асуух хэмжээний тэнхээтэй үлдсэн байлаа.

-Охин. Сүрхий эр хонгор дуутай, хөрс, үс сайтай гэж гайхмаар амьтан юм. Ахайтан таныг дууриасан сар шиг сайхан авхай болж гоо үзэмжээрээ халх, Ойрадад цууд гарах байлгүй хэмээн Жаал эмгэн ярингаа хүүхдийн хүйг сурмаг гэгч нь тасалж, бэлтгэж тавьсан хонины шөлөөр угааж торго мэт зөөлөртөл элдсэн хурганы арьсаар боолоо. Баруун бугуй нь хатны бядтай жижигхэн гарын атгалтанд хөхөрч, хурц хумсанд нь хэгз татуулсан ч Үзмээ бүсгүй амандаа “Ээ гялай ахайтан минь” хэмээн шивнээд баруун орон дээрээс цасан цагаан пансан алчуур авчран хөлөрсөн духыг нь даран боолоо. Гэрт бөөн хөл үймээн эхлэв.

Монгол заншлаар “төрөөгүй хүүхдэд төмөр өлгий” гээд шинэ хүн мэндлэхийн өмнө ямарваа нэгэн бэлтгэл хийдэггүй ч овсгоо сэргэлэн Жангараг бүсгүй эзэн ахайтандаа мэдэгдэлгүй эчнээгээр торго шиг элдсэн хурганы арьс, илэг мэт зөөлөн нэхий хошоодыг зэхэн хөлийн авдарт нь хийсэн байжээ.

- Үзмээ ороод ир. Ахайтанг оронд нь залж хэвтүүл. Алив Жавзан өтөг бууцыг эндээс зайлуулж өргөөг тохинуул хэмээн Жангараг аягач, шивэгчингүүдийг захиран тушаал буулгав.

Энэ үеэр өргөөний өмнөд дэх онь хөтлийн тэндээс олон морьтны газар бөмбөрдөх мэт туурайн төвөргөөн сонсогдоход сая амаржсан хатны цонхигор царайд баярын туяа татаж:

-Хан эзэн минь айсуй гээд сулхан инээмсэглэж билээ.

Өргөөнийхөн эзэн айсуйг үзээд хөл үймээн бүүр ч ихсэв. Энд ч хатанд шөл уулгахаар муулсан шар халзан хонины гэдэс цэвэрлэн, тэнд ч толгой шийрийг нь хуйхлан хиншүү талбин, хоолны гэрт эзний цайг чанан, зоог шүүс бэлтгэх хүмүүс үймэлдэж байх үеэр уяан дээр гал шарга мориноосоо дөнгөж буусан Очирт цэцэн хан ойртож ирсэн хөгшин хиагийн мэндийн хариуд:

-Ахайтан амар жимэр хөнгөрөв үү? гэсэн асуулт тавиад хариулахаас нь урьтаж:

-Хүү юу, хүүхэн үү? гэж асуулаа.

-Ахайтан дөнгөж түрүүхэн хөнгөрч булга зүйгээч бяцхан авхай төрүүллээ,эзэнтээн гэнгүүт алсын аяны тоос дарсан хүрэн царайд нь баярын инээмсэглэл тодорч,Доржравдан хатны өргөө рүү хол хол алхлан явах зуур:

-Аавыгаа Дөрвөн Ойрадын чуулганыг дангаараа тэргүүлэх болоод ирэхэд сүр сүлд,аз хийморийг минь мялаан төрж байгаа охин юм болов уу даа хэмээн бодоод амандаа”Ану” хэмээн шивнэж явлаа.

Ханыг өргөөнд орж ирэхэд амаржсан эх шинэ шөл уун, дэргэд нь өргөн магнайтай манхайсан охин цагаан хурганы арьсан өлгийдөө үнэгчлэн нойрсч байлаа. Эр нөхрөө хараад хатны төдий л томгүй бүйлс хэлбэрт галтай хар нүдэнд баярын оч харваж тохой дээрээ өндийж ирээд:

-Та минь аян зандаа сайн явж ирэв үү? Морин төвөргөөний чимээг тань анирдаад сэтгэл минь баяраар гийлээ хэмээн мишээлээ.

-Сайн явж ирлээ.Чамайгаа хэрхэн амаржиж байгаа бол хэмээн гэр рүүгээ яарч зогсолтгүй довтолгосоор ирсэн ч хөнгөрөхөөс тань өмнө хараахан амжсангүй. За бие тань яаж байна? Шинэ хүн их уйлж байна уу? хэмээгээд зулайнаасаа салхи авахаас сэрэмжлэн цагаан дурдан алчуур ороосон духных нь дээгүүр үсийг нь үнэрлээд эхийнхээ хажууд тайван нойрсох тохойн чинээхэн амьтныг энхрийлэн харахдаа зүүн хөмсгөө өргөн духаа атируулав. Өөрийг нь явахад огт байгаагүй нэгэн халуун амь өлгийдөө үнэгчлэн буйг хараад эр амьтны зөн сэргэж өрөвдөх, энэ арчаагүй жаахан амьтан миний мах цусны тасархай шүү дээ хэмээн бодохоор өршөөлгүй хатуу ерөнцийн аюул бүхнээс үрээ харамлах хөндүүр зүрхийг агшаах ажээ. Манцуйтай охин руугаа нэг, эр нөхрийнхөө царай руу нэг ээлжлэн харж, эрхлэнгүй, басхүү дөнгөж төрсөн эхэд л мэдрэгддэг ертөнцийг гартаа оруулсан мэт эрхшээх байдлаар ялдамхан мишээсэн хатан бядтай гар дээрээ хөнгөхөн өндийж:

-Миний бие сайн.Охин их тайван хүүхэд юм.Таныг дууриасан их өтгөн хөмсөгтэй , уужим магнайтай. Бас тан шиг зүүн хөмсгөө өргөж харна гээч. Та хараач гээд хурган манцуйтай жаахан амьтныг өргөж эцэгт нь харуулахад охин эвшээн нүдээ бяцхан нээгээд яг эцэг шигээ зүүн хөмсгөө өргөснөө эргээд унтчихав. Энэ нялзрай амьтан яг л өөрийнх нь амьд хуулбар мэт зүүн хөмсгөө хүртэл өргөж буйг хараад хан хачин ихээр уярч өөрийн мэдэлгүй өрөөсөн өвдөг дээрээ бохирон суугаад гар сунган хүүхдийн өөдөсхөн биеийг эхээс нь болгоомжтой гэгч нь авлаа.

-Тийм юм. Уужим магнайтай бол ухаантай хүн болно доо гэж хан өхөөрдөнгүй хэлээд, өчүүхэн улаан магнай дээр нь үнэрлэсэн ч “Энэ тохойн чинээхэн ягаан амьтан хэзээ хүн болно доо” хэмээн өр зүрх нь шимширч билээ.

Ийнхүү Алшаагийн их элсэн дунд эртний хошууд овгийн ихэс Очирт цэцэн ханы өргөөнд нэгэн шинэ хүн мэндэлж, угсаа язгуур өндөр эцэг нь зүүн чихэнд нь “Ану” хэмээн гурвантаа шивнэсэн нь хожмоо Зүүнгарын Галдан бошгит хааны хатан болж домог түүхэнд мөнхрөн үлдэх хувьтай охин байлуга.

Анугийн эцэг Очирт цэцэн хан нь Эрдэнэ баатар хунтайжийг тэнгэрт хальсаны дараа



хошууд, чорос, торгууд, дөрвөд, хойд, өөлдийн ноёдыг нэгтгэсэн Дөрвөн Ойрадын чуулганыг ганцаар тэргүүлэх болсон юм. Охин мэндэлснээс хойш гурав хоногийн дараа Зая Бандид Намхайжамцын илгээсэн эрдэмт гурван лам ирцгээж, нярай охины төрсөн өдрийн төөрөг, гарсан өдрийн гаригийг шинжин, ад зэтгэр, хар цагаан хэл амыг зайлуулах ном уншиж, ариун номын үсэг бүхий сахиус зүүж өгсөний дараа угаалгын найр эхлэв.

Очирт цэцэн ханы ёслолын их өргөөний өмнөх морины уяа хол ойрын гийчдийн хүлэг морьдоор дүүрч, хонины чанасан бүхэл мах, самнаа боов, урд зүгээс авчирсан амтат еэвэн, мөсөн чихэр, ааруул, хурууд өрсөн тавагнуудаар ширээ дүүргэж, линхуа цэцгэн чимэгтэй ижилхэн их ваарнуудад айраг чигээ сөгнөж хоймортоо заларсан Дөрвөн Ойрадын чуулганы тэргүүн Очирт цэцэн хан :

-Миний хатан Доржравдангаас охин төрж Ану хэмээх чихэнд сонсголонтой, цээжлэхэд амар нэр хайрлаж, угаалгын найрыг хийх гэж байна. Энэ найраа манай хошуудын цуутай Чойров дуучнаар эхлүүлье! хэмээжүхүй.

Ойрад түмэн үрс гаргах, хүүхэд угаах, шинэ гэрийн найрыг “Нарийн баахан шарга” дуугаар эхлүүлдэг эртний заншлаар Чойров хэмээх эр дунд насны эр босч дунд гарын мөнгөн аягатай архиа барьж байгаад энгүй уудам тал дунд задарсан цээл сайхан хоолойгоор:

Нарийн баахан шаргыг

Амыг нь татаад мордоно

Насанд санасан үйлийг

Номын ёсоор бүтээгийг

Алтан бумбатаа аршааг

Амыг нь дүүрэн байлгыг

Мөнгөн бумбатаа рашааныг

Мөнкөт дүүрэн байлгыг

Мөнкөд санасан үйлийг

Номын ёсоор бүтээгийг

Хазаартайхан байлгыг

Харь хол нутаг

Харьд санасан үйлийг

Номын ёсоор бүтээгийг

Тохомтаахаан байлгыг

Торигор хол нутаг

Тонкинд санасан үйлийг

Номын ёсоор бүтээгийг...

хэмээн хүнгэнүүлэн дуулж ая барилаа.

Хан эзнийхээ хажууд, өлзий хээтэй цэнхэр хоргой цэгдэг, ягаан дурдан лавшиг өмсч, хатан хүний ёслолын малгай асаагаад, хоёр шанх дагуулан зургаан эгнээ сувдан чимэглэл унжуулсан Доржравдан хатан өвлийн тэнгэрт наадах од мэт жижиг хар нүдээ гялалзуулан сууснаа “торигор хол нутаг...” хэмээх бадгийг сонсоод, алс тэртээх Ижил мөрний газар хоцорсон эцгийн гэр, охин хонгор нас, анхны дурлалын эзэн хасаг угсааны сайхан эрийг санан дурсч, харц нь бүүдийн гуниг хураад явчихсан ч сэтгэлийн зүдгүүрийг өнгөний инээмсэглэлээр далдалж сурснаараа жижиг цагаан шүдээ яралзуулан сайхан инээмсэглэн сууж байлаа. Тэрээр сар гаруйхны өмнө их гэдэстэй байсны ором ч үгүй тасам нарийхан бэлхүүсээ туялзуулах нь хэдий гуч хол гарсан ч өдгөө эрчүүдийн харц булаан гунхалзах залуугийн үзэсгэлэн гундах болоогүй харагдана. Ингэж гоо үзэсгэлэн, бие галбирын сайхнаа хадгалахын тулд нярайлаад арав ч өнжилгүй арван хоёр алд гяраг бүсээр гурван шивэгчинтэй хамжиж дэмжин байж гэдэс бэлхүүсээ амьсгал авах аргагүй шахам болтол тасартал ороон дарсаар, бүсгүй хүний гараар хэмжвэл гурван төөгөөс үл хэтрэхээр нарийхан болгодгийг нь өөрийнх нь өргөөний шадар хэдэн шивэгчнээс бусад хэн ч үл мэднэ. Баруун гарынх нь ядам хуруунд болжморын өндгөн чинээ том доржпалам шигтгээт бөгж гэрэл ойлгон гялалзана. Өдөр нартайд харахул хөх ягаан өнгөөр үзэсгэлэнтэйгээ гялалзаж, үдэш дэнгийн сүүмэн гэрэлд бүдэг саарал болон өнгөө хувиргагч ийм чулуун бэлзэгийг хээр талын нүүдэлчдийн язгуур угсаатан авхай нар төдийлөн дурлаж зүүдэггүй ч Доржравдан ахайтан алс тэртээ Орос нутгийн гүнд өнгөрүүлсэн бага залуу насандаа тэндхийн ёс заншил, язгууртан дээдсийнх нь соёлд нэлээд нэвтэрч, орос авхай нарын гоёл зүүсгэлийн үнэ цэнийг мэддэг болсных индранил, доржпалам чулуунд онц ихээр дурладаг ажгуу. Суурь хонины үнэтэй энэ эрхийн чинээ чулуу өөрийнх нь төрсөн гариг одонд ээлтэй, үүнийг л биедээ зүүж явбал газардахгүй хэмээн эх нь захижээ.

Очирт цэцэн ханы охины угаалгын найранд саяхан бие барсан Баатар хунтайжийнхнаас бусад Ойрадын ихэс ноёд бараглан цугаар ирж хүндэтгэл үзүүлсний дотор ахтайгаа эв эвдрэлцсэн Аблай тайш ч их хатнаа дагуулж сартай усан жороо морь ижилсүүлэн унаж, морилон ирсэн нь магнай тэнийм сайхан явдал байлаа.

-Ах та, Дөрвөн Ойрадын чуулганы тэргүүн өргөмжлөгдсөн нь манай хошууд аймгийн сүр сүлд ивээсэн сайхан явдал болсны хажуугаар эрүүл энх бяцхан охин үр тэвэрсэн давхар баяр тохиож байхад угаалгын найранд нь би вээр биеэр хүрэлцэн ирэлгүй яахин болох билээ хэмээн Аблай тайш өглөө ирэхдээ өчиж билээ.

-Танай шандын баян бүрдээр зуншлага сайхан уу? Адуу мал тарган тавтай байна уу? хэмээн эзэн ихэс хүний намба хадгалан мэнд мэдэх Очирт цэцэн хан дотроо

“Ах дүүгийн эв эе энэ чигээрээ байвал юутай сайхан. Тэр жил хасагийн ханыг цохиход дугтрах хүчээ нэгтгэн оролцсоноос хойш эцгийн өмч хөрөнгө, эрх мэдлийг булаалдан Хөндлөн Увштай хавсран тэмцэлдээд нүүр буруулсан Аблай өнөөдөртөө надтай сайн харилцаа эхлүүлэх мэт охины минь угаалгын найранд ирж л байна. Маргааш энэ хэвээрээ байх эсэхийг тэнгэр л мэдэх. Энэ мэтээр зулай зулайгаа гишгэчин төрсөн ах дүүс эвдрэлцээд байхад Халх, Ойрадын эв нэгдлийг хадгалах ч санаан зоргоор болгох үйл биш юм даа...” хэмээн бодож байлаа. Харин Аблай тайшийн их хатан Хөх нуурын хохь тайж гаралтай, тавь шахам насны овор бүдүүн биетэй Жавзандулам ойрын хэдэн жил айлчлан ирээгүй хадам ахын өргөөний тавилга засал, хатад эмсийн гоёлыг гярхай харцтай зууван нүдээр ажин, амгалан, сайн сэтгэлт хүний найртай инээдээр хавай цагаан шүд яралзуулан инээмсэглэх авч дотроо”Цэвээн эгч хэчнээн их өтлөө вэ? Энэ Доржравдан хатан тэр жил хасагийн хантай дайтсаны дараа уулзсанаас хойш огтхон ч оворжиж өтлөөгүй, саявтархан буулгаж авчирсан залуухан хотон бүсгүйгээс дутахгүй гялалзаж байх шив дээ. Хөнгөрөөд удаагүй гэхэд галбираа хэрхэн ингэж хадгалдаг байнаа? Наалинхай зангаар халхавчилсан овтой эм юм даа” хэмээн бодож байв.

Өглөө наран мандахад “Нарийн баахан шарга”-аар эхэлсэн хүүхдийн угаалгын найр наран гудайхад “Урт сайхан хүрэн” хэмээх найр жаргаах дуугаар өндөрлөвэй.

“Урт сайхан хүрэн

Уужмын тааваар гишгэдэлтэй.

Уйдашгүй ах та нарам

Өргөөгөө дүүрээд үлнэ

Алтан шаргаан хөлөглөнө

Алтан эмээлээн тохно

Ар монголын каа нар

Аркитай дарстай сөкөрнө

Маннаг сайхан күрэндээн

Манк эмээл тохно

Манж монголын каа нар

Арьитай дарстай сөкөрнө...

Найр өндөрлөж, зочид тал бүр тийш таран одоцгоов.

-Баатар хунтайжийг насан хутаг болоход дүү чи юуны учир хойлгийн ёслолд үзэгдсэнгүйв? Далай тайш, Хөндлөн увш, Хойдын Сүлдэн тайш цөм хүрэлцэн ирцгээсэн шүү дээ. Зая

бандид багшгантай золгож, авралд нь багтан ном айлдуулсан бол танайханд хэрэгтэй л байсан юм даа хэмээн ахыгаа зэмлэнгүй өчихөд Сэнгээс илүү үг, санаа нийлдэг Цэцэн тайжид хунтайжийн төрийн ор залгуулахыг дэмжиж байсны учир зориуд очоогүйгээ хаацайлан:

-Тэр үеэр би баахан бие чилүүр байснаа элч довтолгон талийгчийн хатан, хөвүүдэд дуулгасан шүү дээ. Хоёр тайж хэмээн Зүүнгарыг төвшитгөж явсан анд тань бие барлаа. Ах та бас биеэ бодож яваарай. Гэвч өдий насандаа үрийн зулай үнэрлэж буйг бодоход та биеийн чалх тэнхээ сайн байгаа юм байна гээд Аблай соёо сахлаа шувтарсан нь ахыгаа өтөл насандаа ийнхүү үр үнэрлэн чалх сайтай, өнгө жавхаатай байж, эрх мэдэл, сүр хүчээ мөд алдах шинжгүйд баахан сэтгэл гонсгор байгаа мэт харагдсан ажгуу. Очирт цэцэн хан уяан дээрээ гарч ирэн дагуул, албат нарын хамт гэрийн зүг мордох гэж буй Аблай тайшийг үдэн өгөхдөө:

-За дүү минь намар үрсийн баяраар манайд ирээрэй! Цус элгэн нэгтэй зулай зулайгаа гишгэн төрсөн ахан дүүс эцгийн захиснаар атгасан гар, хураасан шагай мэт дуугарвал дуу, дугтарвал хүч нэгтэй явах юм сан гэж мунхаглах юм хэмээгээд үдэн мордуулжээ.

Доржравдан хатан ч эр нөхрөө дүүтэйгээ эв сайтай байлгахад хүчээ нэгтгэх санаатай Жавзандулам хатныг нь өргөөндөө урьж дайлан, хойд зүгийн хээнцэр баглаатай амтат бурам, төвд хоргойгоор бэлэг барин “Ахан дүүсийн авьсан, ажин болсон хувь төөргийг хүндэтгэж танд ямагт сайныг хүсч явдгийг бүү мартаарай! Ану охины минь угаалгад морилон ирснийг тань би насан элтэл үл мартана. Хэрэв Аблай тайш цаашид ахтайгаа эвтэй, хатгалдах дайсны өмнөөс хүчин хавсарч явах юм бол хэн хэнд маань өлзийтэй байх сан” гэх зэргээр уярам сайхан үг хэлэхэд, Жавзандулам хатан хэдий дотроо нас үе ойролцоо Цэвээн хатанд илүү талтай явдаг ч, нутаг хошуу алсаас ирсэн, хоёулаа л хошуудын бэрүүд учир эгч дүүс мэт эв найртай явахыг бодох нь зүй хэмээн найртай үгээр хариу барилцан нэгэн оройг их л сайхан өнгөрүүлж билээ.

Хошууд овогтон нь Эзэн Чингис хааны дүү хавт Хасарын үр сад, боржигин удамтай хэмээн түүх шастирт тэмдэглэжээ. Хошууд хэмээхүйн учир нь эзэн Чингисийн өмнө зүгт хийсэн аян дайны цаг дор хос морь хөлөглөн их цэргийн түрүүнд хошуучлан явсан тул хошууч гэгдэх болсон гэдэг.

Доржравдан хатан төдий л зүдрэлгүй амаржсан ч хөхөнд нь сүү орсонгүй. Тэгээд ч цагаан яст язгуур угсаатай ахайтнуудын уламжлалаар гурван сарын өмнө хөнгөрч, хүү төрүүлсэн хоньчин Ханджав бүсгүйг авчран нялзрай Ану охины өрлөг эх болгожээ. Зуны дунд сарын арван тавны билэгт сайн өдөр төрсөн Ану охиныг гурван сар хүрч, эхийгээ танин маасайн инээх болж ид өхөөрдөм дээрээ байхад нь Очирт цэцэн ханых намаржаа руугаа нүүж үрсийн баяр хийжээ.

Нар хур тэгширсэн сайхан өдөр болсон үрсийн баяр дээр нь заавал морилон ирнэ хэмээн ам өгөөд мордсон Аблай тайш ирсэнгүй нь ханы сэтгэлд сэв оруулан сэрүүн салхиар үлээх мэт муу зөн татуулав.

Тэр жил бороо зүсрэн, завсар чөлөөгөөр нь наран ээж, солонго татсан сайхан зун болж, говьд намар оройтон, ханы зусдаг Хонгорын баян бүрдэд намрын эхэн сард хэнзэлсэн яргуй нүдлэн,

хүн малын диваажин гэмээр сайхан байлуга. Энэ үеэр цастын оронд ном үзэж, шавилан суугаа Галдан хүүгээ эргэхээр холыг зорьсон Юм-Агас хатан тэднийхээр хоноглон хүн, хөсгөө амраагаад мордов.

Тас хар даахьтай, хан эцгийнхээ өтгөн хөмсөг, эхийнхээ жижигхэн атлаа цоглог харцтай, сормуус сайт нүдийг хуулж төрсөн бяцхан Ануг харсан Юм-Агас:

-Охин тань ид өхөөрдөм дээрээ байна даа. Нялх хүүхдийн сүүний үнэрийг ч би бараг мартжээ. Одоо гурван сар өнгөрч байгаа бил үү? гэж асуугаад цэнхэр цэцгэн хээтэй дурдан баривч өмсгөсөн сэгсгэр бяцхан охиныг авч хацар, хүзүүг өхөөрдөн үнэрлэлээ. “Эрээ алдаж бэлбэсрээд, ертөнцийн явдлыг тэвчин, ид насан дээрээ эм хүний бахархал гээг үсээ хусуулчихаад ингэж явах хэчнээн бэрхтэй вэ? Гэтэл эм хүн л болсон хойно эр хүний энхрийлэл, нялх хүүхдийн энгэр тэмтчих хөөрхөн гар, сугсран буух гээг үсээ үгүйдэг л байх даа, очирваань” хэмээн Доржравдан бодсон ч нялх охиноо харамнах сэтгэл төрөн, маасайн инээх бяцхан жаалаа Юм-Агасаас аваад:

-Ижийдээ нар болсон амьтан байхгүй юу, миний охин хэмээн бардмаар, бараг л гайхуулах мэт хэлээд даахийг нь үнэрлэлээ. Хүүхдийг эхэд нь өгчихөөд цай оочилж, нэг л мэдэхэд бодол санаа нь алсад байгаа Галдан хүүгийнхээ тийш оччихсон байсан Юм-Агас мөчөөгөө өгсөнгүй:

-Охин үрийг нүдний цөцгий мэтээр хайрлан хайрлан өсгөчихөөд харьд бэр болгон мордуулдаг нь л хэцүү юм даа. Тийм болохоор би хоёр охиндоо төдийлөн наалддаггүй байсан. Танай энэ хөөрхөн охиныг өсөхөд нь болдогсон бол Галдан хүүдээ авч өгөх юм сан. Даанч миний хүү сахил санваар хүртсэн багш лам болох юм даа гэлээ. Атаархсан сэтгэлээ дарж чадахгүй охин үрийг нь гоочилж буйг анзааран Доржравдан нүүр рүүгээ орж ирсэн шанхны унжуургаа донжтойхон арагшлуулаад:

-Тийм ээ. Охин үрээ хадамд мордуулах амаргүй. Гэвч тэр болтол зай ч байна, лай ч байна. Хантан охиноо их л өндөр язгуурт хүнд өгнө гэж ярьдаг юм. Уг нь ч хошууд, чоросынхон эртнээсээ худ ургийн харилцаатай улс даа. Галдан хүү одоо нас хэдтэй билээ? гэж асуугаад” Охин тань хаан хүний хатан болно” хэмээн зөнч эмгэн зүүдэнд нь ирж хэлсэн тухай дурсан санаж, “Миний охин ч зүгээр л нэг тийш нь хадамд мордуулчихдаг эгэл нэгэн сэвгэр биш. Хаан хүний хатан болох хувьтай, хан эцгийн хайртай охин доо” хэмээн бардамхан бодож байв. Тийнхүү хоёр хатан дотроо бяцхан сөргөлдөөд авсан ч өргөөнөөс барагтай бол холуур одолгүй, тулга тойрон өнгөрдөг бүсгүй хүний ёсоор энэ ертөнцийн хэрэг явдлыг сонордох хүсэл хэчнээн их тул Доржравдан :

-Та аян замд бишгүй их зүдэрч яваа биз. Дэр жинтүү тохойлдоод цай идээнээс зоогло. Ингэхэд, мууд дурлав гэж бүү бодном зай. Тэнгэрт халигч хунтайжаас янагш буруд хатан тэргүүтэй хатад өргөөнөөс буруулан нүүж одсон гэж дуулдах юм. Худал байлгүй дээ, ахайтаан? хэмээн гэмгүй дүр эсгэн асуулаа.

Бодол санаа нь алсад бэлчин дуугүйхэн цай оочилж суусан Юм-Агас энэ асуултанд ялимгүй тулгамдах мэт магнайгаа атируулаад амандаа үлдсэн цайг удаанаар залгиснаа:

-Тийм ээ. Оргүй ч юм биш. Миний хүү Сэнгийг эцгийн ор залгамжилсны дараахан Дарабалж хөвүүдийнхээ хамт голомт тасран, Ховог сайрын цаад руу нүүсээн. Нэгэн эр хүний хатан бололцож туурга тусгаар ч, голомт нэг явснаа бодоод талийгчийн хоног хураатал байж байгаад нүүчихсэн. Бодоод байх нээ өөрийнхөө хүүг ор залгамлуулах хүсэл нь талаар болчоод байхад ханцуйдаа мэс нуучихаад нүүрэн дээрээ хуурмаг инээд наадуулан надтай хамтдаа суусаар байх хэрэг юун.

-Тийм бий. Тэгээд өдгөө Дарабалжаас бусад хатад хамтдаа өргөөлж байгаа юм уу?

-Өнөөхөндөө л тийм буй. Мод хэчнээн аварга ургавч үндсийг нь газрын хөрснөөс таслах юм бол хэрхэн ургаж төлжих билээ? Түүнтэй нэгэн адил энэ өргөө гэрийн үндэс язуур болсон хантан үгүй болсон учир хатад, эмс, хөвүүд нь зүг бүр таран зам, замаа хөөх нь бололтой. Ойрноос дуулдах нь Дарь-Увсалж хатан Ижил мөрний зүг төрхөмдөө эгэж нүүх бодол агуулж буй бодолтой.

-Дарь-Увсалж хатан төдий л гоо бус хэмээн сонссон юм. Би нүүр учирч яваагүй болохоор сураг л сонссоноороо...гээд нарийхан хөмсөг өргөн Юм-Агас руу сэмхэн харав.

-Гайхуулаад байхаар гоо хүүхэн биш ээ. Гэвчиг Хоо өрлөгийн охин шүү дээ. Орос үсэгт тайлагдсан, тод бичгээр гаргачихна. Нэгэнт авсан эр нь үгүй болсон юм чинь дөнгөж гуч гарч яваа залуу бүсгүй, тураг ядрахаар уулаа барааддаг жам ёсоор төрхөмчлөх нь зүй биз ээ.

-Тэр чинь тантай адил сахил санваар хүртчихсэн бус уу? Арай төрхөмдөө очоод дахин эрд гарах гэж байгаа юм биш биз дээ? гэж Доржравдан элдэвт дурлахад өвөр дээр нь дэгж дэрвэж асан бяцхан Ану ухасхийн, урьдах аягатай цайг нь татчихав. Айргийн тос самарсан өтгөн шаргал цай хатны ягаан туяатай шашир хоргой лавшигийн хормой руу урсав.

-Очирваань! Эвий минь, түлэгдчихээ алдлаа. Хөөе Ханджав! Охиныг аваад гар гэж Доржравдан уулгалав. Гаднаас өрлөг эх нь сандран орж ирээд охиныг авах гэтэл тэр жаахан амьтан эхээсээ салахгүй санаатай шанхны сувдан унжуургаас нь татан гэдэсхийлээ. “Хүүе унжуурга таслах нь” хэмээн эх нь сандран хэлээд охиноо яаран өрлөг эхэд өгөхөд Ану дахин ухасхийгээд ээжийнхээ доржпалам гялалзуулсан савхан хуруунаас гогодоод авлаа. Охины ийнхүү аяглахыг ажиглаж суусан Юм-Агас тэсгэлгүй инээд алдчихав. Тэгээд “Ижийгээсээ салахгүй санаатай. Хүүхэд ийм байхдаа салмааргүй хөөрхөн шүү” гэхэд түрүүхэн харцыг нь бүүдийлгэн байсан гуниг хоромхоноо арчигдан харц нь инээмсэглэлээр гэрэлтсэн ч хоёр нүдийг нь тойрсон үрчлээ тодроод ирэх аж. Энгүүн ярьж хөөрч суухад нь үл ажиглагдам атал хөмсгөө өргөх, инээмсэглэхэд нь дух, нүдний эргэн тойрон, жавьжны орчимд нь олон нарийхан нарийхан үрчлээ тодрохыг хараад Доржравдан өөрийн эрхгүй санаа алдан “Хорвоод мөнх юм гэж үгүй юм даа” хэмээн бодсоноо нуух мэт хормой хотоо янзлангаа:

-Пээ, яана. Гэдсэнд байхын хөдөлгөөнтэй, адтай гэж хачин хүүхэд шүү. Бүсгүй хүний намба яаж суулгана. Төрөн төртөл нь нуган ч юм уу гэж андуурдаг байлаа хэмээн охиноо өхөөрдөнө.

Арван найман жилийн өмнө дөнгөж Очирт цэцэн ханы хатан болоод удаагүй байхдаа Лхаст мөргөлөөр одохдоо аяны дөрөө нийлэн явахад дөнгөж хорин дөрөвтэй Юм-Агас нар салхины хаагуур нь явдаг юм бол гэмээр хасын цагаахан царай, махир сэлэм мэт хилэн хар хөмсөг, оч

хаялсан нүдтэй ,дэргэдүүр нь өнгөрсөн бүсгүй хүн хүртэл гоо зүсийг нь харан шагширмаар ганган танхил хатагтай байсан сан. Гэтэл одоо хөгширснийг нь ээ. Мөдхөн өөрөө ч бас түүн шиг хөгширнө. Юм-Агас...Тэр хоёр Дөрвөн Ойрадыг хураан захирсан хоёр хүчирхэг тайжийн хайртай хатад болж, Илийн өвөлжөөнд болсон Ойрадын ноёдын чуулган, хурим найр, Лхасыг зорьсон мөргөлийн замд өөр өөрийн эрээ даган олон удаа хамтдаа аяны дөрөө харшуулан явж билээ. Гэтэл гоо үзэсгэлэн, сүр хүчин төгс, эр нөхрийнхөө хайр энхрийлэлд умбасан тэр сайхан хатнаас өнөөдөр энэ сахил хүртсэн, гуниг хурангуй харцтай, өтөл авгай болон хувираад өөрийн биеийн жаргалыг хэдийн хөсөр, хаяж гагцхүү хөвүүдийнхөө төлөө л хорвоогийн тоосыг хөдөлгөж яваад нь үнэмшмээргүй. Өөрийг нь ч өтөл нас үл тойрно. Тэр цагт гоо үзэсгэлэн төгс явсныг нь эргэн тойрны зарц, шивэгчин, үр хүүхэд,эр нөхөр нь л дурсан санахаас бус ертөнцийн жам хэнийг ч үл өршөөнө гэдэг хэчнээн гунигтай вэ? хэмээн Доржравдан гунихран бодсоор маргааш нь Юм-Агасыг үдэж өгч билээ.

## Гуравдугаар бүлэг

Аргын 1656 оны зун. Ойрадын төрийн тулах хоёр баганын нэгэн болсон Баатар хунтайж тэнгэрт хальсанаас хойш гурван өвлийн цас ханзарч, Очирт цэцэн хан дөрвөн Ойрадын чуулганыг ганцаараа тэргүүлсээр хоёр дахь хавартайгаа золголоо. Халх, Ойрадын хувь заяа хутганы ирэн дээр дэнжигнэж асан энэ хэдэн жилд халхын Засагт хан Субадай, Хошуудын Гүүш хан нар насан эцэслэв.

Баатар хунтайжийг тэнгэрт оршсоноос хойш Ойрадад өмнөдөөс Манж чин улс, зүүн зүгээс Халх, баруун хойд зүгээс Хасагийн аюул улам сэтгэл түгшээх болж, дөчин, дөрвөн хоёрын их цааз мөрдөгдөхөө больж, дөрвөн Ойрадын чуулганы тэргүүний хувьд Очирт цэцэн хэтдээ хэрхэн Ойрадын тусгаар байдал, эв нэгдлийг хадгалан үлдэх тухай бодохул магнайн үрчлээс нэмэгдэхээс цаашгүй.

Хонгорын баян бүрдэд тоорой цэл ногоорон, горхины хөвөөгөөр шар цэцэг хивс мэт дэлгэрч найртай зун хэдийнэ айлчилжээ. Очирт цэцэн ханы өргөө зусландаа гарсан байв.

Доржравдан хатны өргөөний хавиас хүүхдийн ход ход хийсэн цовоо инээд хадаж, өдөрт нь төрийн элдэв хэрэгт сэтгэл чилүүрдсэн хан, үдэш алгасалгүй дунд хатныдаа хоног төөрүүлнэ. Хойдын Сүлдэн тайшийн элчийг хүлээн авч уулзаад ирсэн хан Доржравдан хатны өргөөнд орж:

-Зуны дунд сарын 17-ны билэгт сайн өдөр охины даахийг үргээж болно гэж Зая бандид багштан айлджээ. Өөдөсхөн минь хаана байна? Охиныхоо даахийг нь үнэрлэе. Энэ өргөөнөөс алс ганц хоногоор яваад ирэхээр л охиноо санасан байх юм гээд хаяа нь шуулттай цэлгэр өргөөний хоймрыг эзлэн суулаа. Хоймрын авдраа уудлан торго бөс гарган дэлгэж, шинэ цэгдэг хийлгэх эд сонгож суусан хатан ч эр нөхрөө ирэнгүүт юмаа хумин босоод нүд нь баярлан гийлээ.

-Хөөе Хандаа! Охиныг аваад ир гэж Доржравдан хашгираад өргөөнийхөө шивэгчнийг ч дуудалгүй өөрийн гараар айргийн тос самарсан аагтай шаргал цай аягалан ханд барив.

-Аав аа. Би цэцэг түүсэн, хараач хэмээн бөөн дуу шуу хөл хөгжөөн болсоор гурван настай бяцхан Ану өрлөг эхдээ тэврүүлэн орж ирлээ. Зуны хөнгөн бүрээстэй, ханыг нь мөнгөлж, агар зандан авдрууд, луут хар модон ор тавилсан дунд хатны тансаг засалтай найман ханат их өргөө охиныг ороод ирэнгүүт гэрэл гэгээ нь нэмэгдээд явчих шиг болно.

Их гарын мөнгөн аягаар цай оочилж суусан эцэг нь цайгаа тавиад нүд нь сэргэн:

-Миний жаахан үр аавдаа ир! хэмээн өндөлзөхийг харж суусан Доржравдан “Охиноо үзээд харц нь ямар их баяр хөөртэй болох юм бэ? Гэтэл над руу ингэж гэрэлтсэн харцаар харахаа болиод хэчнээн удаж буй билээ” хэмээн харамлангуй бодлоо.

Охины өтгөн хар даахинаас эцэг нь хээрийн танхил цэцэг, нар салхи, эхийн сүү холилдсон энхэр таатай үнэрийг шуналтайгаар үнэрлээд охиноо өвөр дээрээ суулгалаа.



-Аав аа бос.Гадаа гаръя аа.Морь унаая хэмээн охин эцгийнхээ гараас чангаан хөөрхөнөөр гилжийхэд нь хөлд дэх бойтог, годгор гээгнийх нь мөнгөн боолтонд зүүлттэй хонхнууд эгшиг яруухан жингэнэх ажээ.

-Аав нь цайгаа ууна. Дараа нь морий нь унаарай гэж хатан эх нь охиноо өхөөрдөн хэлэхдээ түрүүхэн охиноосоо эр нөхрөө харамлан сэтгэлийн нүгэл хураасандаа гэмшин инээвхийлээд өрлөг эх рүү нь харцаараа дохилоо.

-Үгүй, аав цай уухгүй. Хоёулаа морь чүү чүү.Даадаа чи яв гэж охин зөрүүдлээд өрлөг эхдээ очсонгүй.

Охины өрлөг эх Ханджав дөнгөж гуч гарч яваа ч сааль сүү, гэр малын барагдашгүй их ажил, ядуу зүдүү амьдралын хүндэд нухлагдан нас хэдтэйг нь гаднаас нь хараад яавч хэлэхэд амаргүй оворжуу үзэгдэх, урт шингэн гээгтэй туранхай горзгор бүсгүй билээ. Энэ бүсгүй арав гаруй жилийн тэртээ хантны шадар хамгаалагч солгой Лувсанхайдавыг дагаж хошуудад ирсэн юм. Аргын 1641 он буюу, могой жилийн зуны дунд сард Халхын Засагт ханы нутагт болсон халх Ойрадын чуулганд очиж явах замд нь зуданд хамаг малаа алдаад өлбөрөхийн ирмэгт байсан энэ бүсгүйг солгой Лувсанхайдав олж дагуулан ирснээр Очирт цэцэн ханы албатуудын дунд нэгэн шинэ өрх галаа асаасан билээ. Түүний халх хийцийн хуучин цэнхэр одончуу тэрлэг нь овоо цэвэрхэн өнгөлөг үзэгдэх нь Ану охины өрлөг эх болсноос хойш гар чанга Доржравдан хатны ивээлд орсны ач билээ.

-Охиндоо сартай хүрэн гүүний шийр цагаан унагыг зүсэлж өгнөө. Хошууддаа л урдуураа улаан хөлтөн оруулахгүй цуутай хурдан морь болно доо. Анхны унага нь миний хатирч хүрэн байгаа юм.Цавчилдахад налж өгөөд л мөн ч ухаантай морь доо. Энэ шийр цагаан ч бас миний хатирч хүрэн шиг эзнээ тулаан дундаас аваад л гардаг сайн хүлэг болох байх гэж ярингаа охиныхоо сонжууг өхөөрдөн илж суухад нь Доржравдан хатан саран хөмсгөө өргөн тохуутай инээмсэглээд:

-Охин минь ямар тан шиг эр хүн биш.Цавчилдахад налж өгдөг, тулаан дундаас эзнээ аваад давхидаг хүлгээр ч яах вэ дээ гэв.

-Сурсан бүхэн эрдэм. Охин минь эр хүний эд юмст таашаалтайг чи ажиглаагүй гэж үү? Аавыгаа харахаараа л морь чүү чүү гэдэг. Аавынхаа сэлэмний бариулаар оролдож, нум сумаар тоглох хэмээн шохоорхох юм. Ирэх жилээс бяцхан хавчаахай нум сум төхөөрч өгдөг хэрэг хэмээн хан хэлээд Ану охины зулайг үнэрлэв.

Тас хар өтгөн даахийг нь хоёр салаа сонжуу болгон мөнгөн хонхтой хоргой боолтоор гоёсон бяцхан Ану эцгийнхээ амин сүнс нь байлаа. Зүүд зөндөө төдийлөн итгэдэггүй, дөрвөн Ойрадын шашны тэргүүн Зая бандид Намхайжамц багштаныхаа айлдварыг хэрэгтэй үедээ л сонсдог, бодол уужуу, дайн тулаанд эрэмгий, аливааг шийдэхдээ номын ухаан гэхээс илүү хар ухаандаа найддаг Очирт цэцэн хан яагаад ч юм, насны бөгсөнд мэндэлсэн энэ жаахан амьтны хойчийг бодохоор л сэтгэл нь юунаас ч илүү хөндүүрлэн, тэртээ гурван жилийн өмнө үзэгдсэн хачирхам зүүдээ хэрхэвч үл мартана.

Харь буруу хувцастай, навсгар удган. “Хан таны гэрт хожмоо хаан хүний хатан болох хувьтай

охин мэндэлнэ. Охин тань хааны хатан болоод оноогдсон насаа гүйцэд элээж үл чадан, хатгалдах дайсны халуун суманд өртөн амь нь тасарч, шашгир түүхэнд нэрээ мөнхлөн үлдээх болно...” Охиноо өвөр дээрээ авч эрхлүүлэн суух энэхэн жаргалтай хоромд өнөөх л зүүд гэнэт бодогдох нь юуных вэ?

Гуравхан настай тоодгорхон Ану охины хувьд аав нь хол ойрын аянаас ирэх, эцэг хүний нар салхи, тамхины бохь, өөр юу ч юм холилдсон сайхан үнэрийг үнэртэн цээжийг нь налах, хэт хутга, хавтага, сэлэмнийх нь бариул мэтийг оролдон тоглох, аавынхаа бядтай гарт дээр дээр өргүүлэн эрхлэх нь ээжийнхээ энгэрт наалдахаас дутахгүй баяр жаргал байлаа. Аав хүн холоос ирдэг. Ээж шиг нь дандаа гэртээ байдаггүй, хаа ч юм нэг газраар яваад гэртээ ирж гэнэт баяр хөөр авчирдаг нь охины балчир оюунд ямар нэгэн ид шидийн мэт гайхамшигтай санагдана. Аавыгаа ирэхэд моринд нь мордон хөтлүүлээд явах нь бас л ер бусын гайхамшиг байв. Аавынхаа зэгзгэр биетэй гал шарга моринд мордонгуут тээр өндрөөс бүхнийг харах нь хамгийн сайхан. Өрлөг эх, эсвэл ээждээ тэврүүлэхэс бусад үед хүний өвдөгцөө татах жаахан амьтан эргэн тойрон үзэгдэх бүхнийг ямагт тээр доороос дээшээ өлийж харах болдог. Охинд Тайхар хэмээх бяруун чинээ хоточ халтар нохойн хүзүүвч хүртэл тэртээ дээр харагддагийг яана. Гэтэл хүлэг морины нуруунд гармагц юуг ч тэгж өлийн харах хэрэггүй. Эмээл дээр мордмогц бяцхан бие нь тэнгэр тулам өндөр ч болчих мэт, гэр хотол, энүүгээр тэрүүгээр гэр малын ажил хийж яваа өргөөнийхөн, алсад бэлчих хонь, уяаны шузгаар эргэлдэх алаг шаазгайг харж, эмээлийн бүүрэгнээс бяцхан гараараа тас зууран “чүү чүү” хэмээн явахад газар гайхалтай хурдан хорох нь хүртэл гайхамшиг байлаа. Монгол хүний цусанд шингэсэн моринд хайртай занг ч бяцхан Ану өвлөн төржээ.

Охиныг тийн аавынхаа зэгзгэр хээр моринд мордон, ааваараа нуруунаасаа дэмнүүлэн эрхэлж явахад хажууд нь хайртай өрлөг эх нь дагаж, ээж нь өргөөнийхөө үүдэнд инээмсэглэн зогсох нь үзэгдэнэ. Эргэн тойрон дандаа хайртай хүмүүс нь байгааг хүүхэд юунэс андах билээ. Аавын эзгүйд Галдамаа ах нь хааяа бас түүнийг ийнхүү морь унуулан эрхлүүлдэг сэн. Гэвч сарын өмнө ах нь хөлтэйхэн хурим хийж, нутаг холдон нүүсэн билээ.

Хонгорын баян бүрдний амь судас нь болсон Чулуут горхины ус зуны дуу эгшиглүүлэх мэт хоржигнон урсахыг сонсон, бяцхан Анугаа ход ход инээхийг чагнан, горхины эргийг эмжсэн торгон ногоон зүлэг дундуур алхлан явах нь Очирт цэцэн ханы сэтгэлийг тэнийлгэдэг цөөхөн зугааны нэг болоод байлуга.

Намар нь Очирт цэцэн ханы отгон охин бяцхан Анугийн сэвлэг үргээх найр болов. Ханых Алшаагийн хамгийн өнтэй сайхан нутаг Дуутын бүрдэн дэх намаржаандаа буугаад удаагүй байлаа. Дуутын бүрдний тооройн төгөл алтан хэвнэгээ нөмөрчээ. Өргөөнийхөн хэдэн өдрийн турш Ану охины сэвлэгийн найрт бэлтгэн борви бохисхийлгүй хөдөлцгөөжээ. Найрын зочдод зориулан барьсан өлзий хээтэй таван асар өвгөн тоорой моддын сүүдэрт алаглана.

Охины сэвлэгийн найрт хошууд, хойд, чоросын бүхий л ноёд ихэсийг урьсан нь өнгөн дээрээ отгон үрийнхээ даахийг ёс төртэй үргээх эцгийн хүсэл мэт авч, цаанаа Зая бандида багштайгаа зөвлөлдсөөр зайлшгүй хийх нь зөв хэмээн тогтоод буй Ойрадын ноёдын чуулганы өмнөх сорилгын цугларалт болох ёстой байлуга.

Очирт цэцэн ханы номын багш Пунцагбалдан гавжийн айлдсанаар намрын дунд сарын арван

долооны билэгт сайн өдөр охины сэвлэг үргээх найрыг товлон, сарын өмнөөс Ойрадын ноёдод хэл дуулгасан байлаа. Хошууд нутагт намар оройтдог нь жам. Үе үе намрын уйтай салхи хүүгэн элсээр шуурах авч, оройтсон бороо татрангуут Дуутын бүрдэнд ногоо хэнзлэн, балжингарма цэцэг шүхэрлэн цэцэглэж, нар хүртэл зуныг санагалзах мэт илчээ үл бууруулан саасан налгар өдрүүд болж байлаа.

Товлосон өдрөөс хэд хоногийн өмнө зочид уван цуван цугларч, Очирт цэцэн ханы намаржаа хөл хөсөөнөөр дүүрэв. Маргааш сэвлэг үргээнэ гэж байхад Сэнгэ хунтайж залуу хатан Насанжид ,эх Юм-Агасын хамт ханы намаржаанд буусан нь хамгаас эрхэм зочин байлуга.

Сэнгэ хунтайж эцгийн хөрслөг бор царайг бус Юм-Агас хатны шингэн цайвар арьс, хянуур харцыг дууриасан ч , Баатар хунтайжийг эрхгүй санагдуулсан өтгөн ширвээ хар сахал, нүдэндээ ойрхон сүрлэг хөмсөг, хянуур харцтай жийтгар нүдтэй өндөр чилгэр сайхан эр. Цэвээнравдан хүүгээ тэвэрсэн Насанжид хэмээх дунд зэргийн нуруутай, уруул дээрээ мэнгэтэй үзэсгэлэнт залуу хатан нь Ховог сайрын Билгэ тайжийн охин ажгуу.

-Хан ахын амар амгаланг айлтгая!Та сайхан намаржиж байна уу? хэмээн дөнгөж хорь шүргэж яваа жавхлан төгс залуу хунтайжийг мэндлэхэд өргөөнийхөө үүдэнд хатдын хамт хүндэтгэн тоссон Очирт цэцэн хан андынхаа залуу настай нь учрах мэт болж, бахархах, цочирдох зэрэгцсэн билээ.

Сэнгэ хунтайж эхийн хамт Очирт цэцэн ханы Ану охины сэвлэг үргээх найрт ийнхүү хүрэлцэн ирсэн нь эцгийн ор залгахад дэм болсны ач санахын сацуу, цааш аялан Далай ламд бараалхах, шашны эрдэмд суралцан буй дүү Галдангаа эргэхийг хамтатгаж яваа ажээ. Хоёр жилийн өмнө ирж байснаасаа хойш нэлээд оворжсон Юм-Агас хатан холын замд багагүй аяншсан нь илт үзэгдэх авч, өрлөг эхдээ тэврүүлсэн бяцхан Ануг хараад харц нь сэргэн инээмсэглэж “Танай бяцхан охин овоо хөөрхөн торнижээ. Эцэг эхийнхээ хэнтэй нь ч илүү адилхан юм бэ дээ” хэмээн өхөөрдөнгөө маатан гаргаж өгөөд духыг нь үнэрлэв.

“Үрчлээ нь улам л нэмэгдчихэж. Бүсгүй хүн эр нөхрөө алдахаар навчсаа гүвсэн хайлаас мэт залуу нас, гоо сайхнаа нэгмөсөн гээчих юм даа.” хэмээн Очирт цэцэн хан хоромхон зуурт харамсан бодов. Үдэш нь энэ тухай Доржравдан хатандаа өчихөд нь бүсгүй орноосоо өндийхдөө хөнжлөө унагачихаад хоромхон зуур тэрхүү нүцгэрсэн эгмээ хөх магнаг хөнжлөөрөө далдлангаа “Би ч бас гоо үзэсгэлэнгээ хором хормоор гэж байна даа.” хэмээн гуниглан бодсоноо тэрхэн хоромд нууж хөнгөнөөр инээмсэглээд “Гэвч хайлаас мод дараагийн хавартаа эргээд л нахиалдаг шүү дээ. Харин хүмүүний нас дэндүү богинохон нь уйтай” хэмээжээ. Хан тэр үдэш залуу хатан Нурантай янаглан өнгөрөөх бодолтой байснаа Доржравдангийн цав цагаан эгэмд уягдан, элдвийг ярилцан ээнэгшсэндээ болоод тэндээ хоножээ.

Өдөр нь Алмагүл шивэгчнээр нь дамжуулан өнөө үдэш очно хэмээн нөхрөө хэлүүлснийг сонсоод Нуран мэлрэг цэцгийн үнэрт усаар хүзүү, цээжээ угаан, навчин хээтэй цагаан торгон дотуур хэвнэгээ өмсөн хүлээсээр намрын урт шөнийг цурам хийлгүй үдэж билээ. Энэ үдэш эр нөхөр нь залуухан хотон хатныхаа өргөөнд хонох гэж буйг шадар хиа Равдангаасаа мэдсэн Доржравдан яаж зүгээр байх вэ. Тавь нэлээд гарч, насны наран хэвийж яваа хан гуч ч хүрээгүй эрэвгэр нүдэн бага хатантайгаа цэнгэлдэх нь зүй боловч түүний тооцоолсноор

Нурангийн сарын хир ирээд дундаа орж буй энэ үед эр нөхөртэйгээ загас наадуулбал үр тогтож болзошгүй нь аюул түгшүүр дэлдэж байв. Энэ хэдэн хоногт л хантныг бага хатантай нь энгэр зөрүүлүүлж болохгүй. Бусад үед бол хардах харамлах сэтгэлийн ороолонгоо дарж байгаад “Та Нурангийн өргөөнд морилооч дээ. Юунд миний өргөөнд уяатай юм шиг байхын” хэмээн өчиж болох билээ. Хантны отгон үрийг голт зүрхний хайртай дунд хатан надаас өөр хэн ч төрүүлэх ёсгүй. Үгүй,үгүй. Нуранг л хөл хүнд болохыг харахгүйн тулд юу ч хийхээс буцахгүйсэн.

Өргөөнийх нь зүүнтэй байх өрлөг эхийнхээ гэрт Ану охин нам тайван нойрсч буй нь илт. Харин тэргэл саран тооноор шагайх сүүн цагаан намрын шөнө, тэртээд хол ойрын зочдын унаа, хүлэг морьдын тургилах, энүүхэн зүүнтэй горхи хоржигнон урсах, ноход хуцалдах нь дэргэд мэт сонордох үеэр саяхан үйлдсэн цэнгэлдээ цуцаад нам унтах эр нөхрийнхөө цээжинд наалдан бүжин мэт хяран хэвтэх Доржравдан хатан өчүүхэн төдий хөдлөх юм бол эрдэнийн дуслыг алтан хэвлийгээсээ амсардуулан асгахаас эмээн элдвийг эргэцүүлэн хэвтэнэ.

“Халхын Засагт ханы хүү Лувсан тайж гэж тийм ч нүд алдам сайхан эр биш юм гээч. Гэвчиг яахав, нас залуухан, сайхан чилгэр нуруутай юм. Харин Сэнгэ хунтайж нэг харахад Юм-Агас хатан ч юм шиг. Нөгөө харахад бүрлээч Баатар хунтайж ч хэмээн андуурам сайхан эр болжээ. Сайхан эр гэснээс миний охин Ану ямархан хувь төөрөгтэй хүн юм бол доо. Хэрэв миний зүүдэндээ үзсэнээр хаан хүний хатан болох хувьтай юм бол тэр нь гарцаагүй Сэнгэ хунтайж биш үү? Хэрэвзээ хунтайж миний охиныг арван тав хүрэхэд сүй тавилаа гэж бодох юм бол, дөнгөж гуч гарч яваа идэрхэн сайхан эр байх нь. Эрчүүд ч гуч хүрснээсээ хойш л нас бие гүйцэж, ур бяр тэгшрэн, ухааны цараа сууж, улам хараа булаам болох юм даа...” гэхчлэн элдвийг эргэцүүлсээр нэг мэдэхэд зөөлөн бөхөд автсан байлаа.

Найрын өмнөх өдөр Сэнгэ хунтайжийн авга ах Цөхүр увш Багабанди хүүгийн хамт, Зодов тайж, Зоригт хошууч, Хойдын Бартан тайж, халхаас Засагт хан Омбо-Эрдэнийн хүү Лувсан тайж, Хойдын Сайн хиагийн ууган хөвүүн Номундалай, дунд хөвүүн Номун-Эрдэнэ тэргүүтэн ноёд цугларсан ч Очиртцэцэн ханы дүү Аблай тайж ирсэнгүй нь ханы хувьд магнайн үрчлээг нь гүнзгийлж, санчигт нь буурал нэмсэн базаахгүй явдал байлаа...

Өглөө нар цухуйж байхад эхэлсэн сэвлэг үргээх найр бага үдэд жигдрэв. Хоёр сонжууных нь хонхтой боолтыг тайлж эцэг нь анхлан даахинаас нь нэг туг үс хайчлахад Ану аавдаа гомдсон нь илт байдгаараа өмөлзөж байснаа бумбагар хацраа дарж байгаад уйлсан нь ирсэн зочдын хайр өхөөрдлийг нэгэн зэрэг татав.

-Миний охинд бүүр их гоё, ижийнх шиг нь урт гэзэг ургаж сайхан сэвгэр болно. Даахиа үргээлгэхдээ уйлдаггүйм... хэмээн хэлээд аав нь духан дээр нь үнэрлэхэд ч охин тайвширсангүй уйлсаар байлаа. Хүүхэд гэдэг амьтныг ухаан суугаагүй, юу ч үл мэднэ хэмээн томчууд мунхагладаг ч нялх жаахан тэр амьтдын зөн совин нь араатных шиг соргог байдгаас өөртөө юу таатай, юу таагүйг ухаан муутай зарим нэг том хүмүүнээс илүү нарийн ялган таньж, дурүйцлээ уйлж илэрхийлдэг ажгу. Тиймдээ ч гэр дүүрэн улс цуглан шуугилдаж, аав нь гэнэт тэргүүнд нь халдан үсийг нь хайчилчихсан нь охинд ердөө ч таалагдсангүй.

-За одоо ижийдээ оч.Тэгээд Цэвээн ижийдээ... гэж эцгийгээ хэлж, сахалтай хошуугаараа

духыг нь үнэрлэхэд урьд аавдаа эрхлэн, ижийд нь байдаггүй аав хүнд л байдаг тэр л таатай үнэртэй цээжинд нь наалдан эрхлэх дуртай байсан атал одоо улам ундууцал төрж, тэртээ хатавчны тэнд зогсоо өрлөг эхийн зүг учиргүй зөрүүдлэн тэмүүлж, хадаг уясан хайч, сэвлэг хийх уутыг нь авч чулуудаад цахлан тийчилж:

-Үгүй, боль чи! Миний үс...Ижий муухай, аав муухай! Даадаа очноо хэмээн бархирав.

-Манай хантныг дуурайсан сүрхий шийртэй хүн болох нээ.Үгүй ер. Даадаа гэж хэн юм?

-Хэлээд юүхэв. Хөвүүн асан бол ч Галдмаа ахынхаа шийрийг хатаах нь гээч...

-Ишц,миний шар охин.Тэгдэггүй юм. Аль, ижийдээ ир хэмээн сувдан унжуурга ширжигнүүлсэн эхийгээ ойртон очиход ч охин тайтгарсангүй.

-Үгүй чи боль.Ижийд очихгүй. Даадаа нааш ир дээ!Миний үс.. миний толгой, боль...Би хэмээн зөрсөөр байхад эцэг нь хүд хүд инээгээд хатавчны тэнд зогсоо өрлөг эхийг долоовор хуруугаараа дохин дуудаж:

-Ханджав аа! Охиныг аваад гар.Хөлсчихнө. Тэгсхийгээд тайтгарахаар нь аваад ороод ир гээд цэнхэр торгон баривчтай уйлж уйлж, улайсан охиныг өргөж өрлөг эхэд нь өглөө. Доржравдангийн хуучин усан цэнхэр дурдан тэрлэгийг өмсөн, урт гэзгээ хадамд гараагүй халх бүсгүйн янзаар арагш сүлжин унжуулсан Ханджав гэр дүүрэн ихсээс эмээсэндээ доогуур харсаар хоймор өөд очин ааштай бяцхан авхайг авахдаа “Алив Даадаадаа ир.Энэ олон хүний дэргэд ижий аавыгаа тэгдэггүй юм” хэмээн аргадаад авч гарлаа. Охин зарим үед эхээсээ илүү энэ халх бүсгүйд элэгтэй юм шиг аашилдагт Доржравдан ахайтан их л эвгүйрхэн гомдох шиг болдог нь энэ удаа олон зочдын нүүрэн дээр улам ч уур хүрмээр санагдан дүрсхийн царай хувиргасан ч ааш зангаа чанга барьж, цээжиндээ ассан дөлийг амаараа утаа гаргалгүй унтрааж чаддагийнхаа хүчинд дорхноо тайвшран шанхны үсээ засаад инээвхийлсэн хүн болж аргалж чадав. Гэхдээ энэ өөдөсхөн охиныг урьд төрүүлсэн хоёр хүүгээсээ арай л дутуу хайрлаж, нөхрийнхөө сэтгэлийг өөртөө татах хэрэгсэл мэт үздэгийгээ хатан дотроо мэдрэн хааяа гэмшээд байдаг аж. Бяцхан Ану ч үүнийг мэдсэн мэт өөрийг нь илүү халуун сэтгэлээр хайрладаг өрлөг эхдээ улам элгэмсүү болсоор байлаа. Эхдээ ч очилгүй уйлсаар өрлөг эхдээ тэврүүлэн гарч яваа охины зүг Цэвээн хатан унжсан зовхио өргөн хараад “Эвий гэж. Хэр шүү дээ.Охин хүн үсэндээ харам байлгүй яахав” гэж хажуудаа суух бага хатан Нуранд хэлэхийг Доржравдан харчихаад “хөгшин хатан,хоосон умайтай хүүхэн хоёр сүжрээд их байх шив.Ухаандаа би ч бас охинтой хүн гэдгээ надад далдуур хэлж байгаа ухаантай” хэмээн дургүй нь хүрсэн ч эр нөхөр рүүгээ харан хэнэг ч үгүй инээмсэглээд “Цэвээн ижий нь бас өмөөрч байна” хэмээн шал өөрийг хэлээд авлаа.

-Өө Даадаа гэдэг нь өрлөг эх нь байж. Хан хүний гүнж гэж аргагүй өөр юм. Тэргүүндээ халдахад дургүйцэж байгааг нь.

-Шийртэй охин. Үгүй тэр “Чи боль” гэж байгааг нь ээ.Үгүй мөн айхтар шийртэй хүн гарах нь.

-Бүсгүй хүнд тийм зан тохирохгүй бус уу? гэхчлэн зочид шуугилдахад :

-Бүсгүй хүн зоримог, шаламгай дайчин байх нь юу нь муу байхав?Өэлүн эх тийм байгаагүй бол Эзэн Богдыг төрүүлэхгүй л байсан бус уу? хэмээн Очирт цэцэн хан хэлээд охины сэвлэг хөндсөний эхний дугарааг өргөө! Өчүүхэн намайг хүндлэн, эцэгтэй нь анд бололцон явсныг үл умартан охины минь сэвлэгийн найрт Сэнгэ хунтайж таныг эхийн хамт хүрэлцэн ирсэнд талархаад баршгүй магнай хагартал баярлаж байна. Тахиа жилийн зуны дунд сарын энэ билэгт сайн өдөр Ойрадын олон ихэс та бүгд ийнхүү өчүүхэн миний өргөө гэрт цугларсныг энэ цагийн өнгөнд атгасан гар мэт эв хүч төгөлдөр явахын нигуур хэмээн мунхаглана.За энэ хундагыг тогтооно уу хэмээгээд баруун этгээдэд морилсон Сэнгийн зүг мишээлээ.

Сэнгэ хунтайж живэр сахлаа имрээд гэрийн эзэнд тал өгөн мишээсхийгээд хундагаа тогтоолоо.

Доржравдан нөхрийнхөө нүдийг манаж байгаад Лувсан тайжийн зүг үе үе талимаарсан харц илгээн аалигүйтэн инээвхийлэхийг Юм-Агас ажиглангаа хажуудаа суусан Цөхүр Увшийн хоёрдугаар хатан, хөх царайт Пагмадуламтай ёсыг бодон ганц нэг үг солилцож суулаа. Залуудаа урд зүгээс авчруулсан оо энгэсгийг хэтрүүлэн хэрэглэсээр ийнхүү царай нь хоёр зуны турш хээр өгөршсөн аргал мэт хөхөрсөн гэлцдэг, нас гуч нэлээд гарч яваа ч илүү оворжуу үзэгдэх Пагмадулам Хөх нуурын харц угсаатай ч, бичиг эрдэмд нэвтэрхий Уламбаяр гүүшийн охин,эхийн талаас уйгар угсааны хүн ажээ.

Царай нь хөхөрснөөс биш уйгар хүүхнүүдэд л заяадаг урт сормууст алаг нүд, монхордуу хянга хамартай, тэгш цагаан шүдээ яралзуулан инээх дуртай энэ хүүхэн Юм-Агас хатны чихэнд цэнхэр хилэн нударгаа нааж байгаад:

-Энэ Доржравдан элдэвтэй хүүхэн шүү. Очирт ханы хотонгоос буулгаж ирсэн бага хатан өдийг хүртэл найман жил нойтон сормуустай амьтан унагаагүй байхад өдий насандаа үрийн зулай үнэрлээд сууж байдаг. Нас нь миний үеийн атлаа өөрийгөө хорин тавт шиг л бодох юм.Хараач, нөхрийнхөө сиймхийгээр тэр эрчүүд рүү сээтэн хаялж байгааг нь... гэхэд:

Цөхүр Увшийн үрс гаргах гаргах найран дээр шал согтсон Цэцэн тайж “Ёсгүй хатны хүү Сэнгэ хунтайжийн суудалд удаан тэсэхгүй. Эцгийн суурийг ууган хүү нь залгамжилдаг ёсыг би ч сэдсэн юм биш. Гэтэл үнэгэн зальт Юм-Агас хатан хүүгээ миний оронд эцгийн ор залгуулсныг есөн үеэрээ мартажгүй санаж явах болно доо” гэхчлэн агсан тавьсан тухай дуулснаа бодон, “Энэ бол ухаан молхи Цэцэнгийн үг яавч бус.Харин цаанаас нь Дарабалжи гэж жинхэнэ үнэг шиг эм хатгаж буй нь илт.Энд Очирт цэцэн ханы дүү Аблай тайш алга. Бас л ханцуйдаа мэс өвөрлөж, ахынхаа эсрэг санаа агуулж яваа нь илт. Өнөөхөндөө Цөхүр Увш Сэнгэ хүүтэй минь эвтэй л байна. Маргааш юу болохыг тэнгэр л мэдэх биз” гэхчлэн түмэн бодолд дарагдан сууснаа сая сэргэн хүүхдийн сэвлэг үргээх найр дээр байгаагаа санажээ.

-Дүү минь хүний хэрэгт хошуу дүрээд юуны тус байхав. Хүн бүхэн өөрийнхөө төрсөн өдрийн төөргөөр явдаг. Өдий насанд эм хүн өнгө зүсээ Доржравдан шиг сайхан хадгалж явна гэдэг бахархал биш үү? хэмээн дундыг барьсан хариу хэлэнгээ гэрийн зүүн дээд талд Цэвээн хатны дэргэд суугаа Нуран бүсгүй рүү халти харав. Хүүхний тас хар цөцгийтэй эрэвгэр алаг нүд урт сормуусныхаа сүүдэрт улам ч бүүдийн гуниг хурсан харагдана. Сувдан унжуурга нь эзэндээ тээр болоод байгаа мэт толгойгоо гилжийлгээд гартаа гангар шаазантай цай юм уу,юу юм барьснаа ч мартсан мэт даахиа үргээлгэн буй алдрайхан охины зүг өхөөрдсөн, басхүү үр

хүүхэдгүй эмэгтэй хүний хувь тавиландаа цөхөрсөн харцаар ширтэн суугаа энэ залуухан бүсгүй түүнд үнэхээр өрөвдмөөр санагдах тул, олон хатдын атааг хөдөлгөж, эрчүүдийн хараа булаасаар байгаа Доржравдангийн тухай яриа гарах бүрд Нуран руу байн байн хармаар санагдах ажээ.

“Бүсгүй хүнд өнгө үзэсгэлэн, залуу нас байгаад ч ухаан үгүй бол хэлгүй хонхтой л адил юм даа. Энэ хотон бүсгүйд ухаан дутсанаас л өдий олон жил үр хүүхдээ ч эсэн мэнд төрүүлж чадахгүй, насан хэвийсэн эрийнхээ зүрх сэтгэлийг эзэлж хүчрэхгүй, Доржравданд идүүлж явна. Эр, эм хэнд ч хувь тавилангаа залж явахад хүрэхүйц ухааны сүв хэрэгтэй.

Гэнэ алдчихгүй л бол Сэнгэ хүү минь оюун ухаан сэргэг, хатад эмст ч нүд алдаад байхааргүй чамбай эр болж өссөн юм сан. Очирт цэцэн хантай ураг барилдвал сайн сан. Гэвчиг Цэвээн хатнаас төрсөн ганц охин нь царай зүс дорой хэмээн хүү өөрөө гэж голсоор гурван жилийн өмнө манай Ховог сайр тийш хадамд гаргачихсан. Өнөөдрийн өөхнөөс маргаашийн уушиг гэгчээр сэвлэгээ үргээж буй энэ өөдөсхөн охин харин хэдэн жилийн дараа Сэнгэд дориун хатан болж, хошууд, цоросынхны эртний ураг барилцаж ирсэн уламжлалыг үргэлжлүүлж мэдэх л юм. Хэрэв Галдан хүү минь сахил санваар хүртээгүй бол Сэнгээс ч илүү цөс ихтэй, холыг харах, төр улсыг удирдан залах хүчтэй төрсөн юм сан” хэмээн дахиад л бодлын далайд умбаж билээ.

Харин Пагмадулам найранд эр нөхрөө даган ирснийх жаал хов жив ярьж, шавайгаа хангаж авах гэтэл Юм-Агасын ийнхүү хэвцэг аашлахад урам хугарч, “Үгүй ер, эрийнхээ толгойг залгин, чавганц болж сахил хүртсэнээрээ түрий барьж нэг их уужуу дотортой хүний дүр үзүүлж гэнэ. Будаач будаач гэхээр сахлаа будав гэгчээр өөрийг нь талийгч хадам ах ухаантай ухаантай гэсээр бүүр тэнгэрт гаргачихаж ээ. Хүүгээ хунтайж болсноос хойш хамраа бүүр сөхөөд байгаа гэж Дарабалжи ахайтны ярьсан ортой л юм байна. Хатад, эмс хэзээ л билээ. Наанаа ингэж дарь эхийн дүр үзүүлж л байна. Цаанаа ямрыг хэн мэддэг юм? Залуудаа Баатар хунтайжийн шадар хиа Буянтөмөртэй учир ургуулж явсан л юм гэх чинь билээ. Одоо ч нөгөөх нь үрчгэр илэг шиг царайлчаад энд дагаад ирсэн харагдсан даг. Өнөөхөндөө миний эр нөхөр цоросынхны хамгийн ахмад, нэр нөлөөтэй нь болоод байгааг бүү мартаарай даа” хэмээн зэвүүрхэн бодоод, янз муутай гэгч нь шилбэлзэн цаанаа суусан залуухан ахайтан руу яриа өдөхөөр эргэжээ.

Сэвлэгийн найр бага үдийн үед ид жигдэрч, унаган даахиа үргээлгэсэн жаахан Ану охин хэдийнээ нүцгэн толгойдоо дасан, даахь үргээлгэсний хишиг, чихэр боовонд цадаад өрлөг эхийнхээ орон дээр шилүүсний чих мэт эгдүүтэй хоёр сонжуу сэртийлгэн бөндийтөл нойрсч, их өргөөнд дууны түрлэг ид чангарч байлаа.

Харин орой нь Очирт цэцэн хан Ойрадын ноёдын зонхилох хэсгийг цугларсан дээр нь “Дөчин, дөрвөн хоёрын их цааз бичгийг” сахих, цаашид хэрхэн эв хүчээ нэгтгэн ямагт өмнө зүгээс заналхийлэн буй манжийн аюулын өмнө Алун гуа эхийн багцалсан таван сум мэт байхуйн тухайд хэлэлцэн, заримаас нь, тухайлбал хэзээд санаа буруулж мэдэшгүй Цөхүр Увш мэтээс ам өчгийг нь авах зорилготой хээрийн том асартаа чуулж билээ. Асрын баруунтай Очирт цэцний их хатнаас төрсөн ууган хүү гуч эргэм насны Гартангомбо, түүний дүү Эрдэнэ тайж, насны эрэмбээр хоёр ахын доохно Доржравдан хатны төрүүлсэн Галдмаа хүү нь сууцгаасан байв. Гартангомбо эхийн нунж дорой занг дууриасан, бие муутай, сонсгол сулаасаа

болоод баруун чихээ далжийлган хүний өөдөөс зөрүү хардаг халирхай нүдтэй эр. Түүнээс таван нас дүү Эрдэнэ тайж эрхбиш эцгийн сүрлэг хурц нүд, эрэмгий занг авсан ч ухаан муу. Багадаа Хөх нуурын газар одож, эрдэмт багшид дөрвөн жил шавилан бичиг эрдэм заалгасан ч уйгаржин, тод бичгийг арай ядан үсэглэх төдий, хүнтэй уулзахаараа их дуу гарган цээж түрэх авч, амнаас нь хэрэгтэй үг үл унах тул төдхөнөө гаднаа гяланцаг, дотроо паланцагийн үлгэр болчихно. Харин эцгийн сүрлэг хөмсөг, өргөн магнайг эхийн царайны зөв тиг, сүүн цагаан өнгөтэй хослуулан дууриаж төрсөн, өдгөө арван есөн настай, бяр хүч, ухааны уудам тэгш заяасан сайхан залуу бол Галдмаа. Тэрээр аль өдөр найрын дундуур үе үе Лувсан тайжтай цугтаа гадаалан, хууч хөөрч, халхын байдлын тухайд чамлахааргүй сайн мэдэж авч амжсаных ноёдын цуглаанд үе үе чухал санаа нэмэрлэж эцгийн зүгээс таашаалт харцаар мялаалгаж байлаа.

-Миний бодох нь Хойдын Номундалай ноёны үгийг сонсох нь зүйтэй мэт. Хэдэн жилийн өмнөөс Илийн өвөлжөөнд манай Ойрадын ноёд чуулан, цагийн байдлыг хэлэлцэн хэл амаа овоо ололцсон ч зарим аймгийн ноёд Цорос, Хошуудын ихэсийн нөлөөнд автахгүй хэмээн салан нүүсээр байгаа билээ хэмээн Галдмаагийн хэлсэн нь хорь хүрээгүй залуугийн амнаас гарамгүй буурилаг, дөрвөн Ойрадын ураг элкиний эв эеийг атгасан гар шиг зангидах эцгийн хүсэлд эв мод мэт нийцсэн үг байлаа.

-Өчүүхэн миний хувьд Сэнгэ хунтайжийн ирт мэсний үзүүр болж, Ойрадын тусгаар байдлын төлөө зүтгэхэд бэлэн. Тахиа жилийн хасагтай хийсэн тулаанаас хойш дөнгөж одоо л сэхэл авч, амиа алдсан цэргүүдийг шинэ залуу хөвүүд нөхөж байна даа гэж Номундалай ярьсан ч эцгийг нь хөнөөсөн гэгддэг Цөхүр Увштай найртай сайхан харилцаа үүсгэх бодолгүй буй нь мэдэгдэж байлаа.

-Ойрын хугацаанд Ойрадын ноёдын их чуулган зарлан хуралдуулах бодол байна. Гэвч Далай тайш, миний дүү Аблай тайж, Дайчин хошууч нар буруу зөрүү харсан янзтай хэвээр буй нь сэтгэл чилүүрүүлэх юм. Ийм байдлаасаа болж Ойрадын хүчин буурна уу гэхээс хүчирхэгжихгүй. Зая бандида багшийн айлдварыг эдгээр хүмүүс эрхбиш сонордоно хэмээн найдна. Ямар ч үед бидэнд гадаад талаас Орос улс түшиг тулгуур болох тул сэнгэ хунтайж та, эцгийнхээ үүсгэсэн харилцааг найрсгаар үргэлжлүүлэх нь зүй буй за гэж Очирт цэцэн хан хойморт зэрэгцэн морилсон Сэнгэд хандан хэлээд хултай чигээгээ дуустал залгилав. Сэнгэ:

-Эцгийн бие барснаас хойш миний бие чадахын хэрээр Орос улстай найрсаг харилцааг таслахгүйг хичээсээр ирсэн билээ. Саяхан тэндээс эцэг хунтайжийн анд явсан Тобольскийн захирагч ноён гашуудлын захидал бичиг ирүүлж урьдын найрамдалт харилцаа хэвээр буйг уламжилсан билээ. Номундалай тайжийн хэлдэгтэй би ч санал нэг байна. Бид өнөөхөндөө дотоодын хүчээ бэхжүүлэх, цэрэг эрсээ байлдах дайтах эрдэмд сургах, Манжтай эвийн харилцаагаа аль болох хадгалах нь эрхэм билээ. Харин Халхын тухайд “Дөчин дөрвөн хоёрын их цааз” мордохын хазгай гэгч болж, торгоны зах сэмрэх шиг л манжид хэсэг хэсгээрээ дагаар орсоор дуусах вий гэсэн бодол төрөх боллоо гээд Лувсан тайжийн зүг сэрэмжлэнгүй харц илгээгээд:

-Хэрэг нэгэнт ийм байгаа тул бид Ойрад түмнийхээ хүчийг зангидсан гар мэт нэгтгэхээс өөр замгүй байна гэхдээ Цөхүр увш, Номундалай тайж нарын зүг хяламхийлээ. Энэ нь урьдны өс хонзон, гомдол хорслыг мартагтун гэсэн хүсэлт, гуйлт, захирамж байлаа. Магнайн ганц тод



үрчлээсээ тэнийлгэх гэсэн мэт баруун гараар үрчин мэлмийгээ үлмэдэг анисхийн бодол санаа нь алсад бэлчих мэт суусан Очирт цэцэн хан:

-Халхын тухайд яриа нэг тусдаа.Энд Засагт ханы Лувсан тайж залран ирээд байгаа нь халх ахан дүүс бидэнтэй эв хүчээ нэгтгэх бодол бас ч горь тасраагүйн шинж болов уу.Харин Ойрад бидний эв хүч нэгтгэхэд хэн, юу саад болж буйн тухайд бас яриа жичдээ хэмээн бодно гээд Лувсан тайжийн зүг найрсаг харц илгээлээ.

Түрүүнээс хойш өдөр найран дээр оч хаялсан харц илгээн,гадаалж сэрүүцэх далимдаа хатных нь амгаланг асуух нэрээр илт сээтэн хаялж асан Доржравдан хатны тасам нарийн бэлхүүс, хөнгөн оо түрхсэн тунгалаг цагаан царай үе үе санаанд орж ирэвч, бодол санаагаа захиран ноёдын бага чуулганд эгүүлэн авчирч байсан Лувсан тайж:

-Миний хувьд ах дүү Ойрад түмэнтэй ямагт дуугарвал дуу нэг дугтарвал хүч нэг явсан эцгийн бодлогоос ухрахгүй гэж боддог.Халхын зарим ноёд ганц нэгээр Манжид дагаар орж буй нь бий ч тусгаар гал голомтоо хадгалах язгуур хүсэл манай халхад бүхэлдээ унтарчихсан хэрэг бус.Ойрадын аймаг хошууд ч умард зүг хэсэг хэсгээр нүүн Оросын хаяаг түших,Орос улс Халхын хойд хэсгийн нутаг руу өнгөлзөн тариачид олноороо суурьшин нутаг бэлчээр эзэгнэх болсонд сэтгэл түгшүүрлэн байна. Гэтэл Орос улс Ойрадтай халхаас илүү түншилж буй нь биднийг далдуур хагалан бутаргах гэсэн дээрэнгүй бодлого гэдгийг ул суурьтай цэгнэх цаг болсон мэт гэлээ.

Өдөр нь Доржравдан хатантай нь хөнгөхөн сээтэгнэлийн харц солилцоод байсныг нь ажиглан тэрхэн үедээ хардлагын ч гэх үү, хармын ч гэх үү сэтгэл төрж бяцхан хилэнгийн оч маналзан байсан ч тавин нэгэн хаврын яргуй цэцэглэх, намрын шувуу буцахыг үзсэн хашир эр тэр хилэгнэлээ дарж чадаад өдгөө Лувсангийн үгийг халх, Ойрадын харилцааны талаас эв эеийн төлөө тайван сонсож чадаж байлаа.

Тийм ээ. Орос гүрний зүгээс Халхтай тоомсоргүй дээрэнгүй,Ойрадтай болохоор өнгөн дээрээ найрсаг хөршийн байдалтай хандаж буй нь бас л нэгэн тоглоом. Энэ нь Халх Ойрадын хагалан бутаргах, дундаас нь ашиг хонжоо олж авах гэсэн их гүрний дээрэнгүй,шунахай бодлого гэдгийг монголын ихэс ойшоохгүй хар толгойгоо бодоод нүд анин өнгөрүүлээд байж болохгүйг халхын энэ ноён сануулаад авлаа.

Нөгөө талаас Доржравданг гоо үзэсгэлэн,адтай хонгор аалиараа Ижил мөрний торгууд хошуунаас хальсан цуутай залуу насны сүүлчийн очийг үсэргэн гэмгүйхэн аалигүйтэн буйг энэхэн мөчид ууч уужуу сэтгэлээр ухааран өрөвдөж байв. Хорвоогийн амьдрал хүмүүний хувьд дэндүү охорхон. Тэр дундаа бүсгүй хүний залуу нас,гоо үзэсгэлэн нэгэн зуны цэцэг мэт богинохон ажгуу. Харин Халх,Ойрад ахан дүүсийн эв эе л илүү урт настай байгаасай билээ, тэгвэл Монгол туургатанд л хэрэгтэй сэн хэмээн тэр дотроо сүслэн залбирлаа. Гэтэл Халх,Ойрад хэмээн том ярихаас илүү Ойрад дотроо өөрийнхөө төрсөн дүү Аблай тайштай ч үг хэлээ ололцож чадахгүй байгаагаа санан сэтгэл хөндүүрлэхийг мэдрэх зуур Цоросын ихэс ноёдын хамгийн ахмад настай нь болоод байгаагийн хувьд Цөхүр увшийн саналыг сонсох нь зүйтэй хэмээн найр талбилаа. Цөхүр увш ногоовтор туяат нүдээр асарт суугаа ноёдыг дэс дараалан хянамгай ширтсэнээ:

“Настан хэмээн хүндэлж үгийг минь сонсож байгаад өчүүхэн би таалал өндөр байна. Хорвоогийн явдлыг хэн ч өмнөөс нь тааж мэдэхийн эрхгүйг эрхбиш дээдэс та бүхэн болгоож буй биз. Түүнтэй эгээ ижилхэн ноёд ихэс цуглаад цааз зарлигаар бүхнийг эмхэлчихнэ гэж үгүй. Эрийг бүү бас, далайг бүү янд гэж эцэг өвгөдөөс сургамжилж ирснийг огооролгүй найман настай балчаас наян настны үгийг сонсч яваасай гэж хэлэх байна. Эв нэгдэл гэж ярих хэлцэх хялбар ч, хэн нэгний санааны мухарт юу хадагдан буйг хэн мэдэх билээ. Гэлээ гээд өтөл миний хувьд залуу хунтайж, Дөрвөн Ойрадын чуулганы тэргүүн таны тааллыг дагалгүй яахав...” гэсэн битүү үг хэлээд өнгөрчээ. Үгэн дотор үг гэдэг. “Эрийг бүү бас далайг бүү янд” гэсэн үгээр насан туршид илүү эрх мэдэл, хөрөнгө зорьтой ахын сүрд дуртай дургүй дарагдан явсны гомдол, цөхрөл нуугдан буйг хан анзааралгүй өнгөрсөнгүй. “...Ноёд ихэс цуглаад цааз зарлигаар бүхнийг эмхэлнэ гэж үгүй...” энэ бас л цаанаа Дөрвөн Ойрадын цаазыг эсэргүүцсэн тэрслүүд санаагаа хулдсан үг. Эх ондоо, олон хөвгүүдийн эрх мэдэл булаалдан тэмцэлддэг эмгэнэлт тувилангийн нэгэн золиос бол Цөхүр увш. Очирт цэцэн ханы хоолойд тээглэсэн яс болж эцгийн үхлээс хойш гучин жилийн турш ахынхаа эсрэг өс өвөрлөн яваа Аблай тайшийн өрөөсөн дугуй. Угсаа залгаж, удмын алтан хэлхээг үргэлжлүүлэх нуган үртэй болох юм сан гэсэн бодол эгэл харц ардаас ихэс ноён, төрийн тамга атгасан хаан хүний хүслэнгийн туйл байдаг аа. Хүсэхэд хясдаг хорвоод ихэс ноёдын хувьд хатуухан тавилан заядаг нь олон хатнаас төрсөн олон хөвгүүдийн эрх тушаал, эцгийн суудлыг ганцаар эзлэхийн төлөөх тэмцэл, ахан дүүсийн цус асгаруулсан хонзогнол болж, өв болгон үлдээх эд хөрөнгө, эрх мэдэл үгүй хоосон харц эрээс илүү зовлонгийн үрийг тарьж орхидог. Одоо энэ Сэнгийн хувьд ч Цэцэн, Зодов гээд эцгийн суудлыг би л эзэгнэх эрхтэй гэсэн цээжний өвчнөө дарж чадахгүй яваа ахан дүүс нь гаднаас харгалдах дайснаас илүү зовоох болно. Тэр сөргөлдөөний дундуур энэ Цөхүр увш тоглох гэж хөгшин чоно мэт анаж суугаа нь илт болоод буй билээ. Эрдэнэ баатар андынхаа захиас гэрээслэлийг биелүүлж тавдугаар хөвгүүн Сэнгийг хунтайжийн ор суулгахад хүчин зүтгэснийх нь хариуд Цэцэн тайж өдгөө Очирт цэцэн ханд битүү өс өвөрлөчихөөд өнөөдөр энд ирээгүй атал өөрийнхөө өмнөөс дотуур тамиртай авга ах Цөхүр увшаа илгээсэн нь илт. Түүнээс бус урьд цагт эцгийг нь хөнөөсөн Хойдын Номундалай, эртнээс эв муутай явсан Засагт ханы хүү Лувсан тайж, эцгийн ор эзлэхийг нь огтоос дэмжээгүй Сэнгэтэй нэгэн ширээний ард суун найрлах гэж л дүүтэй нь сүлбэлдэн муудалцаж явсан Очирт цэцэн ханы отгон охины сэвлэгийн найрт ирнэ гэж Цөхүр увш зориогүй нь лав. Гэлээ гээд айлын босгоор алхан орж, ангир үрийнх нь сэвлэг үргээх найрт зочилсных нь хувьд муугийн ёс биш монголын ёс гэрийн хоймортоо залж, идээний дээжээр зочлон, билэгт сайн үг хэлэлцэн суухаас яах билээ.

“Хашир чоно шүү. Хэлж байгаа үгэнд нь авах ч юм байхгүй атал хорон муу гээд хаях ч юм үл олодоно. Өнгөцхөн сонсоход ахмад настны хувиар сайн сайхныг билэгдээд байгаа юм шиг атал цаашлаад халх, Ойрадын эв нэгдэл, наашлаад ойрын хугацаанд хийхээр тохиролцоод буй дөрвөн Ойрадын ноёдын чуулганы тухайд сайшаах, сөргөлдөх ганц ч үг амнаасаа унагалгүй мултарч дөнгөсөн байгаа юм даа, энэ Цөхүр увш.” Хэмээн Очирт цэцэн хан бодоод хундаганы сүүлчийн үг хэлж уулзалтыг өндөрлүүлж билээ.

Ноёдын бага уулзалт гурван марал гудайж байхад Ойрадын чуулганыг цаашид Очирт цэцэн хан дангаар удирдаж байх, ойрын гурван жилийн дотор Ойрадын ноёдын их чуулганыг хуралдуулах дээр тогтоод таржухуй.

Ийнхүү Очирт цэцэн ханы отгон охин Анугийн сэвлэг үргээх найр дуутай хууртай, хөнгөхөн сээтэгнэл, Ойрадын ихэс дээдсийн хавьд цуглаагүй яриа хэлцэлтэй сайхан болж өнгөрсөнд эцэг нь баяртай үлдэж, харин Ану охин найрын маргааш өглөө сэрээд үсий нь хуссан нүцгэн хуйхаа тэмтэрч үзээд “Даадаа, миний үс байхгүй. Муухай байна” хэмээн часхийтэл орилсон гэдэг. Бүсгүй хүний гоо үзэмж сүр сүлд болсон гэзэг үсэндээ харамсаж мэдэхгүй ч зөн совин нь хаачих билээ? Даахиа үргээлгэсэн тэр өдөржингөө уур унтуутай явсаар олны хөлд хөлсөж ядраад өрлөг эхийнхээ өвөрт унтсан охин өглөө нь ийнхүү уйлах чимээнээр хатан эхийнх нь шивэгчин Үзмээ орж ирээд “Ахайтан Ану авхайг аваад ир гэнээ” гээд охиныг ижийнх нь тэрлэгээр ороон Доржравдангийн өргөөнд аваачжээ.

Анугийн уйлах дуугаар гэрийн баруун талаар эгчтэйгээ унтаж байсан өрлөг эхийнх нь хүү Балсан сэрж чимээгүй өндийн суугаад нүдээ нухлана. Харцын хүү болж, хан эзний охиноос гуравхан сарын өмнө төрснөөрөө эхийнхээ сүүг хөхөх эрхгүй болон шоовдорлогдсон энэ бяцхан хүү сүү ихтэй тулман хөхт хөх ямаа, арван нэгэн настай Сэндэр эгч хоёрынхоо ачаар л хүн болж буй амьтан ажгуу. Ханджавын нөхөр солгой Лувсанхайдав урьд шөнө хан эзнийхээ өргөөний харуулд гарч хоноод үүрээр ирж баруун талын намхан модон орон дээрээ нам унтаж байлаа.

-Ишц, миний муу хөх банди. Сэрчихээд чив чимээгүй суугааг нь хар даа. Тэнгэр намайг харж ийм амар амгалан амьтан заясан юм байх даа. Алив ижйдээ ир гээд Ханджав хүү рүүгээ хошуу цорвойлгон очлоо.

-Ану нь мөөмөө гээд уурлана, яах юм хэмээн эхийнхээ хөхийг эзний охинд булаалгасан золгүй хувь заяандаа дассан бяцхан хүү хэлэхэд эхийнх нь самсаа шархираад явчихжээ.

-Уурлахгүй, уурлахгүй. Алив ижий нь хүүгээ ганц өвөртлөөдхөө. Гар хөл нь сарвайгаад цэл мөс гэсээр тэрлэгээ яран хүүгээ өвөртөлж, мөс болсон хоёр можгор хөлийг нь бөөрөндөө наагаад нүцгэн түнжгэр толгойг нь энхрийлэн үнэрлэхэд хөлс, нар салхи нялхынх нь үнэртэй холилдон үнэртэнэ. Амьтан үр зулзагаа үнэрлэдгийг адил эх хүн хүүхдийнхээ толгойг үнэрлэн хэзээ ч үл тасрах амин холбоогоо мэдэрдэг билээ.

Хан эзний эрх гүнжийг эхийнх нь шивэгчин аваад явсан энэхэн олдосгүй завшааныг ашиглан хөөрхий бүсгүй хүүгээ авч эрхлүүлэнгээ дотуур цамцны энгэр задгайлан хараахан сүү нь ширгэж амжаагүй байгаа хөхөө амлуулав.

Гурван сартайдаа хөхнөөсөө гарч, эгчийнхээ өвөрт өссөн бяцхан хүү эхлээд бишүүрхэнгүй байснаа мөөмөө ховдоглон үмхээд саарьтай бор гараараа нөгөө мөөмөө илэн хурга сүүлээ модгонуулдаг шиг хоёр хөлөө годгонуулан эрхлэв. Хүүгээ ийнхүү эрхлүүлэн суух лугаа эх хүний зүйрлэшгүй жаргал үгүй ч Ханджав бүсгүй баруунтайх хатны өргөөнөөс өөрийг нь дуудан хонх жингэнүүлэх буюу Үзмээ шивэгчин “Ханджав эгч ээ!” гэж цахиртсан хоолойгоор сандчин хашгирах вий хэмээн хором бүрийд хулмалзан түгшинэ. Үзмээ дунд зэргийн нуруутай, харахад нүдэнд дулаахан аятайхан бүсгүй атал хоолой нь чихэнд сонсголонгүй ямагт хяхтнаж, цахиртсан өнгөөр дуугардаг аж. Энэ нь өргөөнд үйлчлэх аягачин шивэгчин авахдаа ихэвчлэн, царай зүс гайгүй бол ямар нэгэн бие эрхтэний гажиг согогтой, эс бол ухаан дутууг нь сонгодог Доржравдан хатны далдын санааны нэгэн жишээ. Тэгэхгүй бол эзэн ноёны нүд сэтгэлийг татахуйц зүс гоо, ааш ялдам амьтан өргөөний зарц шивэгчин хүүхнүүдийн

дунд шургалчихвал наанадаж татвар эм, цаанадаж бага хатан суучих ч юм билүү хэмээн болгоомжилно.

-Миний муу шоовдор бор хүү. Ижийгээ харахаас цаашгүй. Эзний авхайд мөөмөө булаалгасан амьтан. Даахин дор хүлэг, дахан дор эр гэж манай халхууд ярьдаг юм. Эр болж өснө дөө миний хүү хэмээн үглэн түнжин толгойг нь элгэндээ наахдаа хүүдээ халуун уургийг нь хөхүүлэн өсгөх мэдэлгүй харцын заяандаа гутран өр өмөрч байлаа.

Анх Ханджав Ойрадын цэргийн зам зуур нутаглаж таараад Лувсанхайдав хэмээх цэрэг эртэй санаандгүй танилцан дагаж холын хошууд аймагт бэрлэн ирээд, халх нутгаас нь тэс өөр зан заншил, ахуйд нь дасах гэж их л зовсон сон. “Бүсгүй хүн цагаан зээр хоёр нутаггүй” хэмээн сэтгэлээ хатамжилсаар Алшаа нутагт идээшин дассан ч, үе үе өсч төрсөн нутаг Түшээт хан аймгийн нутаг Өрмийн гол, Булган хангай уулаа санахаар хамрын самсаа шархиран өр зүрхний гүнд далдлагдсан тайтгаршгүй их гуниг сэрж, адуу байсан сан бол өдийд нутгаадаа гүйчихсэн дээ хэмээн бодолд дарагддаг байлаа. Эргэн тойрон хараа гүйцэмгүй алсад үргэлжлэх нүд алдам элсэн далай шаргалтах Алшаагийн уудам говьд хаа нэг тааралдах баян бүрдэд шуугих тооройн төгөл, хоржигнох бяцхан булгийн хөвөөг эмжсэн номин ногоон ширгээс өөр эх нутгийнх нь баян хангайг санагдуулах юм юу ч үгүй. Ойрадууд тэрлэгийг лавшиг, уужийг цэгдэг гэх, халхчууд шиг өрөм байлгаж иддэггүй нь, махаа борцолдоггүй шуузалдаг нь, цайндаа айргийн тос самардаг нь эхлээд дэндүү төсөө санагддаг байснаа больжээ. Аз түшихэд хувь тавилангийн эрхээр ёстой л зам дээр тааралдсан эр нөхөр нь цавчилдахдаа гарамгай ч, гэр орондоо туйлын түвшин, гэргийгээ алс холын нутгаа санан гуниглаж, үе үе дуугаа хураахад нь ам хэлийг нь татаж чангаагаад байхгүй чимээгүйхэн л сэлмээ билүүдэн, халуун цай хоол ч нэхэхгүй хүйтэн хярам залгилчихаад, хаа нэг бүсгүйн дэргэдүүр нь өнгөрөхдөө ар руугаа сүлжин унжуулсан шингэхэн гэзгийг нь илнэ. Энэ нь л сэтгэл дэх гүн их хайраа илэрхийлж, эхнэрээ дээд зэргээр энхрийлчихэж буй нь тэр. Бүсгүй нутгаасаа гарч Лувсанхайдавыг дагаж ирэхдээ унасан газар, угаасан усаа санаж явах гэж чигчийн чинээ гурван чулуу авч өвөртөлснөө сахиусны уутандаа хийж энгэртээ зүүж явдаг ажгуу.

Хүү нь эхийнхээ халуун элгэнд наалдан, мээмээ үмхэн эрхэлж байснаа унтчихжээ. Бүсгүй хүүгээ баруун гараараа тэврээд, зүүн гараараа сахиуснаасаа нутгийн гурван чулууг гарган үзэв. Ногоовтор, элгэн улаан, цахир цагаан өнгийн гурван чулуу манан будан хөшиглөсөн их хөвч, тунгалаг уст Өрмийн гол, ам суга бүрээс нь горхи булаг хоржигнон, цэцгийн сайхан, жимсний амттайг дэлгэрүүлсэн сайхан хангай нутгийг нь түүнд орлодог билээ.

“Ижийнхээ хийдэг мойлтой цөцгийг ганцхан амсах сан. Өрөмтэй будаа ид, миний охин гээд муу ижий минь өглөө бүхэн духан дээр үнсдэгсэн. Муу ижий минь ганц охин намайгаа хаа холын Ойрад нутгийн бэр болсныг бурханы орноос харж л явдаг байх даа. Нутагтаа байсан бол би ижийгээ тавьсан Өндөр шилийн энгэрийг харж сэтгэл тайтгарч явах байсан болов уу? Хэзээ нэгэн цагт халх сайхан нутгийнхаа хөрс шороон дээр гишгэх болов уу, би гэдэг амьтан? За даа, миний хүү над шиг гэрийн мухар сахиж суухгүй, холын замд гарах заяатай эр хүн болж өсөөд ижийнхээ нутагт хөл тавих ч юм бил үү. Тэгвэл нутгийнхаа энэ гурван чулууг буцаагаад унаган хөрсөнд нь аваачиж тавь гэж захианаа. Байрнаасаа хөдөлсөн чулуу гурван жил зовдог юм гэнэ лээ” гэхчлэн хэрдээ л гүн бодолд дарагдан хэсэг суув. Гэтэл гэрийн эсгий

бүрээс хивэх гэсэн тулман хөхт хөх ямааг “Чаа! Яадаг годрон бэ” гэх Балжир аягачийн дуу гарахад сая бодлын хөвөрсөн ертөнцөөс сэрэх мэт сэхээ оров. Нэг мэдэхэд хүүгээ тэврээд зөндөө суучихжээ.

Ханджавыг Ану охины өрлөг эх болж, өдөр шөнөгүй бяцхан авхайг асрах болсноос хойш Доржравдан ахайтны аягачин Балжир авгай эдний гэрийн хог шороог цэвэрлэх, сааль сүү, хоол хош, гэр малын ажлыг хамжилцах болсон тул дөрвөн ханатай шинэхэн гэрийн дотор цэмцийгээд, аргалын дөрөлж, усны хавчиг дүүрэн байх аж.

Хүүгээ элгэндээ тэврэн хөлстэй духыг нь энхрийлэн үнэрлээд өөрийнхөө намхан орон дээр зөөлхөн тавьж, “ Жаал авхай намайг үгүйлээгүй л юм байх даа. Би гэж ухаан мөхөс амьтан хан эзний хишигт сүслэхийн оронд дэмий юм бодоод” хэмээн цайлган сэтгэлээр гэмшсэнээ охиноо дуудан босгоод, амаа ангайн унтах эр нөхрөө харж “чимх нойр аваг дээ хөөрхий” гэсэн бодол зурсхийхэд ахайтны өргөө рүү гарч одлоо. Намрын сэрүүхэн тунгалаг өглөө байлаа. Баруун ухаа дээгүүр асар майхан барин буудалласан зочдын зарц барлагууд гүйлдэх, Сэнгэ хунтайжийн хөсөг нүүгэлтэн цааш хөдөлж харагдана.

“Орсон бороо арилж, ирсэн гийчин буцдаг гэж энэ дээ. Найрын хөлд хүүхэд хөлсөөд их муу унтсан. Ноёд шөнөжин чуулсан гэсэн. Дайн л бүү гараасай” хэмээн бодсоор ахайтны найман ханат их өргөөний үүдэнд ирлээ.

Түүнийг ахайтны өргөө рүү очиход Анугийн ход ход инээх, “Би морио унаад чүү чүү давхина” гэх цовоо дуу хадаж, охин эхтэйгээ хамт бөөн бэлэг сэлтийн дунд жижигхэн хөөрхөн эмээл дээр мордчихсон цогиулж байв.

-Даадаа энийг хараач. Юмаа нь надад эмээл өгсөн. Аав надад морь өгнө, хараа хараа хэмээн Ану бөөн баяртай шулганах нь үсээ хусуулснаа ч мартчихсан бололтой. Охиныхоо хажууд шив шинэ хоргой лавшигийнхаа хормойг жимбийлгэн өвдөглөн сууж асан ахайтан нүүрсээр лавай болтол өнгөлсөн үл ялиг орсгойдуу цагаан шүд яралзуулан инээж байснаа босоод хормой хотоо гүвэнгээ:

-Юмаа гэж Юм-Агас ахайтныг хэлж байгаа юм. Сэвлэг үргээхэд авсан бэлэгнээсээ энэ эмээлээс бусдыг нь тоодоггүй ээ. За, миний охин Даадаадаа очиж ээдмээ ид. Алив, Үзмээ дэвтээсэн нимбэг, буцалсан устай бэлтгэ гэв.

Хол ойрын зочид голдуу үүр цүүрээр замдаа гарцгааж,өчигдөр үдшийн ноёдын цуглааны дараа хан өөрийнхөө өргөөнд хоноглосон болохоор хатан ганцаараа нойрсоод хар эрт сэржээ. Тэгээд өвөртөө эр нөхөр нь байхгүйг санан гуниглаж,жаалхан охиноо тэврээд унтдаг ч байж уу хэмээн харамсахдаа “Энэ бяцхан амьтанд би ангир уургаа амлуулан өсгөсөн ч биш дээ.Хаа холын халх угсааны энэ харц барлаг хүүхний халуун энгэрт наалдан нойрсч, ангир уургийг нь хөхөж өссөн энэ охин надаас хол хөндий, хүний хүн шиг болихвол яана?” хэмээн охиноо өрлөг эхтэй нь хардах сэтгэл урьд урьдынхаас илүү зүрх сэтгэлийг энэлгэн зовоохыг мэдэрлээ.Тэгээд нар битүүгээр босч хувцаслаад охиноо сэрэхийг хүлээж байснаа уйлах дуунаар нь шивэгчнээ явуулсан нь тэр байж. Өдгөө харин өөдөсхөн охинтойгоо жаал тоглож, бэлэг сэлтийг нь үзүүлж, амттан чихэр өгч эрхлүүлж байх зуур нар ч дээр хөөрч, бас тэр хооронд Сэнгэ хунтайжийн хөсгийг үдэлцэнгээ эр нөхөртөө тунирхаад авсан тул ааш зан нь

засарчээ. Найрын зочин эрсийн нүд булааж, хатад ахайтнуудын атааг хөдөлгөсөн гоо үзэмж, залуу насны жавхлангаа хадгалах олон нууц Доржравдан хатанд байдгийн зах зухаас Ханджав гадарлах болоод буй билээ. Ижил мөрний тэртээд өнгөрөөсөн бага залуу насандаа хатантан биеэ ариглан гоо үзэсгэлэнгээ тордох олон арга сурсан ажгу. Хатан үдэш бүр нүүрэндээ халуун ээдмээр бигнүүр тавьж, гарынхаа цагаахан өнгийг хадгалахын тулд элгэн таргаар шавж, торгоор ороогоод унтана. Үүгээр ч үл барам, хаа холын Турфан, Хами, Бээжингээс элдэв төрлийн жимс авчруулан зооглож, зуны цагт мах огт үл хэрэглэх бөгөөд нимбэг хэмээх хачин исгэлэн жимсийг хатаан буцалсан усанд шүүсийг нь идээшүүлээд хамаг биеэ шавшин арьсаа залуу охидынх мэт чивчийсэн чанга гөлгөр байлгадгийг Үзмээ шивэгчнээс нь халти мөлт дуулсан билээ. Мөн хаа холын хангай газраас хараалч цэцэг гэх гэзэгтэй юм шиг хөх ягаан цэцэгсийг уут уутаар нь түүлгэн авчирч хандлаад өтгөн гэзгээ угаана. Бэлхүүсээ бүдүүрэхээс болгоомжлон цэгдэгнийхээ дотуур хэдэн алд гяраг бүсээр тасартал орооно. Халхаас авчирсан хушны нүүрсээр өдөр бүр шүдээ өнгөлнө. Царайны тунгалаг, нүдний хар цагааныг ялгаруулахын тулд цөсөө өтгөрүүлэхгүй хэмээн сардаа нэг удаа шар сүү ууж гэдэс дотроо эргэтэл бөөлжинө.

Энэ бүхнийг дуулаад харц бүсгүй гайхахдаа “Ээ бүү үзэгд, гоо үзэсгэлэнгээ хадгална гэж эм хүний бас нэг үйлийн үр юм даа “ хэмээн бодож билээ.

Тэр өдрийн орой нар ханын толгойд бууж байх үес Ану охин аавынхаа өөрт нь зүсэлж өгсөн шийр цагаан унаганы нуруун дээр мордож, хэнээр ч түшүүлэлгүй хоёр гурав алхуулсандаа учиргүй их хөөрөн баярлажээ. Угаас өсгөлүүн төрсөн тэр унага зунжин ус ургамал тэгш баян бүрдэд ногооны сөлтэйг идсээр бараг л давжаахан даага шиг харагдахаар тэвээрч, цээж өндөр, зоо уужим, урд хоёр хөл нь зэгзгэр урт, яваандаа хурдан хүлэг болох шинж бүрдэж эхэлсэн байлаа.

Анхлан эцэг нь охиндоо зүсэлсэн унагыг авчран эзнийг нь нуруунд нь мордуулах санаатай өөрийнхөө хөтөч Мандахыг дуудан ” Алив хө, тэр шийр цагаан унагыг аваад ир” хэмээн зарлиг буулгаад өөрийнхөө ойр зуур унадаг жороо бууралд охиноо мордуулаад хөтлөн явж зугаацуулж байв.

Хөтөч Мандах бол адуунд хорхойтой гэж жигтэйхэн. Байнга морь унасаар явган явахдаа хоёр хөлөө солбин хол хол гишгэн хайвганадаг , цалам шидсээр гар нь өвдөгнөөс доош унжих болсон идэрхэн улаан эр.

-Жаа, эзэнтээн. Энэ унага бараг дааган насны адуу шиг харагдаж байна шүү. Хурдтай болно доо гээд тэр авчирсан унагаа өхөөрдөх, бахдах хосолсон харцаар харж, нударгаараа нурууг нь энхрийлэх мэт арчиж байв.

-Миний охин. Аав нь энэ унагыг охиндоо өгнө. Энэ чиний морь болно. Анугийн морь. За харав уу? гэж хан охиндоо хошуу цорвойход, эцгийнхээ өндөр буурал морины жолоог атган хөөрцөглөж асан бяцхан Ану гялаан толгойдоо үлдсэн хоёр сонжуугаа сэжин гэдэсхийж:

-Би бууяа. Аавын морь муухай. Миний морь хөөрхөн. Даадаа миний эмээл аваад ирээ хэмээн чарлав. Энэ дуу шуугианаар Доржравдан гэрээсээ ухасхийн гарч, Цэвээн хатны гэрт цайлж суусан их бага хоёр хатан ч юу болж буйг сонирхон хүрээд ирцгээхэд, өрлөг эх нь Юм-Агас

хатны өгчилгөсөн харганан бүүрэгтэй, утсан сүлжмэл мөнгөн чимэглэлтэй хөөрхөн эмээлийг барьсаар ирэв.

-Морио дараа жил даага болохоор нь эмээллэдгийн миний хүү. Одоо аавынхаа морийг унаж байгаад буу гэж эхийгээ хэлэхэд:

-Үгүй ээ.Ижий цаашаа. Би өөрийнхөө жижигхэн морийг унана.Эмээлийг нь тавь, ааваа хэмээн зөрлөө.

-Давжаахан дааганаас дээр унага байгаа юм.Алив, Мандах наадахаа эмээллэчих. Миний охин ийм л шийртэй хүүхэд дээ. Монгол хүн моринд дурлана гэдэг зөв хө хэмээн эцэг нь улам өөгшүүлэхэд Доржравдан хатан наран сөрөг урт хилэн нударгаа өргөн саравчилж байгаад охиноо ширүүн харж:

-Юу гэсэн хэл вэ!Ингээд наашаа гэхээр цаашаа болоод байдаг янзын хүүхэд шүү.Бүсгүй юм байж дандаа морь, сэлэм гэх юм. Та юунд энийг өөгшүүлж байдаг юм. Байтлаа эхээ элэг барьдаг хүн болох нь гэх зуур хөтөч Мандах яах ийхийн зуургүй шийр цагаан унагыг охины бяцхан мөнгөн эмээлээр эмээллэчихсэн байлаа.

-Галдамаа ах нь бас гурван насандаа эмээл дээрээ ганцаараа тогтож сурсан юм. Бүстэй хүүхдээс дутах юу байхав, миний охин. Алив аав нь мордуулж өгнөө гэсээр эцэг нь сонжуу модгонуулсан зөрүүд бяцхан авхайг өөрийнх нь хүлгийн зоонд мордуулж, жолоог нь атгууллаа.

-Аав цаашаа бай. Би өөрөө гэнгүүт бяцхан охин дөрөөндөө хүрэх яагаа ч үгүй бяцхан хөлөөрөө давирчихав. Шийр цагаан унага ч бяцхан эзнийхээ хүслийг ойлгох мэт ухасхийхэд:

-Тэнгэр минь!Болиоч,хонины морь биш дээ! хэмээн эх нь ухасхийнгүүт цугласан хүмүүс ч сандран ам амандаа уулга алдаж байх зуур хөтөч Мандах хоёр алхаад цулбуурыг нь барин авлаа.

-Юу гэсэн хэл вэ! Чи ингэж байгаад ойчвол ижийгээ яана гээ вэ? Яана гээ вэ? гэсээр хатантныг охиноо зууран авахад охин ход ход хөхрөн:

-Чи намайг унахгүй гэж мэддэгүйм уу? Ижий? Би ердөө унахгүй. Чүү чүү хэмээн угалзтай хөөрхөн гуталтай жижигхэн хөлөөрөө давирах аядан томоогүйтнэ.

-Үгүй ер, сургаж номхруулаагүй унагаа ганцаараа унаад давхих нь гээч. Үгүй ер.Эцээхэн зоримог хүн болох нээ.Зөв хө. Охин хурга л юм даа. За аав нь буулгаж авья хэмээн хан хэлэх нь хүүхдээ төрхгүйтсэн ч, тийм л байгаасай гэсэн далдын хүсэлд нь нийцсэн үед эх шиг нь эмээхийн оронд харин ч миний үр удам ийм л эрэмгий болох нь хэмээн омогшдог эцэг хүний зан билээ.

-Энэ хүүхэн өөрийгөө гоодож үрчлээгээ хэрхэн толийлгохов гэж л арга барж суудгаас биш үр хүүхдээ тоодог юм уу. Нялх хүүхэд ч гэсэн энийг нь мэдээд элэг барьж байхгүй юу хэмээн Цэвээн хатан хөх хамбан нударгаараа амаа таглаж байгаад хажуудаа зогсоо Нуранд донжтой

нь аргагүй хэлээд авснаа гэмгүй царайлан:

-Эвий. Сүнс нь зайлчих вий гэсэн чинь юу ч болоогүй юм шиг төрхгүйтэхийг нь. Аавыгаа дууриагаад ийм зовхи өөдөө байгаа байх даа хэмээн эр нөхөртөө тал засав.

-Харин тийм ээ.Хатантан минь. Доржравдан ахайтан энэ бяцхан амьтнаар түрий барьж хан эзнийг өргөөндөө уяж суухаа л боддог болохоос биш эхийн ялдам сэтгэлээр хайрлах биш дээ. Тийм болохоор хүүхэд эхээ тоохгүй байх нь хэр шүү дээ гэж Нуран хариу шивнээд хүүхэддээ санаа зовсондоо зүрхээр нь хатгуулсан хүн болж далимд нь доржпалам шигтгээ гялалзуулсан цагаахан гараараа цээжээ даран эр нөхрөө түшин зогсох дунд хатан руу хүйтнээр харав.

-Хар даа,та. Хүүхэд морь унасан биш бас далимдуулаад эзэнд наалдсаныг нь гэж бага хатныг зэвүүцэхэд их хатан үрчгэр хацраа илэн хажуу тийш гэмгүй царайлан хазайж байгаад:

-Овтой эм шүү.Чи бид хоёрын бэлчээр гүйцэхгүй гэчихээд дунд хатан,хан хоёрын зүг харан:

-Алив Доржравдан минь, одоо зүгээр зүгээр. Нэг их сүржигнээд хүүхэд айлгачихна. Ану миний хүү Цэвээн ижийнхээ өргөөнд ирээрэй. Шинэ гоёхон эмээлийг нь бас , морь унаж сурч байгааг нь мөсөн чихрээр мялаая хэмээн саяхан бага хатантай нийлэн муучлаагүй юм шиг ах зах хүний буурь заав.

-За.Бас Нураа ижийнхээ гэрт очноо. Гэр нь гоё.Та над бас илжгэн чих өгнө тийм ээ?гэж аавынхаа энгэрт наалдсан эрх охин хэлэв.

-Тэг миний хүү...Ижий...нь Нураа ижий нь хатаасан гоё илжгэн чих өгнө гэж хөөрхий шоовдор залуу хатан баярлан хэлэхэд хоолой нь сааралтав.Цовоо цолгин охины хэлсэн “Нураа ижий” гэсэн хоёрхон үг л хөөрхий золгүй бүсгүйн сэтгэлийг тэгтэл донсолгоход хангалттай байлаа.

Хэзээ ч үр хүүхэд төрүүлээгүйдээ ямагт гуниглан энэ өргөөнд ирсэн цагаасаа хойш их, дунд хоёр хатны сөргөлдөөний золиос болж, угаас цаг төр, Ойрадын чуулганы их ажилд дарагдан өөрт нь санаа тавих завдалгүй явдаг эр нөхөртөө шоовдорлогдсон энэ бүсгүйн сэтгэлийг Ану охин л хааяа ч гэсэн баясгана. Хоёр ч удаа хэвлийдээ үр тээсэн ч эх болж үрээ үнэрлэх аз дутсан хөөрхий бүсгүй энэ охиныг анх мэндлэхэд аргагүй л дунд хатанд жөтөөрхсөн ч, бяцхан цэнхэр дурдан баривч тоодгонуулан хаа нэгтээ Ануг тэнтэр тунтар алхлан өргөөнд нь орж гарах болсон цагаас эхлэн өөрийн эрхгүй сэтгэл татагдан хайрлах болсон билээ. Насан туршдаа нялх нойтон сормуустнаар “ижий” хэмээн дуудуулахгүй нь хэмээн гашуун хувь заяатайгаа эвлэрсэн түүнийг Ану охин л “Нура ижий” хэмээн дуудан элгийг нь дэвгээх тул бяцхан авхайн дуртай илжгэн чих, нанжин чавга, хушга, наргилын самар тэргүүтнийг ганц түүнд л гэж эрж хайж, олж тавьдаг болсоор уджээ.

Ингэж бяцхан Ану сэвлэгээ үргээлгэсний маргааш эцгийнхээ зүсэлж өгсөн унаган хүлгийн нуруунд мордон хэнээр ч түшүүлэлгүй хоёр алхуулсандаа баярлан хөөрч, өдөр бүр “Миний морийг аваад ир” хэмээн шийр цагаан унагатайгаа тоглох болж билээ.

Хүмүүс ихэнхдээ тав зургаан нас хүртэл үзсэн дуулснаа санадаггүй, тэгээд ой дурсамжаа



Тодхон санах болсон тэр үеэ л “ухаан орсон үе” гэлцдэг ч хоёр, гурван насандаа тохиосон зарим онцгой явдлыг сайн санадаг. Ану ч ийнхүү сэвлэгээ үргээлгэсний маргааш өөрийнхөө шийр цагаан унаганы нуруунд мордож байсан намрын тэр оройг “...Эцээхэн зоримог хүн болох нээ.Зөв хө...Охин хурга л юм даа” гэхдээ аавынх нь нүд өхөөрдлөөс гадна бахархлаар гэрэлтэж байсныг сүүлчийн амьсгалаа татах мөчийг хүртэл тодоос тод санаж байсан санж.

## Дөрөвдүгээр бүлэг

Гахай жилийн хаврын дунд сар гарч байлаа. Аргын тооллын 1659 он. Зургаан настай Ану сартай хилэн хар мориноосоо буув. Морийг нь өрлөг эхийнх нь хүү Балсан уяд үлдэв. Тэр хоёр Зэгстэйн цөөрөмд өвөлждөг хоёр ангирыг очиж холоос харж байгаад замдаа баахан оньсого таалцан тоглож яваад гэрийнхээ барааг хармагц мориныхоо хар хөлсийг асгартал давхин уралджээ. Чингээд Ану хөвгүүнийг тоосон дундаа хаян түрүүлж сэтгэл амраад ирэхэд нь уяан дээр Очирт цэцэн ханы өндөр буурал морь баахан морьдын дунд дүүхэлзэн зогсох харагджээ. Ханы хөтөлгөө морьдыг Мандах хөтөч нь адуутай нийлүүлэхээр хөтөлж яваа харагдана. Өргөөний өмнөх морины уужим уяан дээр таних танихгүй нэлээд олон морь байсны дотор Галдамаа ахынхаа суман хар дэлтэй согоон саарал морь байхыг хараад “Ээ гялай, ах ирчихэж. Нум сумаар нь харваж үздэг хэрэг ээ” хэмээн охин баярлан сэвхийтэл мориноосоо буугаад Ойрад заншлаар олон салаалан гөрж, мөнгөн оосроор уясан өтгөн хүрэн гэзгээ савчин хөл дээрээ догонцон дэвхцсэнээ:

-Аав ирсэн байна. Бас Галдамаа ах. Би бичгийн өргөө рүү орлоо. Чи миний морийг уяд, эмээлийг нь аваад хөлсийг нь сэврээчих гэж ихэмсгээр тушаагаад харайн одлоо.

-Тэгьеэ. Ашгүй, Мандах гуай холдоод явчихлаа. Тэхгүй бол хаврын хатуу цагаар морио хөлөртөл давхиж шарлаалаа гээд намайг л аашилна хэмээгээд хүү Анугийн морины цулбуураас барьж авлаа. Охины сэвлэгийг үргээхэд Юм-Агас хатны бэлэглэсэн харганан бүүрэгтэй, утсан сүлжмэл нарийн хийцтэй, оюу шигтгээт мөнгөн баавартай хөөрхөн эмээлийн гөлөм нэлээд элэгдсэнээс үзэхэд бяцхан авхай моринд үнэнхүү хорхойтой нь илт. Энэ өргөөний бүсгүйчүүдийн дотроос эзэн ханы ажил хэргээ явуулдаг бичгийн их өргөөнөө соёрхолгүйгээр дайран ордог ганц л хүн бий болсон нь Ану билээ.

Охин багадаа жижигхэн товчин хамартай байснаа одоо хамар нь шулуухан өндөрдүү болсноос өтгөн хөмсөг, жижигхэн нүд нь илүү зохицлоо олсон мэт харагдуулах агаад аливааг нэвт ширтэх урт сормуустай жижигхэн нүд царайг нь улам хөөрхөн атлаа үеийнхнээсээ хавьгүй буурьтай харагдуулж, үлмэдэг тахир өтгөн хөмсөгний нь хэлбэр хан эцэгтэйгээ бүүр ч адилхан болгожээ. Жижигхэн хар нүд нь эхтэйгээ адилхан бүйлс хэлбэртэй болж, нууц давхраа ороод харц нь яг түүн шиг үе үе жоготой цоргих атал Доржравдан хатны нүдэнд гэрэлтэн байдаг сээтэгнүүр аалигүй төрх огт үгүй, алив хүний өөдөөс төв чигчээр цоргин ширтэх агаад гайхах, баярлах үедээ зүүн хөмсгөө өргөн духайна.

“Уяан дээр юун олон морь байгаан бэ? Аав өргөөндөө хуралдай хийгээгүй байлтай. Тийм юм болно гэж надад юу ч айлдаагүй юм чинь. Орчихдог юм бил үү?” хэмээн охин өчүүхэн тээнэгэлзсэнээ эцгийн хайраар түрий барин дураараа аашилж сурсан зангаараа хаалганы нь арслан толгойт алтан шармал бариулаас нь угзран онгойлгоод яваад орчихлоо. Бичгийн өргөөний гурван хавгастай зандан хаалгаар хүн ороход чимээ өгөн жингэнэдэг хонх нь охины хүчтэй угзарснаас болж ердийнхөөс илүү чангаар хангинан дуугарах дуутай зэрэгцэн:

-Аав аа! Би Зэгстэйн тэндээс ирлээ гэсээр орж очлоо.

Найман ханат уужим саруул өргөөний хойроос баруун тийш зээглэн суусан хүмүүстэй нэг л чухал юм зөвшилцөн хөмсгөө атируулж суусан хан хөл хөөр болсоор орж ирэх охин руугаа

зүүн хөмсгөө өргөн бухимдангуй хараад яриагаа завсарлан хоолой засахад нь эцгийн алба ажилтай завгүй байхад садаа болсноо ойлгосон хэрсүү охин аавынхаа нэг хиа Уламбаярын ухасхийхээс ч урьтан буцаад годхийн гарлаа. Гэр рүү хөл тавиад буцан гарах зуурт харж амжсан хүмүүс гэвэл ямагт тэднийхэнтэй саахалтын зайд нутаглан дагалдаж явдаг холын төрлийн Юмнэрэн тайж, Галдамаа ах нь, бас өртөө зайд байх Сэрүүн бүрдийн хийдийн хоёр гурван лам, эцгийнх нь бичгийн түшмэл Чингэл гүүш, Улаанхүү бичээч болон зуут мянгатын ноёд баатрууд цуглаж, бултаараа царай хүрлийлгэн дүнсийгээд аавынх нь яриаг чагнаж байсан санагдана.

Охин ийнхүү аавыгаа хүзүүдэн эрхэлж чадаагүйдээ урам хугаран “Өө, ингээд аав дандаа алба ажил, хуралдайтай, эс бол хол яваад өгөх юм. Надад цавчилдах эрдэм зааж өгч, хамтдаа бургас цавчина гэсэн байж...Одоо ижий дээр очих уу,яахав?За яршиг. Ижий, гэрийн тоосыг гүв гээд Үзмээ,Жавзан хоёроо загнаж байвал яршиг. Аавыг ирэхээр дандаа л тэгдэг юм чинь. Даадаагаар давхар бин хийлгэж иддэг хэрэг” хэмээн бодолхийлэн зогсох зуур Очирт цэцэн ханы шадар хиа Цанжид гэрээс гарч хоолны өргөө рүү явах гэснээ авхайг хараад зогстуссанаа:

-Авхай минь энүүгээр эргэлдээд хэрэггүй.Явж тогло гэж эзэн хэлүүлж байна. Гашуудалт хэрэг гараад байгаа.Хүүхэд энд байгаад хэрэггүй хэмээн өвдөг дээрээ суун тусч байгаад учирлан хэллээ.

-Байз. Юун гашуудал болсныг надад хэл л дээ. Хэн үхсэн юм бэ? гэж охин асуугаад зүүн хөмсгөө өргөж яг эцэг шигээ захирангүй харцаар өөдөөс нь тас ширтэхэд эр дунд насны, хэзээ ч дуугаа өндөрсгөх буюу намсгалгүй нэгэн жигдээр учирлан ярьдаг заншилтай тэр хүн хүүхдийг өхөөрдөх, бас эзний авхай хэмээн хүндлэхийг хослуулан :

-Авхай, тэгж хүндэтгэлгүй ярьж яаж болдог юм?Хэн таалал болоо вэ? гэж ярьдаг юм. Манай Ойрадын шашин номын их багш Зая бандид багштан жанч халсан байна.Ум ма ни бад мэ хум гэж хөмсөг зангидан гашуудаж, харамссан, басхүү балчир авхайг сургамжилсан царайтай атлаа ердийнхөөрөө намуухан дуугаар хэлээд зоогийн өргөөний зүг хурдлан алхлав.

Охин ганцаар үлдээд ижийнхээ өргөөний өмнөх сэхээвчийн зүг элдвийг бодолхийлэн аажуухан гэлдэрлээ.Ижий нь өргөөнийхөө эргэн тойронд зулзаган хайлаас, өмнөдөөс авчруулсан үзэмжит цэцэгтэй сакура мод бут тариулан сэхээвч бариулсан нь өсч төрсөн Ижил мөрний орд өргөөгөө санагалзсаных бөгөөд охин тэнд саатан тоглох дуртай ажгуу.

Тэртээ барлагуудын гэрүүдийн тэндээс Мандарваа, Булган хэмээх эгч дүү хоёр охин “Ану авхай! Хэдүүлээ чоно тарвагацах уу?” хэмээн даллацгаахад “Үгүй ээ.Та хоёртой тоглохгүй.Явж нусаа арч” хэмээн ундууцан хашгирахад өнөө хоёр охин хашаа хорооны цаагуур бултасхийн далд орлоо.

Авхайн том дуугаран”Нусаа арч!” хэмээн хэн нэгнийг зандрах чимээнээр хатны өргөөнөөс өрлөг эх нь гарч ирээд:

-Өө, та хоёр хэзээ хүрээ ирээв?Балсан хаачаа вэ?Зая багштан жанч халж, өргөөнд гашуудлын хоног хураахаар болсныг дуулав уу?Орж халуун юм оочлон дулаацнуу даа? Алийв гар нь

даарчаа юу? хэмээн аргадангуй хошуу дэвсэхэд мөнгөн өнгөтэй шашир хоргой хошмоглон эмжсэн, шагайныхаа дээхнүүр татсан урт хормойтой үүлэн хээтэй хөх ягаан хөвөнтэй дээлийнхээ цэнхэр хилэн нударга дор халуу дүүгэн буй хоёр жижигхэн гараар өрлөг эхийнхээ ширүүн улаан сарвуунд хүрч, нэлээдгүй тээршаасан дуугаар :

-Хар л даа. Даараагүй байхад. Би ямар тийм нусаа чирсэн дааранхай амьтан биш. Юу ч идэхгүй ээ. Юм бодмоор байна хэмээгээд улаан угалзтай канчин гутлынхаа хоншоороор цас цоохортсон шороо сэндийлж гарав. Өрлөг эх:

-Байг. Газар сэндийлдэггүйм. Ижийд тань таныг даараагүй, юм идэхгүй гэнэ хэмээн дуулгаадахья гээд баруун тийш саравчлан Балсан хүүгийнхээ барааг нэг харчихаад ашгүй өргөө рүү орчихлоо.

“Томчууд тэгдэггүй юм, ингэдэггүй юм гээд зааж сургаад юутай бэрх юм бэ? Хэзээ нэг хэнээр ч заалгаж сургамжлуулахгүй өөрийнхөө зоргоор байх бол доо. Зая багштан цастын оронд морилохоор одсон. Бид хаврын адаг сард хойноос нь явна гэж аав ярьж байтал багштан бүрлээч болжээ. Үгүй ер, лам хүн үхэхээр заавал юу гэнэ вэ,” жанч хална” гэдэг юм байх даа. Дараа нь ааваас асууя даа, байз. Тэгээд аав одоо нэгэнт Зая багштан үгүй болсон болохоор тэртээ холд байх цастын орон гэдэг рүү нь явахаа болих болов уу, яах бол? Тэгвэл ч Зая багш юу билээ, жанч халсан нь үнэхээр тоогүй юм болох нээ.” хэмээн бодон удтал суусаар хөл нь даарч, өрлөг эх нь халуун хайлмаг ид хэмээн дуудахад сая хатан эхийн өргөөнд оржээ. Ийнхүү Ойрад түмний номын их багш Зая бандида Намхайжамц таалал төгссөн их гашуудлын хоног хурааж, Очирт цэцэн ханы өргөөнийхөн дөчин ес хоногийн турш цагаан хоол зооглохоор болж, Сэрүүн бүрдийн хийдийн уншлагын лам нар залагдан ирж, хойдын буяныг нь үйлдэн ном уншаар олон хоногийг үдэж билээ.

Рабжамба Зая бандид Намхайжамц нь шороон гахай жил буюу аргын тооллын 1599 онд мэндэлсэн гэдэг. Түүнийг багад нь Сирхабаг, Сирханбух хэмээдэг байсан гэж тэмдэглэгдсэн ч түүхэн сурвалжаар нотлогдоогүй аман мэдээгээр уламжлагдан иржээ. Эцэг эхээс өгсөн нэр нь ийнхүү тодорхойгүй боловч сахил хүртсэн номын төвд нэр нь Намхайжамц. Монголоор дуун хөрвүүлбэл Огторгуйндалай юм. Ойрадын номын их багш, соён гэгээрүүлэгч Зая бандидын угсаа гарал намтарт нь тэмдэглэснээр яс нь хошууд, овог нь гөрөөчин шангас ажгуу. Өвөг нь дөрвөн Ойрад даяар машид алдаршсан Хүнхүй Заяач хэмээх ажээ. Баавханд 8 хөвгүүн байснаас тавдугаар хөвгүүн нь Зая бандид буй за гэжээ. Намхайжамц дөрвөн Ойрадаас алс хол Төвд оронд шашны ном суралцахаар одсон язгууртны 32, ардын 120 хүүхдийн хамтаар явжээ. Тэд аргын 1616 онд эх нутгаасаа гарч Хөх нуураар дамжин могой жил буюу аргын 1617 онд Төвдөд хүрсэн байна. Намхайжамцын анхны сурсан сургууль нь цанид хэмээх шашны гүн ухаан заадаг хийд байв.

Далай ламын ширээнд шинээр тодорсон хувилгаан гэлэнгийн сахил хүртэхдээ Төвдийн Литан хийдэд очиж нэг үе сууж, шашин номын тэргүүн энэ их хүний ирээдүйн үйл хэрэг бүтэмжтэй байхыг билгэдэн тусгай зан үйл гүйцэтгэдэг уламжлалтай байжээ. Далай ламыг Банчин богдоос гэлэнгийн сахил хүртэх тэр ёслолд Төвдийн шилдэг 10 гэлэн суудал гүйцээж сахилынх нь номыг уншихад тэр арван гэлэнгийн нэг нь Рабжамба Намхайжамц байсан гэдэг. Тийнхүү бурханы шашны төв Цастын оронд шилдэг арван гэлэнгийн нэг болж Далай ламын сахилын номыг уншина гэдэг маш их нэр төртэй хэрэг байв. Зая бандид Намхайжамц

тийнхүү алс холын Цастын оронд шашны номд хорин хоёр жил суралцсаны дараа түүнийг монгол хэлтэнд шашин дэлгэрүүлэх хэмжээнд хүртэл эрдэм номд нэвтэрсэн гэж үзээд Банчин богд, тавдугаар Далай лам тэргүүтэн мутрын эрихээ соёрхсон ажгуу. Рабжамба Зая бандид Намхайжамц эх нутагтаа эргэн ирснээсээ хойш Монголын тусгаар тогтнол, эв нэгдлийг бэхжүүлэх, шашин дэлгэрүүлэх, шашны ном зохиолыг эх хэлнээ хөрвүүлэх зэрэг улстөр, шашны үйлст насан эцэслэх хүртлээ 20 гаруй жил хүчин зүтгэсэн нийгэм, улс төр, шашин соёлын нэрт зүтгэлтэн байсан билээ.

Хошууд аймгаас тодорсон номын их багш Зая бандид тийнхүү жанч халан хүний ертөнцийг орхисон явдал Очирт цэцэн ханыг хамгаас илүү харамсал, гашуудалд унагасан юм.

Шуудайд хийсэн үхрийн эвэр шиг зүг зүг харалцаад буй Ойрадын ноёд Зая бандид Намхайжамцтаны айлдвараар, хулгана жилийн зуны эхэн сард Илийн зусланд цуглан чуулахаар ам хэлээ ололцоод байтал “Үхрийн сүүлэн дээр хутга” гэгчээр ам мөлтөс жанч халчихдаг. “Хувьтай хүн хулгана жилийг үздэг” гэдэг сэн. Хошууд аймгаас төрсөн шашин ном, бичиг эрдэмд төгс энэ их хүнд хувь дутна гэж яавч үгүй. Харин Ойрад түмний хувь дутагдаа л энэ их хүмүүнээ ийнхүү цаг бусаар алдав” хэмээн Очирт цэцэн хан номын өргөөндөө хэдэн хоногийн турш элдвийг бясалган суухдаа бодсоор байлаа. Аливаа ард түмэн өөрийнхөө суутныг төрүүлж, тэр хүн нь түүхэн хувь заяаг нь залдаг. Монгол түмний үсэрсэн цус, тасарсан мах байтал халх Ойрадаар талцан хэдэнтээ цусаа урсгасан нь багадсан юм шиг, тахиа жилийн намар \аргын 1657 он\ Эмиль голын тэртээ Ойрадууд баруун, зүүн гар болон тэмцэлдэхийн даваан дээр Зая бандид Намхайжамц багштан болиулсан. “Хувьтай хүн хулгана жилийг үзмүй. Хулгана жилдээ Илийн зусланд Ойрадын ноёдын их чуулганыг хийвэл зохилтой” хэмээн айлдаад тэнгэрийн оронд одсон их багштаныхаа хойдын буяныг номын ёсоор үйлдэж дөчин есөн хоногийг нь хураагаад алтан шарилыг нь Раашлхүмбэ хийдэд залж оршооход хүрэлцэн очсон Очирт цэцэн хан зуны эхэн сард Лхаст мөргөл үйлдэхээр мордохдоо бяцхан охин Анугаа эхийнх нь хамт, мөн бага хатнаа бас дагуулан явжээ.

“Зая бандид Намхайжамц багштан жанч халжээ “ хэмээн анх дуулсан өдрөө аав намайг дагуулаад цастын оронд мөргөлд явахаа больчих юм биш байгаа хэмээн бяцхан цээжиндээ түгшиж байсан Ану ижийнхээ хамт зөөлөн нумтай мухлаг тэргэнд суугаад алсын аянд гарахдаа сэтгэл хөөрөн догдолж байлуга.

Өргөөнд олон өдөр гашуудлын хоног хураан, залагдан ирсэн лам нар ном уншиж байхад чанга хашгиран шуугиж, инээж хөөрч болохгүй гэдгийг хэрсүү ухаандаа ойлгоод дэггүйтэн үймүүлэхгүй томоотой байж, өдөр өнжилгүй үзэмтэй будаа, хайлмаг, шүүрмэг, хавсаа боов, сүүтэй будаа\Ойрадууд сүүтэй тасалсан гурилаа сүүтэй будаа гэнэ\ гэхчлэн махгүй хоол зооглосноос уйдан махассан, бүрлээч багштаны шарилыг оршооно хэмээн холын холд одсон ааваа тэсэшгүй ихээр санан үгүүлснээс орондоо нэг бус удаа нойтогносон тэр олон хоног сар ашгүй өнгөрч, урьд хожид явж үзээгүй алсын замд гарна гэхээс балчир охины нойр хүрэхгүй орондоо эргэж хөрвөөсөөр үүр цайлгаж билээ. Хүүхэд л юм хойно нэг л мэдэхэд ижийнхээ анхилуун үнэрт зөөлөн эгэмд наалдан нам унтчихаад нар битүүгээр өрлөг эхийгээ дуудахад Даадаагаа дандаа элэг барьдаг зангаараа халуун хэвтэртээ хоргодон хөнжилдөө шургах гэтэл:

-Өө, ингээд эрт босдоггүй хүүхэд хэвтэртээ хоцроод ижий аав нь чамайг гэрт нь орхин Цастын оронд явлаа даа. Ануг орхиод явцгаая цугаараа гэх эцгийнхээ дуунаар гэнэт үсрэн

босч гэр дэх хүмүүсийг инээлгэж, өөрөө тийнхүү томчуудын тоглоом тохууны бай болсондоо шаралхан уйлаад өрлөг эхийнхээ энгэрт очин наалдах зуур нээрээ орхиод явчих вий гэж сэмхэн тойруулан харахад, эх нь өргөөнийхөө зүүн хойморт байдаг танан чимэглэлтэй том толь руугаа хяламхийн шанхныхаа хэсэг үсийг засч байхыг харангуут хор шарандаа хурдан хурдан хувцаслав. Харин эцэг нь охины унтуу хөдөлснийг мэдсэн мэт гараад явчихсанд нь дотроо их л баярлаад ижий рүүгээ муухай харан харан дээлээ бүслүүлж байлаа. Охиныг тийнхүү өөртөө эрэмших зандаа баригдах буюу, эхээсээ алив нэгэн өөгшүүлэл эрэн уйлмаар болоход ижий нь ихэнхдээ ийнхүү эс ойшоодог, охиныхоо дотоод санаа бодол, алив шаналгааг бус гагцхүү өөрийнхөө хэр сайхан харагдаж байгаад л санаа тавьдагт дургүйцнэ. Охиныг хувцаслаад өрлөг эхтэйгээ гарч ирэхэд сая ижий нь дэргэд ирж, тэр хоёрын сууж явах зөөлөн нумтай бүхээгт тэрэгний хажууд зогсоод бараа бологчдодоо заавар өгч байсан эцэг рүү нь очихоор охины гараас хөтлөх гэхэд Ану гараа ууртайгаар угз татан аваад аав руугаа өөрөө гүйчихлээ.

Наран дөнгөж мандаж, улбар ягаан туяагаар газар дэлхийд мэхийн инээмсэглэж байх шиг, юм бүхэн өнгөлөг, алсын замд гарна гэхээс догдолсон сэтгэл нь тогоотой сүү дэврэх шиг хөөрсөн охиныг мөн л ааш зан сайхан, хол явахад билгэдэл бодон магнай тэнүүн зогсох аав нь тэврэн авч духан дээр нь үнэрлэлээ. Анугийн эхтэйгээ хамт суух мухлагт тэрэгний ард арай хуучивтардуу боловч, шар цацагт улбар хамба хилэн чимэглэлтэй өөр нэгэн тэргэнд бага хатан Нуран Алмагүл шивэгчнийхээ хамт суусан байлаа. Нүдэнд нь ямагт гуниг хурж явдаг залуухан бүсгүй, дуу хадаан гүйж ирсэн Ануг хараад мухлаг тэрэгнээсээ гарч ирэн хацар дээр нь үнсээд еэвэн өглөө. Өглөө нойрмоглоод, бас оройтож боссоноосоо болоод өөрийг нь үлдээчих вий гэсэн түгшүүр, хүүхдийн яарч догдолсон сэтгэл нь цатгалдаад зэлгээн хярамнаас өөр юу ч хоолой давуулаагүй охин тэр еэвэнг амаа олохгүй идэж байтал эх нь ирж тэргэндээ сууж буй Нурангийн ар нурууг сүлбүүрдэх мэт ширэв татаад :

-Алив, одоо тэргэндээ суу. Гэдэс чинь зайлагдаад бөөлжих вий. Юун болох болохгүй юм идээд байна? гэж охиноо зандраад бага хатанд хандсан нь илт “Элдэв идэж уух юмаар хүүхэд өөртөө татах санаатай” гэж нөхөртөө дуулдахгүйгээр уцаартай зуунги хэлснээ хөтчийнхөө авчрах гал шарга мориндоо мордоод ачаа хөсөг, хатдынхаа суусан хоёр мухлагт тэрэг рүү инээмсэглэн ирж яваа хантныг хармагц хоёр нарийхан хөмсөгнийхөө зангилааг сулхан уяасан гогцоог хөвөх мэт дорхон нь тэнийлгээд юу ч болоогүй мэт мишгээхийг ижийдээ түрүүнээс хойш ундууцангуй байсан охин ажиглаад улам ч дургүйцэн эцэг рүүгээ ухасхийж:

-Би аавтайгаа сундлаад явна. Ижийтэй хамт тэргэнд суухгүй хэмээн зөрүүдлэв.

Эх охин хоёрын энэ зөрөлдөөнийг мухлаг тэрэгнийхээ гэгээвчээр ажиглаж суусан бага хатан “Элдэв идэж уух юмаар хүүхэд өөртөө татах санаатай” хэмээн тухайлан өөрт нь зориулан шидсэн дунд хатны үгийн хариу болгох мэт санагдсан “Ижийтэй хамт суухгүй” гэсэн охины үгэнд дотроо сэтгэл ханан инээмсэглэлээ. “Энэ бяцхан амьтныг эхийн хайраар хайрлахгүй байж, ямагт хантны сэтгэлийг өөртөө татах арга мэх болгон ашиглаад байгааг нь нялх хүүхэд өөрөө хүртэл мэдээд байгааг энэ ахайтан эс гадарлана гэж үү? Тэнгэр юунд ийм шударга бус юм бэ? Хэрэв надад үр заяадаг юм бол бүстэй, бүсгүй ялгаагүй, сэтгэл минь хэчнээн тэнийн баярлах бол? Эх хүн болж, үр заяадаг л юм бол надад хан эзний сэтгэл хувирах, эс хувирах ялгаа юун” хэмээн бүсгүй гуниглан бодож, хэдий өөр шашинтай ч, бурханы орон Лхасын

эрдэмт мэргэн лам хувраг, ариун гэгээн шүтээнүүдэд мөргөн залбирч, үрийн хутаг гуйхыг мөрөөдөн гөлөрч явлаа.

Охины зөрүүд занг яагаад ч эс дийлэхээ мэдэх эх нь хүүхдийн энэ төрхгүйтэлд дургүйцэх, эс бол өөгшүүлэхээ мэдэхгүй толгой сэгсрэн, зүүлт чимгээ дуугарган, тэр хангинан жингэнэх чимээндээ өөрөө таатай гэгч нь зогсоход аяны хөнгөн эмээл тохон, нил хөх индранил эрдэнийн чимэглэлтэй алдтадсан махир сэлэм, нум саадаг агссан нөхөр нь сахал дороо инээмсэглэх атал түүнээ нууж, охин руу өхөөрдөнгүй хараад :

-За яахав.Тэгээд ижийнхээ үгийг дуулахгүй, заавал аавдаа дүүрүүлж явах юм бол ам цангалаа, бөгс холголоо, буумаар байна гэхгүй.Бууж үдлэх хүртэл хагас өдөрчийн газар явна шүү дээ.Чадах юм бол нааш ир дээ гэлээ.

Замд өмсгөх гэж тухайлан хийлгэсэн мөнгөлөг хоргойгоор хошмоглон эмжиж, үүлэн цэнхэр минчүүгээр оёсон урт тэрлэгийнхээ хормойг өргөн эцэг рүүгээ ухасхийсэн охин өөрийг нь сорьж, басхүү тэсвэр тэвчээрт нь эргэлзэх маягаар хэлсэн эцгийнхээ үгэнд шар нь хөдөлж, зогтуссанаа хөмсгөө зангидан,хөмхий зуун хэсэг зогссоноо эцэг эхийнхээ царай руу ээлжлэн хилэнтэй гэгч нь хараад:

-Та нар юунд дандаа намайг нялцгай жаахан хүүхэд гэж боддог юм бэ?Би үдлэх хүртэл мориор аавтай явж чадна.Хараарай гээд эцгийнхээ хөтөч Пагваа өөд ихэмсгээр ширвэхэд өнөөх нь охиныг өргөн эцэгт нь дүүрүүлэв. Хан өнгөн дээрээ охины зөрүүд өөрийнхөөрөө занд гонсойн буруушаах мэт царайлавч, үг хэлсэн хэлээгүй ямагт эргэн тойрны зарц барлагуудаас өгсүүлээд өөрийг нь ч санаснаараа хөдөлгөж чаддагт нь сэтгэл хангалуун буй нь илт, сахал дороо мушийгаад морио давирангаа Анугийн дагзнаас өхөөрдөн үнэрлэх аж.

Тэрхэн мөчид Доржравдан хатан хормойгоо өргөн мухлаг тэргэндээ суух зуур төрхгүй аашлах тусам эцгийнхээ хайрыг татаж буйд нь дотроо охиндоо атаархах сэтгэл төрж байгаагаа мэдрэн хөмсөг атируулав.Тийм ээ. Эр нөхөртөө таашаагдах гэж л өдийг хүртэл амьдарсаар ирсэн түүний хувьд энэ бяцхан охин шиг өөрийнхөөрөө байх мөч хэчнээн байсан бол? Бүү мэд. Ямагт дотроо нэгийг бодсон ч ,гаднаа тэс өмнөө дүр төрх гарган,эгнэгт бүхнийг эрхшээгч эр нөхрийн таалалд нийцүүлэх гэж элдвээр аашлах, өөрөөс нь арван таван насаар дүү, нүд хөмсөг болсон хөөрхөн хотон бүсгүйг бага хатан болгон буулгахад нь дотроо энэлэн өмрөх зүрх сэтгэлээ тас барин хүлцэнгүй царайлах, эр нөхөр нь бага хатны өргөөнд морилсон шөнүүдэд дэрээ нэвгэртэл уйлж хоноод, өглөө нь хар хороо нууж, хавдсан нүдэндээ хүйтэн жин тавиад инээмсэглэн угтах, аливаа явдалд уур унтуу хэчнээн хүрсэн ч энэ хүний нүдэн дээр л бол утааг нь амаараа гаргалгүй цээжиндээ тэр уурын галыг унтраан өнгөрөх, төрж хөнгөрөн бүдүүрсэн биеийн гоолиг галбирыг эгүүлэн авчрах гэж арван алд гяраг бүсээр амьсгалж чадахгүй болтол ороох, амттан шимттэнээс татгалзан өлөн хоосон байх, их хатны хорон санааг тэсч өнгөрүүлэн худал дүр эсгэн сайхан загнах...Тийм ээ худал хуурмагаар дүүрсэн энэ амьдрал хариуд нь хэчнээнхэн жаргалыг хайрласан билээ түүнд? Гэтэл өөрийнх нь яс махны тасархай, энэ өөдсийн чинээхэн охинд бол тийнхүү худал хуурмаг аашлах, эцгийн хайрыг татах гэж элдвээр арга мэх хэрэглэх, тэр хайрыг нь хэвээр нь хадгалан үлдэхийн төлөө дуслын төдий ч чармайлт хэрэггүй байх нь. Хэчнээн шударга бус вэ? Эх хүн төрүүлсэн үртэйгээ ийнхүү барьцан, сэтгэлдээ атаа жөтөө агуулах нь нүгэл бус уу?

Охиноо юунд хоёр ууган хүүгээсээ бага хайрладгаа одоо л ухаарах мэт. Нуган үрс мэндэлснээрээ эр нөхөр, хадмын гэрт нүүр тал байр суурь олж авсандаа ч биш, мөн л хоёр хүү төрүүлснээрээ эрт оворжсон үрчгэр царайдаа бардамнал тодруулдаг асан Цэвээн хатныг давсандаа ч бус. Өөр шигээ бүсгүй дорой төрөлтөн биш, хийморилог эр хүйстэйд нь, одоо энэ Ану шиг өөртэй нь эр нөхрийнх нь хайрыг булаалдах мэт сэтгэгдэл хэзээ ч төрүүлж байгаагүй учраас л хөвгүүддээ энэ бяцхан охиноос илүү их хайртай байдаг байх нь.

-Аав аа, одоо цастын орон харагдах болж байна уу? Юу... тийм хол юм гэж үү? Хөх нуураас хол гэж үү? хэмээн охины шулганасан дуу алсран холдож, хатан бодлынхоо ертөнцөд гагцаар хоцорлугаа.

Алсын замд явах хантны ачаа хөсөг гэж гучаад тэмээ гурван бүхээгт тэрэг, толгойн харуул, хэвтүүлийн жараад баатар эрс, аягачин шивгэчин, хөсөг хөтлөөч, агтчин, хоол зоог бэлтгэх хөгшин залуу хоёр зам гээд зуугаад хүнтэй цастын орны зүг эртлэн хөдлөв. Охины өрлөг эх Ханджав бие барагтайхан амьсгаадангуй буй тул хамтдаа замд гарч чадсангүй, хөсгийг саахалтын газар морьтой дагаад сүү өргөн үдэж хоцорлоо.

-Даадаа! Би танд Далай ламын шүншиглэсэн бурхан авчирч өгнө. Бас дээлийн түвд хоргой, яг ижийнхтэй ижилхэн гал шаргал өнгөтэйг авчирч өгнө. Битгий уйл гэж охин өрлөг эхээсээ салах тэр мөчид хэвлүүхэн гэгч нь хэлээд мордохдоо өөрөө аяга дүүрэн нулимсаа дуслуулахгүй гэхдээ хөмхийгөө зуун нүдээ цавчрахгүйг хичээн цааш эргээд аавынхаа гарт буй цулбуураас атгаж билээ.

Охины хувьд төрж өссөн гэр өргөө, сэтгэлд дотно элстэй дов толгод, алсад ногоорон үлдэж буй дасал болсон Дуутын бүрдэн дэх зуслан, сүүн цацал өргөөд нүдэндээ нулимс цийлэгнүүлэн торойн хоцорч буй хайртай өрлөг эхээ орхиод ийнхүү анх удаа алсын моринд дөрөөлж буй хэрэг байлаа. Урьд дандаа эцэг нь холын аян замд явдаг, чингээд эгэн ирэхдээ гэр өргөөнийхөндөө ховор сонин бэлэг авчирч өгдөг, охин тэгээд очиж үзээгүй, төсөөлж үл чадам тэр газар орны байдал ямар болохыг зураглах хэмээн оролдон, өөрөө бас аав шигээ тэгж алс газрыг зорьж үзэх сэн хэмээн мөрөөдөж явсаар өнөөдрийг хүрсэн билээ. Гэтэл тийнхүү холын замд гарч буй энэхэн мөчид ангир уургийг нь амтлан төрсөн шиг нь ээнэгшин дассан өрлөг эхээ орхиод, гэр өргөөгөө нүдний үзүүрт алсран үлдэхийг үзээд балчир сэтгэлийнх нь нэгэн эмзэг газар хөндөгдөн, төрөлх нутагтаа хоргодохуйн зөн нь анх сэрж буйг өөрөө ч мэдэхгүй хөөрч догдлохын хажуугаар нууцхан гуниглаж байв.

Аавынх нь уужим суудалтай эмээл хэдий эвгэйхэн ч нэлээд хол газар морьтой явсны дараа аргагүй л бөгс нь холгогдон чилж, нар хөөрөх тусам агаар улам халж, Алшаагийн их элсэн далай эцэс төгсгөлгүй мэт шаргалтан үргэлжилж, охины ам нь тэсэшгүй ихээр цангавч “Та нар юунд намайг нялцгай жаахан хүүхэд мэт боддог юм бэ? Би үдлэх хүртэл явж чадна” хэмээн ам алдсандаа баригдан “Юм ууя ч” гэсэнгүй, үзээгүй газар орны байдлыг сонирхон явсаар л байлаа. Хэрэв хайртай өрлөг эх нь хамт явсан сан бол ч зэлгээн хярам авчран морины явдал дунд ч хамаагүй уулган цангааг нь тайлах байсан даа. Гэтэл Даадаагийнх нь оронд охиныг асрах учиртай, эхийнх нь шивэгчин Үзмээ цагаан царайгаа наранд борлуулахгүй санаатай мухлагт тэргэнд хоргодон биеэ оторлож яваа биз...

-За ингээд Алшаа нутгийнхаа төв рүү орж ирж байна даа миний үр. Өмнө зүгт тээр тэнд



Дэрстийн тойром гэж бяцхан нуур харагдаж байна. Усны шувууд ирдэг юм гэхчлэн аав нь охиныг балчир гэлтгүй газар усаа үзүүлэн зааж явах сайхан байсан ч тэртээд зэрэглээн дунд мяралзах цэнхэр усыг хараад ам нь тэсэшгүй ихээр цангаж , тэрмэн тэрлэг хөлсөнд нэвтрэн толгой нь эргэж эхлэв.

Тэгтэл ашгүй хуяг дуулга, сэлэм дөрөө харших чимээ дуулдан эцгийнх нь шадар хамгаалагч солгой Лувсанхайдав зуузай холбон зэрэгцэж ирээд нүд нь сүүмийн гархилж, дээлээ нэвт хөлөрсөн охиныг хараад :

-Эзэнтээн,одоо нэг үдэлнэ байгаа.Та бид бол ч яана вэ.Хүүхэд, эмэгтэйчүүд аяншиж буй биз. Даан ялангуяа бяцхан авхайтан бүүр цангаж яваа болтой гээд бүлээн устай дашмагнахаа амыг нээн охин руу сарвайлаа. Усны бараг үнэрээр ангасан охины нүд сэргэн эмээл дээрээсээ ухасхийн хүнд дашмагийг шүүрч аваад хахаж цацан залгилахад хамраар нь буцаад садрав.

-Ишш, муу охиноо ангааж алдаж ээ.Алив, үдэлцгээе.Асар босгож, сүүдрэвч гарга гээд хан охиноо эмээл дээрээс буулган хөтөчдөө өглөө.

Саахалтын цаанаас хөсөг ч хөврөн гүйцэж ирэв. Өрлөг эхийнх нь эр нөхөр юм гэсэндээ Лувсанхайдав охиныг өрөвдөн дашмагтай усны үлдэгдлээр толгойг нь шавшин, дээлийх нь энгэрийг ярж цээжийг нь норгох зэргээр эхийнх нь тэрэг гүйцэж иртэл асрамжлав.Хэдий өдий хол замд халуун говь дундуур хагас өдөр шахуу эмээл дээр явсан гэхэд Ану хамар амаараа садруулан байж цайны аяга хэрийн ус ууж, толгой цээжээ норгонгуут нүд нь сэргэчихсэн өндийж:

-Аав аа,би үдлэх газар хүртэл ам ангалаа,бөгс холголоо, бууя энэ тэр гэхгүй явж чадаж л байгаа биз дээ?Одоо би явж бие заслаа гээд хармагийн бутны цаагуур орчихлоо.

Эцэг нь мухлаг тэрэгнээсээ буугаад хормойгоо өргөсхийн ойртон ирж яваа дунд хатан руугаа нэг хараад охиноо өхөөрдөн инээмсэглэв.

Энэ охиныг мэндлэхийн өмнө “За даа, тавь ч хүрлээ.Эцгийнхээ хүрээгүй насыг насалж явна. Нуган, охин үрстэй болж, бэр буулгаж, хадамд гаргаж, дайн тулаан хийж, олж, алдаж, анд нөхөд, атаатан дайсантай ч болж, нартад үздэгээ үзлээ.Эдүгээ Дөрвөн Ойрадын төрийг түшилцэж яваад үхэхэд хэзээд гомдолгүй “ хэмээн санаж,хасагийн хантай хийсэн тулаанд баруун хавиргандаа олсон хуучин шарх тэнгэрийн муухайд янгинах бүрд үнэхээр хадан гэр ойртож буй мэт санагддаг байсан нь ч яалаа. Энэ шулганаа жаахан амьтны хөлийг дөрөөнд хүргээд, удам угсаа сайтай хүнд өгч сайн сайхан явааг нь үзтэлээ гол тасрахгүй мэт бодогдон, урьдынх шиг гагцхүү төр улсын хэрэг, Халх Ойрадын эв нэгдэл гэхээс илүү,хэнз нялх үрийнхээ хойчийн амьдралд сэтгэл чилэн явах болсон ажгу. Тиймдээ ч “Аавын бийд хүнтэй танилцаж, агтны бийд газар үз” гэдгийг санан цастын оронд охиноо эхтэй нь аваад явахаар шийдсэн билээ.

-Ганц удаа ам ангалаа гэхгүй өдий хүртэл яваад ирдэг. Үгүй мөн шийртэй хүүхэд ээ.Бүстэй төрсөн бол ч хэмээн Лувсанхайдавыг хэлэхэд тэр таа муутай хяламхийгээд:

-Бүсгүй хүүхэд тусмаа ингэж тэвчээр зааж байгаа ч юм уу? Хэн мэдлээ гээд дотроо их хатнаас төрсөн урагш муутай Гартангомбо хүүгийнхээ тухай “Манай Гартангомбо бол эр сүвтэйгээс цаашгүй бүтэл муутай амьтан шүү дээ. Тэр бол одоо ч ийнхүү говь дундуур хугас өдөр амаа чийглэлгүй явж дөнгөхгүй” хэмээн бодоод царай нь барайн сунадаг шар дурангаа гаргаад хол ойрыг хараачлав.

Тэд өргөөнөөсөө гараад долоон хоног хошуудын унаган нутаг говь дундуур зүүн өмнө зүг барин явсаар Алшаа уулын бэлд ирлээ. Өнгөрсөн жил ганц удаа Хөх нуур орсноос өөр хол газар хааш ч явж үзээгүй, намхан намхан элсэн манхнууд, Дуут, Дэрстийн бүрдийн хөгшин хайлаас, заг, тооройн ногоон шугуйд нүд дассан бяцхан охин сэрийсэн хад асга нь харлан үзэгдэх олон ам нугачаатай сүрлэг их Алшаа уулыг хараад гайхан биширчээ.

Зуны тэргүүн сарын хөхөмдөг униар дунд тэртээ тэнгэрийн хаяанд зүүрмэглэх мэт хөхрөн харагдсаар байсан энэ уул бэлд нь хүрээд ирэхээр ийм амьсгал давчдам сүрлэг байх гэж.

Үдэш Ануд эцэг нь, Тангудын хааны үзэсгэлэнт Чагаа гүнжийн домгийг ярьж өгөөд бас, Чингис хаан Уйгурын хаанд Алалтун бэхи гүнжээ өгөхдөө “Хатан хүн гурван эртэй болой. Анхны эр нь төр болой. Удаахи эр нь авсан нэр буюу. Гутгаар эр нь ёсолж авсан эр нөхөр нь больюу. Төрөө түвшин, нэрээ бүтэн авч явахын цагт авсан эр алс хаа одох “ хэмээн сургасныг хүртэл өгүүлэхийг сонссоор охин нэг л мэдэхэд зуны сэрүүн сайхан үдэш, асрын үүдэр үзэгдэх тунгалаг хөх тэнгэрт хээнцэр одод нэг бүдгэрэн нэг тодорсоор нойрны зөөлөн бөхөд автсан байлаа.

Маргааш өглөө нь эрт хөсөг цааш хөдлөхөд говьд ховорхон тохиолдох зөөлөн бороо шивэрч байлаа.

-Урьд өдрийн шүүсэнд гаргасан хундан хонь хээлтэй байсан гэнэ. Хээлийг нь хүүхдэд үзүүлэвзэй. Ихэр хурга байсан байна. Энэ хонийг ихрийн удамтай, хээлтэй гэж хэн ч мэдээгүй юм байх даа. Анзааргагүй гэдэг нь гэхчлэн аавыгаа ярихыг нойрон дундаа сонсон, тэр сонссоноо зүүдэндээ оруулан “Даадаатайгаа хамт хоньчин айлд очин нялх төл үзэж байна. Гэтэл олон нялх хурган дундаас хоёр ихэр хүн толгойтой хурга өөдөөс нь чиглэн майлалдаад хүрээд ирэх юм гэнэ. Чингээд тэр хоёр хургыг сайн харах ахул хоёулаа охин хурга байхын гадна, мөнөөх хамт тоглодог эгч дүү Булган, Мандарваа хоёр байх юм. Тэгтэл Мандарваа нь “Булган зүгээр хөөрхөн чихтэй байхад, намайг юунд хув чихтэй хурга болгов?” гээд уйлж, нусаа гоожуулан байхыг хараад өөрөө “Чи нусаа арчаач. Юун хув чих” хэмээн зандарч байна” хэмээн зүүдлээд сэрэхэд гадаа бороо орж, эцгийнх нь аяны хөх үүлэн хээтэй цагаан асрын дээврээд зөөлөн шивэрч хурын чийгний сэргэг сайхан үнэр хамар цоргиж байх аж. Охин тэр хачин зүүдээ санан нойрмоглож хэвтсэнээ ухасхийн өндийж хэзээний сурсан зангаараа:

-Даадаа! хэмээн чангаар дуудлаа.

Охины хашгирах дуунаар ижийнх нь шивэгчин Үзмээ орж ирээд:

-Авхай сайхан унтав уу? Чиний Даадаа чинь энд байхгүй. Газрын сүрд дарагдана гээд өргөөнд хоцорсон шүү дээ. Хувцаслаад өглөөний цайгаа уу гэхэд Ану бяцхан булцгар хөлөө

хучлаганаасаа гаргаснаа өрлөг эхээ энд байхгүйд сая үнэмшиж урам муутайхан өндийж ирэв.

Тэгээд зүүдээ Үзмээд ярих гэснээ түүний хайхрамжгүйхэн харц, охиныг асрах халамжлах үүргээ бушуухан шиг гүйцэтгээд холдох сон гэсэн шиг цаанаа л нэг яаруу сандруу шинжтэй зогсоог хараад больчихлоо. Учир нь тэр бол ангир уургаараа тэжээсэн хайртай өрлөг эх нь биш, ердөө л ижийнх нь шивэгчин Үзмээ байлаа.

Тиймээс өрлөг эхдээ эрхэлдэг шигээ хөнжилдөө шурган туньсангүй ухасхийн босч, мөнгөн гадартай усаар нүүр, гараа булхсан болоод эзгий, үзэмтэй хайлмаг, самнаа боовыг ам руугаа чихлэн хурдхан шиг цайлаад аавдаа очихоор гүйн одлоо.

Алшаагийн их говийг туулах энэ зүдэргээнт аялал гэртээ байдаг бүхий л тохь, тухыг умартуулсан ч Ану охинд хамгаас аз жаргалтай өдрүүд болж байлаа. Өглөө сэрээд л аавынхаа цээл сайхан дууг сонсч өнөөдрийнх шиг хам хум цайлаад аавдаа очих гэж яарна. Гэртээ байх үед бол ихэвчлэн өөр өргөөнд нойрсч өглөө эртлэн босоод, голдуу бичгийн өргөөндөө залран ийш тийш бичиг захидал илгээн, хэрэг зарга таслан, энд тэндээс ирсэн гийчин, элч төлөөлөгчтэй уулзах зэргээр ямагт завгүй, ажилд дарагдан байх буюу зайлшгүй аянд мордон оддог аав нь аяны энэ урт замд л өдөржин түүнтэй хамт, үргэлжид нүдэн дээр нь байж, үлгэр домог хуучлан, том том цагаан шүд яралзуулан морины тухай олон дууг сэтгэл сэргэтэл исгэрнэ.

Аманд элс шажигнуулсан Алшаагийн их говь шувтран алсад уулсын бараа тодроход охин ааваасаа:

-Та ямар дуу исгэрч байгаан бэ? хэмээн асуугаад нүүр рүү нь өлийн харав.

-Эркин зээрд морин гэдэг дуу даа, үр минь.

-Морины тухай дуу юм байна тиймээ, аав аа? Тэгээд энэ дуунд юу гэж гардаг юм?

Лхаст заларч буй Галдан хүүтэй уулзахын хамт Далай ламд мандал өргөх болон шашин төрийн хэрэг, Манжтай харилцах зүдэргээнт харилцааны тухай гүн бодолд орчихсон явсан Очирт цэцэн алсад бэлчсэн ухаан бодлоо оролцуулалгүйгээр охиныхоо асуултанд зөнгөөрөө л хариулж байснаа сая л сэхээ оржээ.

-Аан?

-Өө, та миний яриаг сонсохгүй байгаа юм уу даа? Охин хэзээний эз дийлж сурсан эрх танхи, басхүү төрөлхөөсөө захирангуй зангаараа эцгийнхээ царай руу ширтлээ.

-Сонсож байнаа, сонсолгүй яахав хэмээн гэмшингүй өгүүлэх эцэг нь хоромхон зуур оюун бодлоо төвлөрүүлэн зангидаад ширвээ сахлынхаа нэг үзүүрийг имэрснээ:

-Энэ дуунд Эркин зээрд морин

Түмэн агтын түрүүнд

Түрүүлэвч яахав

Кэтийн заяа мэдэм зэ

Гунан зээрд морин

Гучин агтын түрүүнд

Түрүүлэвч яахав

Кэтийн заяа мэдэм зэ...гэдэг юм даа үр минь гээд хүрлэгэр царайдаа охиноо өхөөрдсөн зөөлөн инээмсэглэл тодруулав.

Охин мориныхоо дэлийг ширтэн алхаанд нь бүүвэйлэгдэх мэт чимээгүй хэсэг явснаа:

-Аав, яагаад бүх дуу дандаа морины тухай байдаг юм бэ? хэмээн санаанд оромгүй юм асуух нь тэр.

-Яагаад, яагаад хэмээн толгой сэгсрэх эцгийнх нь нүд дахин энхрийллээр гийж:

-Яагаад гэвэл бид чинь морьтон монголчуудын удам. Монгол хүн алсад эзнээ хүргэдэг эр сайн мориндоо хайртай байдаг. Тэгээд ч монгол хүн морины нуруун дээр өсдөг. Чи ч бас моринд дуртай биз дээ, хэ? гэлээ.

Эцгийнх нь энэ хариулт төгсгөл рүү гээ өөрийг нь бага зэрэг тохуурхсан өнгөтэй болсныг мэдэрсэн охины хөгжиж асан царай дахин барайж нарийхан хөмсгөө зангидан хүрлийснээ аавыгаа давах санаатай:

-Тийм л дээ. Гэхдээ яагаад над шиг хүүхдийн тухай, эсвэл гоё цэцэгний тухай дуу байдаггүй юм? хэмээн асуучихсан нь хантныг санаандгүй ацан шалаанд оруулчихжээ.

Өөдсийн чинээ ийм амьтан намайг байсгээд л хэлэх үггүй болгох юм даа хэмээн бодоод хан хоолой зассанаа:

-Тийм дуу байж бололгүй яахав. Харь улс гүрнүүдэд байдаг л байх даа. Харин монголчууд бид чинь холын замд найдвартай түшиг, эр хүний итгэлт нөхөр болсон мориныхоо тухай л дуулах дуртай байдаг юм даа гээд олон салаа годгор гэзгийг нь илбэлээ. Урьд залуудаа төрийн хэрэг, байлдаан тулаан энэ тэр гээд хүүхдүүдээ хэрхэн өсч буйг огтоос анзаардаггүй, ерөөс хүүхэд өсгөж, асрах бөөцийлах нь эхийнх нь хэрэг хэмээн бодсоор тэднээсээ баахан хөндий байсан бол өтөл насанд нь заяасан энэ хэнз охин зүрхэнд нь гүн нуугдсан эцгийн элгэн хайрыг сэрээх мэт ямагт ийнхүү наалдан, элдвийг шалгааж, заримдаа хариулах аргагүй юм асууж, эс бол гэнэн хонгор аалиараа хөрч царцсан мэт хөшүүн сэтгэлийг нь бүлээцүүлэх ажгу.

“Морь яагаад заавал эр хүний итгэлт хань гэж? Ижий, Цэвээн ижий, Даадаа, Нуран эгч бид бүгд л моринд дуртай шүү дээ? хэмээн охин гайхан бодсон ч эцгээсээ асуусангүй. Тэгээд аавыгаа дахин гүн бодолд орсныг ажиглаад морио давирлаа.

-Энд буудаллана. Үүнээс цааш газар бүүр их өндөрсч хүн мал улам л цуцна. Хүчээ нөөцөлж авах хэрэгтэй хэмээн эцэг нь албатууддаа лүндэгнэх сонсогдоход охин морин дээрээ үүрэглэж яваад цочин сэрэв.

-Хүүе авхай минь, наршчихав уу? Аль эс бол үүрэглэв үү? Давхийгээд байх чинь. Үзмээ чи юугаа харж явдаг дээлийн гол вэ? хэмээн эхийнх нь шивэгчин Жангараг зандраад охиныг мориноос буулгаж авчээ.

Алшаа уулын бэлд халх, Ойрадын мөргөлчдийн хэд хэдэн цуваа буудаллан хөл үймээн болж байлаа. Тэдний дунд халхын Түшээт хан аймгийн залуу тайж Төмөр-Очир явсан ажгу. Тэрээр бурханы оронд мөргөхөөр яваа аяны замд дөрвөн Ойрадын чуулганы тэргүүн Очирт цэцэн хантай тааралдсандаа ихэд билгэшээн орой нь залуухан гоо хатны хамт бараалхав.

-Өнөө орой ижий, аавыгаа үймүүлээд хэрэггүй. Эндээ наадаж бай хэмээн Үзмээ шивэгчин Ануд хэлээд хорол, даалуу, алтан мөнгөн боронзоор будсан зээрийн шагай дүүрэн чихсэн жижиг богцтой тоглоомыг нь асгав. Болцгор хуруугаараа олон салаа гэзгээ оролдон том хүн шиг дүнсийн суух охинд тоглох дур өчүүхэн ч байсангүй. Өдөржин морины нуруун дээр явсаар агсагадан ядарсан, эцгээ ноолон үлгэр яриулах гэтэл зочин гийчинтэй байгаа, гэр өргөөндөө байхдаа ямагт хамт тоглосоор ижил дасал болсон Балсан, Мандарваа, Булган гурав нь үгүй. Эхээс илүүтэй ээнэгшсэн өрлөг эхээ санасан зэрэг нь зэрэгцээд унтуу хөдөлнө. Ер нь хүүхэд заримдаа ааш нь олдохгүй, яах гээд байгаагаа өөрөө ч мэдэхгүй, сонин уцаар бишүүрхүү зантай болчихдог доо. Ану тэр орой яг л тиймэрхүү ааштай байлаа.

-За, хоёулаа морь уралдуулъя. Би зээрд морио уялаа хэмээн Үзмээ охиныг аргадах санаатай урдуур нь бөндөгнөн баахан шагай өрсөн ч охин “Үгүй, морь уралдахгүй” гээд тарааж хаячихаад асрын хаяанд очин зөрүү хараад хэвтчихэв. Зуны эхэн сарын орой ч уулын сүүдэр хүүшлэн, өндөр газрын сэвэлзүүр салхи асрын хаяагаар нимгэн лавшигийг нь жиндтэл үлээнэ. Арсгар барсгар хад байц нь сүглийсэн Алшаа уулын ам суга бүхэн нь үдшийн бүрийд барайн харлаад охинд нэн аймаар санагдана. Ядахад ижийг нь хошуудын бэр болж ирсэн цагаас нь хойш арван гуравтайгаасаа эхлэн шивэгчин нь болж дэргэд нь байсаар аливаад үнэн сэтгэлээсээ хандахын оронд дүр үзүүлж, юм л бол эзэн ахайтнаасаа магтаал, сайшаал хүртэхийг горилогч эрвээхий мэт дэгжин хээнцэр Үзмээгээр асруулмааргүй, түүний хэлсэн, хийсэн бүхнийг тас зөрмөөр адын хүсэл төрнө. Тиймээс л унтаж сэрээд зузаан чисчүү лавшигаа сольж, цэнхэр дурдан дээл өмсч, сэрүүц хэмээн Үзмээг хэлэхэд тэгэхээс тэгэх гэж өрлөг эхийнхээ хийж өгсөн, багадаад амаараа гарах дөхсөн буруу энгэртэй дээлийг гарган өмсөв. Энхрий, эмзэг хүүхдийг ад зэтгэр, хар цагаан хэл амнаас хамгаалахын тулд тийн зүүн тийш зөрүүлсэн буруу энгэртэй дээл хийж өмсгөдөг нь халх монголчуудын заншил ажгуу.

-Даадаа, халх яриа Ойрадууд биднийхээс их зөрүүтэй юу? хэмээн энэ яргуй цэнхэр дээлийг өмсгөнгөө “Урд хормой нь унага даага, хойд хормой нь хонь хурга, эд нь хэврэг, эзэн нь мөнх байг ээ!” хэмээн мялааж байх ахуйд нь охин асууж билээ.

-Ойрад, халх адилхан л монголчууд. Ярианд жаахан жаахан зөрүү бий. Лавшигийг халхчууд тэрлэг гэдэг юм даа гээд нүдэнд нь нулимс цийлэгнэх шиг болсон ч нимгэн уруулаа хамхин гүнзгий санаа алдахад нь жавьжных нь орчимд хэдэн нарийхан үрчлээ нэг тодроод алга болоход төвөнх нь хөдлөн тэр нулимсыг цааш нь залгичих шиг болжээ. Шинэ дээл өмсөн

сэтгэл хөөртэй байсан охин Даадаагаа гунигламагц бяцхан духаа атируулан хөмсөг зангидаад:

-Та халх нутгаа санаад байгаа юм уу даа? гэж хэрсүү гэгч нь асууж билээ.

-Төрсөн нутгаа санахгүй хүн байдаггүй юм. Гэхдээ нутгаа орхиод алсад бэрлэдэг нь бүсгүй хүний заяа тавилан юм даа гэснээ духан дээр нь үнэрлээд босчээ.

-Үгүй. Би л лав хошууд аймгаа, Алшаа нутгаа орхихгүй. Ижий, аав, Даадаа таныг санана гэж охин хэлээд шинэ дээлээ найзууддаа үзүүлэхээр гүйн одсон сон.

-Би яагаад аавын асарт орж болохгүй юм? гэж Ануг гэнэт асуухад маргааш эрт Лхасын зүг хөдлөхөд бэлтгэн хатан ахайн юмсыг эмхэлж суусан Үзмээ бараг л цочих дөхөв.

-Аав нь халхын зочдод зоогой барьж буй. Хүүхэд очоод дэмий. Асар бачуу, бүгчим гэж хүүхэн аргадангуй хэлэв.

-Хантны бяцхан авхай хаанав? Энд үү? гэх цээл хонгор дуу гэнэт асрын гадна хадахад эхийнх нь шивэгчин Жангарагийн араас уужим сайхан магнайгаа улаан торгон тасам, сувдан хэлхээгээр чимсэн, зүүн хацартаа тас хар мэнгэтэй эрвэлзэн наадсан тунгалаг нүд, ягаахан хацартай хараад баймаар гоё хатагтай орж ирээд:

-Эвий, хэчнээн хөөрхөн амьтан бэ? Охин үртэй болох сон хэмээн дуу алдахад Үзмээ ухасхийн босч, доор мэхийн хүндэтгээд хоёр алгыг дээш харуулан асрын хоймрыг зааж “Ахайтан хоймроод морилогтий!” хэмээн уриад Жангарагийн дохиогоор чигээ аягалаар зэхэв.

-Зүгээр. Би энэ бяцхан амьтныг л харах гэсэн юм. Айраг сөгнөж хөл болох юун. Тэнд дайлуулж буй юм чинь гэснээ Анугийн бумбагар хацрыг үнсч, өврөөсөө мөсөн чихэр, хуван зүүлт гарган өгөөд хүзүүг нь үнэрлэснээ “Нялхын үнэр нь яг хэвээрээ” гэхчээд гарахаар эргэв. Охин танихгүй ахайтныг гайхан харсаар байлаа. Залуу хатан гарахдаа эргэн харж, гуниглангуй болчихсон нүдээрээ инээвхийлэн:

-Чи том болоод халх нутгаар явбал Туул голын хөндийд эгчийнх нь төрсөн нутаг бий. Наад хуваа зүүж яв. Хоолойн өвчинд тустай гээд гарч одов.

Бэлэг авч хөөрсөн бяцхан охин эцгийн асар руу дахин тэмүүлсэнгүй. мөсөн чихэрт хацар амаа гөлөг мэт халтайлгаад унтаад өгөв.

Өглөө нь бороо ороод ч байх шиг нүүрэн дээр нь ганц нэг дусал нойтон юм дусалж, гадаа морьд тургих чимээнээр охин хагас дутуу сэрснээ эргэн зүүрмэглэж хачин зүүд үзэв. Ганц нэг дуслах бороон дунд танихгүй нэгэн газар нутгаар ганцаараа төөрөн бэдэрч явна. Тэр нь барзгар шар хад чулуунууд барсайсан, өтгөн ногоон ойтой сүрлэг уулсын хормойгоор захаараа хайлаас мэтийн мод бут шавсан өргөн цэнхэр гол байх ажээ. Цэнхэртэн мяралзах тэр голын хөвөөнөө өчигдрийн хуван зүүлт, мөсөн чихэр өгсөн ахайтан зогсоод:

-Бяцхан охин минь, Туул гол гэж энэ дээ. Чи том болоод энд ирнээ гэснээ гэнэт алга болж, дахин бороо дуслах юм. Охин энэ өргөн их Туул голоос хэрхэн төрсөн нутаг Алшаадаа буцах

вэ? хэмээн шаналан уйлсаар гэнэт сэрэхэд нь ижийнхээ өвөрт хэвтэж байв.

Ээж нь уйлсан болтой нүд нь сэмбийчихсэн, өөрийнх нь дээрээс нь тонгойн сууна. Урт гээг нь баруун мөрөн дээгүүрээ асгарч, цагаан торгон цамицны задгай энгэрээс сайхан цагаан цээж, охины одоо ч нялхынх шигээ сонирхон харах дуртай хөхний дундах хонхорхой нь цухуйна.

Гэвч ижийнхээ мөөмөнд тэр төдийлөн хайртай байсангүй. Ану өрлөг эхийн хөхийг хоёр ой өнгөртөл хөхөж, хожим дөрөв хүртлээ барьж унтах дуртай байж билээ. Харин төрсөн эхийн мээмийг хөхөөгүй тул нэг л харь, өөр хүнийх шиг санагдан, өрлөг эхийнх шиг нь хайр татам байдаггүй байлаа. Үүнээс ч болдог юм уу, эх нь бас түүнд нэг л хөндий санагдана.

Унтаж асан охин гэнэт нүдээ нээж дүрлийн ширтэхэд эх сандран урт савхан хуруутай гоё гараараа хацарт нь хүрэхэд дахин нэг том нулимсан дусал нүднээс нь гэнэт тасран охины эрүүн дээр подхийн уналаа.

-Ижий! Та юунд уйлаав? Аав Нураагийн д хоноо юу? гэж охин цангинуулан асуув.

Бороо дусалж байна гэж зүүдлээд байсан нь ижийнх нь нулимс байжээ.

-Миний охин зүүдэндээ өмөлзөөд байсан. аймаар юм зүүдлээ юу? Алив нааш ир гээд эх нь охиныг сайхан үнэрт энгэртээ наав.

-Гав ганцаараа танихгүй харь газар төөрчихсөн явна гэж зүүдэллээ гэж эхийн энгэрт наалдсан охин хэлээд “Бас Туул гэж их уст гол байсан” гэх гэснээ яагаад ч юм больчихоод урьд хожид үзээгүй тэр газар орон, өргөн цэнхэр бүс мэт мяралзан мушгиран урсахыг нь тодхон үзсэн Туул гэж нэртэй голын тухай дотроо бодсоор байлаа.

Тэгснээ хүүхдийн зангаар ээждээ наалдан чингэж удаан байхаас уйдаж, ухасхийн мултрад зөөлөн хэвтэр рүүгээ эргэн хөрвөөснөө гэнэт өчигдрийн явдлыг санаж, жижиг улаан жинтүүн дороосоо том том шаргал хэлхээ хув гарган ирлээ.

-Ижий хараач!

-Өө, ямар гоё юм бэ? Норжин хатан өгөө юу? Миний үрд? гэж хэлэнгээ инээвхийлэх хатны нүд гунигтай хэвээр байлаа.

-Мэдэхгүй ээ. Их гоё ахайтан байсан. Бас над мөсөн чихэр өгсөн.

-Тийм байх аа. Даанч халтар ухна болчихсон байсан юм гээд эхийн царай ширүүвтэр болж, жижиг мөнгөн хонхоо жин жин хийлгэн дөрөв дуугаргахад Жангараг, Үзмээ хоёр орж ирлээ.

-Үзмээ, тэр хуван хэлхээг охинд зүүж өгөөд хувцасла наадхаа. Хүүхдэд хув зүүлгэхэд багалзуурын өвчинд сайн гэдэг. Төмөр-Очир тайжийн Норжин хатан үрийн зулай үнэрлэж чадахгүй зовж яваа амьтан гэнэ. Утай Гүмбүмд мөргөж, үрийн хутаг гуйхаар яваа юм байх хэмээн ярихад Жангараг тахимаа шүргэсэн урт хүрэн гэзгийг нь зандан самаар самнангаа хүзүү, мөрөнд нь иллэг хийн базалж, хатан нүдээ үлмэдэг аниад урт амьсгаа аван

тайвшрахыг хичээх авч, хантан урьд шөнө гийчдээ үдэж өгөөд гэнэтхэн бага хатны асарт хоноглохоор яваад өгснийг яагаад ч мартаж чадахгүй байлаа.

Тэр өглөө охин морь унан эцгээ бараадсангүй. Яагаад ч юм нэг л номой томоотой болчихоод эхийнхээ суганд шигдэн мухлаг тэргэнд сууж явлаа.

Лхасын зүг хөдөлсөн мөргөлчид халх, Ойрад, Ижилийн тэртээх торгууд гэхчлэн зүг бүрээс нэмэгдсээр асар урт цуваа болон нийлж, хүн малын хөлд боссон тоос пургин, чих дөжрөм чимээ шуугиан, нүсэр их хөл хөсөөн үүсгэжээ.

Нутгаас гарснаасаа хойш хэдийн хорь гаруй хонож, аяншиж ядарсан охин аяны эхний өдрүүдийнх шиг үзээгүй, хараагүй газар орны байдлыг сониучлан сонирхох нь ч багасаад, замд тааралдах сэгсийсэн үстэй, улаан нүдтэй, пад хар царайлсан тангадууд, толгой дээрээ гээгээ овоолсон хачин дээлтэй түвд хүмүүсийг ч тоохоо больж, тэнгэрт оргил нь сүмбэрлэх их уулсыг уйтгарлан харж явлаа. Зүрх дэлсүүлж, цөс халиасан айхтар өндөр олон давааг эсэн мэнд давсаар хантны хөсөг Гүмбүмд ирлээ.

Тэр цаг дор Түвдийг захирч асан Даян ханы элч дөрвөн Ойрадын тэргүүнийг тосон ирж хүндэтгэл үзүүлэн, урьдаас бэлтгэн зассан асар майханд хонины ууц тавьж дайлсан нь бяцхан охинд хүчирхэг хан эцгээрээ бахархах сэтгэлийг улам их бадраав.

Алтан оройт ганжирууд нь наранд гялалзан нүд гялбуулсан сүм хийд, их Зонхов багшийн асар том алтан шуумал дүр, тахилын сүмд байх шөнийн одод газарт буусан мэт сүрлэг гоёмсог үзэгдэх хэдэн зуун асаатай зул, олон зуун лам хуран сууж, дүнгэнэтэл маань уншин хурал хурах, бие биенээ зандчаад байх мэт хачин хазгай хэлтэй, зүс буруу мянга мянган сүсэгтний хөл үймээн бяцхан Ануд гайхаад баршгүй санагдаж байлаа.

Алсыг ширтэх мэт зууван алаг мэлмийдээ юуг ч үл оноон халиах нүсэр том Зонхов багшийн зүүн өвдөгцөө хоргой цэгдэгнийхээ мөнгөн хормойгоор сүмийн шороотой бохир шалыг шүргүүлэн амарлингуй номойгоор сунан мөргөж, адбиш хүслээн сэтгэлдээ шивших хоёр хатан хувь хувьдаа тэс өмнөө зүйлийг даатган залбирч байлаа.

-Зонхов гэгээн багш минь, өчүүхэн буурай эм надад үрийн хутаг хайрлаач. Өөр надад энэ ертөнцөд хүсэх санах юм юу ч алга хэмээн Нуран хатан чин зүрхнээсээ гуйн залбирч байхад хажуудаа эрвэгэр хөөрхөн охиноо суулгасан Доржравдан нүдний булангаар бага хатны зүг хүйтэн харц чулуудаад дотроо өөрийнхөө мэддэг ганц ерөөлийн тарни шившин” Хан эзний минь шавданг бат оршоож, дөрвөн Ойрадыг олон жил захирах сэтгэлийн их хүч чадал хайрла. Энэ буруу номт хатанд үр бүү заяаг” гэхчлэн уртын уртын хүслээ шивнэн залбирч суув.

“Энэ бурхан тэмээнээс ч том мөртөө яг манай тахилын өргөөнд байдагтай адилхан юм гээч. Ёооё, өвдөг нухаад. За байз, энэ том Зонхов багшид юуны төлөө залбирдаг юм билээ? Ижийг минь бүү уйлуул, бас Даадаагийн минь зүрхийг илаар болгож, аавын төрийн хэрэг бүтэх болтугай гэвэл дэндүү олон юм гуйлаа гэж уурладаг юм болов уу?” хэмээн Ану охин бодон сууж байлаа. Тэгтэл ашгүй залбирал дуусч шүтээний сүмээс гарч явахдаа гэнэт өөрт нь хуван сондор бэлэглэсэн сайхан ахайтныг санаж, “Тэр ахайтан хөөрхөн манцуйтай хүүхэдтэй



болоосой. Ум ма ни бад ми хум” хэмээн залбирав.

Дараа өдөр нь тэднийг Лхаст очиход хотын хаяанд далай ламын илгээсэн элч угтан тосч авчээ. Лхас орох замаар мөргөлчдийн цуваа тоос шороо манаруулан хөвөрч, алсад алтан ганжир гялалзуулсан гоёмсог дээвэртэй сүм хийдүүд, олон давхарлаг байшин, хэрмэн хашаа, шавар тагз шавааралдсан их хот нэвсийн үзэгдэхэд бяцхан охин үнэхээр гайхан сүрдэв.

Аваасаа энэ их байшин сав, сүм хийдтэй хотын тухай элдвийг асууж шалгаамаар байвч, Далай ламын элч сойвон лам гэх улаан шарыг тунаруулсан хөнхөр өвгөн, түүний дагуул урт гэгчийн эрхи хүзүүндээ зүүж, үсээ хачин янзаар толгойгоо ороож сүлжсэн, эр хүн атал өрөөсөн чихэндээ ээмэгтэй төвд хүмүүс эрээн асар дүүрэн суучихаад аав нь тэдэнтэй их л чухал зүйл ярьж буй болтой.

Харин ээж нь бага хатанд дургүй атал инээмсэглэн түүнтэй юм ярьж, үзэм, чавгатай цагаан будаа идэх аж.

Лхаст тэднийг Далай ламын эзэмшлийн бага шиг нэгэн өргөөнд байрлуулав. Олон өрөөтэй, хоёрдугаар давхарт нь байх сэрүүн тагтан дээрээ ваартай цэцэгнүүд тавин хана бүрд нь бурханы зураг хөрөг өлгөсөн тэр ордны үзэмж төгөлдөр нь Ануд их таалагдав. Ордны гадаах бяцхан цэцэглэгт тогос хэмээх нүд булаам солонгорсон урт сүүлтэй гоёмсог шувууд ихэмсгээр алхлах аж.

Ижий нь тэр орой олон хоногийн аяны шороо тоосноосоо сална хэмээн асар том зэс гадарт бүлээн ус дүүргүүлэн угаал үйлдэж, Ануг ч бас угааж цэвэрлэн, аяны замд холцруутсан хацарт нь сүүлний тос түрхэж, шинэ дээл өмсгөлөө.

Лхаст байсан хэдэн өдөр бяцхан охины хувьд хэзээ ч мартагдашгүй гайхамшиг болон өнгөрч билээ.

Алшаагийн нүд алдам говь, хараа гүйцэмгүй шаргалтсан элсэн далайд төрж, өссөн охин анх удаа хэл хэлийн түмэн хүн холхилдсон их хотод хөл талбиж, хорвоо дэлхийн уудмыг балчирхан оюундаа чадан ядан ухамсарлахад бурханы орон Лхас зүйрлэшгүй том нөлөө үзүүлсэн юм.

Лхаст очсон эхний өдрөө охин ижийнхээ тэргэнд суун Их зуугийн шүтээнд мөргөхөөр явахдаа алхам тутамд үзэгдээгүй сонин гайхалтай юмстай тулгаран гэнэхэн тунгалаг нүдээр гайхан ширтсээр бараг амьсгалахаа ч мартаж шахаж байв.

-Ижий, тэр хачин хар царайтай хүнийг хараач. Духан дээрээ мэнгэтэй юм гэж час улаан саари ороосон махлаг энэтхэг эмэгтэйг заахад эх нь тэр зүг тоомсоргүй ширвэн хараад охиноо өөртөө наалдуулан тэвэрч:

-Энэтхэг жагар эмэгтэй байна. Духан дээрээ зориуд улаан зосоор энгэсэг тавьдаг заншилтай улс гэж хэлэхдээ дотроо, маргааш зах орж, жагарын орны наймаачдаас хийц сайтай гарын алтан бугуйвч, доржпалам, бадмаараг тэргүүтэн эрдэнийн шигтгээ авах юм шүү хэмээн бодож байлуга.

-Тэр ёнхор хамартай улаан хүнийг хараач. Нударга ч үгүй, хормой ч үгүй зах ч үгүй, хачин этгээд хувцастай юм гэхчлэн охин гайхан дуу алдсаар явав.

Эцгээсээ орой энэ тухай асуусан нь өдрийн үзсэн тэр гажууд хувцас, өмсгөлтэй ёнхор хамар, хөнхөр нүдтэй, халцгай улаан ягаан нүүртэй улс нь өөрсдийгөө цагаан арьстан гэлцдэг орос, пийлэн хүмүүс юм гэнэ.

Тэр ч бүү хэл тийм пийлэн ахайтнаа даган хойноос нь нохой мэт даган явах хөө шиг падан хар нүүр, дамбагар зузаан уруул, нялх хурганых шиг тачир аржийсан үстэй, нүд нь хар цагаанаар эргэлдсэн аймаар хүнийг хүртэл Ану Лхаст үзсэн ажээ. Энэ бүхнийг нутагтаа очоод Балсан, Булган, Мандарваа гуравг яривал яасан ч үнэмшихгүй дээ хэмээн охин Их зуугийн сүмд Майдар бурхан, нигүүлсэнгүй Арьяавал, орчлонг мэлмийдээ тольдогч Жанрайсэг шүтээнд дараалан мөргөж байхдаа бодсоор явлаа.

Тэднийг Лхаст ирсэн гурав дахь өдөр нь Далай ламд бараалхуулахаар болов. Далай ламд бараалхахын өмнө эцгийнх нь анд агсан Баатар хунтайжийн хүү Галдан, лам багшийн хамт тэдний өргөөнд залран ирэв.

-Галдан ламтан бурханы ном эрдэмд оройгүй болж байгаа юм байх. Мутрынх нь адисыг хүртэж, сахиус зангиа залдаг хэрэг ээ хэмээн эцгийнх нь дэргэдийн хиа Өлзий, Үзмээ шивэгчинд ярьж байхыг сонсоод олон жилийн өмнө өөрт нь хөөрхөн эмээл бэлэглэсэн Юм-Агас хатны хүү гэдгийг нь мэдэх атал яагаад ч юм багадаа нэг удаа үзсэн Зая бандид багш шиг хижээл байргашуу хүн байх хэмээн Ану бодож төсөөлж байжээ.

Галдан ламтан заларч айсуй хэмээн эцгийнх нь зам өвгөжөөр хүн хоол цай болон үзэмтэй, эззгийтэй тос хайлж, Лувсанхайдав, хамгийн сүсэг ихтэй хөтөч Пагваа тэргүүтэн үүд хаалганы хавьд цагаан эсгий дэвсэн хөл болцгоохын хажуугаар “Бурхан болооч Баатар хунтайжийн хүү Галдан ламтан нас бага хэдий ч тэнгэрт хальсан Зая бандида Намхайжамц багшганы орыг залгах их номтой хутагт болж буй гэнэ. Урьд эхээс төрөхдөө л эсэн хутагтын хойд дүр байсан бус уу?”, ”Зулай дээр нь Базардарь, магнай дээр нь Зонхов гэгээн, нүүрэн дээр нь Махгал бурхан, хоолой дээр нь Хоньсонбодьсадваа, хоёр мөрөн дээр нь хорин нэгэн дарь эх тодорсон, бар арслангийн хүчтэй хувилгаан болохын гэнэ лээ” хэмээлцэн шивэр авир хийхийг Ану сонсон тэр оройн дээд шүтээн болсон ламыг ямар хүн байдаг бол хэмээн дотроо бяцхан сонирхсон ч багадаа үзсэн Зая багш шиг намбатай хижээл хүнээр төсөөлөөд л өнгөрчээ. Гэтэл дээд тагтан дээр тогостой хөөцөлдөн гүйж явсан охиныг эх нь дуудаж:

-Миний охин Галдан ламтнаас адис ав хэмээн эцгийн зочин гийчин хүлээн авч буй тасалгаа руу түүнийг хөтлөн одоход бяцхан охины зүрх үлмэдэх шалтгаанаар догдлон, ямархан нэгэн сонин учралыг зөгнөх мэт түг түг хийн цохилж билээ.

Амнаасаа гал бадраасан арслангийн дүрт гуулин шар цагирган бариултай хоёр хавгаст гоёмсог хаалга нээгдэн, охин ижийнхээ мөлчгөр цагаан гараас хөтлөн тэр тасалгаанд оров.

Аавынх нь дэргэд ханцуйгүй улбар шар торгон дээлтэй, чийрэг боровтор мөр гар нь ил гарсан, суурин газар удаан суусных юм уу, ер бусын цэвэрхэн арьстай цагаан цайвардуу царай, давхраалаг хурц нүд, өтгөн хар хөмсөгтэй, дээд уруулын хэлбэр зузаавтар уран, их

сайхан өргөн магнайтай залуу хөвүүн сууж байлаа. Дэргэд нь өвгөжөөр, халзан түвд лам заларсан нь номын багш нь боллоотой.

-Миний охин Ану энэ дээ. Харин Доржравдан хатныг та юу эс андахав гэж эцэг нь тэр лам хөвүүнд их л хүндэтгэлтэйгээр хэлээд:

-Охин минь Галдан ламтнаас адис хүрт гэлээ.

-Ахайтан, та аян замдаа алжаалгүй сайн явж ирэв үү? Алив авхай нааш ир гэж түүнийг хэлэхэд тэр уран хэлбэрт уруулынх нь завсраар лавай цагаан шүд гялалзах агаад эх нь:

-Очирваань, Арьяавал сахиус минь авралдаа багтаасан юм уу. Сайн явж ирлээ. Галдан ламтан эрдэм номд гэгээрч байна уу? Гээд Ану хөтөлсөөр Галдангийн өмнө очин зүүн өвдөг дээрээ сөгдөн сууж адис авлаа.

Ану тэр лам хөвүүнийг үзмэгц ичингүйрэх сэтгэл төрж, баруун гараараа зулайд нь адис хүртээхэд зүрх нь нүгэлтэй түргэн түргэнээр цохилон үл мэдэгдэх нэгэн түгшүүртэй атал сайхан ч юм шиг гайхалтай мэдрэмжинд хоромхоноо автагджээ.

Охин Галдан шиг тийм цэвэрхэн царай, уран уруул, тэгшхэн хуруутай сайхан гартай эр хүнийг урьд хожид хэзээ ч олж үзээгүй явснаас гадна, бяцхан зүрх нь анх удаа өөрт таашаагдах эр хүйстнийг үзээд шохорхон догдолсныг ч өөрөө гадарлахгүй байв.

Тэр өдрийн үдийн хойно Очирт цэцэн ханыхан Далай ламд бараалхлаа. Лхас хотын захад байх Марбори толгой дээр тавдугаар Далай лам Агванлуvsанжамцын бариулсан олон давхарлаг, сүр ихт Будалин ордны дэргэд ирээд Очирт цэцэн хан ч өөрөө сүрдэн биширч байх шиг харагдав.

“Хоньсонбодисадва Авалокитшвары бурханы оршдог гэх домогт Будалин уулын алдраар нэршсэн хэдэн зуун гишгүүртэй олон давхарлаг сүрдмээр өндөр тэр ордныг Цастын орны эзэн Соронзонгомбо хааны үндэслэсэн цайз шилтгээний суурин дээр нанхиад, балба, түвд урчуудын гараар сүндэрлүүлж дуусаад удаагүй буй” хэмээн эцэг нь Анууд тайлбарлаж өгөв.

-Ийм том ордныг тэгээд нүүлгэхдээ яадаг байнаа? Тэмээнд ачиж лав болохгүй дээ хэмээн охин туйлын их гайхшран бодоод ойр явснаар нь эцгийнхээ хөтөч Пагваагаас асуужээ.

-Лхаст суудаг төвдүүд хаашаа ч нүүдэггүй суурин улс. Далай ламын ордонг бол бүүр ч нүүлгэж яахин болнов авхай минь. Энэ бол бурханы орон хэмээн Пагваа айж эмээсэн мэт нам дуугаар тайлбарлажухуй.

Түүхийг нь сөхвөөс аргын 637 онд Төвдийн Соронзонгомбо хаан өөртөө есөн зуун ерэн есөн тасалгаатай асар том ордон цайз бариулсан ч наймдугаар зуунд галд өртөн хайлжээ. Түүнээс хойш есөн зуун жилийн дараа тавдугаар Далай лам гурван мянга долоон зуун мэтрийн өндөрлөг Марбори толгой дээр Побранг Карпо хэмээх цагаан ордныг барьж 1648 онд дуусган Потранг Марпо гэх Улаан ордныг босгож эхэлжээ.

Говь нутгийн бяцхан охин ам ангайн гайхсаар ертөнцийн түмэн гайхамшгийн нэгэн болсон уул мэт өндөр сүрлэг Будалин ордны босгыг давав. Тэд тоо томшгүй олон тасалгаатай Будалин ордны нэгэн их танхимд амьд бурхан Далай ламд бараа болоочдоор нь замчлуулан бараалхлаа. Олон бурханы хөрөг дүр залсан уудам саруул тэр танхимын хойморт босоо хүнээс хэдэн толгой дээгүүр өндөр сэнтийд заларсан тавдугаар Далай лам Агваанлуvsсанжамц гэж гуч гаруй насны цонхигор царайтай хүн үзэгдсэн нь охинд тийм ч хүчтэй сэтгэгдэл төрүүлсэнгүй. Харин Далай ламд залбирч зогсохдоо өөрийн эрхгүй Галдан ламтны тухай бодоход сэтгэлд нь илүү сайхан санагдаж байжээ.

“Тэр Галдан ламтан хэдэн нас сүүдэртэй бол?”

“Морь унаж чаддаг болов уу? Тэгвэл ижий, аав хоёр шиг ижил зүсмийн сартай хар хээр морь унаад нутгийнхаа Шар хоолойгоор түүнтэй уралдан давхивал гоё оо!” хэмээн охин бодчихоод дотроо ичингүйрч байлаа.

Ийнхүү аргын 1659 оны зуны тэргүүн сарын сүүлчээр Ану охин ирээдүйн заяаны хань нь болж, эцсийн амьсгалаа зориулах голт зүрхний хайртай хүн, Зүүнгарын хаан болох хувьтай Галдан ламтай Лхаст зургаан насандаа анх нүүр учирчээ.

Энэ үеэр Чин гүрний Эеэр засагч хааны ордонд хоёрдугаар агь таван настай Кан Си буюу Сюанье дэггүйтэн гүйж яваад эхийнхээ тарьсан ховор үзэсгэлэнт удвал цэцэг бүхий үнэт хөх ваарыг хагалчихаад цээрлэл үзэж байв. Манжийн Эеэр засагч буюу Шунь Чи хааны хоёрдугаар агь Кан Си үүнээс хойш хоёрхон жилийн дараа Зүрчидийн Алтан Улсын хаан ширээнд залран Энх-Амгалан хаан нэрийдэж, хожим нь Халх Монголыг эрхшээлдээ бүрэн оруулаад зогсохгүй Дөрвөн Ойрадын Галдан Бошгит хааныг дарж, Төв Азийн элгэн дээрх хамгийн хүчирхэг гүрнийг нэгэн жарныг элтэл захирах болно.

Хувь тавилангийн хачирхалтай шоглоомоор өдгөө зургаан настай Ану, 14 сүүдэртэй бурханы шавь Галдан лам, таван наст ханхүү Сюанье буюу хожмын Энх-амгалан хаан гурвын заяа төөргийн шугам яг гучин долоон жилийн дараа халхын нутагт эцсийн удаа огтлолцох ёстой байлаа.

Тэр үдэш Очирт цэцэн Далай ламаас хайрласан Дөрвөн Ойрадын чуулганы ханы ёслолын өмсгөл малгайг агсаад Доржравдан хатныхаа хамт цайлангаа бодол санаа нь алсад бэлчин байлаа. Дөрвөн Ойрадын ч, Халхын ч дотоод хэргийг Цастын орноос удирдан залж, цол чимэг, тамга түгээн тоглож ирсэн Далай лам цагтаа Ойрадын чуулганаар сонгогдсон Хойдын Сайн хиаг чуулганы ханаар ёсчлон соёрхолгүй гэдийж байсан ч удаа бий билээ.

Бурхан багш эхийн хэвлийгээс хөрст газарт унамагцаа шууд босч алхсан алга дарам газар бүрээс нь дэлгэрсэн хэмээх домогтой үзэсгэлэнт бадамлянхуа цэцгэн хээгээр чимэглэсэн адар, цэцгэн дэнлүүний бүдэг гэрэлд үлмэдэгхэн сүүдэртэн, хойморт тахисан Арьяавал бурханы өмнө асаасан олон зулын гэрэлд хан, хатан хоёрын сүүдэр үлэмж томрон үзэгдэнэ.

-Охин унтчихсан уу? хэмээн хантан оюун тархийг эзэмдэн үл эмхрэх түмэн бодлоосоо түвэгшээх мэт гэнэт асуухад эр нөхөртэйгээ хамтдаа байх ахуйдаа амьдралын бараан сүүдэр бүхнийг хүчээр умартан ямагт эрх танхи, эелдэг наалинхай, уяхан ялдам бүсгүй төрхөө

үзүүлэхийг эрхэмлэдэг Доржравдан нарийхан хөмсгөө өргөн нүдээ сэртийлгээд:

-Бундан хацарлаад нойрсч байнаа эзэн минь.Таныг Далай багшгантай чухал уулзаантай байгааг өчиж хэлээд байтал ааваараа тангадын хааны Чагаа гүнжийн домгийг хэлүүлнэ хэмээн зөрсөөр чүү гэж л нэг юм хар нүд хамхин унтлаа гэв.

Хатан нь ийнхүү хөмсгөө өргөн сээмгэр нүдээ сэртийлгэх бүрдээ гэнэхэн, хонгорхон, эгдүүтэй харагддаг сан. Гэтэл өнөөдөр хоймроос гэрэлтэх олон зулын гэгээ, дэнгийн сүүмгэр гэрэлд хэдий гоо үзэсгэлэнгээ ид шидийн гэмээр удтал хадгалан яваа ч аргагүй дөч хэвийж буйн гэрч духных нь атираа тодрон үзэгдэхийг хан сая л ажиглав.

-Мөн,мөн.Балчирхан амьтан минь.Хүүхэд яаж өсч өндийдгийг урьдах таван хүүхэд дээрээ огтхон ч анзааралгүй өнгөрч дээ.Гэтэл надал л ямар учиртай заяасан амьтан юм.Энэ өөдөсхөн охин л голт зүрхний аргамжаа болох юм даа гэж хан хэлээд ширвээ сахлаа шувтран бослоо. Нөхрийнх нь өтгөн ширвээ сахалд нэлээд буурал орсныг харсан Доржравдан “Анх энэ хүний хатан нь болж ирээд эхний шөнөө оронд орохын өмнө хүзүүгээ үнсүүлэхэд энэ сахал нь хатгаад хамаг бие айж, догдолсондоо чичирч байж билээ.Тэгэхэд хэчнээн хар сахалтай байж вэ! гэсэн ч эр хүн өтлөн, санчиг, сахалд нь буурал орж, ухааны атираа духанд нь суух тусам улам сүр хүчтэй, хараад баймаар сайхан болох атал эм хүний толигор царайд ганц үрчлээ суухад л үнэ цэнээ лан лангаар алдаж байдаг шударга бусын хорвоо юм даа” хэмээн гуниглан бодлоо.

Нойрсохоор явж ахуйдаа хантан цаг хугацаа хэрхэн харвасан сум мэт нисэн одож, өтөл нас хаяанд буусныг хатныхаа духны үрчлээ, суларч эхэлсэн жавьжны арьсыг нь үзээд эрхгүй ухаарчээ.

Мах цусанд төрсөн хүмүүнтэй ижилхэн улс гүрэнд ч бас мандан бадрах өсвөр үе, ид цог заль төгс жавхалзах идэр нас, бууран доройтох өтөл цаг гэж байдаг аж.Манж Чин гүрэн өдгөө ид хүчирхэгжин мандаж өдрөөр бол бага үдийн наран мэт гялалзаж байхад ертөнцийг талыг эзэгнэн эрхшээж явсан Их Монгол Улс өтлөн доройтож хэдэн хэсэг тасраад гал голомтоо авч явах сүүлчийн бүтэн үлдсэн хэлтэрхий нь болсон Дөрвөн Ойрадын орших, эс орших нь өчүүхэн миний атганд байна гэж үү? хэмээн бодсоор хүнд энэ бодлоосоо салахын түүс болж хажуугаараа шурган орж ирсэн хатныхаа зөөлхөн биеийг таалан тэврээд:

-Нохой өдөр нутгаа зоривол ямар бол, чи минь юу гэж бодно? гэлээ. Наашаа зорьж явсан аян замын тэр нэгэн шөнөөс хойш нөхөр нь дахин бага хатнаа өвөртлөхгүй байгаад баярлан гийсэн хүүхэн ч урин тачаангуйн авьяасаа ид гайхуулсан наалинхай хоолойгоор :

- Тэгье эзэн минь! Хүн малаа хэсэг амраая.Буцах зам урт.Та өнөөдөр их алжаасан байх хэмээгээд уруулаа цээжинд нь наалаа...

Тэдний нойрсдог исэр орны дэргэдэх өндөр хөлтэй чамин үхэг дээр хантанд далай ламаас соёрхсон Дөрвөн Ойрадын чуулганы ханы ёслолын малгайг тавьсан нь сүртэй үзэгдэнэ. Хатан нь урьд хожид үзэгдээгүй ховор чамин унждаг ээмгийг бэлзэгтэй нь ижилсүүлэн зүүснийг нь хантан орондоо орж, салхи борооны хэрэг гүйцсэн хойно сая л ажиглан сонирхож шохоорхох сэтгэл төрж, хүүхний эрүүн дээрээс нь өргөн нүд рүү нь эгцлэн

ширтсэнээ зөөлөн уруулыг нь озон үнсч цасан цагаан хүзүү, эгэм рүү нь унжих чамин гоёмсог ээмгийг нь сонжингоо ширүүн алгаараа торго мэт гулсамтгай арьсыг нь энхрийлэн илээд өөр рүүгээ дахин татав.

-Би өнөөдөр Лхасын их зээл дээрээс ийм ээмэг авсан юм. Гэрэлт чимэд чулууг хар мөнгөнд суулгасан үнэ ихгүй ч хийц сайтай юм хэмээн хатан эр нөхөртөө таалуулангаа зөөлхөн дуугаар ярина...

Ийнхүү эцэг эхийн хамт холын Лхаст мөргөл үйлдээд буцсан нь Ану охины бяцхан тархи задран, нүд тайлсан анхных нь урт аян байлаа. Гэртээ ирээд ч охин эцэгтээ улам наалдан, дотносох нь их болж, алсад хамт явах гэж дагадаг, далим гарах бүрд харийн улс гүрэн, эзэн Чингисийн тухай, Ойрад түмний бахдал болсон Эсэн хутагтын тухай домог түүх яриулах хэмээн элдвийг шалгаах болжээ. Харин сүүдэр мэт өөрийг нь дагаж явдаг Балсан, хамтдаа тоглодог эгч дүү Мандарваа, Булган, Бундир дөрөвт Далай ламын уул шиг өндөр сүрлэг Будалин ордны гайхмаарыг, Дэрстийн хийдэд Майдар эргэж буйгаас ч олон хүн шавааралдан суух атал хаашаа ч нүүдэггүй багширсан их хот Лхасын тухай амыг нь ар дээр нь гартал ярьсан ч өргөөний эргэн тойрны хэдэн толгод, хаваржаа, намаржаа, өвөлжөө, зуслангаас цааш хэтрээгүй хөөрхий хэдэн найзынх нь ой тойнд төдийлөн буухгүй уурыг нь хүргэх агаад харин сэтгэл дотроо нууцлан хааяахан бодох болсон Галдан ламтны тухай тэдэнд ганц ч үг цухуйлгасангүй өнгөрч билээ.

Тэгээд л арга буюу ихийг үзэж, дуулсан өөрийнх нь боддогоор ертөнцөд хамгийн ухаантай хүн эцэгтэйгээ наалдах болсон нь өдрөөс өдөрт задран тэлсээр буй оюун ухааныг нь тэтгэн тэжээх ганц хүн энэ өргөөнд аав нь гэдгийг зөнгөөрөө мэдэрснийх буй за. Нэн ялангуяа харвах намнах, цавчилдах эрдэмд сургахыг эцгээсээ цуцалтгүй шаардах болсон нь Доржравдан хатны гайхшийг барж байв.

## Тавдугаар бүлэг

Намрын сөл хараахан тасраагүй нэгэн орой Очирт цэцэн хан Доржравдан хатны өргөөнөө цайлж суув. Ану солгой Лувсанхайдавын хүү Балсантай хамт өргөөний хамгаалалтын шадар зуутын цэрэг эрсийн хамт нум сумаар харвах сургууль хийж ирээд шийр цагаан мориноосоо үсрэн бууж эцэгтээ эрхлэхээр гүйн орж ирэв. Лхасаас ирээд эцгээ шалсаар төхөөрүүлж авсан алтан шармал чимэгтэй, жижигхэн гуулин дуулга, элгэндээ гялалзсан хүрэл тольт илгэн цээживч өмссөн нь хоёр мөрөн дээгүүр нь цухуйх олон салаа гэзгийг нь эс анзаарсан хүнд цог жавхлан төгс баатрын өмсгөлтэй бяцхан хөвгүүн мэт үзэгдүүлнэ.

-Аав аа! Би их сайн харвасан. Тавин тохой газраас арав харваад үхрийн ширэн байны гол дахь улаан зосон тэмдгийг таван удаа яг голд нь оносон. Харин Балсан байны голд нь дөрөв оноод охин хүүхдэд давагдлаа хэмээн аавдаа зэмлүүлсээн хэмээхэд эцэг нь охины хээрийн агаар салхи, хөлс үнэртүүлсэн духыг нь үнэрлэн үнсээд бяцхан булцгар гарынх нь баруун эрхий долоовор хэдийнээ нумын хөвч татсаар эвэршин хатуурсныг үзэн толгой сэгсэрч, омголон чийрэг үр үндсээрээ бахдан хүд хүд инээж, цайнд норсон зүүн сахлаа имрэн зассанаа:

-Өөдсөн чинээ охин байж эр цэргийн эрдэмд татагдах нь хайшаа юм бэ, үр минь? Хааяа ч гэсэн ижийнхээ үгийг дуулж, өргөө гэртээ тогтон, оёж хатгахыг заалгахгүй юу гэлээ.

-Хэлээд юухэв. Энэ хүүхдийг хэвлийдээ тээж байх ахуйдаа осол цалгар болж давхар биетэй өөр сэвгэртэй золгон хүйсийг нь сольчихоогүй л байлтай. Арьяабал шүтээн минь. Дувтан байлдах, харвах, намнахыг л сонирхох юм гэж эхийгээ хошуу нэмэхэд охин бяцхан нум сумаа гэрийн баруун уннд байх мөнгөлсөн оонын эвэрт тохохдоо эцгээдээ зүүн хөмсгөө өргөн ихэмсгээр харж:

-Би Мандухай цэцэн хатан шиг эрэлхэг баатарлаг хатан болмоор байна гэлээ.

Энэ үед Үзмээ ирж, охины илгэн цээживч, дуулгыг нь тайллаа. Эхийн өргөөний аягач Норов зэлгээн чигээ аягалан их үгт охинд өгөв. Ам нь хатах дөхсөн охин хүйтэн чигээ сэхээ мадаггүй залгилахад эцэг нь духыг нь зөөлөн илбэх зуур хөмсөг зангидан нэг барайснаа:

-Үр минь, Мандухай цэцний тухай хэнээс олоод дуулчихав? хэмээн асуухад хоолойд нь түрүүхний өхөөрдөн энхрийлсэн өнгө арилан арай ширүүвтэр болсныг анзаарсан Доржравдан амсрыг нь алталсан зандан аягатай цайгаа амнаас холдуулаад хөшчих мэт зогтусав.

Мандухай цэцэн хатан нэгэн цагт туурга тусгаар Ойрад түмнийг дайлан хурааж, их Монгол улсад нэгтгээд айраг гэхийг чигээ хэмээх, махаа хутгаар огтлохгүй шүдээр зулгааж байх мэтээр доромж дорд үзсэн зарлиг гаргаж байсныг хантан мартаж үл чадна. Гэтэл үүнээс гадна охиныг нь эхээс унаа ч үгүй хэвлийдээ нойрсч байх ахуйд хэд хэдэн удаа навсгар удган эм зүүдэнд нь ирж “Таны хатнаас мэндлэх охин хаан хүний хатан болж, хатгалдах дайсны халуун суманд өртөн халина...” хэмээсэн, нэг талаасаа билэггүй ч гэмээр, охиныг хааны хатан болно гэснээрээ харин ч сайны зөн ч гэмээр зүүд нь энэхэн хэдэн жилд мартагдах аястай байснаа бас л санаанд нь орж ирэв.

-Даадаа над хүүрнэсэн.Би түргэхэн бичиг эрдэмд сурч, тан шиг судар ном уншин, түүх шастирт юу өгүүлдгийг мэдмээр байна гэлээ.

Үгүй ер.Хий настайгаа дөнгөж долоотой гэхэд адтай сэргэлэн, их үгтэй гэж яанав.Насыг нь ес хүрэхээр Хойдын Дүүрэн бичээчид хадаг барин залж энэ охиныг тод, уйгаржин үсэгт сургая гэсэн оройтох нээ.Даруйхан цагаан сарын дараа номын багшийг нь залж авчрая даа. Сураг дуулахад нааштай байна гэсэн. Үгүй ер, бас зүгээр ч үгүй Мандухай цэцэн шиг эрэлхэг хатан болмоор байна гэнэ. Халхаас домог түүхэнд мөнхөрсөн тийм хатан төрсөн байхад манай Ойрад түмнээс болохгүй нь юу байхав. Бүсгүй юм атал мөн их үгтэй амьтан аа. Бурхан өршөөг дээ, энэ нялх амьтныг минь хэмээн үрээ өхөөрдөн бодоод барайсан царай нь дорхиноо зөөлрөн инээмсэглэв. Энэ үеэр Балсан хөвүүн орж ирээд хан эзэн, хатан ахайтандаа сөгдөн ёслоод :

-Ану,Нэмэх дарханыд очъё! Чиний илдийг давтаж хатаасан гэнэ хэмээн дуудаад гарахад охин тоорцгоо толгой дээрээ тавиад гүйн одов.Хантны өргөөний гадаа охиныг хүлээж зогссон Балсан:

-Бас ижий чамд үзэмтэй, ээзгийтэй хайлмаг хийсэн гэлээ.

-Аа тийм үү?Очиж иднээ гэж хэлэх зуураа Ану Балсангийн саарьтай гарыг харангуут гэнэт Цастын орноо суугаа уужим магнай, өтгөн хөмсөг, ховсдох мэт цоргисон харцтай, уран цэвэрхэн уруултай өнөөх Галдын ламтны бүсгүй хүнийх шиг цэмцгэр зөөлөн мутрыг санан уйтгарлав.

-Хантан минь, Аблайн үрс гаргахад Цөхүр увш, Алдар хошууч, Чуу мэргэн зайсан нар цуглан найрласан гэнэ. Аблай, Алдар хошууч хоёр санаатайгаар чуулганд морилоогүй улс.Хажуугаар нь Цөхүр увш Цоросынхны ахмад нь болж үлдсэнээрээ түрий барин давхар тоглолт хийгээд байна би ш үү? Энэ хэдэн ноён таны араар сэм нийлж буй бололтой гэж хатан цайгаа оочингоо ярилаа. Доржравдан ямагт уян наалинхай зан гаргавч, угсаа сурвалж өндөр, гүйлгээ ухаан сайтай тул үе үе хантанд ийнхүү санаагүйг нь сануулах нь цөөнгүй.

Хантны нүүрнээс дүрсгүй цовоо охиноо өхөөрдөн хайрласан аз жаргалын өнгө хоромхоноо замхран арилж хүрлийгээд:

-Чуу мэргэн бас тэдэнтэй нийлээ юу?Уг нь Алдар хошууч ,Чуу мэргэн хоёр Далай багшаас надад дөрвөн Ойрадын чуулганы ёслолын бүрэн өмсгөл, тамга хүртээснийг дуулаад мялаалгын идээ будаа,тус бүр арван лангийн алтан ембүү, баранзад хадгийн хамт илгээн найрсаг харилцаагаа илэрхийлсэн юм сан.Гэвч цаагуураа санаа буруулан Аблай,Цөхүр увш нартай сэм нийлэн хуйвалдаан зохиож буйд төдийлөн гайхахгүй байна гэснээ санаа алдав.

-Та минь бодолтой л яваарай.Сураг дуулахад Цэцэн, Зодов хоёр Сэнгийг эцгийн ор залган суухад нь хүчин хавсарч хамгийн ихээр дэмжсэнд тань өс өвөрлөсөөр явдаг гэх юм хэмээн Доржравдан хэлээд:

-Таны шар хөөрсөн бололтой.Би өвчүү далыг тань базалж өгье хэмээн гэнэт наалинхай дуугаар хэлээд шүрэн оруулгатай, есөн салаа, бүсэлхий шүргэсэн урт сувдан унжуургаа



жингэнүүлэн намс намс алхалсаар нөхрийнхөө дэргэд очлоо.

Хатан гарын алгаа хүйтэн болгох гэж мөнгөн гадартай булгийн цэнгэг усанд дүрээд зориуд цасан цагаан бугуйгаа эрдээ харуулан өөртөө тачаах сэтгэлийн галыг нь дүрэлзүүлэх гэж хоёр хилэн нударгаа тохой хүртэл шамлаад эр нөхрийн хүдэр чийрэг хүзүү, ид залуугийн хэвээр буй зузаан дал мөрийг базлан жаргааж эхлэв. Хүүхний цэл хүйтэн, торго мэт зөөлхөн танхилхан алга хүзүү, чих, чамархайд нь хүрэн базлах бүрд алжаал ядралыг умартуулан тоост ертөнцийн хэрэг явдлаас таслан сансрын хийд хөөрөх мэт аятайхан мансуурлыг авчирна.

-Уухай, уухай. Чиний минь мутар хэчнээн ч шидтэй юм дээ. Хүзүү толгойн зааг дээгүүр эцээхэн чангахан баз. Уухай даа. За болно доо. Алив энд суу гэж хан хэлээд хатнаа өвөр дээрээ суулгахдаа урьд урьдынхаас ялимгүй жин нэмснийг нь анзаарч, махлаг бөөрөнхий ташаа, гоолиг нарийхан хэвээрээ бэлхүүсээр нь тэврэн цагаахан хүзүүг нь үнэрлэж, нүцгэн бугуйг нь янаглан илнэ.

Хүүхэн эр нөхрийнхөө цээжинд шигдэн наалдаад:

-Би танд одоо хөгшдөж байна уу? Нас минь дөч шүргэчихлээ гэнгээ нөгөө л сэрүү татуулсан зөөлөн алгаараа чихнийх нь арыг илбэн нүдээ анилаа.

-Юуны хөгшдөх билээ дээ. Чи минь өдрөөс өдөрт сэтгэлийг минь улам өөртөө татах юм гэж хан амьсгаа нь давхцаж тачаадангуй хэлээд хатныхаа хүзүүг зөөлөн шимэн озлоо.

Гэнэт гадаахь цэрэг эр ханиан чимээ өгч, эм хүний хувцасны шүржигнээнтэй зэрэгцэн Жангарагийн:

-Хан эзэнтээн! гэх дуунаар эр, эм хоёр сая л янаглалын халуун манан дундаас тоост хорвоод эгэн ирэх шиг болов.

-За! гэх хантны уцаар дуунаар Жангараг орж ирээд алга хавсран мэхийж:

-Нуран хатны бие чилээрхэж Алмагүл шивэгчнээ илгээжээ гэв.

-Юу болоов? Шивэгчнийг оруул!

Үргэсэн гөрөөснийх мэт хоргол хар нүдтэй залуухан шивэгчин сандран орж ирээд хан, хатан хоёуланд бөхөсхийн хүндлэл үзүүлэв.

-Бага хатан яагаав? гэж Доржравдан хатан ийм үед санаачлагыг хэзээд алддаггүй самбаатай зангаар өрсөн асуулаа.

-Мэдэхгүй хатантаан. Цай зоогло гэсэн чинь нэг өндөсхийгээд л муураад уначихлаа. Ойрдоо нойр хоолонд муухан байгаа.

Энэ өргөөнд хамгаас дорд байр суурьтай эзэн хатнаа дагаад энэ шивэгчин ч зарц барлагуудын дунд хүртэл дуу сул, ямагт харц доогуур явах агаад, нэн ялангуяа барлагуудын зүрхийг чичрүүлдэг, хан эзний хамгийн хайртай дунд хатнаас бүүр ч цөсөө хагартал эмээх бөлгөө.

Эр нөхрийн тэвэрт мансууран эрхэлж асан олдосгүй нандин хормыг нь огоот бусниулсан эл цочир явдалд ундууцсан Доржравдан дүрэлзэн ассан уур омгоо өвчүү цээжнийхээ чинадад нуун намжаах зуур “Өлөгчин чинь бие давхар болчихоогүй байгаа! Агаа таван тэнгэр, Арьяавал шүтээн минь болгоогтун!” гэхчлэн хорсон, заных, гуйн залбирах бодлоо эмхлэх зуур догшрон гялалзах нүдээрээ аймхай туулай мэт хяран зүүн хатавчинд зогсоо хөөрхий шивэгчин рүү тас ширвээд хан эзэнтэн өөдөө харц шилжүүлэхдээ хурын усанд угаагдсан цэцгийн дэлбээ мэт зөөлрүүлэн сүүмийлгээд:

-Эзэн минь та оч доо. Барагтайд өвчин хэлдэггүй, залуу бага хүн ямар гай дайрав даа? Би Лу маарамбад элч довтолгоод Жангаагаар сэргээгч тан олуулаад очье гэлээ.

Бага хатны өвч хатгамлаар солонгоруулан чимсэн жижгэвэр цэмцгэрхэн өргөөнд хатныг сандруухан очиход бүсгүйг ирвэсэн хөнжлөөр нь таг хучин хэвтүүлээд урдуур нь эрвээхэй хатгамалдсан ягаан торгон хөшиг татаастай байлаа. Хөшигний наана хөөрхий хатныг төрхөмөөс нь дагалдан ирсэн цагаан алчуурт асрагч эх нь уймран залбирч суулаа.

Хан хамгийн сүүлд чухам хэзээ энэ хөшгийг сөхөн залуу хатнаа таалснаа ч санахгүй байгаадаа гэмшин хөмсгөө зангидаад сиймхий ягаан хөшгийг ярахдаа:

-Хөшиг битүү татдаг нь юу билээ дээ? Агаар салхийг нь хаагаад гэснээ Нурангийн шанхны нь тас хар хэсэг үс сүлжээснээсээ задран ганц үрчлээсгүй гялгар духан дээрээ унасныг нь илбэн засангаа магнайд нь гараа хүргэхэд хүйтэн хөлстэй, бүлээхэн байлаа. Эр нөхрийнх нь алга хүрмэгц бүсгүй урт сормуусаа чичрэгнүүлснээ торомгор хархан нүдээ нээлээ. Энэхэн зуур Алмагүл хан эзэндээ матигар хөлт явган сандайлга дөхүүлээд ухран холдлоо.

Царайн тиг нь их гонзгой, монгол хүүхнүүдийн төрхөөс арай өмнөө, хамар өндөр, гүн ухархайд эргэлдэх тугал алаг нүд нь хоорондоо их ойр, Доржравдан хатныг бодвол царай арай боровтор, тас хар үс, хөмсөгтэй дөнгөж гуч хүрч яваа энэ бүсгүйн гоо үзэсгэлэн хантны сэтгэлийг татах нь нэгэнт багасчээ.

Лхаст мөргөлөөр одоод ирснээс хойш зам зуур нэгэн үдэш зочдоо үдчихээд сэтгэл гэнэт хөдлөн асарт нь орж таалан хоносноос хойш энэ өргөөнд ганц ч удаа шөнийг өнгөрүүлээгүйдээ гэмшиж, хөөрхий бие ядруу буй бага хатнаа өрөвдсөн хан шивэгчний дөхүүлсэн сандалд суугаад:

-Яаж байна чи минь? хэмээн аль болох элгэмсүү энхрийлэнгүй дуугарахыг хичээлээ. Тэгээд гараа магнайд нь дахин хүргэхэд бүсгүй чичирхийлсэн савхан хуруутай, жижигхэн борхон гараараа эр нөхрийн мутрыг давхар атган духан дээрээ тавьснаа:

-Одоо зүгээр ээ хэмээн сулхан өгүүлэн инээмсэглэх аядсанаа:

-Таныхаа мутраар магнайгаа илбүүлэх хэчнээн сайхан юм бэ? гэж тамир муутайхан чичирсэн дуугаар шивнээд хөнжил дотроосоо нөгөө гараа гарган эр нөхрийнхөө зүүн гарыг нь авч хацартаа наалаа. Бүсгүйн гар ширүүвтэр, алга нь хав халуун байлаа. Дух нь бүлээхэн байсан атал хацар нь халуу шатаж байх аж.

Яг энэ торгон мөчид Цэвээн ахайтан Доржравдан хатны хамт өргөөнд орж ирээд орных нь өмнүүр зэрэглэн зогсоход Нуран гэр доторхи хүмүүсийг эргэлдсэн алаг нүдээр тойруулан хараад:

Бурхан надад үр хайрлажээ, хан эзэн минь! хэмээн түрүүчийнхээс арай тодхон дуугаар хэлэхэд хан цочин зүүн хөмсгөө өргөж, хөгшин их хатны нүд баярлан гийж, Доржравдан дотроо палхийснээ чадмаг нуун инээвхийлэхэд өөрийгөө эрийн чалх бууран Ану охиноор үр удмаа отголсонд бат итгэж явсан хантныг энэ мэдээ баярлуулахаас илүү цочирдуулж өөрийн мэдэлгүй санаа алдаад:

Болж дээ. Хүсэл тэнь биелэх нь. Гагцхүү биеэ сайн аригла даа гэлээ.

Тэгтэл их хатны үрчгэр хөх царай улам баясан гийж, хатан болж ирсэн цагаасаа эхлэн энэ өргөө хотлыг гартаа бүрэн атган, өөрийг нь замаасаа зайлуулаад зогсохгүй, үр заяагаагүй хөөрхий бага хатнаас ч эзний сэтгэлийг хөндийрүүлсэн Доржравданд дургүй нь хүрэвч яаж ч чаддаггүй хорслоо ядаж энэ удаа тайлах далим гарсанд түүн рүү илт тавласан харцаар шиврэн инээвхийлээд:

-Хан эзэн таны биеийн чалх өчүүхэн ч дордсонгүйд их хатан, ханийн тань хувьд би нэн таатай байна. Ойр хавьд ийм чихэнд чимэгтэй үг сонссонгүй. Бага ахайтан та биеэ тойгло. Урьдынх шиг осол явдал болох вий! гэлээ.

-Бурханы орны гэгээн шүтээн танд үрийн хутаг хайрлажээ. Шүтээндээ залбирч яв даа хэмээн Доржравдан биеэ хүчлэн, цаагуураа Нурангийн шашин буруутай байсныг егөөдөн хэлэхээ ч мартсангүй.

Энэ тухай эхээсээ сонссон Ану өрлөг эхийндээ гүйн орж:

-Даадаа! Би манцуйтай бяцхан дүүтэй болох гэнэ. Гялай, гялай. Том болохоор нь би дүүгээ шийр цагаандаа дүүрээд давхина хэмээн хөөрцөглөв. Гэвч Нуран хатан үртэй болох нь хэмээн бөөн баяр хөөр болж, Цэвээн ижий гэгддэг их хатан ч бас үе үе бага ханы өргөө рүү бэлэг сэлт барин гүйж байхад өөрийнх нь ижий, хэдэн хоногоор хөмсөг зангидан хилэгнэж, Үзмээ, Жангаа хоёр болон хэдэн аягачаа загнаж зандчин, огт тайвшрахгүй байгаад охин гайхан учрыг нь олох гэж ааваасаа асуух гэснээ гэнэт энэ бол түүнтэй ярих сэдэв биш гэдгийг зөнгөөрөө мэдрээд үеийн юм шиг өөртэй нь хөөрөлдөн, өхөөрдөн эрхлүүлж суудаг өрлөг эхээсээ асуучихлаа.

-Даадаа, манай Нураа ижий хүүхэдгүй гээд дандаа уйлж суудаг байсан даа. Тэгээд Цастын оронд очин баахан бурханд мөргөөд одоо гэдсэндээ хүүхэдтэй болсон гэж бөөн баяр болж байхад миний ижий уурлаад л байх юм. Тэр чинь гарахаараа чиний дүү болно, та хоёр хөтлөлцөөд тоглож гүйнэ гэж Нураа надад хэлсийн. Цэвээн ижий ч бас Нурааг хүүхэдтэй болох нь гээд баярлаад алтан сүйх ээмэг өгөөд л байсан. Яагаад намайг нялх жаахан дүүтэй болно гэж баярлаад байхад ижий уурлаад байгаан бэ? хэмээн асуулаа.

Галынхаа захад суун нөхрийнхөө хуучин оймсны харааг цойлдож суусан Ханджав долоовроосоо хуруувчаа салгаж тавиад охины нарийхан нарийхан салаа хүрэн гэзгийг

өхөөрдөн илж, зөөлхөн, хэрнээ учирласан харцаар нэг харан бодол болсноо санаа алдаад:

-Хатан ахайтан хүний л нэг зовлон юм шүү дээ, охин минь. Манай хан чинь харин ч гуравхан хатантай.Одоо өргөөнд татвар эм ч алга.Чамайг төрөөгүй байхад нэг татвар байсан юм. Хатан хүн гэдэг эхнэр л юм хойно эр нөхрөө бусад эмээс харамлана, хардана.. Ухаандаа чиний шийр цагааныг Мандарваа унавал чи уурлах уу? гэхэд охин бодлогоширсноо:

-Уурлаж ч магад.Үгүй ч магад. Энд чинь тэгээд морь ямар хамаатай юм бэ? Даадаа гээд нүүрээд нь хүүхдийнх гэхэд дэндүү ухаалаг хэрсүү харцаар цоо ширтлээ.

-Даадаа нь мунхаглаж байна. Ихэс дээдэс олон хатан авдаг юм.Гэтэл хатан бүхэн эр нөхрөө харамлана.Намайг л илүү хайрлаасай хэмээн бодно. Ухаандаа өрсөлдөнө өө дөө гэхэд охин нууц давхраатай хөөрхөн сээмгэр нүд эргэлдүүлэн бодолхийлнэ.

-За тэгээд хатан бүр үр хүүхэд гаргана.Миний л хүүхэд бусад хатдынхаас илүү байгаасай гэж бодно. Харин эзэнд бол аль ч хатнаас мэндэлсэн бай, өөрийнх нь үр хүүхдүүд нь л юм чинь адилхан. Ижий чинь бага хатныг давхар биетэй боллоо гэдэг нь хан эзний хайрыг хуваалцахгүй гэж, бас төрөх хүүхэд нь эцгийнхээ хайрыг чамтай хуваачихна гэж ундууцаж байгаа юм.Ойлгов уу?

-Лувсан ахад танаас өөр авгай байхгүй тийм ээ? хэмээн охин адтай гэгч нь асуулаа.

-Байхгүй.Лувсан ах чинь харц хүн.Ноёд ихэс л олон хатан авдаг юм шүү дээ.

-Тэгвэл харц хүний авгай болбол сайхан юм байна. Өөр авгай авна гэхгүй.Их,бага, хатан байхгүй,тийм ээ? хэмээн Ану өрлөг эхийнхээ нүүрээд өлийн ширтэнэ.

-Гэсэн ч харц хүний зовлон бас их шүү дээ,охин минь. Амьдрал гэдэг үйлийн үр гэж бурхан багш сургасан юм гэнэ лээ,базардар гээд өрлөг эх нь зэс домбоныхоо ёроолыг шавхан зэлгээн цай хийж уухад хуруунууд нь хүнд ажилд эвдрэн мойнийсныг Ану сая л анзаарлаа. Уг нь өрлөг эх нь өөрийнх нь ижийгээс ганц насаар дүү гэдэг авч хавьгүй өтөл хөгшин харагддаг билээ.

Гэвч үүнээс хойш таван сар өнгөрч, цагаан сарын хөлтэй өдрүүд өнгөрч, хөх бичин жил гарсны дараахан Нуран хатан зургаан сартайдаа үр зулбан хэвтэрт орсноор Доржравдан хатны магнай тэнийж, Ану охиноор үрсээ отголно хэмээсэн Очирт цэцэн ханы зөн биелсэн ажгу.

Бичин жилийн хавар ногоо эрт соёолон дэлгэр сайхан зун болов. Хаврын дунд сард Очирт цэцэн ханы хүү Галдмаагийн дунд нуган үр заяаж, Гартангомбын хоёр дахь хатан бас хүү төрүүлснээр хантан дөрвөн бэрх буулган аливаад азаа үздэг алталсан дөрвөн шагайнхаа тоогоор дөрвөн ач хүүтэй болжээ. Ийнхүү Гартангомбынх хоёр, Эрдэнэ тайж,Галдамаагийнх тус бүр нэг хөвүүнтэй болсон агал хоёр ч бяцхан охин эндэж, дувт нуган үр мэндэлсээр бүхийд Цэвээн хатнаас өгсүүлээд Ойрад түмэн хөл хөсөр, гар газар байсан энэ хэдэн жилийн энх амгалан амьдралыг эвдэх дайн дажин болох вий хэмээн зовницгооход хүргэж байлаа. Хөвүүн олон төрөх нь удмын хэлхээс үл тасран, овог аймаг улам хүчирхэг, эрмэг оршихуйн

ТЭМДЭГ МЭТ АВЧ НӨГӨӨ ТАЛААС ХОРВООД МЭНДЭЛЖ БУЙ НЯЛХ ҮРСИЙН ДУНД ОХИД ДИЙЛЭНХ БОЛ ДАЙН  
ДАЖИНГҮЙ, ЭНХ АМГАЛАН БАЙХУЙН БИЛЭГДЭЛ, НУГАН ҮРС ЗОНХИЛОХ НЬ ДАЙН САМУУН ҮҮДЭХИЙН ЁР Ч  
ГЭЖ ӨТГӨС ХЭЛЦДЭГ НЬ БУЙ БИЛЭЭ.

## Зургадугаар бүлэг

Аргын тооллын 1660 он, хулгана жил гарлаа. Дөрвөн Ойрадын шашны тэргүүн Зая бандид гэгээний гэрээсэлсэн ёсоор Ойрадын чуулганыг хуралдуулах ёстой байлаа. Халхын ноёд ганц нэгээр Манжид даган орж эхлээд буй эгзэгтэй нөхцөлд Зүүнгарын ихэс дээдэс туурга тусгаар байдлынхаа төлөө, өстэй нь урьдын гомдол хорслоо хүлцэн тэвчиж, цөстэй нь уур омгоо барин эв мод мэт байх цаг иржээ.

Илийн зусланд зуны тэргүүн сарын арван тавны билэгт сайн өдөр хийхээр тогтсон Дөрвөн Ойрадын чуулганы зарыг тараах, бүгдээр хэлэлцэн тохиролцох алба татвар, Манжийн хаан Эээр засагчид илгээх захидлын агуулга зэргийг бичгээр тоймлон буулгах, чуулганаар батлах шинэ цааз бичгийн эх зохиох хүчир ажилд нухлагдсан Очирт цэцэн ирж яваа цагийн урин тансагийг бахдах завдалгүй өнгөрөөв.

Өвөл нь Алшаа нутгаар цас барагтайд унаагүй тул харын зуд нүүрлэснээс олон айлын мал усгүйдэн өөдөж, хаврын энх улиралтай золгохдоо хотоо харлуулан модоо барьсан айл олон байсан нь ч хошуудын Очирт цэцэн ханы бас нэгэн толгойн “өвчин” болов. Энэ бүхнээс гадна, дайны хажуугаар дажин гэгчээр бага хатан нь зургаан сартай нуган үрээ зулбаж, бурханы оронд очин Галдан, Сэра, Бэрэвэн хийдүүдийн нандин шүтээнүүдэд биечлэн мөргөж залбирсны буянд үнэрлэх үрийн хутаг заяав хэмээн магнай хагартал баярлаж асан сул дорой бүсгүйн эмзэг сэтгэл хувь тавилангийн энэхүү хүчир цохилтыг гэтэлгэж хүчрэлгүй хэвтэрт орж, хоол унднаас гарсан тул өргөө гэр доторхи энэ золгүй явдал мөн л төрийн ажлын бэрхтэй нэгдэн өр өмлөх ажээ.

“Өчүүхэн миний бие талийгч анд Баатар хунтайжийн адил арваар тоологдох хатан, татвар эм авч, хараа булаасан бүхнээ өөрийн болгож явсангүй. Өөрийнхөө авааль гурван хатны дотроос дунд хатандаа л голт зүрхний угаас сэтгэлтэй. Их хатан Цэвээнийг хар багад эцэг эхийн тавьсан өндгөн сүй задалж буулган авчирсан ч сэтгэл зүрхээ түүнд өгч явсангүй ээ. Арван зургаан насандаа эхийнхээ шадар хамгаалагч Гөлгөө баатрын ганц охин, харзны ус шиг мэлтэгнэсэн нойтон хар нүдтэй Сэржмядаг бүсгүйд тэсгэлгүй сэтгэл алдран охин насыг нь үргээж явсан ч жилийн дараа түүнийг нь Тэнгэр уулын цаадтай Хойдын Сайн хиагийнхны зүгт бэрлэн мордуулсан билээ. Түүнээс хойш хоёр жил өнгөрч удам угсаа сайтай, эртнээс худ ургийн холбоотой явсан Цэвээн бүсгүй тэр хоёрын өндгөн сүйг задлан Алшааг доргиосон хурим найр хийж буулган авсан билээ. Жийхайсан нүдтэй, хөнхөр бор духтай, эв хавгүй өндөр бие, урт чацтай, шингэхэн үстэй Цэвээн охин түүний сэтгэлийг огтоос татаагүй. Хатан нь болж ирээд эрхгүй эр эм бололцсоных гурван хүү, хоёр охин төрүүлж, заримыг нь алдан хамтдаа уйлж, инээж, хань нь болон, удмын хэлхээг нь үргэлжлүүлэн арваад жил амьдарсан ч зүрх сэтгэл нь тэр хүүхэнд татагдсангүй хөндий хэвээр үлдэж билээ. Цэвээнийг буулган авчирснаас хойш хэд хэдэн царайлаг татвар эм өргөөндөө авчран нүд сэтгэлээ баясгаж байгаад шадрууддаа өгчихсөн. Харин анхны хуримаас хойш арван зургаан жилийн дараа Ижил рүү дайжин одсон торгууд аймгийн тэргүүн, Шүхэр Дайчины авга Наянтай зайсангийн отгон охин арван долоон настай Доржравданг хатан болгон авахаар очоод нүүр тулмагц зүрх сэтгэл нь зүйргүй гүн догдлон дур сэтгэл алдарч билээ.

Тэгэхэд тэр сэвгэрийн шахсан бяслаг мэт булцгар цагаахан царайны нь сүүн өнгийг алтлаг туяатай өтгөн хүрэн гэзэг нь улам ч сэтгэл татам болгож, том ч бус, жижиг ч гэмээргүй, нууц

давхраатай, цоргисон харцтай нүд нь оч хаялах мэт тормолзож асан.

Харин энэ бага хатанг авья ч гэж хүсэн тачааж авсангүй. Турфаны наагуур нутагладаг хотон аймгийн ноён Кукушийн найр тавьсаны хариуд, цаашид мөн найрамдалтай байж, үе үе дайсагнадаг хасагийн султаны эсрэг хүчин хавсрахад хэрэгтэйг ч бодолцон охиныг нь бага хатнаа болгон авахдаа сэтгэл нэг л дундуур байсны учир энэ байж. Дөчин зургаан насанд нь арван тавтай нялхаараа шахуу ирсэн энэ бүсгүй өнөө жил дөнгөж л гучтай. Эм хүн эх болж, нойтон сормуустай амьтан төрүүлэн, үрээ үнэрлэн, хөхөө амлуулан жаргах гэж л энэ ертөнцөд ирдэг атал хөөрхий Нуранд үр заяавч хүн болсон золтой нь ганц ч үгүй. Дөнгөж арван тавтай охин хонгорхон насандаа дөч хэвийсэн хижээл эрд богтлогдон, бага хатан нь болоод насан турхруу өвөр хоосон, үнэрлэх үр ч үгүй, ёсолж авсан хатан нэртэй хаягдмал бага эхнэр явсаар төгсөх хэчнээн бачуу тавилан заяа гэгч вэ гэхээс хөөрхий бүсгүйг өрөвдөн элэг эмтрэх нь олонтаа.

-Энэ Нуран хатан нутаг усандаа сэтгэлт хүнтэй байсан юм гэнэ. Өргөөнийхөө гадаа баруун урд зүг рүү ширтээд л мэлэрч суух юм хэмээн бага хатанг бэр буулган авчирсны хойтон жил нь Доржравдан шилбэлзэн байж хэлсэн нь яавч ортой байж таараа. Болдог сон бол бага хатнаа нутаг хошуунд нь буцааж, төрхөмд нь хүргээд өгөх сөн. Гэвч хадмын босгыг давсан л бол эгүүрд хүний хүнд тооцогдон, төрхөмдөө буцаад ирвэл шороо цацан хөөдөг хотон ёсыг яалтай хэмээн бичгийн гэртээ цай оочлон суусан Очирт цэцэн бодож байлуга.

Энэ үеэр бичгийн өргөөний хаалга онголзон нөгөө л бяцхан гуулин дуулга, элгэндээ тольт илгэн цээживчээ өмсөн, хавчаахай нум, жижиг махир сэлэм агссан дэггүй жаахан Ану шагайснаа:

-Аав аа! Би морин дээрээс алаг даахай оночихлоо. Бундир, Балсан хоёр оноогүй, муу нусгайнууд гэсээр орж ирлээ.

-Юутай лут мэргэн харваач охин бэ? гээд эцэг нь Ойрадын цааз бичгийн шарласан хуудсуудыг эргүүлэнгээ охины хөлстэй духыг үнэрлэснээ зогтусав.

Охины дух ердийнхөөс арай л илүү халуун байх шиг санагджээ.

-Аав аа, та өнөө үдэш надад “Шидэт хүүрийн үлгэр” хүүрнэж өгнө тийм ээ? гэх охин эцгийн ширээн дээрх хаш чулуун тавагнаас хасарвааны самар атган авлаа.

-Алив хөө, над руу үлээгээч үр минь гэж эцэг нь хөмсөг зангидан охин руу анхааралтай хараад хонхдон шадар хиагаа дуудах зуур “Амьсгал нь бас халуун ч байх шиг. Дотор халуун байна аа даа” хэмээн бувгнахад өтгөн сахал нь амьтай мэт хөдөлж, охин “таны сахалд будаа наалдсан байна” хэмээн зүггүйтэн хэлээд эрхлэн чангаар ход ход хөхрөв.

-Тэгвэл сахал дээрх будааг унагахын тулд жаахан хүүхдийг үнэрлэдэг юм даа хэмээгээд эцэг нь охины нарийхан хүзүүг үнэрлэн сахлаараа гижигдэв.

-Жа эзэнтээн! гэсээр хиа орж ирэн бөхөсхийв.

-Доржравдан ахайтнаа дууд.Охинтой цугтаа тоглодог хүүхдүүдийг гэр гэрт нь оруулан халуурч бүлээрсэн эсэхийг сураг тавь хэмээн хан хөмсөг зангидан зарлигдав.

Тоглоомондоо улайраад өвдсөнөө мэдээгүй охин оройдоо дух нь халуу шатан дэмийрч, өргөөнийхнийг тужид нь хөл дээр нь босгон сандаргав.Ану охин улаан эсэргэнэ туссан байв.

Энэ хавартаа Хойдын Дүүрэн цэцэн бичээчид элч илгээн охиндоо тод, монгол бичиг, түүх заалгахаар залан авчрах эцгийн санаа ч хойшлогдов.Улаан эсэргэнэтээд илааршсан хойноо ч охины бие сул, ханиад томууны сургаар л халуурч, бүлээрсээр зуны эхэн сартай золгож билээ. Зая бандид гэгээн багшийнх нь гэрээсэлснээр Ойрадын ихэс дээдсийн чуулган хуралдуудалах цаг ойртон төрсөн дүү Аблай тайж,Хөндлөн увш, Далай тайш нарын зэрэг ноёд сэтгэл буруулсан нь илт, элчийн хүргэсэн чуулган зард хариу өгүүлээгүй буйд хан сэтгэл чилүүр байлаа.Харин Цэцэн тайж, Зодов баатар,Цөхүр увш, Хойдын Сүлдэн тайж нар дөрвөн Ойрадын чуулганд оролцох нааштай хариу илгээжээ.

Ану охин хаврын турш өвчтэй хэвтэхдээ урьдын адил морь унан хээр талаар салхи тагуулан хөндлөн гулд давхих, эцгээ даган хол ойрын аянд мордох, солгой Лувсанхайдав, Хөлчүг баатар нарын зэрэг эцгийнхээ мянгатын дарга нартай хамт цэргийн сургуулилтанд очин нум сум харвах, сэлмээр цавчих эрдэмд шамдах, хааяа бас Булган, Мандарваа, Балжид гэсэн өргөөний шадар хиа барлагуудын охидтой бөгцөг няслах, алаг мэлхий өрөх, хорол наадах сан хэмээн тэсгэлгүй хүсэвч эх нь энэ бүгдийг тас хорьж байлаа.

Тиймээс “Аав аа,надад тод үсэг зааж өгөөч.Таны бичгийн өргөөнд байдаг ном судраас уншиж хэвтмээр байна.Би уйдаад байх юм” хэмээн өрөвдөлт нүдээр царайчлан гуйсны хүчинд өргөөнд эцгийнх нь бичиг хэргийн албанд зүтгэдэг Улаанхүү бичээчээр тод үсгийн цагаан толгой заалгаж эхлэв.

Бяцхан гартаа өдөн бийр барин багшийнх шигээ жирийтэл цэвэр, гаргацтай бичихийг хичээхдээ хэлээ булталзуулан, жижигхэн цээжээ түхэлзүүлэн суух охин үрээ хараад Очирт цэцэн хан өөрийн эрхгүй уярч, төрийн хэрэг, халх, Ойрадын язгууртан ноёдын хагарал, дов дош бүхэн дээр тодрон, задарч бутрах санаа агуулж яваа төрсөн дүү Аблай тайж тэргүүтнийг бодон ямагт сэтгэл зовинон буйгаа түр ч гэсэн мартагнаж, Байбагас хааны удам, Очирт цэцэн ханы үр үндэс аргагүй мөн өө дөө.Охин хүйс заяагаад мэндэлчихсэнээс бус харвахдаа мэргэн, бичиг эрдэмд нэвтэрхий хүн болох нь “ хэмээн бахдах сэтгэл төрнө.

Харин эр нөхөртөө тохойд нь ивэх жинтүүний уут зэхэн солонгын өнгөт эр тогосын сүүлийг өнгө ялган зүү ороон хатгаж суух Доржравдан “Бүсгүй хүн бичиг эрдэмт хэтийдтэл шамдлаа гээд хар толгойдоо лай хураах нь илүү.Түүний оронд уур омгоо дарж, эр нөхрийнхөө тааллыг даган, аашийг нь олж, сул дорой, гэнэн хонгор зангаараа бамбай хийж сурах нь дээр сэн. Насны бөгсөнд заяасан энэ өөдсөн чинээ охин бүсгүй заяатан гэхэд даанч дэндүү эрэмгий зан төрхтэй юм даа.Арьяавал шүтээн минь өршөө” хэмээн дотроо дургүйхэн байлаа.

Тэр зун Алшаад өдөр нь халуун салхи үлээн элсээр шуурч, шөнөдөө хүйтрэн, хавраас хойш тэнгэрээс дусал ч хур унасангүй гантай жил боллоо. Гэвч Очирт цэцэн ханы хүү Галдмаад Хойдын Сүлдэн тайжийн дүү Жамьянмядагийг буулган хөлтэй хурим дэглэв.Хавар нь эсэргэнэтэн сульдаад, хуримын үеэр гэдэс дотор нь эвгүйрхэн гүйлгэж байсан Ануг хуримд



аваачсангүйд их л гонсгор, бичиг номоо нухсаар хоцорчээ.

Алшаад өвөл ч мөн цас унаагүй шахуу, харын зуд нүүрлэж, цагаан сараас хойш ч хүйтний эрч суларсангүй, хавар оройтсоноос чүү ай өвлийг давсан туранхай мал тэвээрэхгүй хэцүүхэн байлаа. Иймд Очирт цэцэн хан өөрийнх нь мал хөрөнгийг адуулдаг албатуудаа аваад Хөх нуурын тийших нутагтаа зусахаар хаврын сүүл сард их нүүдэл хийв.

Хантны ойр шадар албат таван зуугаад айлд өөрийнх нь өмчний хоёр түм, тэдгээр айлуудын малтай нийлээд хэдэн түмэн малын хөлгүй их нүүдэл тоос манарган Хөх нуурыг зүглэлээ.

Олон хоногийн хөлтэй нүүдлийн эцэст Хөх нуурын Сэрүүн дэнжид хүрч Очирт цэцэн ханы өргөө зусав. Энэ нутгаар өвөлдөө цас багатай, хавар мөн л оройтсон ч газар нь Алшаагаас илүү шимтэй, анхны бороо хаврын эхээр орсон тул Хөх нуурт дэлгэр сайхан зун болж, хатуу өвөлд туйлдсан хүн малын зоо тэнийн, идээ цагаа дэлгэрлээ.

Ану охиныг тод үсгийн цагаан толгой нүдэлж шувтрах үеэр эцэг нь Илийн зуслан тийш дөрвөн Ойрадын чуулганд мордон оджухуй.

Очирт цэцэн ханы хувьд Далай ламтнаас дөрвөн Ойрадын чуулганы ёслолын иж бүрэн хувцас, очир эрдэнийн жинст малгай тэргүүтнээ соёрхон хүлээж аваад удирдаж буй анхны чуулган нь энэ байв. Дөрвөн Ойрадын чуулганы түүхээс нэхэн өгүүлбэл: түүхэнд Явган мэргэн хэмээн алдаршсан нөлөө бүхий этгээд арван дөрөвдүгээр зууны эхээр дөрвөн Ойрадын холбооны чуулганыг үндэслэж, анхны ханаар өргөмжлөгдсөн гэдэг.

Аргын тооллын 1582 онд хошууд аймгийн ахлагч Хан ноён Хонгорын Аха хатнаас төрсөн, эзэн Чингис хааны дүү Хавт Хасарын арван ес дэх үеийн хөвүүнийг Төрбайх хэмээн нэрийдсэнийг хожим Гүүш хан хэмээн түүхэнд үлджээ. Гүүш ханы эцэг хошуудын Хан ноён Хонгор, Халхын Авгай сайн хантай хийсэн тулаанд үрэгдсэн гэдэг. Түүхнээ “Хөвгөрийн тулалдаан” хэмээн нэрийдсэн энэ явдал аргын 1585 онд болж, Аха хатан эрээ алдаад хөвүүдээ өсгөж, дөрвөн Ойрадын чуулганы эрхийг хэсэг хугацаанд өөрөө барьж байсан ажгу. Удалгүй Хан Хонгор ноёны ууган хүү Байбагас эрийн цээнд хүрч, эл чуулганыг тэргүүлэн, Ойрадын хүчийг нэгтгэх, харийн дайсны халдлагаас хамгаалж эхэлсэн аж. Харин түүний дүү, Хан Хонгор ноёны гутгаар хөвүүн Төрбайх багаасаа ер бусын сэцэн сэргэлэн, бичиг ном, цэргийн эрдэмд тэгш гарамгай эр болон өссөн гэдэг. Байбагас ханы ууган хүү нь Очирт цэцэн хан бөлгөө.

Ойрадын чуулган арван долдугаар зууны дунд үе буюу Очирт цэцэн хан тэргүүлж асан тэр цаг дор туйлын эмх цэгцтэй, хуралдааны тусгай дэг жаягтай болсон байлаа.

Ойрадын чуулган нь эзэн Чингисийн Их хуралдайн чанд хатуу дэг жаягийг уламжлан авчээ. Нэн ялангуяа дөрвөн Ойрадын чуулганыг хошуудын Байбагас хаан тэргүүлж байх үеэс Хавт Хасарын удам гэдгээрээ ихэд омогшин бахархаж, эзэн Чингис богдын тогтоосон эрхэм дэг жаягийг билгэшээн дэлгэрүүлсэн гэдэг.

Чуулган хуралдах өдөр цагийг эрдэмт багш ламаас асуун тогтоож, Ойрадын зонхилох ноёд зөвшилцөж байж, эцсийн шийд гаргана. Чуулганы ханыг тохоон сонгоогүй үед хамгаас илүү

нэр хүндтэй ахмад насны ихэс ноён тэргүүлнэ.

Чуулганы хан болох хүнийг дөрвөн Ойрадын холбооны нэгдлийг бодож гаргасан журмаар цорос, өөлд, торгууд, хошууд аймгийн дотроос дараалан сонгох учиртай.

“Дөрвөн Ойрадын ураа” нэртэй сүлд дууллыг икэл буюу морин хуурын хөгөөр аялан хэлдэг байсан гэдэг. Хан сонгох, дайн зарлах мэтийн чухал зүйл хэлэлцэх чуулганы товыг Далай лам, Банчин богд нарт мэдэгдэн, хуралдах үеэр лам хуврагууд ном хурж, овоо тахин газар лусаа баясгадаг байж.

Гүүш хан Хөх нуурыг захирсны дараа нийт Ойрадын хэргийг хамаарч, чуулганы хан болж чадахгүй болсон тул дөрвөн Ойрадын чуулган хуралдан, шинэ хан сонгох хэрэг тулгарчээ. Тэр цагт дөрвөн Ойрадын дунд нэр нөлөөтэй ахмад ихэс гэвээс Хойдын Сайн хиа, Дөрвөдийн Далай тайш, хошуудын Хөндлөн увш нар байсан ажгу. Эдний дундаас Сайн хиа нь нэг бус удаа Ойрадуудын хагарал дайн болон өдөөгдөхөөс ухаан сийлэн сэргийлж байсан, зориг баатарлаг хүн байж. Чуулган хуралдаж Хойдын сайн хиаг ханаар сонгосон ч Далай лам дэмжсэнгүй.

Гэвч Сайн хиа чуулганы “хан” болоод зангаа хувирган сагсуурч, чуулганаар хэлэлцээгүй бичиг дур мэдэн үйлдэх, бор дарсанд шунан хөлчүүрэх болж, удалгүй Хоо өрлөгийн үр ач нарт хорлогдон жанч халсан гэдэг. Тэргүүнгүй болсон чуулган аргын 1640 оны орчим хуралдан Хоо өрлөгийн хөвүүн Шүхэр дайчинг “хан”-аар сонгосныг Далай ламтан дэмжиж чуулган ханы тамга, айлтгал бичгийн хамт ирүүлсэн аж. Гэвч нэгэнт уугуул нутгаа орхин Ижил мөрний тэртээ нүүн одож суурьшсан Шүхэр дайчин “Алс хол харь газраас Ойрадын холбоог тэргүүлэх хэцүү, эцгийн хамт хошууд, дөрвөдийн ноёдтой эв эвдрэлцэн Ойрадын нэгдэлд сэв суулгасан, эх нутаг, элгэн саднаа огоорон алсад нүүн одсон” зэрэг буруугаа тоочоод “мөхөс би чуулганы хан болохоос татгалзаж байна” хэмээсэн захиаг чуулганд болон Далай ламд илгээсэн тул цоросын Баатар хунтайжийг чуулганы ханд өргөмжилжээ.

Гэтэл Гүүш хан, Баатар хунтайж нарын Хөх нуурын эл шийдвэрт сэтгэл дундуур хоцорсон нэгэн ноён болбоос хошуудын Байбагас ханы хүү Очирт цэцэн хан байсан бөлгөө. Дөрвөн Ойрадад нэр нөлөө их, сүр хүчин төгөлдөр Очирт цэцэн чуулганы хан сууринаас болж Баатар хунтайжтай харилцах урьдын найрсаг харилцаанд далдуур ан цав суухад бэлэн болсон байлаа. Чухам эл эгзэгтэй үед Ойрад даяар нөлөөгөө тогтоосон Зангиа хутагт, Очирт цэцэн хантай Тарвагатайд хамт өвөлжсөн Зая бандид Намхайжамц нарын мэргэд тэднийг эвлэрүүлж, дөрвөн Ойрадын чуулганыг цугтаа тэргүүлэх гарцыг олсон билээ.

Үүнийг үл өгүүлэн цааш өгүүлэхэд, эцгээ Илийн зуслан тийш шадар зуутаа дагуулан чуулганд мордсон хойно Ану охин зуны нэгэн өглөө эрт сэмхэн босоод шүүдэр туучин гүйсээр бичгийн өргөөнд орж ногоон хашаар сийлсэн нагван, бийр янтай зэргийг нь үзэн зугаацаж суутал гэнэт ширээн дээрх нэгэн судрын нүүрнээ” Эрдэнэ үн тоб-чи “\Эрдэнийн товч\ гэсэн үгс амилах шиг болж өөрөө ч мэдэлгүй тэрхүү үгсийг холбон уншандаа итгэж үл чадан балмагдан зогтусав.

Тэгснээ “СА-ГАН СЭ-ЦЭН” хэмээн дахин нэгэн үг уншчихаад тэр нь эцгийн хүүрнэлд хааяа нэр дурдагдаж асан эрдэмт мэргэн хүмүүний нэр алдар болохыг ухан ойлгоод зүйрлэшгүй их баясч, өргөөнөөс ухасхийн гарч өрлөг эх өөдөө гүйв.

-Даадаа!Би үсэг холбон уншиж сурлаа хэмээн дуу хадаасаар жижиг дөрвөн ханат руу нь эрчээрээ гүйн ороход шүүрмэг хийж суусан Ханджав үрчлээт магнайгаа тэнийлгэн мишээж:

-Юутай их баяр вэ? Эрдэм ном дээд баян, үр хүүхэд дунд баян, эд хөрөнгө адгийн баян гэдэг юм.Эрдэмд оройгүй хүн болоорой гээд духан дээр нь үнэрлээд босч, гараа даалимбан тэрлэгийнхээ дотоод хормойд арчин ийш тийш сандчин, охинд өгөх байх юмаа олж ядан дэмий л хоймрын халцархай авдраа ухааж сууснаа буланд нь цэцэг хатгасан цагаан дурдан алчуур гарган өглөө.

Тэр бэлгийг хоёр гардан авч тахимаа нугалан талархаад Ану:

-Би таны ярьж өгсөн Мандухай сэцэн хатан шиг эрдэм номтой, баатарлаг хатан болж чадах болов уу, Даадаа? гээд тэр алгын чинээ цагаан алчуурыг хүүхдийн томоогүй зангаар шохоорхон үзэх зуур ер бусын анхилуун тансаг үнэртэйг нь санамсаргүй мэдээд дахин дахин үнэрлэж үзэн, хэзээний зангаараа зүүн хөмсгөө эгдүүтэй эрхэмсгээр өргөнө.

-Хүдрийн заар шингээсэн алчуур байгаа юм. лувсан ах нь авчирч өгсөн юм.Их сайхан үнэртэй байгаа биз?Би энэ чамин эдээр яахав дээ.Миний хүүхэн энийг хадгалж, Даадаагаа санаж яваарай гэснээ толгойг нь илж:

-Миний хүүхэн Мандухай сэцэн шиг хатан болноо.Даадаа нь мэдэж байна. Харин миний нас гүйцэж харж чадахгүй байх даа гэлээ.

-Мандухай сэцэн чинь халх хүн ийм ээ?Манай Ойрадаас тийм ухаант хатан байдаг болов уу? гэж хөөрхөн жижигхэн нүдээ дүрлийлгэн асуулаа.

-Мэдэхгүй юм даа.Даадаа нь эрдэм номгүй харанхуй цээжтэй мөхөс хүн юу мэдэхэв.Улаанхүү багшаасаа асуу л даа гэлээ.

Охин өргөөндөө элдэв амтганд умбаж байдаг ч Даадаагийнхаа гарын идээнд дуртай тул шүүрмэгээс нь атгаж аваад гүйн одлоо.

Гэвч номын багш Улаанхүү бичээч нь эцгийг нь дагаад дөрвөн Ойрадын чуулганд мордсон тул ямагт элдвийг сониучирхан бяцхан оюунаа тэлэх хэмээн тэмүүлж явдаг охин долоон янзын асуултад нь хариулах хүнгүй, үсэг холбож сурсан баяраа хуваалцах ухаант аав, номын багшаа үгүйлэн өргөө рүүгээ урамгүйхэн гэлдэрлээ.

Уг нь Мандарваа,Булган, Балжид,Дарьжав гэсэн хэдэн охинтой айл гэр болж тоглоно хэмээн амласан ч тэртээ борчуудын гэрүүдийн тэнд өөрийг нь хүлээн зогсох охид руу очих хүсэлгүй болжээ.

Түүнийг өргөөндөө ороход эх нь нимбэгийн шүүсээр нүүр, хүзүүндээ бигнүүр талбин, Жангараг шивэгчин нь дал мөрийг нь базалж байлаа.Амтлангуут арааны шүлс асгаруулан, нулимс гоожуулдаг айхтар гашуун, исгэлэн гэж жигтэй, шав шар өнгөтэй тэр жимсгэнийг эх нь холын дулаан орноос эсгийд хучуулан авчруулж, шүүсээр нь нүүр, биеийн арьсаа цагааруулж, зөөлрүүлж байна хэмээн ийнхүү бигнүүр тавьдаг нь охины хувьд эл дол болсон

зүйл бөлгөө.

Нүүрэндээ цагаан самбай даавуунд нимбэгийн шүүс шингээн битүү бигнүүр тавьсан эх нь хаалга онголзох чимээнээр:

-Миний үр үү?Хаагуур сэлбэгнээд явна чи?Одоо зам ирж өдрийн зоог авчирна.Үзмээ энэ хүүхдийн гарыг угаалга гэлээ.

-Гар яах вэ?Ижий, би уншиж сурсан! хэмээн охин цангинуулан хэллээ.

-Арьяавал гэж !Үсэг холбоод үг гарган уншиж чадлаа гэнэ үү? гээд хатан нүүрнийхээ бигнүүрийг хуу татаад өндийлөө.

-Тийм гээд байхад.Би эхлээд өөрөө ч итгээгүй.Аавын бичгийн гэрт ороод мэлхий ширээн дээрх нагван, бийр янтайг нь үзэж байтал нэг судрын нүүрэн дээр Саган сэцэн “Эрдэнийн тобчи” гэж бичсэн байсан хэмээн хөөрөөд эхийнхээ дэргэд гүйн хүрч, барьж байсан цагаан самбайг нь авч хивсэн дээр хаяад түрэмгий гэгч нь дэвслэн хилэгнэж:

-Яагаад та намайг магтаж үнсэхгүй байгаан бэ?Тэгээд бас юунд Даадаа шиг намайг үсэг холбож сурсныг ч мялаахгүй байгаам бэ,ижий? гээд хошуугаа унжуулан зогслоо.

-Ану гүнж наймхан насандаа тод үсэгт тайлагдаад дөч талийсан манийхаа дэргэд эрдэмтэй хүн болчих гэж. ижий нь мялаалгүй яахав гэж Жангараг хэлээд хатныг орон дээрээс нь түшин босгов.

-Алив ижий нь үнсэлгүй яахав дээ.Харин юугаар мялаадаг юм билээ? гэж нүүр нь ер бусын толийж улам ч залуу харагдах Доржравдан хатан хэлээд охиноо тэврэн хоёр бумбагар хацар дээр нь ээлжлэн шунагаар үнссэнээ савхан хуруугаараа бундгар ягаан хацрыг нь чимхэн духыг нь духандаа наагаад:

-Чи өвдсөнөөсөө хойш хацрын унаган мяраагаа гэж, том сэвгэр шиг болох нээ гэснээ гүнзгий санаа алдав.

-Алив Ану гүнж үүнийг унш даа гэж овжин зант Үзмээ хатны орны толгойн авдар дээр тавиастай тод үсгийн судраас нэгийг авчрах нь үнэхээр үсэг холбож чадаж буй эсэхийг сорих гэсэн бололтой.

-Аа, энэ үү?”Мон-ггол –ун нигуца тоб-чиан” гэнээ.Би уншиж чадаж л байгаа биз дээ? гээд ээж рүүгээ болон хөгшин, залуу хоёр шивэгчний зүг ээлжлэн харж ташаа тулан зогсов.

-Бүсгүй хүн ташаа тулдаггүйм гэж Жангараг сургахад охин дургүйцэн хамраа үрчийлгээд цацагт хивстэй өөрийнхөө ороод очин лагхийтэл суулаа.

Аливаад туйлын ёсорхуу, намбалаг Жангараг, охин руу өхөөрдөн харснаа ёроолыг нь мөнгөлж, хатны дурладаг доржпалам эрдэнэ суулган урласан үндсэн тагшинд сүү дүүргээд, урт цэнхэр соном хадаг дээр тавьж эхэд нь өглөө.

Охины ийнхүү унтууцангуй байгааг өхөөрдөнгүй бас доогтой харж суусан хатан жуумалзан инээмсэглээд:

-Ижий нь охиноо уншиж сурсныг мялаая.Нааш ир. Эрдэмд оройгүй гэдэг.Энэ нь хүн энэ яваа насандаа сураад сураад эрдмийн оройд гарч үл чадна гэсэн үг.Багшийгаа залагдан ирэхээр бүр ч ихийг шамдан сураарай.Гэхдээ бүсгүй хүн ном хэчнээн ихийг сурсан ч номхон зангаа гээж болдоггүй юм шүү дээ гээд түнжгэр духыг нь яг аав шиг нь үнэрлээд газар шүргэсэн урт соном хадаг, мөнгөн аягатай сүүгээ өглөө.

Ану их л додигор ёсорхуугаар хадаг сүүг хоёр гардан авахдаа аавынхаа хөдөлгөөнийг яг дууриахыг их л хичээж байв.Гэсэн ч гадуур гүйсээр ангаж гүйцсэнээ сая л анзаарч өнөөх сүрхий ёсорхуу зангаа мартаж, жижиг мөнгөн аягатай сүүг ааг амьсгаагүй цээжээ түхэлзүүлэн байж залгилж орхиод дээд уруул дээрх цагаан “сахлаа” эхийнхээ орны дэргэдэх зуван босоо толинд харчихаад” Хараач, би аав шиг сахалтай болчихож” гээд нударгаараа арчих гэснээ өрлөг эхийнхээ өгсөн алчуурыг санаж, өврөөсөө түүнээ гарган уруулаа арчаад эргүүлэн өвөртөлснөө мөнгөн аяганы ёроолын эрдэнийн чулуун чимгийг шохоорхон үзэж эхлэв.

-Хэн танд ийм гоё алчуур өгөөв? хэмээн ширээ зүлгэж суусан Үзмээ адтайгаараа анзааран харчихаад асуув.

-Даадаа намайг тод бичигт тайлагдлаа гэхээр мялаасан юм.

-Аан.Тийм үү? гээд Үзмээ хатантан өөд болгоомжлон хяламхийгээд ширээгээ зүлгэж гарав.Доржравдангийн царай хоромхоноо хувьсхийгээд дорхиноо биеэ барьж чадав.

Охин ийнхүү баяр, гунигаа ямагт төрүүлсэн эхээсээ түрүүнд өрлөг эхтэйгээ хуваалцах бүрийд хатан эр нөхрөө бага хатантай нь харддагтайгаа төстэй дотор харлуулсан атаа, жөтөөнд автан сэтгэл үймрээд авах тул сурсан зангаараа хөмхий зууснаа зөөлнөөр хоолойгоо засаад:

-Энэ аягыг миний охин ав.Ёроолд нь ижийнх нь дуртай доржпалам чулуу шигтгэсэн эд. Аягаа хүнд өгч үл болно.Аа бас, хүний аяганд үүнээс хойш ууж үл болно.Монгол хүн аягатайгаа явдаг юм.Энэ чулуу эзнийхээ сүр сүлдийг шингээж аваад доройтон буурч явах үед нь хүч чадал эгүүлэн хайрладаг шидтэй эрдэнэ юм гэнэ лээ гэлээ.

-За мэдлээ, ижий.Би энэ чулуунд бас дуртай.Таны бэлзэгнийхтэй адил юм гэж охин хэлээд хөөрхөн инээмсэглэв.

-Юу ч боллоо гэсэн хамгаас түрүүнд ижийдээ хэлж бай охин минь гэж хатны дал мөрийг базалсаар буй Жангараг сургамжлангуй хэлэв.Энэ нь одоо чи том болсон. Өрлөг эх өөдөө юмны түрүүнд гүйхээ боль гэсэн битүү сануулга гэдгийг хэрсүү охин ойлгоод хөмсгөө зангидсанаа:

-За, мэдлээ гэхихээд хивсээр бүтээсэн, алтан зүмбэрт модон орныхоо толгойн шургуулганд аягаа хийгээд гүйн одов оо.

Мандарваа, Булган, Балжид гуравтай чулуун гэр барьж тогломоор санагджээ.

Очирт цэцэн хан Илийн зусланд болсон чуулганы дараа Сэнгэ хан, Цөхүр увш, түүний хүү Багабанди, Хойдын Сүлдэн тайж худ, Шүхэр Дайчины хүү Пунцаг тайж нарын зэрэг Ойрадын эрх нөлөөт ноёдын хамт Арашлхүмбэ хийдэд морилон очиж, Зая гэгээн Намхайжамц багштаныхаа ариун шарилд мөргөн, мандал өргөж, молон хуруулаад сарын дараа эргэн ирлээ.

Ойрад түмний номын их багш Зая бандид Намхайжамц агсны гэрээслэлийг аймшиггүй зөрчин дөрвөн Ойрадын чуулганд санаатайгаар ирэлгүй чуулганы хан төрсөн ахтайгаа илт тэрслээд зогсохгүй, эмзэг хэврэг буй Ойрадын эв нэгдэлд сэв суулгаж буй дүү Аблай тайш нь түүний хувьд сэтгэлийн их чилүүр болоод байлаа. Эцгийн үлдээсэн өв хөрөнгөнөө ахтайгаа булаалдан тэрсэлдсээр дөрвөн Ойрадын холбоонд багталцахаа больтлоо эвэр, туур нь томорч, их санаагаа өчүүхэн бие нь гүйцэхээ больсон Аблайн талд Хөндлөн увш, Далай тайш, Цагаач зайсан нар эвсдэг нь ч юу билээ. Үр дүнд нь юу болов? Чуулганаас дөрвөн Ойрадын холбоонд тэрслэгч нэр зүүсэн Аблай тайш тэргүүтнийг зэвсгийн хүчээр номхотгон дарах шийд гарсан билээ. Уйлах хүүхдийн хошног урьд өдрөө умалздаг гэдэг билээ. Төрсөн ахтайга тэрсэлдсэн Аблайтай дөрөө нийлүүлсэн тэр хэдэн ноёд ч нэг л өдөр утсан чинээ улаан амиа гуйх бий вий, гэтэл хажуугаар нь халх, Ойрад руу шүлсээ залгин өнгөлзөгч Манж дайчин гүрнийг яах билээ хэмээн Очирт цэцэн хан аян замын турш бодолд умбан явлаа.

Аян зам хэдий урт, зүдэргээнтэй ч гэртээ ирж төгсдөг нь юутай аз жаргал. Олон хоногийн зүдэргээнт аянд сульдан, тус бүр биеэ ихэд бодон дов дошин дээрээ хаан мэт эзэн суусан ихэс ноёдын адармаатай ааш аягийн эвийг олон, нэгдсэн төр улс, тусгаар байдлын зүгт хандуулах чуулганы “хан”-ы амаргүй албанд зүдэрч яваад ирэхэд нь халуун дулаан гал голомт нь дөхөж, хотны ноход морин төвөргөөнийг саахалтын газраас анирдан мэдээд дуу авалцан хуцахыг сонсох хэчнээн сайхан.

Ааль намба уяхан Доржравдан хатныхаа толигор царайг харж, адармаатай бяцхан гүнж Анугийн хөлстэй хонгор толгойг үнэрлэх нь эгэл энгүүн атал зүйрлэшгүй их жаргал юм гэдгийг өргөөний нохдын хуцалдах дуун ойртох тусам ухамсарлан яарч явлаа.

Зая бандид Намхайжамц багшийн үгүйд хуралдсан анхны чуулган төдийлөн санаанд хүрээгүй, дөрвөн Ойрадын холбоо, цаашлаад Далай багшийн соёрхолт чуулганы хан ахаасаа сэтгэл буруулан тэрслүүд ноёдын эвсэл байгуулан дайсагнаж буй дүү Аблайтай махан хэлээр бус, ирт зэвсгийн хэлээр “ярьж” хашраах хүндхэн шийдтэйгээр орд өргөөндөө ирэхэд нь нэг бус баярт мэдээ түүнийг хүлээж байлаа.

Энэ нь Ану охин нь багшийн эзгүйд үсэг холбож торолгүй уншдаг болсны магнай тэнийм баяр, нөгөө нь үр зулбаснаас хойш олон сар бие суларч, сэтгэл гутран хэвтэрт ороод утсан чинээ улаан амь нь юун дээр торж байнав? гэмээр турж эцэн хоёр тугал хар нүднээс өөр юу ч үгүй болоод байсан Нуран хатан сүрхий илааршин боссоноор барахгүй, саалийн үнээ малладаг Дулбаа хүүхний хоёр ихэр нярайн нэгийг үрчлэн аваад элэг нь дэвтсэн явдал байлаа.

-Залуу бага хүн үрийн мөрөөсөл бололгүй яахав. Дулбаа хүүхэн сая нярайлж, охин, хүү хоёроор ихэрлээд, зайлуул хөх нь сүүгүй. Улаан нялзрай хоёр ам чарлаж байна хэмээн

сонсоод охиныг нь авч Нуран хатанд үрчлүүлчлээ. Тэр нь хайдаг ямааны сүүгээр угжуулаад бөндийсөн цагаан амьтан болсон. Ану дүүтэй боллоо гээд амь хэмээн аливаад самбаатай, хэний ч санаж сэдээгүйг түрүүлэн хийчихдэг Доржравдан хатан нөхөртөө ярьж, хантны талархлын харцанд талимаарч суулаа. Үнэн хэрэгтээ Доржравдан өөрөө Нуран хатны анхны үрийг юмдүүжингээр зулбуулснаас болж хөөрхий бүсгүй эгүүрд үрээ тээх чадваргүй болсонд эрхбиш гэмших сэтгэл, нөгөөтэйгүүр хантан юмыг яаж мэдэхэв, залуу татвар эм авчирчихвал тэр нь гахай мэт зулзагалаад эхлэх вий гэсэн болгоомжлол, басхүү нөхөртөө энэрэнгүй хүний дүр үзүүлэх мэтийн олон давхар санаа агуулан саальчин Дулбаагийн ихрийн өрөөснийг бага хатанд өргүүлэх санаа төрснийг гадарлаж буй хүн өөрөөсөө илүү итгэдэг Жангараг шивэгчнээс нь өөр хэн ч үгүй билээ.

Одоо нэгэнт үр хүүхдээ бүрэн есөн сар тээж чадахаа больсон Нуран руу хантан хааяа гүйвэл гүйж л байг. Хортой юм биш хэмээн Доржравдан бодож байв.

Хөшиг цавгийг нь ирвэсний ганган цоохор арьсаар битүү бүрж, унины углуурга бүрийг хүрдэн хээтэй мөнгөн даруулгаар чимж, Турфанаас авчирсан хар модон ор, шүүгээ, мэлхий ширээ, тана, оюугаар хүрээлсэн босоо толь тавьсан уужим саруул, тансаг чамин эдээр дүүрэн өргөөндөө Доржравдан хатан цоо шинэ улбар ягаан лавшиг дээрээ цасан цагаахан хоргой цэгдэг галалзуулан гоёод эр нөхрөө явснаас хойш улам ч өнгөлөг, толигор болсон цагаахан царайдаа хөнгөн инээмсэглэл бүжиглүүлэн айргийн тос самран хушганы идээ хийсэн аагтай хонгор шаргал цай өөрөө аягалан барьж:

-Алив Ану, миний үр үсэг холбон уншиж сурснаа аавдаа ярь даа. Цай уучаад хоёулаа Нуран хатны өргөөнд очин таны өргөмөл бяцхан охиныг үзье гэхчлэн усан дээр өрөм тогтом аашилна.

-Аав, би таныг санаад бичгийн гэрт орж мэлхий ширээн дээрх нагван, бийр, янтайг тань шохоорхон үзэж байгаад нэг судар руу санаандгүй харсан чинь үлгэрт гардаг шиг л юм болсон.

-Уухай ?

-Ямар үлгэр шиг гэж үү? Таны ширээнд дээр байдаг нэг судрын үсэгнүүд нь гэнэт өөрсдөө нийлээд л Саган сэцэн “Эрдэнийн товчи” гэсэн үг болоод ...

-Үгүй энэ чинь, миний үр Улаанхүүгээр дөнгөн данган цагаан толгой заалгаад хоцроо биз дээ? тэгтэл ингээд өөрөө уншаад сурчихдаг. Аав нь юугаар мялаах билээ? хэмээн өвөр түрийгээ ухаж буй янз үзүүлснээ ганц нүдний бяцхан дуран гаргаад ирлээ.

-Ээ, гялай! Урд довцог дээрээс энэ дурангаар дурандаж байгаад тарвага мөндөл нүхнээсээ цухуйхаар нь нам харвана даа хэмээн охин хөөрцөглөнө.

Охины бие овоо торниун илаар болж, буцаад хацар нь мяраалж байна. Намартаа Хөх дэрсний булан руу нүүхээсээ өмнө Улаанхүүг Мандал хиатай мордуулж, Хойдын Дүүрэн бичээчийг урьд хэлэлцэн тохирсон ёсоор залж авчран охиндоо ном заалгая хэмээн Очирт цэцэн хан шийдэв.

Өргөөний хэрэг явдал ийнхүү нэг хэсэгтээ намжиж, байтал дүү нь гар дорхи мянгатаа шар тал тийш аваачин, цэргийн бэлтгэл хийлгэж, албат иргэдээсээ цэргийн хүнс хэмээн нэмэлт гувчуур хурааж буй тухай мэдээ Аблайн өргөөний зүгээс сонордон, асуй тулалдааны чимээ айлсан эхнэр, эмсийн сэтгэлд түгшүүр төрүүлнэ.

Алшаад өвөлжсөн олон албат нь харын зудад таван малынхаа талыг шахуу үхүүлж, гарз ихтэйгээр хахир өвлийг давсан нь цэргийн хүнс татахад улам үгүйрэн өлбөрөхөөр байлаа.

Юутай ч энэ жил өвлийг өнтэй даван малаа өсгөн, цэргээ бэлтгэж, хүчээ зузааруулан, хань хамсаа олныг татах хүртэл тулааныг хойшлуулах нь зүйтэй хэмээн Очирт хан шийдэвэй.

“Морьд дэндүү туранхай, цэргийн хүнс хүрэлцээгүй буй” хэмээн Галдмаа ч эцгийн талд зогсов.

Харин Гартангомбо, Эрдэнэ тайж хоёр “Сэнгэ хантай хүчин хавсран Аблай авгыг эртхэн нуга даръя. Барын зулзагыг бага дээр нь” гэлцэн эрхбиш нэгэн эхийн хэвлийгээс унасан юм гэсэндээ элэг нь хаачихав. Бие биенээ дэмжин дуу нэгтэйгээр зүтгэцгээсэн ч эцэг нь төдий л ойшоосонгүй, хөмсөг зангидан, бодолд дарагдахаараа тэгдэг зангаараа баруун талын сахлаа имрэн суусаар авай. Тийнхүү хэрэг бүхэн ямагт амны нь салиа арилаагүй Галдмаагийнхаар шийдэгддэгт ах дүү хоёр сэтгэл нэн дундуур хоцорчээ.

Хөх нуурын баруунтай Хөх дэрсний булан хэмээх хужир мараа ихтэй, хөвөөгөөрөө өндөр хөх дэрстэй цэнхэр тойрмууд өндөр тэнгэрийг тольдон мэлтийсэн сайхан нутагт Очирт ханых намаржив.



## Долдугаар бүлэг

Намрын сүүл сарын бүүдгэр нэгэн өдөр байлаа.Шувууд нь ганганан ганганасаар эзгүйрсэн цэнхэр тойрмын ус захаараа зайрмагтан хөлдөж, уйтайгаар мэлтийн, хэнз ботгонууд гадсаа тойрон гунигтайгаар буйлж, сөл өвс шаргалтан тахийн зоо шиг бидэрлэсэн тэр өдөр гэнэт том том ширхэгтэй тэмээн туйлаадас дундуур нэгэн айлын хөсөг хойд зүгээс тэднийхийг чиглэн нүүгэлтэн ойртсоор тодорч ирсэн нь Хантны заллагаар эрх бяцхан гүнжид нь ном заахаар ирж буй Дүүрэн бичээчийнх бөлгөө.

Таван ат, дөрвөн шар тэргээр нүүн ирж буй энэ айлын тэмээнд ачсан гуулин бүслүүртэй олон зандан авдрыг халиасан хүн хур их хөрөнгөтэй, алт эрдэнэ хураасан баян айл юм даа хэмээн шуналын шулам нь сэрж тонгочим.

Гэвчиг хэдэн үе улиран судар номтой нөхөрлөж, нанхиад, төвд хэлээс яруу найраг, гүн ухааны сургааль, шашны ном дуун хөрвүүлсээр ирсэн бичгийн удамт энэ айлын тэр олон авдарт алт мөнгө, торго дурдангаас илүү эцэг өвгөдийн бүтээн, уншиж гэгээрч нандигнасан судруудаас гадна Дүүрэн бичээчийн өөрийнх нь тод үсгээр буулгасан олон баринтагтай номууд чихээстэй байжухуй.

-Ану, багшийнхаа нүүдлийг тосон идээ цай хүргэж өг хэмээн Жангарагийг дуудахад өргөөний гортигийн гадна хүүхдүүдтэй чоно тарвагацан ухаангүй тоглож асан охин гүйж ирлээ.

-Охин минь малгайгаа өмс.Нударгаа буулга.Ном дор мөргөмү.Багш дор мөргөмү гэдэг юм. Эрдэм заах багшаа бурхан мэт дээдлэн хүндэл гэсэн үг. Ижийнхээ өгсөн идээ,домботой цайг бариад нүүдлийг тосч “Багш Та аян замдаа амархан сайн явж ирэв үү?” хэмээн хүндэтгэл төгс мэндийг нь мэдээрэй хэмээн эцэг нь сургав.

-Мэднээ,аав аа! Тэгээд чингэж мэхийнэ тийм ээ? хэмээн сэргэлэн охин тахимаа нугалан мэхэсхийж үзүүлэв.

-Балсантайгаа яв.Алив тэр домботой цайг нь барь чи хэмээн өрлөг эх нь хүүгээ урагш түлхлээ.

Хэдийгээр эхийнхээ ангир уургийг бүрэн хөхөөгүй ч Ану гүнжээс нэг сайн төө өндөр биерхүү тул арав гаран настай мэт үзэгддэг өсгөлүүн чийраг Балсан хүү сийрэг шингэн хөмсөг дорхи урсгал алаг нүдээ доошлуулан:

-За ээжээ гэсээр дуртай нь аргагүй гүйн ирж Доржравдан хатны өмнө нэг мэхийгээд гараас нь алталсан утсан чимэглэлтэй, том мөнгөн домботой цайг авлаа.

Хүүгийн гар саарьтай, ногоон даалимбуу дээлийн хуучин ямаан хилэн нударга нь халцарч сэмэрснийг үзээд хатантан дургүйцэн ярвайж:

“Энэ Ханджавт хүүдээ шинэ дээл хувцас хийх хэдэн толгой чисчүү өгье байз.Миний охины сүүдэр нь болж хаа явсан газар нь дагадаг, хэтдээ хадамд мордоход нь шадар хэвгүүл зуутын

дарга болгон явуулах юм чинь өнгөтэй өөдтэй үзэгдэх нь зүй” хэмээн боджээ.

Харин хөөрхий Ханджав, хатан ахайтны царай янз муутай буйг харцаар нь ажин мэдээд хүүгийнхээ гар хөлийг угааж, цэвэрхэн хувцаслаж байхгүй бол хатантан хилэгнэх нь. Орос газар бага насаа өнгөрөөсөн, ихэс дээдэс хүн борчууд бидэн шиг хир сайрандаа баригдаад явж үзсэн биш. Тэр Орос газар эхнэр эмс нь өмд өмсдөггүй, урт нэлмэгэр банзал өмсч явдаг. Тэгээд банзлаа шууж, гуя хасаа гялалзуулаад лус хилэгнэнэ гэхийн зовлонгүй гол усанд хир тоосоо угааж зогсдогийн гэнэ билээ хэмээн гэмшин бодов.

Ийнхүү Очирт цэцэн ханы Ану гүнжид ном заах багш Хойдын Дүүрэн мэргэн бичээч хэмээх нас тавь шахаж яваа, хөмсөг сахал нь тас хар атал, үс нь хоёр санчгаасаа эхлэн өл бууралтсан, соёо сахал, ухаалаг дөлгөөн харцтай бүлцэндүү нүд, монхордуу хамар, уужим магнайтай, дунд хэрийн нуруутай, ясархаг эр, өөрөөс нь хэдэн нас эгчмэд мэт үзэгдэх зузаан бадируун гэргийн хамт нүүн ирлээ.

Гэргий нь хөрөнгө чинээ зузаан, Хами, Хөх хот руу жин тээж хөлжсөн худалдаачин хүний охин Зэсэнжав нэртэй, бүдүүн богинохон хуруу, гэдэс ихт том чихэндээ шижир алт гялалзуулсан, орсон гарсанд унд ус сайтай, өгөөмөр зантай, хүүхэд багачууд амттан тараан инээд алдсан авгай байлаа.

Харин хар хүн нь галав юүлж байсан ч хоймортоо судар дэлгэн шагайж суудаг бичиг номын бодь хүн ажгу. Зая бандида Намхайжамц гэгээнтний удирдлага дор түүх, уран зохиол, шашны сургаалийн ном судар дуун хөрвүүлж, тод үсэгт буулгахад идэвхийлэн зүтгэж, тэнгэрт хальсан Баатар хунтайжийн албанд хүч өргөж явсан Дүүрэн мэргэн бичээч насны бөгсөнд заяасан ганц хүүгээ цэцэг өвчнөөр алдаж зовлон зүдүүр үзсэн хүн ажээ. Тиймээс ааль сайт гэргий нь хүүхэд л харагдвал нусыг нь арчин, сайрыг нь мулз угаан арилгаж, хирийг нь цэвэрлэн, авдраа уудлан амттан түгээж хүүхдийн гэгээн нүд баярлахыг үзэх дуртай аж.

Тэднийхийг гэрээ барьж, төвхнөсөн хойно Ану охин хүндэтгэлийн дээд шар баранзад хадаг барьж, багшдаа золгон хүндлэв.

Був буурал үстэй атал өтгөн хөмсөг, соёо сахал нь тас хар, тэгээд нүд нь зөөлөн атал зан нь цаанаа ширүүн юм шиг үл таних энэ хүнээс, эрх дураараа Ану охин нилээд бишүүрхэх мэт дөлсөөр золгож билээ.

-Долоотой гэхэд биеэр бага юм. Магнай уужим, хөмхий зуугаад байхыг бодоход шартай охин биз. Чи хө, эрдэм сурах дуртай юу? хэмээн багш нь асуулаа.

Охин эхлээд гэрийн баруунтай суух эцгийн зүг, тэгээд эх, өрлөг эх өөдөө дараалан дэм эрсэн харцаар хараад гэнэт зүүн хөмсгөө өргөн толгой гэдийлгээд:

-Дуртай. Би тод үсгээр уншиж чадна шүү! хэмээн эрхэмсгээр хэллээ.

-За тийм байдаг байж. Чи хө, надаар юу заалгамаар байна?

-Уйгаржин монгол бичиг, бас түүх...гээд охин бодолхийлснээ тэргүүнээ өргөн:

-Мандухай сэцэн хатны домгийг яриулмаар байна. Бас өөр хатдын тухай ч гэсэн гэлээ.

Охин хүүхдэд ном заана гэж сонсоод цаанаа дурамжхан байсан Дүүрэн мэргэн Анугийн нүдэндээ цогтой, сэргэлэн төрх, цод цодхийсэн яриаг сонсоод соёо сахал дороо мушийн хүд хүд инээгээд охины толгойг илж, эцэг рүү нь сэтгэл дүүрэн харцаар хараад:

-Ном сурах хүүхэд юм шиг байна, таны гүнж хантан минь гэж билээ.

Ховог сайр дахь Баатар хунтайж агсны ордон.

Дотоод ордныхоо шадар түшмэлүүдийн зөвлөлдөх танхимд Сэнгэ хунтайж гагцаар гүн бодолд дарагдан сууна. Өв хөрөнгөнийхөө тэн хагасыг, эзэн суудлынхаа хамт өөрт нь үлдээгээд тэнгэрийн оронд одсон эцгийнх нь эш хөрөг эл танхимын хойморт залаастай.

Зураг дээрээс тэргүүндээ очир алмас эрдэнийн жинстэй хүрэн булган малгай асааж, булган эмжээртэй хар хамбан дээл өмссөн эцгийнх нь догшин нүд өөрийг нь дагуулан ширтэх мэт.

“Эцэг минь та өв хөрөнгөнийхөө талыг над, нөгөө талыг ах дүү есөн хүүдээ хуваан өгчилгөнө хэмээн гэрээсэлсэн нь мөхөс надад аз уу, эз үү? хэлэхэд бэрх зүйл юм. Оногдсон өв хөрөнгө, эрх мэдлээ чамлан, ахмад хүү хэмээн хан сууринд санаархсан Цэцэн, Зодов ах нар дөрвөн Ойрадын чуулганд ирсэнгүй, санаа буруулан одлоо. Буруд хатан Дара Балжи ууган хөвүүн эзэн сууринд суудаг эртний заншлыг зөрчин ёсгүй хатны хүү эцгийн суудлыг эзэрхийлэн эзлэв хэмээн гүтгэлгийн үг цацсаар явна. Энэ зун хур бороо татруу байснаас эцэг Таны эхлүүлсэн тариалангийн ажлыг эгээтэй л тасалдуудсангүй. Ургац хомс байв хэмээн уйгар тариачдыг торлогдон гэсгээгээд ч хөрс шимээ нэмэх биш дээ.

Манжид идүүлчихэлгүй Зүүнгар түмнээ туурга тусгаар авч үлдэхэд хойд зүгт элэг татаж, Оростой найрамдалт харилцаагаа таслахгүй байх минь хэмээн хичээн элч зарж бэлэг хүргүүлсээр байна. Удам залгах хөвүүд Цэвээнравдан, Сономравдан нар мэндэлж, таны үр үндэс эгнэгт тасрахгүй нь гэдэгт л магнай тэнийх юм.

Цастын оронд одсон Галдан дүүгээ зарим үед дэргэдээ үгүйлэх ч бурхан болсон номын гэгээн багштан Зая бандид шигээ номд гэгээрсэн их ламтан болж ирээд Ойрад түмнийхээ хүндэтгэл, бишрэлийг хүлээн, төрийн хэрэгт минь шашны алтан багана нь болон түших болбуу хэмээн найдах юм хэмээн ганцаар үлдэх үедээ тэгдэгчлэнгээрээ эцгийн хөрөгтэй сэтгэл дотроо хүүрнэн гүн бодолд дарагдан суух ахуйд өргөөний гоцго ногтон сахалт Гуулин шагайж доор мэхийн:

-Таны эх Юм-Агас ахайтан залрав хэмээлээ. Хормын дараа хоргой цэгдгийн хормой ширчигнэн, хатан хүний ёслолын малгай өмссөн атал гялтайх нэгээхэн ч чимэг зүүлт үгүй нь нэг л хөмсөггүй нүд мэт цулгай харагдах Юм-Агас хатны цонхигор царай үзэгдэв. Наснаас нөхчигч эр нөхрийн хойноос гашуудан эм хүний чимэг сайхан үс гэзгээ хусуулан, сахил хүртсэн цагаас эхлэн хатан хүний ёслолын хувцас өмсөвч, урьдын адил алт, сувд зүүхээ болиод удаж буй эхийнхээ энэ энгүүн бодь төрхтэй Сэнгэ хэдийн дасал болжээ.

Гүн бодолд дарагдан барайж суусан Сэнгэ хааны царайд гэрэл гийж, эхийн орж ирсэнд

олзуурхан суудал засан нуруу цэхлээд:

-Хатан ижий, та амгалан морилж явна уу? хэмээн хүндлэв.

-Тэнгэрийн тааллаар амгалан тайван байна.Цастын орноо суугаа дүүгээс тань захидал иржээ.Винайн ёсны зэрэг зиндаа ахиж гавьжийн дамжаа барьж гэнэ гээд Сэнгийн зүүн талын бадмаараг цэцгэн суурьт сэнтийд суухад хунтайж зүүн гараа сунгамагц баригдсан ган хэлтэй, алт шармал хонхыг авч ганц жингэнүүлмэгц түрүүчийн ногтон сахалт гоцго орж ирэв.

-Хатан ижийд цай, идээ!

-Жа, хунтайжтаан.

Хэдэн мөчийн дараа хоёр хавгаст сийлбэртэй хаалга нээгдэж, гурван шивэгчин хүүхэн домботой аагтай цай, самнаа боов, үзэмтэй хольсон тос, хатаасан нандин чавга, илжгэн чих, чихэртэй хурууд, аяга өрсөн тавиур барьсаар цувран орж ирэхэд хамгийн сүүлд яваа тормон нүдэт, харь зүсний, урьд ордонд үзэгдээгүй бүсгүй рүү сэртэндсэн харц чулуудах Сэнгэ хунтайж:

-Жасмин үлдээд цай аягал!гэлээ.Тэгснээ сая эхийн зүг эргэж:

-Юутай сайн хэрэг билээ.Дүү минь шашин номын эрдэм ухаанд цоорхой гэгээн хутагт болбол миний төрийн хэрэгт хамжаа болж, талаар нэг тарсан Ойрад түмнээ шашин бурханы малгай дор нэгтгэхэд тустай. Гэвчиг олон жил Цастын орноо сууж гэр ордноо санаж л байдаг байх даа хэмээснээ тормон нүдэт шивэгчин бүсгүйн аягалж өгсөн аагтай цайг авахдаа зүүн хацрыг нь сэм илбээд авахыг эх нь ажиглахгүй өнгөрсөнгүй.

Шивэгчин бүсгүй хатан эхэд цай аягалж өгөөд холын самаркандаас ирүүлсэн хасарвааны самар, амтат халва таваглан өрөөд бөгсөөрөө ухран гарч одох хүртэл Сэнгийн жоготой хар нүд эхийн нүдийг хариулан хүүхний зүг ширтсээр үлдээд, сая эхийн түвшин царай өөд хүндэтгэнгүй харц шилжүүлэв.

Юа-Агас хатан халванаас хэсэгхэнийг элтлэн үмхээд хүүгийнхээ шивэгчинтэй шалиглахыг дуугүй ажиглан суухдаа “Тэнгэрт хальсан эцэгтэйгээ юутай адил болно вэ?Төрийн хэрэг хэлэлцэх, аян зам, алалдах тулаанд явахдаа ч өнгөтэй залуу эмс үзэгдэх л юм бол улаан хөлтнийг урдуураа өнгөрөөдөггүй сэн” хэмээн талийгч эр нөхрийнхөө тухай гунигтай ч юм шиг, басхүү егөөтэй ч юм шиг дурсамж сэргээв.

-Маргааш авга тань ирнэ хэмээн хэлүүлээ юү?

-Тэгсэн.Юутай ч гэсэн чуулганд ирж, Ойрадын эв нэгдэлд цөв суулгах санаа өнөөхөндөө үгүй гэдгээ нуталсанд нь би баяртай л сууна.Харин Багабанди ах л их янз муутай харагдана лээ.

-Цөхүр увш дотуур тамиртай хүн биш.Санаагаа ил шулуун хэлэх хүн. Харин хүү нь илүү мигуй санаатай. Чамтай алсуураа суурь булаалдаад амраахгүй байгаа сурагтай.

-Тэгээд маргааш авга тухайлан энэ тухай ярих гэж ирнэ гэж Та бодож байна уу?

-Би тэгнэ л гэж мунхаглана.Энэ бол ацан шалаатай шаардлага.Үгүй гэхэд хэцүү.Багабанди чамтай хамсан төр барья гэж тулгана биз.

-Эцэг минь гагцхүү надад л хунтайжийн суурийг залгамжлуулсан. Ууган хүүдээ ч өвлүүлээгүй хан сэнтийг авгын хүү Багабандитай...

-Хүү минь сайн бод.Нэг бол чи насаараа эцэгтэй чинь өв хөрөнгө, байр суурь булаалдсан авгынхаа хүүтэй эрх мэдлээ хуваах. Нөгөө бол тэд чиний төрсөн ах Цэцэн, Зодов нартай хавсраад чамайг “нүхэнд” унагах.Цэцэн бол чамтай юухнаа ч үл хуваалцах хүн. Харин Багабандитай эрх мэдэл хуваалцах нэрээр цоросын дотор хамгийн ахмад, нөлөөтэй нь болоод буй эцгийнх нь нөмөр нөөлгийг түших нь нэг хэсэгтээ мэргэн шийд ч байж магад.

-Тэгэхээр би Багабанди ахтай хунтайжийн эрх мэдлээ хуваалцах нь зөв гэж үү?

-Өнөөхөндөө энэ л ганц зөв гарц.Тамга, сэнтий чиний гарт буйг бүү умарт.Чи албат иргэдийн татвар, гувчуураас Багабандитай хуваалц, ийш тийш илгээх айлтгал бичгийг хамсран хэлэлц.Зарим онц чухаг бус бичгийг тэр мутарлаг. Хариуд нь авга чинь Аблайтай үгсэн ханцуйдаа хутга нуухын оронд чиний гол холбоотон Очирт цэцэн хантай нэг хэсэгтээ бөөр нийлж хүчин хавсарна.

Сэнгэ эхийн адил цайвар царайгаа барайлган, мөн эхтэйгээ адил, хүүхэн хүнд илүү зохилтой гэмээр нарийхан хөмсөг зангидан живэр сахлаа оролдон бодлогошров.

-Бодоод байхнаа хатан ижий таны санаа зөв байх юм аа.

Эх нь нэгэн цагт ягааран гэрэлтэж явсан ч одоо цонхийн цайсан царайдаа ядрангуй мишээл тодруулан амтат халванаас элтлэн нэг буланг ам руугаа хийгээд хөрч зөөгшсөн цайныхаа шавхрууг ёроолдон ууж дуусгав.

Сэнгэ эхдээ цай хийлгэх ялдар уйгар угсааны хөөрхөн шивэгчний зүсийг дахин харах далим гарган хонхоо хоёр цохив.

Энэ нь гоцгыг бус шивэгчнийг орж ирэн цай аягал гэсэн дохио аж.

Жасмин хэмээх уйгар бүсгүй орж ирэхийг сайн ажвал цэнхэр торгон шарваар, хоёр талаараа оноотой хурц ягаан цэгдэг маягийн хантааз, ханцуй уужим торгон өмсгөл, толгой дээрээ цагаан алчуур дээр алтан утас шагласан тоорцог тавиастай, тормон нүднийхээ дээгүүр тодхон зурайх хөө хархан хөмсөгтэй үзэмж хөөрхөн бүсгүй аж.

Уйгар бүсгүй Сэнгэ хунтайж, Юм-Агас хатан хоёрт цай аягалан дэвүүр мэт урт сормос буулган бөхөлзөнө.

-Жасмин нааш ир!Үзэм ид гэж Сэнгэ нялуун шалиг дуугаар хэлээд үзэм атган өгөхдөө жижигхэн гарыг нь байж ядсан мэт атгаж аваад тавилаа.

-Хүү минь, монгол хүн чихэр амттан түлхүү зооглоод байвал хэдий амт нь сайхан ч шүд муутай болно. Таваг идээндээ шүүрмэг, хурууд эцээхэн тавьж бай хэмээн эх сургамжлах нь далдуур уйгар, буруд, хасаг харь элгийн, буруу номын эмс, хүүхэнтэй багахан орооцолд гэсэн сануулга байлаа.

Ийнхүү нэгэн хэсэг дөрвөн Ойрадын холбооны чуулган хоёр хантай болж, Хотогчин Баатар хунтайж, хошуудын Очирт цэцэн хан хоёул мөр зэрэгцэн их үйл хэрэгт зүтгэж явсны нэгэн адил, Цоросын хунтайжийн эрхийг Сэнгэ хаан авгынхаа хөвүүн Багабандийн хамт атгахаар болсон нь Ойрад түмний эв нэгдлийг эрхэмд үзсэн алхам байлаа.

Юм-Агас хатан төрийн ёслолын ордноос шадар гоцго Буянтөмөрөө дагуулан гарлаа.

Халуун орныг зорих тогоруун цуваа тэнгэрт зэллэн, төрж өссөн нутагтаа хоргодон ганганах үрс нь өмнийг зорих аяндаа шуударч үл төвдөн уй гунигийн дуу хадаана.

Хатан явсаар цувраа гурван хиймэл нуурын хөвөөнд ирж гантиг чулуун хашлагыг нь сандайлан суулаа.

Цөөрмийн хөвөөнд бөгтийн ургасан дулаан газрын уд мод нарийхан нарийхан навчсаа гөвж, уй гашууд автсан эмэгтэй мэт гуниглан бөхийжээ. Бяцхан цөөрмийн ногоовтор ус уд модны гонзгой шар навчсыг тээршаах шиг сэвэлзэх салхинаа жижигхэн жижигхэнээр бидэртэн долгиолж нэг тийш нь хамах авч, уд мод дахин бөөн бөөн навчсаар уйлах аж.

дасал болсон голомт, орд өргөөгөө, нутаг ус, хайрт ижий таныгаа тэсгэлгүй их санавч, хатамжлан хүлцэж, бурханы номдоо шамдсаар винайн аймгийг үзэж дуусган гавьжийн зиндаа барив... хэмээн голт зүрхний нь зул болсон Галдан хүүгийнхээ илгээсэн захидлыг хатан зүрхэн талдаа нандигнан хийснээ авч уруулдаа наав.

“Эр нөхрийн хойноос гашуудан сахил хүртэж, энэ ертөнцийн элдэв нүгэл хилэнцээс ангижран чавганц болсон надад хунтайжийн сууринд суусан хүү Сэнгэ, Цастын орноо шавилан суугаа отгон хөвүүн Галдан хоёр минь харанхуй цээж гэрэлтүүлэх наран, саран хоёр минь юм даа” хэмээн бодох зуур гэнэт Галдангаа хэвлийдээ тээж явахдаа энэ цөөрмийн хөвөөнд эр нөхрөө хүлээн басхүү сэтгэлдээ гомдолтой цээж харлан, гэдсэнд үе үе тийчлэн буй үрдээ бүүвэй аялан суутал:

-За чи минь энд юу хийж, хүйтэн хашлага сандайлж суудаг билээ хө! гэх Баатар хунтайжийн почмог чанга дуу хадаж, бядтай хоёр халуун гараараа нүдийг нь дараад:

-Алт уу? Мөнгө үү? гэж асууж билээ.

Урьд шөнө нь уйгар татвар эм авчран өвөртөлж хоноод өргөөнд нь морилон ирээгүйд нь гомдон суусан хатнаа аргадаж, сэтгэлийг нь тайтгаруулах гэж ирсэн нь илт.

Хэдий өргөөнд нь ирнэ хэмээн амласнаа умартан шинэ татвар эм авчран самуурсанд нь голдоо ортол гомдовч, басхүү авааль хатнаа аргадах санаатай тийнхүү тоглоом наргиа хийж, өөрийг нь эрж хайж яваад нь туйлаас их догдлон баярлаж, гомдлоо хоромхоноо мартсан

бүсгүй хайртай түүнийхээ бадриун гарыг хоёр жижигхэн алгаараа илбэснээ:

-Алт! гэхэд нь :

-Ха!,ха! Алтанд тийм их дуртай хүн үү? Чи? хэмээн нөхөр нь хэлээд өөртөө татан эргүүлж цээжиндээ нүүрийг нь наагаад уруулыг нь сахлаараа хатган тачаангуй гэгч нь озон үнссэнээ:

-Май.Үүнийг зүүгээд хөөрхөн хөмсгөө зангидахаа больж үз хэмээж билээ.

Түүнийг нь үзвэл битүү сувд шигтгэн чимсэн жигтэйхэн гоё дугуй хайрцаг байв. Юм-Агас тэр хайрцгийг бяцхан түгжээг нь торхийлгэн нээвэл дотроо тольтой, ёроолыг нь хар хилэнгээр бүрсэн тэр хайрцагт шижир алтаар цутгасан алтан гинжээр оосорлосон, гойд чамин хийцтэй бурхан багшийн дүр байж билээ.

-Хээ!Хэчнээн чамин эд гээч вэ?Гялайлаа тандаа!

-Алив би чамд зүүгээд өгье! Чамайг бие давхар болов гэмэгц Хами руу хятад инжаанд захиалуулан хийлгээд, төлдөрхөн Зая багшийг морилох үеэр аравнайлуулж авсан юм даа.Чамаас төрөх нуган үр минь эрдэм төгс хутагт болж юун магад хэмээн Зая багштан айлдсан шүү дээ гээд алтан бурханыг нь хүзүүнд нь зүүж өгөөд духан дээр нь үнсч:

-Тэр муу татвар эмтэй бүү жөтөөрхөлц хонгорхон минь. Татвар эм бүү хэл, энэ ордонд ёс төртэй буулган авчирсан зургаан хатнаас ганцхан чамдаа л би зүрхнээсээ хайртай.Нас өтлөн энэ ертөнцөөс одохын цаг дор чамаас мэндэлсэн Сэнгэ хүүдээ л хан суурь залгамжлуулах болно хэмээн аргадаад гараас нь хөтлөн өргөөнийх нь зүг одож билээ.

Тэгэхэд хавар цаг байсан сан.Энэ уд мод навчлан, хорвоо ертөнц хаврын жавхаагаар гийж байж дээ.

Яруухан хавар шиг залуу насны ялгуун сайхан дурсамж.Янаг хайрт эр нөхрийн яргуй мэт хэнзэлсэн хайрын эзэн байсан зүйргүй жаргалтай цаг байж дээ.

Одоо ч эр нөхрийнх нь дурлал хайрын дурсамж болон үлдсэн алтан бурхан хүзүүнд нь зүүлттэй яваа. Насан зүг болж энэ биеийг орхих хүртэл эл алтан бурхан зүүлттэй явах биз.

Юм-Агас хатан босч гоцгоо дагуулан навчис хөглөрсөн бяцхан цэцэрлэг дундуур өргөө рүүгээ гэлдэрлээ.

Залуу сайхан бүсгүй явахдаа буцах намрын уй гуниг, зэллэн нисэх шувуудын ганганааныг ингэж зүрх нэвтэртэл мэдэрдэг ч үгүй байж. Эр нөхрөө харамлах, хайрлах, бусад эхнэр хатад, татвар эмстэй жөтөөрхөлцөх, тэдэнтэй битүүхэн өрсөлдөн гоёж гоодох, уралдан жирэмсэлж хөл хүндрэх, их гэдэстэй болчихоод эрдээ хошуу унжуулан эрхлэх, алтан заадас зад татан тарчлан байж үр төрүүлээд нуган гэж дуулан хөөрч баярлах алтан мөч,араг түшин баавгайн савраар илүүлэн байж, ясаа үйртэл өвдөн байж хоёр яс салснаа тэр дорхноо умартаад хонины шинэ шөл оочлон хөлсөө дуслуулаад хөөр баяртай хэвтэх, алаг үрээ бүлээрэн уйлагнахад яах учраа үл олон зүрх сэмрүүлэн шаналах, алсад мордсон амраг ханиа хүсэн морин туурайн

чимээ анирдан хүлээх, ам мурийн гомдох, алга тосон бэлэг хишгийг нь хүртэх энэ бүгд эргээд бодоход эм хүнд заяасан зүйргүй их аз жаргал байж гээч.

Аргын тооллын 1662 он буюу усан бар жил гарлаа. Тэр жил Манж чин улсын эеэр засагч хаан тэнгэрт хальж, хоёрдугаар хүү Сюанье буюу Энх-Амгалан хаан сууринд суусан нь хожмоо элэг бөөрний холбоотой халх, Ойрадыг хагаралдуулан байж нэгмөсөн залгих луугийн зулбасга үүрэндээ дөнгөж бойжиж асан үе байлаа.

Очирт цэцэн ханы өргөө Тарвагатайн Улаан эргийн өвөлжөөнд өнтэй сайхан өвөлжжээ.

Байгаль эх хахир хатуудаа үедээ хатуу ч , өгөөмөр гараа дэлгэхээрээ өрөвч нинжин байдгийн учир Алшаад хоёр жилийн өмнө харын зуднаар олон малаа алдан үгүйрч асан айлуудын үлдсэн мал энэ хоёр жилд будаа шиг үржин, төл хорогдолгүй бойжиж байлаа.

Цагаан сар энэ жил нэлээд орой болж, сар шинийн даллага авахуулж, овоо индрээ дөнгөж тахиад байтал Халхаас гашуудалт мэдээ буухиалан ирэв. Манжид өмнөд, төв хэсгээрээ элтрэн идэгдсээр буй халх түмний дотроос Ойрадтой газар нутаг ойр, хамгийн найрсаг харилцаатай Засагт хан Норов гэнэт жанч халжээ.

Засагт ханы эзгүйрсэн суурийг хүү Ванчиг нь эзэлсэн дуулдаад удаагүй байтал байдал бишдэв. Учир нь Засагт хан Норовын ууган хүү Чуу мэргэн суудал залгах ёстой атал ахынхаа хүч чадал доройг дээрэлхэн дүү Ванчиг нь эцгийн суурийг хүч түрэмгийлэн булаасан байжээ. Тэгтэл дөнгөж тэнгэрт хальсан хотгойдын Омбо-Эрдэнэ ноёны хүү Лувсан тайж цэрэглэн Засагт ханы өргөөг дайлж Ванчигийг алаад ах Чуу мэргэнийг нь суулгасан аж. Эцгийн ор залгамжлахын төлөө хоёр хүүгийнх нь тэмцлээс үүдэн Засагт ханы ихэс ноёд хоёр талцан хөлгүй үймээн самуун дэгдэж, хөлд нь гэмгүй ард олон чирэгдэвэй.

Халхын баруун гарт цаг төр тогтворгүй болж цус урсан, Ванчигийн талыг дагалдагч Ахай тайж тэргүүтэн ноёд Түшээт ханыг бараадан Чахундоржийн нөмөрт гүйлдэн оров.

Харин Чуу мэргэнийг дэмжигч Лувсан тайж төв халхын томоохон ноёдын хүчинд түрэгдсээр аргагүйн эрхэнд Ойрад нутгийн зүг амь зулбан иржээ.

Хэдэн жил дайн дажингүй хөл хөсөр, гар газар, байгаль дэлхий ч ээлээ хайрлан зуд турхангүй байсан Ойрадад айсуу түгшүүрийн харанга нүргэлж эхлэв.

Илийн зусланд дөрвөн Ойрадын холбооны чуулганд санаатайгаар оролцоогүй Аблай тайж тэргүүтэн хэсэг ноёд хоёр жилийн турш алба гувчуур төлсөнгүй тул чуулганы шийдвэрээр Сэнгэ хаан, Очирт цэцэн хан нар хүчээ нэгтгэж цэрэглэн хаврын дунд сард Цагаан чулуутын сайр хэмээх газар үймээн дэгдээгчдийг бут ниргэв.

Сэнгэ хааны эх өөртэй дүү эрэлхэг жанжин Онцон цалам шидэхдээ гарамгай баатар хэмээн Ойрад даяар цууд гарсан эр.

Цагаан чулуутад Аблайн мянгат руу Очирт цэцэн ханы цэрэг гэнэт уухайлан дайрч цочоогоод, Аблай тайж, Хөндлөн увш, Далай тайш нар толгойн харуулын торгон цэргийн хамт газрын



бартаа даган зугтан зайлах гэснийг Сэнгэ хааны шадар мянгатыг удирдсан Онцон жанжин арван алдын цалам шидлэн нэг нэгээр нь бариад иржээ.

Үдэш нь Сэнгэ хунтайжийн хээрийн цацарт олзлогдсон гурван хулгайг авчран ам тангаргийг нь авч, мал хөрөнгө, албат иргэдийг нь хуу хураах ял асуув.

Гэтэл эцгийнхээ доохно суусан Галдмаа баатар дуулгаа авч баруун гартаа бариад:

-Харгалдах дайсны нүдээр харах юм бол харганы толгой дохилзох бүрд ч тас цавчаад байж болно. Хань хамсаатан, зулай гишгэсэн дүү минь хэмээн харвал гэм бурууг нь өршөөн хэлтрүүлж болохгүй нь юу билээ, аав минь! Хунтайжтан минь! гэснээр Аблай тайжийг хань хамсаануудынх нь хамт суллан, мал хөрөнгө, албат иргэд, өргөөг нь санд хураахаас түдгэлзээд чуулганы ханд тэрсэлсний ял асууж, таван зуун бодоор торгон шийтгээд нутаг зааж суллан тавив.

Бар жилд хий настайгаа арван нас хүрч буй Ану гүнж Дүүрэн мэргэн бичээчээр уйгаржин, тод үсгийн дүрэм, зурхай, тооны ухаан заалгасаар хоёр дахь жилийн нүүр үзэж, багын дэндүү дэггүй зан нь байргашиж эхлэв.

Дүүрэн бичээч маш хатуу багш тул бага үдээс эхлээд бүрэнхий болтол охиныг суулган ном заах агаад оройдоо хуулж сийрүүлж ир хэмээн бүтэн баринтаг судар өгч явуулна.

Билгийн тооллын хаврын адаг сар гарч байлаа. Цас цоохортон хайлж, өдөртөө уур савсуулан шалбааг тогтоож, шөнөдөө мөсөн дош болон хөлдөж, нялх төлийн дуу цуурайтсан монгол нутгийн хавар.

Ханш нээгдэж, үүр ичээндээ хоргодсон хорхой шавж, араатан амьтад хэвтэртээ хөрвөн хөдөлж, өвлийн цасан дахан доор нойрссон газар дэлхий сэрж, мөнх залуу хавар айлчлан ирлээ.

Очирт цэцэн ханы өргөөнд, ойролцоох Шүхэртийн хийдийн лам нартай хамт, алс Цастын орноос залран ирсэн эрдэмт лам Агванхайдавтан ирж, жилийн өнгийг тольдон, засал хийж, ерөөл, ном уншина хэмээн хавь ойрын сүсэгтнүүд цугларан багахан наадам шиг юм болж, гадуур бөөн шуугиан, хөл хөсөөн болж байвч багш нь “Жангар” туулийг тод үсэгт буулган хуулж талд нь оруул гэсэн даалгавар өгсөн тул Ану охин багшийнхаа хойморт байх улаан зандан ширээнд суун судраа хуулсаар л байлуга. Хэрэв салахын мөн болж яарсандаа муухай сарайлгаад биччихвэл багш нь цээрлэл үзүүлэн дахин эхнээс нь хуулуулдаг тул цэвэр, хичээнгүй атал хурдан бичих гэж охин байдгаараа хичээн чармайсаар хэлээ бултайлгачихна.

Энэ үеэр Үзмээ шивэгчин, хатны зараалаар яваа болтой Дүүрэн бичээчийн гэрийн эсгий үүдээр шөвгөр цагаан царай цухалзуулан хошуу цорвойлгоод:

-Дүүрэн багштаан! Ану гүнжийг ахайтан хурал ном дээр аваад ирээч гэлээ хэмээх нь ямар нэгэн цагаан булга ч юм уу үен ч юм уу цайвар зүсний мэрэгч амьтан мэт үзэгдэх нь инээдтэй.

-Ану хуулан бичих хичээлээ гүйцээгээгүй байна. Юун хурал ном.Овоо зэгсэн хичээн бичиж байхад нь сатааруулаад хэмээн багш нь зандраад хамар дээрээ тохсон тунгалаг болор шилэн дээгүүрээ Үзмээгийн зүг муухай харав.

-Жа...гэж Үзмээ хэлээд бултасхийн алга болов.

Доржравдан хатан дуудаж байна гэвэл өргөөнийхний цөсийг ганц халиадаг дунд хатнаас эмээсэндээ өөрийг нь явуулчих юуны магад хэмээн Үзмээгийн зүг аврал эрэн хялалзаж байсан охины горьдлого тасарч, бичиж буй судраадаа анхаарлаа хандуулав.

Бүр долоон насандаа тод үсэг холбон уншиж сурсан Ану хуулахдаа гаргуун цэвэрхэн бичиж сурч байлаа.

Ойрад түмний билэг эрдмийн охь болсон “Жангар” туулийг тод үсэгт буулгаж суугаа шавийнхаа дэргэд ирж хараад багшийн царай баярлан гийлээ.

-За шавь минь үзгээ тавиад нуруугаа тэнийлгэ дээ.Зэгсэн сайхан бичиж байх чинь хэмээн багш нь амнаасаа ховорхон унагадаг магтаалын үг хэлээд тас хар соёо сахлаа имрэн байж охины сийрүүлэн бичсэн хуудаснуудыг бичгийн хулсан хавчаараар чимхэн эргүүлж зогсоно.

-Жа багш аа! гээд охин годхийн гарч одлоо.

Том том ширхэгтэй тэмээн туйлаадас хаялсан бүрхэгдүү өдөр болж байлаа.

Дээр мэлтийгч хязгааргүй хөх тэнгэр бүрсгэр саарал жанч нөмөрсөн мэт бараан үүл толгой дээрээс юу юугүй унаад ирэхнүү гэмээр тээр доор нэвсийн , ааштай эмгэн тэр үүлэн дээр суучихаад зулсан ноос газар дэлхий рүү цацалж буй мэт охинд санагдана.гэтэл зузаан нэвсгэр үүлсийн сиймхий дундуур нэгэн ганц од гялсхийхийг охин олж харлаа.”Өдрийн од!” Өдрийн одыг өдөр олж үзэх нь тэр.

-Өдрийн од үзэх нь их л ховор завшаантай явдал.Тиймээс олдошгүй ховор зэвэр юмыг өдрийн одтой зүйрлэдэг юм хэмээн багш нь нэг удаа утга найруулгын хичээл заахдаа хэлж билээ.

-Багш аа! Шөнө тэнгэрт дүүрэн гялалзаж харагддаг тэр их од өдөр хаашаа алга болчдог юм бэ? хэмээн Ануг нэг удаа асуухад:

-Талд шөнө олон түүдэг гал асаахад чи алсын уулын орой дээрээс олж харах уу?

-Харна шүү дээ.

-Тэгвэл өдөр асаасан тэр олон түүдэг алсаас сайн харагдах уу?

-... охин юу хариулахаа мэдэхгүй дуугүй зогсоход багш нь хүд хүд инээгээд:

-Тэгвэл од эрхэс түүнтэй л адил. Өдөр нарны хурц гэрэлд одод үзэгдэхгүй.Шөнө нар жаргасан хойно л гэрэлтэн үзэгдэж буй нь тэр дээ хэмээн багш нь тайлбарлаж билээ.

“Өдрийн од”. Нарны хурц гэрлийг нэвтрэн газар дэлхийд ганцаар үзэгдэгч өдрийн од мэт содон хүн болох сон хэмээн охин мөрөөдөн тэмээн туйлаадас хаялах бүрхэг тэнгэр өөд ширтэн хаврын сэрүүн тунгалаг агаар цээж дүүрэн сорон зогсож авай.

Дараа жил нь охин арван нас хүрч, монгол Ойрадын түүх үзэж эхлэв.

“Монголын нууц товчоо”-нд гардаг Өэлүн, Бөрт үжин, Есүй, Есүгэн,Хулан хатны тухай сонсохдоо охины нүд оч мэт гялалзаад явчихна.

Бар жилийн шувтарга цагаан сар дөхөж байлаа.

-Багш аа!Хубилай хаан нийслэлээ Бээжинд шилжүүлээгүй бол Хар хорум хот мөхөхгүй байсан болов уу?

-Тэгж хэлэхэд хэцүү дээ,шавь минь.Орчлонгийн явдлыг таамаглаж хэлэхэд амаргүй. Заяа төөргийн хүрд хаашаа эргэхийг хэн ч хэлж мэдэхгүй.Орчлонд мөнх юм гэж тэнгэрээс өөр үгүй.

Охин бодлогошрон жижигхэн боловч, өргөн магнайгаа атируулна.

Юан гүрний сүүлчийн хаан Тогоонтөмөр нанхиадын босогчдод хөөгдөн Бээжингээс хайртай солонгуд хатнаа дагуулан монгол эх нутгаа тэмцсэн тухай багшийнхаа яриаг сонссон охин:

-хэрэв Аригбөх Хубилай хааныг ялж, Хар хорумаас нүүгээгүй бол юунд Тогоонтөмөр хаан муу хятадуудад хөөгдөх вэ дээ.Багш аа, тэр солонгуд хатан чинь тэгээд монгол хүн биш юм уу? хэмээн шалгаав.

-Биш ээ.Солонгуд улс гэж нанхиад улсаас цааш өмнө этгээдэд их далайн тэртээ байх жижигхэн улс.Уур амьсгал нь их зөөлөн чийглэг.Хүн ард нь тариа, ногоо, тутарга тариалж, загас гөхдөн, суурьшин амь зууна.Уур амьсгал зөөлөн дулаан тул хүмүүс нь цонхигор цагаан царайтай, хөө хар үстэй.Эмс охид нь гангар шаазан мэт цагаахан царайтай байдаг гэлцдэг гэв.

Охин жижигхэн ширхэгтэй цас хаялах тэнгэрээд нүдээ сүүмийлгэн харж, хаврын цээж тэнийм цэнгэг агаарыг ханатлаа сорж зогссоноо, тэртээд өргөөний тигийн цаана гүйлдэж яваа Мандарваа, Бундир хоёрыг олж үзээд бийр янтай нийлж хөдөлгөөнгүй удаан суусан биеийн хөшөөг гаргамаар санагдан тэр хоёрын зүг чавхдан одов.

Амьгаадсаар гүйн очиж яваа Ануг хараад нөгөө хоёр ч дөхөөд ирэв.

-Балсан,Булган хоёр хаачаав?

-Мэдэхгүй. Хурал номын тэрүүгээр шалсай горьдож яваа биз хэмээн Мандарваа хэмээх өндөр бор охин доогтой хэлээд хөхөрнө.

Бундир инээсэнгүй. Хөмсөг зангидсанаа яваад өгөв.

-Бундир яасан юм бэ? хэмээн Ануг асуухад Мандарваа олон салаа гээгнийхээ үзүүрээр оролдож зогсоноо Аблай тайжийг дарах байлдаанд Бундирын аав нь эгмээ тас харвуулж үхсэн шүү дээ. Ижий нь тэгээд аавынх нь хойноос ном хуруулна гээд үүний хайртай загал морийг өргөлд барьчихсан. Одоо бас нялх дүүгий нь тэврээд хурал ном хурж буй лам нарт аавынх нь сүнсий нь даатгахаар явсан гэсэн.

-Тэгвэл чи юунд Булган, Балсан хоёрыг балин шалсай горьдож яваа гэж хэлээв?

-Гэхдээ би Бундирыг шоолоогүйм чинь хэмээн Мандарваа биеэ өмөөрлөө.

Ану уурлан хөмсөг зангидаад:

--Чиний толгой юм боддог толгой юу, үгүй юу? \Энэ нь багшийнх нь дувт хэлдэг үг ажээ \Булган, Балсан хоёрыг хурал хурж буй өргөө рүү очсоныг балин шалсай горьдож яваа гэж хэлдэг чинь бүрлээч аавынх нь сүнсийг даатгах гэж очсон Бундирын ижийг дайруулж хэлсэнтэй ижил болж мэдэв үү? хэмээн ууртай хэлээд гэмшин бантсан Мандарвааг үг сүггүй орхичихоод өргөө рүүгээ гүйн оджээ. Тэгээд үдэш нь эцэгтээ Бундир унах морьгүй, үнсэх аавгүй болсныг хэлж, хурдан хээр морь өгүүлэхээр болж санаа амарч билээ.

Лам нарын ном хурж буй ёслолын найман ханат өргөөний гадаа Үзмээ Ануг хүлээж инээмсэглэн зогсоо харагдана. Өрлөг эх нь гүн их сүсэгтэй хүн тул өргөөний хатавчны хавьд наманчлан зогсоо биз.

-Таныг ижий тань эрээд байна. Дүүрэн мэргэн багш төлдөрхөн ийшээ орсон. Та хаачиваа? гэж асуухад зүүн хацар нь хөөрхөн хонхойж, давхраагүй атал цоглог хар нүд нь очтон байх аж. Үзмээ юунд тийн баяр хөөртэй байгааг Ану ухаарсангүй. Дотроо гайхасхийгээд гараас нь хөтлөн өргөө рүү оров.

Хурал ном нар шингэж байхад л сая өндөрлөв.

Ойрд уулзаагүй Галдмаа ахыгаа хатнаа дагуулсангүй ганцаар ирснийг хараад Ану ижийнхээ гараас тавиулж ах өөдөө гүйлээ.

Ижий, аав, Цэвээн хатан гурав нь зэрэгцэн явах агаад захад нь өвчилж хэвтэрт ороод боссоноосоо хойш бүрэн тэнхрээгүй Нуран хатан хоёр настай өргөмөл охин Бээвэнхандаа хөтлөн алхана.

Өргөөний хиа, аягачин, шивэгчин, галч, усчин, агтчин, хэвтүүл олны дунд Галдмаа ахынх нь өндөр нуруу, алтан сампинтай ёслолын малгай гялсхийн үзэгдэнгүүт охин нэг дуудах гэснээ хойноос нь гүйцэн очвол ах нь хажуугаараа шурдхийн өнгөрөх Үзмээгийн гарт нэг юм сэмхэн атгуулаад “Үдэш сар гарахад сэнжит хадан дээр хүрээд ирээрэй” хэмээхийг нь охин тодхон сонсчихов.

Үзмээг арван гурван жилийн өмнө арван настайд нь Сөнид аймгаас авчран үс зүс тэгш, ой сэргэлэн охин тул Очирт цэцэн ханы хайртай хатан Доржравданы шадар шивэгчин болгон өгчээ.

Эцэг нь түүний хар нялхад цэргийн албанд одоод сураггүй болж, долоотойдоо хүнд өвчнөөр эхээ алдан өнчирсөн энэ охин зарц шивэгчингүүдэд чанга , монгол ахуйгаас тэс өөр орос авхай нарын янзаар цэвэрч, сэжигч заншилтай, биедээ хариг, гоо үзэсгэлэнгээ ямагт тордон, ордны дотор цагийн мөнхөд далд явуулга хийн зам дээр нь хөндөлссөн хэнийг ч үл өршөөдөг, ухаан төгс, сэтгэл хатуу Доржравдан ахайтны наян найман аашийг хүлцэн тэвчсээр дэргэд нь арван хоёр жилийг үдэж чадсанаас үзэхэд өөрөө ч хатуухан “боорцог” биз.

Нүд хөмсөг айхгар тодгүй ч царайны тиг зөв, үзэмжтэй, дарь эхийн хөрөг дээрх шиг уран шулуун хамар, жижигхэн амтай, хун шувууных мэт урт цагаахан хүзүү, гунхалзсан нуруу даган мурилзах өтгөн хар гээгтэй энэ гоо бүсгүй өргөөний харуул, хэвтүүл, шадар хиа , гоцго, баатар эрс болоод орсон гарсан гийчдийн нүдийг хужирлах болж, хошууддаа нэртэй хөрөнгө чинээ гологдохооргүй хэд хэдэн айл хадаг тавин гуйсан ч гар чанга эзэн ахайтан хөдлөөгүйн дээр, дотроо бол Очирт цэцэн ханы цэргийн жанжин Илдэн баатрын хүү Өлчирт өгөөд өргөөндөө өөрийнхөө дэргэд байлгах бодолтой явдаг ажгу.

Гэтэл арван тав хүрмэгц уулын царамд ургасан вансэмбэрүү мэт цэвэрхэн бүсгүй болж, гоо үзэмж бүрдсээр буй Үзмээ өөрийг нь шохоорхон сээтэн хаялах эрчүүдийн хэнд нь ч нүүр өгсөнгүй өдий хүрэв. Энэ нь Доржравдан хатны гайхшийг барж, эгдүүт хөдөлгөн, аяагачин Гажидмаа, Шигшрэг \Мандарваа охины эх\ гээд амтай, хэлтэй ордны эмсээр нүд, чих тавиад ч өчүүхэн төдий сэжүүр олж атгаж чадаагүйдээ гайхшаа барж, “Энэ чинь арай битүү сүвтэй эрхтэн дутуу гайхал биш байгаадаа” хэмээн Жангарагтаа аминчлан ярьж байхыг нь Ану санаандгүй сонсч байжээ.

Тэр өдөр Галдмаа ах нь охинд жороо буурал морио унуулан эрхлүүлж, хөдөлгөөнт байг нум сумаар хэрхэн алдалгүй онох, амьсгалаа түгжин хараагаа онох цэгт төвлөрүүлэхэд гараа чичиргэхгүй байхын тулд яахыг зааж өгөөд, бичиг эрдэмд шамдан сурч буйг нь сайшаан магтжээ.

-Ах аа, та Жамьянмядаг эгчийг юунд авчирсангүй вэ? Миний гэзгэнд зүүх мөнгөн оосор бэлэглэж, гоё самнаж сүлжиж өгдөг юм. Бас эртээд ирэхдээ надад олон алаг туушин бэлэглэсэн хэмээн Ануг ахынхаа нүүр өөд өлийн нэхэл хатуу гэгч нь асуухад Галдмаа охиныг жороо буурал мориноосоо өргөн буулгаад Тарвагатайн уулсын оройг ширтэн байснаа шүүрс алдаад:

-Эгч нь тулгар биетэй. Хол газар мориор явж үл болно хэмээн Тарагт бариач хорьсон. Манайх удахгүй чам шиг хөөрхөн охинтой болох гэж байгаа гээд духан дээр нь үнссэнээ морио хөтөч Дэрэм гэдэг залууд өгөөд Ану руу тонгойн салаа гээгнээс нь нэгийг өхөөрдөн илж:

-Зуны дунд сард Мядаг эгч нь нярайлсны дараа шинэ төрсөн хүүхдийн угаалгын найранд очоорой дүү минь гэлээ.

Галдмаа ах нь том хүнийхээр сайн таван тохой, нэг төө илүү өндөр нуруутай тул дээл хийхэд жирийн хүнийхээс дэлэм илүү эд ордог эцгээсээ ч гурван хуруу өндөр, Майдар эргэхэд цугласан олон дотор малгайных нь оройн алтан сампингаар хүүгээ хаа явааг олчихдог хэмээн эх нь сайрхан ярих дуртай ажээ.

Ану нэгэнт л Үзмээ, Галдмаа ах хоёрынхоо дунд байдаг нууц явдлыг санамсаргүй гадарласан тул орой үхрийн өвчүүг зөөлөртөл чанан, мангиртай бууз, мөөгтэй битүү шөл гээд өргөөний хөгшин зам өвгөн гараа гарган барьсан зоог дээр тэр хоёрын харц хэрхэн тулгарч, шивэгчин бүсгүй цоо шинэ цэцгэн хээтэй хөх ягаан лавшигаа өмсч, хааяа эхийг нь дагалдан айл хунараар айлчлаар явахдаа зүүдэг мөнгөн суурьтай гурван эгнээ сувдан унжуургаа гарган чихэндээ зүүснийг ажиглан харсаар суулаа.

“Мэдлээ, мэдлээ. Үзмээ чинь Галдмаа ахад сэтгэлтэй юм байна. Даанч ноднин жил Аблай авгыг дарах тулаанд явж ирээд хацраа суманд халти шүргүүлэн шархалсныг нь үзээд уйлах гэж нүдэнд нь нулимс цийлэгнэж ирснээ ижийд “Нүдэнд юм орчихоод тороод...” гээд гарч гүйгээд байсан юм. Ахыг Жамьянмядаг эгчтэй өргөөнд ирж золгоход санаа алдаад, юм асуухаар сонсохгүй, ижийд “Хөөе дүлий годил чинь!” гэж загнуулаад байсан даг. Ахыг хатнаас нь харамлаад байдаг байх нээ. Ингэхэд Жамьянмядаг эгч том алаг нүдтэй, хөөрхөн ааштай, ганган гоё хувцастай ч хараад байхнээ Үзмээ шиг нарийхан, гоолиг хөөрхөн биш шүү дээ. Тэгээд юунд Галдмаа ахын хатан болсон юм бол оо? хэмээн охин орондоо ороод бодолд орон хэвтэж байснаа гэнэт гурван жилийн өмнө Цастын оронд учирсан Галдан ламтныг санан бяцхан зүрх нь догдлон булгилав.

Ану охин түүнээс хойш олон ламтай учирсан ч Галдан шиг цэвэрхэн залуу, бараг хөвүүн настай, дуу хоолой нь бүдүүн ч биш, нарийн жонгинуур ч биш, сэтгэл татам цээлхэн, уруул нь зурсан мэт уран, гар нь эм хүнийхээс ч цэмцгэр, тэгээд духанд нь адис хүртээхэд хамаг бие жирсхийлгэсэн тийм санваартан дахин тааралдаагүй билээ. Өргөөний орчмоор өдөр бүрий тааралддаг эцгийн шадар зуутын дарга Наваан агсны хүү арван хоёртой Бундир, өрлөг эхийн хүү, өөрийг нь сүүдэр мэт дагагч Балсан, Жанчивдорж дарханы ихэр хөвүүд Чилэгэр, Чилэдү хоёр, саахалтын Лавдандаш тайжийн Сандуйжав гээд үеийн хүүхдүүдийн хэн нь ч хэзээ ч Галдан шиг тийнхүү сэтгэл догдлуулах буюу хүсэмжлэн санахад хүргэдэггүй билээ.

Тэр зун Галдмаа баатрын хатан нярайлж охин төрүүлэв. Очирт цэцэн ханыхаас өртөө хол зайтай Сэрүүн дэнжид зусч байсан Галдмаагийн хатан Жамьянмядаг төрөхийн халуунтай байсан тул лам багш нь хар цагаан хэл ам, ад зэтгэрийн хорлолоос сэргийлэх ном айлдаад угаалгын найр ойрын үед хийхийг хорьжээ.

Тэгсээр намрын эхэн сард бэрийн бие илаар болсны хойно Доржравдан хатан ач охиноо үзээр Анугаа дагуулан нэг тэмээн ачаа дүүрэн бэлэг сэлт ганзгалаатай хүүгийнхээрээ айлчлав. Хачирхалтай нь хатан ахайтны сүүдэр шиг хаа явс ан газар нь дагалдан явдаг, энэ өргөөнд ирснээс хойшхи арван дөрвөн жилд ганц ч удаа өвчин зовлон тоочиж үзээгүй, хахир хатуу ахайтны заавраар хоёр шөнө цурамхийлгүй өргөөний тоос шороог цэвэрлээд ч цагаан сарын шинийн нэгний өглөө жижигхэн нүдээ тормолзуудан ядарсан шинжгүй гүйж явдаг Үзмээ бүсгүй энэ удаа Галдмаагийнх руу очиж чадсангүй. Гэнэт халууран хэвтжээ.

Сүүлийн үед сэм сэмхэн огиж, толгой нь дүйрээд байх болсныг нь хашир толгой Жангараг ажсан ч арай тиймдээ хүртэл доройтно гэж сэхээрээгүй биз.

Харин Ану л Үзмээгийн өвчний шалтгаан Галдмаа ахтай нь холбоотойг таамаглаж байлаа.

“Сэнжит хадны тэнд үдэш сар гарахад хүрээд ирээрэй...” гэж Галдмааг хэлэхэд Үзмээгийн

нүд хэрхэн баяр хөөрөөр гэрэлтэн гийж, тэр өдөржингөө очтон гялалзаж байсныг охин санаж байлуга.

Тэгээд хоёр хоногийн дараа Галдмааг явсны хойно ээмгээ далд хийж, хуучин одтой цэнхэр лавшигаа өмсөөд сав л хийвэл зүүн зүгт гөлрөн зогсдог, домбонд цай юүлж байгаад давуулж асгаад ахайтанд “Мэлрээ,гөлрөө өвчтэй болоо юу энэ чинь?” хэмээн зандчуулах болоод буй билээ.

Өглөө эрт нар битүү байхад хөтөлгөө морьдтой, тэмээн ачаатай гарсан хатан дагуул, бараа болоочдын хамт их үд өнгөрсөн хойно Галдмаа хүүгийн дээ ирэв.

Очирт цэцэн ханы овгийн сүлд бүхий туг хиур хийсгэсэн арваад хэвгүүл цэрэг, тэмээн ачаа, хөтөч, гоцго хиа дагуулсан хорь гаруй морьтны барааг харсан Галдмаагийн цэргийн толгойн харуулын хуяг дуулгатай хүдэр чийраг аравт цэрэг саахалт илүү холоос хатан ахайтныг хүндэтгэн тосч авлаа.

-Хатан ахайтан та амгалан морилж явна уу? хэмээн аравтын дарга, түрүү жил санаа буруулагч Аблай тайжийг номхотгоход онц гарамгай байлдан нөөцний агтыг нь хөөж авчран явгалсан гэж дуулдсан Хөхөчү гэдэг, төдий өндөр биш ч шагай тэгш биетэй, зүүн шанаандаа сумны сорвитой идэр чийраг цэрэг эр оройдоо улаан цацагт дуулгыг баруун гартаа авч жолоо атгасан зүүн гартаа хүртэл тэргүүн мэхийн хатанд хүндэтгэл үзүүллээ.

Араас нь дагалдан зэр зэвсэг, ган дөрөө харшилдуулан яваа баг цэрэг ч дөхөн ирээд нэгэн зэрэг дуулгаа тайлан мэхийж эзэн ахайтны амгаланг эрэх нь нэн сүрлэг аж.

-Амар сайн явж ирлээ.Танай энүүгээр амгалан сайхан, нярай үр, эхийн бие лагшин тунгалаг биз дээ? хэмээн Доржравдан хэлэхдээ ойрд морь унаж хол яваагүй танхи ямбалаг бие агсадсан ч эрхэмсэг дүр үзүүлэн инээмсэглэл тодруулав.

-Тайван амгалан байцгаана.Эх үрсийн биес сайн байгаа гэж Хөхөчү хүнгэнүүлэн өчлөө.

Энэ идэр дайчин санаа буруут Далай тайшийн “тэжээсэн бяруу” Жархай харваачийн сумны урдуур орон байж голын хайрт Галдмаа хүүг нь аварсан тухай сонссоноо санаад зүүн гарын ядам хуруунаасаа төгсгөлгүй үргэлжлэх түмэн наст хээ сийлсэн шижир алтан бэлзгээ сугалан сарвайж:

-Эзэндээ үнэнч, Ойрад зонхоо төлөө урсах цусаа хайрлалгүй зүтгэж яваарай,хүү минь! гээд согоо чихт жороо шарга морио давирав.

Өтгөн хөмсөг, товгор шанаатай цэрэг эрийн хүдэр царайд баяр хөөр, даруу зангийн ичингүйрэл нэгэн зэрэг тодорч, эзэн ахайтны өгөөмөр хишгийг хоёр гардан аваад духандаа хүргэн адис авч:

-Эзэн хатантны хишигт мөргөө! гэж сүрлэгээр өчив.

Ирүүл, угтуул гучаад морьтныг галдмаа баатар гэрийн урьдхи тахилгат овоо индрийн дэргэд

угтан, эхийгээ сугадан буулгаж, Ану охин дүүгээ морин дээрээс нь сэвхийтэл өргөн авч үнсэв.

Тэднийг овоо индэртээ сүслэн нар зөв гурав тойрч, хишиг мандал өргөөд Галдмаагийн өргөөнд иртэл цагаан үенгийн арьсан чимэгт найман ханат их өргөөний нь зүүн захад улаан халзтай шинэ гэр бариастай халх янзын хувцастай, гозгор бор бүсгүй хулгасхийн гарч ирээд Доржравдан ахайтанд мэхийн халх аялгаар мэнд мэдсэн нь Ануд их л харь, хазгай дуулджээ.

-Амар сайн уу,сэвгэр минь! гэж хатан алсын уул ширтэн тэр залуу эмтэй тоомжиргүй мэндлээд :

-Өндөр ижий,өндөр ижий! гэлцэн уралдан гүйлдсээр ирсэн хоёртой, гуравгай Ринчен, Дэнзэн хэмээх цовоо цолгин хоёр ач хүүгээ үнэрлэн чихэр жимс атгаар нь өгөөд их өргөөнд орлоо.

Нярайлаад хоёр сар болж буй бэр Жамьянмядаг зулай боосон цагаан дурдан алчуур дээрээсээ ёслолын хилэн малгай духдуулан хадам эхдээ хүндлэл үзүүлээд:

-Ээж та амгалан сайн морилж ирэв үү?Морь унаж биеэ агсдуулаад яах нь вэ? хэмээн тал засав.

Гурван ачийг нь төрүүлсэн Хойдын Сүлдэн тайжийн дүү угсаа гарал сайт, төлөв даруухан энэ бэрдээ Доржравдан хатан муу байхын ч аргагүй.

-Зүгээр охин минь.Яажшуухан хоёр яс салав даа?Төрөхийн халуун гэмтэй.Алив тэр өөдөсхөн охиныг үзье хэмээгээд бэрийнхээ духан дээр хошуу хүргэнгүүт нярай охины унтаж буй зүүн ороод зүтгэв.

Цагаан үенгийн арьсаар хөшиг цавгийг бүрж, унь ханыг битүү сийлбэрлэсэн Галдмаагийн энэ өргөө дөнгөж нярайлсан эхийн цонхигор царай, цагаан хурганы арьсанд манцуйлсан нярай охин, алхан хээгээр хөвөөлөн чимсэн шинэ ширмэл ширдэг ч цагаан.Аргагүй л залуу идэрхэн хосынх гэмээр сүүн цагаан өнгө зонхилсон үзэмжтэй сайхан айл байлаа.

-Алив, хумсын чинээхэн хүүхнийг өндөр ижий нь үнэрлэе гэхдээ Доржравдан өөрийгөө “эмгээ нь” гэж хэлж түвдэхгүй л байлаа. Тиймээс ч аль залууд нь Цэвээн хатны ач нарын өөрт нь өгсөн өндөр ижий гэсэн нэрийг Ринчен,Дэнзэн хоёрт хэлүүлж сургаад эмээ гэж дуудуулахаас өөрийгөө аварсан ажээ.

Ямагт залуу бүсгүй мэт сэмбэгнэн, бэлхүүс нь хэчнээн махлаад ч дөч хол гарсан гэмээргүй царай зүс, бие галбир, гоо үзэмжээ алдаагүй яваа эхээ хайрласан Галдмаа ч хоёр хүүдээ “өндөр ижий” гэж бай хэмээн сургажээ.

Цав цагаан хурган манцуй дотроос нэг их даахьтай хар толгой, алгын чинээ улаан нүүр л цухуйх аж.

Хоёрхон сартай нярай хүүхэд ийм ойроос огт үзээгүй Ануг жаахан бишүүрхэсхийн орноос



холхон зогсч байтал бэргэн нь дуудаж:

-Ану, дүү минь наашаа ойртож нялх дүүгээ үз дээ.Их хөөрхөн тоглоом шиг амьтан байна. хараач гээд охиноо авч Ану руу ойртуулав.

Юм бүхнийг цэвэрхэн байна уу, бохир заваан байна уу хэмээн сэжиглэн цээрлэж, Үзмээ, Жангараг хоёроор суух олбог, хивс ширдэгээ өдөрт хэд цэвэрлүүлж, цайны аягаа үнсээр зүлгүүлэн, гараа өдрийн хэд булхан угааж, гүнжидийн тос түрхэн, бурхан тахил, толь шүүгээгээ цагаан бөсөөр арчин цэмцэгнэж суудаг Доржравдан ахайтан өнөөдөр хайрт хүүгийн дээ айлчлан ирээд хайлсан шар тос шиг л сайхан аашлан, тэдний аягачин, шивэгчин, хиа зарц нарт толгой дараалан хишиг түгээж, бэрдээ үнэт усан биндэрьяа шигтгэсэн бэлзэг, бугуйвч, олон толгой хоргой, алтан хатгамалтай үнэт торго бэлэглээд бяцхан танан хайрцаг гарган тэнгэрийн өнгөт индранил шигтгээт хос алтан бэлзэг гарган нэгийг нь Ануд зүүж, нөгөөг нь хайрцагт эгүүлэн хийж бэрдээ өгөөд нярайг өвөр дээрээ авч үнэрлэсэнээ:

-Энэ бэлзгийг зориуд амтай хийлгэсэн юм.Охиноо арван нас хүрэхээр нь зүүлгээрэй.Индранил эзэндээ ээлтэй чулуу. Хүүхэд нүдээ нээлээ.Эхийнхээ том алаг нүдийг хуулчихаж. Тамшаалаад хамраа зангидаж байгаа нь яг Галдмаагийн багынх шиг. Ану дүүгээ үнэрлэ дээ.Нялх хүүхдийн үнэр хэчнээн хөөрхөн гээч хэмээн ярьж суулаа.

Ану ингэж ач охин дүүтэйгээ яг ижилхэн бэлзэгтэй боллоо.

Уйлах, ярвайхад нь хөгшин хүнийх шиг үрчийх улаан нүүр, амандаа ганц ч шүдгүй улаан буйл, дээшээ дэндүү шовгор жижигхэн толгой, өрвөлөг шиг босоо хэдхэн үс гээд нярай хүүхэд Ануд ердөө ч өхөөрдөм хөөрхөн биш,харин ч үзлийн царай муутай санагдсан тул томчуудын ярианд үл оролцон чимээгүй сууж байлаа.

Бэргэн эгч нь охиноо задлан манцуй доторхи живхийг нь солиход тэр хүүхдийн гарынх нь хуруунууд хариугүй нарийхан эгээ л өт шиг харагдсан бөгөөд зун Түргэний горхины эргээр жаалуудтай зүггүйтэн гүйж яваад барьсан мэлхийнх шиг сарьсан нимгэн арьстай харагдахад ердөө ч хайр хүрсэнгүй. Бушуухан шиг харьж “Оюунтүлхүүр”-ээ хуулан бичье байз.Судраа сайн хуулаад байвал багш Ойрадын түүх, тэгээд монгол хатдын түүх намтраас хүүрнэн ярьж өгнө гэсэн хэмээн бодож хүйтэн чигээ залгилж суулаа.

Галдмаа ах нь охиндоо Ахай нэр өгчээ. Нэр нь ч хэлэхэд хөөрхөн л нэр юм.Харахад даанчиг хөөрхөн биш,хөгшин хүн шиг амьтан юм хэмээн охин бодож суутал нярай охины ах нар дэггүй хоёр хүү түлхэлцсээр гүйж ирээд Анугийн ташаандаа зүүсэн жижигхэн сэлмээр нь оролдож эхлэв.

-Ану маань охин хүүхэд атал сэлэм агсч явдаг юм уудаа? гэж хүүхдээ хөхүүлж суусан бэргэн эгч нь асуулаа.

-Тэгдэг юм аа.Эр хүний үйлийг эрхэмлэдэг хүүхэн байгаа юм гэж ижий нь хэлэхэд Ану:

-Хэрэг гарахад бүсгүй хүн өөрийгөө хамгаалж чаддаг байвал сайн гэж аав хэлсэн.Би сэлэм, нум суманд дуртай хэмээн духайн хэлээд энэ эмс, эхнэрүүдтэй юугаа ярихав гэсэн шинжтэй

гараад явчихлаа.

Царцаа цар цар дуугаран дээр дээр нисч, алсын ууланд манан будан хөшиглөөд намар ахайтан хаяанд иржээ.

Зүүнтээх гэрээс нөгөө үл таних бүсгүй гарч их өргөө рүү саравчлан зогссоноо Ануг харчаад тарвага дошин дээрээсээ нүхэндээ бултгасхийн орох адил гэрээдээ орчихов.

Хоолон гэрээс энэ өргөөний зам идэрхэн эр гурилаар бүрхэн чанасан хонины хуйхалсан өвчүү, тагалцаг их царан дээр овоолон тавиад ирж айсуу.

Галдмаа ах нь өргөөнөөсөө гарч ирээд Ануг харснаа түрүүн ирэхэд нь үнссэн атал дахин духан дээр нь үнэрлээд:

-Үзмээ яагаад ирсэнгүй вэ? гэж гэнэт асуув.

Уг нь Ану тэр хоёрын нууцыг гэр өргөөнийхөн дотроос хамгийн түрүүнд гадарлачихаад энэ тухай хэн ч мэдэх ёсгүй, тэр тусмаа хүүхэд мэдэх хориотой, ёс бус зүйл олж сонссондоо шаналж, нөгөө талаар урьд нь дэндүү зальжин, хуурмаг зантай гээд муу байдаг асан Үзмээг өнөөдөр яагаад ч юм нэг л өрөвдөн элэг нь эмтрэн, чаддаг сан бол түүнийг өмгөөлөн ивээлдээ авмаар санагдан яах учраа олохгүй явтал ах нь түүний тухай, тэгээд бүүр яагаад ирээгүй юм бэ? хэмээн охиноос асуудаг байна шүү!

-Үзмээ юу? Үзмээ шивэгчин өвчтэй байгаа гээд ахынхаа нүүр өөд та юунд ингэж асууна вэ? хэмээн зэмлэх мэт харцаар харав.

-Яасан юм бол?

-Мэдэхгүй ээ. Халуураад хэвтчихсэн. Сүүлийн үед дандаа л санаа алдаж, гөлөрч байдаг, домботой цай халиагаад ижийд загнуулдаг болсон гэчихээд охин нэг л мэдэхэд юунд ч юм уур нь хүрч өргөө рүү гүйн орлоо.

Тэгээд өөрт нь зориулан мангираар амтлан чанасан үнхэлцэг идэж суухдаа “Жамьянмядаг эгч юугаараа Үзмээгээс дээр болоод Галдмаа ахтай хуримласан юм бол? Үзмээ чинь энүүнээс хавьгүй хөөрхөн, бас ажилсаг хүн. Гэтэл ижийд загнуулж, Галдмаа ахыг санаад сэмхэн уйлж суудаг.” Аа мэдлээ. Үзмээ бол өнчин, ядуу, зарц. Харин Жамьянмядаг эгч Сүлдэн тайжийн дүү шүү дээ.” хэмээн урьд төдийлөн анзаарч ухан бодож яваагүй ядуу, баяны тухай, хүмүүний угсаа, гарвалын тухай гүн бодолд автчихсан байлаа.

Тэднийг Галдмаагийн хоноглоод маргааш нь эртээ босч гэрийн зүг хөдлөхөд Галдмаа ах нь Үзмээгийн төлөө зовсон ч юм шиг, битүүхэн гунигтай харагдсан агаад Ануг моринд нь мордуулж, олмыг нь чангалж өгөхдөө:

-Миний дүү номоо сайн үздэг юм шүү хэмээн захиад хааяа аав нь өхөөрдөхдөө тэгдэг шиг зүүн нүдээ ирмэснээ духан дээр нь үнсээд:

-Нялх дүү нь хөөрхөн байгаа биз? гэлээ. Ахыгаа харах бүрд, уйлж, унжин, гөлрөнгө болж,

урьдынхаа цовоо сэргэлэн, зальжин занг бүрмөсөн гээчихсэн Үзмээг санан өрөвдөөд байх болсон Ану асуултанд нь юу хэлэхээ мэдэхгүй духайн, шийр цагаан мориныхоо согоон чихээ солбиулахыг харан байснаа, сумлаж зассан дэлийг нь илснээ:

-Том болоод л бүр хөөрхөн болох байх даа гээд урагш давирав.

Үнэндээ өрвийсөн тас хар даахьтай, үрчгэр улаан нүүртэй тэр нярай охин түүнд нэг л эмзэгхэн, өрөвдмөөр, том хүн болно, хөлд ороод гүйнэ гэхэд хэцүү, битүүхэн айдас түгшүүр төрүүлснээс цаашгүй байжээ.

Доржравдан хатны хувьд шинэ мэндэлсэн ач охиноо үзэх далимаар хүүдээ Сэнгэ хунтайжийн Орос руу и лгээх элч төлөөлөгчдийн багт орж, Ижил хавиар нутаглаж буй нагацынхантайгаа уулзан эхийнхээ төрхөмөөр айлчлахыг зөвлөх, халхаас нэгэн бүсгүйг татвар эм болгон авчирсан тухай сонсоод тэр хүүхнийг яагаад ч бага хатны сууринд өргөмжлөхгүй байх нь зүйг ятган ухуулах давхар санаатай иржээ.

Ойрад даяар цуутай баатар, эхийн цайвар царай, тэгш шулуун хамар, эцгийн өтгөн хөмсөг, нагац талынхны гуалиг өндөр нурууг өвлөн төрсөн энэ сайхан эрд арай л тэнцүүргүй харагддаг, царай зүс гойдын үзэмж төгс бус Жамьянмядаг ёстой л эзэн Чингисийн Бөрт үжин хатны айлдсанаар :

Эрэг мөрөнд

Хун галуу олон гэнэм

Эрхийгээ чилтэл намнахаа

Эзэн минь мэднэм зэ

Энэ их улсад

Эмс охид олон гэнэм

Эрж авахаа

Эзэн минь өөрөө мэдэм зэ

Хулст нууранд

Хун галуу олон гэнэм

Хуруугаа чинэтэл намнахаа

Эзэн минь мэдэм зэ гэмээр боловч эр хүн эмс хатад хэдийг, хэзээ, хаанаас авахаа бодож тунгаах нь хожмын амьдрал, үрс хойчийн хувь тавиланд өгүүлшгүй чухаг явдал болохыг анхааруулахыг зорьжээ.

-Хүү минь, Өэлүн эхийн хэлснээр “Мухлаг тутамд охид бий.Тэрэг тутамд хатад буй.Бурханы оронд одсон Баатар хунтайжийн зургаан өөр хатнаас мэндэлсэн арван нэгэн хүү эцгийн өв хөрөнгө, хунтайжийн орыг эзлэх гэж хэрхэн гэдсэндээ хөлөө жийлцэж буйгаас сургамж авагтун.Хатан буулгахдаа бодолтой байгаарай хэмээн сургамжлаад:

-Энэ татвар эм нэртэй халх хүүхнийг хатан суулгаж болохгүй. Уг сурвалжийг нь хөөвөл Засагт ханы хохь тайж Дарамбалын бутач охин юм байна. Эхийн талаас ухаан самуурдаг удамтай гэнэ лээ.Чи бол хан хүний удам залгах хүү. Дүү чинь чамайг бодохноо сул зантай номын хүн. Сэнгэ хааны бичиг эрдмийн ажилд алба өргөсөөр яваад дуусна. Гартангомбо сул биетэй, Эрдэнэ ухаан мулгуу мөхөс хүн.Аз болоход эцэг чинь төдийлөн эмс хүүхэнд хөл алдаад явдаг хүн биш тулдаа чамтай арсалдаад байх олон ахан дүүс алга буйд хөх тэнгэрт залбирч яв.

Шонхор шувуу хэзээ ч болжмортой нөхөрлөдөггүй.Хошуудын хамгийн нөлөө ихтэй ноён, дөрвөн Ойрадын чуулганы “хан” хүний угсаа залгамжлах хүү хэзээ ч эмсийн өнгөнд хууртаж, харц доодостой хутгалдан, цусаа бохирлож үл болно гэж эрс хатуухан хэлээд морджээ.

Галдмаа эхийнхээ шивэгчин Үзмээд хар багаасаа сэтгэл татагддагаа хэлж, ядахад татвар эм болгон авчирч өргөөнийхөө дэргэд байлгахыг гуйх гэснээ эхийн энэ ширүүн үгсийг сонсоод зүрх алдан больчихов.

Доржравдан буцах замдаа Үзмээгээ Галдмаагийн цэргийн толгойн харуулын аравтын дарга мөнөөх сорвит Хөхөчүд ураглахаар хатуу шийдэвэй.Үзмээ,Галдмаа хоёр багаасаа бие биедээ талтай, Галдмаа аян замд яваад ирэхэд Үзмээ гойд их хөл хөнгөрөн царай нь гийдэг байсныг хатантан ажиглалгүй дээ.

Аргын тооллын 1665 он буюу гал могой жил гарлаа. Ану охин тод, уйгаржин монгол үсгээр бичих, найруулахдаа гаргуун чадамгай болж, Халх-Ойрадын түүх сонирхон заалгасаар багшаасаа элдвийг асуух нь нэмэгдсээр байв.

Хошуудын Очирт цэцэн ханы Ану гүнжид ном заахаар анх залагдан ирэхдээ эрх танхи, бяцхан охин хүүхэд юу л сурч гийгүүлээ аж.Тод, монголоор халтар хултар уншиж сурвал гүйцээ хэмээн басамжлангуй бодолтой ирсэн Дүүрэн мэргэн бичээч хантны хаяанд гурван оныг үдэж, адтай, сэргэлэн, юмыг санаанд оромгүй талаас нь ухааж асуун хэрийн хүнийг хэлэх үггүй болгон мад тавьчихаа сийхгүй шавиа ихэд тоож ,маргааш надаас юу асууж хэл ам сугалах бол? хэмээн Рашид Аддин,Саган сэцэний туурвисан түүх шастир, “Монгол-Ойрадын цааз бичиг”,”Ойрад монголын түүх” зэрэг нанхиад, төвд, монгол судрын шарласан хуудсууд эгүүлэн уншиж суух нь улам нэмэгджээ.

-Багш аа,Ойрад,Халх хоёрыг хоёулаа монгол хэлтэн,монгол аймгууд хэмээн Та хэлсэн. Гэтэл юуны учир туурга тусгаар явсаар ирэв? гэж Ану нэгэн өдөр багшаасаа асуулаа.

Шавь нь нэг л өдөр ийнхүү асууна гэдгийг мэдэж байсан Дүүрэн бичээч гэргийнхээ барьсан ёроолдоо мөнгөн хос загастай, зэсээр доторлосон их гарын үндсэн тагштай цайг хоёр гардан авч нэг оочоод тавьж, соёо сахлаа шувтран духаа атируулаад:

-Шавь чиний ухаан их тэлж байгаа нь сайн хэрэг. Энэ болж үргэлжид өчүүхэн бичээч миний сэтгэл чилүүрдэж явдаг зүйл.” Нууц товчоонд” өгүүлдэг Алунгоо эхийн домгийг халхын ихэс дээдэс, Ойрадын ноёд ухаарч Эзэн Чингисийн алтан ургийнханд захирагдан эв найртай явах тавилангаа хүлцэн тэвчиж ирсэн бол өдгөө Монгол улс минь манж зүрчидүүдийг толгой түрүүндээ гаргахгүй л байсан юм.

Одоогоос хоёр зуун далан жилийн өмнө Монголын их хаан сууринд заларч асан Элбэг нигүүлсэнгүй хаан монгол туургатны хүчийг нэгтгэх, ”ойн иргэд” гэгдсэн Ойрадуудыг өөртөө татах бодлого явуулсан ч шунал тачаал, ухвар мөчид бодлын уршгаар эмгэнэлт төгсгөлд хүрсэн гэдэг.

Түүх шастир яриулахдаа нэг хөлөө нугалан баруун өвдөг дээрээ тохойгоо тавьж, шанаа тулан суудаг зантай Ану багшийн ярианд автаж гүйцээд Зэсэнжав эхнэрийн аягалж тавьсан цайнаас ганц ч балгасангүй.

-Шавь минь цайгаа уу. За тэгээд Элбэг Ойрадын цуутай ноён Өрлөг хошуучийн хүү Хутхай таюуг талдаа татан баруун гарын түшмэл болгожээ. Нэгэн өдөр Элбэг хаан албат дагуулуудаа аван ан авд явж бүхийд шархадсан туулайн цус шинэхэн цасан дээр дуссаныг үзээд “Үүний адил цас мэт цагаан царайтай, цус мэт улаан уруултай гоо үзэсгэлэн төгс эхнэр байдаг болов уу?” хэмээн түшмэлүүдээсээ асуув гэнэ.

Тэгэхэд нь Хутхай таюу “Хаан таны дүү Хархуцаг Дүүрэн тайжийн гэргий Өлзийт гуа бэйжийгийн өнгө зүс нь таны хүссэнээс хэдэн хувь үлэмж төгс гоо билээ” хэмээж гэнэ. Элбэг хаан туйлын их баярлан “Үзээгүйг үзүүлэхийг, үлэмжийн хүсэл хангахыг Хутхай таюу чи мэдтүгэй. Хожим энэ гавьяаг тань мялааж Чинсан өргөмжлөмз” хэмээн айлтгав.

Удалгүй нэгэн өдөр хааны дүү Хархуцаг тайж анд явав. Араар нь Хутхай таюу ордонд нь очин Өлзийт гуа Бэйжийд “Хаан эзэн чиний өнгө үзэсгэлэнт царайг өдөржин, шөнөжин хүснэ” гэсэнд хатан ихэд хилэгнэж, “Хаан тэнгэр, эх газар хоёр нийлж болдог юм уу?” гээд Хутхай таюуг гэрээсээ хөөн гаргажээ. Хутхай таюу болсон явдлыг айлтгахад Элбэг хаан ихэд хилэгнэж, төрсөн дүү Хархуцаг тайжаа замд нь тосч алаад Өлзийт гуа Бэйжийг богтлон хатнаа болгов гэнэ. Өнгө үзэсгэлэн, оюун ухаан тэгш хосолсон Өлзийт гуа хатан эр нөхрийнхөө өшөөг шуналт хаан, долдой түшмэл хоёроос авахаар шийдэв.

Нэгэн өдөр Элбэг хаан анд явжээ. Хутхай таюу Чинсан хэргэмээ горьдон нэхэж, хааны зам тосон сууж буйг Өлзийт гуа мэдээд Догшин шар гэдэг хүнийг Таюу руу явуулж “Чи хээр сууж хааныг хүлээхээр ордонд ортугай” хэмээн хэлүүлэв. Хутхай таюу дуртай нь аргагүй очжээ. Өлзийт гуа хатан мөнгөн аяганд архи хийж “Бага биеийг минь их болгов. Бэйжий намайг хатан болгов” хэмээгээд барив. Дараа нь “таны энэ их ачийг би мартаггүй. Нэн их хайр хүртээхийг хаан эзэн мэдтүгэй” гэж дахин дахин уулгасаар Хутхай таюуг согтоогоод зарц нараа дуудан хааны исэр оронд оруулан хэвтүүлэв. Ингээд өөрийнхөө нүүрийг самардан шалбалж, үс гэзгээ сэгсийлгэн уйлж суув. Тэр зуур хаанд яаралтай элч илгээн дуудаж авчрахад, хаан “Хатан чи юунд уйлав” хэмээв. Бэйжий хатан “Хутхай таюу согтож намайг чангаасанд би эс зөвшөөрөв” гэлээ. Хэрэг бишдэхийг ухаарсан Хутхай таюу гарч зугтав. Хаан араас нь нэхэн хөөхөд Хутхай таюу хааны эрхий хурууг тас харважээ.

Шадар цэргүүд Хутхай таюг барьж алаад нурууны арьсыг нь хуулан хаанд авчрав. Бэйжий хатан босч хааны цусыг Таюгийн арьсны тос лугаа хольж хэлсэн нь “Хар санаат хааны цусыг толиогоод хатган өгүүлсэн Хутхайгийн тосыг уугуужу. Эм хүмүүн би эрийнхээ өшөөг авлаа. Эдүгээ үхэвч надад гомдол үгүй” гэж зориглон хэлсэн гэдэг.

Элбэг хаан Бэйжий хатанд хууртагдсанаа мэдээд ихэд гэмшин Хутхай таюгийн хүү Батулад “Эцгийг чинь хилсээр хороов. Одоо чамайг Чинсан өргөмжлөө. Чи Ойрадын эзэн Үгч хашха лугаа хамтаар дөрвөн Ойрадыг захиртугай” гэлээ. Мөн Элбэг хаан Эсий хатнаасаа төрсөн Самар нэрт гүнжээ Батула чинсанд хатан болгон өгч худ ураг бололцов.

Энэ домгоос хаадын ёсгүй явдлаас үүдсэн цуст хилсдүүлэлт, өшөө хорсол, монгол эмэгтэйн эр нөхөртөө үнэнч чанар, халх, Ойрадын холбоо, Батула чинсан хэрхэн манай Ойрадын холбооны тэргүүн болсон зэрэг түүхэн явдлуудыг ухан ойлгож аваарай шавь минь хэмээн Дүүрэн мэргэн бичээч хэлээд цайнд норсон урт соёо сахлаа шувтран арчив.

Тэр жил Сэнгэ хаан их Оросын нийслэл Санкт Петербург хотод анхны элчээ зарж, бурханы оронд одсон эцэг Баатар хунтайжийн үед үүсгэсэн найрамдалт харилцааг хэвээр үргэлжлүүлж буйгаа илэрхийлэн нотловой. Дөрвөн Ойрадын чуулганы ханы хувьд Оросын их хаанд бараалхах элч нарын тэргүүнээр Очирт цэцэн хан одох нь зүй байсан ч энэ жил нас сүүдэр жаран гурав хүрч, бие лагшин алс холын аяныг даахад бэрх хэмээн татгалзан өөрийнхөө оронд хүү Галдмаагаа илгээхээр болжээ.

Хэдийгээр Галдмаа баатар нас ид гуч шүүрч Ойрадын дотоодын эв нэгдлийг хангах, эцэг, авга Аблай тайш, болон Сэнгэ нартай үг хэлээ ололцож чаддагаараа ч, олон удаагийн дайнд гарамгай гавьяа байгуулснаараа ч төлөөлөгчдийг ахалж болох байсан авч, цорос аймгийн хамгийн ахмад, нэр нөлөө ихтэй Цөхүр увшийг Орос улсад одох элчин төлөөлөгчдийн тэргүүнээр томилохоор Сэнгэ хунтайж шийдсэн билээ.

Галдмаа баатар Орос улсад одохын өмнө эцгийн ордонд ирж, дөрвөн Ойрадын чуулганы ханы хувьд аавынхаа үг сургаалийг нь сонсож, эхтэйгээ уулзан Ижилийн тэртээд суугаа төрхөмөө өгчилгөх бэлэг сэлт, бичиг захидлыг нь авлаа.

Хаврын дунд сар гарч гадаа жихүүн салхи үлээн, зулсан ноос мэт цагаан үүлс хөвсөн хөх тэнгэр улам ч өндөрсөн мэт. Хаврын урь орсон нь үстэй дээл хүндрүүлэн, шилжрэн одсон өвөл өвгөний алсаас үлээх жавар хэдийнээ хацар тас ороолгох хүчин суларснаас илхэн.

Өргөөний зүг газар бөмбөрдөх олон морьдын төвөргөөнөөр Очирт цэцэн ханы зарц барлагууд гийчдийг тосон хөл болцгоов.

Ану охины багш Дүүрэн мэргэн гэргийгээ дагуулан Эмилийн тийш ах дүүстээ золгоор одсон тул охин “Эр хоёр загалын тууж”, “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шастир” зэргийг тод бичгээр хуулан, завсар чөлөөгөөр нь Мандарваа найздаа тод үсгийн цагаан толгой заасан шигээ хаврын урт өдрийг барж байлаа.

Галдмаа ах нь Сэнгэ хааны элчдийн нэг болж алсад мордохын өмнө ирнэ гэдгийг нь мэдэж байсан болохоор саахалтын зайд хаваржиж буй Бундирынх руу явалгүй өргөөндөө номоо үзэж

суусан Ану олон морьтны туурайн төвөргөөн , Асар, Басар, Нянгар, Цагаадай гээд тэдний өргөөг манадаг дааган чинээ нохдын хуцалдах дуунаар хар үнэгэн малгайгаа өмсөөд гэрээс гүйн гарлаа. Охин эхийнхээ нүүрний нарийхан, өндөрдүү шулуун хамар, нүдний нууц давхраа, эцгийн зузаавтар уруул, өтгөн атал нарийхан хөмсгийг дууриаж, царай төрх нь нилээд хүүхэн шинж оржээ. Нууцхан давхраатай, төдий л том биш эхийнх шигээ оч хаялсан цоглог нүднийх нь урт сормуус өвөл цантаад, мөнгөн сортой хар үнэгэн малгайн дороос хараад баймаар хөөрхөн үзэгдэнэ.

Өргөөнд ирж буй зочдын чимээнээр Мандарваа бас Анугийн хойноос гарч ирэв.

-Чи ацаг шүдний зайг хэт ойртуулж, нөгөө бол хэтийдүүлээд муухай бичээд байгаан байж юун илүү хоншоортой хүн бэ? Орж бичгээ бич гэж Ану зандраад ах руугаа гүйлээ.

Мандарваа охиныг Ану гүнжийн шадар шивэгчин болгохоор эцэг эх нь нэгэнт шийдчихсэн тул бичиг үсэг, мэндлэх хүндлэх, идээ зоог барих ёс зэрэг дээдсийн бүхий л дэг горимд аажмаар сургаж эхэлсний дотор, ирээдүйн эзэн ахайтан нь өөрөө тод үсгийн цагаан толгой зааж буй ажээ.

Өндөр дэнхэр нуруу, тогорууных шиг урт хөлтэй тул дээлээ дээгүүр бүсэлчихээрээ дэглий шувуу мэт харагддаг Мандарваа охин дургүйхэн буцаж өргөөнд оров.

Очирт цэцэн хан нас биед хүрэх дөхөж яваа хэнз отгон охиноо эрх дураараа байг гэсэндээ бичгийн гэр нэрээр зургаан ханат өргөө гэр барьж өгснөөр Ану перс газрын эрээн хивс солонгорсон шинэ гэртээ Мандарваагийн хамт голдуу суух болжээ.

Галдмаа баатар битүү цан хүүрэг болсон орос адууны эрлийз өндөр, жороо, хар хээр мориноосоо буун хөтөч Бартан гэх майга бахим хөлтэй, үрчгэр духтай, насыг нь чухам хэд гэдгийг оноож хэлэхэд хэцүү, идэрхэн эрд өгөөд өөдөөс нь тосон гүйж очсон охин дүүгийнхээ духан дээр үнсээд:

-Ижийн бие сайн уу? гэснээ өргөөний тэртээ захад байх зарц шивэгчин, аягачингуудын гэрүүд рүү зэрвэс хараад өргөөний зүг шийдмэг алхлаа.

Тэртээ гурван жилийн өмнө хөөрхий Үзмээ бүсгүй Галдмаагийн үрийг хэвлийдээ тээж, ордны зарц, шивэгчин хүүхнүүд албан ёсоор татвар эм нэр зүүгээгүй л бол эзэд, агь нартай энгэр зөрүүлэхийг тас цаазлан хорьсон хатуу журмыг эрслэн зөрчсөн билээ. Тэгээд ч зогссонгүй. Доржравдан ахайтан нэгэнт тэр бүсгүйг уруу татсан буруутан нь өөрийнх нь голоос хайртай Галдмаа хүү нь байсны учир шивэгчин бүсгүйг ёс алдлаа гэж хатуу цээрлүүлэхийн оронд, “Үр зулбуулах нанхиад эм уулгаж, тэр аранганаас нь салгаад нууцыг чандлан хадгалахыг тушааж, тэнхэрсэн хойно нь хэр тааруу түшмэл, гоцго, аль эсвэл зуутын даргатай ёслон хадамд гаргая” хэмээн харин ч өр зөөлөн зан гаргаж билээ.

Энэ өргөөнд ирснээс хойшхи арван дөрвөн жилийн турш эзэн ахайтны үг зарлигаас ганц ч зөрж байгаагүй, хүн хүний ааш аягийн аясаар бөмбөрч, хөмсөг гэдгийг зангидаж, нүд гэдгийг хялайж үзээгүй болбуу гэмээр байдаг Үзмээ гэтэл, ахайтны зарлигийг тас зөрж, сэтгэл зүрхний хайртай хүнээсээ олсон эрдэнэ мэт энэ үрээ үгүй хийснээс өөрөө амиа тэвчсэн нь

дээр хэмээсэн нь Доржравдан хатны төмөр мэт хатуу сэтгэлийг ч хайлгаж билээ. Хорвоо хатуудаа хатуу зан гаргадаг болохоор “Үзмээ далдуур хүнтэй нөхцөн хүүхэд хормойлж ахайтныг хилэгнүүлж гэнэ” гэсэн явган яриа өргөөгөөр тэнүүчилж байтал дөрвөн сартайдаа ураг зулбан, цус алдсан бүсгүй арай л гэж амь голтой үлдсэн билээ. Түүнээс хойш нүднийх нь гал цог унтарч, турж эцээд, намрын хагдарсан цэцэг мэт болсон бүсгүйн урьдын гоо үзэсгэлэн нь дахин сэргэсэнгүй, нандин ариун нэрээ ч эгнэгт хугалсан тул түүнийг хадамд гаргах ахайтны бодол найдлагагүй болж, хүүхэн ганц бие зарц шивэгчдийн дунд “хормой султай, өвөр хоосон хүүхэн” нэртэй үүрд хүний гэргий, хүүхдийн эх болох горьдлогогүй хоцорсон билээ.

Галдмаа Орос газар явсан аян замын сонин хачнаа эцэг, эхтэйгээ хуваалцан, эцэгтээ галт буу, эхдээ зүүсгэл чимгээ хадгалах ногоолин эрдэнийн хайрцаг, эгшигт хайрцаг хэмээх хөгжим дуу аялдаг шидтэй эд, дүү Анудаа бичгийн хуван хэрэглэл, гарын толь гарган бэлэглэж, эхийн талын ойрын төрөл Ижилийн торгуудын хан Пунцаг тайжийн захидлыг гардуулав. Зам хөгшин Галдмааг өргөөний эрх танхи агь байх ахуйд хийж өгдөг байсан таван халуунаар амталсан сайхан хуушуур хийж хүндэтгэв. Эдүгээ өнгө зүс доройтсон Үзмээгийн хажуугаар эхэд нь зарагдах болсон шинэ шивэгчин Уламнэмэх нэрт дөрвөд угсааны жижигхэн цагаан бүсгүй цай аягалан, сархад сөгнөж, борви бохисхийлгүй үйлчилнэ.

-Үзмээг дууд! Хүүгийн авчирсан бэлэг сэлтийг аялуулаг. Бас ач охин, хөвүүдэд өгчилгөх юм зэхэг хэмээн Доржравдан Уламнэмэхэд хэллээ.

Ийнхүү хатаны зарлигийг зөрчин, нэрээ хугалж, зүсээ доройтуулан, хүүгийнх нь удам угсааг харцын цустай холих гэж зөрүүдэлснийх нь хариуд Үзмээг ямагт, хэргээр Галдмааг байхад дуудан, хатан, хүүхдүүдэд нь өгчилгөх бэлэг сэлтийг өөрийнх нь гараар боолгож, зэхүүлэн цээжнээ буцлах уур, өширхлөө тайлах аян шалтаг хайдаг билээ.

-Жаа ахайтаан! гэсээр Үзмээ орж ирлээ. Үс нь шингэрч, угийн гонзгой царай нь турж шөвийснөөс улам ч жижигрэн хатсан жимс мэт хорчийж, нүд нь газар шагайсан ч Галдмаагийн ирсэн чимээнээр навчин хээтэй цэвэрхэн цэнхэр лавшиг өмсчээ. Үүрд сэвгэр хэвээр үлдсэний тэмдэг олон салаа гэзэг нь шингэрч, духанд нь зовлонгийн атираа суусан багын сэтгэлт бүсгүйгээ хараад Галдмаа өр өвдөн, нүд рүү нь эгцлэн ширтэж чадсангүй, нүд буруулав. Хэрэв тэр нэгэн үдэш Галдмаагийн болзоонд Сэнжит хад руу очоогүй л бол энэ бүсгүйн хувь тавилан ийнхүү эмгэнэлтэйгээр эргээ ч үү, үгүй ч үү. Бүсгүй хүн гэдэг эр хүнийг сохроор хайрлан дурлаж, оюун тархиндаа бус, зүрх сэтгэлдээ ямагт захирагддагтаа л богино жолоотон хэмээн адлагдсан юм болов уу? Харцын охин болон төрж, элбэрэлт, эцэг эхээсээ багадаа өнчрөн, хахир хатуу эзэн ахайтны итгэлийг хүлээн, сарьдагт ургасан вансэмбэрүү мэт эрхэмсэг явсан энэ бүсгүйн хөөрхөн царай, гоолиг бие, наалинхай аашинд татагдан хувь тавиланг нь зовлонгийн далай дунд живүүлэн орхисондоо Галдмаагийн сэтгэл энэ орой сэмрэн гуниглаж байвай.



## Наймдугаар бүлэг

Арван дөрөв хүрсэн Ану охинд багш нь өөрийнх нь гуйснаар түүх шастираас түүвэрлэн Мандухай сэцэн болон бусад домогт монгол хатдын түүхийг хүүрнэн ярьж эхлэв.

“Монголын нууц товчоо”-нд өгүүлдэг, хөвгүүдээ багцалсан таван сумаар жишээлэн эв найртай явахыг сургасан Алунгуа хатан бол эдүгээгээс долоон зууны тэртээ амьдарч асан ухаант хатан юм. Алунгуа Хори түмэдийн ноён Хорилардай мэргэний гэргий Баргужин гоогоос Ариг ус хэмээх газар мэндэлсэн гэдэг. Түүний эцэг Хорилардай мэргэн нутаг усныхантайгаа ан гөрөөний газраас болж муудалцан Хорилар овогтон болж, Бурхан Халдуныг гөрөөс, булга ан ав сайтай шимт газар хэмээн Шинчи баян урианхайд нүүн очжээ. Энэ үед Бурхан Халдунд нутаглаж байсан Торголжин баяны хүү Дува сохор, Добу мэргэн хоёр тэдгээр нүүн ирсэн хэсэг айл руу очвоос үзэсгэлэн гоо, эрд гараагүй нэгэн охин байсан нь Алунгуа бөлгөө.

Дува сохор тэр охиныг дүүдээ гуйн авч өгсөнөөр Алунгуа Бүгүнүтэй,Бэлгүнүтэй хэмээх хоёр хөвүүн төрүүлжээ. Хожим нь Добу мэргэн тэнгэр болсны хойно бэлбэсэн хоцорсон гэргий нь Буха хатаги,Бухату Салжи, Бодончар мунхаг хэмээн нэрийдсэн гурван хүү төрүүлсэн гэдэг. Нэгэнт эр нь наснаас нөхцөж бэлбэсэрсэн байтал эх нь гурван хүү төрүүлсэнд хоёр том хүү нь “бидний эх эргүй бөгөөтөл энэ гурван хөвүүнийг хэрхэн төрүүлэв? Гэр дотор Малиг баяуд угсааны ганц зарц байна.Энэ гурав бодвол түүний хүүхэд биз” гэлцэн далдуур хэлэлцжээ.

Үүнийг ухаан төгс Алунгуа мэдээд учрыг хөвүүддээ тайлбарлан ярьж өгөх нь зүй хэмээн шийдэв.Тэгээд сайтар бодож тунгаасны эцэст хаврын нэгэн өдөр таван хүүгээ дуудан авчирч хатаасан борц чанаж өгөөд “Та нар юмны учрыг мэдэхгүй атал юунд дэмий үг хэлэлцэнэ? Үдэш бүр унтаж байхад минь цэгээн шар хүн гэрийн өрхөөр тод гэрэл цацруулсаар орж ирээд миний хэвэл гэдсийг илэхэд гэрэл нь миний хэвлийд шингэнэ.Наран ургах үеэр тэр хүн шар нохой лугаа шарвалзсаар арилна.Үүнээс үзвэл эдгээр гурван хөвүүн лавтай хар толгойт эгэл хүмүүний үрс биш болой.” гэжээ.

Чингээд Алунгуа эх таван сум авчруулж, зэрэгцэн суусан таван хүүдээ тус бүрд нь нэжгээд сум өгч “хугал” хэмээхэд, хөвгүүд нь дорхиноо хугачин хаяцгаав.

Тэгэхэд эх нь таван сумыг баглан боогоод “хугал!” гэсэнд тавуулаа ээлжлэн хүчлээд хугалж дийлсэнгүй тул эх таван хүүдээ” та тавуул бүгд миний хэвлийгээс мэндэлсэн билээ.Та нар хэрэв ганц ганцаараа салан одож, эв найргүй явбал яг саяын дан ганц сум мэт бусдад хялбархан дарагдана.Харин багцалсан таван сум мэт эв нэгтэй байвал хэнд ч үл дийлдэнэ” хэмээн сургасан гэдэг хэмээн Дүүрэн багшийн хүүрнэл Алунгуа эхийн домгоос эхэлсэн ажгу.

-Хэрэвзээ Алунгуа эхийн энэ таван сумны домгийг монгол туургатнууд үүрдийн үүрд ухамсарласан болчиг Монгол их гүрэн задран буурахгүй байх сан даа хэмээн Дүүрэн мэргэн багш нь Ануд хэлээд их санаа алдаж билээ. Эзэн Чингис хааны эх Өэлүн, Чингис богдын өөрийнх нь хатан Бөрт үжин, ухаант Есүйн тухай нэгэнт “Монголын нууц товчоо”-нд өгүүлсэн тул багш шавь хоёр цааш одон, Чингис богдын гүнж нарын тухай хүүрнэлд шилжсэн бөлгөө.

Дүүрэн мэргэн бичээч домогт хатдын түүхийг сонирхон шалгаагч адтай шавийнхаа шахалтаар түүх шастир уйгагүй нэгжсээр Эзэн Чингисийн гүнж Алахи бэхи,Алалтун бэхи, Сэчэйхэн бэхи гурвын тухай жаал зугаа баримт сэлт цуглуулсандаа их л олзуурхан баясчээ.

-“Нууц товчоо”-нд Бөрт хатнаас мэндэлсэн Зүчи,Цагадай, Өгөдэй, Толуй нэрт дөрвөн хөвгүүнийг нь өгүүлээд гурван гүнжийн тухай төдийлөн тодруулалгүй орхисон байдаг билээ. Гэтэл Бөрт үжин хатан эзэндээ Алахи бэхи,Алалтун бэхи,Сэчэйхэн бэхи нэрт гурван гүнж төрүүлж өгсөн гэдэг. Мөн эзний хайртай Хулан хатнаас Хөлүгэ гүнж, Есүй хатнаас Юнибай гүнж мэндэлсэн буюу.

Эзэн Чингис тэдгээр гүнж нарын дотроос Бөрт хатнаас мэндэлсэн отгон Алаха бэхи охиндоо голоос хайртай байсан агаад Онгууд аймагт хадамд гаргасан гэдэг. Аргын 1207 онд Чингис хаан өөрт нь дагаар орсон Онгууд аймгийн эзэн Алахууш тэгиний ахмад хүү Буяншбалд Алаха бэхи гүнжээ өгөхдөө:

Харайхад минь хөл болж

Хазайхад минь түшиг болж

Халамж тус хүргэхээ

Хайрт Алаха минь мэдтүгэй

Энэ бие хэврэг боловч

Эрхэм нэр мөнх шүү

Саруул ухаанаас илүү сайн нэр байдаггүй

Мунхаг ухаанаас илүү муу нэр байдаггүй

Эрхэм итгэлтэн олон боловч

Энэ бие бүхнээс итгэлтэй

Хайрлах зүйл олон гэвчиг

Халуун амиа хамгаас хайрлалтай

Хатуужиж явбал хамагт тустай

Ариун явбаас ашид тустай...” хэмээн сургасан гэнэм.

Удалгүй Онгууд аймагт самуун дэгдэж, эзэн Алахууш тэгин, гүнжийн эр нөхөр Буяншбал эцэг хүү хоёул хорлогдож, Алаха бэхи хадам ах Буюух, түүний садангийн Жинхүү нарын хамт албат иргэдээ авч дутаан одоходоо хаан эцэгт элч илгээжээ. Эзэн Чингис охиныхоо захидлын хариуд их цэрэг хөдөлгөснөөр Алаха бэхи Онгууд аймгийг дахин хурааж Жинхүүд

захируулсан түүхтэй. Ийнхүү Алаха бэхи гүнж бэлбэсрэн хоцорсон ч эртний монголчуудын “асрахуй” ёсны дагуу Онгууд аймгийн шинэ хан Жинхүүгийн хатан болжээ. Гэвчиг аргын 1219 онд эзний их цэрэг Хорезмыг дайлахад Жинхүү хан, Мухулай жанжны хамт Алтан улсыг хураах дайнд мордож насан эцэслэжээ. Эрээ Алтан улсад дайнд мордсон хойно Алах бэхи гүнж Онгууд аймгийг захирч, эцгийн захиасыг үл умартан ухаан чадвараар ихэд тодорсон байдаг. Иймд Чингис богд Хорезм, Персийг дайлахдаа ар талын амар түвшинг батлан хамгаалуулахын тулд охин Алаха бэхи, дүү Отчигин ноён хоёрт уугуул голомт Монголын хэргийг захируулж орхисон тул түүх шастирт “Төр захирагч гүнж” хэмээн алдаршсан ажгу.

Ану охин эзэн Чингисийн Алаха бэхи гүнжийн түүхийг нүд нь гялалзаж бишрэн сонсоно.

Энэ тухай хожим Бээжин хотод очин Мухулай сэцэнтэй уулзсан өмнөд Сүн улсын элчин Мэн Хун “Дэд гүнж Алаха бэхи Онгууд аймгийн Алахаш тэгиний ахмад хөвүүн Бай ши бу \нанхиад дуудлагаар Буяншбалыг хэлж байсан бололтой\ гэгчид ураглан очоод удалгүй бэлбэсэрч өдгөө цагаан татаар Онгууд аймгийн хэргийг мэдэж буй. Тэрбээр өдөр бүр ном судар уншин, эмэгтэйчүүд хэдэн мянган хүнээр сувилуулмой. Аливаа дайн гаргах ба алалдан цавчих явдлыг өөрийн биеэр шийдвэрлэнэ...” хэмээжээ. Үүнээс үзэхэд Чингис хааны гуравдугаар гүнж Алаха бэхи төрийн хэргийг захирах чадвар төгс төдийгүй, бичиг ном, цэргийн эрдэм хосолсон эрхэмсэг гүнж байсан ажээ.

Аргын тооллоор 1225 онд Чингис хаан Хорезм, Персийг идээд нутагтаа эгэн ирэхэд Буюуху Онгуд аймагтаа харьж, Жинхүүгийн хэргэмийг залгамжлан Алаха бэхийг хатан өргөмжлөн суужээ.

Ану багшийнхаа амтат хүүрнэлд авган чагнасаар, өлсч ундаассанаа сая л мэдэж:

-Зэсэн эгч ээ! Зэлгээн цийдэм, шүүрмэг юу байгаагаа өгөөч гэдэс хонхозоод, ам ангах нь гээд өврөөсөө эхийн өгсөн ёроолдоо доржпалам суулгасан мөнгөн аягаа гаргав.

-Үгүй ер, хан хүний гүнж гэх. Амаа ангатал түүх, шастир сонсч суудаг. Эхнээр, надад чигээ аягалаадах хэмээн багш нь доог хийгээд саяхнаас бууралтаж эхэлсэн сахлаа шувтрав.

Анх энэ хүнд шавь ороод шанх, санчиг цал буурал атал сахал, хөмсөгнийх нь тас харыг гайхан суудаг байснаа бодоод Ану охин сэмхэн инээд алдав.

Зуны эхэн сар гарч, Хөх нуурын үржил шимт тал хөндий ногоорч, идээ цагаа дэлгэрч байлаа. Хантан охиныхоо багшид чигээний хэдэн сүү сайтай гүү таслан өгч, өргөөний зарц шивэгчингүүдээс гэрийн ажилд нь хамжилцуулах болсон тул эднийх айраг чигээгээр үл тасарна.

Угаас хот суурин газар чинээлэг худалдаачны гэрт өссөн Зэсэнжав эхнэр сүү саалины ажилд төдгүй атал, хэдийгээр бичиг номын удамтай ч Хойдын малч угсаатай, цагаан идээнд дурладаг эр нөхөр нь шүүрмэг, айргийн тос самарсан цайнд дуртай тул Доржравдан хатны өргөөнд хар бор ажилд зарагддаг Балжир эмгэн эдний гэрийн ажлыг нугалалцах болсон билээ.

Эхлээд зэлгээн цийдмээр ангаагаа тайлж, сүүлд нь айргийн тос, гурилтай самарсан өтгөн сайхан цайнд самнаа боов хөшиглөн идэж гэдэс гарсан багш шавь хоёр Эзэн Чингис хааны гүнж нарын тухай хүүрнэлдээ ороод явчихав.

-Багш аа, тэгээд Алаха бэхи гүнжийн нөгөө эгч дүүс Алалтун бэхи, Сэчэйхэн нарын тухай ярихгүй юм уу?

-Зэ тэгэлгүй дээ. Багш нь энэ тухай чамд хүүрнэн сонирхуулах гэж зэгсэн олон судар ном нухлаа гээд Дүүрэн мэргэн мэлхий ширээний ард суусаар хөшсөн дал мөрөө эхнэрээрээ базуулан хэсэг азнаад яриандаа оров.

-Чингис хаан ууган гүнж Алалтун бэхийгээ уйгурын Идүүд ханд өгөхдөө мөн л билэг сургуулиа айлдсан байдаг. Уйгурын Идүүд хан Чингис хаанд дагаар орохдоо “Эзэн Чингис та соёрхвол алтан бүсний тань горхиноос барьж, ариун дээлийн чинь үртэснээс олж, тувдугаар хөвүүн тань болж хүчээ өгч явья” хэмээн өчсөнөө элч илгээн дамжуулсан гэдэг. Идүүд ханы тэр өчлийг сонсоод Чингис богд ихэд таалж, хариуд нь соёрхохдоо:

-Охиноо өгье. Миний тавдугаар хөвүүн болтугай. Алт мөнгө, сувд, тана, хоргой торго, хивс, хатгамал эд уурсыг авч ирэгтүн гэвэл Идүүд, эзэн соёрхов хэмээн баясч, үнэт эд уурс ачин ирж Чингис богдод бараалхав. Чингис хаан Идүүдийг соёрхосны тэмдэг болгож Алалтун бэхи гүнжээ өгөөд:

Хатагтай хүнд гурван эр буй

Анхны эр нь алтан төр

Түүний дараахи эр нь ариун нэр

Түүний удаах эр нь авсан эр болой.

Алтан төрийг хатуужин дагавал

Ариун нэр бэлэн бөлгөө

Ариун нэрээ авч явбаас

Авсан эр ангид үл одно хэмээн сургажээ.

Туулай жил, аргынхаар 1207 онд Зүчи баруун гарын цэргийг авч ойн иргэдийг эзлээр очиход, гээд багш нь шавийн зүг зэрвэс харвал охин сэрдхийн яриаг нь тасалж:

-Энэ чинь манай Ойрадууд мөн үү, багштаан? хэмээн асуулаа.

-Тийм ээ. Ойн иргэд буюу Ойрадын Худуга бэхи түмэн Ойрадоо авч дайн тулаангүйгээр дагаар ирэхээр шийджээ. Ингээд эзний өөдөөс сөргөлгүй дагаар орсон Худуга бэхийн урдаас угтан Чингис хаан соёрхолоо хайрласан гэдэг. Тэгэхдээ Худуга бэхийн хөвүүн Иналчид Сэчэйхэн бэхи гүнжээ ураглаад:

-Эрт босч,орой хэвт.Өдөр шөнө нэгэн сэтгэлээр хатууж.Амны ухаан билгээ тогтоо.Эс сурсан мууг энд тавьж од.Сурсан сайныгаа авч хадмынд морд. Ойрад иргэнээ сэлбэн холбон соёрхогтун хэмээн сургаалиа айлдсан гэдэг ээ.

-Тэгэхээр манай Ойрадын эзэнд Чингис хаан гүнжээ соёрхож байжээ? хэмээн Ану охин баясан асуулаа.

-Эзэн Чингис өөртөө дагаар орсон нэр нөлөө ихтэй хан эздэд эгнэгт эв найртай байх, олон овог аймгийг эгүүрд өөртөө нэгтгэн авах зорилгоор ийнхүү хайртай гүнж нараа ураглан мордуулдаг байсны нэг нь тэр дээ шавь минь. Үүнийг эзэн хааны алтан хайрцгийн бодлого буюу “Төрийн ураг барилдах ёсон”,”Алтан аргамж” гэдэг юм даа гээд яриагаа дуусгалаа.

-Маргаашдаа ирээд хэрэггүй ээ.Миний бие барагтайхан байна. Маарамбатны илгээсэн цөс хөөх танг хүртэн хэвтэх байх. Шавь минь чи ч гэсэн морь унан хээр талаар давхиж залуу биеийн чилээг гарган өргөөний жаалуудтай хөгжилд. Нөгөөдөр хоёулаа түүх шастираа хүүрнээ хэмээн багш нь хэлээд ядрангуй нүдээр инээвхийлэв.

Гадаа бүрэнхий болжээ.Охиныг хүлээн багшийнх нь гэрийн гадаа холхиж байснаа хаяаг нь түшээд үүрэглэж суусан Балсанг Ану ханцуйнаас нь угз татан сэрээгээд “Хөөе,унтаахай босч үз.Маргааш бозлог харвах уу? Би багш руу ирэхгүй” гэсээр өргөөнийхөө зүг хөгжилдөн ярилцан одовой.

Охин харвах намнахдаа Балсан, Бундир хоёрыг урдаа оруулдаггүй байсан боловч, сүүлийн жилүүдэд ном эрдэмд шамдан сурсаар цаг их алдаж, хөдөлгөөнт бай онох, морины давхиан дунд харвах зэрэг олон зүйлээр тэдний дийлэхээ болиод байлаа.

Маргааш нь Ану хөгшин шийр цагааныхаа оронд, сартай жороо хээр морио майга хөлт баавгай шиг харагддаг агтчин Мандахаар авчруулан унаад Мандарваа,Булган, Балсан, Бундир дөрвийн хамт Шар хоолой руу давхицгаав. Даахиа үргээлгэдэг тэр жил нь Юм-Агас хатны бэлэглэсэн хөөрхөн эмээл хэдийн хуучирч, нас биед хүрч яваа эзэндээ багадах болсон тул өнгөрсөн жил аав нь нанжин гахай гөлөмтэй, цул мөнгөн баавартай сайхан эмээл төхөөрч, энэ сартай жороо хээрийг өмчлүүлсэн билээ. Усан тэлмэн жороо явдлаар бөмбөлзүүлэн толгой хаялан дүүхэлзэх энэ хүлгийн дэргэд хөөрхий хэдэн найз нар нь ёстой л хонины бор гэмээр тааруухан морьд унасан нь Ану гүнжийн жороо хээрийн сүрд дарагдан урагш сугаран давхихад нь хэчнээн давирч ташуурдаад гээгдэн хоцорцгоох нь охинд зугаатай агаад бахтай сайхан байлаа.

Зуны эхэн сарын нарлаг сайхан өдөр байлаа. Нар дээр хөөрсөн ч төдий л халуу шатаагүй,байгаль дэлхий өнгөө дэлгэн ногоон хивс мэт тал хөндий маргадын өнгөөр нүд булаан, алсад хонин зэрэглээ мяралзана. Тэртээ ухаа толгодоор хантны их хонин сүрэг бэлчин сувд мэт цайрна. Нөхдөөсөө илүү сайн эрмэг хурдан хүлэгтэйдээ эрдэн түрүүлж давхисаар нэгэн толгой даваад, алсад тоос манаран их хөсгийн цуваа үзэгдэхийг ажсан Ану өврөөсөө тод бичигт тайлагдлаа хэмээн өгсөн эцгийн бэлэг ганц нүдний дурангаа гарган алсыг хараачлав. Тэмээн тэрэг, туг хиур мандуулсан цэрэг, улбар шар хувцастай лам нар ч үзэгдэх шиг.Хүмүүсийн царай ялгарахааргүй хол байсан ч томоохон лам багштан заларч яваа боллолтой.

-Ану! Чи чинь биднийг хаяад хэчнээн хол сугаран одов оо? гэсээр Мандарваа , Балсан хоёр арай сайн морьтойгоороо нөгөө хоёроосоо түрүүлэн морио усан хулгана болтол нь хөлөргөчихсөн давхиж ирэв.

Хойноос нь хашин буурал морьтой Бундир, тэгээд амаа авч хадуурдгаас, уг нь хурд сайтай хатирч саарал морьтой Булган ергүүлсээр ойртов.

-Хараач,Булганы ам нь өмөлзөн уйлах нээ.Саарал морь нь баруун тийшээ хадуураад давхичихсан юм аа.Мориндоо уурлаад бөөн хор шар явна гэж Мандарваа дүүгээ шоолов.

Энэ жил арван гуравтай, Анутай нас чацуу Булган эгчээ бодвол биеэр жижиг, хөөрхөн алаг нүдтэй, жигд цагаан шүдтэй, нилээд ааштай, хортой шартай охин тул юм юманд хүний ард орохыг үл тэвчинэ. Тиймдээ ч Анугаар тод үсэг заалган нусаа татан түнтгэнэх эгчийнхээ дэргэдээс нь харсаар байгаад бичигт тайлагдан эцэгтээ магтуулж, энэ ам авч давхидаг ч хурд сайтай хатирч саарал морийг унах эрх олж авчээ. Гэтэл тэр нь өнөөдөр амаа авч хадууран давхиад нэг гүвээ давж байж, арайхийн тогтоосон тул хамгаас хоцорсондоо уурсан богинохон ташуураар морио толгой түрүүгүй нүдсээр ойртон ирэв. Араас нь юм л бол энэ охины аяыг харж, санаашран ширтэх болсон Бундир ергүүлсээр даган явна. Бундир одоо нас арван тав хүрч, эртний монголчуудын жаягаар эр цэргийн насанд хүрсэн атал Булган охинд сэтгэл алдаж, түүнд үг дуугүй загнуулан явдаг билээ.

-Алсад тоос дэгдээд холын аянчид явна биш үү? хэмээн нүд хурц Балсан баруун зүг саравчлан хараад хэлэв.

-Мэднээ,мэднэ.Би аль түрүүн дурангаараа харчихсан юм чинь. Том ламтан заларч яваа бололтой харагдсан хэмээн Ану ихэмсгээр хэлээд зүүн хөмсгөө өргөн хүүхдүүд рүү харснаа:

-Хараач, тэр довцог дээр бозлог нүхнээсээ цухалзаад байна.Би эхэлж харвана шүү гээд нум сумаа гарган хараалав. Ахынхаа зааснаар амьсгалаа түгжин, эрхийгээ чивчиртэл татаж байгаад сумаа тавьсан ч өнөөх бозлог оногдсонгүй нүхэндээ шуртхийн орчихов.

-Одоо тэгвэл тэрийг би харвана шүү гэж Бундир хэлээд хүүхдүүдийн зүүхэн талд булталзаж байсан хэрэгт дуртай хотилыг нам харвачихлаа.

-Ээ,хөөрхий амьтныг алчихлаа шүү дээ хэмээн Булган охин, өр нимгэн бүсгүй хүний зангаар нүүрээ даран Бундир руу зэмлэнгүй харахад саяхан Анутай арцалдан байсан хөвүүн, сэтгэлт охиныхоо зэмлэлийн харцанд шалчийн духаа маажих аядав.

-Охин хүүхэд харвах намнахдаа эрчүүдийг яаж гүйцэхэв дээ гэж Бундир Булганыг даган нусаа татаж явдаг өнөө дуу муутай, доожоогүй амьтнаас яаж гарав гэмээр егөөтэй хэлэхэд нь Анугийн хор шар буцалж жороо хээртээ үсрэн мордоод “Тээр тэнд дэгдэж яваа хярсыг харж байна уу?Би тэрийг нам харвана мэдэв үү?Харж бай,чи” гээд давхин одов.

Хөл хөнгөн сартай хээр нь толгой хаялан дүүхэлзэж бөмбөлзүүлэн жороолсоор хурдаа авлаа.

Охин морины давхиан дунд нум сумаа онилон баруун нүдээ аниад, хойноос нэхэх аюулаас

ТЭНХЭЭ мэдэн зугтах өчүүхэн хярсны нурууг зүүн нүдээ чилтэл хараачилж байгаад сумаа тавилаа. Нов ногоон тал дундуур шаргал нуруу гялалзуулан чавхдаж явсан өчүүхэн хярс татвасхийн уналаа.

-Ухай! Оночихлоо доо, чамайг хэмээн Ану амандаа баярлан шивнээд агнасан ангийнхаа дэргэд давхин очлоо.

Дулаан цаг ирмэгц үсний сороо гээж царай алдсан туранхай хярс байв.

Хашин морио давиран ирж яваа Бундираас ам асуух гэсэн Ану намнасан хярсныхаа дэргэд түүнийг хүлээн ташаа тулан, эр хүн шиг зогсч байтал Балсан түрүүлэн давхиж ирээд:

-Чи хөдөлгөөнт бай харвахдаа сайн хэвээрээ байна шүү. Аман хүзүүгээр нь сум орж. Даанчиг үс гэж хэрэггүй болжээ. Дулаарчихсан байхад арга байж уу. Хөөврөө гээгээд үсэнд нь сор гэх юм даанч алга хэмээн шогширч зогсонгоо Ану руу сэм хяламхийнэ.

Ам авч давхидаг ч эрхбиш хурдан морьтойгоороо Булган, тэгээд хамгийн муу морьдтой Мандарваа, Бундир хоёр сүүлдэж ирцгээлээ.

-За, чи охин хүүхэд харвах, намнахдаа эрчүүдийг яаж гүйцэхэв гэсэн бил үү? Би бичиг ном гээд суугаад байгаагүй бол та муу хоёрыг урдуураа гишгүүлэхгүй л дээ гэж Ану Бундирт бардмаар хэлээд үхсэн хярсны сургаар тэнгэрт эргэлдэх элээ, тас шувуудыг ширвэн хараад:

-Үс муутай юм. Шувуунд хоол бэлдчихлээ. Ам ангаж байна. Явцгаая гээд сайхан жороо морины хурдаар давхин одлоо.

Тэднийг өргөөнд ирэхэд Цастын орноос гэртээ харьж яваа Галдан гавьж замдаа алжаалаа тайлан Очирт ханыд айлчлах болсон тухай мэдээ угтав. Анугийн дурангаараа харснаар ачаа хөсөгтэй том лам явж байсан нь Галдан ламтан байжээ.

Тэртээ найман жилийн өмнө, зургаахан настай байхдаа анх учирч, мутраас нь адис авахдаа догдлон булгилж асан зүрх нь өнөөдөр Галданг өргөөнд нь гэгээн дүрээрээ морилох сургаар ахин нэг агшиж, айдас, түгшүүр, баяр хөөрийн аль нь үл мэдэгдэх сэрэлд цочроод авлаа.

“Галдан ламтан тэгэхэд арван таван сүүдэртэй хөвүүн байсан. Харин би зургаахан настай нялх амьтан байсан атал түүнийг анх үзээд зүйргүй их догдолж байсан сан. Харин эдүгээ хорин гурав хүрээд ямархан эр болсон бол? Цастын оронд надад адис хайрлаж байснаа санаж буй болов уу? Лувсандаш тайжийн хүү Сандуйжав шиг над руу өлөн харц шидлэхгүй л байх, лам хүн чинь. За байз, гоё шинэ лавшигаа гаргаж өмсөе. Үс гээгээ эмхлэн самная. Сая хээр хөдөө давхисаар, гээг үс хээрийн салхинд хийсээд сэгсийсэн толгойтой л юм болсон байж таарна” гэхчлэн залуу охины сэтгэл, догдлолд авган хайрт хүнээ угтах гэж буй бүсгүйн дүрд орчихов.

Түүнийг элдэв зарц, шивэгчин, энэ өргөөг засаглан захирагч эхтэйгээ учрахаас зайлсхийн өөрийнхөө бичгийн өргөөнд ийнхүү ганцаар догдлон суутал Мандарваа орж ирэв.

Барагтай бол тольдоод үс зүсээ гоодоод байдаггүй Ану, Галдмаа ахынхаа бэлэглэсэн ногоолин чимэглэлтэй гарын толь барьчихсан царайгаа шинжин хөмсгөө нэг өргөж, нэг буулган эхийнхээ хэрэглэдэг оо энгэсгийг өмнөө тавьсан суугааг хараад найз нь их л гайхав.

Тэрээр багшийнхаа сургадагчлан “Алив үзэмж сайхан зүйлс нэгэн цагт элэгдэн хуучрах тул мөнх бус. Иймийн тул гадаад өнгөний гоёд бүү хуурт. Дотоод сэтгэлийн өнгө үзэмж үзэгдэхгүй авч, үжирч муудна гэж үгүй тул мөнх юм” хэмээн үзэж, өнөөг хүртэл эр хүнд татагдан сэтгэл догдлуулсан мөч амьдралд нь тохиогоогүй байснаас ч тэр юм уу, эсвэл хар нялхаасаа л тансаг сайхан эдлэлд умбаж өссөнөөс нүд дассаных юм уу, бүсгүй хүний сонирхдог алт мөнгөн чимэглэл, хоргой торгон эдлэлд өчүүхэн төдий ч шохоорхдоггүй байсан билээ. Мандарвааг:

-Хүүеэ, ахайтан таныг хоол зоогло,хээр яваад өлөрхдөггүй юм байх даа? гээд намайг олоод ир хэмээн явууллаа.Та чинь юундаа гоёж гоодоод явчихав аа? гэхэд нь Ану түүн рүү зүүн хөмсөг өргөн хяламхийгээд:

-Алив, миний гэзгийг задлаад дахин гөрөөд өг. Хээр морьтой давхисан чинь задраад нэг л муухай харагдаад байх шиг.Тэр зоог моог яахав ээ.Зугтаад алга болчих биш. Мандарваа!

Миний шинэ лавшигуудаас аль нь илүү хээнцэр харагддаг вэ,надад? хэмээн толь руугаа ширтсэн хэвээр асуулаа.

-Ахайтан таны дуртай мөөгтэй шорлогийг...

-Тэр шорлог яах вэ гээд байхад! Бүдэг ягаан, цав цагаан одтой торгон, алтан хатгамалтай цэнхэр, навчин хээтэй ногоон лавшигнуудын аль нь надад эцээхэн зохиролтой үзэгддэг вэ? Чи тийм юманд надаас илүү сайн болохоор чинь асуугаад байхад даа хэмээн нарийхан хөмсөг зангидан ундууцлаа.

-Таны үс хүрэгтэр өнгөтэй, тэгээд алтлаг туяатай, царай их цагаан болохоор алтан хатгамалтай тод цэнхэр лавшиг хээнцэр харагддаг шүү дээ. Тэгээд тэр алтан бадамлянхуа цэцгэн хатгамалтай хоршуулаад алтан унжуурга ээмгээ зүүчих. Алив би үсийг тань самнаж гөрөөд өгье.Үсэндээ алтан оосор зүүгээрэй.

“Одоо Галдан ламтны хөсөг ойртож яваа даа. Ирэхэд нь гоодож амжих байгаа. Хаа байсан Хар хадатын тэртээ үзэгдсэн тэмээн хөсөг нар шингэж байхад л өргөөнд буух биз дээ.Надад ч цаг зөндөө байнаа” хэмээн бодсон хэр нь сэтгэл догдлон булгилна.

Мандарваа охин Ануг ийнхүү догдлон гангалж, гоодоод буйн учрыг гайхавч , “Тэмээ хариулсан хүн буурынхаа занг андахгүй” гэгчээр нэгэнт өөрөө учраа ярихгүй байхад нь асууж лавлаад дэмийг гадарлах тул, үг дуугүй л гэзгийг нь задлан том зандан самаар самнаж суулаа.

Багадаа Анугийн гэзэг тас хар байснаа томрох тусмаа шаргалтан алтлаг хүрэн өнгө сууж, нарны гэрэлд алтан сортой юм шиг үлэмж үзэмжтэйгээр гялалзан харагдах болсон билээ.

Охины өтгөн хүрэн гэзэг дал мөрөө бүрхэн намираад, өдгөө өмссөн ухаа улаан хуучивтар



лавшиг нь үзэгдэхээ болиод үслэг хүрэн нөмрөг нөмөрсөн мэт харагдах аж. Өчигдөрхөн шүүгээр угааж, хараалч цэцгийн хандаар зайлсан өтгөн алтлаг хүрэн гээг самнах тусам ширэлдээ нь гарч, улам л хараад баймаар сайхан гялалзан намирахад Мандарваа яаралгүйхэн салаалан гөрж эхэллээ.

Энэ үед үүдээр эхийнх нь шинэ шивэгчин Уламнэмэх шагалзан:

-Ахайтан зоог тань хөрчихлөө хэмээн ундууцаад байна хэмээн шавдууллаа.

-Очлоо гэж ижийд хэл.Түвэгтэй юм.Аль Мандарваа түргэлж үз. Хоол зоог хүртэх дур өчүүхэн ч алга байхад байсгээд нэг хүн илгээх. Би ямар мангас биш. Идэх, унтахаас өөр идгүй хүн биш дээ гээд толио авч царайгаа янз янз болгон харж “Явал Галдан ламд илүү хөөрхөн харагдах бол? Надад хөнгөхөн инээмсэглэл зохиролтой юм гээч.Уруулаа гялалзуулбал зүгээр юм. Ижийгээс уруулын шунхыг нь гуйвал яадаг бол?Үгүй чи чинь эм сүвтэйгээ одоо л мэдэв үү? хэмээн ам асуух байх даа.Яршиг, Мандарвааг сэмхэн гүйж очоод толиных нь өмнөөс аваад ир гэвэл хулгай хийсэн болдог юм болов уу?” гэхчлэн хөгийн бодолд автан суулаа. Тэгснээ нэгийг санан хажуудахь жижигхэн мөнгөн хонхоо авч жингэнүүлэхэд өргөөнийх нь залуухан хиа Магсар орж ирлээ.

-Жа гүнжтээн!

-Жангаад очоод намайг шинэ лавшигууд бичгийн өргөөнд аваад ир гэсэн гээд авчир.Хурдан! Эмсийн зангаар элдвийг шалгаагаад байвал мэдэхгүй гээрэй хэмээн захирлаа.

Хэдхэн хормын дараа Магсар баахан торго, хоргой лавшигууд тэвэрсээр орж ирэхэд Мандарваа олон салаа үсийг нь сүлжиж дуусаад байлаа.

“Үнсийг нь цэвэрлэсэн тулга нэг цэмцгэр

Үсээ самнасан эхнэр нэг цэмцгэр ” гэдэгчлэн энд тэндээ сэвлэг үс нь сүлжээнээс задран арзайсан гээгээ самначихаар Ану охин үнэхээр цэмцгэрхэн харагдаж байлаа.

-За ижийн өргөөнд очиж, өнөөх хорхой хүргэсэн зоогоо хүртдэг хэрэг ээ.Тэхгүй бол одоо Жангааг явуулж ч мэдэшгүй. Хоёулаа явж мөөгтэй шорлогоо идье, гэдэс өлөрхсөнөө сая л мэдлээ.Хоржигноод байгаагий нь ээ хэмээн Ану тас тас хөхөрлөө.

Гүнжтэн одоо л энгүүн байдаг шигээ хээгүй, эрс шулуун төрхөндөө орсныг үзээд Мандарваа ч бас баясан:

-Ёооё, миний өлссөнийг яана.Таны гэзгийг гөрж суухдаа бас ходоод хонхолзоод хоржигнохоор нь санаа зовсон гэдэг нь.Түрүүн таныг дууд хэмээн ахайтныг зарлигдахад өргөөнөөс нь ханхийсэн шорлогийн хорхой хүрмээр байсныг яана гэлцсээр үеийн хоёр охин ахайтны өргөө рүү гүйн одлоо.

Охидыг инээлдсээр ороход зоогоо хүртэж дууссан Доржравдан охиноо ундууцахаасаа илүү гайхасхийн харсаар угтав.

-Ижий бүү ундууцаарай. Хээрийн салхинд үс гэзэг сандран садраад Мандарваагаар самнуулаад удчихлаа. Үгүй, та над хэчнээн сайхан хоол зэхүүлээ вэ? хэмээн Ану хэлээд шорлог руу дайрав.

-Бүсгүй хүн гэдгээ хааяа нэг санан, үс гэзгээ эмхэлдэг чинь яамай даа, үр минь. Гэвчиг өвгөн замын чамд гэж сэтгэл гарган хийсэн зоог хөрчихсөн байна. Халуун цайгаар даруулаад ид дээ гээд охиноо шинжин харлаа.

Түрүүн Магсарыг явуулж бараглан өмсдөггүй шинэ лавшигуудаа бичгийн өргөөндөө аваачсан байсан. Гэзгээ өдөрт ганц л самнадаг хүн юуны учир гэнэтхэн зоогоо умартан дахин янзлав? Охиных нь харц энгүүн үеийнхээс илүү гялалзаад, гэзгээ самнан, хацраа оодсоныг үзээд их л гайхсан ч түүний адайр занг мэддэг тул олныг асуулгүй ажиглан суулаа.

“Үгүй ер, харахад л бүсгүй хүүхэд болохоос хүйсээ солиод төрчихсөн юм болов уу? гэмээр эрмэг зантай энэ охин өнөөдөр юу болчихов доо? Аль Галдан ламтныг ирнэ гэхээр ингэж гоёв уу? Долоон жилийн өмнө нялх шахуу байхдаа л түүнийг үзсэн хүн шүү дээ Галдан ламтнаас болж ингэж гоёж гоодно гэж баймгүй юм. Тэгээд ч тэр чинь эхнэр хатан авч үл болох тангарагтай санваартан хүн шүү дээ. Саахалтын Лувсандаш тайжийн хүү Сандуйжавыг ер ойшоохгүй байгаа харагддаг. “Морин дээрээс харвахдаа бүсгүй хүнээс доор, нус Сандуйжав” ирж явна хэмээн өнгөрсөн жил үрс гаргахын баяр дээр Мандарваад хэлээд тас тас хөхөрч байсан, ер нь түүнийг байн байн өргөөгөөр ирж очиход өчүүхэн ч ойшоохгүй буй харагддаг. Тэр жил Сэнгэ хунтайжийг морилон ирэхэд ч ингэж их гоодож харагдаагүй. Тэгэхэд ч дөнгөж арван нэгтэй байсан л даа. За ер нь энэ хүүхдийн аашийг олохоо болих нээ. Арай өргөөний харуул, хэвгүүлүүдийн нэгэнд сэтгэл алдраагүй байгаа. Ганц охиноо нүдний цөцгий мэт харж хямгадаж бай хэмээн хантан захиад байдаг. Гэтэл энэ хүүхэд өнөөдөр гэнэт гоёж гоодоод эх наддаа оньсого таалгаад эхлэх юм даа” хэмээн эх бодолд орон охиноо ажсаар суув.

-Ахайтаан! Зум хийх үү? хэмээн ахлаач замын зараалаар хоолон гэрийн усчин Жигмэд хаалгаар цухуйн бодлыг нь тасалчихав.

-Тэг ээ. Хүндэтгэлийн дээд хэмээн ёс болгож зум тавина. Гэвчиг зочин маань амьтны амь таслахыг тэвчсэн ариун санваартан учраас махгүй цагаан хоол эцээхэн бэлтгэ гэж байна хэмээн дамжуулаадах гэж ахайтан захирамжлав.

“Галдан ламтан ямаршуу эр болсон бол? Намайг үзээд яах бол? Ижий яагаад далан хэл дэлгэхгүй намайг чимээгүйхэн ажиглаад байна? Мандарваагийн хэлснээр хатгамалтай цэнхэр торгон лавшигаа өмсчихдөг юм билүү? Тэр олон шинэ хувцас гоёлоо бичгийн гэр рүү зөөснөө ижийд юу гэж хэлнэ? За, ер нь би ямар жаахан Бээвэнханд биш. Бичгийн өргөөндөө нэгмөсөн амьдармаар байна. Тэгээд юмаа зөөж байгаан гэж ижийд хэлнээ, яадаг юм.” гэхчлэн Анугийн толгойд элдэв бодол хөвөрсөөр хөрч царцсан мөөгтэй шорлогны амтыг ч мэдэрсэнгүй өнгөрөв.

-Дуудаад байхад ирэхгүй алга болоод, хоолоо хөргөчих юм. Шорлог хөрчихөөрөө тусгүй байдаг. Хойноос нь халуун цай оочилж үз. Нар тонгойсон хойно л холын гийчид маань ирэх юм шиг байна. Хантан тосуулын хэдэн хүн явуулсан. Галдан ламтанг өргөөнийхөө үүдэнд

хүндэтгэн угтахад алга болчихов доо, үр минь! хэмээн эх нь үглэнэ.

-За тэгнээ ижий.Юу гэж алга болдог юм.Хүндтэй гийчин морилж байхад...За болчлоо.Сайхан шорлог байна,амаа олохгүй чихлээ хэмээн Лхасран замд хэлээрэй. За би номоо сийрүүлбэ. Бийр янтайгаа нийлүүлж, бичиг цаасандаа салхи оруулья байз хэмээн Ану босон гарч алга болов.

Үнэн хэрэгтээ бийр янтай нийлүүлэх хүсэл, сонирхол түүнд хумсын чинээ ч байгаагүй юм. Оройн саалийн цаг дөхөж тэртээх үхэрчин айлуудын тийш үхэр мал мөөрөлдөн, ялаа, шумуул үргээх гэж тавьж буй утаа май баагин, саалиндаа гарч яваа бүсгүйчүүдийн шуугиан сонсогдоно.

Ану Мандарваагаа дагуулан бичгийн гэртээ орж, өнөө олон гоё лавшигуудаа өмсч үзэж эхлэв.

Дугуй хээтэй бүдэг ягаан лавшиг өмсч үзлээ. Царайны нь цагаанаас ялгарахгүй сүр муутай санагдах тул болив. Одтой цагаан хоргой лавшиг нь гялалзаад нүд булаам боловч өмсчихөөр нэг л биш юм шиг. Цасан цагаан дээр,мөнгөн одтой хоргой, царайны нь өнгөнөөс ялгахааргүй атал, түүний нүүрний зөв хэлбэр, сэтгэл татам ялдам төрхөөс гялалзсан од нь хүний харцыг илүү татаад байх шиг. За больё. Навчин хээтэй ногоон торгон лавшигаа өмсөөд босоо толиндоо харлаа. Газар эхийн тод ногоон өнгө ёстой л “Хөхөө Намжил”-н үлгэрт гардаг лусын дагинын дээл шиг, охины царайны сүүн өнгийг тодруулаад гоёхон. Гэвчиг нэг л даруу, бас тэгээд арай л эршүүд өнгө юм шиг. Эцэст нь алтан утсаар бадамлянхуа цэцэг хатгамалдсан үнэт цэнхэр торгоор урласан лавшигаа өмсч, олон салаа алтан унжуургаа өрөөсөн чихэндээ зүүлээ. Хацар нь үл ялиг ягааран гэрэлтсэн цасан цагаахан царайг нь тодруулж, ижийнх нь бэлэглэсэн индранил эрдэнийн бэлзэгтэй цэнхэр өнгө нь хослоод, гээгнийхээ үзүүрт зүүсэн алтан оосрууд, алтан унжуурга ээмэгтэй хатгамал нь хоршоод энэ саан хатгамалтай цэнхэр лавшигийг гагцхүү Ануд л зориулан урласныг илтгэнэ.

-Та тэр олон гоё ээмэг, зүүсгэлээ зүүж байгаач. Энэ могой ороосон алтан унжуурга чинь хэчнээн чамин эд вэ? хэмээн лавшигийг нь өмсгөн хормой, хот, бүсний орчмын нугалааг нь толийлгон засангаа сийлбэртэй зааны ясан хүрээтэй нарийхан босоо толь руу зэрвэхэн хяламхийх Мандарваа зэмлэнгүй хэллээ.

-Өдөржин багшийн гэрт бичиг сачиг хуулж өнгөрөөх юм чинь хэндээ үзүүлэх гэж алт, эрдэнэсээр биеэ чимэх вэ дээ хэмээн Ану хэлснээ өнөөдөр тэгээд Галдан ламтанд хөөрхөн, хээнцэр харагдах л гэж гоёж гоодоод байгаагаа илчилсэн мэт санагдаж, ичсэндээ хоёр жижигхэн чихний нь омог улайгаад явчихав.

Удалгүй хотны ноход хуцалдан, тэртээ баруун өмнөдөөс наашилсаар айсуй гийчдийн хөсөг хантныд буудаллав. Галдан хутагт Очирт цэцэн ханыхаар буудаллахаар айсуй сураг чимээ хээр талаар салхи мэт хурдан түгж, хавийн сүсэгтэн ардууд өргөө хавиар цуглан багахан наадмын чинээ явдал болж байлаа.

Гэрийн эзэн гурван хатан, гүнж зарц, шивэгчдийн хамт их өргөөний гадаа хүндэт зочноо угтан тослоо. Ану Галдан ламтантай нүүр учрахаас эмээн цээж дүүрэн түгшүүр, айдас, баяр хөөрийн алиныг үлмэдэх догдлолд авган алтан саагаар хатгамалдсан цэнхэр торгон

лавшиг,суддан чимэглэлтэй тоорцгоо өмсөөд, эцгийнхээ дэргэд хормой чичиргэн зогсоно. Уг нь “Зая багштаны хувилгаан дүрд тодрон, гавьжийн дамжаа барьсан Галдан хутагтын зулай дээр нь Базардарь, магнай дээр нь Зонхов, нүүрэн дээр нь Махгал, хоолой дээр нь Хоньсонбодьсадваа, хоёр мөрөн дээр нь хорин нэгэн дарь эх тодорсон эгэлгүй их эрдэм төгс хувилгаан ” хэмээн итгэж, гишгэсэн газраас нь ч болсон атга шороо олж аваад шүтэх гэсэн энэ олон сүсэгтний араар нуугдмаар байсан ч дөрвөн Ойрадын чуулганы “хан”-ы гүнж тул эцгийн дэргэд зогсон гийчиндээ хүндэтгэл үзүүлэх ёстой байлаа.

Алтан шар магнаг торгоор бүрсэн тэмээн тэрэгнээс Галдан ламтан бууж, олон дагуул, бараа болоочдын хамт шууд Очирт цэцэн хантны зүг эрмэг алхлан ирэв. Түүнийг үзээд Анугийн зүрх цээжиндээ багтахгүй булгилан догдолж, нүүр өөд нь халуун цус мэлсхийтэл хөөрөх мэт болох нь тэр. Найман жилийн өмнө Цастын оронд ганц удаа уулзан адис хайрлаж байсан өнөөх хөвүүн танихын аргагүй сайхан эр болжээ. Алтан сампинт номын малгай, ханцуй үгүй хүрэн дээл, тод улбар шар орхимж намируулсан л болохоос үлгэр туульд гардаг Жангар баатар л ийм байсан болов уу гэмээр. Хүнгэнэсэн сайхан баргил дуугаар:

-Очирт цэцэн хан таны лагшин амгалан уу? хэмээн мэнд мэдээд ойр хавийн хүмүүсийг тойруулан амгалан харцаар халиангаа Галдангийн нүд Ану охины царайд тулаад шохоорхол, бахдалын оч нэг гялалзах шиг болмогц хоромхоноо өөрчлөгдөн хажууд нь зогссон Доржравдан ахайтан руу шилжлээ. Охин ч ламтны цоргисон харцтай тулгарсан тэрхэн хоромд ховсдуулах шиг болж ичингүйрэн нүдээ доошлуулав.

“Бурхан минь! Найман жилийн өмнө зургаахан настай охин явахад минь сэтгэл булгилуулж байсан энэ залуу ламтан өдгөө эрийн цээнд хүрч, эхийнх шигээ саран хэлбэрт сайхан хөмсөг нь зузаавтар уран хэлбэрт уруулынх нь дээгүүр зурайх сахлын ормын адил улам өтгөрөн, сайхан алаг нүдний нь харц тогтож, чилгэр бадируун цээж нь номт хувцасны цаанаас хараа булаасан, ширтээд баймаар эр болжээ.Зүй нь эхнэр авах, амьтны амь таслах зэрэг хорвоогийн явдлыг тэвчсэн эрдэмт хутагт бус, хуяг дуулгаа наранд гялалзуулан, хурдан хүлгийн нуруунд дүүхэлзэн давхиж, охидын сайхныг шилэн хуримлах баатар эр байлтай. Чингээд тэр шилэгдэх гоо охин нь би байвал сайхан аа” хэмээн Ану охин бодоод тэр бодлоосоо ичингүйрэн хацар нь халуу шатах аж.

-Амгалан сайхан байнаа. Эрдэмт хутагт Та аян замдаа амгалан сайхан морилж явна уу? Өчүүхэн миний өргөө гэрт тавгай зочлоорой хэмээн эцэг нь мэндийн үг хэлэхийг охин бүүр түүр сонсон алаг зүрх нь догдлон цээж бөмбөрдсөөр зогслоо.

Эцгийн ёслолын их өргөөнд Галдан хутагтыг хүндэтгэн зоог барив.

-Их хатан Цэвээн,дунд ахайтан Доржравдан,бага хатан Нуран.Энэ миний отгон охин Ану гүнж гэгчлэн эцэг нь өргөө гэрийнхнээ толгой дараалан нэрлэж, Галдан хутагтаас адис авахуулав. Залуу сайхан хутагтын зөөлөн цэвэрхэн гар магнайд нь хүрэх тэрхэн агшинд охин энэ хөрстөөс нисэн хөөрч сансар огторгуйн хязгааргүйд хөвөн одох шиг л гайхамшигт мэдрэмжинд авгжээ.

-Очирт цэцэн хан Таны гүнж Цастын оронд анх очиж байснаа бодвол том сэвгэр болжээ хэмээн Галдан хэлээд хурц алаг нүдээрээ охиныг тас ширтсэн аж.

-Тэгэлгүй дээ. Одоо арван дөрөвтэй.Тод, уйгаржин үсэгт гаргуун, халх, Ойрадын түүх заалгаж буй. Зүгээр ч үгүй нум сумаар харвах, намнах, сэлмээр цавчилдахдаа хоосонгүй охин доо,миний Ану хэмээн хар архинд ялимгүй халамцсан эцэг нь охиноороо бардамнан сайрхахад охин улам ч их ичин нүүр хийх газаргүй болж бушуухан шиг эхийнхээ цаагуур орчихлоо.

-Тийм гэж би бас сонсч байсан юм байна. Та гүнжээрээ бахдах нь аргагүй ээ.

-Галдан хутагт Цастын орноо эргэн явахгүй Ойрад түмэндээ номын гэрлээ түгээн суухаар яваа гэж сонордсон юм. Энэ үнэн үү? хэмээн эцэг нь асууж буй дуулдана.

-Тийм санаатай Далай багштанаас соёрхол авч яваа.Сэнгэ ахын төрийн хэрэгт шашны багана нь болдог юм уу гэсэн бодолтой явна. Нас ахиж яваа ижийнхээ дэргэд байж сэтгэлийг нь дэвтгээж явах нь ч үр миний үүрэг шүү дээ.

-Тэр тэгэлгүй яахав. Юм-Агас хатан таныг их санадаг биз. Манайд хэд хоног саатан морилох вэ?

-Маргааш өглөө эрт хөдөлнөө.Ижий миний сургаар хараад байгаа байх.

Гэтэл Галдан ламтан яагаад ч юм маргааш нь Ховог сайрын тэртээх орд руугаа хөдөлсөнгүй. Хүн, хөсгөө амраах нэрийдлээр өнжиж, өдөржин сүсэгтний хөлд дарагдан мутрын адис хүртээн, ном айлдаж, Далай ламтны шившлэгтэй зангиа, сахиус түгээн өргөөгөөр нэг хөл үймээн бужигнаан болгоод нар шингэхийн өмнөхөн сүсэгтнүүдийг арай хэмээн тараав.

Үнэндээ Очирт цэцэн хантныг хүндлэн өргөөнд нь ганц нэг хоног саатан морилох ялдамд сүсэгтэн олонд адис, зангиа хайрлах бодолтойгоор зам зуур буусан Галдан хутагт Ану охиныг нь ийм хараа булаам хөөрхөн сэвгэр болсныг мэдээгүй явжээ. Найман жилийн өмнө Лхаст нэг удаа харсан жаал охин өсч томроод цоморлигоо дэлгэсэн сарнай мэт ягаахан хацар, алтлаг хүрэн гэзэг, харзны ус мэт мэлмэрэн оч хаялсан жижигхэн хөөрхөн нүдтэй, жирвийсэн хөмсөг, дэвүүр сормосогтой гоо үзэмж төгс бүсгүй болчих гэж! Хантныд ганцхан хоног саатаад ижийдээ, Ховог сайрын тэртээх эцгийн ордон руу замд гарна гэсэн бодол нь тэр шөнөдөө замхран одож, маргааш нь сүсэгтнүүдэд адис хайрлах халхавчин дор Ану охины гоо царайг дахин харах дийлдэшгүй хүсэлд баригдан өнжжээ.

Тэгээд оройхон хантны зүүн өмнөдөд байх овоо индэрт идээ тахил өргөн, хангай дэлхийг баясган ном айлдах нэрийдлээр ордны хатад, гүнж, шадар барлагуудыг дуудуулсан нь Анугийн гоо дүрийг харах гэсэн халхавч байлаа.

Овоо индэрт идээний дээж өргөн, Галдан хутагт, дагалдан яваа хуврагуудын хамт ном уншиж байхад Ану охин өчигдрийн цэнхэр саатай торгон лавшигтайгаа залуу ламын зүг хулгай харц илгээн зогсч байв.

“Маргааш эрт хөдөлнөө..” хэмээн эцэгт нь өчихийг сонсоод “Галдан ламтан маргааш л яваад өгөх юм гэж үү?” гэж сэтгэл нь гонсойн цээж дотор нь харлаж байсан охин, өнөөдөр залуу хувраг яваагүйгээр барахгүй овоо индэрт тахил өргөх нэрээр өөр рүү нь сэм сэмхэн хараад

байгааг мэдээд сэтгэл нь бүүр ч их догдлон, болдог сон бол түүнтэй хоёулхнаа үлдэж ганц нэг үг солих юм сан гэж бодчихоод , тэр бодлыг нь хэн ч гадарлаагүй байхад ичсэндээ чихний нь омог улайх боловч зүрх сэтгэл нь аз жаргалаар эгшиглэн байлаа.

Хангай дэлхийдээ ерөөл уншин аршаан цацалж байсан Галдан ламтанд ч гэсэн тэрхэн агшинд Ану руу харангуут яг тийм бодол төрж билээ.

Овоонд тахил өргөөд буцах замд эцгийнх нь олон азарга адууны сор болсон хурдан зээрдийг унасан Галдан ламтан сартай жороо хээрээ унасан Ану охины дэргэд дөрөө харшуулан зэрэгцэж ирснээ:

-Ану гүнж тод үсгээр ном их сийрүүлж байна уу? хэмээн асуув.

-Т.тийм ээ.Сийрүүлж л байна хэмээн Ану түгдчив. Эр хүн гэж ийм л ухаан, самбаатай байдаг юм гэж үү? Ойрад түмний номын их багш болон заларч яваа хутагт хүн залуу сайхан бүсгүйтэй үүнээс өөр ямархан сэдлээр гэмгүй яриа өдөж болох билээ дээ.

Саяхан овоонд тахил өргөн, ерөөл ном айлдаж байхдаа сэм сэмхэн харц тулгараад байсан сайхан залуу ламтай ийнхүү дөрөө харшуулан зэрэгцэн явахын бахдамыг яана. Гэтэл юм ярих гэхээр догдолсон зүрх, ичиж гирэвшихийн зовлонг яалтай.

-Эцэг тань Таныг их сайхан бичдэг хэмээж байсан. Би төвд бичигт гэмгүй ч тод үсэгт Тан шиг гаргуун бишээ хэмээн Галдан хэлээд охины од шиг гялалзах жижигхэн нүд рүү эгцлэн ширтээд хоромхоноо харц буруулав.

-Аав минь намайг хэтэрхий даваадуулан магтаж байгаа юм хэмээн Ану ичсэндээ мориныхоо амыг татаадагтал жороо хээр нь бүдэрч эзнээ эгээтэй л эмээл дээрээс нь хийсгэчихсэнгүй.

-Ижий! хэмээн охин дуу алдахад хажууд нь явсан Галдан бугалга дээрээс нь зөөлөн дэмнэн эмээл дээр нь тогтооход охины толгой залуу ламтны бадируун цээжийг шүргээд тогтоход хоёул ичиж нүүр нь улс улсхийсэн ч зүрхэндээ зүйргүй их жаргалтай байлаа. Нэг мэдэхэд Галдан лам охины нарийхан цагаан бугуйнаас барьчихсан явжээ. Бодвол Ануг түшихдээ л зүүн гар нь түүний бугуйнаас барьж таарсан биз. Хоёр догдолсон зүрх, аз жаргалаар лугшин, нэг нь бугуйгаа бариулаад л баймаар, нөгөө нь дулаахан алгаа охины энхрийхэн биеийн тэр хэсгээс салгамгүй байсан ч хойноос нь хүмүүс гүйцэн ирж, аргагүйн эрхэнд өчүүхэн холдсон ч үе үе бие биений зүг харц илгээн ширтэлцсээр буцав.

Нэг нь сахил санваар хүртсэнээ энэхэн жаргалтай эгшинд тас мартаад, нөгөө нь сэтгэлийг булаасан энэ залуу эртэй хамт тэртээх Тарвагатайн нурууг хүртэл ч ийнхүү зэрэгцэн шогшуулмаар санагдана.

Гэвч удалгүй өргөөний тигт хүрч эцэг, эх, барлаг дагуулууд гүйцэн ирснээр сэтгэл догдлуулсан тэр зугаалга өндөрлөж билээ.

Залуу ламтан Очирт ханы сайхан охинд сэтгэл хоргодон Хөх нуурын баруун урагшаа Өндөр эргийн зусланд байх өргөөнд нь өнжин хонон саатмаар байсан ч, олон он жилээр барааг нь

хараагүй хайрт ээж, авгын хүү Багабандийн хамт Ойрадын төрийн хэргийг эрхлэн өөрийг нь шашны тулах баганаа болгохоор хүлээн суугаа зулай гишгэн төрсөн ах Сэнгэ хунтайж, мутрын адис хүртэхээр зам зуурт нь асар, майхантай хүлээн суугаа сүсэгтэн олноо бодоод маргааш нь арга буюу Ховог сайр дахь эцгийн ордны зүг замд гарчээ.

## Есдүгээр бүлэг

Охин хонгор сэтгэлийг нь үймрүүлэн, зүрх сэтгэлийн хойморт нь нэгэнт эзэн суусан Галдан ламтан Ховог сайр дахь Сэнгэ хунтайжийн ордон руу одоод гурав хонож байлаа. Түүний үгүйд олон өргөө, гэрүүд ярайсан Өндөр эргийн зуслан уй гунигаар дүүрчих шиг, Галданг угтан тосохдоо өмссөн саатай, цэнхэр торгон лавшиг нь өнгөө алдчих шиг, хөгжөөнт зуны цаг хоромхон зуур буцах намар болон гундчих шиг, Ану охины сэтгэл тогтохгүй хэд хонов.

Хэзээ ч өөрийг нь хатан буулган авахгүй, сахил санваар хүртсэн гэгээн хутагт хүнд сэтгэл зүрхээ өгчихсөн арван дөрөвтэй охин ирээдүйн амьдралаа бодохоос цээж харанхуйлан гунихарч байснаа номдоо шамдан, эрдэмт багшийнхаа хүүрнэх түүх шастирыг сонссоор бага багаар тайтгарч, хорвоогийн амьдралд эгэн ирэх шиг болжээ.

Харин түүний үе үесхэн санаа алдан, шөнөдөө уйлсны ул мөр, харзны ус шиг цовоо нүд нь бүүдийн байх болсныг ажигч гярхай хатан эхээс нь эхлээд, өргөөний дотоод хэрэг явдалд хайхрамжгүй хандах атал, охиндоо амин зүрхний хайртай, өвгөрч яваа эцэг нь хүртэл анзаарч, хоорондоо Анугийн хойшдын амьдралын тухай хөөрөлдөх болсон байв.

-Цастын орноос ирсэн залуу хутагтад охин маань сэтгэл алдсан бололтой. Яана вэ, эзэнтэн минь? Зөрүүд гэж туйлгүй амьтан. Нас нь даанч нялх. Урьд нь ийм байхыг нь мэдэхгүй л юм байна. Цаадхийгаа эхнэр хатан авч болохгүй санваартан хүн гэдгийг мэдэхийн цаагуур мэдэж байгаа атлаа гэнэн хонгор амьтан болохоор сэтгэл татагдсан юм байх даа. Хэд хоног хоол зоогоо ч хүртэхгүй, сэтгэл чилээгээд байх юм хэмээн Доржравдан хатан нэгэн орой эр нөхөртөө ярив.

Ногоон пийсүү соруултай гаансаараа тамхи нэрэн бодолхийлж суусан хан санаанд оромгүй энэ мэдээг дуулаад гансаа хаш суурь руу нэг тогшоод зангидсан хөмсөгөө тэнийлгэн баруун шанаагаа тулж зүүн хөмсөгөө өргөөд хатны царай өөд харж:

-Залуу багад аль тийм хөнгөн шохоорхол байхыг тэр гэхэв. Охин минь ухаан хэрсүү хүүхэд. Галдан хутагт ч аргагүй сайхан эр болж дээ. Тэгж байгаад мартагнана даа хонгор минь гэлээ. Гэвч аливаад дэндүү чигч, эр хүнд баймаар хэрсүү ухаантай охин нь үнэхээр Галданд сэтгэл алдарсан бол тийм чиг амархан мартаж чадахгүйг дотроо хүлээн зөвшөөрч, хатнаасаа ч илүү шаналж байв.

Эцэг эхийнх нь хооронд өөрийнх нь хайр сэтгэлийн тухай, хачин жигтэй загнах болсон тухайд нь ийм яриа болсныг охин огтхон ч гадарласангүй. Алтан саатай цэнхэр лавшигаа авдартаа эвхэж хийгээд багшийндаа очин номоо заалгаж, түүх шастир хүүрнэхийг сонсч эхэлснээр амьдрал нь энгүүн гольдрилдоо орох шиг болж залуу хутагтыг санагалзах нь арай багассан билээ.

-Монголын түүхэнд төр барьж асан анхны хатан Дөргөнийн тухай өнөөдөр шавь чамд би хүүрнэх болно хэмээн багш нь хэлэв.

Ану сурсан зангаараа өвдгөө нугалан баруун гараараа шанаа тулан суугаад багшийнхаа хүүрнэлд анхаарлаа хандуулаад:



-Багш аа,эхнэр хагад төр барьж болдог юм уу?Би ер дуулаагүй юм байна. Төр барих, дайн тулаан хийх нь эр хүний эрхлэх үйл бус уу? хэмээн бодлогошронгуй асуув.

-Түүх шастирт тийм үе байсаан. Төр барьж Монгол улсыг хүчирхэгжүүлж явсан Мандухай сэцэн хатны тухай чи мэднэ шүү дээ.

-Тийм л дээ. Гэхдээ тэр чинь балчир Батмөнх даян хаантай дэр нэгтгээд, түүний нэрээр төр барьж байсан гэж сонссон юм байна.

- Гэхдээ л Мандухай хатан төр барьж байсан. Харин Дөргөнийн хувьд бол бүр өөр. Чингис хааны гутгаар хөвүүн Өгөдэй хаан эцгийн ор залгасныг чи “Нууц товчоо”-ноос уншиж мэдсэн. Өгөдэй хаан төр барихдаа эрдэмтэн мэргэдийг сорчлон сонгож, төрийн албанд хүчин зүтгэх хууль журам тогтоох, Их хуралдайн дэг ёсыг шинэчлэх, алба гувчуур татах нэгдсэн хууль гаргах, хуурай зэлүүд говь талд худаг гарган бэлчээрийг устай болгохын зэрэгцээ, дайнд үрэгдсэн эр цэргийн ар гэр, өнчдийг тэтгэх улсын санг байгуулах зэргээр мэргэн бодлого явуулж “Өршөөл ихт Өгөдэй хаан” хэмээх алдарт хүрсэн их эзэн хаан байлаа.

Чухам Өгөдэй хааны үед одоо энэ толгой түүрүүнд гараад буй Зүрчидийн Алтан улс,Төвд, Солонгудыг эзлэн тохинуулж, нийслэл Хархорумыг өргөтгөн сэлбээд зогсохгүй “Суурин”, ”Тосох” нэртэй шинэ шинэ хот балгадыг байгуулсан түүхтэй юм.

Өгөдэй хааны зургадугаар хатан Дөргөнэ эр нөхрөө тэнгэр болсноос хойш аргын 1242 оноос эхлэн дөрвөн жил дангаараа төр барьсан байдаг. Дөргөнэ хатныг түүхийн сурвалж бичгүүдэд Наймажин, буюу Наймалжин ч гэж тэмдэглэсэн нь найман аймгийн угсааны хүн гэсэн утгатай агаар нэгэн болов уу.

За тэгээд, Дөргөнэ бол мэргид аймгийн Тогтох бэхийн ууган хүүгийн гэргий байсныг Чингис хаан мэргидийг дайлахдаа олзлон Өгөдэйд өгсөн гэдэг. Дөргөнэ Өгөдэйн хатан болоод Гүюүг, Годан, Хүлчүг, Холчар, Хадаан нэрт таван хөвүүн төрүүлсэн гэдэг юм.Төрөлхийн зоримог,шударга эрс зантай, ухаан хурц Дөргөнэ Өгөдэйн олон хатны дотроос эр нөхрийнхөө хайр сэтгэлийг илүү булааж чаджээ.

Өгөдэй хаан ширээг эзлэн арван гурван жил суухдаа монгол төрийн түүхнээ гайхамшигтай гавьяа байгуулсан ч эцэстээ бор дарсанд шунан дурласаар, төрийн хэргээ цалгардуулах болсон тул Дөргөнэ их хааныг амьд сэрүүн байх үеэс нь засаглах болсон байна. Энэ хатан төрийн хэрэгт оролцох болмогц лалын шашинт худалдаачдыг дотночлон дэмжих болсны нэг нь Абдурахман хэмээх хүн байж. Хожим Өгөдэй хаан Абдурахмантай хамт бор дарс хүртэж байгаад учир битүүлгээр тэнгэрт хальсан ч гэдэг. Тийнхүү Өгөдэй хаан зуурдаар наснаас нөхчихдөө хаан ширээг хэнд залгамжлуулахаа гэрээсэлж амжаагүй тул Монгол гүрний их хааны ширээг булаалдсан алтан ургийнхны тэмцэл, самуун дэгджээ. Өгөдэй хаан амьд сэрүүндээ дэргэдээсээ салгадаггүй хайрт хатан Мөгэдээ “Чи төрийн хэргийг хамаарч, Ширэмүнийг дэмнэн хаан ор залгамжлуулаарай” хэмээн аман захиас хэлж байсан гэдэг. Ухаалаг, ааль сайт Мөгэ хатан ч насалсангүй, хааны хойноос удалгүй халин одмогц, Дөргөнэ хатан алтан ургийнхан болон нэр нөлөөтэй ноёдыг Далан даваа гэдэг газарт урин Их хуралдайг хийлгэжээ. Өгөдэй, Толуйн угсааныхан их хааны орыг булаалдан маргаан дэгдсэн тул Их хуралдай эцсийн шийдэлд хүрч чадсангүй,Дөргөнэ хатанд төрийн хэргийг түр

хамааруулахаар тогтжээ. Дөргөнэд төрийн хэргийг хамааруулахад тэр үед их эзний хөвүүдээс ганцаараа амьд сэрүүн байсан Цагадай сүрхий нөлөөлсөн ажгу. Түүнчлэн арга заль, гүйлгээ ухаан ихтэй Дөргөнэ ч элдэв үнэт бэлэг шангаар ноёдыг өөртөө татан, хаан ширээ залгамжлагч Ширэмүн хунтайжийн балчир бага байсныг дулимдуулсан хэмээн персийн түүхч Рашид Аддин тэмдэглэсэн нь бий хэмээн Дүүрэн мэргэн хүүрнээд дал мөрний хөшөөгөө гарган суниахад Ану охин ч өвдөг дээрээ гараа тавин шанаа тулан суусаар хөшсөнөө сая л анзаарч суудлаа засаад:

-Миний бодож байгаагаар хаан ширээг эзлэхийн төлөө бэлэг шангаар ноёдыг татах нь зөв шүү дээ. Дөргөнэ хатан үнэхээр зориг төгөлдөр, арга ухаантай хүн байж дээ хэмээгээд шүүрс алдав.

Багш нь хүд хүд инээгээд зэс аягатай зэлгээн цайгаа хэд балган хоолой чийглээд:

-Чиний хэлдэг зөв. Эрх мэдэл хэмээх зүйлийн амтанд орсон хүн амь насаа ч огоорон тэмцэлдэх нь зүй. Дамаан бүсгүй хүн тэр их тэмцэл дунд арга залиар төрийн эрхийг булаана гэдэг үнэхээр ухаан төгс байсны тэмдэг. Дөргөнэ хатан ийнхүү төрийн эрхийг гартаа оруулсныг Өгөдэй хааны ахан дүүс, алтан ургийн ноёд, тэнгэрт хальсан их хааны дотны түшмэл Чингай чинсан, лал шашинт түшмэл Мухамед Ялавач, Өгөдэйн хоёрдугаар хөвүүн Годан нар хамгийн ихээр дургүйцсэн ажээ.

Дөргөнэ хатны явууллагад буруу номын лал шүтлэгт Фатима гэдэг эм тусалж байжээ. Фатима Персээс олзлогдон ирсэн ов заль ихтэй, ордны дотор хов хутгахдаа гаргуун эм байж. Чингай чинсан, Мухаммед Ялавач нарын мэргэн түшмэлүүдийг Дөргөнэд гүтгэн өстөн болгож, Годан хунтайжийг хорлосон буруутан нь Фатима гэж түүхэнд тэмдэглэсэн нь бий. Дөргөнэ хатны төр барьж буйг эсэргүүцэж асан бас нэгэн ноён бол эзэн Чингисийн дүү Отчигин ноён юм. Тэр цагт Бойр, Далай нуурын хоорондуур нутаглаж асан Отчигин ноён цэрэглэн Хархорумд ирснийг хаан ширээ булаах, эс бол Дөргөнийг зайлуулан Гүюгээр хаан ор залгамжлуулах гэсэн хоёр зорилгын аль нэгийг бодож явсан хэмээн түүхчид тайлбарладаг. Хэрэг явдал буруугаар эргэх янз ормогц Отчигин “Би хаан ширээнд санаархаагүй. Өгөдэй хааны таалал төгссөний уй гашуу тайлах ёслолд ирсэн билээ” хэмээгээд цэргээ татсан гэдэг.

Дөргөнэ хатны ууган хүү Гүюг ч их хааны орыг залгахаар санаархаж байсан ч төрсөн эхийн өөдөөс эрслэн тэмцэх зориг хүрэхгүй байжээ. Чингээд алтан ургийнхан дунд хагарал үүсч, Зүчийн хүү Бат, Толуйн угсааныхан Гүюүгийг эсэргүүцэж, харин Өгөдэй, Цагадайн удмынхан дэмжиж байх үед Дөргөнэ Их хуралдайг зарласан гэдэг. Нэгэнт Гүюүгийг хаан ор суухыг эсэргүүцэж байсан Бат олон шалтаг хэлэн ирээгүй тул аргын 1246 оны зун Хар хорумын зуны ордонд Их хуралдай эхэлж, эхийнхээ дэмжлэгээр Гүюүг хаан ширээ залгамжилсан юм. Хүүгээ хаан ширээнд залуулсан Дөргөнэ хатны эрх сүр буурахгүй байсан тул Гүюүг хаан эхийнхээ хань хамсаатан Фатима тэргүүтэн лал мөргөлтнүүдийг баривчлан Годан ноёныг хорлосон ял тулган алж, хаан ширээнд санаархсан хэмээн Отчигин ноёныг цаазалжээ. Үүнээс хойш удалгүй Дөргөнэ хатан ч нас баржээ.

-Багш аа, та Дөргөнэ хатныг буруутай гэж үзэх үү? хэмээн Ану асуулаа.

-Мунхаг миний бодлоор харин ч Дөргөнэ хатан алтан ургийнхны хооронд цуст дайн гарахаас

сэргийлж, цаг төрийг намжааж байж, Гүюүгийг их хааны сууринд залж чадсанаараа гавьяатай хүн.

Сар гарч, тэнгэрт одод түгжээ. Ану охин бичгийн гэгдсэн өөрийнхөө шинэхэн өргөөндөө орж, хөнжилдөө шургамгагц алтан ургийнхны тэмцэл дунд арга ухаанаар төрийн эрхийг дөрвөн жил атгаж чадсан ч учир битүүлгээр насан эцэслэсэн Дөргөнэ хатны түүхийг бодон бодсоор зөөлөн бөхөд автжээ.

Маргааш нь охин дараачийн хатан хэн байх бол? гэсэн сониучхан бодолдоо хөтлөгдсөөр багшийндаа очлоо.

Багшийнх нь гэргий түүнийг Самаркандаас өгчилгөсөн идээ хэмээн амтат халвагаар дайлав.

-Манайхны хольсон тостой л төсөө санагддаг юм. Надад бол халва дэндүү нялуун, бялуурмаар амттай эд. Дотор муу байхад бүүр ч дэмий хэмээн багш нь ярин, аагтай хонгор цайндаа самнаа боов хөвүүлэн суух аж.

-Би бол халванд дуртай. Аав хааяа надад авчирч өгдөг юм. Багш аа, та өнөөдөр надад ямар хатны түүх хүүрнэх вэ? хэмээн Ану асуув.

-Амтганд дурладаг хүнд түүх хүүрнэхгүй ээ хэмээн багш нь доогтой хэлээд соёо сахлаа шувтран хүд хүд инээв. Харцны өнгөнөөс нь наадам хийж буйг мэдсэн Ану “Тэгвэл би энэ жижиг цартайг бүгдийг нь идчихээд харилаа яршиг” хэмээн өөдөөс нь тохуу хийлээ.

-Сав хоосон буцаахгүй нь ээ. За наад золигийн нялуун юмаа хүртчихээр наашаа суу даа хэмээн багш хэллээ.

-За, шавь чамд Чингис хааны отгон хүү Толуйн хатан Сорхагтань бэхийн түүхийг хүүрнэе дээ. Толуй бол ах Өгөдэй хааныг хүнд өвчинд шаналж байх цаг дор “Хаан ахын амийг хэлтрүүл.Хариуд нь би өөрийн биеэр үхье” хэмээн тэнгэрт амиа өргөснөөс золиос болон нас нөхчсөн домогтой.

Түүний хатан Сорхагтань ухаан, эвийг эрхэмлэгч зан, өглөг хишигт өгөөмөрөөрөө түүхэнд мөнхөрсөн бүсгүй юм.Түүхэн сурвалжид Сорхагдай, Сорогдай гэхчлэн олон янзаар бичигдсэн энэ хатан Хэрэйд аймгийн захирагч Ун ханы дүү Жаха Хамбын охин юм.Аргын 1203 онд Эзэн Чингис Хэрэйдийг дайлж мөхөөгөөд Жаха Хамбын хоёр охиныг олзлон эгч Ибагийг өөрөө хатан болгож, дүү Сорхагтанийг нь отгон хүү Толуйд өгсөн гэдэг. Харин хожмоо дайн байлдаанд онцгой гавьяа байгуулсан эрэлхэг жанжин Сүвээдэй баатрын ачийг бодож Ибаги хатнаараа шагнажээ.

Сорхагтань Толуйн хатан болоод Мөнх,Хубилай, Хүлэгү,Аригбөх хэмээх дөрвөн хөвүүн төрүүлсэн нь цөм алдар цуугаа мандуулсан хаан, баатар эрс болж, шастир түүхэнд мөнхөрсөн билээ.

Толуйг насан эцэслэхэд нь Өгөдэй Сорхагтанийг Гүюүг хүүдээ хатан болгох гэсэн ч “Хааны зарлигийг хэрхэн сөрж болох.Гэвчиг өчүүхэн би өнчрөн хоцорсон хөвүүдээ өсгөн

хүмүүжүүлж, гарыг нь ганзаганд, хөлийг нь дөрөөнд хүргэхийг илүүтэй хүсэмжилнэм” хэмээснээр их хаан түүнийг хүүгийнхээ хатан суулгах бодлоо орхисон гэдэг.

Толуйг насан эцэс болоход Өгөдэй хаан түүний харьяат арван хоёр түмэн цэрэг, албат иргэдийг бүгдийг бэлбэсэн хатан Сорхагтаньд захируулан Хэнань, Сианьши мужаас таслан өмчлүүлжээ. Сорхагтань хатан эр нөхрөөс өвлүүлсэн харьяат цэрэг, албатаа дөрвөн хөвүүндээ эн тэнцүү хуваан захируулж, их хаан, эрэлхэг жанжин болгон хүмүүжүүлсэн юм.

Өөрөө загалмайн шашинтай Сорхагтань хатан аливаа өөр шашныг хүндлэн эгэл ядууст өглөг хишиг өгөөмрөөр түгээдэг байв. Нэгэн удаа мянган лан шижир алтаар Бухар хотод мянган хөвүүнийг сургах лалын шашинтны сургууль байгуулсныг олон үед дурсан “Хатны сургууль” гэдэг байж.

Бас нэгэн удаа Өгөдэй хаан Сорхагтаний албат хоёр аймгаас гурван мянган хүнийг таслан хүү Годанд өгсөнд тэдгээр аймгийн ноёд хатанд зарга мэдүүлэхээр иржээ. Арга ухаант, уужуу тайван Сорхагтань хариуд нь” Зарга мэдүүлж буй тань шударга хэрэг ч гурван мянган албат гэдэг харин ч миний хөвүүдэд гарз болохооргүй өчүүхэн бага тоо. Ийм өчүүхэн хэргийн тулд их хаанд зарга мэдүүлэх нь гутамшиг. Их хаан гэдэг бид цөмийн эзэн тул зарлигийг нь зөрчиж үл болох билээ” гээд буцаасан байна. Энэ тухай Өгөдэй хаан сонордоод Сорхагтань хатны эрдэм ухаан, уужуу холч бодлыг бишрэн төрийн хэрэг хэлэлцэхэд урьж оролцуулан үг сургамжийг нь сонсох болжээ.

Хожмоо Өгөдэй хааныг тэнгэр болсны дараа Дөргөнэ хатны төр барьж байх цаг дор дов бүхэнд нэг хан тодорч, татвар гувчуур дураараа хураан, хөл толгойгүй үймээн дэгдэж байхад Сорхагтань хатан л хөвүүдийн хамт төв төлөв байсан тул Гүюүг хаан ширээнд заларсны дараа хатныг хөвүүдийнх нь хамт шагнан хөхүүлж, алтан ургийнханд үлгэр дууриал болсныг нь тэмдэглэж байсан гэдэг. Алтан ургийнхны дотоодын эв нэгдэлд туйлын их санаа тавьж байсан Сорхагтань хатан, Гүюүг хаан өөрийг нь хаан ширээнд залах Их хуралдайд ирээгүй Бат хаанаас өшөө авахаас сэрэмжлэн, түүнийг Эмилийн зүг биеэ сувилуулахаар явсныг сэжиглэн Батад “Гүюүг хаанаас сэрэмжтэй бай” гэсэн хэл өгч байжээ. Энэ нь ч эцэстээ их хүү Мөнхийг хаан сууринд залагдахад Батаас дэмжлэг авахад нь нэмэр болсон гэлцдэг.

Аргын 1251 онд Гүюүг тэнгэрт хальж, шинээр их хаан өргөмжлөх хуралдай хийхэд алтан ургийнхан аанай л хоёр хэсэгт талцан хагаралдсаар эцэст нь ураг төрөлдөө хамгийн ахмад нь болох Батыг хаан ширээнд залахаар тогтсон ажгу. Гэвчиг Бат хаан энэ саналыг хүлээн авахын оронд Толуйн ахмад хөвүүн Мөнхийг их хаанд өргөмжлөх нь зүйтэй гэжээ. Ийнхүү Мөнх хаан ухаант эхийнхээ ачаар Монголын их хааны сууринд залагдсан түүхтэй бөлгөө. Мөнхийг хаан болмогц эх нь “Чи өршөөлт засаг явуулах нь өлзийтэй. Хаймиш хатан болон хөвүүдийг нь цээрлэлээс хэлтрүүлэх нь зөв” хэмээн зөвлөсөн ч Мөнх хаан Сорхагтань хатны ухаант зөвлөгөөг нь үл хэрэгсэн, Өгөдэй, Цагадайн угсааныхныг шийтгэсэнд хилэгнэн буруушааж байсныг түүхэнд тэмдэглэсэн байдаг.

Сорхагтань хатан аргын 1252 оны цагаан сарын баяраар тэнгэрт хальсан гэдэг. Алтан ургийнхан дотор өндөр нэр хүндтэй, олны хүрээлэл дунд байсан эхийгээ таалал төгсмөгц Мөнх хаан төрийн эрх булаалдсан Гүюүгийн хатан Хаймиш, ач хүү Ширэмүнийг цаазалсан юм. Энэ нь эзэн Чингисийн угсаа алтан ургийнхныг үүрд өстөн болгон эв найрамдлыг

таслахад хүргэсэн юм даа.

Алтан ургийнхны аль ч талд өндөр нэр хүндтэй явсан Сорхагтань хатны гавьяа зүтгэлийг дурсан хоёрдугаар хөвүүн Хубилай нь Юань гүрний эзэн болоод олон цол гуншин шагнасан байдаг. Персийн мэргэн түүхч Рашид Ад-Дин “Сорхагтань хатан бол сод ухаан, авьяас чадвараараа бүх дэлхийн эмэгтэйчүүдийг тэргүүлж чадах ухаантан байсан” хэмээн тэмдэглэжээ гээд багш нь яриагаа дуусгажээ.

Зуны дунд сар гарлаа. Нар, хур хосолсон дэлгэр зун. Очирт ханы өргөө зусаж буй Өндөр эргийн ойролцоох Тохомын тойром хэмээх жижигхэн нуурын эрэг дээр Ану дагуул охин Мандарваагийн хамт сууна. Мандарваа нь Анугаас хоёр насаар эгчмэд, биеэр илүү өндөр дэнхэр авч номын ухаан, цэргийн эрдмээр хаана нь ч хүрэхгүй тул аяндаа эзэн авхайн дохио зангааны аяар амьдрах болжээ.

Тохомын тойромд энэ жил хоёр хун зусч, хавийн амьтан ирж үзэсгэлэн гоо, хоёр биедээ үнэнч энэ хос шувууг үзэн нүд хужирлаж байлаа. Биеэр арай том эр хун нь түрүүлэн нисч ирээд тойромд хөвж эхлэхэд хойноос нь эм хун гунганасаар усны мандалд буухад цасан цагаахан биеийнх нь аясаар усан дээгүүр дугуй дугуй долгио хүрээлснээ замхран алга болов. Эр хун эм рүүгээ хөвж ирээд хоёр шувуу гоо хүзүүгээ ороолдуулан эрхлэхийг хараад Ану Галданг бодон, “Түүнтэй энэ Тохомын тойрмын эрэг дээр эл хоёр хун шиг эрхлэлдэн суух сан. Аль эвэл Шар хоолой дундуур ижил зүсмийн хурдан жороо морь унаад уралдан наадвал хэчнээн сайхан бэ! Тэр овоо индэрт тахил өргөөд буцахад миний морь бусгаад түүний цээжийг түшихэд зүрх хэчнээн аймшигтай цээж бөмбөрдөн цохилон оо. Хайр дурлал гэдэг нь энэ юм байх даа. Азгүй хүн юм даа би. Гэргий хатан хэзээ ч үл буулгах хувраг санваартан хүнд зүрх сэтгэлээ өгчихдөг” хэмээн бодолд дарагдан суулаа.

Мандарваа Ануг ажиглан чимээгүйхэн суух зуур Жанчивдорж дарханы ихэр хөвүүдийн нэг Чилэдү өөрийг нь үзээд санаа алдан, уулзахаараа дөлөөд байдаг болсныг санан инээмсэглэв.

-Чи юунд инээв? Уйлсныг бүү асуу, инээснийг асуу гэдэг юм хэмээн Ану гэнэт түүнийг шалгаав.

Мандарваа бодлоосоо өөрөө ичин нүүр улайгаад:

-Юу ч биш ээ. Шал дэмий юм бодоод хэмээн дүйвүүлж босоход нь Ану лавшигийн хормойноос нь татан суулгаад:

-За хэлчих л дээ. Дэмий юм бодоод хүн инээдэг юм уу? Чи бодвол дурлал хайрын тухай сэтгээд инээмсэглэсэн буй за. Мөрий тавьсан ч болж байна. Тийм үү? За хэлчих хэмээн шаргуу гэгч нь тулган асуув.

-Чилэдү л байхгүй юу. Намайг хараад нүүр нь улайгаад зугтдаг болчоод байгаа. Түүнийг бодоод л инээсэн юм хэмээн Мандарваа үнэнээ өчингүүтээ, хариуд нь Анугийн нууцыг шалгаах хүсэлд автан:

-Би танд бодсоноо л өчлөө. Харин та юунд сүүлийн үед ботгоо санасан ингэ шиг уй гунигт

авган сүүрс алдаад байдаг болов?

“Чилэдү юм л бол авхай сэлмээ ирлүүлнэ үү? хэмээн өөрийнх нь өргөө рүү гүйх аян шалтаг хайх болсон нь Мандарваатай холбоотой байсныг сая л ухаж ойлгоод инээмсэглэчихсэн суугаа Ану хэзээ нэгэн өдөр өөрт нь хэн нэгний тавих байсан энэ асуултанд тулгамдан өнөөх хурц хэл ам, эршүүд бардам зан нь хаачив? гэмээр сандчин ичихээрээ тэгдэгчлэн аанай л чихнийх нь омог улайж:

-Худал бүү хэлээд бай чи. Би хэзээ тэгж ботгоо санасан ингэ шиг байлаа хэмээн ундууцаад “За хоёулаа харья.Гэрээ мартсан Гэсэрүүд биш дээ. Багшийн сийрүүл гэсэн судар яагаа ч үгүй байгаа.” гээд хормой хотоо гүвэн босч морь руугаа алхав. Галдангийн тухай бодол нь хэнд ч хэлэх ёсгүй, сэтгэл зүрхний нь нандин нууц байсны учир бусадтай хуваалцмааргүй байлаа.

Өргөөний тэндээс Балсан хатирч хүрнээ унаад ирж яваа үзэгдэнэ. Эхийн ангир уургаа хуваан хөхсөн энэ хөвүүнийг охины амь сахигч шадар хамгаалагч болгохоор хан,хатан хоёр нэгэнт шийдсэн тул Очирт цэцэн хантны олон мянган агтны дотроос энэ хурдан хүлгийг Балсанд зүслэн өгсөн билээ.

-За тэр таны гэрэлтэй өдрийн сүүдэр, бүгээн шөнийн дагуул ирж явна гэж Ану нэгэнт нууцаа нээх бодолгүй байгаад урам хугарсан Мандарваа хэлээд морь өөдөө очив.

Анугийн өнөөдөр бариулж авчран унасан өндөр цоохор морь ялаархан, ганган толгойгоо хаялан дүүхэлзэх нь Мандарваагийн хашин саарлын дэргэд аргагүй л аргамаг хүлгийн жавхааг гайхуулах аж. Оросоос бэлгэнд ирсэн гоолиг өндөр гүүнээс төрсөн, сүүн цагаан дээр хар цоохор ганган зүстэй авч ааштай, ороо, хурдан гэж нүд цавчлах зуур бараг саахалтын зайд онцгой сум шиг тасран давхидаг энэ эрлийз морь бүсгүй хүн унахад зохиролтой ховор зүсмийн сайн хүлэг атал ялаархан бусгахдаа л эзнээ эмээл дээрээс нь шидчих гээд байдаг тул хантан хайртай охиндоо унуулахдаа дурамжхан байдаг билээ.

Өнөөдөр эцэг нь Хамийн зүгт худалдааны хэлэлцээр хийхээр хэдэн хоногийн аянд мордон, бөгс өндийх чөлөөг завшаалан Ану агтчинд урьд өдөр нь хэлж байж ороо цоохорыг бариулан унаж хорхойгоо дарж буй нь энэ ажгу.

-Балсан чинь миний хэвтүүл болох юм чинь арга байж уу гэж Ану хэлээд ороо цоохорынхоо суман дэлийг илбэн зогсохдоо, нүүр өөд нь шавах ялааг зүүн гараар үргээн Сэнгэ ханы өргөө байх алс хойд зүгийг ширтэнэ.

-Тэхдээ тэр чинь танд сайн гэдгийг мэддэгүйм уу?

-За, Балсан уу даа?Нэг эхийн сүүг хуваан хөхсөн ах дүү хоёр байхгүй юу, бид чинь гэж Ану хэлэх зуур Балсан давхин ирж:

-Ану! Мордохоосоо өмнө хүлээж байгаарай гэсээр эмээл дээрээсээ үсрэн буугаад морио тушив.

-За юу болоов?Түймэрт хөөгдөж, түйрэнд уруудсан зээр шиг хашгичин давхиад гээд охин тас тас хөхрөв.

-Ороо цоохорыг бариулж унасныг тань мэдээд ахайтан сэтгэл чилүүрдэн намайг хойноос тэнь илгээлээ. Алив би чамайг, үгүй чамайг гэнэ шүү, таныг мордуулж өгье гээд ирж тохой дээрээс нь түшин моринд нь мордуулж өгөөд, өөрийнхөө морь өөд явах зуур “Бултаараа хамтдаа өргөө рүү алхуулъя. Мориндоо ташуур бүү өгөөрэй. Наадхи тэнь таныг аваад давхичихаж мэдэх ороо адгуус байгаа юм. Ахайтны сэтгэл зовж байгаа гэж жигтэйхэн” гэлээ.

Хантны өргөөний зарц, барлагууд Ануг мэндэлсэн цагаас нь эхлэн та гэж авгайлж сурсан байтал хамт тоглож өссөн хэдэн хүүхэд л саяхныг хүртэл “чи би” –дээ хүрэн дотнотчилдог байсныг Доржавдан ахайтан “Эзэн боолоо ялгаж сур. Энэ өргөөний дотор хэн ч Ануг “чи” гэх ёсгүй” хэмээн зарлигдсанаар хүүхдүүд саяхан болтол чоно тарвагацан, хорол наадаж, бөгцөг няслан, бяцхан гартаа хонины хоргос\хоргол\ нууж, “утас авах”, буур ботго, цагаан тэмээцэх зэргээр цугтаа тоглон, уйлж дуулж өссөн найзаа “Та” гэх нь анхандаа аманд нь багтахгүй байснаа аажимдаа дасч хэвшсэн ажгу.

Хүүхдүүд эхлээд морьдынхоо амыг сул тавиад алхуулан явтал Анугийн дүрсгүй зан хөдлөн мориндоо ташуур өгмөгц ороо цоохор сум шиг цойлон хурдалж, цөс нь хөөрсөн Балсангийн хатирч хүрэн хойноос нь элдэн давхихад хашин морьтой Мандарваа ташуураа гозолзуулан хоцров.

Тэр өдөр багш нь Ануг хүүхэд юм хойно тоглож наадаж, хөшсөн биеийн чилээгээ гаргаг гээд ирэхгүй байж болно гэсэн ч түүх шастир яриулах хорхой нь хөдлөөд болсонгүй тул нар ташсан хойно очиж Гүюүг хааны их хатан Огул Хаймишийн тухай хүүрнэлийг нь сонссон билээ.

-Гүюүг хаан бол Монголын их хаан Өгөдэйн ахмад хөвүүн бөлгөө. Ухаант хатан эхийн гавьяагаар их хааны сууринд заларсан Гүюүг хаан алтан ургийнхны дотоодын эв эвдрэлийг намжаахад чармайн зүтгэж, хууль цаазыг шинэчлэн, Монгол гүрний хүн амыг тоолон, алба гувчуурыг журамлан тогтоох зэргээр төрд мундашгүй их гавьяа байгуулсан ч хоёрхон жил засагласан юм.

Гүюүг хаан эцгийнхээ үед монгол төрд чин шударгуугаар хүчин өргөж явсан Чингай чинсанг шадар түшмэлээрээ томилоод, Мухаммед Ялавачийг Хятад оронд, Масудбекийг Туркестанд, Мавенехарыг Харосон, Перс, Азарбейжанд, Аргуныг Гүржид захирагчаар томилон эцэг өвгөдийн эмхлэн хураасан их гүрнийг тохинуулан түвшитгэх үйлсэд багагүй хүчин өргөсөн хэмээн түүхэнд тэмдэглэсэн байдаг. Гүюүг хаан Их Монгол улсад үл захирагдаж алсуур биеэ даах бодлого явуулж байсан Алтан ордны улсын хаан Батыг гэнэдүүлэн цохих бодолтой аргын 1248 он, шар бичин жилд өрнө этгээдэд аялж яваад Самарканд балгадын хавьцаа гэнэт тэнгэрт хальсан байна.

Гүюүг хааны их хатан Огул Хаймиш хатан хурц ухаан, холч бодлоороо түүхэнд үлдсэн эмэгтэй байсан бөлгөө. Огул Хаймиш хатан Ойрад аймгийн тэргүүн Худуга бэхийн охин болой.

Тэрбээр Гүюүг хааныг насан эцэслэмэгц дараагийн их хаан Мөнхийг хаан ширээнд суутгал гурван жил төрийн хэргийг хамаарсан бөлгөө.

Мөн л гэнэт тэнгэр болохдоо өөрийнхөө оронд хаан суух залгамжлагчаа гэрээсэлж завдаагүй Өгөдэй хааныг нас эцэслэсний хойно Дөргөнэ хатныг дөрвөн жил төр барьсны дараа их хуралдай болж, тэрхүү Их хуралдайгаар Гүюүгийг хаан ширээнд залахад тэрбээр “Намайг таалал болоход бас миний ураг удмынханд хаан ширээг залгамжлуулах юм бол би хаан суухыг зөвшөөрнө” гэсэн болзол тавьсан гэдэг. Их хуралдайд оролцсон алтан ургийн ноёд ч “Таны хойч үед өвсөнд ороовч үхэр тоож идэхгүй, өөхөнд хулдавч нохой тоож шиншлэхгүй амьтан төрөвч бид бүхэн өөр бусад удмаас хаан ширээнд залахгүй” гэж айлтгаж байжээ.

Гэвч хоёрхон жил төрийн эрх бариад дөчин хоёр насандаа ид зуны халуунаар Туркестаны нутагт тэнгэр болсон Гүюүг хааны шарилыг эх нутагт нь авчирч завдсангүй, тэнд нь хөдөөлүүлсэн бөлгөө. Гүюүг хааныг тэнгэрт хальсны дараа эзэн Чингисийн дөрвөн хөвүүний үр ач нар аанай л хоёр бүлэгт хуваагдан Зүчи-Толуйнхан нэг талд, Өгөдэй-Цагаадайнхан нөгөө талд зогсон хаан ширээний төлөө тэмцэл эхэлсэн тул арга буюу хааны бэлбэсэн хатан Огул Хаймиш төрийн эрх барихад хүрчээ. Гүюүг ханы олон хатан дотроос хамгийн ухаалаг, ултан ургийнхны дотор нэр нөлөө ихтэй байсан нь Огул Хаймиш юм. Хадам эх Дөргөнийн ов заль, хорон явууллагыг огт таашаадаггүй байсан Огул Хаймиш өөрөө хууль цаазыг дээдлэн, үнэнч шударгуу ёсыг сахидаг, чигч шулуун зантай хүн байж. Эр нөхрөө хаан ор эзлэхэд “Цаашид Өгөдэйн угсааныханд хаан ширээ залгамжлуулбал их хаан больё” гэсэн болзол тавих зөвлөгөөг Огул Хаймиш хатан өгч байсан гэж түүх сурвалжид тэмдэглэсэн байдаг. Гүюүгийг аян замд гэнэт насан эцэслэхэд Чингис хааны удмынхны дотор хамгийн ахмад настайн хувьд Бат хаан Огул Хаймиш хатанд захидал илгээн “Их хаан наснаас нөхчсөний бэлбэсрэлийн ёслолыг гүйцэтгээд төрийн хэргийг Огул Хаймиш та эрхийн дагуу хамааран мэдэж, онц чухаг хэргийг шийтгэхдээ мэргэн түшмэл Чингай чинсангийн санал бодлыг сонсч байгтун” хэмээжээ. Ийнхүү алтан ургийнхны хамгийн ахмад нь болсон Бат хааны соёрхлоор Огул Хаймиш хатан төрийн эрхийг барьсан ч түүний төрүүлсэн Хожа,Нагу гэсэн хоёр хүү нь эхтэйгээ төрийн жолоо булаалдан хаан ширээний төлөө хэрүүл тэмцэл хийж эхэлсэн юм. Төрийн чинсан Чингай, Огул Хаймиш хатан нар түрүүчийн Их хуралдайн гаргасан батламж бичгийн дагуу их хааны суудалд гагцхүү Өгөдэйн угсааны хүн залрах ёстой хэмээн үзэж, “Гүюүгийн угсаанаас өвсөнд ороовч үхэр тоож хивэхгүй, өөхөнд хулдавч нохой тоож шиншихгүй амьтан төрсөн ч их хааны сууринд зална “ гэсэн ам өчгийг байн байн уншин сануулж байсан ч Бат, Мөнх тэргүүтэй Зүчи-Толуйн угсааныхан хөдөлшгүй зогссон тул төрийн эрхийг тэдэнд өгөхөөс өөр аргагүйдсэн ажээ. Тэгээд ч нөгөө талд эвсч байсан Цагадай-Өгөдэйн угсааныхан хоорондоо хагаралдаж,Огул Хаймишийн хоёр хүү Хож,Нагу хоёр хүртэл өөрсдийнхөө эзэмшил нутагт бие даан дураар аашилж, эхтэйгээ төрийн эрх булаалдаж байсны улмаас бусад сурвалжит язгууртнууд алба гувчуур зоргоороо хураан, монгол түмний хилэн цухал туйлдаа хүрч байсан гэдэг. Ийнхүү цаг төр тогтворгүй байсантай зэрэгцэн, дайны хажуугаар дажин гэгчээр ган гачиг нүүрлэснийг далимдуулан Бат хаан санаачлагыг гартаа авч Их хуралдай зарлажээ. Ноёдын чуулганы өмнө Бат хаан Монгол гүрний их хааны суудалд Мөнхийг залах саналаа захидлаар илгээхдээ ”Мөнх бол ертөнцийн сайн мууг таньж хамаг хэрэг явдлыг үзсэн, олон орныг цэрэглэн дайлж, ямагт ялж гавьяа байгуулж байсан төрд зүтгэлтэй, түмэнд нэртэй, авьяас билэг төгөлдөр, эрэлхэг баатар, хатан зоригт, бүхнээс онцгой, арга ухаан мэргэн хүмүүн тул түүнийг хаан сууринд залах юм бол



наран ургахаас, жаргах хүртэлх өргөн уудам нутгийг эзэлсэн их Монгол гүрнээ төвшитгөн тохинуулж чадна. Тэр цагт энэ улс гүрэн, эгэл ард, баатар эрс, хаан хөвүүд бидний жаргал золтой амьдрал баталгаатай болж, хамаг улсаа мандуулна” хэмээсэн гэдэг.

Ингээд нэг талд Бат хааны дэмжлэг, арга ухаант Сорхагтань хатны зүтгэл, нөгөө талд Өгөдэй-Цагадайн угсааныхны дотоодын хагарал, эв нэгдэлгүй байдлаас нөхцөлдөн Толуйн угсааны Мөнх Монголын их хаан болсон түүхтэй.

Огул Хаймиш хатан Хурц, Хожа,Нагу гэсэн гурван хөвүүн төрүүлсэн нь бүгд эцгийн хаан суурийг залгамжлах ухаан, чадал төгс, зориг төгөлдөр эрчүүд байсан ч Бат хааны хатгалгаар Мөнх хаан Өгөдэйн талын далаад хүнийг цаазлан харгислахад өртөн амь эрсджээ. Их хуралдайн батламжийг зөрчин Толуйн угсааны Мөнхийг хаан суусныг эрс эсэргүүцэж байсан Огул Хаймиш хатныг Мөнхсаран нэрт ноён нүцгэлэн доромжилж, амийг нь хороожээ.

Багш нь яриагаа төгсгөөд судар бичгээс түүвэрлэн авсан тэмдэглэлээсээ нүд салган болор шилээ авч, охин өөд эгцлэн ширтэж:

-Зарим бичгийн мэргэдийн үлдээсэн сурвалж бичигт Дөргөнэ, Огул Хаймиш хатдын төр барьж байх цагт дотоодын үймээн самуун дэгдэж, төрийн эрх суларч, өлсгөлөн зовлон нүүрлэж байсныг бүсгүй хүн эрх барьснаас болсон мэтээр өгүүлсэн байдгийг шавь чи юу гэж тунгаана? хэмээн асуулаа.

Урьд нь Анугийн хүсэлтээр монголын түүхэнд алдар гавьяатай хатад, гүнж нарын тухай хүүрнээд зогсдог байсан багш нь өнөөдөр ийнхүү шавийнхаа бодох, тунгаах, дүгнэх чадлыг сорьж буйд охин эхлээд тулгамдан сандарч чимээгүй бодолхийлж байснаа:

-Би тэдгээр хатдын буруу үгүй хэмээн мунхаглаж байна багш аа! гэснээ багшийн зүг хянамгай харц шидлээд зориг орж хоолой зассанаа:

-Учир нь гэвээс Өгөдэй, Гүюүг хоёр их хаан, ширээ залгамжлагчаа гэрээслэлгүй гэнэт үхсэн нь тэдгээр хатдыг төрийн эрх авахаас өөр аргагүй байдалд оруулсан. Нэгэнт монгол гүрэн наран ургахаас жаргах хүртэл өргөн уудам нутгийг дайлан эзэлсэн нь хаангүй болмогц гавьяат олон ноёд, жанжингууд эзэмшил нутагтаа ах захгүй дураар дургихад бэлэн байсан биш үү? хэмээн сүрхий гэгч нь хариулахад багш нь ихэд сэтгэл баясахаараа тэгдэг зангаараа нүдний болор шилээ зөөлөн илгээр зүлгэн хүд хүд инээж:

-Үгүй ер.Сүрхий “охин хурга” байх нээ! Гэвчиг их хаадыг гэнэт үхсэн хэмээн ярих нь алдас болно. Нохой, эсвэл хонь үхлээ гэхээс хүнийг, тэр дундаа их хааныг үхлээ хэмээх нь хүндэтгэлгүй нь хэтийдсэн хэрэг. Монгол хэлний хүндэтгэлийн үгнээс сонгон тэнгэр болох, насан эцэслэх, наснаас нөхчих, таалал болох, тэнгэрт халих гэхчлэн баялаг хэлбэрээр ярьж хүүрнэж сур хэмээн сургалаа. Тэртээ багадаа бас Зая бандид гэгээнийг “үхэв” гэж амны алдас хийж байснаа санаад Ану түргэхэн шиг:

-Жа багш аа! Манай Ойрадын мах цусны тасархай тэр Огул Хаймиш хатны үхэл хэчнээн эмгэнэлтэй вэ хэмээснээ багшдаа хүндэтгэл үзүүлэн мэхийгээд ном судраа тэвэрсээр өргөөнийхөө зүг мөнхийн сүүдэр Балсангаа дагуулан одовой.

Хэд хоногийн хойно, Ануд багш нь Хубилай сэцэн хааны ухаант мэргэн хатан Чимбайн тухай хүүрнэжүхүй.

-Шавь минь чи “Монголын нууц товчоо”-г олон удаа уншиж, басхүү тод бичгээр сийрүүлэн бичсэн тул Монголын их хаадын түүхийг надаас дутуугүй мэдэх болсонд би сэтгэл нэн хангалуун байгаа.

Харьд халдварт тахал өвчнөөр өөд болсон Мөнх хааны дараа Хубилай сэцэн, дүү Аригбөхөө ялж, хөх хулгана жилд буюу аргын тооллоор 1264 онд хаан сууринд заларсан билээ. Өвөг дээдэс эзэн Чингисийн хойно их үйл хэргийг нь нэр төртэйгөөр үргэлжлүүлсэн Хубилайг Юань улсын түүхнээ “...Сэтгэл санаа уужуу тавиу, хүний чадварыг сайтар үнэлж, таньж, хэрэглэж чаддаг...” хэмээн тэмдэглэсэн. Эгэл ардууд ч их хааныхаа мэргэн ухааныг бишрэн “Хубилай сэцэн хаан” хэмээн алдаршуулжээ.

Монголын түүх заалган их хаадын тухай өөрийн гэсэн бодолтой явах болсон Ану охин “Хубилай хаан уугуул голомт, Хархорумыг орхин Юань улсад очиж суугаагүй бол Монгол их гүрэн мөхөхгүй байсан” хэмээн санадаг тул багшийнхаа энэ их магтаал, хүндэтгэлийг нилээд дургүй шинжтэй, сурсан зангаараа нугалсан өвдөг дээрээ гараа тавьж шанаа тулан, хөмсөг зангидан сонсч суугааг Дүүрэн мэргэн бичээч эс анзаарагч болон хүүрнэлээ үргэлжлүүлсээр байлаа.

Хубилай сэцэн хаан Монгол улсын нийслэлийг дотор газар шилжүүлэн, улсынхаа нэрийг халж, Юань улс буюу “Язгуурын Монгол улс” хэмээх шинэ их гүрэн байгуулж, тэрхүү улсын шинэ нийслэлдээ Дайду нэр өгсөн нь Хаан балгас гэсэн утгатай ажгу. Хубилай хаан бас Монгол гүрний эзлэн авсан өргөн уудам нутагт аж төрөгч олон өөр шашинтай ард түмнүүдийг нэгэн шашны тугийн дор нэгтгэхийг оролдон Төвдөөс Пагва ламыг урин Бурханы шашны улааны урсгалыг төрийн шашин хэмээн зарласан байдаг. За тэгээд Хубилай хааны гавьяа зүтгэлийг тоочоод байвал чи бид хоёр барахгүй дээ. Одоо гол чухаг сэдэвтээ орё.

Хубилай сэцэн хааны хамгийн итгэлт зөвлөх болбоос түүний хайрт хатан Чимбай байсан гэдэг. Чимбай хатныг түүхийн эх сурвалжуудад Чавь, Чамбуй, Чибэр гэх зэргээр олон янз дуудлагаар бичиж үлдээсэн нь уйгаржин, нанхиад, перс бичиг, хэл аялгын зөрөөнөөс болсон болов уу хэмээн багш нь мунхагладаг.

Чимбай хатан бол эзэн Чингисийн эх Өэлүн хатны төрхөм, хацар гоо охидоороо цуутай Хонгирад аймгийн Анчин ноёны охин байжээ. Чимбай Хубилай хаанд ураглан ирээд Дорж, Мангала, Чингим, Номхон хэмээх дөрвөн хөвүүн төрүүлсэн. Хонгирад угсааны энэ хатан сэцэн ухаантай, ажилч хичээнгүй хүн байснаар барахгүй их хаан Хубилайн төрийн хэрэгт шадарлан тусалдаг байсан хэмээн түүх шастирт тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

Хубилай хааныг өмнөдөд дайлаар мордсон чөлөөнөөр Мөнх хаан насан эцэслэж, Хар Хорумыг сахин үлдсэн дүү Аригбөх нь хаан суудалд санаархан цэрэг хурааж байгааг анирдсан Чимбай хатан эр нөхөртөө нууц элч илгээн шинэ сэргэг мэдээ хүргэсний ачаар Хубилай Монголын их хааны суудалд өргөмжлөгдөх ёслолоо яаралтай гүйцэтгэн хаан суусан юм. Энгүй их ачийнх нь хариуд Хубилай хаан аргын 1260 онд Чимбай хатнаа Дундад ордныхоо тэргүүн хатан болгон өргөмжлөв.

Энэ цагаас эхлэн Чимбай хатан их хаанд төрийн хэрэг шийтгэхэд нь шадарлан оролцох болжээ. Энэ хатан Хубилай сэцэн хааны үнэнч хань, төрийн их үйл хэрэгт нь найдвартай түшиг тулгуур нь болж чадсан үзэсгэлэн гоо зүстэй төдийгүй, ухаан холч, өрөвч энэрэнгүй, ажилсаг эмэгтэй байсныг түүхч мэргэд цохон тэмдэглэжээ. Юань улсыг эмхлэн байгуулж асан он жилүүдэд цэрэг дайны хөлд үрэгдэн тариалан сүйрэлд ороод байхад зарим түшмэл нанхиад тариачдын тариалангийн газрыг малын бэлчээр болгох санал гарган мунхаглаж байв.

-Юуны учир мунхагласан гэж?

Багшийн ярианы амтанд ороод хөлөө оршгол сууснаа сая л мэдсэн Ану бадайрсан хөлөө жийн, өлмий рүүгээ цус гүйж ирвэгэнэхийг нь мэдрэн угалз чимэглэлт гос гутлын хоншоороо харж сууснаа ийнхүү асуув.

Сониуч, сортоотой шавь охины нь энэ асуулт багшийг ч түр завсарлан эхнэрийнхээ аягалан тавьсан цайнаас хэд балган хоолойгоо чийглэх чөлөө олгов.

-Учир нь их нарийн. Юань гүрэн нанхиад газар төвлөрөн суусан. Нанхиад хүмүүс газар тариалан эрхлэн гэдсээ тэжээдэг байтал манай зарим монгол түшмэлийн мунхагласнаар тэдний амин зуулга болсон тариалангийн газрыг хураан малын бэлчээр болгон талхчуулбал идэх хоолгүй өлөн хоосон олон мянган тариачид бослого, үймээн үүсгэн, өлсгөлөн зовлон нүүрлэж, төр донслох байсныг Чимбай хатан анхааруулан хэлснээр Хубилай хаан Дайду хотын хаяа орчмын газраар байсан тариалангийн газрыг адууныхаа бэлчээр болгох хүсэлтэй цэргийн жанжнуудын санаархлыг хориглож байсан гэдэг. Ийнхүү шинэ тулгар Юань гүрний эхэн үед газар тариалан үтэр түргэн хөгжин, тариачид улсад татвар гувчуур арвин хураалгаж байснаар улсын сан хоромхоноо хүчирхэг, баян болсонд ухаант Чимбай хатны гавьяа их байв.

Чимбай хатан бол төр улсын хэрэгт туйлаас холын хараатай, элдэв хэрэг явдлыг бусдын хараагүй талаас нь цаад, наадхийг нь нарийн бодож тунгааж чаддаг ухаан төгөлдөр эмэгтэй байжээ.

Нэгэн удаа Юань улс Өмнөд Сүн улсыг мөхөөж, дайны их ялалтаа ёслон хөл толгойгүй баяр наадам болж байхад Чимбай хатан ганцаараа бодолд автан сууж. Үүнийг нь Хубилай сэцэн хаан анзаараад ”Бид Өмнөд Сүн улсыг дайлан энх цаг ирж, эзэн доодосгүй баяр хөөр болж буй энэ цагт хатан та юунд үл цэнгэнэ?” хэмээн асуухад нь “Эрт цагаас энэ өдрийг хүртэл мянга мянган онд мандан бадраад мөхөн алга болоогүй төр улс гэж үгүй. Бидний үр ач нар Өмнөд Сүн улс шиг мөхөхгүй болбоос сая зол завшаан гэж үзнэ.” хэмээн гайхалтай сэцэн хариу хэлсэн гэдэг. Хэдэн зууны тэртээ Чимбай хатны сэтгэл чилж байсан тэр үйлийн үр өнөөдөр монголчууд бидний толгой дээр бууж, Их монгол улс Манжид идэгдэн мөхөхөд хүрээд байна шүү дээ гээд багш их сүүрс алдаад хүүрнэлээ үргэлжлүүлэв.

Хубилай хаан Өмнөд Сүн улсыг эзлэн бүх Хятадыг нэгэн тугийн дор нэгтгэж авсныхаа дараа Өмнөд Сүн улсын эрдэнэсийн санд байсан бүх үнэт эдлэлийг хэдэн зуун хасаг тэргээр тээж авчран хатад, гүнж нартаа дэлгэн үзүүлэхэд Чимбай хатан онц анхаарсангүй халти тойрон үзчихээд яваад өгчээ. Гайхсан Хубилай хаан хойноос нь гоцго илгээн Чимбай хатнаас тэр баялгийн чухам аль эрдэнийг өөртөө авах саналтайг нь асуулгав. Ухаант хатан хариуд нь “Тэр их эрдэнэ баялгийг Сүн улсын хаан чухам өөрийнхөө үр хүүхдэд хэмээн үлдээн хадгалсан.

Гэтэл үхээнц дорой үр удам нь эцэг өвгөдийн өвлүүлсэн их эрдэнэс баялгаа хамгаалж үл чадан бидэнд ялагдаад эдэлж чадсангүй болохоор эдүгээ манай гэрт овоорон байна. Иймд хүний эд баялгийг би аваад юу хийхэв” хэмээн Хубилай хааныг дуугүй болгож байсан гэдэг.

Бас нэгэн явдлыг өгүүлбэл энэ хатан хэчнээн өр зөөлөн, нинжин сэтгэлтэн байсны гэрч мөн. Өнөөх Өмнөд Сүн улсыг дайлсны хойно Монголын дээд нийслэл хот Шандуд хааны ор залгамжлагч нялх хүүг аваад их эзэн хаанд хүндэтгэл үзүүлэхээр ирсэн Сүнгийн хөгшин хатныг үзээд Чимбай хатан өрөвдсөндөө нулимс асгаруулан байж, сөнөсөн улсын өтөл хатанд чадлын хэрээр тусалж, өглөг буян хүртээжээ.

Төр улсын хэрэгт мэргэн, өрөвч нинжин Чимбай хатан үр хойчоо сурган хүмүүжүүлэхэд гойд анхаардаг хүн байж. Хүү Чингимийнх нь бичгийн багш нэгэн өдөр ордонд хатантай учраад “Тайзы \ханхүү\ бурханы номыг хичээнгүйлэн сурч, ихэд гэгээрлээ.Өдгөө цааш Хүнзийн сургаальд сургах эсэхийг та мэдтүгэй. Хэрэв Хүнзийн суртлыг заах бол энэ нь тайзын үнэн чанарт харшлах бус уу?” хэмээн зөвлөлдөв. Тэгэхэд нь хатан ”Би хэдийгээр хааны ордонд сууж ертөнцийн ёсыг сайн мэдэхгүй ч миний олж сонордсоныг үзэхэд эртнээс нааш хүн ард, төр улсыг жолоодохуйд Хүнзийн ёсыг хэрэглэсээр ирсэн буй. Бурханы ном хэдийгээр мэргэн гүн ч улсыг засч эс чадмой. Тайзы хожим ирээдүйд улсыг засан удирдах хүнд хүчир үүрэг нуруундаа үүрэх тул чухам энэ Хүнзийн суртлыг ухаж ойлгуулахгүй байж хэрхэвч үл болно” гэж хариулсан гэдэг. Энэ мэтчилэн Чимбай хатан аливааг нарийн тунгаан бодож, зүй зохисыг олж чаддагаараа гарамгай байв.

Аргын тооллын 1244 оны намрын тэргүүн сард Өгөдэй хааны хоёрдугаар хүү Годан ноёны урилгаар Төвдийн бурханы шашны Сажийн урсгалын толгойлогч Саж бандид Гунгаажалцан лам Мати Дувази, Чагнаа нэрт хоёр ачаа дагуулан нутгаасаа гарч, хоёр жил аялан явсаар Монголд иржээ. Тэд Монгол газар бурханы шашныг дэлгэрүүлэн, хаад ноёдыг шашиндаа оруулсаар Мати Дувази нь сүсэгтэн олны дунд хувилгаан лам хэмээн алдаршсан байдаг. Хоёр жилийн дараа хувилгаан лам Мати Дувази нийслэл Дайдуд хүрч ирэхэд Чимбай хатан “Энэ ламыг хүн амьтан хувилгаан лам гэлцэх юм. Үнэн худлыг нь маргааш сорьж үзээд үнэн бол авшиг хүртье “ гэж хаанд айлдав.

Хубилай хаан хатандаа ”Хатан чиний үг зүйтэй ч тэр бага хүүхдийн дор их хаан би хэрхэн суух билээ? Гэтэл би хаан гээд ширээнд суугаад тэр хүүхэд доор суувал авшиг хэрхэн хүртээх буй?” хэмээн зөвлөлдөхөд Чимбай хатан хааны үгийг ламд дамжуулсанд Мати Дувази “Би хэдий нас бага, цус шингэн ч Бурхан багшийн шавь тул хааны доор яахин сууж болох ажам?” гээд Хубилай хааны үгийг хэрэгссэнгүй.Эцэст нь Чимбай хатан ухаан сийлж”Эдүгээ ном айлдан авшиг хүртээхэд лам тавцанд сууж, хаантан доор нь байгаад, төрийн хэрэг шийдэх ахуйд хаан, лам хоёр эн чацуу тавцан дээр морилбол ямар?” гэсэнд хоёр тийш харан ихэрхэж байсан Хубилай хаан, Мати Дувази хоёул зөвшөөрчээ. Ухаант Чимбай хатны ачаар ийнхүү номч мэргэн лам, Хубилай хааны төрд үнэнчээр зүтгэж, их хаан ч номын багшаа олж авсан гэдэг. Хожим энэ Мати Дувазийн шашин дэлгэрүүлсэн гавьяа зүтгэлийг үнэлж Хубилай хаан “Гурван хийд дэх номын хаан,үлэмж лам” цол хайрлаж, улсын багшаар залж, эл ламтан түүхэнд Пагва лам хэмээн мөнхөрсөн юм шүү дээ.

Пагва лам Хубилай хаанд дөрвөлжин бичиг зохиож өгч байв.Хубилай хаан эзэмшлийнхээ өргөн уудам газар нутгийн хэл шашин өөртэй түмэн олныг нэгтгэх зоригоор албан ёсны

бичигтэй байхыг хүссэнээр Пагва лам энэхүү бичгийг зохиожээ. Харамсмаар нь Пагва лам монгол хэл мэдэхгүй, манай бичгийн боловсролыг эзэмшээгүй төвд хүн байсан учир дөрвөлжин бичиг хэрэглээнд нэвтрээгүй гэдэг.

За тэгээд, Чимбай хатан, хааны гол өргөө Дундад ордныг тэргүүлэн торгоны сайхныг өмсөж, алтны дээдийг зүүж байсан ч туйлын ажилч, хямгач хүн байсан тухай мэргэд тэмдэглэн үлдээжээ. Тухайлан жишээ дурдваас хог дээр хаях болсон хуучин нумын ороолт торгыг хуулан аваад утсыг ашиглах буюу үжирсэн нэхийний үсийг хярган авч хивс нэхүүлдэг байж. Тэрчлэн Хубилай хааны үеийн монголчууд малгадаа саравчгүй байснаас нартай болон цастай өдрүүдэд нүд гялбан зүдэрдэг байсан тул нэгэн өдөр хаан авд яваад “Өнөөдрийн их цасанд нүд гялбаад юу ч харваж чадсангүй” гэснээс үүдэн тэр шөнөдөө хааны малгайд саравч оёж өгчээ. Маргааш нь хаан авд явахдаа хатныхаа урласан саравчтай малгайг өмсөн нүд нь цасанд гялбахын зовлонгүй ихээхэн олз омогтой ирж байсан аж. Үүнээс хойш хааны зарлигаар бүх цэргийн дуулга малгайг саравчтай хийх болсон юм гэдэг.

Ухаан билэг төгс Чимбай хатны мэндэлсэн он тод бус. Харин аргын 1281 онд таалал болсныг түүхнээ тэмдэглэжээ. Чимбай хатан дөрвөн хөвүүнээс гадна Цэцэг нэртэй гүнж төрүүлжээ. Хубилай хаан Чимбай хатнаас мэндэлсэн ханхүү Чингимээр хаан сууриа залгамжлуулахаар шийдсэн байсан ч өвчнөөр үрэгдсэн тул түүний хүү Өлзийт хунтайж их хааны суудалд заларсан билээ.

Хожмоо Юань гүрний 21 дүгээр онд Хубилай хаанд эрхэм дээд цол өргөмжлөх үед хэдийн нас нөхцсөн Чимбай хатныг “Маш үзэсгэлэнтэй, ёсыг нэвтэрхий мэдэгч хувилгаан Хуаньхоу хатан” цол нэхэн олгосон юм.

Нүд нь сэргэн гийсэн Ану босч суниагаад дотроо Чимбай хатны сэцэн мэргэнийг гайхан, түрүүчийн хүүрнэсэн Ойрад угсааны Огул Хаймиш хатныг бодвол сайхан төгсгөлтэй түүх байсанд баяртайгаар багшдаа хүндэтгэл үзүүлээд өргөөнийхөө зүг одлоо.

Багшдаа бараалхан түүх шастирт мөнхөрсөн ухаант хатдын тухай хүүрнэлийг нь сонсон, “Жангар”, “Гэсэр”-ийн туулиудыг тод үсэгт сийрүүлэн тэр зуныг өнгөрөөж байтал эрихний ширхэг шиг эгэл өдрүүдийн хэмнэлийг эвдсэн хоёр үйл явдал тохиожээ.

Нэг нь гэвэл номын мэргэн багш Дүүрэн бичээчийнх нь архаг хууч хөдлөн хэвтэж, нөгөө нь бүрлээч Баатар хунтайжийн хатан Юм-Агас ахайтан Очирт цэцэн ханы өргөөнд айлчилсан явдал байлаа.

Ану охиныг мэндэлсэн тэр жил Ойрад түмний гарамгай нэгэн удирдагч Баатар хунтайж нас нөхчиж, эр нөхрийн хойноос гашуудан энэ биеэ хорвоогийн нүгэл хилэнцээс ариулан сахил хүртэж асан Юм-Агас хатан өдгөө санаснаас харин ч бага өтөлсөн мэт. Эр нөхрөө алдсаны дараа дорхиноо өтөлж, үс гэзгээ авахуулаад энэ хүн хорвоогийн тоосыг яахин хөдөлгөнө дөө гэмээр уй гашууд автан байснаа бодоход өтөл нас тэгсхийгээд номхрон тогтчихсон мэт тавь хол гарсан гэхэд хөнгөн шингэн үзэгдэх аж.

Юм-Агас хатан эднийд зүгээр нэг ирсэнгүй. Очирт цэцэн хан, Доржавдан ахайтан хоёртой ургийн ёс хэлэлцэхээр иржээ. Дөрвөн Ойрадын холбооны цорос, хошууд, торгууд, дөрвөд

аймаг дотроос хамгийн хүчирхэг нь болох Цорос, Хошууд хоёр эртнээс худ ургийн алтан аргамжаар эв найрамдалт харилцаагаа бэхэлсээр ирсэн ажгу.

Тиймээс өдгөө гучин дөрвөн сүүдэр зооглож буй Сэнгэ хунтайжид Очирт ханы Ану гүнжийг гуйж ураглах явдлыг бэлбэсэн хатан цухуйлгав.

-Танай охин Ану гүнж миний санахаар бүрлээчийг өнгөрдөг жил мэндэлсэн, өдгөө хий настайгаа арван тав хүрч, бэрийн насанд ойртож буй билээ. Угсаа гарал өндөр, ухаан санаа сэцэн цэлмэг, өнгө зүс үзэсгэлэн гоо хэмээн Ану гүнжийн тухайд Ойрад даяар шуугих болсон нь намайг ийнхүү ургийн явдлыг та хоёртой яаравчлан хэлэлцэхэд хүргэлээ. Миний сонсч дуулснаар охинд тань сэтгэл алдсан хүн үгүй. Бэр гуйж хараахан эхлээгүй байгаа болов уу? Та хоёр минь цорос, хошууд аймгийн эртний ургийн хэлхээг таслахгүй гэсэн санааг минь дэмжин тэтгэх болов уу хэмээн мунхаглана хэмээн ирсэн оройдоо санаагаа шулуухан айлтгасан нь хантныг бодолд оруулан, Доржравдан ахайтныг уулга алдуулав.

-Хөх тэнгэр өршөө! Гуравхан жилийн өмнө улаан эсэргэнэтэн ухаан малгайгүй сандаргаж байсан, эхийнхээ өврөөс гараагүй шахуу нялх амьтан шүү дээ тэр чинь! хэмээн хатан эх нь аягатай цайгаа алдах шахан уулгалахад эрхбиш эр хүний хувьд хантан дуугүй хөмсөг зангидан духайв. Үнэн хэрэгтээ үрээ гэсэн эцэг, эхийн хайрыг туухайгаар жинлэж болдог сон бол хантан, Доржравдан ахайтнаас илүү энэ үгэнд цочихоор билээ. Танхил, хээнцэр ахайтны хувьд охиноо харамлахдаа л “Эхийнхээ өврөөс гараагүй нялх амьтан” гэсэн үг унагаснаас бус үнэн хэрэгтээ гурван нас хүртлээ өрлөг эхийнхээ хөхийг үлгэн хүн болж, төрсөн ижийнхээ өвөрт барагтай бол орж ирдэггүй, нялхад нь хааяа ахайтан хөхөө гаргаад “мөөмөө ид дээ” гэхээр ярвайгаад буруу харчихдаг байсны нарийн учрыг Юм-Агас хатан мэдэх ч биш дээ.

Ясан төрлийн холбоотой Доржравданы занг муугүй гадарлах Юм-Агас эцгийн шийд хамгаас чухал тул Очирт цэцэн ханы нүүр өөд хянуур ширтэн хариу үг хүлээн цайгаа оочилж тавилан суувай.

Энэ үед Ану номын багшийнхаараа орж, бие тэнхээг нь асуун, хүч тамир сэргээх хүн орхоодойн үндэстэй цай өгчилгөөд холын гийчинтэй мэндчилэхээр орж ирлээ. Тулганы захад суух Үзмээгийн цонхигор царай, нэг нь тэднээс хамгийн үнэт эрдэнийг гуйн амыг нь харж, нөгөө хоёр нь өгөх, байх эсэх, юу хэлэхээ ч үлмэдэн тулгамдаад байх тэрхэн мөчид цовоо цолгиун охин орж ирэн:

-Юм-Агаа ахайтны амгаланг эрье. Та холын замд тавтай аялж ирэв үү? хэмээгээд мэхийн хүндэтгэсний хойно, ирж хоёр хацраа үнсүүлэн золголоо.

“Хэргийн эзэн, хэнгэргийн дохиур”, энэ гурван хүний ярианы гол шижим болоод буйгаа огт үл гадарлах охин Үзмээгийн аягалсан цайг авч ёсыг бодон хошуу хүргээд тавихад Юм-Агас хатан охины царайг яггүй гярхай нүдээр сонжих мэт ширтсэнээ бяд муутай сулхан инээмсэглэл нүүрэндээ тодруулан:

-Ану охин хэчнээн том болоо вэ? Дөрвөн жил барааг нь харсангүй. Тээр жил Галдан хүүгээ эргэхээр Цастын орныг зорих замдаа дайрахад харагчин туулай жил \1663 он\ гарсан байл уу? Эрдэм ном сайн сурч байгаа гэж сонссон гэхэд охин дотроо “Энэ чинь Галдан ламтны ээж

шүү дээ” хэмээн бодоод миний тухай очоод лав хүүдээ ярина даа гэж бодохоос ичингүйрэн харц доошлуулаад ёслолын өргөөний хивсний ланз хээг ширтэнэ.

-Охин маань уйгаржин, тод үсэгт гаргуун. Хэчнээн олон судар хуулж сийрүүлэв дээ хэмээн хэзээний сайрхуу зантай Доржравдан сайлаад авлаа.

-Үр минь багш нь яаж байна? хэмээн түрүүнээс хойш дуугүй, бодолд дарагдан суусан эцэг нь сая толгой өндийлгөн асуулаа. Халуун цай оочлон хивсний хээ ширтэж суусан охин эцгээ дуугармагц борооны дараахь байгаль дэлхий өнгөө засдаг шиг илт сэргэн өндийж:

-Бузгай сайжирч байна. Ижийн өгчилгөсөн хүн орхоодойн цайг аваад сүслэн талархаж байгааг минь дамжуулаарай гэсэн. Хүн орхоодойн үндэс тархи, судасны хаванд их сайн гэж маарамба айлдсан. Хайгаад олдохгүй биз, Хами руу хадмын талынханд захью хэмээж байсан юм гэж байна лээ. Аав аа, багшийн бие чилээрхсэнээс болоод хатдын түүхээ яриулж чадахгүй уйтай л байна. Өнөө орой та миний өргөөнд ирж надтай хорол наадна шүү хэмээн хошуу цорвойлгон эрхлэхэд холын холд бэр болон одох нас нь ойртоод, авах хүн нь гуйх гээд ирчихсэн буйг бодохоос эцгийн сэтгэл хямран золтой л нулимс цийлэгнүүлчихсэнгүй биеэ хатамжлав.

Ажигч гярхай, эр нөхрийнхөө ааль занг андахгүй мэддэг Доржравдан самбаачлан Үзмээ рүү Юм-Агаст цай хийж өгөхийг нүдээрээ дохиод:

-Мартсан, Галдан хувилгаан гал голомтдоо идээшин амгалан морилж байна уу? Хар нялхад нь хүний газар явуулсан хүүгээ ирэхээр таны сэтгэлийн хүнд чилүүр тайлагдаад сайхан байгаа байх даа хэмээн би бодож байлаа хэмээн яриаг өөр тийш нь залчихлаа.

-Өө, тэгэлгүй дээ. Санасан сэтгэл минь аргагүй л дэвтэж байна. Гэвчиг ном айлдана, шинэ барьж буй дуганаа эргэнэ, ахдаа төрийн хэрэгт хань хамжаа болно, сүсэгтэн олонд адис хайрлана гээд маньдаа олдохгүй шахам юм. Харин Сэнгэ хүү маань одоо л эрийн цээнд хүрч, төрийн хэрэгтээ гаршин сэтгэл амар байлгаж байна даа гээд Сэнгийн тухай яриаг хэр сонирхон сонсч буйг мэдэх санаатай Ану охины зүг сэм хяламхийв.

Харин охин Галдангийн тухай эхний хэсгийг сонсоод баярлан догдолсон ч түүнээ сэтгэлдээ чандлан нуухын тулд аягаа тавиад босч:

-Юм-Агаа ахайтан та манайд тавтай зочлоорой. Би багшийнхаа даалгасан судрын сийрүүлгээ хийе дээ гээд ухасхийн гарч одов.

Охиныг гарч одсон хойно Очирт цэцэн хан сая ам нээж:

-Урьдын сайн нөхөр агсны удам угсаатай худ ургийн холбоо тогтооход татгалзах юун. Дамаан манай хошууд, цоросынхон хэдэн үеэрээ ураг барилдан алтан аргамжаар холбоотой явсаар ирсэн улс билээ. Эцгийн ор суухад нь дэмжин тэтгэсний хувьд, Ойрадын төрийн хэргийг эмхлэн эцгийн үйлсийг залгамжлан авч яваа хийморлиг эр Сэнгэ хунтайжид охиноо өгөхдөө эцэг би дургүйцэх юм алга. Гэвчиг охин үр минь өнөөхөндөө дэндүү нялх байна. Сүй бэлэг хэлцэн, ургийн холбоо тогтоохыг дараа гарах шар бичин жилд гүйцэлдүүлбэл ямар? гэхэд

Юм-Агасын нүд сэргэн:

-Очирт цэцэн хан танд би туйлаас талархаж байна. Ургийн явдлыг ирэх жил гүйцэлдүүлье дээ хэмээн баяртай хэлэхэд Доржравдан:

-Ингэхэд Сэнгэ хаан өдгөө хэдэн хатан, татвар эмтэй билээ? Миний охин эрх дураар, эрмэг эршүүд зантай хүн. Олон хатантай хаан ихэс хүнд очоод зол жаргалтай байх болов уу гэдэгт эхийн сэтгэл төвдөнө хэмээн улаан халз асуучихлаа.

Сэнгэ хүү нь эхэндээ гайгүй юм шиг байснаа сүүлдээ эцгийнхээ хүүхэмсүү занг хуулан төрсөн нь илт болж, нүдэнд торсон олигтой өнгөлөг бүсгүйчүүдийг урдуураа зүгээр өнгөрүүлэх нь ёсонд хазгайд эхийн сэтгэл төдийлөн таалалтай байдаггүй тул овсгоо ихт Доржравдан яриа хэлцээ нийлэх торгон энэ агшинд эх, хүү хоёрын эв найрыг эвдэх дөхдөг амин цэг рүү нь оночихсонд Юм-Агас яггүй цочирджээ.

Тэгээд сандарснаа нуун зориуд нүүрэндээ инээмсэглэл тодруулаад үсээ авахуулж чавганц болсноос хойш хүзүүндээ зүүж явдаг алтан бурханыг эс тооцвол биедээ үлдээсэн цорын ганц үнэт гоёл нь болсон том сувдан бэлзгээрээ оролдох зуур Доржравдан хатны зүг ялдамхан харц илгээн:

-Хаа очиж тэр талаар эцгээ нэг их дууриасангүй. Эдүгээ гурван хатантай. Харин татвар эм хэд бий нь ч бий. Ану гүнжийн тухайд бүрлээч Баатар хунтайж надад ханддаг байсны үлгэрээр онцгой эрх ямба олгоно, хатан болж ирээд нуган үр төрүүлбэл түүгээр нь ор залгамжлуулна гэж ярьдаг юм хэмээн хүүгийнхээ өмнөөс айлдаадхав.

-Миний хүү Галдмаа бол ёсолсон ганц хатантай л байгаа гэж Доржравдан сайрхах, магтахын хооронд шөвөгнөөд авлаа.

Үнэн хэрэгтээ хоёр жилийн өмнө Цастын орныг зорих замдаа найрсаг ёсыг бодон хантныхаар хоноглоод явахдаа Ануг үзээд “Хөөрхөн сэвгэр болох охин байна” гэсэн бодол төрж, тэрүүхэн үедээ шохоорхоод авснаас биш өргөөндөө арваад татвар эмтэй, тэднийгээ хатан өргөмжлөх эсэх талаар эхтэйгээ зөрөлдөж суудаг Сэнгэд Очирт цэцэн ханы хайртай гүнжийг аваад тэгнэ, ингэнэ гэсэн бодол байгаагүй, тэр талаар эхтэйгээ ам нээн ярилцаж ч амжаагүй. Гагцхүү хошууд, цоросын ургийн барилдлагыг хадгалах, өнөөг хүртэл дөрвөн Ойрадын чуулганы хан сууринд суусаар буй хүчирхэг эцгийнх нь хамжааг хэрэглэх, нөгөө талаар Ану охин дориун үзэмжтэй, эрдэм ухаанд гаргууд гэсэн дам үгс нийлээд эхийн үгэнд орж эднийтэй ургийн явдал хэлэлцэхийг Сэнгэ даруй зөвшөөрсөн билээ.

Очирт цэцэн ханы хувьд “Хамгийн хайртай юмаа өг гэж мангасын нэхэхэд нь гэргийнхээ хөл хүнд болсныг мэдэлгүй амиа аврахын тулд” тэгье” хэмээн амлаад хүүгээ мангаст алддаг эрийн үлгэр шиг л “үгүй” гэж болохгүйн эрхэнд дараа жил сүй бэлэг, ургийн явдлыг хэлэлцье хэмээн ам алдчихаад амин хайртай охиноо хүний хүн болно гэдэг зайлшгүй үнэнтэй эвлэрч үл чадан ухаан санаа нь дэн дун сууна. Тэртээ арван дөрвөн жилийн өмнө тэнгэрт хальсан андынхаа хойдын хэрэг явдлыг гүйцэлдүүлэх, гэрээслэл ёсоор нь Сэнгэ хүүг нь хунтайжийн ор суулгахаар Ховог сайр дахь Баатар хунтайж агсаны өргөөнд очоод буцахдаа “Өнөөдөр насанд хүрч буй охинтой ч болоосой. Тэгвэл залуу хунтайж Сэнгэд хатан болгож өгөөд эцэг



дээдсийн уламжлалын дагуу цоростой ураглах сан” хэмээн хүсч байсан хүн өдгөө “Хүссэн юм хүзүүгээр” гэгчийн үлгэрээр голоос хайртай охин үрээ өгөхөөс харамлан гонсойж суух гэж.

Харин Юм-Агасын бодлоор бол хүү нь чухам Ануг дөрөвдүгээр хатнаа болгон авч, дөрвөн Ойрадын чуулганы хантай ураг барилдсанаар, хадам эцгээсээ гадна Ойрад даяар цуутай Галдмаа баатрын дэмжлэгийг давхар өвөртлөөд зогсохгүй, Зая бандид гэгээн багшийн залгамжлагч хэмээн сүсэгтэн олноор хүрээлүүлсэн дүүгийн тусламжтайгаар Ойрадын хүчирхэг нэгдсэн улсыг гартаа оруулах сүүлчийн хаалганы түлхүүрийг атгах боломж олж авах юм.

Маргааш нь Юм-Агас хатан хошуудын танил тайж ноёдынхоор айлчлан, оройдоо Цэвээн хатантай уулзан, холын гийчнээ хүндэтгэн барьсан үдшийн зоог дээр Ану гүнж, Нуран хатны өргөмөл охин хоёрт үнэтэй гарын бэлэг өгчилгөөд нөгөөдөр нь Шүхэртийн хийдийн ширээт хамбатай уулзах ажлаар мордсон ажгу. Юм-Агас ахайтныг яван явтал эцэг, эх нь Ануд түүний ирсэн хэрэг зоригийг хэлсэнгүй тул багшийн өвчтэй байх чөлөөнөөр охин өргөөний хэдэн хүүхдүүдтэй нийлэн хээр талаар давхиж, хөвгүүдтэй сэлмээр цавчилдан, тарвага, зурам намнан хөхүүн зугаатай өнжихийг хараад эцэг нь эрд гарах нас нь айлсаж, харьд мордох цаг дөхөж буйг нь санахаас охин үрээ өрөвдсөөр байлаа.

Ануг Бундир, Сандуйжав, Балсан, Чилэдү дөрөвтэй мөрийцөн зурам харваад хамгийн олныг онож дийлчихсэнээ эцэгтээ өчих гэж бөөн хөөртэй амьтан эхийнхээ өргөөнд орж хүйтэн чигээ залгилаад, хөрчихсөн будаатай шөл \Ойрадууд гурилтай шөлийг будаатай шөл гэнэ\ халаалгах уу? гэхэд нь цааргалан чихэртэй шүүрмэг идэж суутал нь нас ахисан ч хөнгөн тэнхлүүн Цанжид хиагаа заран эцэг нь ёслолын өргөөндөө дуудуулжээ.

Эрх танхи, эршүүд гэжүүн зантай атал дэндүү хүүхдээрээ байгаа, тэгээд дээр нь Сэнгэд сэтгэлгүй охиндоо Юм-Агас хатны санааг хэрхэн яаж хэлье дээ гэдэг дээр эр, эм хоёр удтал зөвшилцсөний эцэст Очирт цэцэн хан өөрөө эвгэйхнээр дуулгах нь дээр хэмээн тогтсон ажээ.

-Аав ёслолын өргөөндөө дууддаг нь юу вэ?Өчигдөр надтай хорол наадна гэчихээд амласандаа хүрээгүй. За за, ижий би ёслолын өргөөнд очлоо. Аав сүртэй гэдэг нь гэсээр чихэртэй шүүрмэг мэрсээр гарч одоход араас нь Мандарваа бас нэгийг шүүрээд ухасхийлээ.

“Аав аян замд мордох гэж байгаан болов уу? Юм-Агааг ирээд явснаас хойш үе үе сүүрс алдаад л юм л бол миний толгой тархийг илээд л жигтэй болчихоод байгаан байна шүү!Юу болсон байх вэ?Арай намайг Галдан ламд сэтгэлтэйг мэдчихсэн юм биш байгаа даа. Аль эсвэл Сэнгэ...Сэнгэ хунтайжид хатан болгох гэсэн хэрэг үү?” гэсэн бодол орж ирэнгүүт сэтгэл түгшин зогтусав. Өнгөрсөн жил ижий нь нэг тиймэрхүү үг хүнд цухуйлгаж байсан санагдаад явчихлаа.

-Хөх тэнгэр, хорин нэгэн дарь эх минь.Тийм үг л бүү дуулгаасай. Үгүй, ингэхэд би тэгээд санваартан хүнд очихгүйгээс хойш хэрхэх билээ. Сэнгэ хунтайж...Сэнгэ....

Өргөөнүүдийг хооронд нь холбосон чулуун хашлагатай элсэн замаар ийнхүү бодолд дарагдан

явсаар эцгийн ёслолын их өргөөний үүдэнд тулаад шуудхан орохоос түдгэлзэн дахин зогтусав. Баруунаа тэнгэрийн хаяа улааран наран авхай жаргаж байлаа.

“Жаргалтай хатны хацар нэг улаан

Жаргах нарны туяа нэг улаан...” гэдэг сэн. Байгаль дэлхий, хөх тэнгэр, ээлт наран авхай мөнхөд ийнхүү оршсон биз. Гэтэл байгаль ертөнцийн дэргэд хүмүүний амьдрал хэчнээн богинохон. Зүйрлэвэл нэгэн зуны настай ялаа, шумуул л гэсэн үг ажгу. Багшийн хүүрнэдэг домогт хатдын хэн нь ч хайр сэтгэлээрээ эрд гараагүй. Ихэн гол нь дайн тулаанд олзлогдон ирээд хэн нэг ханхүү, хааны хатан болсон, эс бол овог аймаг, улс гүрнүүдийн эв найртай ёсыг бодон эцгийн зарлигаар урагласан байдаг бус уу?

Бусад өргөөнийх шиг эсгий биш хоёр хавгастай улаан модон сүрлэг хаалганы очиртой бариулаас Ану шийдмэг татан эцгийнхээ ёслолын өргөө рүү ороод явчихлаа.

-Би энд хүлээж байя хэмээн Мандарваа ард нь бувтнан хоцрохыг л халти сонсчээ. Эзэн авхайгаа хүлээн зогсох нь түүний үүрэг, бүүр төөрөг тавилан юм хойно, зогсч л байхаас өөр яана аж. Төөрөг тавилангийн замаасаа гажсан хүмүүн энэ орчлонд байдаг гэж үү?

Охиныг салаа гэзэгнийхээ үзүүрээр оролдосхийн тээнэгэлзэнгүй орж очиход эцэг нь зандан мэлхий ширээнийхээ ард удмын сүлд бүхий сэнтий дээрээ тух муутайхан сандайлан бодолд дарагдан суух ажгу.

-Аав аа, би таны дуудсанаар ирлээ хэмээн охиноо цовоо дуугаар хэлэхэд эцэг нь сая л анзаарах шиг толгой өндийн хараад хөмсөгний зангилаагаа тэнийлгэн мишээж:

-Нааш ир, үр минь аав нь духыг нь үнэрлэе хэмээн хачин зөөлөн ээвэргүү дуугаар хэллээ.

Ихэнхдээ охинтойгоо тоглоом тохуу хийлцэн, аль эсвэл түүх цадиг хуучлан, үеийн юм шиг гангар гунгар хийж, заримдаа сургааль ном айлдан суудаг аав нь нялх багад нь өхөөрддөг байсан шигээ ийм өнгөөр сүүлийн үед ярихаа болиод байсан тул Ану ялимгүй гайхан дуугүйхэн духаа өгөхдөө “Аав хөлчүү байгаан болов уу?” гэтэл үгүй аж. Чингээд хан охиныхоо духыг үнэрлэн сүүрс алдаад зүүн тал руугаа алга дэлгэн зааж:

-Миний үр наанаа суу. Хэлж дуулгах юм байна гээд хонхоо авч жингэнүүлэхэд Цанжид хиа орж ирээд алга хавсран мэхийж:

-Жа эзэнтээн гэхэд:

-Хоолон гэрээс цай авчраад наашаа хэнийг ч бүү оруул! хэмээгээд охин руугаа зөөлөн харав.

Түрүүнээс хойш аав юунд эхийн өргөөнд ярилцахгүй холын гийчин, төрийн хэрэг зөвшилцөх түшмэл, төлөөний хүнийг хүлээн авдаг ёслолын өргөөнд хиагаараа дуудуулав. Царай нь Юм-Агас хатны ирээд буцсан өдрөөс хойш юуны учир барайн явах болчихов? Одоо ингээд охиноо урьд урьдынхаас илүү өрөвдсөн, хайрласан харцаар харж, нялх багад нь эрхлүүлж байсан лугаа ижил өхөөрдсөн өнгөтэй дуугарч буйгаас үзэхэд Сэнгэ хунтайжид өөрийг нь ураглах

тухай л яриа үүдэх болов уу? хэмээн сэргэлэн ухаандаа таамагласан нь бүр ч бат нот болох шиг зөн мэдрэмж төрөөд явчихав.

Гэвч ааваасаа өөрийг нь юуны учир ийн ёслолын өргөөндөө сүр болгон дуудуулсныг асуусангүй. Өөрөө түрүүлэн ам нээхийг нь хүлээлээ.

Охин нь урьдын томоогүй зангаараа “Аав юу болов?Өчигдөр хорол наадна гэсэн яагаав? Юунд өр алдсан хужаа шиг уруу царайлаав?” хэмээн шалгаасан бол уг нь эцэгт нь амар байх байж. Гэвч аргагүй л Байбагас ханы удмын “охин хурга “ юм гэсэндээ илүү үг унагахгүй, байр байдлыг ажиглаж суугааг нь эхээсээ дэндүү анги зан төрхтэй хүн дээ хэмээн эцэг нь нэг бодлын бахдан, нөгөө бодлын эм хүнд ахдахаар холч бодолтой төрсөн охиноо өрөвдөх, хайрлах зэрэгцэн байлаа.

-Багшийнх нь бие тэнхээ дээрдэж байна уу,үр минь?

-Дориун болж, босоод сууж байна лээ.Намаржаанд буухаар түүхэн хүүрнэлээ үргэлжлүүлнэ гэсэн гээд охин эцгийн царай өөд хянуур ширтэв.

Удалгүй өргөөний залуу шивэгчин, багадаа Анутай тоглодог асан Дархижав бүсгүй алтадсан том домботой сайхан хийцтэй цай, амтат бор еэвэн, чихэртэй шүүрмэг, хурс овоолсон жижиг мөнгөн царын хамт оруулж ирээд цай аягалчихаад гарч одов.

-За охин минь, эцгийн гэрт төрөөд эрийн гарт очдог нь хорвоо ертөнцийн жам юм гэдгийг чи юун эс андах...\За тэр, ургийн явдлын тухай ярилцах нь зөв болж таарлаа хэмээн Ану хоромхон зуур бодлоо. Уг нь эцэг эх хоёр нь түүнийг ямагт үр минь гэхээс охин минь гэх нь ховор байжээ\ Юм-Агас хатан төлдөрхөн гийчлэхдээ тухайлан Сэнгэ хунтайжид чамайг хатан буулгах тухай хүсэлтээ уламжилсан.Манай хошууд, цорос аймгийнхан эртнээс худ ургийн хэлхээтэй явсан уламжлалтай. Ану “Сэнгэ хунтайжид чамайг хатан буулгах хүсэлтээ уламжилсан” гэхэд нь нэг сэртэсхийгээд явчихсан ч царайд нь баяр, гунигийн алины ч ул мөр үзэгдсэнгүй ээ.

-Өнөөхөндөө чамайг нас балчир байгаа тул дараа жил ургийн явдлыг хэлэлцье гэж аав нь хариу өгсөн гээд эцэг нь үрчлээт магнайгаа атируулан охиныхоо нүүр өөд харав.

-Би Сэнгэ хунтайжийг уржнан л нэг харсан. Түүний хатан болох нь гээд дурлаж баясах сэтгэл алга. Нэгэнт аав та хойтон жил ургийн явдлыг хэлэлцэхээр тогтсон бол эцгийн өөдөөс сөргөх зүрх надад бас үгүй хэмээн өчихдөө Ану аавынхаа нүднээс харц буруулаад байв. Үнэндээ нялх багаас сэтгэл зүрхээ өгчихсөн хайртай хүнийхээ төрсөн ахтай нь гэрлэнэ гэдэг ёстой л хувь тавилангийн хяслан бололтой. Гэхдээ Сэнгэ хунтайж бол өтөл хөгшин хүн буюу өвчтэй , царай дорой, өнөө багшийнх нь хүүрнэлдээ өгүүлдэгчлэн “Өвсөнд ороовч үхэр тоож хивэхгүй,Өөхөнд хулдавч нохой тоож шиншихгүй амьтан” бус. Өөрөөс нь нилээд олон насаар ахмад ч гуч гаран насны идэрхэн сайхан эр, басхүү зүүн гарын хаан болж байгаа хүн тул хувь заяандаа бүүр ч нэг гоморхоод байх шалтгаан үгүйг охин тунгаан бодож суулаа. Хамгийн гол нь хайр сэтгэлтэй хүн нь ариун номын санваартан, хэзээд өөрийг нь гэргий болгон авахгүй тул түүнийхээ ахад нь очно гэдэг басхүү аз завшаан ч гэлтэй.

-Миний үр ийм л ухаантай төрсөн сэвгэр дээ хэмээн сэтгэл уужирсан эцэг нь өчөөд сүүрс алдлаа.

Ингэж Ану охин Сэнгэ хунтайжийн хатан болох хэтийн тавилантайгаа эвлэрч, эцгийнх нь сэтгэл өчүүхэн ч болтугай уужран, хоёр гурван жилийн дараа эгнэгт энэ гэрээс явтал нь эрх дураар нь байлгахаар шийдэж билээ.

## Аравдугаар бүлэг

Ховог сайр дахь Сэнгэ хунтайжийн өргөө. Эцэг Баатар хунтайжийн амьд сэрүүн ахуйд бариулсан “Номын өргөө” нэртэй хоёр давхар чулуун байшинд Галдан хувилгаан бурхан тахил, судар номоо дэлгэн тавиад, нэгэн жижиг тасалгаанд нь өөрөө суух болсон байлаа.

Бас л намар цаг. Ордны гэгээвчээр харахад алсын ууланд намрын будан хөшиглөөд буцах шувууд зэллэн ганганана.

Саяхан л зуны эхэн сар гарч, тэрбээр Очирт цэцэн ханы өргөөнд айлчлан хорвоод хосгүй хөөрхөн гэмээр хонгорхон охинд нь сэтгэл алдарч байж билээ. Арван дөрвөн настай алдрай жаахан Ану гүнж. Найман салаа өтгөн хүрэн гээг нь нарны гэрэлд алтран гялалзаад л очтон гялалзах жижигхэн хар нүднийх нь урт сормуус ягаахан хацартайгаа хоршин сүүдэртээд л...Бурханы шавь болж сахил санваар хүртээгүйсэн бол тийм л хонгорхон сэвгэртэй цэцэгт талаар дөрөө харшуулан морин дэл дээр хийсгэж явах нь хорвоогийн дээд жаргал байх сан. Олон он жил Цастын орноо сууж бурханы ном үзэн, хорвоогийн элдэв нүглийг тэвчсээр өдийг хүрэхдээ, хааяа нэг гудамж зээлээр явахад заншил ёсоо даган цайны хандаар нүүрээ будсан хүрэн царайт төвд хүүхнүүдийг харсаар байгаад цасан цагаахан царай, ягаан хацарт хээр талын үзэсгэлэнт монгол охинтой анх учирсан нь Ану байсан сан.

Тэр жаалхан сэвгэрийн алтан хатгамалтай хөх торгон лавшигаа түрэн томбойж асан бяцхан хоёр хөхийг санамагц Галдан ламтны нандин эрхтэн гантайтал босоход сандран сэтгэл тайтгаруулах тарни уншин ухаан бодлоо түвшитгэхийг оролдлоо.

Хаалга зөөлхөн тогших чимээнээр тэр сая сэхээ орж:

-За! хэмээн ширүүхэн дуугарваас эхийнх нь шадар хэвтүүл Буянтөмөр зогсч байлуга.

-Жаа, хувилгаан агь минь. Сэнгэ хааны \Дүүгээ Цастын орноос ирснээс хойш Сэнгэ биеэ хаан хэмээн дуудаж байхыг албатуудаасаа эхлэн, хавь ойрын ноёд ихэст зарлигджээ\ ёслолын өргөөнд ирнэ үү хэмээн ахайтан хэлүүллээ.

-За мэдлээ гээд номоо хураан босохдоо Галдангийн сэтгэл тохинон хорвоогийн нүгэлт шунал тачаалаас ангижирсан ч сэтгэлийн гүндээ уй гуниг дүүрэн байлаа.

Цастын орондоо номоо бясалган, Чойнхор дүйцэн хурж суусан сан бол сэтгэл үймрэхгүй, амар амгалан байх байж дээ хэмээн тэрээр Ойрадад буцаж ирсэндээ анх удаа харамсах сэтгэл төрөн төрөн, ахынхаа ёслолын өргөөний зүг навчсаар уйлах бутнуудын дундуурхи хайрга,алаг чулуу дэвссэн явган жимээр алхалж явлаа.

Эцэг нь амьд ахуйдаа байгуулсан хөх тоосгон хэрэм доторхи чулуун ордон, жижигхэн хиймэл цөөрмүүдийг тойруулан суулгасан уд мод, нохойн хошуу, үхрийн нүд, чацарганы бутнууд, нилээд өндөр ургасан улиас модод бүхий бяцхан цэцэрлэг цөм хуучнаараа. Мод, бутнууд навчсаа гөвжүлмэдэгхэн сэрчигнэх салхинаа аяар аяархан шуугина.

Хөлөөр хөглөрөх навчис шаржигнуулсаар Ёслолын өргөө гэгддэг Дотоод ордон руу ороход

дааман хаалга сахисан харуулын цэрэг эрс хувилгаан агийг хүндлэн мэхийж, өөрийг нь хүлээн зогссон бололтой залуухан гоцго:

-Сэнгэ хаантан, хатан эхийн тань хамт зөвлөлдөх танхимд таныг хүлээж буй хэмээгээд замчлан бөхөлзөв.

Эцэг нь амьддаа энэ танхимд төрийн хэргээ явуулдаг, сэтгэл зүрхийг нь булаасан алдрайхан Анугийн эцэг Очирт хан ч идэр залуудаа энэ танхимд мөн ч олон удаа ирж байсан даа.

Залуухан гоцго танхимын хоёр хавтаст хаалгыг үлмэдэг чихруулан нээж өгөхөд Галдан ижий, ах хоёрынхоо хүлээж суугаа, эцгийнх нь сүрлэг хөргийг хоймортоо залсан уужим танхимд орж явчихлаа.

Ард нь хаалга чимээгүйхэн чихран хаагдахад Галдан:

-Хаан ахын болон ижий таны амрыг айлтгая гээд ахын баруун талын алтлаг шар өнгийн хоргой бүрээст сэнтийд очин суулаа.

-Амгалаан, дүү минь тавтай юу хэмээн ах нь мэндийн хариу хэлэхэд эхийн ядрангуй царайд бахтай мишээл гэрэлтэн:

-Хүү минь амгалан морилж байна уу?Ижий нь сайн л байна гэлээ.

-Ижий аян замдаа сайн явсан биз дээ? гэж Галдан асуугаад юуны учир өөрийг нь зөвлөлдөх танхимд дуудуулсныг ухаж ойлгох санаатай эх, ах хоёрынхоо царай руу ээлжлэн харав. Эх нь сарын өмнө Хөх нуур руу одоод өчигдөрхөн буцаж ирсэн тул тухтай уулзаж амжаагүй байжээ.

-Хүүгийнхээ уншсан аян замын ерөөлөөр тэр юм уу,холын замд өчүүхэн ч ядарсангүй.Сайн яваад ирлээ. Хөх нуурын газарт Очирт цэцэн ханыхнаар айлчлаад /Энэ нэрийг сонсоод Галдангийн царай хувьсхийхийг Юм-Агас хатан ажаад таамаглал нь ханатай байсанд залбирчээ.Галдан цастын орноос буцаж ирээд нэг л юманд санаашран,шалтаг гарвал л тойруу замаар Очирт цэцэн ханы Ану гүнжийн тухай тандсан яриа өдөөд байхыг ажигласан эх нь хүүгээ тэр адтай бяцхан сэвгэрт сэтгэл алдарсан байж мэдэш хэмээн сэжиглээд яаравчлан Сэнгэ хүүдээ хатан болгон гуйхаар шийдсэн юм байж/ ирлээ. Хэдий санаа буруулж асан ч Аблай тайжийнхаар зочиллоо. Хөх нуурын Шүхэртийн хийдэд бүрлээч эцгийн тань нэрээр суварга босгуулахаар болж, шинэ барьж буй дуганд нь хандив буян өргөлөө хэмээн урсгалаа.

Галдангийн хувьд эхийн яриа хэдий өөрийнх нь сонирхох ёстой шашин номын хэрэгт холбоотой байсан ч Очирт цэцэн ханыхнаар гийчилснээс бусад нь сонирхол татсангүй.

Гэтэл чигээ залгилан нанхиад заншлаар зүүн алгандаа тугалган бөмбөлөг эргэлдүүлж суусан Сэнгэ ах нь хулаа хаш ширээн дээрээ тавиад:

-Ижий маань надад Очирт цэцэн хантны Ану гүнжийг ураглахаар яриад нааштай хариутай ирж. Хувилгаан дүү чи энэ тухайд ямар бодолтой байна? хэмээн түс тас асуучихдаг байгаа.

Амандаа тарни шившин эхийн яриаг бараг л нойрмоглоон сонсч суусан Галдан энэ үгийг

сонсоод чихэн дээр нь аянга ниргэх шиг л тас буугаад явчихад арай гэж л биеэ барьж дөнгөөд:

-Аа, юу... тэгэлгүй дээ. Танд Очирт цэцэн хан, чуулганы ханы түшиг хэрэгтэй хэмээн чихарсан дуугаар арай ядан хариу өчихийг эх нь ажиглан хуруундаа үлдсэн ганц бэлзгээрээ оролдон суух аж.

-Харин тийм. Тэгээд аз болоход тэр сэвгэрийн хөөрхөн гэдэг нь. Уржнан би Очирт ханыхнаар зам зуур дайраад харахад бүр сэвгэр шинжээ олчихсон байсан. Урьд нялх байхад нь ч түүнийг анзаардаггүй байсан юм аа хэмээн Сэнгэ хөгжин ярихад Галдангийн сэтгэлд ёстой л говийн угалз шиг хүчит шуурга дэгдэн, хайртай бүсгүйгээ ингээд эгнэгт алдаж буйтайгаа хүчлэн эвлэрэх, түүнийгээ төрсөн ахдаа найр тавин өгөхдөө сэтгэлээ амгалан байлгах гэж байж ядан тэмцэж байж билээ.

Харин бэлзгээрээ оролдон суусан эх нь “Дөрвөн Ойрад даяар цуутай Галдмаа баатар ч Сэнгийн хадам ах болно гэдэг бүр чухал.” гээд Анугийн бичиг ном, цэргийн эрдэмд төгсийг магтах гэснээ Галдан хүүгийнхээ сэтгэлийг бодоод больчихов. Тэгээд дотроо “Хүү минь сэтгэлээ барь. Зүрхээ захир. Заяа тавилантайгаа эвлэр. Бурхан номын хэрэгт зүтгэн, хорвоогийн нүглийг тэвчих тангарагтай санваартан, Бурханы шавь, Ойрад түмний номын их багш гэдгээ бүү умарт! Хайртай бүсгүй чинь хүний хүн биш, харин зулайгаа гишгэж төрсөн ахын чинь гэргий хатан болох гэж байгаад баярлан ерөөл айлд” хэмээн хүүгээ аргадан аргадан залбирч байлаа.

-Тэгээд... Ану гүнжийг ёс төртэйгээр хэзээ сүйлэх юм бэ? Ижий та тэр тухай ярилцаа юу? Заяа төөрөг, оюу чулууг\* нь нь би үзье дээ хэмээн Галдан арайхийж биеэ барьж чадаад эхийн нүүр өөд харан асуухдаа харц нь тогтохгүй л байлаа. Юм-Агас:

-Очирт цэцэн хан, эцгийн хувьд татгалзахгүй, харин охин арай балчир байна. Хойтон бичин жил гарахад сүй бэлгийн тухай хэлэлцье гэсэн хэмээн нам дуугаар ярилаа.

-Дүү минь чи Ану бид хоёрын оюу чулууг харж, засал ном айлдаж өгнө биз дээ хэмээн ах нь хайхрамжгүйхэн хэлэхэд Галдан:

-Жа хэмээн өчихдөө хоолой нь үлмэдэгхэн чичирснийг эх нь л анзаарчээ.

Хөх нуур. Хөх дэрсний булан дахь Очирт цэцэн ханы намаржаа.

Ану гүнжийн багштан Дүүрэн бичээчийн архаг хууч хөдлөн сар гаруй таг хэвтээд илааршин босч, шавьдаа номоо зааж эхлэв.

Намрын будан уулаад хөшиглөсөн тэр нэгэн өдөр зуны турш багшаа өвчилж хэвтсэнээс хойш охины хүсэн хүлээсэн домогт хатдын тухай хүүрнэлээ залган үргэлжлүүлээ.

-Судар ном эргүүлсэн хэдэн зүйл тэмдэглэл олж эвлүүлсээр шавь чамд би Хотол цагаан гүнж Аюуругийн тухай хүүрнэхээр бэлтгэлээ хэмээгээд багш нь хоолойгоо засч үргэлжлүүлэн:

-Хотол цагаан гүнж Аюуруг нь Өгөдэйн үр ач нарын нэг, ухаан сэргэлэн, алсын хараатай хэмээн цууд гарсан Хайду ноёны охин юм.

Хайду ноён шавь чиний нэгэн адил Их монголын нийслэлийг нанхиад оронд шилжүүлэн харьд төвлөсөн Юань гүрнийг байгуулахыг эсэргүүцдэг хүн байсан. Тиймд Хубилай хааны эсрэг тэмцлийг толгойлон Аригбөхийг тууштай дэмжиж байсны улмаас Мөнх хааны үед хааны эсрэг хуйвалдаанд оройлон оролцсон хэргээр төвөөс хол цөлөгдөн суусан ноён байж. Хайду ноён Монгол гүрний нийслэл Монголдоо л байж, эцэг өвгөдийн уугуул голомтоос их гүрнээ захирах ёстой хэмээн үзэж, Хубилай хааныг хятадын нөлөөнд хэт орсон хэмээн буруушаасаар байсан тул хожмоо Мөнх хаан түүнээс болгоомжлон Тарвагатайн өмнө этгээдэд тусгай цэрэг суулган сэргийлж байжээ.

Хайду ноёны Аюуруг гүнж буюу Сарангэрэлт гүнжийн тухай түүхэн баримт, домог хууч зарим сурвалжид тэмдэглэгдэн үлдсэнийг хүүрнэе дээ.

Энэ гүнж хар бага наснаасаа “Хүү хүний зантай, эрэлхэг баатарлаг атал үзэсгэлэн гоо өнгө зүстэй төрсөн тул эцэг нь олон хүүхдийнхээ дотроос онцгойлон хайрладаг байсан” хэмээн Рашид АдДин бичжээ.

Хайду ноёны дөчин түмэн цэргийн дотор эрэлхэг баатарлагаараа Аюуруг гүнжтэй эн тэнцэх нь цөөхөн байв. Аюуруг \Сарангэрэлт\ гүнж арван тав хүрмэгц эцгээ даган дайн тулаанд явах болж, их цэргийг оройлон байлдаж, дайсны жагссан цэргийн дундаас морьт баатруудын нэгийг сугалан амьдаар нь олзлон авчирдаг зориг самбаа ихтэй, мохошгүй хүчтэй бүсгүй байв гээд Анугийн зүг сэм харвал охины нүд гэрэлтэн сурсан зангаараа шанаа тулаад ихэд таашаан сонсч суувай.

Хайду ноён тэр үед охид сэвгэрүүдийг шууд хүчээр богтлох буюу сэтгэлгүй хүнтэй нь сүй тавиулан урагладаг уламжлалыг зөрчин хайрт охиноо өөрийн дур хүслээр хадамд гарч болохыг зөвшөөрсөн бичиг шийтгэн өгсөн гэдэг. Багшийнхаа ярианы энэ хэсгийг сонсоод Ану хайр сэтгэлгүй Сэнгэ хаантай хойтон жил сүйлэх болсноо гэнэт санаж гуниглачихав.

Багш нь охины нүүрний хувирлыг гярхай ажигласан ч үл анзаарагчин болж хүүрнэлээ үргэлжлүүлнэ. Тэр хоёрыг шастир түүхийн хүүрнэл хичээл хийж байх зуур багшийн гэргий Зэсэнжав саад үл болохын тулд өнгийн торгон утас гарган хатгамал хийж суудаг зангаараа дэрний бүтээлэг дээр үзэмж төгөлдөр цэцэг, эрвээхэй зэргийг хатган нам гүмхэн суунгаа басхүү сониуч зангаар эр нөхрийнхөө цадиг хууч хүүрнэхийг чагнах ажгу.

Хайду ноёны Аюуруг гүнж бяр чадал нэн их, хэрийн эр хүнд үл дийлдэх тул “Хүчийг үзэн барилдаж, хэн нэгэн эр намайг дийлбээс би түүнтэй гэрлэх болно. Хэрэв намайг хаяж хүчрэхгүй бол зуун агтаар торгоно” хэмээн зар тараажээ. Гүнжийн түгээсэн зар Монгол гүрний олон эзэмшил даяар тарж, газар газрын идэр залуус, эгнэшгүй хүчтэнгүүд цуглан тэмцэлдэх болов. Домогт өгүүлснээр тэдний дунд Самарканд Бухар орчмын уулархаг орон Памир улсын вангийн хунтайж, нүд булаам сайхан эр бараа болоочдоо дагуулан, мянган сайн агт туусаар ирсэн гэдэг. Хунтайжийн ирсний маргааш Хайду ноён хатдынхаа хамт өргөө хүрээнийхээ төвд босгосон цацартаа тухлан, албат иргэдээ тойруулан сууж Памирын хунтайж, Аюуруг гүнж хоёрын тэмцэлдээнийг сэтгэл хөдлөн үзжээ. Цацрын өмнө гоёмсог



зодог шуудагтай гарч ирсэн бүстэй, бүсгүй хоёр хүчтэнийг цугласан олон хараад залуу нас, гоо үзэсгэлэн, ид хавыг нь гайхан биширчээ.

Памирийн энэ сайхан хунтайжид Аюуруг гүнжийг дийлдэн гэргий нь болчихоосой хэмээн эцгийн хувьд Хайду ноён ихэд хүсэмжилж байсан ч төдөлгүй “хотол цагаан Сарангэрэлт” гүнж өнөөх залууг дээр хөвсийтөл өргөөд шидчихэв гэнэ. Нэгэнт ялагдсан хунтайж тууж ирсэн мянган агтаа алдаад бараа болоочдоо дагуулан хоосон буцсан гэдэг.

Үзэсгэлэн гоо царай, үнэн хүч чадлыг нэгэн биед цогцлуулан төрсөн Аюуругийг хаях хүчтэн тодроогүй тул өөрийнхөө хүслээр Курлас овгийн эгэл цэрэгтэй хуримлан хоёр хүү төрүүлжээ.

Хайду ноёныг таалал төгссөний дараа Урус хэмээх хүү нь төрийн эрхийг эзэлснийг Аюуруг гүнж үл зөвшөөрөн эцгийн суурийг эзлэхийг хүсэмжлэн тэмцсэнд ноёны Чидар, Дува, Урус нэрт хөвүүд нь хилэгнэн “Чамд утас, зүү үйл үртэсний ажил чинь чухаг эрхэм тул төр улсын хэргийг юугий нь мэдэх вэ!” гэцгээсэн тул арга буюу төрийн хэргийг засаглах эрмэлзлээ орхин гэртээ буцсан ажээ.

Хожим “Хотол цагаан” Аюуруг Сарангэрэлт гүнж Или, Чу голын хөндий дэх Шонхорлигт нутаглуулсан хайрт эцгийнхээ онгоныг батлан сахих болсон гэдэг.

Дараагийн удаад Ануд багш нь Хубилай хааны хүү Чингим хунтайжийн Хөхөгчин хатны түүхийг хүүрнэв.

Чингим нь урьд чамд ярьж өгч байсан ухаант Чимбай хатнаас төрсөн зан ааш номхон, ил шулуун, ухаан уужим, ачлалыг үл огоорох, цэрэг дайн, эрдэм номын үйлд тэгш чадварлаг тул Хубилай хаан энэ хүүдээ хаан сууриа залгамжлуулахаар амьддаа шийдээд байсан юм.

Иймээс Чингимийг ерөнхийлөн захирагч шадар сайд бөгөөд, цэрэг дайны хэрэг эрхлэх жанжнаар томилон, төрийн чухал хэргийг хаанаас түрүүлэн Чингимд айлтгаж байх зарлиг гаргасан нь хунтайжийг хожмын хаан болж төрийг жолоодоход нь чиглүүлж байсных ажээ.

Гэвч Хубилай хаан урт насалж, Чингим эцгийн урьд орж, өвчнөөр нас эцэслэсэн тул олон хөвүүд, ач нарын дотроос түүний хүү Өлзийтөмөрт хаан ширээ залгамжлуулахаар гэрээсэлсэн бөлгөө.

Хунтайж Чингимийн хатан Хөхөгчин бол Бөртэ үжингийн төрхөм Хонгирад аймгийн эгэл ард угсаатай бүсгүй байсан байна. Хонгирад аймаг нь “Харь улсыг үл довтлон

Хацар сайт охидоо

Хаан болсон ... бүхний

Хатан сууринд суулгадаг” уламжлалтай , хацар гоо охид ихтэй тул, зээгийн зүсээр, охидын өнгөөр явдаг заншлын дагуу охидоо төрийн хатан болгох бүхий л эрдэмд сурган бэлддэг байв.

Их Монгол улсын хаадтай ураглан төрийн хатад болсон Өэлүн эх, Бөртэ үжин, Чимбай хатан, Намби хатан, Сүйлэн гэх мэтийн ухаант бүсгүйчүүд цөм Хонгирад аймгийн охид бөлгөө.

Тиймээс Хубилай хаан ор залгамжлагч хүү Чингимдээ мөн л Хонгирад аймгаас бэр буулгасан нь Хөхчин болой. Эгэл ард угсаатай энэ хатан энгийн даруу, эрдэм ухаанаараа түүхийн хуудаснаа үлдэж чадсан бүсгүйчүүдийн нэг юм.

Анх Хөхчин охиныг их хаан хүүдээ олж авсан түүх нь домог болон үлджээ. Хубилай хаан чигээнд их дуртай хүн байж. Их хаан нэгэн удаа ан авд явж байгаад тэвчишгүй ихээр ангасан тул зам зуур таарсан айлд ортол нэгэн залуу охин тэмээний ноос зулаад суух юм гэнэ. “Амны ангаа тайлах чигээ өгөгтүн” хэмээн хааныг гуйхад охин “Чигээ манайд бий нь бий. Гэвчиг аав, ээж, ах дүү нар бүгд гадуур явцгааж, гэрт би л үлдсэн. Хэдий гийчнийг ундаалаагүй ёс алдсан хэрэг атугай ч өчүүхэн охин би толгой мэдэн үл таних эр хүнд юм өгч яахин болох буй” хэмээн өчихөд нь аргагүйдсэн эзэн хаан үгийнх нь үнэнд гүйцэгдэн гарч явах гэтэл охин “Эрхэм хүмүүн гэрт минь морилон ороод амарч алжаалаа тайлах ч үгүй буцаад одох гэж үү? Хэрэв таныг ингээд явчихвал би хэрхэн сэтгэл амар хоцрох билээ? Та манайд суугаад аав, ижийг минь ирэхийг хүлээж хайрлаач “ хэмээв. Удсангүй охины эцэг эх гэртээ ирэхэд Хубилай хаан тэгтлээ уухыг хүссэн чигээгээ ханатлаа ууж цангаага тайлаад охины ухаан цэлмэгт биширсэндээ хүү Чингимдээ хатан болгож буулгасан гэдэг юм даа.

Хөхчин Чингим хунтайжийн хатан болоод Гамала, Дарамбал, Төмөр гэсэн гурван хөвүүн төрүүлсэн байдаг. Хубилай хаан чухам энэ хүүдээ хаан сууриа залгамжлуулах хүсэлтэй байсан ч эцгээс урьтан нас нөхчсөн тул Хөхчин хатан, төрийн мэргэн сайдуудтай зөвлөлдөөд отгон хүү Төмөрийг хаан сууринд залахаар тогтжээ. Энэ тухайгаа Хубилай хаанд дуулгахад их хаан зөвшөөрсөн гэдэг.

Аргын 1294 онд Хубилай хаан өөд болов. Хөхчин хатан төрийн их хатны хувьд Баян ноёныг элчээр заран Хубилайн эсрэг тэмцэгч Хайду ноёны бослогыг дарахаар Алтай орчимд албан хааж байсан хүү Төмөртөө илгээгээд, хүүг алсын газраас хүрэлцэн ирэх хүртэлх нэг жилийн хугацаанд нь төрийн эрхийг гартаа авчээ. Энэ хооронд Төмөр хунтайж Алтайгаас их цэргээ хурааж, дээд нийслэл Дайдуд хүрэлцэн очиж Хуралдай зарлав. Алтан ургийн зарим ноён ахмад хүү хаан суух ёстой хэмээн Чингимийн их хүү Гамалаг дэмжиж байж. Эшитөмөр хэмээх түшмэл”Хубилай хааныг тэнгэр боллоо гээд хаан ширээг эзэнгүй удаан байлгаж үл болно. Хунтайжийн тамгыг Их хаанаас авсан хүү байсаар байтал Гамала ван та юунд эргэлзэнэ?” гэсэнд Гамала босч “Их Хаан болох эзэн нь суудалдаа залрах аваас миний бие түшмэл болж хүчээ өгнө” гэсэн тул хуралдайд ирсэн олон сайд түшмэл, жанжин цөмөөр Төмөрт мөргөжээ. Персийн мэргэн бичгийн хүмүүн Рашид АдДина бичсэнээр “Хаан залах их хуралдай дээр Гамала ван, Төмөр хунтайж хоёр маргалдсанд Хөхчин хатан “Сэцэн хаан сэрүүн тунгалаг ахуйдаа Чингис хааны билэг сургаалийг хэн сайн мэднэ, тэр хүн их хааны суурийг залгамжилна” хэмээн гэрээсэлсэн. Хоёр хүү түмэн олны өмнө билэг сургаалийг айлдацгаа гэсэнд Төмөр хунтайж Эзэн Чингисийн сургаалийг яруу сайхнаар уншсанд ноёд, түшмэлүүд сөгдөн мөргөж, их сэнтийд залж, “Тэнгэрийн зарлигийг үүрд эзэлсэн, эвдэршгүй мөнх эрдэнэ” гэсэн үсэгт тамгыг өөрсдийн гараар их хаанд гардуулжээ.

Өлзийт Төмөр хаан Хөхчин хатан эхдээ “Хуанхоу тайху” буюу хааны эх цол өргөмжлөн барлаг зарц нарынх нь тоог нэмж, алтан ургийн хуралдайд оролцон мэргэн сургаалиа хайрлаж байх эрхийг шийтгэж олгов.

Хожмоо Өлзийт Төмөр хаан Хөх мөрний өмнөх тарианы уудам газрыг эхдээ өгөхөд “Ганц бие

эхнэр надад үржил шимт ийм арвин газар хэрэг юун. Мөрний өмнөх шимт газар бол улсын маань өмч билээ” гээд хүлээж авалгүй энгүүн амьдралаар суух болжээ.

Өлзийт Төмөр хаанд өргөмжлөгдөөд удалгүй Хубилай хааныг эсэргүүцэн тэмцэгч Хайду ноёныг дарахаар цэрэглэн мордох гэхэд нь эх нь “Умард орны цэрэг шилдэг агаад тулаанд туршлага арвин. Тийш одох зам урт бөгөөд бартаа их. Ирэх очиход бүтэн он зарлагадах зуур Дундад орны хаан ширээ эзгүйг шамшигдуулан бослого урвалт гарна” хэмээн хориглосноор дайн дажин үүсгэлгүй өнгөрөөсөн гэдэг. Өлзийт Төмөр хааны үед ард олон сэтгэл тэнэгэр, гар газар, хөл хөсөр байсан нь ухаант Хөхчин хатны гавьяа байсан юм. Хубилай хаанаас хойшхи Монголын их хаад цөм Хөхчин хатны үр сад билээ хэмээгээд багш нь яриагаа төгсгөв.

Багшийнхаа хүүрнэлийг амтархан чагнасаар бүхий л бие нь хөшсөн Ану охин их сүүрс алдан босоод:

-Багш та их чилэв үү? Хичээл зүтгэл гарган олон ном судар эргүүлэн уншиж байж монгол хатдын тухай тэмдэглэлийг шүүрдэн надад ийм эрхэм чухаг мэдлэг олгож буйд Танд талархаад баршгүй. Түүхэн ном сударт ихэн гол нь хаадын түүхийг бичдэг тул гагцхүү надад зориулан хатдын тухай энэ арвин хүүрнэлийг хичээн бэлтгэсээр биеэ муутгах вий хэмээн зовиновч, дараа нь чухам аль хатны тухай хүүрнэх бол хэмээн хорхой асах юм гэлээ.

Багш нь хүнд болор шилээ нүднээсээ авч, гэргийнхээ өгсөн зөөлөн цэмбээр зүлгэнгээ:

-Урьд надад бүсгүй шавь байгаагүй. Иймд хэн ч надаас монголын түүхэнд мөнхөрсөн ухаан мэргэн хатад, гүнж нарын тухайд нарийвчлан судлах санаа сэдлийг өгч байсангүй. Харин шавь чи ухаан сэргэлэн, эрдэм сурах эрмэлзэл дүүрэн учраас надад монгол хатдын түүхийг сонирхон судлах сэдэл өгсөнд би шавьдаа талархууштай хэмээгээд:

-Манай монгол угсаатны бахдууштай нэгэн чанар бол буруу номын лал сүсэгтэн, Хүнзийн сурталт нанхиадууд шиг бүсгүй хүнийг илт дорд үл үздэг. Харин ч түүхэнд тодорсон олон ухаант хатад төрийн жолоо атгаж явсан. Эзэн Чингис, Хубилай, Гүюүг, Мөнх хаан цөм элбэрэлт эх, хатдынхаа ухаант сургааль, үг зөвлөмжийг сонсч явсан түүхтэйг шавь чи ойлгож ухааж авсан биз ээ. Нанхиадын бичгийн их хүмүүн, суртал номлогч Хүнз “Эм хүнд тахианы тархи заяажээ. Эгэл нэгэн эм хүний тархи нэг тахианыхтэй эн тэнцэнэ. Эгэлгүй ухаант эмийн тархи хошоод тахианыхтэй энэ тэнцэнэ” хэмээн айлдсан байдагчлан, урд зүгийнхэн охидын хөлийг хатаан шувууных мэт жижиг болгоод гэрээсээ алхам ч холдож чадахгүй болгодог. Харин манай монгол охид сэвгэрүүд морин дэл дээр хийсэн давхилдаж, уужим хээр талаараа эрхлэн тоглож өсдөг билээ гэжээ.

Ану охин энэ жил урьд урьдынхаас илүү өсөн төлжиж ноднингийн хийлгэсэн хуяг, цээживч нь бачуудах болсон тул маргааш нь ном үзэхгүй сул өдрөө ашиглан ямагт хантныхаас саахалтын зайд нутаглан, эр цэргийн зэр зэвсэг, хуяг дуулга урлан, засч сэлбэдэг дархчуулын отогт Мандарваа, Балсан хоёроо дагуулан очлоо.

Дархчуулын аглагч Жанчивдоржийнд тэр гурвыг ороход гэрийн эзэн өөрөө дархны газраа байсан тул гэргийнх нь аягалсан хүйтэн сайхан чигээг залгилангаа:

-Чилэдү, Чилэгэр хоёр хаачаав хэмээн Ану асуулаа.

-Чилэдү дарханы газар эцэгтээ тусалж буй. Чилэгэр их агт руу одсон. Ороо адуу цаламдахдаа онцын гарамгай хэмээн агтчин Мандах түүнийг магтсан юм даг уу даа. Тэгээд л агтны зүг гүйх болсон хэмээн айргийн тос базалж суусан Мэнд эхнэр өгүүлээд:

-Чилэдү дархан болох дуртай байгаад эгч нь нэн баяртай суугаа. Юмыг яаж мэдэх вэ, дайн тулаан болж цэрэг хураавал нэг нь ч гэсэн дархан юм гээд гэртээ үлдэнэ шүү дээ гэж цайлганаар өгүүлэхүйд нь Ану энгүүн ард байх, эх хүн байхын хүндийг ухааран их л өрөвджээ.

Сул ард хүн хөвүүнээ цэрэгт мордон дайнд одоход “явуулахгүй” гэх толгойгүй шүү дээ. Тэгээд арван сар хэвлийдээ тээж, алтан заадас салган төрүүлж, ангир уургаа шимүүлэн өсгөж хүн хийсэн идэр сайхан хөвүүн нь атаатны сум, сэлмийн ир, жадны үзүүрт өртөн хаа хол харь газар үхэхэд эх нь охилон уйлахаас өөрийг хийж чадна гэж үү? Одоо энэ Бундирын ээж байна. Эр нөхрөө дайнд алдаад хөхнөөс гараагүй нялхаас арван гурав хүртэлх насны дөрвөн хүүхэдтэй бэлбэсрэн үлдээд, энэлэн гашуудсанаасаа болж хэдхэн жилийн дотор л өтөл буурай эмгэн болон хувирсан.

Хүүхдүүдийг дархны газар очиход Чилэдү эцгийн хамт хөөрөг үлээн намрын энэ дулаахан өдөр дотор нь хүн байхын аргагүй халуунд хөлсөө гоожуулан ган төмөр сэлэм ширээж байв. Тэгснээ багын найзуудаа хараад Ануд хүндэтгэн мэхийсэн атал, Мандарваагаас ичсэндээ халуунд улайсан нүүрнийхээ хөлсийг хажуу дахь хиртэй цууямбуу алчуураар шудран арчигчин болж царай буруулан цааш эргэв.

-Аа, Ану гүнж, Та амгалан морилж явна уу? хэмээн Жанчивдорж дархан амар мэнд мэдээд пүнхийсэн халуун дарханы газраасаа гарч ирэн сүүдэрт зогсов.

-Амар мэнд ээ. Та амар сайн байна уу? хэмээн Ану мэнд мэдэлцээд:

-Миний хуяг надад бачуудаад, цээживч бас багадсан. Би энэ жил их өсөөд байна. Та хэмжээ аваад шинэ хуяг хийж өгөөч гэлээ.

-Та дараа жил мөн л хуягандаа багтахгүй болно доо. Охин хүүхэд лавтай арван таван сүүдэр хүртэл өсөөд зогсоно. Иймд би одоо байгаагаас тань арай эцээхэн уужуу хуяг хийе. Цээживчээ мөн тэгж хийлгээрэй. Бас хоёр хөхөн дээр тань тааруулан алтадсан ган толь хийх болно хэмээн Дархан хэлээд цээж, нурууных нь хэмжээг нарийвчлан авч хоцров.

-Ану, Сэнгэ хаан тантай сүй тавих юм гэж үнэн юм уу? хэмээн буцах замдаа Мандарваа палхийтэл асуудаг байгаа.

Тэр тухай аль болох л санахгүй бодохгүй байхыг хичээн, эцгийн өргөөн дэх амарлингуй, хөгжөөнт амьдралдаа умбаж байхыг зорьсон Ануг энэ асуулт нэлээд цочирдуулав.

-Яаж байна? Чи юун ч илүү хоншоортой амьтан бэ?

-Өргөөнийхөн тэгж шивэр авир хийцгээгээд байхаар нь асууж зүрхлэв. Та хэрэв Сэнгэ ханд ураглан одох аваас би ч мөн дагаад Ховог сайрын тийш явах тавилантай шүү дээ. Илүү хоншоорлосондоо бус өөрийнхөө хэтийн заяа төөргийг мэдэх гэж л... хэмээн Мандарваа нүдний булангаар хяламхийн гэмшингүй өчихөд нь Ану бас л харц ард хүний тавиланг ухаарч сая зөөлрөн:

-Тэр үнээн. Хойтон жил сүй тавьж ургийн хэргийг хэлэлцээд, намайг арван долоо хүрэхээр мордуулах байх. Тэр хүртэлх гурван жилд зай ч байна, лай ч байна даа, Мандарваа минь гээд сартай хээр мориндоо ташуур өгөн ухасхийв. Хоёр охины яриаг чагнан хэзээний зангаар дуугүйхэн явсан Балсанд ч энэ хэрэг хамаатай атал юу ч шалгаасангүй. Харин хоёр нөхрөөсөө морины хурдаар сугаран давхисан Анугийн хойноос хатирч хүрнээрээ элдэн хурдлав.

-Та хоёр зүгээр хашин морьтойг минь мэдсээр байж намайг тоосон дундаа хаяад давхичих юм аа хэмээн Мандарваа гомдоллосоор хойноос нь сажлуулна.

Тал хөндий намрын гоёл алтлаг шаргал лавшигаа нөмөрч, хорвоо дэлхий амарлингуй налайсан сайхан өдөр байлаа. Хээрийн бор оготно, тарвага, зурам айсуй хахир өвөлд бэлтгэн нүхнийхээ аман дээр хөөөгөө хурааж, усны шувууд дэгдээхэйнүүдээ дагуулсаар зэллэн нисч ганганалдана.

Хөөрхий хашин морьтой Мандарваагаа эргэн хараад Ану сая хурдан хүлгийнхээ амыг татан хүлээзнэв. Дүү Булганаа бодвол хор шар багатай, тайван намуухан ааштай ч аргагүй талын морьтон монгол угсааны үр сад тул хээр хөдөө морьтой явах тоолон тоосонд булагдан хоцордогтоо бухимдсан Мандарваа хашин морио ташуурдаж, давьчсаар тэр хоёрыг гүйцэн ирээд:

-Яршиг, би энэ муу урагшаа алхахаа мэддэггүй хашин морьтой дахин хээр хөдөө гарахгүй хэмээн хошуу унжуулав.

Ану тас тас хөхрөөд :

-За би Мандах гуайд хэлээд чамд сайвар борыг бариулья даа. Хошуугаа бүү унжуулаад бай. Надаас хоёр насаар эгчмэд атал нялх мэт аашлах юм хэмээн доог хийснээ зүүн зүг рүү ширтэн санаа алдаад:

-Манай зуслангийн тэндэх Тохомын тойрмын хоёр хун гурван хөөрхөн дэгдээхэйтэй болсон байсан. Энэ шувуудтай хамт буцаж байгаа байх даа хэмээн өөртэйгээ яриад ч байх шиг аман дотроо бувтнаад “Тэгэхэд Сэнгэ хаантай ураглах тухай яриа гараагүй дөнгөж л Галданг явсны хойно гэгээн хутагт санваартан гэдгийг нь мэдсээр байж сэтгэл алдарч, бас ч хойчийн амьдралд өчүүхэн төдий найдлага горьдлого байж дээ. Одоо гэтэл би түүний төрсөн ахын хатан болох нь илт болчихлоо. Гэсэн ч тэр намайг санан дурсч, ахынх нь хатан болох гэж байгаад харамсан гашуудаж байгаа болов уу? Бурхан та юунд намайг хэзээ ч эхнэр хатан авахгүй санваартан хүнд дурлахыг таалав даа.” хэмээн гуниглан бодож зогслоо.

Балсан, Мандарваа хоёр дуугүйхэн л өөрийг нь ажиглан зогссоор буйг тэр сая л анзаарч :

-Та хоёр чинь эхээ нутаглуулаад буцаж яваа хүмүүс шиг юунд ингэж гуниглачихаа вэ? гэж өөрөө эхлэн уйтгарт автаагүй юм шиг асуугаад морио давирлаа.

Дараа жил зусландаа гарч өнөөх Тохомын бяцхан тойром дээр очиход сэтгэл зүрхний шарх сэдэрэн, бас л ийм гунигт автах байх даа хэмээн охин бодож явлаа.

Тэгээд шөнө нь орондоо ороод шинэ хуяг, цээживч хийлгэх болсны шалтгаан хоёр хөхөө тэмтрэн үзэж жижигхэн алганд нь багтахаа болин томорсныг нь мэдэж хөнжил дотроо ганцаараа атал хуйх, чихнийхээ омгийг улайтал ичжээ.

“Ингээд би том сэвгэр болох нь. Дараа жил арван тав, хий настайгаа арван зургаа хүрч, эцэг эхийн соёрхлоор Сэнгэ хааны сүйт бүсгүй болно. Ижий намайг гэдсэнд байхад навсгар хувцастай удган зүүдэндээ үзэж, тэр нь ахайтан танаас төрөх охин үр хаан хүний хатан болно... гэсэн юм гэнэ лээ. Тэр нь Сэнгэ хаан байж дээ. “Саяхан цорос аймгийн хунтайж байснаа одоо Зүүнгар улс байгуулж хаан болно хэмээн мөрөөдөж, өөрийгөө хаан нэрийдэх болж. Хувилгаан дүү нь энэ олон Ойрад аймгуудыг нэгтгэн захирахад нь хамжаа болж, итгэл төрүүлсэн юм байх даа” хэмээн эцэг нь төлдөрхөн тэднийхээр айлчилсан Зоригт хошуучтай хөөрөлдөж байсныг саналаа. Тэгтэл Сэнгийн “Хувилгаан” гээд байгаа тэр дүү нь хайрынх нь эзэн Галдан ламтан байдаг. Ижийн шүтдэг Арьяавал шүтээн минь өчүүхэн сэвгэр надад сэтгэл зүрхээ захирах хүч чадал хайрлаач. Зүсийг нь хэдхэн удаа үзсэн, өөрөөсөө хорин насаар ахмад Сэнгэ хаанд энэ биеэ хэрхэн тушаана! би Сэнгэ хааны дөрөвдүгээр хатан болон очно. Миний олж дуулснаар Ховог сайрын өргөөнд Сэнгэ хааны хатдаас гадна татвар нь гэж арав гаруй эмс арцалдаж суудаг юм гэнэ лээ. Гуравхан хатантай энэ өргөөнд ижий хэрхэн гашуун нулимсаа урсган сууж, гоо үзэсгэлэнгээ хадгалан өтөл настай тэмцэх гэж хэчнээн үйлээ үздэг билээ. Хөх тоосгон хэрэм, хиймэл нуур, жимст цэцэрлэг, чулуун ордонтой тэр сүрлэг өргөөнд өөрийг нь ямархан заяа тавилан, гашуун зовлон тосч буйг хэн мэдлээ. Энэ бүхнийг бодоод байвал үс минь цайх магад. Маргааш багшаараа яриулах сонин сайхан түүх, хуулж сийрүүлэх судрынхаа тухай л бодье хэмээн гэнэт мэргэн бодол орж ирэхэд нь охин бөх нойрондоо автлаа.

Багш нь энэ удаа түүнд Ойрадын Батула чинсангийн хатан Самар гүнжийн түүхийг хүүрнэв.

-Элбэг нигүүлсэнгүй хаанд дүүгийнх нь гэргий Өлзийт гоо Бэйжийг зааж өгөн зусардаад эцэст нь хилсээр хороогдсон Хутхай таюгийн домгийг санаж байна уу? Шавь минь. Энэ Самар гүнж бол түүний хүү Батулагийн хатан юм.

Элбэг нигүүлсэнгүй хаан Өлзийт гоо хатны үгэнд хууртан Хутхай таюг хилсээр хороосондоо гэмшин хүү Батулаг нь чинсан болгосон ч тэрээр аргын 1401 онд эцгийн цусан өшөөг авч Элбэг хааныг хороожээ. Энэ хүн болбоос одоогоос гурван зуун жараад жилийн өмнө манай Ойрадын тэргүүн байсан хүн юм. Түүний хөвгүүд Тогоон тайш, Эсэн тайш нар цөм түүхэнд мөнхөрсөн цуутай баатрууд байсан. Манай Ойрадуудыг аргын 1208 онд Чингис хаан их улсдаа хураан нэгтгэж, түүнээс хойш Монголын их хааны тохоон томилсон тайш Ойрадыг үе үеийн турш захирах болсон юм. Аргын 1438 онд Ойрадын Тогоон тайш зүүн монголыг эзлэн авч нэгтгэсэн. Дараа нь түүний хүү Эсэн тайш эцгийнхээ үйл хэргийг нь үргэлжлүүлэн нэг хэсэг халхыг Ойрадтэй нэгтгэн захирсныг сурвалж бичигт “Дөчин дөрвөн хоёр эвлэв” хэмээн тэмдэглэсэн байдаг.

Одоо түүхийг нь чамд өгүүлэх Самар гүнж бол Элбэг нигүүлсэнгүй хааны охин. Эцгийг нь хилсдүүлснээ мэдмэгц Элбэг хаан хүү Батулад нь чинсан цол олгож, эш хатан Гөвгүдэйгээсээ төрсөн Самар гүнжээ гэргий болгон өгчээ. Хэдий гүнжийг нь хатан болгон авсан ч Батула чинсан Элбэг хаанаас өшөө авахаар далдуур явуулга хийж эхлэв. Ийнхүү аргын 1401 онд Батула чинсан, Үгч хашха нар зүүн Монголыг довлон Элбэг хааныг алж, эхнэр хатан, эд хөрөнгийг нь олзлон авчээ. Ойрадын захирагч Үгч хашха Элбэгийн хатан Өлзийт гоог гэргий болгон аваад төдөлгүй өөрөө насан өөд болоход нь Самар гүнж Өлзийт гоо хатан, түүний хүү Ажай тайж, Аругтай нарт:

Эзэн тань үхэв

Эртний дөрвөн Ойрад

Эх сүүлээ алдав

Энэ үед хэрэв

Эртхэн дайлаар ирвэл

Эзэнгүй олон Ойрадыг

Эрхбиш дийлж чадна хэмээгээд төрхөмдөө буцахаар нууцаар бэлтгэж байтал Хүү Богаму нь сонсоод:

Учирсан газар муу боловч өөрийн гэр болно

Уг төрхөм сайн боловч хүний газар болно

Ижий та тэгж хэлбэл

Эцэг тэнгэр үл таалах буй за гэснийг Самар тайху үл тоон зүүн Монгол руугаа оджээ.

Энэ тухай Өлзийт гоо хатнаас сонссон Адай хаан баярлан аргын 1410 онд Аругтайг тайш өргөмжлөн өөрийн биеэр арван түмэн цэрэг хураан мордож дөрвөн Ойрадыг дайлав. Ойрад халхын цэрэг хоёр талаас Зэлмэн хадны тэндэх Бор нохойн зоо хэмээх газар тулгаран тулалдаад Адай хаан ялж Батула чинсанг хороон хүү Богамуг олзлон авчрав. Ажай тайж Самар хатан бидэнд сайн үйл хийснийг нь бодон хүүг нь тавьж явуулья гэсэнд Аругтай үл зөвшөөрч”Араатны зулзагыг тэжээж үл болно

Атаатны үрийг өрөвдөж үл болно” гээд “Урьд чиний эцэг намайг араг дор хөмрөн “Аругтай” хэмээн доромжилж байсан, миний ээлж ирж, би одоо эцгийн өшөөг хүүгээс нь авах боллоо” гээд Богамуг тогоон дор хөмрөн боолоо болгосон нь хожим Тогоон тайш болсон билээ.

Дараа нь Тогооны эх Самар гүнж Адай хаанд “Амийг минь аварч хатан болгоод хөвүүдийг минь юунд зарцлана чи?Нэг бол эх хүү биднийг хоёуланг нь алж хая, эс бол эрх дураар нь явуулах буюу “ гэсэнд зөвшөөрч хүү эхийнхээ хамт Ойрад нутагтаа буцжээ. Тэднийг харихад Ойрадын ноёд чуулж байсан тул Тогооноос “Халхын хаан, тайш, эгэл даяар улсын ааль ааш

ямар вэ?” хэмээн сонжиход Тогоон ”Зүүн Монголын Аругтай өтөлж, аливаа үйлс нь бүтэхээ больж, ус мэт сарнинам.Саадаг нь хувилавч санаа нь эс хувилна.Төр мэдэх сайдаа гадаа суулгаж, зэвийн морийг гэрт унанам, өчүүхэн хүнээр төр мэдүүлэн, үрээ морийг зэвлэнэм. Борви хөхүүрт сархад хийнэм,буургүй тэмээ, бухгүй үхэр, азаргагүй адуу мэт байнам” гэсэнд эх Самар гүнж нь сандран “Энэ өчүүхэн хүү биеийг нь зовоосонд өс санан халх-Ойрадыг дайтуулан, доройтуулахыг санаархаж буйг бүү сонс” гэж эв нэгдлийг эрхэмлэн дээдлэхийг хичээсэн ч үгийг нь Ойрадууд эс сонсон дөрвөн түмэн цэрэг дайчлан Халх руу довтолсноос дотоодын хямрал дахин дэвэрсэн гэнэм.

Тогооны тэнгэрт хальсны хойно хүү Эсэн тайш дөрвөн Ойрадыг гартаа оруулаад Чингисийн угсааны Тайсун хаан, түүний дүү Агбаржин жононг хороогоод их хааны сэнтийг эзлэв.

Эсэн тайш ийнхүү Их монголын хаан ширээг булаан эзлээд өөрийгөө их Юань улсын “тэнгэрлэг хаан” хэмээн өргөмжилсөн байдаг. Алтан ургийн бус хааныг ноёд, язгуутнууд хүлээн авалгүй аргын 1455 онд Эсэн тайшийг хороож, Монгол аймгууд бутран дахин шуудайд хийсэн үхрийн эвэр мэт болсон юм.

Агбаржин жононгийн хүү Харагцугийн гэргий Цэцэг нэрт хатан Эсэн тайшийн охин байв. Цэцэг эрээ алдаад долоон сартай жирэмсэн төрхөмдөө буцан ирж нэгэн хүү төрүүлснийг тэр үед эмгэн болоод байсан Самар тайху “Боржигоны үр” хэмээн дээдлэн өөрийнхөө өргөөнд тэврэн авчирч “Баянмөнх” нэр хайрлан асруулаад, Ойрадын Өгэдэй баатрыг “Чи Чингисийн алтан ургийн хойч үеийг аварсан хэмээн монголчуудад үеийн үед өргөмжлөгдөх болно” хэмээн ятгасаар Зүүн Монгол дахь төрөл саданд нь хүргүүлсэн юм гэдэг. Ийнхүү Их Монгол улсын сүүлчийн их хаан Батмөнх даян хааны эцэг Баянмөнх жононг асран тэтгэж эх нутагт нь хүргүүлсэн Самар гүнж Чингисийн алтан ургийн сүүлчийн угсааг аварснаараа түүхэнд мөнхөрчээ.

-Энэ түүх чамд ямар бодол төрүүлэв дээ? гэж багш нь хүүрнэж дуусаад асуухад олон салаа хүрэн гээгнийхээ үзүүрээр оролдон бодлогоширч суусан охин тийн элдвээр аяглахаа орхин царайгаа төв болгоод:

-Самар тайхугийн түүх их сайхан төгсгөлтэй юм.Харамсах юм гэвэл Ойрад, Халх хоёрын мөнхийн зөрчил, эв нэгдэлгүй байдлын дүр юм даа. Багш аа, эр хүн дайн тулаанд юунд ингэж дурладаг юм бэ? хэмээн асуулаа.

Багш нь охины ийн ухаан сэргэлэн, аливааг эргэцүүлэн бодох сэхээтэйд баясан хөгжсөнөө гурван эгнээ үрчлээт уудам магнайгаа агируулан:

-Шавь чи мунхаг миний хэрээс хэтийдсэн асуултаар мэд тавих юм даа. Эр хүмүүс дайнд дуртайдаа дайтдаг хэмээн би бодохгүй байна. Их эрх мэдэл, газар нутаг, эд баялгийн төлөөх шунал хүмүүнийг дайн өдөөхөд хүргэдэг. Миний олж сонссоноор эртний Эллинд дан бүсгүйчүүдээс бүтсэн Амазонууд хэмээх улсын тухай домог буй. Амазонуудын улсад эр хүн үгүй. Ойролцоох арлын эрчүүдтэй жилд нэг удаа учраад буцан ирж, бие давхар болдог.Гарсан хүүхэд нь охин байх аваас авч, эр байвал амийг нь тасалдаг. Хатан хаантай улс байсан хэмээсэн домог буй. Тэр улсын бүсгүйчүүд дайн тулаанч, эрмэг зоримгоороо эрчүүдээс үл дутдаг байсан гэж өгүүлдэг. Мөн Мандухай цэцэн хатан ч хаан төрд тэрслэн том толгойлсон



олон ноёд ихэсийг цэрэглэн довтолж хурааж байсан. Ер нь эр, эмдээ ч биш, эд хөрөнгө, эрх мэдлийн төлөөх шунал, өш хонзон л дайны үрийг тарьдаг хэмээн би боддог. Чухам Эсэнгийн хувьд түүнийг хороосон нь халх монголчуудын зөв байсан гэж би боддог.

-Юуны учир зөв гэж? Эсэн тайш Монголын нэгдсэн улсыг байгуулна гэж зорьсон. Монгол улс эв нэгдэлтэй байвал хүчжинэ гэж та өөрөө хэлдэг, тэгээд бас өөрөө Ойрад хүн байтал? хэмээн охин гайхаж зүүн хөмсгөө өргөж, нүдээ сэртийлгэн багшийгаа тас ширтэв, Дүүрэн мэргэн бичээч хүд хүд инээгээд шилээ авч арчин:

-Юуны учир Самар тайху түүхэнд мөнхрөв гэдгийг бод. Үймээн самууны тэр цагт Чингисийн алтан ургийн сүүлчийн удмыг аварсан. Монголыг халх, Ойрадтой нь нэгтгэсэн Эсэн яагаад хороогдов? Монголын их хааны суудалд гагцхүү алтан ургийн хүн л залрах эрхтэй. Гэтэл Ойрадын Эсэн тайш сууж болж байгаа юм бол Хавт Хасар, бөх Бэлгүтэйн удам хойчис, аль эсвэл Сүвээдэй жанжны үр ач бид монголын төрд бас эгэлгүй их гавьяатай, Эсэн хаан сууж болсон юм бид яагаад эс суухав гээд дуртай нь хаан болохыг хүснэ. Хэдий халх, Ойрадууд эв нэгдэлтэй байх нь зүй ч алтан ургийн бус хүн хаан сууснаар тэр эв нэгдэл бутран унах байсан болоод Эсэн алагдсан биз ээ гээд толгойгоо сэжлэн:

-Чиний толгой юм боддог толгой болж буйд багш нь туйлын сэтгэл тэнэгэр байна. Одоо явж амар даа. Би ч их алжаалаа гээд босов.

Багшийн дараагийн хүүрнэл охины өрлөг эхийн амнаас анх домог төдийхөн сонсоод гайхан биширч үлгэр дууриал болгон харвах, намнах, цэргийн эрдэмд хорхойсоход хүргэсэн Мандухай сэцэн хатны түүх байлуга.

Охиныг ном судраа сугавчлан орж ирэхэд Дүүрэн бичээч сэтгэл дүүрэн байдалтай мишээж:

-За хоёулаа өнөөдөр Мандухай сэцэн хатны тухай хүүрнэе. Манай Ойрадыг их хаанд захирагдахгүй том толгой гаргалаа хэмээн өөрөө саадаглан ирж дайлан хураагаад, доромж агуулга бүхий зарлиг гаргаж байсан тул зарим Ойрад ноёд энэ хатны тухайд сүжиггүй байдаг ч миний хувьд Мандухай сэцний зөв байсан гэж мунхагладаг юм хэмээн ярихад Ану дотроо “Аав бас намайг Мандухай сэцэн шиг эрэлхэг хатан болно гэхэд дурамжхан царайлж байж билээ. Ийм учиртай юм бий” хэмээн бодож суулаа.

Их эзэн Чингис хааны арван тавдугаар үеийн ач, мөнөөх Самар тайхугийн ачаар эхийн төрхөмөөс эх нутагтаа харьж аврагдсан Баянмөнх жононгийн хүү Батмөнх аргын 1470 онд Монголын хаан ширээнд сууж, “Амь нь бат, төр нь мөнх, явдал нь сайн, даяар бүгдийн эзэн болтугай” хэмээн билгэдсэн Даян хаан цол өргөмжлөгдөн их хатан ухаант Мандухайн тус дэмээр хагарч бутарсан улсаа нэгтгэн захирсан билээ. Батмөнх даян хаан нийт дөчин жил Монголын их хаан сууринд заларсныг “...Зургаан түг түмэн олныг эмхлэн цуглуулж, энхжин жаргаасан гар газар, хөл хөсөр тавьсан энх цаг” хэмээн тэмдэглэсэн нь буй.

Батмөнх даян хаанаас өмнөх зуун жилд их хаан суудалд суусан алтан ургийн хүн хоёр гуравхан жил засаглаад л ордны хуйвалдааны золиос болон нас эцэслэж байснаас “бага хаад” хэмээн түүхэнд тэмдэглэсэн, Монгол улс дотоодын хямрал, хагаралдаа идэгдэн төрөө мөхөөхөд хүрч байсан эмгэнэлт үе байсан бөлгөө. Энэ хагарлыг зогсоон, алтан ургийн их

хааны эрх мэдлийг сэргээн бутарсан улсаа цуглуулах үзэл санаа түгж эхлэх үеэр Мандухай сэцэн хатны байгуулсан гавьяа онцгой их юм.

Мандухай бол Түмэд Цоросбай төмөр гэдэг хүний охин. Тэрээр бага залуудаа Мандуул хааны бага хатан болжээ. Дөрөвхөн жил төр барьсан Мандуул аргын 1467 онд таалал төгсч, Мандухай сэцэн хатан хоёр гүнжтэйгээ бэлбэсрэн хоцров. Нэгэнт Мандуул хаанд нуган үр заяагаагүй учир Чингис хааны алтан ургийн ганц хүн үлдсэн нь Баянмөнх болох жононгийн өнчин хөвүүн Батмөнх байсан бөлгөө. Гэвч дэндүү балчир настай хөвүүн цаг төр самууран, төр доройтсон тэр үед хэрхэн бутарсан улсаа нэгтгэн хураах билээ. Тийм байлаа гээд хааны сэнтийг эзэнгүй удаавал их сууринд санаархсан ноёдын тэмцэл ширүүсч, дайн тулаан, самуун явдал улам дэлгэрэх аюул айлсан ирээд байв. Тиймээс эртний уламжлалыг даган шинэ хааныг сууринд залгах хүртэл нас нөхцсөн хааны хатан төр барьж байсан заншлын дагуу Мандухай сэцэн төрийн эрхийг хамаарах зуураа балчир бага Батмөнхийг өөрийн гараар хүмүүжүүлэн хаан болгож чадсан билээ.

Сурвалж бичгээс үзэхэд Батмөнх нь насан элсэн Мандуул хааны ач дүү Баянмөнх болох жононгийн хатан Шихэр тайхугаас төрсөн хөвүүн ажгу. Ойрадын Исмэн тайш Зүүн Монголыг довлох үед Баянмөнх жонон зугтан одож, Исмэн Шихэр тайхуг нь хатан болгож аваад, хүү Батмөнхийг нь Балгачины Багай нэрт хүнд өгчээ. Эцэг нь амь зулбан явахдаа алагдаж, хаан хөвүүн өнчрөн үлдээд бэтгэ өвчинд нэрвэгдэн их гэдэстэй шаналж байхад нь тангуд угсааны Төмөр Хадаг гэдэг хүн Батмөнхийг Багайгаас булаан авч, эхнэр Сайхайгаараа асруулав. Тэд есөн цагаан ингэний сүүгээр хүүг тэжээж их гэдсийг нь гурван мөнгөн аяга цоортол илж, эмчлэн сувилснаар Батмөнх илааршжээ. Хаан хөвүүнийг нэгэнт эдгэрсэн хойно Төмөр Хадаг түүнийг Мандухай сэцэнд аваачиж өгөв. Ийнхүү алтан ургийн сүүлчийн хөвүүнийг олж асран хүмүүжүүлэх зуураа төр барьж байсан Мандухайд урьд сэтгэлтэй явсан Хорчин аймгийн Хавт Хасарын хойч Өнөболд ван элч зарж:

-Галыг чинь цахиж, нутгийг чинь зааж өгье гэжээ.

Үүний хариуд Мандухай:

Хааны өвийг Хасарын үр чи иднэ үү?

Хасарын үр чиний өвийг бид иднэ үү?

Өргөж үл болох үүдтэй билээ

Алхаж үл болох босготой билээ

Хааны минь үр байсаар байхад

Хасарын үр чамтай юунд ураглах билээ? хэмээсэн гэдэг.

Мөн Мандухай бусдын үгийг сонсон зөвшилцөх үүднээс Алагчигуудын Сатайгаас энэ тухай асуухад "Өчүүхэн хүүхдийн эр болохыг хүлээснээс Өнөболд вантай сууж хатан нь болбол таарна" гэжээ. Мандухай дахин өрлөг жанжныхаа гэргийгээс асуухад тэрбээр:

Хасарын үрд очвол

Хар мөр удирдан

Хамаг улсаасаа хагацаж

Хатан нэрээ алдана

Хааны үрд очвол

Хаан тэнгэрт аврагдаж

Хамаг улсаа эзлэн

Хатан нэрээ алдаршуулна

Цагаан хөвүүнд очвол

Цагаан мөр татаж

Цахар түмнийг эзэлж

Цаглашгүй нэр алдаршина хэмээн мэргэн зөвлөсөн бөлгөө. Энэ хоёр хүний үгнээс үзэхэд Мандухай хатны өмнө хоёр зам байж. Хэрвээ тэрээр хайр сэтгэлээ даган Өнөболд ванд очвол монголын хаант төр Чингис хааны алтан урагтнаас Хасарын үр ач нарын гарт орж язгууртан, ноёдын дургүйцлийг өдөөж, хагарал самуун улам дэврэх тул Батмөнхийг өсгөн хүмүүжүүлж, хаан суулгахаар зорьж, хувийн жаргал цэнгэлээ огоорох замыг сонгожээ. Чингээд өөрийг нь Өнөболдтой суу хэмээн зөвлөсөн доголлон Сатайд:

Хааны үрийг өчүүхэн гэж

Хамаг улсыг үгүй гэж

Хатан биеийг минь бэлбэсэн гэж

Хасарын үрийг их гэж

Хаашаа үг хэлэх буй хэмээгээд халуун цайгаар цацан өргөөнөөсөө хөөн гаргажээ. Ингээд гучин гуравтай Мандухай долоон настай Батмөнхөд гурван давхар ултай гутал хийлгэн өмсгөөд эзэн Чингисийн найман цагаан ордны өмнө очин хаан, хатны сүлдэнд цацал өргөн:

Хар морины зүс үл харагдах газар бэрлэм билээ

Хааны тань үр нярайдав гэж

Хадар авгайн үр авья гэхэд

Хан ордны дэргэд ирэв

Алаг морины зүс үл үзэгдэх газар бэрлэдэг билээ

Ачит үр чинь авья гэхэд

Айх амиа орхиж алтан ордны дэргэд ирэв би

Айх амь минь алдрав

Ичих нүүр минь эвдрэв

Өргөн их үүдийг чинь хөнгөн гэж

Өндөр их босгыг чинь нарийн гэж

Өнөболд энд өчихүүл

Уурга тань урт,хуйв тань агуу буй, намайг уургалж ав

Чиний үрийг өчүүхэн гэж басах ахул

Өнөболд ванг уургалж ав

Харь бүрсэн хан хөвүүн төрж,

Хан хөвүүн чинь халив гэж

Эр Богд эзэн минь хөвүүн төрж билээ

Эзэн хөвүүнийг минь алдав гэж

Эм биеэ мэдэж эчивэээс

Эш хатан чиний өмнө эвдүүлсү би хэмээн тангараг өчсөн гэдэг.

Монголчууд эртнээс бэрлэх зан үйлийг хэрхэн сахиж буйгаар нь эмэгтэй хүний билэг оюуныг үнэлдэг ёс уламжлалтай. Тэрхүү “бэрлэхүй” ёсны хамгийн чухаг нь айлын бэр хүн хадам талынхаа ахмад хүмүүсийн алдрыг ямагт цээрлэж, тэдний нэртэй адил үг хэлэх болбол утга ойролцоо өөр үгээр орлуулан ярьдаг заншил байжээ.Тиймээс Мандухайн тангарагт эш хатан болон Өнөболдын дээд өвөг Хавг Хасарын нэрийг хүртэл цээрлэн “Хадар авгай” хэмээн хэлснийг шавь чи тунгааж байгаа бизээ.

Монголын нүүдэлчин аймгуудын гэр бүлийн уламжлал “Асрахуй”-н ёсны дагуу эр нөхөр нь таалал болсон хойно төрлийнх нь эр бэлбэсэн эхнэртэй нь сууж үр удмыг нь залгуулан асарч тэжээдэг заншил одоо ч манай Ойрадад мөрдөгдсөөр байгаа билээ. Тэр эрхэм заншлыг зөрчин хааны үрийг нялх балчир хэмээн басч хатныг нь авья гэж Өнөболдыг гуйхад Мандухай хайр сэтгэлээ хөсөр орхин журамт бэрийн ёсоор өндөр дээд хадмын өргөөнд ирж тангараг

тавихад хүрсэн болов уу. Монголын эртний заншлаар айлын бэр хадмын гэрт зоргоор орж гардаггүй, хадам эцгийн голомтноос дээш гарч хоймор гарах ёсгүй, гэрээс нь гарахдаа нуруугаа харуулах нь цээртэй бөлгөө. Гэтэл Мандухайн хувьд арга буюу өндөр дээд хадмын өргөөнд очин тангараг тавих болсноо”Айх сэтгэл минь алдрав,ичих нүүр минь эвдрэв” гэсэн байдаг.

Мандухай хатны тангаргийн үгэнд “Хаан хөвүүн чинь халив гэж хар биеэ мэдэж эчвээс хаа гуяа ханзлуулсу,эзэн хөвүүнийг чинь алдав гэж эм биеэ мэдэж эчвээс эш хатан чиний өмнө эвдүүлсү би” хэмээн өгүүлсэн нь эр нөхөр нь тэнгэрт хальсан ч бэр хүн биеэ мэдэн нөхрийн ургаас гадуур дахин гэрлэж үл болохыг заасан хэрэг бөлгөө.

Ингээд аргын 1470 онд Мандухай сэцэн хатан нас бага Батмөнхийг хаан ширээнд суулган, даяар олныг захирах”Даян хаан” цол өргөмжлөн хатан нь болж эрхэт боржгоны галыг асаасан юм.

Даян хааны нас балчир үед түүний нэрээр Мандухай хатан төр барьж байх үеийн Монгол гүрний “шүдний өвчин” нь толгой даан тусгаарласан Ойрадууд байсан тул “Сайтар саадаглаж, садарсан үсээ хурааж, сайн даян хааныг үхэглэж мордон” Ойрадын нилээд хэсгийг их Монгол улсад нэгтгэж чадсан юм. Мөн Зүүн,Баруун түмний “том толгойлсон” зарим ноёдыг ч цэрэг хөдөлгөн дарж, улсдаа хураан нэгтгэж Монгол улсын нэгдсэн төрд үлэмж гавьяа байгуулсан хатан бол Мандухай сэцэн билээ.

Чингээд Мандухай хатан сайд түшмэдээ цуглуулан төрийн эрхийг Батмөнх Даян хаанд тушаахдаа “Эзэн хаан та бээр өссөн тул

Иргэн түшмэд, засгаа баригтун

Эм хүн над төрийн хэрэг юун” хэмээсэн нь түүхийн хуудаснаа үлджээ.

Мандухай хатан өсч том болсон Батмөнх Даян хаанд эм биеэ тушаан Чингис хааны найман цагаан ордны өмнө үрийн хутаг гуйн залбирахдаа:

Эрхт хаан эцэг минь

Эш хатан эх минь

Дотоод энгэрт минь

Долоон хөвүүн төрүүл

Гадаад энгэрт минь

Ганц охин төрүүл

Доорд хатан надад

Долоон нуган заяаваас

Долууланд нь Болд нэрийг өгч

Гал голомтыг чинь сахиульа

Газар нутгийг чинь эзэмшүүлье гэжээ.

Үнэхээр тэнгэр өршөөж Мандухайн хүсэлтээр долоон нуган, ганц охин заяасан гэдэг.

Ингэж Мандуул хааны бага хатан байсан Мандухай эрээ алдсаны дараа Чингисийн алтан ургийн угсааг таслалгүй үргэлжлүүлж, Даян хаан Батмөнхийг хаан ширээнд суулган төрийг түвшитгэн, их Монгол гүрний түүхэнд үлэмж гавьяа байгуулсны тул “Цэцэн хатан”, ”Сайн хатан” хэмээн мөнхөрсөн буюу.

Ану охин шанаа тулан бодолд дарагдан суусаар байлаа. “Мандухай сэцэн ч өөрийнхөө хайр сэтгэлээр ураглаж үл чадсан байхад өчүүхэн би Сэнгэ хааны хатан болохоос өөр зам үгүй юм байна даа. Харин энэ хатад шиг наснаас нөхчөөд төчнөөн зуун жилийн хойно шастир түүхэнд мөнхрөх юм сан” хэмээн охин бодож суулаа.

Дараагийн удаад багш нь бууралтаж эхэлсэн сахлаа имрэн инээмсэглэн угтаж :

-За, шавь чиний хүслээр Монголын домогт хатад, гүнж нарын түүх, домгийн тухай түүвэрлэсэн хүүрнэл маань өнөөдөр төгсөх нь. Өнөөдөр би чамд Түмэдийн Алтан ханы хатан Их Юнгэний тухай хүүрнэх болно.

Боди Алаг хааны үед Баруун түмний эзэн нь Барсболд жонон байж. Түүний дараа хүү Гүнбилэг ор суусан. Гүнбилэгийн дараа Барсболдын хоёрдугаар хүү Алтан хан баруун түмнийг захирчээ. Өрнө зүгт хийсэн дайнд гарамгай гавьяа байгуулсны учир их хаан “Алтан хан” цол олгосон энэ хүний жинхэнэ нэр нь Анда юм.

Алтан хан хятадын Мин улстай харилцаа тогтоож, үр тариа, бөс даавуу авч байхын тулд цэрэглэн аргын 1551 онд Бээжин хотод тулж очсоны хүчинд хэлэлцээр байгуулан Датун, Сяньфу зэрэг газар адууны зах нээлгэжээ. Баруун монгол гэгддэг Ойрад дараа жил нь халх руу довтлон ороход нь Алтан хан цэргийн хүчээр дэмжсэний тул Ойрадыг бутцохижээ. Үүний дараа Ойрадууд зүүн Монголоосоо салан тусгаарлахыг оролдсонд Алтан хаан зарлиг гарган ач хүү Хутагтай сэцэн хунтайжийг цэрэглэн мордуулснаар Ойрадын дөрвөд, цорос аймгийг цохиж түвшитгээд ийшээ Хөх нуурт цөмрөн орж гартаа оруулан ихэд хүчирхэгжсэн байна. Баруун гарын жонон ийнхүү илт хүчжихэд Дарайсун Гүдэн хаан зүүншээ Ляодунгийн орчмоор нутаглах болсон тул цахар түмэн Алтан ханы ахмад хүүгийн мэдэлд орж ирсэн юм. Монгол улсын тархай бутархай байдлыг дан цэргийн хүчээр эмхэлж хүчрэхгүй тул нэгэн шашин шүтлэгийн дор нэгтгэх нь зөв хэмээн тэрээр үзэж шарын шашныг дэлгэрүүлэхэд идэвхийлэн зүтгэв.

Харин Мин улс монгол овог аймгуудыг нэтгэн хүчирхэгжиж эхэлмэгц нөлөө бүхий ноёдыг элдэв цол хэргэм, эд агуурсаар татан дотоодын хагарал үүсгэх аргад шилжсэнээр Алтан ханд “Шунь И” буюу журмыг сахигч ван цол шагнаж, харьяат далаад ноёнд нь мөн цол хэргэм дараалан түгээж, Датун, Сюаньфу, Шаньси мужуудад адууны зах нээсэн юм.

Аргын 1558 онд их хаан Дарайсүн Гүдэн тэнгэр болж, хүү Түмэн тайж хаан суугаад Монгол улсаа нэгтгэх гэсэн Алтан ханы бодлогыг сайшаан дэмжсэн юм. Алтан хан Төвдөөс шар малгайтны шашны тэргүүн лам гуравдугаар Содномжамцыг урьж авчраад “Далай лам” цол хайрлан Хубилай хааны үеийн улсын багш Пагва ламын адил өргөмжилсөн ажээ хэмээгээд шавийн зүг харж:

-Өнөө Юнгэн хатан нь гарч ирэхгүй байгаад бүү гайхаарай. Алтан ханы үеийн Монгол улсын аж байдал, гадаад, дотоод байдлын эгзэгтэй эргэлтүүдийг мэдэж аваасай гэсэндээ ийнхүү нуршчихлаа.

Ийнхүү нэгдсэн Монгол улсаа сэргээх, нэгэн шашны дор монгол аймгуудыг нэгтгэх, адуу малаар үр тариа, тутарга, бөс даавуу, торго солилцох худалдааны харилцааг Мин улстай тогтмол явуулахын төлөө зүтгэж явсан Түмэдийн Алтан ханы Юнгэн хатан бол ухаалаг, үзэсгэлэн гоо, авьяас билэг төгөлдөр бүсгүй байсан хэмээн түүх сударт тэмдэглэжээ. Тэр үед нас нилээд өндөр болсон байсан Алтан ханаас Юнгэн хатан нь олон нас дүү, залуу жавхаалаг хатан байсан тул төрийн хэрэгт нь оролцон, түшиг тулгуур, шадар зөвлөгч нь болдог байсан гэдэг.

Тэр үед жилд нэг удаа болдог асан Монгол, Мин улсын хооронд харилцан алба барих, худалдаа наймаа хийх ажлыг Юнгэн хатан өөрийн биеэр эрхлэн захирдаг байсан учраас говийн өмнөдөд нутагладаг монгол аймгуудын дунд ихээхэн нэр хүндтэй болж чаджээ.

Юнгэн хатан цаг үргэлж нэхий дээл хэдэрч, булган малгай тэргүүндээ асаагаад морь унаж, саадаг агсан, хил хязгаарыг эргэн байцааж, Монгол, Мин улсын хооронд тогтоосон найрсаг харилцааны хэлэлцээрийн биеллээ олж буй эсэхийг хянан тохинуулж явдаг байв. Аргын 1581 онд Алтан хан далан таван сүүдэр дээрээ өвчин хүрч тэнгэрт хальжээ. Эцгийн орыг Алтан ханы өөр нэгэн хатнаас төрсөн ахмад хөвүүн Дүүрэн Сэнгэ хунтайж залгамжлахдаа Юнгэн хатныг өөрийнхөө хатан болохыг гуйхад дөнгөж гуч гарч явсан Юнгэн хатан нас ахимаг Сэнгэ хунтайжтай ураглах дургүй байсан тул харьяат албатаа аван Хөх хотоос нүүн одсон ажгу.

Гэтэл тэр үеийн Монгол, Мин улсын харилцаанд туйлын өндөр байр суурьтай байсан Юнгэн хатныг хунтайжийн хатан болохыг Мингийн түшмэлүүд хүртэл ятгаж байсан тул Юнгэн хатан эргэцүүлэн тунгаасны эцэст Сэнгэ хунтайжтай ураглан суусан юм. Эцгийн орыг залгамжилснаас зургаан жилийн дараа Сэнгэ хунтайж насан эцэслэхэд Амудай сэцэн хунтайж ор суужээ. Юнгэн хатан Амудай сэцэн хантай хавсран төрийн хэргийг явуулж, Монгол, Мин улсын найрсаг харилцааг таслахгүйн төлөө хүчин зүтгэсэн тул Мингийн хаан түүнд “Үнэнч шударга хатан” цол өргөмжилсөн байдаг.

Ухаант Юнгэн хатан жаран гурван сүүдэртэйдээ насан эцэслэсний дараа монгол, мин улсын олон мэргэд түүнийг дурсан шүлэг магтаал зохиож, уран зураачид эш хөргийг нь зурсан нь бий.

Юнгэн хатны гавьяа зүтгэлийг дурсан амьдарч асан Хөх хотыг нь нэгэн үе “Юнгэн хатны балгад” хэмээн нэрийдэж байжээ. Алтан ханы амьд сэрүүнд шарын шашныг дэлгэрүүлэхэд хүчин зүтгэж асан Юнгэн хатан хожмоо Амудай сэцэн хан, Бодашир хунтайжтай хавсран “Ганжуур” судрыг монгол хэлнээ дуун хөрвүүлүүлсэн билээ.

Энэ хатны тухай хүүрнэлийг чагнан суухад нь “Дөнгөж гуч гарч явсан Юнгэн хатан нас ахисан Сэнгэ хунтайжтай ураглах дургүй байсан тул харьяат албатаа аван Хөх хотоос гарч явсан ажээ...Гэвч Юнгэн хатан эргэцүүлэн тунгаасны эцэст Сэнгэ хунтайжтай ураглан суусан юм...” гэсэн хэсэг Ану охины өөрийнх нь тухай өгүүлээд байгаа юм шиг сонин санагдан бодолд оруулжээ.

-За шавь минь өвгөн бичээч миний түүх шастир, судар ном эргүүлэн сууж хичээнгүйлэн түүвэрлэсэн хүүрнэл ийм өчүүхэн тул өнөөдөр төгсч байгаа нь энэ. Хан хүний гүнжийн хувьд монголынхоо хатдын түүхийг мэдэх гэсэн эрмэлзэл чинь туйлаас зөв. Ухаарч ойлгон тусгаж авдаг хүнд өчүүхэн төдий үлгэр хууч ч үнэт сургамж болон оюун ухааныг нь тэжээнэ. Ухвар мөчид мунхаг хүнд хэдэн тэрэг ном үзүүлээд ч оюун тархинд нь гэгээ үл туснам хэмээн сургасан ажгу.

Багшаараа монголын түүхэнд үлдсэн ухаант цэцэн хатдын домог, түүхийг яриулж дууссан тэр шөнөө охин Галдан ламтан “шар шувтлан” хар болж, хаан суугаад, өөрөө хатан нь болон хоёул хамтдаа хүнд хэцүү аян дайны газар зовж зүдрэн явна. Тэгээд дайсны талаас хайрт Галдангийнх нь зүрхэнд онилон харвасан хурц гилбэрт сумны урдуур өөрөө орон хаагаад тэр суманд өртөн үхэж байна. Гэтэл сүнс нь биеэ орхиж үл чадан тарчилна хэмээн зүүдэлж, үүрээр усан хулгана болтлоо хөлрөн сэржээ.

Энэхүү хар дарсан зүүдэндээ бүүр итгэчихээд “Хэдий би үхсэн ч хайртай тэр минь амьд сэрүүн үлдэв. Хэрэв тэр минь үхэж, би амьд үлдвэл Юнгэн хатны адил “Асрахуй” ёсны дагуу нас ахисан ах Сэнгэ хунтайжтай нь ураглах болно. Хэдий би бүсгүй богино жолоотон ч эртний ёсыг даган эрийнхээ төрөл, ах дүүтэй нь ураглахыг үл хүснэ” хэмээн бодож, тэгсэн атлаа цэл залуу насандаа амьдралыг орхиж буйдаа харамсан уйлаад ч байх шиг дотор цээж бачууран тэлчилж байгаад сэрвэл арван дөрвөн настай Ану охин хэвээрээ, өөрийнхөө өмчний өргөөнд ирвэсэн хөнжилдөө хар даран зүүдэлж хэвтсэнээ мэджээ. Тэгээд уржнан жилийн хавар эцгийн өргөөнд айлчлан ирж асан Сэнгэ хааны овор төрхийг ухаан санаандаа ургуулан дүрслэхийг оролдлоо. Тэгэхэд гучин нэгэн сүүдэртэй хэмээн сонсч байсан Сэнгэ хаан алтан сампинтай, очир эрдэнийн жинстэй хар булган малгай, луун хэт цагаан дээлтэй, эх Юм-Агас хатныг дууриасан нүд хөмсөгний зай ойрхон, хянуур зальжин харцтай агаад, Галданг бодвол жижигхэн нүдтэй, өтгөн ширвээ сахалтай, нүдэнд дулаахан эр байсныг санав. Тэр үед арван хоёр настай балчирхан байсан Ану нум саадаг агсан хөвүүдтэй тоглон гүйхээ бодож байснаас бус өөрөөсөө даруй хорин насаар ахмад, цорос аймгийн тэргүүн тэр том хүнийг эр нөхрөө болох юм гэж зүүдлээ ч үгүй явсан цаг. Гэтэл одоо нэгэнт тэр хүний хатан болох нь зайлбаргүй болсон хойно ч өөрийнхөө голоос хайртай хүн, Сэнгийн төрсөн дүү Галдан ламтай л ураглан гэргий нь болоод түүнийхээ төлөө амь насаа үл хайрлан тэмцэж байгаагаар зүүдэлж байдаг. Бодоод байхнаа багшаараа яриулсан тэр олон ухаалаг, чин шударгуу, баатарлаг дайчин хатад, гүнж нарын дотор Хайду ноёны Аюуруг гүнжээс өөр хайр сэтгэл, дур хүслийнхээ дагуу хадамд гарч, хүний гэргий хатан болсон бүсгүй нэгээхэн ч үгүй байтал зүрх сэтгэл нь оюун бодлоо сөрөн зүтгэсээр байгаагаас л ийм этгээд зүүд зүүдэлж байгаа биз.

Тэр намар Очирт цэцэн хан хэдийгээр нурууны архаг хууч хөдлөөд тэнхэл муу байсан ч хоёр гуравхан жилийн дараа хадмын газар одох охин үр Анугаа сэргээн баясгах үүднээс анхны



цаснаар ав хоморгонд дагуулан явжээ. Хантан өргөөний шадар зуутаа аван тусгай хүмүүсээр тэжээлгэдэг хурдан анч нохдоо авчруулан, Тарвагатайн нуруунд чоно, үнэгний анд явав.

Олон хоногийн өмнөөс Ану авд мордоно хэмээн баясахдаа Жанчивдорж дарханыхаар эргэлдэн ган утсаар хэлхэж буй шинэ хуягаа дуусч буй эсэхийг шалган, үйлчин Борхүүхэн авгайн урлаж буй шинэ цээживчээ тааруулан үзэж, өргөөний тигээс зайдуу гарч тэнгэрт нисч яваа элээ шувууг хүртэл харван бөөн хөөр болж буйд эцэг, эх хоёр нь нэгэн бодлын сэтгэл тэнийж, нөгөө бодлын, энэ балчир амьтныг хоёр гуравхан жилийн дараа хол газар хадамд мордуулна гэхээр өр зүрх хөндүүрлэн байвай.

Чонын үргээлгэнд гарах хүмүүс, эзнээсээ урьтан авын газарт очиж отог байгуулан цацар майхнаа босгох барлагууд хоёр хоногийн өмнө Тарвагатайн зүг морджээ.

Урьд жил нь Ануг ав хоморгод авч явна хэмээн эцэг нь амласан авч, тэр үеэр охин хамрын ханиад хүрч халуураад анд явж чадаагүйдээ удтал хар буун гасалсаар байсан тул өнөө жилийн намар заавал охиноо авд авч яван баясгана хэмээн Очирт хан хэдийн шийдээд байсан ажээ.

Зун намартаа налайн, өндөр ургасан сөл өвсөнд хучигдан амгалан талбиун байсан байгаль дэлхийг нүднээ үзэгдэх төдий нарийн ширхэгт цасан хялмаагаар нэг л өглөө хучиж орхисон өвөл өвгөн догшин аашаа сануулан хүйтэн салхиар үлээсэн намрын жихүүн өглөө авд мордох хүмүүс өргөөнөөс хөдлөв.

Газрын бартаанд илүү хэмээн Ануд барьсан суман халтар морь харахад үзэмж сайхан биш ч өндөр уул, хадан дунд хөл сайтай, анд явж ноходтой зэрэгцэн чоно, үнэг хөөж эзнээ сум тавихад нь үргэж бусгалгүй хурдаа жигд барин давхидаг, ааш номхон, хөл хөнгөн сайн хүлэг аж.

Хошууд заншлаар буруу талын гуяндаа хас тамгатай, урьд унаж үзээгүй суман халтарыг агтчдын ахлагч Мандах урьд өдөр нь цаламдан барьж авчраад өглөө Анугийн эмээлийг тохон олмыг нь чангалаад хөтлөн авчрав. Ан авд олон явсан сайн морь хэмээн урьд орой аавынх нь үгээ олохгүй магтаад байсан суман халтарыг үлгэр туульд гардаг хөө хар морь шиг л ганган хүлэг юм байх гэж бодсон нь хонины бор гэмээр зүс муутай амьтан байсанд Ану гонсойгоод явчихыг харсан эцэг нь сахал дороо хүнгэнүүлэн инээж байгаад мэнгэрээ хөдөлгөчихөөд ханиаж ханиаж, газар нулимаад:

-Үр минь. Хүлгийн сайныг унан байж мэдэм зэ. Хүний сайныг нөхөрлөн байж мэдэм зэ гэдэг юм. Чиний жороо хээр шиг ч юм уу, ижийн чинь унадаг гал шарга шиг үзэмж сайхан биш ч холын зам, газрын бартаа, ав хоморгонд зохилтой сайн хүлэг байгаа юм. Морд морд гэлээ.

Авд явах хүмүүс дунд Мандарваа, Ану хоёроос өөр бүсгүй хүн байсангүй. Ануг ав хоморго, нум саадаг, хуяг дуулга гээд дувтан эр хүний эрхэлдэг зүйлийн юунд нь тэгж дурлаад байдгийг огтоос үзэглэдэггүй Мандарваа өргөөнөөс алс газар аялан явна гэдгээс бусдаар сэтгэл хөгжих юм байхгүй тул уруу царайлан байлаа. Анхны цас орж буй хүйтэн нойтон цагаар хол газар хээр, хөдөө даарч хөрч явах нь Ануг даган тансаг дулаан өргөөнд сууж, өнгөтийг өмсч, амтаныг зооглосоор муу зан сурч, тэрүүхэн тэндээ ямбалж дасаад буй түүнд халширмаар байвч эзэн боолын ёсыг яалтай

-Үр минь хадтай газар морио цочоов! Үргэж бусгах вий. нэн ялангуяа үнэг их гэмтэй гэдэг юм. Газрын бартаа руу улайран орчихуузай. Даарч хөрөв. Даадаа нь хөтөлгөө моринд хоёр чонон дах дайсан гэсэн. Шөнөдөө Мандарваатайгаа өвөртөө хонодог юм шүү, дулаахан гэхчлэн Доржравдан хатан баахан захиас хэлснийг сэтгэл хөөрсөн Ану олигтой ч сонссонгүй.

Гэвч өргөөнөөс хөдлөн холоо явсан хойноо эргэн харвал намрын хүйтэн өглөө араас нь сүүн цацал өргөн, шивэгчин Уламнэмэх, нас өтөлж яваа Жангараг, Үзмээ, өрлөг эх тэргүүтний хамт зогссоор буй эхээ хараад өрөвдөн “Би мөн ачлалгүй хүнээ. Ижийгээ сэтгэл тавин сургааль, захиас хэлж байхад нь эс дуулагчин болж огоот хайхрахгүй зогсдог. Хэдхэн жилийн дараа Сэнгэ хааны өргөөнд ураглан одохоороо олон ааштай, бааштай ч гэсэн энэ биеийг минь төрүүлсэн элбэрэлт ижийгээ санах л болно шүү дээ” хэмээн гэмшилд авгаж байснаа тэгсгээд мартчихаж билээ.

Тэд хялмаа хаялсан хүйтэн өглөө өргөөнөөсөө гараад өдөрчийн газар явсаар Тарвагатай уулын бэлд шивээлсэн ангийн отогтоо хүрэв. Замдаа Ану эцэгтэйгээ багшийн хүүрнэсэн түүх, домог хуучийн тухай ярилцан, Очирт цэцэн хэрэвзээ аз болж, туйлын ховор ан цагаан үнэг авлавал охиндоо малгайн үс болгон бэлэглэнэ хэмээн амлаж явлаа.

Эцэгтэйгээ ийнхүү дөрөө харшуулан гангар гунгар хийж явах нь охинд хэзээний хамгийн хүсэн хүлээдэг сайхан явдал нь байсан билээ.

-Аав аа, та Өгөдэй хааны ач Хайду ноёны охин Аюуруг гүнжийн тухай мэднэ үү?

-Хайду ноёны тухайд Хубилай хааны эсрэг босч байсныг сонссон. Тийм гүнжтэй байсныг нь мэдэхгүй ээ.

-Тэр Аюуруг гүнж, хүү хүний зантай эрэлхэг баатарлаг атал гоо үзэсгэлэн төрсөн учир Хайду ноён олон хүүхэд дотроосоо түүнийгээ онцгойлон хайрладаг байж.

-Ухай... эцгийн гүн үрчлээт нүүрэнд сонирхсон шинж тодрон буйг ажаад Ану цааш үргэлжлүүлэн:

- Аюуруг гүнж арван тав хүрмэгцээ эцгээ даган аян дайнд мордон их цэргээ оройлон байлдаж, дайсны цэргийн хүрээ, жагсаал уруу аюумшиггүйгээр дайран орж морьт цэргийг олзлон дүүрээд амьдаар нь авчирдаг хүч чадал, самбаа зориг ихтэй гүнж байжээ гэснээ инээд алдан, ижий намайг дувган эр хүний эрхлэх хэргийг хөөцөлдөн дурлав хэмээн зэмлэдэг. Гэтэл энэ Аюуругийн домгоос үзэхэд над шиг охид, сэвгэрүүд зөндөө байж дээ гэсэн бодол төрсөн хэмээн эцэгтээ хуучлаад “Хайду ноён охид сэвгэрүүдийг хүчээр богтлон хайр сэтгэлгүй хүнд нь ураглуулдаг уламжлалыг зөрчин өөрийн дур хүслээр хадамд гарч болохыг соёрхсон бичиг Аюуруг гүнждээ шийтгэн өгсөн” тухай цааш нь хүүрнэх гэснээ өөрөө Сэнгэ хунтайжид хүчээр очих болсондоо эцгээ буруутган “Хотол цагаан Аюуруг” гүнжтэй барьцсан мэт болчих вий гэж үзээд больчихов. Охиныхоо хүүрнэлийг сонсон таашаалтайяа явсан хантан:

-Тэгэлгүй яахав. Бүсгүй хүн болж төрлөө гээд дуртай үйлээ хийхгүй байж үл болно. Тийм учраас аав нь охиндоо багаас нь нум саадаг төхөөрөн өгч, Ойраддоо цуутай номын мэргэн багшийг залан авчирч шавь оруулсан юм шүү дээ. Хатад эхнэрүүд ухаан уужим байх аваас эр

нөхөртөө мэргэн зөвлөгөө өгч, үр хүүхэддээ эрдэм ухаанаа өвлүүлэн өсгөх тул охид сэвгэрүүд ном сурахыг би таашаадаг гэлээ.

-Харин энэ Мандарваа арай хэмээн тод үсэг төсөөлж сурсан. Би уйгаржин заая гэхээр ахиж буй юм юу ч алгаа хэмээн охиноо шогшроход эцэг өхөөрдөн инээж:

-Хүн хүний ухааны сав хэмжээ адилгүй шүү дээ. Үр минь. Мандарваа чиний шивэгчин болох харц угсаат хүн. Тод үсэг гаргадаг болсоныг нь харин ч эрхэмд бод гээд мориндоо ташуур өгөхөд дайн тулаан, ав хоморгод унадаг өндөр саарал морь нь хурд аван ухасхийв. Ану ч суман хүрнээ ташуурдан эцгээ дорхиноо гүйцэн ирээд:

-Хүлгийн сайныг унан байж мэдэм гэж таны сургасан үнэн юм гээч. Хэчнээн хурдан хүлэг вэ гэлээ.

Тэд отогтоо бүрэнхийд ирж хоноглоод маргааш нь үүр цүүрээр нимгэн ширдэг шиг хялмаанд хучигдсан уулын бэлээр чонын мөр хөөн авд гарлаа.

Очирт ханы тэжээлгэсэн анч хурдан тайган дөчөөд нохой хуцалдан үргээлгэний хүмүүсийн морьд үүрсэх, дөрөө харшилдан, цэрэг эрсийн зэр зэвсгийн чимээтэй хоршин цасан хялмаанд хучигдан анир чимээгүй дүнсийх уул талыг амилуулах шиг.

-Үр минь намрын адаг сарын хүйтэн шөнө цацарт даарч зутрав уу? хэмээн эцгээ асуухад сэтгэл хөөрч нүд нь очтон гялалзах Ану:

-Ердөө ч үгүй. Мандарваа гэдэг чинь тулганы халуун гал шиг л илчтэй амьтан юм. Хажуу бөөрнөөс төөнөөд... хэмээн тас тас хөхөрлөө.

-Яамай даа. Та хоёрын хучлаганд өгсөн хоёр дах идэр есийн хүйтэнд хяр дээр хоноход ч дааруулахгүй, илчтэй, шинэхэн эд байгаа юм. За, охин минь энэ мөр үзэж байна уу? Үүнийг дагаад зүүн гүвээн дээгүүр ташин явцгаана. Үргээлгийн хүмүүс эртлэн мордсон хэмээн эцэг нь өгүүлэв.

Тэд хоёр ч чонын мөр хөөсөөр нар цухуйж байхад сэрэвгэр хаднуудын дунд нэгэн том улаан чонын бараа харав. Цаанаас нь үргээлгийн цэргүүд анчдын зүг хөөсөн тул тэр ховор зүсний том улаан чоно өөдөөс ирж яваа хүмүүсийн бараанаар хоромхон зуур хаднуудын цаагуур орчихов. Очирт цэцэн хан мориндоо ташуур өгч чонын хойноос баруун талаас нь давхилаа. Ану тэр улаан чонын хоргодсон хадны зүүн талаар нь орох санаатай морио давираад нум сумаа зэхэв.

Олон анч ноход уяанаас сулрангуут амь зулбасан чоныг элдэн давхилдсаар нуугдсан хадных нь цаанаас хөөн гаргахад өчигдрийн идсэн хоол нь болтой бөөн бөөн бүхэл махаа бөөлжин гаргаад хөлийн хурд мэдэн зугтаж азарган улаан чонын зүүн гуяар Очирт цэцэн ханы тавьсан сум харван орж дунгуй хадан унагахад нь үргээлгийн цэрэг эрс уухай хадаан хөөрцгөөв. Гэтэл гуяндаа шархтай тэр араатан, чоно гээч амьтан долоон голтой байдгийг харуулан шархтай хөлөө чирэн гүйсээр бас нэг хадны хойгуур орчихов. Анч ноход тэр чонын хойноос хуцалдан давхилдаж элдсээр амь зулбасан хадных нь цаанаас дахин хөөгөөд гаргачихав.

-Аав аа, би гүйцээе! гэж Ану хашгираад бэлэн зэхсэн нум сумаа онилон морины хурдаар давхих зуур амьсгаа түгжин нэг харватал оносонгүй. Зүүн гараа мөр давуулан хоромхон зуур дараагийн сумаа авч, хадан дундуур нуруу нь улалзан давхих тэр араатныг онилон эрхийгээ чивчиртэл татаж байгаад сумаа тавихдаа чонын бөөрийг оносноо зөнгөөрөө мэдэрчээ.

Чоно ганц харайгаад нам уналаа.

-Ухайс! Байбагас ханы удам мөн дөө хэмээн эцэг нь хашгираад ангийн олз руугаа ухасхийхэд охин “Би харвахдаа лав Хотол цагаан гүнжээс дордохгүй бий” хэмээн бодоод олз руугаа давхилаа.

-Үнэхээр ховор зүсмийн сайхан амьтан юм. Ийм том биш бол зост хадны улаан үнэг байна л гэж бодмоор юм байна. Хар эс бол , хаа нэг цагаан зүсний чоно авлаж байсан ч ийм том улаан азарган чоно агнаж байгаагүй юм байна хэмээн эцэг нь хэлээд мориноос бууж чоно руу очиход Балсан:

-Хантан сэрэмжтэй байгтун! Үхээгүй ч байж магад, гэнэт үсрэн дайрах вий гэхэд

-Тийм шүү! Балсангийн зөв гээд арагш нэг алхам ухрах зуур давхин ирсэн Ану дахин нэг сум чонын хүзүү рүү нь тавихад тэр араатан сүүлчийн удаа татвасхийн амь тавилаа. Анч ноход хуцалдан үхсэн чоно руу дайрч, үргээлгийнхэн ирцгээн “Мөн булиа том амьтан аа!”,”Ану гүнжийн хоёр сум байна. Ангийн тэнгэртэй охин юм!” ,”Нуруу нь хоншоор сүүлээ оруулахгүйгээр нэг сайн алд илүү юм гээч” гэцгээн шагшаан шуугиан болоход Балсангийн эцэг Лувсанхайдав ирж:

-Та минь, өвчихдөө арьсыг нь гэмтээв! хэмээгээд эцэгтэйгээ хамсан авласан анхны чонынхоо ховор зүсийг гайхан арьсыг нь илж үзэх санаатай гараа сунгасан Ану хориолон:

- Авхай холдогтун. Нохой бөөс, ширх үсэрнэ. Арьсыг нь өвчиж элдсэн хойно үзээрэй гэв.

-Алив, анхны ав хоморгондоо энэ том олзтой буй үрээ үнсье! хэмээн эцэг нь хошуу цорвойн охиныхоо духыг нь сахалтай хошуу хүргэн үнэрлээд:

-Шинэ цээживч нь үнэхээр уран хийцтэй болж. Бүсгүй хүнийх юм гэсэндээ цээжиндээ хос алтадсан тольтой. Үнэхээр миний охинд зохирсон дэгжин эд болжээ хэмээн магтав.

Анчид тэр өдөртөө дахин хоёр үнэг авлаж, өнөө улаан азарган чонын гичийнх бололтой өөр нэг мөрөөр мөшгин явсаар цагаан гэгээ тасрахын алдад барааг нь нэг хараад алдчихав.

-За, яав. Ав хоморгын эхний өдөр олз омог ихтэй болохоор бахтай байгаа биз? Миний үр хийморь ихтэй нь төдий хэр байхгүй юу хэмээн үдэш отогтоо буцаж ирээд түүдэг галд мах шорлон идэх зуур эцэг нь асуулаа.

-Ёстай бахтай юм аа. Би ч Хайду ноёны хотол цагаан Аюуруг гүнж шиг бял тэнхээ ихгүй ч, харвахдаа лав түүнээс дордохгүй юм байна хэмээвэл биеэ хэт ихэд бодсон болох байх даа? хэмээн Ану хэлэнгээ жаварт хээрийн хойморт ил гал дээр шорлон шарсан мах идэн авласан

ангийнхаа тухай хөөрөн суух нь үнэхээр бахтай сайхан цэнгэл бөгөөд “Эр хүний жаргал эзгүй хээр” хэмээн юуны учир хэлэлцдэгийг ухаарах мэт болов.

-Яалаа гэж дутахав. Илүү ч байж мэдэш.Энэ улаан чонын арьсыг өвчиж элдүүлээд охиндоо өгөм зэ. Ангийнх нь анхны олз, хийморь дагуулах биз хэмээн эцэг нь догионо.

-Би тэр шар халтар үнэгийг л өөрөө авласнаас биш чоно бол таны олз шүү дээ, ааваа хэмээн охин хошуу унжуулан эрхэлнэ.

Анчдыг эзгүйд отогтоо залуухан зам Дондовдоржид хамжилцан хоцорсон Мандарваа галын захад дах нөмрөөд үүрэглэж суухыг Балсан үзээд хөхөрч:

-Ану гүнжтэн, шивэгчин охин тань хээр ямба алдан зутарчихаж. Дахан доор үүрэглэж сууна хэмээн шоолоход гал тойрон суусан эрс хөхрөлдөх чимээнээр охин цочин сэрэхэд Ану бүүр ч их хөгжин тас тас хөхрөн:

-Хөөе Мандарваа чи юун хийморьгүй золиг вэ! гал өөд дөхөөд л байсан, наад дахны хормой түлчихэвзэй. Нойроо дийлэхгүй, хээрийн жаварт тэсэхгүй байгаа бол үтэр түргэн цацартаа морил! хэмээн зандрах, шоглохын хооронд хэлж хүмүүсийг улам хөгжөөв.

Маргааш нь авынхан дахин хоёр үнэг, хэд хэдэн туулай, тураг гөрөөс намнаад тэнгэр муухайран цас шуурах төлөвтэй тул үтэр түргэн гэрээдээ буцах замд оржээ.

## Арваннэгдүгээр бүлэг

Аргын тооллын 1668 он, шар бичин жил гарлаа.

Цагаан сарын дараахан хөгшин Цэвээн хатны лагшин чилээрхэн хэвтэрт орж, хаврын дунд сард дотрын хүнд өвчнөөр насан элжээ. Ухаан төдийлөн хурц бус, гоо үзэсгэлэн гайхмаар биш ч уужуу тайван, аливаа хэрэгт хошуу дүрээд байдаггүй, бага залуу хоёр хатантай төдийлөн жөтөөрхөлцөлгүй байж, хантанд хоёр хүү, гурван охин төрүүлэн өгч хоёрыг нь нялхад нь алдан, дөч гаруй жил их хатан нь болж, хорвоогийн жаргал зовлонг хамтдаа туулсан, насаар өөрөөс нь хоёрхон дүү жаран гурван сүүдэр зооглосон хөөрхий хатнаа алдаад Очирт цэцэн хан ихэд гашуудан эмгэнэв.

Ховог сайраас Сэнгэ хаан Ануд сүй тавихаар ирэх гэж байснаа их хатан Цэвээн таалал болж, хантны өргөө гашуудалтай буйн тул больж, эх Юм-Агас нь Галдан хүүгийн хамт хүрэлцэн ирж эмгэнэл хуваалцахаар болжээ.

Цастын орноос ирснээс хойш Ойрад даяар Эсэн хутагтын хойд дүр гэгдэн, Зая гэгээн багшийн залгамжлагч номын их багшийн сэнтийд залраад буй Галдан хувилгаан Очирт цэцэн ханы их хатны хойдын номыг уншин, алтан хайрцгийг нээхээр морилон ирнэ гэдэг хүндэтгэлийн дээд байлаа. Залуу хувилгаан дөрвөн Ойрадын чуулганы “хантныг” хүндлэн, өтөл насандаа таалал болсон талийгч их хатныг нь бодсондоо бус, өсч яваа үзэсгэлэнт Ану охиныг л харах гэж шалтаглан урт зам туулан Хөх нуураад морилж буй гэдгийг ухаан сэргэлэн Доржравдан хатан, тааварлан мэдэж байлуга.

Ану ч хайр сэтгэлийг нь булаасан Галдан ламтныг морилон ирэх сургаар эртний заншлыг даган түүндээ тамхины хавтага оёж өгөхийг хүссэн ч эхийн үгийг тас зөрөн оёх хатгах үйлд төдийлөн шамдаагүйн гай одоо л илрэв. Оёдол хатгамлыг сурахаас цааргалан хойш тавьж, цэргийн эрдэм, бичиг номыг илүү чухагт үзэн шамдсаар ирсэн Анугийн хувьд тамхины хавтага оёх нь гурав дөрвөн хоногт багтаахааргүй хүчир зүйл байсан тул авдраасаа цэнхэр панс гаргаж, түүн дээрээ бурхан багш эхээс мэндлээд алхахын тоолонгоор нь хөрстөд дэлгэрсэн домогтой бадамлянхуа цэцэг зүү ороон хатгамалдаж үзүүрийг нь имхэрдээд амны алчуур оёж түүндээ бэлэглэхээр шийдэв.

Тийнхүү алчуурын пансаа гаргаад хатгаж эхлэх гэтэл хатгамлын зургаа хэрхэн буулгах, өнгийн торгон утас хаанаас авахаа мэдэхгүй сандран өрлөг эх өөдөө гүйв. Сүүлийн жилүүдэд зүрхний архаг хууч нь үе үе сэдрэн хэвтэх болсон өрлөг эх нь аанай л тулганыхаа захад хуучин оймс цоолдож суув.

-Даадаа! Энэ алчуур дээр бадамлянхуа цэцэг хатгах гэсэн юм. Оёх хатгахдаа төдгүйг минь та мэдэх хойно доо. Зургийг нь буулгаж аль. Чингээд зогсохгүй өнгийн торгон утас аль! хэмээн Ану багынх шигээ эрхлэн туньсан өнгөөр нэхлээ.

-Охиндоо хар цайтай хэмээн өрлөг эх нь гүвтнээд хэдий сүүгүй ч сайхан гурил хуурч самарсан цай аягалан, гуйлтыг нь сонсоогүй мэт “Саяхан цай чанаж уудалчихаад сууж байсан юм. Ямагт цай идээ болсон хойно орж ирдэг ”морьтой” хүүхэн шүү хэмээн ярихад нас ахисны улмаас халх аялга нь улам ч тодорсныг Ану анзаарав.

-Та ч бүүр халхаар ярьдаг болжээ. Халхууд сэвгэрээ “хүүхэн” гэдэг биш үү? гэж Ану хэлснээ халуун цай оочлох зуур:

-За тэгээд миний гуйсныг түргэл дээ. Харин юуны тулд? хэмээн бүү илүү хоншоорлоорой хэмээн өчив.

Охины занг гаргуун сайн үзэглэдэг өрлөг эх нь үрчлээт царайдаа хөнгөхөн инээмсэглэл тодруулаад:

-Яалаа гэж илүү хоншоорлохов дээ, Даадаа нь. Харин хатгамлын зураг дүрс ахайтанд л байдаг юм. Торгон утас бол надаас ав даа охин минь гэлээ. Тэгээд Ану алчуурын буланд дүрс хийж аль гэж орхиод өнгийн утсыг нь аван өргөөнийхөө зүг “нисэн” одлоо. Удалгүй өрлөг эхийн зүг Мандарваагаа зарвал ямаршуухан шалтаг хэлж ижийгээс нь бадамлянхуа цэцгийн дүрс буулгаж авсныг бүү мэд. Ямар ч гэсэн цэнхэр пансан алчуурын захад цоморлигоо хагас дэлгэсэн гоёмсог бадамлянхуа цэцгийн дүрсийг шохойгоор буулган явуулжээ.

-Еэ гялай! Миний Даадаа ийм сайн шүү гэж Ану хөөрөн дэвхцэхийг Мандарваа гайхан харна.

-За бүү илүү хоншоорлоорой чи! Намайг алчуур хатгамалдаж байна гэж үхсэн ч хүнд бүү хэл, мэдэв үү хэмээн Ану зандраад торгон утас ороон бадамлянхуа цэцгээ хатгаж эхэлж билээ. Ийнхүү чадан ядан хатгамал хийж суухдаа эм хүний эрдмийг бас сурах нь амин чухаг зүйл хэмээн ижийнх нь сургадаг орой руу нь орж, за энэ хавраас ижийгээр хатгамал оёх, нүүр царай, биеэ ариглан, галбираа хадгалах олон аргаас нь заалгая хэмээн сэтгэжээ.

Энэ өдрөөс эхлэн гурав хоног махран хатгаж, муухай болсныг нь буцаан хөвөрдсөөр буландаа цоморлигоо дэлгэж буй цагаан бамлянхуа цэцгэн хатгамалтай цэнхэр алчуур бэлэн болж охины сэтгэл амран цээж дотор онгойж билээ. Чингээд зогсохгүй Өэлүн эх Есүхэй мэргэнд булаагдан одохдоо эр нөхөр мэргидийн Чилэдү баатарт “Үнэрийг минь үнэрлэж яв...” хэмээгээд цамцаа тайлан өгснийг санан нөгөө алчуурт үнэрээ шингээх гэж өвөртлөн унтаж байв.

Их хатан таалал болж, өргөөний зам махгүй цагаан хоол бэлтгэсэн тул эхийнхээ өргөөнд үзэмтэй будаа зооглож суусан Ану гашуудлын явдлаас үүдэн гэнэт өнгөрсөн жилийн хар дарсан зүүдээ санав. Урьд нэг удаа шар шувтлан хаан суусан Галдантай ураглан хатан нь болоод дайсны сумыг хаан өмнөөс нь амиа зольж байна хэмээн хар даран зүүдэлсэн нь санаанд орж:

-Би нээрэн, ноднин жил нэг муухай хар дарсан зүүд зүүдэлж, үхэж байна гэж итгээд уйлж байгаад сэрсэн шүү дээ. Үхэх гэдэг их аймшигтай санагдсан гэхэд үхлийн тухай ярианд их л сэжиг цээртэй ханддаг эх нь цочин:

-Юутай муу ёрын зүүд үзээ вэ? Ижийдээ өчихгүй яагаав. Багштанд айлтгаж, ном уншуулах байсан юм гэхэд эцэг нь:

-Үр минь яагаад үхэж байх юм? хэмээн хэнэггүй асууж хатнаа их харахад хүргэв.

Олон дайн тулаанд явж, гэдсээ хүү татуулан татваганаж, хүзүү толгойгоо тасдуулаад хөл нь тийчлэн, эх биеийнхээ тэхий дундуур тас цавчуулан хоёр хэсэг болж эсвэл хэвлийгээрээ сэлэмдүүлээд цувдайгаа гоожуулан үхэж буй цэрэг үзэхээрээ нэг болсон хантанд үхэл гэдэг аймшигтай санагддаггүй ажээ.

-Их сонин зүүд байсан. Би нэг хаан хүний хатан болсон байх юм. \Тэр нь Галдан байсныг мэдээж эцэг, эхдээ ярихад зохисгүй тул алгасаад\ Тэгээд тэр хаандаа их л хайртай, сэтгэлтэй бололтой. Түүнийг харваж алах гэж буй дайсны сумны өмнүүр ороод хэвлийгээрээ тас харвуулан үхэж байна гэж зүүдэлсэн юм. Үхэж буйгаа мэдэхдээ гараа хөдөлгөх гэтэл хөшчихөөд, дуугарах гэтэл дуу гарах үгүй, сүнс минь энэ муу биеэ орхин одож буйг мэдээд үхмээргүй, энэ хорвоод үлдмээр санагддаг юм билээ.

Эцэг эх хоёр нь түгшин хоёр бие рүүгээ харц солилцов.Охиныг төрөхөөс өмнө хоёулаа үзсэн зүүдээ өнөөг хүртэл бие биедээ хүүрнэлгүй явсан атал тэр зүүдийг нэгэн зэрэг санацгааж, харцаараа ойлголцсон нь тэр аж.

Ерөөс өргөөнд гашуудал зарласан энэ үед барлаг, зарц нар их дуу чимээ гаргахаас эмээн сэм сэмхэн алхацгааж, ярих хүүрнэхдээ шивнэлдэн байсан цаг билээ.

Охиныг Мандарваагаа дагуулан өөрийнхөө өргөөнд очихоор одох үед гэр дэх зарц шивэгчингүүдийг гаргаж байгаад хан хатан хоёр хоёулангийнхаа олон жилийн өмнөх зүүдний тухай ярилцан ихэд гайхацгаав. Очирт цэцэн ханд овоо индрийн тэндээс гарч ирсэн навсгар удган, хатантанд бага ахуйдаа оросын Астраханьд таарч байсан цыган хэмээх ов заль ихтэй, дуулж хуурдан, тэнэж явдаг, эх нутаггүй зайгуул омгийнхны хөгшин эм үзэгдсэнээс бус Доржравдан хатнаас мэндлэх охин өсч томроод хаан хүний хатан болж, хожмоо хатгалдах дайсны халуун зэвсгийн суманд оногдон нөхчиж, шастир түүхэнд мөнхрөх болно хэмээсэн нь яг ижил ажгу.

-Арьяавал шүтээн минь, өөдөсхөн сэвгэрийг минь авралдаа багтааж хайрла. Охин сэвгэр болж мэндэлсэн байтлаа хүү хүний зантай энэ хүүхдийг тийм гашуун тавилан угтаж байдаг юм байх даа. Тийм чивэлтэй аюумшгийн зүүдийг хэн хаанаас бидэнд илгээнэ вэ?Өөрөө хүртэл зүүдэлсэн байна шүү дээ,хан эзэн минь гээд хатан нүдний нулимсаа бөмбөрүүлэн эр нөхрийнхөө энгэрээд наалдлаа.

Хатныхаа уйлан чичрэх дал мөрийг илбэн том ган тулганд улалзах аргалын галыг ширтэн гүн их бодолд орсон хантан буурал тэргүүн бөхийлгэн сүүрс алдаад:

-Хувь төөрөг нь тийм бол хэн ч өөрчлөх арга үгүй шүү дээ. Чи минь тайтгарч үз. Өнөөхөндөө энэ өргөөнд таалал төгссөн хүн Цэвээн хатан л байна бус уу?Охин минь будаагаа хүртчихээд гарч өргөөндөө очсон шүү дээ хэмээн тайтгаруулав.

Цэвээн хатны бүрлээч болсны тав дахь өдөр нь Галдан хувилгаан, эхийн хамт Очирт цэцэн хантны өргөөнөө морилов. Бүрлээчийг хөдөөлүүлээд гурав хонож байсан үе. Галдан хувилгаан залрах чимээ уул, талаар салхи мэт хурдан түгж, Хөх нуур хавийн сүсэгтнүүд хантны өргөөний хавиар шаван ирж, цацар майхан шааж багахан балгад суурин мэт хөл дараад байлуга. Эхийгээ хөдөөлүүлэн хойлог хийхэд оролцохоор Гартангомбо,Эрдэнэ тайж,



холд бэрлэн одсон охин Дарьжав болон Доржравдангаас төрсөн Галдмаа баатар нар ирцгээж өргөө ч хөл ихтэй байлаа.

Аанай л ёслолын өргөөнийхээ гадаа хоёр хатан, хүүхдүүд, зарц барлагуудын хамт Ойрад түмний шашны тэргүүн Галдан хувилгааныг хүндэтгэн угтах Очирт цэцэн хантай залуу ламтан мэндийн билэг ерөөлтэй үг солилцоод, өөрийн эрхгүй эхийнхээ цаана хяран зогсох Ануг нүдээрээ хайж олоод харц тулгарчихлаа. Хэдий хаврын урь орж байсан ч хээр талд жихүүн жавартай хэвээр тул цагаан үнэгэн малгай, дугуй хээтэй цэнхэр торгон хөвөнтэй дээлний гадуур цагаан булган богино хүрэм өмсөн, нүд гялбам цагаан сувдан урт унжуурга зүүсэн залуу охины хацар ягааран, үнэгэн малгайн цагаахан сор үсэн доороос жижигхэн цоглог хүрэн нүд өөрийг нь үзээд баяр хөөрөөр догдлон очтохыг харсан залуу хувилгааны амгалан зүрх ч булгилан цохилон.

“Чи минь сайн сууна уу?”

“Амархан сайн даа. Та минь аян замдаа сайн явж ирэв үү?”

“Чамтайгаа учран золгоно гэхээс газрын холыг хэрхэн туулснаа ч ухсангүй”

“Өргөөнд уй гашуу тохиолдсон нь юутай аз вэ! Сэнгэ хаан ахтай тань тавих сүйг минь хойш тавиуллаа”

”Тийм ээ. Тэгээд бас бидэн хоёрыг дахин учрууллаа” хоромхон зуур хайртай хосын нүд харц солилцохдоо үггүйгээр ийнхүү “ярилцаж” амжжээ.

Тэр өдөртөө Галдан лам өргөөнийхөнд адис хүртээхэд тэр хоёр дахин учрав. Хажууд нь эцэг, эх, зарц барлаг олон хүн байсан ч сэтгэлтэй хоёрын хос нүд яаж ийгээд “ярилцаж” амжаад, адис хүртээх далимаар хоёр бие шүргэлцэх тэр агшинд хөвчин бие жирсхийлгэн, халуун цус бүхий л биеэрээ таран, зүрх сэтгэл догдлон баясах хормыг хамтдаа эдлэн цэнгээд хоёр биедээ хоргодон хоргодон холдоцгоож билээ.

“Хүн амьтан саад болохооргүй газар хоёулхан учрах сан”

“Тийм ээ, эр хүний хувьд би чамтайгаа хоёулхан учрах агшныг бэлэглэнээ”

“Би тандаа хатгамалтай алчуур өгнө”

“Би бас чамдаа дарь эхийн алтан дүр гуутай нь хийлгэн өөрөө аравнайлаад авчирсан.”

“Бушуухан шиг тантайгаа учрах сан”

“Чамдаа би ч адилхан хүсэн тэмүүлж байна. Гэвч хонгорхон минь сэрэмж бүү алдагтун”

“Мэднээ. Ойрад түмний шашны тэргүүн Та минь нэрээ сэвтээж үл болно. Би чинь бас Сэнгэ хаан ахын тань сүйт бүсгүй болох хэвээр шүү дээ”

Тэр хоёр харцаараа ийн “хүүрнэлдэж” байлаа.

Галдан ламтан эцэгтэй нь төрийн хэрэг хэлэлцэж, наснаас халин одсон Цэвээн ахайтны хойноос ном хурж, өргөө тойрон шавсан хэдэн зуун сүсэгтэндээ авшиг адис хүртээн завгүй байсаар ирснийхээ гурав дахь орой нь өөрийнхөө шавь ламхайгаа явуулан Ануг буусан өргөөндөө сэмхэн дуудуулжээ.

Хүсэн хүлээсэн мөч ирэх нь! Охин сийлбэртэй, зааны ясан хүрээт босоо толинд зүс царайгаа яаран сандран харчихаад гарч гүйх гэснээ хэчнээн шөнө үйл мэтгэн сууж хатгамалдсан цэнхэр пансан алчуураа мартсанаа гэнэт санаад буцан орж дэрэн доороосоо авч сандчин өвөртөө шургуулаад булган хүрмээ хэдрэн, цагаан үнэгэн малгайгаа далиу тавиад “Чи өргөөндөө сууж бай. Намайг хүн асуух болбоос багшийндаа морилсон гээрэй” гэснээ малгайгаа тэгшлэх зуур хэрэв ижий намайг Галдан хувилгаанд бараалхсаныг мэдчихсэн байвал багшийнд очоогүй нь илчлэгдэх юм байна хэмээн сэтгээд “Үгүй ээ, Галдан хувилгаанаас авшиг хүртээд багшийндаа очно гэсэн” хэмээн өчдөг юм шүү гэж Мандарвааг захиран суулгаад гарч одлоо.

Түүнийг хайртай хүнийхээ хүлээн суугаа өргөөний дэргэд нисэх мэт хурдалсаар ирээд цээж бөмбөрдөн дэнслэх зүрхээ даран хэсэг зогсох зуур Галдангийн шавь ламхай гүйцэн ирээд:

-Та чинь талын гөрөөс мэт хэчнээн хурдан юм бэ! Чүү гэж гүйцэв хэмээгээд өргөөний хүнд эсгий үүдийг өргөж оруулав.

Зочин гийчдэд барьж өгдөг зургаан ханатай уужим өргөөнд галын илч түгэн асч, хойморт байх гүнгэрваатай бурхан тахилын өмнө хэдэн арван зул асаасан нь тэнгэрийн одноос хэсэгхэнийг таслан авчирсан мэт өргөөг өдрийнх шиг гэрэлтүүлж, баруун дээд талд зассан зузаан олбог дээр Галдан хувилгаан номоо бясалгаж байна уу гэлтэй мэлмийгээ анин эрхиэ эргүүлж суухыг охин хараад гирэвшихдээ буцаад гүйчихмээр л байв.

Гадаа хөлөртлөө гүйгээд дулаан гэрт ормогц үнэгэн малгай, булган хүрэм нь халууцуулан, айж, ичих зэрэгцсэн охин юу гэхээ мэдэхгүй зогстол залуу хутагт мэлмийгээ нээж орж ирсэн хоёрын зүг халиагаад:

-Ану гүнж ирэв үү? Малгай, хүрмээ нимгэл. Агваанлуvsан чи гарч бай гэлээ. Түүний баргил сайхан хоолойн амгалан өнгө охины айж ичих сэтгэлийг илбэн тайтгаруулж Ану малгай, хүрмээ тайлан зүүн орон дээр сандайллаа.

-Наашаа ойрт доо. Адис хайрлаж ерөөл айлдья хэмээн ламтан хэллээ.

Галтай тулганы доогуур хэд алхаад охин хайртай түүнийхээ өмнө хормой чичрүүлэн очиж сөхрөн суун туслаа. Хажуу дахь олон зулынхаа гэрэлд Галдан хутагтын цайвардуу цэвэрхэн царай, өнөөх уран хэлбэрт зузаан уруул, өндөр шулуухан хамар, өтгөн хөмсөг доорхи ховсдох мэт цоргисон харцтай алаг нүд Бурхан багшийн хөрөг шиг эрхэмсэг үзэгдэх аж.

-Духаа ойртуул...

-Жаа...гээд Ану нүдээ анимагц хутагтын зөөлөн өндөгтэй хуруунууд духанд нь аяархан хүрэхэд хамаг бие нь ирвэгнэн жирсхийхэд цочин нүдээ нээж зориглоод түүний сайхан нүд

рүү эгцлэн ширтэж:

-Таны гар хэчнээн сайхан зөөлхөн юм бэ?

-Чи үнэхээр улам хөөрхөн болж... Чамайг анх үзсэнээсээ хойш мартаж үл чадах юм...

-Би ч мөн адил... Гэхдээ ах тань намайг буулгаж авна шүү дээ.

Галдан хутагт гүнзгий шүүрс алдаад охины бугуйнаас атгаснаа зөөлөн том гараараа баруун гарыг нь энхрийлэн атгаад тэссэнгүй хөөрхөн ягаан хацарт нь уруулаа хүргэн үнссэнээ гарыг нь атгаастай хэвээр амандаа маань уншин мэлмийгээ аниж, хэдэн хором болсноо тавьж сүүрс алдан:

-Чиний дэргэд удах юм бол сахил санваар, ам тангаргаа ч умартах бололтой сэвгэрхэн минь гээд цааш эргэн хадагт ороолтой юм гарган ирж задлаад бяцхан мөнгөн гуутай эрхийн чинээ алтан бурхан гарган ирж, үүнийг хадгалж эс бол, оосорлоод зүүж, шүтэж, намайг дурсч яваарай гээд өглөө.

Догдолж баярласан охин чичирхийлсэн гараа сунган тэр эрхэм бэлгийг нь хоёр гардан аваад доош өвдгөө хүртэл мэхийн талархаад бурханыг гуунаас нь гарган үзвэл Галдан:

-Цагаан дарь эх. Ямагт шүтэж яваарай. Бүсгүй хүнд ээлтэй. Чи минь наддаа цагаан дарь эх л гэсэн үг гээд нүд рүү нь урсгал харцаар ширтэв.

-Жаа... багшгаан.

-Одоо яв даа. Миний сэтгэл тайтгарлаа хэмээн Галдан охиноос нүд салгаж үл чадан ширтсээр байхад өчүүхэн зүрх нь цээжиндээ багтахгүй дэлдсээр буйд улам ч сандран мэгдсэн охин зүүн орны зүг үлгэн салган явж очоод цагаан үнэгэн малгайгаа толгойдоо тавьж, булган хүрмээ углахдаа аль болох удаан аажуу хөдлөн энэ хүний дэргэд дахин ганц хором ч атугай саатмаар санагдан тэр зуур өнөөх алтан бурханаа зүүн гартаа тас атгасан байлаа.

-Энэ малгай доороос нүд чинь очтоод хэчнээн хөөрхөн сэтгэл булаам үзэгдэнэ вэ чи?

-...охин юу хэлэхээ ч үл мэдэн хувцаслаж дуусаад:

-Та ...та хэзээ буцан морилох вэ? гэж зориглон асуугаад өнөөх сайхан алаг нүд рүү нь харахдаа сая л нөгөө цэнхэр пансан алчуураа санаж өврөөсөө санд мэнд суйлан гаргаад:

-Би хэчнээн мунхаг хүн бэ? Танд өгчилгөх гэж л үүнийг чадан ядан хатгамалдаж, үнэрээ шингээх гэж өвөртлөн унтаж байсан атлаа мартаад гараад явах нь гээд тулганы доогуур хурдан гэгч хэд алхаад Галдангийн өмнө очиж сөгдөн суугаад алчуураа өгөв.

-Гялайлаа, чамдаа гээд ламтан алчуурыг авч үнэрлэсэнээ охины хацрыг баруун гараараа зөөлөн илбээд:

-Бид маргааш Ховог сайрын зүг хөдөлнө. Энэ алчуурыг чинь үхэн үхтлээ хадгалж

явнаа.Гялайлаа чамдаа!

-Би ч бас таны хайрласан алтан бурханыг насаараа дээдлэн шүтэж , хайрлан хадгалж явна.

-Амархан сайн сууж байгаарай!

- Та аян замдаа сайн яваарай!

Охин сэтгэлээ барьж дийлэхгүй мэлтрэн ирсэн нулимсаа түүндээ үзүүлэхгүйн тулд огцом эргэн үүдэнд хүрч, нэг л мэдэхэд жихүүн хүйтэн хаврын шөнө гадаа гарч ирсэн байв. Тэргэл саран гийж, өргөөний орчмыг мэлтийтэл гийгүүлнэ. ”За бушуухан өргөөндөө очихгүй бол ижий, аав, Юм-Агас хатан мэдчихнэ. Оронгуутаа Мандарваад юу хэлнэ?Ямар ч гэсэн энэ нууцаа хэнд ч дэлгэхгүй. Амнаас алдуурсан ганц үгийг хадны цуурай хүртэл давтан, ертөнцөөр нэг тараадаг гэж багш хэлдэг” хэмээн бодон өргөө рүүгээ алхах гэтэл нөгөө хувраг хөвүүн нэгтэйгээс гүйн ирж:

-Багш таныг өргөөнд нь хүргэж өгөөрэй гэсэн гэлээ. Насаар Анугаас ганц хоёр л дүү хөвүүн бололтой.

-Чи Галдан хувилгааны шавь юм уу?

-Тийм ээ.

-Бурханы шавь болоод удаж байна уу?

-Дөрвөн жил нутгийнхаа хүрээнд шавилан суугаад өнгөрсөн жилээс Галдан хувилгааны шавь болон шалгарсан. Багш маань тарнийн аймгийн ухаанд нэвтэрсэн хүн дээ хэмээн хүү ярьж явлаа.

“Надад бол хутагт хувилгаан биш зүрхний минь хайртай хүн. Номт хувцас өмссөн, тарнийн ухаанд нэвтэрсэн хувилгаан байгаагүй зүгээр л Галдан баатар байсан бол чинийхээ төлөө бүх амьдралаа зориулан, амиа өгсөн ч харамсах юм алга” хэмээн Ану бодож явлаа. Чингээд өргөөнийхөө үүдэнд ирэнгүүт:

-Гялайлаа.Чи манайд орж цай уухгүй юм уу гэхэд ламхай:

-Үгүй ээ.Багш дуудна. Удахгүй Юм-Агас ахайтан багштаны өргөөнд морилох байх.Би явлаа гээд гүйн одов.

Ану түүнийхээ өгсөн, одоо ч алганых нь дулаан илчийг хадгалсаар буй мэт санагдуулах өнөө бяцхан дарь эх бурханаа уруулдаа хүргэн, сарны гэрэлд нэг сайн харж аваад өвөртөлчихөөд өргөөндөө орлоо. Мандарваа ганцаараа тулганы дэргэд ширдэг дээр дөрвөн бэрх буулган сууж байв.

Ану явсаар хоймрын авдрынхаа өмнө очиж цүүг нь тайлаад дээд тавиур дээр нь өнөөх нандин шүтээнээ тавиад цуургалж, түлхүүрээ хүзүүндээ зүүгээд:

-Намайг явсанаас хойш хэн ч асууж шалгаасангүй юу? хэмээн асуулаа.

-Үгүй гүнжтээн. Ижийн тань өргөөнд Лувсандаш тайжтан хатны хамт, мөн танай худ Сүлдэн тайжтан, Гартангомботон, Эрдэнэ тайж, Галдмаа баатар, Юм-Агас ахайтны хамт зочлуулан зоог барьж буй гэнэ билээ. Дараа нь Сүлдэн тайж, Лувсандаш тайжтан нар Галдан хувилгаанд бараалхах юм гэсэн хэмээгээд Анугийн царайг харж нүд нь ер бусын баясгалантай гэрэлтэн гийснийг үзээд гайхсан ч “Бүү илүү хоншоорло” гэх вий хэмээн зүрхшээгээд :

-Та багшийндаа морилоо юу? хэмээн тэс өөрийг шалгааж, түрүүхэн хоолон гэрээс авчирсан домботой цай, үзэмтэй хайлмагийг хоймрын гантиг өрөн дээр тавьж, цай аягалан барилаа.

Ижийнхээ тээр жил тод үсэгт тайлагдлаа гэж мялаасан ёроолдоо доржпалам эрдэнэ суулгасан дунд гарын мөнгөн аягатай бага зэрэг зөөгшсөн цайг Ану хэдхэн сорчихоод хайлсан тосонд ам хүрснээ, сэтгэл нь хайр дурлал, догдлолоор цатгалдан байсан тул цааш нь түлхчихлээ.

-Аягандаа тос хийгээт. Та чинь оройн зоог хүртээгүй шүү дээ. Туслах зам үүнийг оруулж ирэхэд нь би таныг ирэхээр хууч хөөрөнгөө хүртье гээд хүлээж суусан юм хэмээн өөрийнхөө аяганд нэлээд том хэсгийг авч хийхийг Ану харж сууснаа :

-Чи өөрөө ид. Би юм идмээргүй, гэдэс эвгүйрхээд гэсэн шалтаг заан ном судраа дэлгэн суухдаа дотроо Галдангийн дүрийг ургуулан ургуулан санаж, “цэнхэр алчуурыг тань үхэн үхтлээ хадгалж явна”, “Энэ малгай дороос нүд чинь очтон гялалзаад хэчнээн хөөрхөн үзэгдэнэ вэ чи?” гэсэн үгсийг нь санан зүрх нь хөөр баяраар гийж ирснээ, хувь тавилан нь түүнтэй хэзээ ч ураглуулахгүй, тиймд хайрын дээжийг нь эгнэгт амтлан жаргаж үл чадна гэхээс цээж харанхуйлан гуниглах зэрэгцээд, ном судраа орхин ахынхаа бэлэглэсэн гарын толиндоо нүүр царайгаа шинжин, урт сувдан унжуургаа сонжин хараад “Нээрээ чи хөөрхөн сэвгэр болж байна уу даа” гэж бодон инээмсэглэв.

Галдан хувилгааныг өргөөнд нь морилохоор л Ану гүнж ийнхүү ааш зан нь олдохоо болино хувираад, юм л бол зүс царайгаа тольдон, ээмэг, зүүсгэлээ зүүн гоодоод байдгийг Мандарваа сая л ухаарч, “Гүнжтэн тэгээд Ойрад түмний номын их багш Галдан хувилгаанд дур сэтгэлтэй юм гэж үү? Мунхаг миний ухаанд ч үл багтах юм байна. Тэр чинь амилсан бурхан шиг байлтай. Үгүй нээрээ, хараад байхад үнээр сайхан эр байдаг шүү, хувилгаантан биш байсан сан бол. Хөөрхий гүнжтэн удахгүй түүний ах Сэнгэ хаанд ураглан очиж, дөрөвдүгээр хатан нь болох гэж байдаг. Юутай гашуун заяа тавилан бэ! Эм хүн болж төрнө гэдэг үйлийн үр, урьд насанд хийсэн лай хэмээн ижийн хэлдэг үнэн юм байна даа” хэмээн өчүүхэн ухааныхаа хэрээр л болж буй явдлын учрыг тунгаах гэж оролдон, эзэн авхайгаа өрөвдөн суужээ.

Юм-Агас хатан Анутай хэд хэдэн удаа тааралдахдаа түүнийг Галдан хүүтэйгээ хайр сэтгэлийн холбоотойг мэдээгүй юм шиг, басхүү Сэнгэ хаантай сүй тавих тухайд өдгөө ярихад зохисгүй гэж бодсон бололтой, хэв ерийн зүйл ярьж, улам өсч том болж буй, нүд салгамгүй хөөрхөн сэвгэр болж байгаагаас нь өөр бусад сэтгэл түгшээх сэдэл үл өгсөнд Ану туйлаас баяртай байлаа.

Маргааш нь өргөөнийхөн цуглан Галдангийн хөсгийг үдэхдээ аян замдаа сайн явахыг ерөөн, тэд ч үлдэгсдийг амар мэнд сууж байгаад, билэгтэй сайн өдөр учран золгохын сайхан үг хэлэлцэн салахад залуу хутагт хүний нүд хариулан өврөөсөө цэнхэр пансан алчуур гарган үнэртэхийг Ану олж үзээд сэтгэл нь баяр хөөрөөр дүүрэн догдолж, бяцхан гараа зүрхэндээ хүргэн энэ дохиогоороо “Таны хайрласан бурхан, Таны дүртэй хамт энд шүү” гэдгийг ойлгуулав.

Олон бараа бологч, гоцго, хэвтүүл цэрэг эрс, лам, ламхай дагуулсан хөсөг хойд зүгт аажим аажим алсран холдсоор хаврын зэрэглээн дунд уусан одовой.

## Арванхоёрдугаар бүлэг

Тэр жилийн зун Хөх нуурт дэлгэр сайхан зун болж, намрын эхэн сард намаржаанд буусны дараа хантан Ану охиноо дагуулан Бээжин хотыг үзүүлэнгээ, замдаа Хөх хотод мал хуй, ангийн үс наймаалан гарын бэл хийгээд өргөөнд хэрэгцээтэй нарийн нандин эд бараа базаахаар морджээ.

Их хөлийн Бээжин хот, эрээн мяраан бараа дэлгэсэн зах зээл, олон хэлтэн хөлхөлдсөн давчуу гудамж, чамин тансаг нанхиад идээ зоог, эцгийн танил манж түшмэлийн хээнцэр цэцэрлэг, ганган ордон охинд багадаа үзсэн Цастын орны Лхас хотоос илүү сэтгэгдэл төрүүлэн бахдуулав.

Ану урьдынхаа зангаар түрийний чамин хутга, хулсан бийр зэрэг эр хүний эд хэрэглэлээс гадна битүү оюу ухаж хийсэн чамин эдлэлийн хайрцаг, цэцэг навч, эрвээхэй хатгасан нимгэн гоёмсог пансан эд, шанхны сувдан сам зэрэгт нүд унаган, оо энгэсэг хүртэл сонирхон буйг эцэг нь чимээгүйхэн ажиглан, охиныхоо нүд унагасан юманд нь гар татахгүй авч өгөн хэтэвчээ тэмтэрч байлаа. Доржравдан хатан энэ удаа холын замд ядрахаас түвэгшээсэн үү, аль эсвэл удахгүй хол газар ураглан одох охиноо хайрт эцэгтэйгээ хоёулхнаа хамт аминчлан аялаг гэж бодсон уу, “Та минь Анугаа аваад яв. Би Бээжинг үзээгүй бишталийгч их хатнаас хойш орд өргөөгөө эзгүйрүүлээд яахав” хэмээн цааргалан хоцорчээ. Мандарваа сэвгэр, эзэн авхайнхаа ачаар түмэн хүн холхилдсон их балгад Хөх хот, Бээжинг үзэн, илжиг луус хөлөглөсөн нанхиадууд, газар хагалан будаа, тариа, ногоо тарьж суурьшин суудаг хятадуудын амьдрал ахуй, халууны ялаа шиг шавааралдсан навтгар шавар урцнуудыг ам ангайн харж, Манж чин гүрний эзэн хааны сүрлэг их орд харшийг алсаас үзэн сүрдэж ёстой л “юм үзэж” нүд тайлж, орой нь дэн буудалдаа ирээд Ануд энд чинь “ногоон хурганы арьс, нохойн битүү туурай”-наас бусад нь байх шиг байнаа хэмээн шагшин, эзэн авхайгаа нулимсыг нь гартал инээлгэж билээ.

Тэднийг Бээжингээс буцаж харихад өргөөнийхөн Хар хадны өвөлжөөндөө хэдийн төвхнөсөн байлаа.

Нэг мэдэхэд идэш хийж, нөгөө өдөр нь ес эхлэн жавар тачигнаж, цас их унасан ч малын гарз хохирол ихгүй өвөл болж, Ану багштайгаа “Судрын чуулган”-ыг тод үсэгт буулгалцан, түүх шастир хүүрнэсээр өвлийн гурван сар дорхноо өнгөрч цагаан сар гарав. Тэр жил их хатан Цэвээн таалал төгссөн тул цагаан сарыг сүр багатай ёслон өнгөрөөв.

Аргын 1668 он, шар бичин жил гарлаа. Тэр жилийн хавар нь урт болж, зуны эхэн сарыг хүртэл дулаарсангүй, цас, шороон шуурга шуурсан хахир жихүүн байв. Очирт цэцэн хан Эмилийн тал руу илүү зуншлага сайн байж магад гэсэн сураг сонсоод тийш нүүж, тэнд зусахаар их нүүдэл хийв. Эмилийн тал нь ирээдүйд хүргэн болох гэж буй Сэнгэ хунтайжийн Ховог сайр дахь ордонтой илүү ойр, зэрэгцэн орших нь ч таатайг бодолцсон биз. Нүүдлийн эхэнд хэдэн мянган хонь, ямаа бүхий богоо тааваар нь туухаар төлөвлөж, агтныхан нэг тусдаа, тэгээд хантны олон өргөө гэр, зарц барлагуудын хамт хөсөглөн хөдөлсөн нь бүтэн өдөрчийн газар цувран үргэлжилсэн урт цуваа болжээ.

Нүүдэл хийхэд хөгшид ядарч, хүүхэд нялхас зутрахаас биш, Ану, Балсан, Мандарваа мэтийн

залууст зугаатай сайхан байв.

Гурав хоног нүүдэллэн явсаар Очирт ханы түрүүлэн илгээсэн хүмүүс газар нутгийг шинжээд горхи булаг ихтэй, хойд талаасаа уулархаг, тэнэгэр сайхан хөндийд байх Хөшөөтийн хөндлөн гэдэг газар зуслан болгон сонгожээ. Хавар оройтсон ч газрын чийг сайн буй тул зуны эхэн сар гэхэд том том хөх яргуй хэнзлэн, шилбээр татах өндөр өвсөн дунд ногоон хамбан дээр шигтгэсэн индранил эрдэнэ мэт үзэмжтэй гоё харагдах аж.

Хантных шинэ зусландаа олон том өргөө гэрүүдээ барин чулуугаар тиг гортиг татан, ширэг ногоон зүлгийг халцлахгүйн тулд гэрүүдийг хооронд нь холбосон чулуун хашлагат элсэн зам тавих зэргээр гайгүй сайхан төвхнөөд байтал Сэнгэ хунтайжийн өргөөнөөс элч довтолгон ирэв. Урьд Хөх нуур, Алшаад байхад хунтайжийн өргөөнөөс гурав, дөрвөн өдөрчийн зайтай байсан бол өдгөө сайн морьтой элч хоногтоо хүрэлцэн ирж багтахуйц газар дөхөм болжухуй.

Хунтайжийн элчийн өчсөнөөр гурав дөрөв хоногийн дараа Оросын Томск балгадаас ирэх элчийг хүлээн авч уулзсаны хойно Сэнгэ хаан ирж, охинтой нь ёс төртэйгээр сүй тавихаар болсныг дуулгажээ.

Шинэ газарт нүүж ирээд сэтгэл дэврүүн, сартай жороо зээрдээ унан хээр талаар давхиж, тарвага зурамны толгой тас харван наадах буюу бичгийн нэртэй өөрийнхөө өргөөнд ном судар эргүүлэн суух болсон охиноо эцэг нь тэр орой эхийнх нь өргөөнд дуудуулав. Анугийн багш Дүүрэн мэргэн бие тэнхээ төдгүй өвчин хууч хөдөлж буйн дээр Очирт цэцэн ханы Ану гүнжид миний заах эрдмийн хэмжээ төгсөв хэмээгээд төрсөн нутаг, ус, төрөл саднаа бараадахаар болж Хөх нууртаа үлдсэн билээ. Ийнхүү Ану номын багшаас хагацсан нь нэгэн бодлын насанд хүрч буйн ид бахыг үзэн, басхүү харвах, намнах эрдэмд илүү шамдах завшаан ихэссэн ч хорвоогийн элдэв явдлыг бясалган, санасан бодсоноо хүүрнэлдэн мэргэн сургаалийг нь сонсдог эрхэм хүнээ үе үе үгүүлэхэд хүргэж байсан ч чадалгүй эрд гараагүй залуу сэвгэрүүд эцгийн гарт байхдаа эдэлдэг хоромхон зуурын зугаа цэнгээтэй амьдралд умбан сэтгэл тайтгарчээ.

Сувдан тоорцогтойгоо өнгө хоршин гялалзах лавай цагаан шүдээ яралзуулан инээсээр эхийн өргөөнд гэнэ сэрэггүй орж ирсэн охиноо үзээд эцгийн сэтгэл өмрөн унах шиг болов. Сэнгэтэй гурван жилийн өмнө ганц нэг уулзахдаа мэнд мэдэхээс өөр үг сольж үзээгүй, өөрийнх нь олж дуулснаар эцгийн эмс сэвгэрүүдэд шунамтгайг хуулж төрсөн, охиноос нь даруй хориод насаар ахмад, дур сэтгэлгүй хүнд нь амь шиг хайртай Анугаа өгнө гэдэг цаг дээрээ хантанд амар байсангүй. Сүйг нь хүлээн аваад, хоёр жилийн дараа хуримыг нь хийлгэе хэмээн хэсэг цаг хожихоор дотроо шийдээд байлуга.

Ану цагийн мөнхөд дагуулж явдаг Мандарваатайгаа хөтөлцөн инээд алдсаар орж ирэв.

Эцэг нь дүнсгэрдүүхэн царайлан халуун цай оочилж, эх нь охин өөдөө арга ядсан харцаар харан угтав. Эхийн өргөөний залуу шивэгчин Уламнэмэх бүсгүй Ану, Мандарваа хоёрт цай аягалан бариад гарч одов.

-За үр минь, Сэнгэ хаан элч илгээв. Өнөөхөндөө Оросын элчин төлөөлөгчдийг хүлээн авч уулзах алба ажил төдгүй байгаа юм байна. Холын гийчдийг үдэж өгөөд урьд жил



тохиролцсон ургийн хэргийг гүйцэлдүүлэн хадаг тавихаар удахгүй морилон ирэх гэнэ. Охид сэвгэрүүд эцгийн гэрт төрж өсөөд эрд гарч ураглан одох нь энэ ертөнцийн жам буюу гэлээ.

-Жаа, аав аа.

-Өнөөг хүртэл үр чамайгаа хайрлаад харвах, намнах, цавчилдах цэргийн эрдэм, номын ухаанд шохоорхон эр хүний үйлд шамдахад чинь би цээр тавиагүй. Харин өдгөө хадмын газар хатан болж ураглан одохын өмнө журамт бэрийн ачлалд суралцан, ижийгээрээ оёж хатгах үйл, хатан хүнд сонсч, мэдэх учиртай юм юу байна, тэр бүгдийг заалган үгийг нь дуулж бай. Чамайг хадаг тавьж гуйх улс өнөө маргаашгүй ирж, Сэнгэ хааны сүйт бүсгүй болох ч гэсэн балчир охиноо арван найм хүргэж байж хуримын үйлийг нохой жилд дэглэх нь зөв хэмээн аав нь мунхаглана. Тиймд үр минь эцгийн гэрт байх энэ чөлөөнд эрх дураар жаргаж ав хэмээгээд гүнзгий сүүрс алдлаа. Тэрхэн мөчид охиноо эхийн хэвлийд байхад тэнгэрт хальсан Баатар хунтайжийн хойдын хэрэг явдлаас харих замдаа үзсэн өнөөх билэггүй зүүдээ эргэн санаж “Охин тань хаан хүний хатан болж, хатгалдах мэсний үзүүрт халуун зэвсгийн суманд өртөн үхэх болно...” гэсэн удганы үг чихэнд нь сонсогдох мэт болоход нь “Хоёр жилийн хойно хонин жил гарах хүртэл зай ч байна. Лай ч байна. Хэрэг явдал энэ хооронд хаашаа ч эргээ билээ. Зүүдэнд үзэгдсэн тэр удганы өчсөн хаан нь Сэнгэ ч бай, эс бөгөөс өөр хэн ч бай энэ хооронд үр минь сэтгэл тааваараа байг. Тэгж байтал учир начир нь тодрох биз” хэмээн бодоход цээж дотор чилүүрдэх нь арай ч багасах мэт.

Сэнгэ хаантай хоёр жилийн дараа нохой жилд ураглуулна гэсэн эцгийнхээ үгийг анирдаад охины нүд баяр хөөрөөр сэргэн гийхийг хан, хатан хоёр анзаарч дор дороо томоогүй үрээ өрөвдөн энэлж байв.

-Жа мэдлээ. Би ижийгээр оёх хатгах, бэрийн ёс журам, бүсгүй хүний нарийн ухааныг заалгая даа хэмээн өөрөө хүсээд яваа юм хэмээ Ану өчив.

-Тэгмээр дээ. Нэгэнт бүсгүй заяатны төрлийг олж төрснөө мэдэж байгаа нь яамай хэмээн тэндээс хатан шөвөгнөхөд Ану зүүн хөмсгөө өргөн эх өөдөө нэг хяламхийгээд гарч одов.

Энэ нутгийн зүг нүүж явахдаа Ховог сайртай ойролцоо зусах нь. Яаж ийгээд хайртай хүнийхээ барааг харчих сан гэж хайр дурлал, мөрөөдөл тэмүүлэлдээ шатан догдолж явсан охин ийнхүү дур сэтгэлгүй хүнтэй ураглах цаг айсуй түгшүүрийн чимээг анирдан зүрх нь палхийсэн ч ухаант эцэг нь хадаг хүргэснээс хурим хүртэл “Мах идүүлгэ”, “Зүс хадаг”-ийн найр, “Сүй бэлэг”, “Эд хүргэх” зэрэг олон ёслолыг цугааранг хоёр жилээр хойш татан нохой жил хүртэл охиноо эрх тааваар, амар тайван байлгах бодолтой буйгаа өчсөн нь дотор цэлмээсэн тул “Сэнгийн тухай бодлоо орхиё. Өнөө үдэш Далай тайшийн хөвүүд айлчлаар ирэх юм чинь “Буур ботгон болох”\*, “Алчуур гүйлгэх” \*\*наадам наадаж цэнгэхээ бодъё” хэмээн сэтгэв.

Тэр үдэш саахалт зусч буй Далай тайшийн Цэрэн, Баваасан нарын Анутай ойролцоо насны залуус ирж, Балсан, Чилэдү, Чилэгэр, Ану, Мандарваа, Булган энэ хэдтэй цагаан гэгээ тасартал наадацгаав. Алчуур гүйлгэн наадах үеэр дугуй хүрээ үүсгэн суусан залуусын дундаас Далай тайшийн ач хүү арван естэй Цэрэн хэргээр Анугийн ард гүйж ирэн Мандарваагийн ягаан дурдан алчуурыг унагаад “Алчуур гүйлээ” хэмээн аялгуулан хэлээд Булганы дэргэд очин

суулаа. Нар шингээгүй байхад дүүгээ дагуулан хөө хар зүсмийн усан тэлмэн жороо морь зүс ижилсүүлэн унаж ирсэн, улаан хацартай, тэг дөрвөлжин цээжтэй, бахим тэр залуу шинэ нутагт буусан өдрөөр анх үзээд л Ануг санаашран ширтэх болсон билээ. “Энэ Цэрэн хэчнээн түвэгшээлтэй амьтны үр гээчив? Зориуд миний ард алчуур авчирч тавиад л, харц салгахгүй ширтээд л. Өөдөөс нь ганц харахад л хацар нь улам улайчих юм байж...” хэмээн охин доогтойхон бодсон ч сэмхэн алчуурыг авч өвөртлөв. Харин алчуурыг олох учиртай Балсан бас л Ануг нүд салгахгүй ширтэн үүлгэртэж явдгийн хэрэг юу билээ. Цэрэн тип тапхийн гүйж гүнжийн ард очоод алчуур унагаж, Ану түүнийг нь өвөртөө шургуулахыг сортоочлон харж амжсан ч эс үзэгчин болж баахан тойрч гүйгээд “Алчуур эндээ” хэмээн Булганыг гөрдөв.

“Ээ, Балсан хоёр цийлэн нь яачаав? Надад алчуур байхгүй ээ” хэмээн адтай Булган жиг жиг хөхрөн төрхгүйтэж, өвөр түрийгээ нэгжин үзүүллээ.

-За, Балсан оньсого хэл. Эсвэл үлгэр домог хуучил. Эс тэгвээс чи ямар дуулж, икэл хуур татаж хүчрэх биш хэмээн Мандарваа доохойллоо.

Хэдий алчуур Ануд буйг харсан ч ийнхүү эс үзэгчин болсныг нь Мандарваа л ганцаараа таамаглаж байсан тул тийнхүү доохойлсон биз.

Морин дэл дээр дүүлэн нисэх мэт давхих зуур зурамны толгой алдалгүй нам харвах буюу, морины давхиан дунд эмээлээсээ зүүгдэн гэдсэн доогуур нь орж байгаад харвах, чичлүүр хутга мэргэн шидэх зэрэгт чадмаг атал яриа хөөрөө болхи Балсан хуучин дөрвөн талт тоорцгийнхоо оройг оролдон ичингүйрч зогссоноо арайхийж ганц оньсого санасан бололтой “Үсүн\*\*\* далай сүрхийнэ. Сүрхий баатар ухасхийнэ. Ян шувуу ярхийнэ. Ясан толгойт годхийнэ” тэр юу гээч вэ? хэмээн бүгт дуугаар хэлээд дороо суун тусав.

-Энэ чинь бас часхийсэн оньсого мэддэг хөвүүн байсан юм бий. За таацгаа хэмээн Ану чанга хэлэхэд Булган:

-За энэ оньсогыг мэдэхгүй хүн байдаг буюу?

Үсүн далай сүрхийнэ гэж хоттой хонь үргэх биш үү?

Сүрхий баатар ухасхийнэ гэдэг чинь хээрийн саарал чоно бус уу?

Ян шувуу ярхийнэ гэж хотны нохой хуцна биш үү?

Ясан толгойт годхийнэ гэж унтаахай эзэн хүн нь гэрээсээ булт үсрэн гарч ирнэ биз дээ? хэмээн дор нь таачихсан тул тоглоом наадмын амт сулруулчихав.

Эцэст нь залуус “Цагаан мод хаяж” тоглов. Ану хэдий үеийн залуустай ийнхүү наадаж тоглон сэтгэл хөгжүүн байсан ч тэр улаан хацарт Цэрэнгийн оронд сэтгэлийг нь булаагч Галдан хувилгаан байсан сан бол... хэмээн үе үе дотор цээжиндээ түүнийгээ санагалзан байж билээ.

Хэд хоногийн дараа зуны дунд сарын билэгт сайн өдөр, бэр гуйн хадаг тавихад өлзий билэг дүүрэн хэмээн Галдан хувилгаан дүүгийнхээ шоо хаян байж хэлсэн өдөр нь Сэнгэ хаан цөөн

хэдэн бараа бологч, шадар хэвтүүл гучаад морьтон, хадаг тавихад хүргэний эцэг буюу авга талын настан буурал ах заавал очдог заншлыг барин авга Цөхүр увшийг дагуулан Очирт цэцэн хантныд буулаа.

-Хүргэн болох Сэнгэ хаан морилох гэнэ. Өнгөтэй өөдтэй лавшигаа нөмөрч, үс гэзгээ самнан, зүсээ гоодоорой үр минь хэмээн Доржравдан ахайтныг өглөө нь хэлэхэд Анугийн царай хувьсхийгээд явчсан ч эхийн сэтгэлийг эрхбиш бодон тэргүүн бөхийлгөж:

-Жа ижий хэмээгээд сүүтэй будаа, үзэмтэй шарвингаа дутуу орхин гарч одов.

Уг нь өргөөний хөгшин зам Анугийн дуртай үзэмтэй шарвинг хайрч, жижиг мөнгөн цар дээр овоолон авчирч тавихдаа:

-Гүнжтэн сайн зоогло. Үдэш цагаан гэгээ тасартал үсэрч наадацгаах юм. Турж эцэх вий хэмээн сайхан сэтгэлийн угаас хэлж, буурал хөмсөгний хооронд хоёр гүнзгий атираагаа тэнийлгэн мишээж асан билээ.

-Та чинь умдаа дуустал зооглохгүй гараад гүйчихдэг. Би цартай шарвинг тань аваад ирлээ хэмээн Мандарваа шогширсоор орж ирсэн нь Ануд сэтгэл чилэхээс илүү өөрөө тэр амттанд хар буусан нь илт.

-Юм ууж идэх дур алга. Чи өөрөө наадхиа барж дуусгаарай хэмээх Ану босоо толиныхоо өмнө суух атал үс, зүсээ ямар буйг харах ч үгүй, хивсний алхан хээг ширтэж байна уу гэмээр гөлрөн сууж байлаа.

-Та зооглохгүйм уу? Хөрчихлөө, хайран сайхан идээ. Би ганцаараа хэрхэн барах билээ? Та шальтай юу ч идэж уухгүй юм. Би л өмнөөс тань хамсаар мяраалж, зоолж гүйцэх шиг байна. Үсийг тань самнах уу? Авдраас лавшигуудыг тань гаргая даа хэмээн ам дүүрэн шарвинтай Мандарваа өндөлзөнө.

Хивсний хээг гөлрөн харсаар бодолд дарагдан суусан Ану сая толгой өндийлгөн шивэгчин охины нүүр өөд сортосхийгээд “Арай ахынхаа хадаг тавихад хань болох гэж Галдан хувилгаантан морилон ирэх юм биш байгаа? Тэгвэл гооддог ч юм бил үү? Хүний болох гэж буйгаа гайхуулан бардамнах мэт санагдах юм болов уу? Энд бууснаас хойш нэг морилоод ирэх болов уу? хэмээн хэчнээн ч их харав даа. Усан нүдтэй, цусан зүрхтэй эгэл хүмүүн бидний нэг биш юм болохоор хөөрхий сэвгэр миний зүрх сэтгэлийг үймрүүлээд яана хэмээн халиасан биз дээ” хэмээн урамгүйхэн бодоод:

-Надад Сэнгэ хааныг гэх сэтгэл үгүйг чи мэднэ. Лавшиг дээлээ солин сэртэндэх дур алга. Харин толгой дээрх энэ таван хялгасаа нэг эмхлэн самнаж шинээр гөрвөл болох нь тэр хэмээгээд харц шилжүүлэн толь руу хараад гүнзгий сүүрс алдах аж.

Мандарваа дотроо эзэн авхайгаа өрөвдөн мөн л сүүрс алдаж “Сэтгэл зүрхээ даган эрд очсон сэвгэр гэж байдаг юм гэж үү? Бүсгүй богино жолоотон бидний үйлийн үр энэ шүү дээ. Гүнжтэн тэгээд хэнд сэтгэлтэй юм бол оо? Хөх нуурт байхаас л ноёд ихсийн хөвүүд шохоорохон эргэлдэхэд нүүр өгч буй нь үзэгддэггүй. Уг нь цорос аймгийн хунтайж, өдгөө

Зүүнгарын хаан болж буй гэх Сэнгэ хаантан нас идэрхэн, зүс сайхан, хийморлог эр шүү дээ. Би л лав тийм ихэсийн хатан болж мордоно гэвэл хөөрч баясахдаа торгоны сайхнаар биеэ хучиж, алт эрдэнийн сайнаар өөрийгөө чимээд хүлээн суух байсан даа. Өөр хэн нэгэн эр хүнд сэтгэлээ өгсөн болоод л өнөөдөр хадаг талбих хүн нь морилох гэж байхад ийнхүү гуниглан суудаг байх даа. Гэтэл тэр хүн нь хэн юм гэдгийг хэн ч гадарлахгүй” хэмээн гайхширна.

Авдраас Мандарваагийн гарган дэлгэсэн олон дээл, лавшигууд дунд тэртээ хоёр жилийн өмнө Хөх нуурын Өндөр эргийн зусланд Галдан хувилгаантай учрахдаа өмсч асан алтан хатгамалт хөх цэнхэр торгон лавшиг нүднээ тусахад охины зүрх нь палхийн, итгэл найдварын сүүлчийн зул нь нэгмөсөн унтрах мэт болж, гол харлан суун тусчээ.

Анугийн сүүн цагаан царайд ургасан мэт зохидог тэр хуцвсаа үзээд царай нь хувьсхийхийг ажсан Мандарваа шинэ нутагт буусны хойно зүүнээс гарсан, цэцгэн хээ товойлгосон тод ягаан лавшигийг авчран дуугүйхэн өмнө нь тавиад үсийг нь задлан том зандан самаар самнаж эхлэв. Ану юу ч дуугарсангүй. Номын багшаа байсан бол Сэнгэ хаантны хатан болох тухайд нь юу хэмээн айлдах байсан бол? хэмээн бодож суув.

Үсээ самнан гөрж, олон салаа алтлаг хүрэн гээгнийхээ үзүүрт алтан оосор уян чимээд, цээнийн цэцгийн өнгөт торгон лавшиг өмсөн, өрөөсөн чихэндээ танан шигтгээт алтан унжуурга зүүн, сувдан тоорцог өмссөн гуниг дүүрэн нүдтэй Ану эхийн өргөөнд ороход нь хатуу сэтгэлт Доржравдан хүртэл өрөвдөн хяламхийгээд олон үг өдөлгүй сэтгэлийг нь бодон дуугүйхэн суулаа.

Удалгүй хүмүүс шуугилдан, ноход хуцалдан, хүндэт гийчин морилон ирэхэд охин эхийнхээ хамт ёслолын өргөөний зүг гарав.

Сэнгэ хааныг дагалдан ирэгсдийн дунд Галдан хувилгаан байсангүй. Дүүгээ бодвол жижигхэн нүдтэй, ширүүн харц, өтгөн ширвээ сахалтай л болохоос Сэнгэ хаан сайхан эр юм гэдгийг Ану сая л ажиглав.

Бэр гуйж хадаг тавихад хүргэний эцэг буюу, авга талын хамгийн настай ахмад хүн заавал очдог цоросын хуучны ёсыг дагаж нүүр дүүрэн үрчлээтэй ч хөнгөн шингэн хөдөлгөөнтэй Цөхүр увш ёслолын бүрэн хувцастай хүрэлцэн иржээ.

Эхийнхээ ятгалгаар дөрөвдүгээр хатан болгон авах гэж буй Ану гүнжийг үзээд Сэнгэ хаанд сайхан төрх нь сэтгэлд нийцсэн ч төдийлөн өндөр бус бэсрэгхэн бие, ийм залуу бага эм хүнд хэтийдсэн ухаалаг харцтай жижигхэн нүд, хаан хүн хадаг талбин гуйж байхад үхэл өөдөө очих гэж буй хүн шиг уй гуниг дүүрэн гөлөрч суусан нь таашаагдсангүй ээ.

Хашир чоно Очирт цэцэн хан ч юу бодсон юм, охиноо харамлаад хар буугаад байгаа ч юм уу, хуримын ёсыг заавал хоёр жилийн хойно нохой жилд гүйцэлдүүлнэ хэмээн хойш татаад буйд дотроо ихэд цухалдан, эгдүүрхсэн ч гаднаа ил гаргасангүй, найртай үгс хэлэлцэн Цөхүр увш урьд Сэнгийн ах нар Цэцэн, Зодов тэргүүтэнд хатан буулгахад хэд хэдэн удаа хадаг тавихаар мордож байсан хашир толгойн хувьд “Булга торго оёдог нь танайд, буга марал намнадаг нь манайд” хэмээгээд:

-Хан таны гүнж Ану бичиг эрдэмд гаргуун, зүс царай гоо үзэмж төгс, басхүү цэргийн эрдэмд төдгүй хэмээн дөрвөн Ойрад даяарт цууд гарчээ. Харин миний ач Сэнгэ хаан өдгөө нас гучин тавтай. Эцгийн ор залгаад даруй арван зургаан он өнгөртөл энэ цорос аймгаа тэргүүлэн, нэг бус удаа дайлаар мордон дайн тулаанд ялж, овгийн сүлдэт туг хиураа мандуулж яваа цог заль төгс эр бөлгөө. Энэ хоёрын хувь заяаг нэгтгэн, эртнээс улбаатай цорос, хошуудын ургийн барилдлагыг үл таслан авч явах нь зүйг та юун эс андах. Иймийн тулд таны охин Ану гүнжийг Сэнгэ хааны дөрөвдүгээр хатан болгож буулган авах хүслээ илтгэн бурхан шүтээнд тань эдийн дээд хөх баранзад хадгаа өргөө дөө хэмээгээд хадаг дээрээ тавин лангийн алтан ембүү тавиад барилаа. Дөрвөн Ойрадын чуулганы ханы ёслолын хувцсаа агсч, тэргүүндээ очир эрдэнийн жинст малгай асаан ёсорхуу зангаар сэтгэл доторхи эцгийн харамсал, өр өвтгөх гунигаа хаацайлах мэт хөмсөг зангидан суусан Очирт цэцэн хан хоолой засаад:

-Миний өчүүхэн сэвгэрийг ихэд бодон хадаг тавьж буйд эцэг миний сэтгэл тэнэгэр байна. Хан эцгийн гэрт төрөөд хадмын гэрт мордох нь сэвгэр хүний тавилан билээ. Хадгийг тань хүндэтгэн хүлээж авч байгаагаа уламжилъя хэмээв.

-Таны өнгө үзэсгэлэн Ану гүнжийг би бусад хатдаасаа илүү эрхэмлэн хайрлаж, нуган үр төрүүлбэл өөрийнхөө орыг эзлүүлнэ хэмээн сэнгэ эхийн зааж өгсөн үгийг тэр чигээр нь хэлээд хантны нүүр өөд дулаан харц илгээв.

-Чихэнд таатай үг айлдаж буйд талархаж байна. Үнэндээ таны эцгийг тэнгэрт хальдаг жил мэндэлсэн, өтөл миний отгон үр учраас энэ охиндоо би амь тавьдгаа нуух юун. Аминаасаа илүү хайрлан өсгөсөн охин сэвгэр үрийг минь удам сайт, ухаан төгөлдөр хаан та муу үгээр харааж, мод саваагаар жанчихгүй нь лавтай. Ану охин минь, авга хадам, эр нөхөр болох хүндээ хүндэтгэлийн ёс үйлд хэмээгээд өргөөний зүүн талд эхийн цаана нуугдах мэт хярсан Ануг дуудав.

Ийнхүү Очирт цэцэн ханы Ану гүнжид Сэнгэ хаан хадаг тавьж, дөрөвдүгээр хатнаа болгон буулгах болсон тухай сураг дөрвөн Ойрадаар барахгүй халхын нутгаар ч хуй салхи мэт хурдан тарж байхуйд бүсгүйн дурлалт залуу лам орох байх газраа үл олох мэт цээж дотор харлуулсан гашуун гунигаа умартах гэхдээ Илийн хойд эрэг дагуух үзэсгэлэнт тохойд барихаар эхэлсэн Алтан угалзын сүмийн ажилдаа улайран оржээ.

Хэд хоногийн дараа Цөхүр увш арваад бараа бологчийн хамт хантныд морилон ирж хадгийн лав аваад цагаан гэгээ тасартал найрлаж байгаад буцав.

Намрын эхэн сарын нэгэн сайхан өдөр Сэнгэ хаан хориод тэмээ ачаа хөсөг, зуугаад дагуул бараа бологч, эх Юм –Агас хатан, авга Цөхүр увшаа авчран цорос ёсоор “Мах идүүлгэн”-ий найр цэнгэл үйлдэж, хантны өргөөнийхөнд найман настай балчираас наян наст буурал хүртэл толгой дараалан үнэт бэлэг сэлт түгээн, гүнжийн сүйд хоёр зуун булга, хоёр зуун шилмэл агт, хорин цагаан тэмээ, хоёр мянган хонь, хоёр зуун лан алт өргөв.

Царайных нь сүүн өнгөнд уусан улам ч цонхигор мэт харагдуулах мөнгөн одтой цагаан торгон лавшиг, туяхан гоолиг бэлхүүсийг нь өнгөрөн унжих арваад салаа алтлаг хүрэн гээгнээсээ мөнгөн оосор унжуулан, өрөөсөн чихэндээ сайн төө гаруй урттай, гурван эгнээ сувдан унжуурга ээмэг зүүсэн Ану энэ өдөр хэний ч нүдэнд тодрон гоё сайхан харагдах

хүсэлгүй, сэтгэл дэх мөрөөдлийн харш нь нуран унаж буйг урамгүй доош ширтэн гөлрөх харцаараа илтгэх мэт эцгийн ёслолын өргөөний зүүн талд гуниглан суусаар байвай. Сүйт эр, Зүүнгарын хаан хэмээн өөрийгөө өргөмжлөх болсон Сэнгээс түүнд шар будаан чинээ оюу, номин, сувдаар чимсэн алтан шармал хайрцагтай үсний танан сам, гарын толь, оо энгэсэгний сав, хөмсөг зулгаах чимхүүр, хэлний хусуур, хумс богиносгодог бяцхан хайч зэрэг гоо заслын тансаг сайхан хэрэглэл бэлэг болгон ирүүлсэн нь Мандарваа, Доржравдан хатан хоёрыг л уулга алдуулснаас бус, бүсгүй хүний элдэв чимэг зүүлт, оёмол хатгамал, гоёл чимэглэлийн зүйлд төдийлөн сонирхон шохоорхдоггүй Анугийн сэтгэлийг өчүүхэн ч хөдөлгөсөнгүй. “Мах идүүлгэний” найрт газар хол тул Галдмаа ах нь биеэр ирж чадаагүйд харамсан, Хөх нуураас наашаа нүүхийн өмнө эхтэйгээ тэднийхээр гийчлэхэд өнөө бяцхан Ахай охин нь зургаан нас хүрч, эхийн том алаг нүд, эцгийнхээ царайны гонзгойвтор зөв хэлбэр, эмэг эхийн үзэмжтэй цайвар арьсыг дууриасан тас хар өтгөн гэзэгтэй, барьж авч үнсээд тавихгүй баймаар эгдүүтэй амьтан болсныг хараад нярай байхдаа өрөвгөр үс, үрчгэр арьстай муухай хүүхэд байснаа ийн хөөрхөн болсонд нь ихэд гайхан, түүнд өөрийнхөө багадаа тоглож асан ширэн тулам дүүрэн боронзтой шагай, жижигхэн агар хувингаа бэлэглэж билээ. “Би тэр ач дүү Ахай шиг бяцхан охин байсан ч болоосой. Тэгвэл чингэж сэтгэлгүй, өөрөөсөө олон насаар ахмад, өчнөөн хатан, татвар эмтэй Сэнгэ хаан шиг хүнтэй ураглах гээд “Мах идүүлгэн”-ий найран дээр хөлчүү улс “Зээ бичкэн хээрийг...” хэмээн орилолдохыг чагнан, хайртай хүнээ санан өр зүрхэн хөндүүрлэн суухын зовлонг огтоос үл гадарлан эрхэлж цэнгэж явах сан” хэмээн холын хол газар эцэг, эхийнхээ дэргэд, хөөр баяр дүүрэн тоглон гүйж яваа Ахай охинд атаархан, бүсгүй хүний тавиланг хайрласан бурханд гомдох ч шиг, санаа амар, сэтгэл хөөртэй эрх бага насандаа хоргодох мэт суувай.

Сэнгэ, сүйт охины эцэг Очирт цэцэн ханы хамт хойроор зэрэгцэн суугаад өөрийг нь хүндэтгэн барьсан зум хэмээх бүтэн хонины махыг арьстай нь хуйхлан битүү жигнэсэн хүндэтгэлийн зоогт ам хүрэх зуур саяхан Зоригт хошуучаас хантны өргөөнд шивэгчин болгон өгсөн өтгөн хар хөмсөгтэй хиргис угсааны нуруулаг сэвгэрээд шохоорхлын харц илгээн өргөөний зүүгээр суусан сүйт бүсгүйгээ төдийлөн анзаарахгүй буйг ажигласан Юм-Агас хатан хүүтэйгээ харц тулгарах завшаанд Анугийн зүг дохих, Цөхүр увш бэр гуйгчаас илүү Очирт цэцэн хантныг хожмын холбоотноо гэж харж буй нь илт хуруувчин хундагатай хар архиа тулган найрсаг яриа өдөх, Доржравдан хатан цагийн эрхээр гундаж буй гоо сайхнаа хадгалсаар буйгаа үзүүлэх гэсэн мэт инээхэд нь хоёр нүд, хацрын хонхорхойг нь тойрон илт тодордог үрчлээсээ нуун завьжаараа инээх аядах, зэргэлдээх Зостын хийдийн ширээт лам шалхгар бүдүүн Санжжав гавьж жасын будаандаа цадахаа больсон болов уу гэмээр зумын амтлаг махнаас хомхойрон идэх зэргийг охин гунигтайгаар ажиглан бодолд дарагдана.

Харин Очирт цэцэн ханы хувьд сүүлийн үед Сэнгэ төрийн хэргийг өөртэй нь зөвлөх нь багасан, ойр хавийн Ойрад аймгуудыг ухуулахыг нь ухуулан, дайтахыг нь дайтан гартаа оруулж, халхад нэгэнт хаант төр үгүй болсон тул, дөрвөн Ойрадыг нэгэн тугийн дор нэгтгэн Зүүнгар улс байгуулна хэмээн бүтэхэд хэцүү мөрөөдөлдөө умбан, их толгой гаргах болсныг нь хадам эцгийн хувьд чадлаараа хазаарлах, дөрвөн Ойрадын чуулганыг бутаргах нь магад буйд хориг тавих боломжийг энэ ургийн холбоо гарт нь авчрана гэдгээр л үймэрсэн сэтгэлээ тайтгаруулж, хатуу дарсанд мансуурч суув.



## Арвангуравдугаар бүлэг

Сэнгэ хаан Ану гүнжийг гуйж хадаг тавин, сүй бэлгээ хүргэж уламжлалт “мах идүүлгэ”-ний найраа хийгээд мордсон тэр намар Ану эхээрээ оёх хатгахыг заалган, олон юм үглэхийг нь тэвчээртэй сонсон суусаар цагаан сартай золгов. Тэр хооронд Галдан ламтан ханы өргөөгөөр огтхон ч үзэгдсэнгүй. Тэдний зуслан, намаржааны дэргэдүүр зориуд юм шиг алгасан өнгөрч, шинээр бариулж буй Алтан угалзын хийдийнхээ элдэв ажлаар нааш цаашаа довтолгон яваа сураг сонсогдохоос бус, гэгээн дүрээрээ морилон ирэхгүй л байлаа.

Аргын 1670 он, цагагчин нохой жилийн хавар. Сэнгэ хаан дүү Галдан, ах Цэцэн тайж тэргүүтэн элчдийг Бээжинд зарж, Манж чин гүрний Энх-Амгалан хаанд бэлэг хүргүүлсэн сураг дуулдаж, Ану охин тэр их хөлийн газар хоёр жилийн өмнө аавтайгаа хамтдаа аялан, багшийнхаа “Хүнзийн гэр” хэмээн сургасан дотор газрын суурин ахуй, элбэг баян зээлийн газраар явснаа дурсан, түүнийгээ ямархан бодолд автан явааг таамаглаж болдог ч болоосой, энэ хорвоог амгаланаар халиагч саруул мэлмийг нь ганц харахсан гэсэн элдвийн бодол толгойд нь эргэлдэн байж билээ.

Хахир хатуу, урт хавар дуусан хур бороо элбэгтэй сайхан зун залгав.

Галдан хувилгаантны Илийн зүүн эрэгт байгуулсан Алтан угалзын хийдэд зуны дунд сарын билэгт сайн өдөр цам харайн, Майдар эргэх сураг уул талаар тарж, сүсэгтэн олны магнайг тэнийлгэлээ. Архаг хууч нь үгдрэн бие ядруу суух болсон өрлөг эх нь цам харайх, майдар эргэхээс илүү, дөрвөн Ойрадын шашны тэргүүн Галдан хувилгаантны мутрын адис хүртчихвэл санаа амар, сэтгэл түвшин нүд аних сан хэмээн хөөрнө. Нас тавин дөрөв хүрсэн ч анзааргагүй хүнд дөчөөд насны эхнэр мэт толиотой харагддаг Доржравдан хатан лавшиг, цэгдэгнийхээ өнгийг тааруулан, авдар дүүрэн алт үнэт эдлэлээсээ шилж зүүн, олны хөлийн газраар явна гэхээс хөл хөнгөрөн, хувцас гоёлоо дэлгэн хөл болно. Нуран хатан өргөмөл охиныхоо гэзгийг шүүгээр угаан Доржравдан ахайтны өгчилгөсөн бүдэг ягаан торгоор охиндоо лавшиг хийлгэж, өөрөө нас залуу ч, өргөмөл бяцхан үрээ л цэмцгэр харагдуулах гэж хичээнгүйлнэ.

Сэнгэ хаан өөрийг нь гуйхаар хадаг тавих болон, “мах идүүлгэн”-ий найр цэнгэл үйлдэхээр хэд хэд ирэхэд гоёж гоодох бодолгүй суусан Ану ч хүний хатан болоогүй сэвгэр ахуйдаа эцсийн удаа сэтгэлт хүнтэйгээ учрах гэж буй энэ завшаанаар түүндээ гоё сайхан үзэгдэхийг мөрөөсөн, бас хөл болон сандарлаа.

Авдар дүүрэн хоргой, торгон лавшигууд дунд нь түүний бодлоор зүрхний хайрт Галданд таашаагдах нь ганц ч үгүй мэт санагдан өргөөний бойдаагаас шинэ лавшигийн торго үзүүлэхийг шаардав.

Ануг Алтан угалзын хийдэд болох цам майдарт өмсөх шинэ лавшигийн торго үзэн өргөөний бойдааг сандаргаж буйг дуулсан Доржравдан хатан “Өнөө бяцхан сэвгэр чинь хувилгаан ламтнаа мөрөөдсөөр суугаа байх нь. Одоо ядаг билээ? Эцэгт нь дуулгах уу, яанав?” хэмээн эх хүний мөнхийн зовнилд автан, хэр барагтайд хөдөлдөггүй омголон сэтгэл нь түгшүүрлэв. Эм хүний зүрх сэтгэл гэдэг энэ туйлбаргүй, богино жолоотонд элбэгдсэн хатуу зоргоороо эд байдагт хатан харамсан, охиноо өрөвдөж суулаа. Өөрөө бас л арван долоотой явснаа хатан



умартаагүй. Эцгийн гэрт байхдаа тэрээр хасаг угсааны, өтгөн хар хөмсөг, дэгжин ширвээ сахалтай царайлаг сайхан зуутын даргад мөн л энэ Ану шиг сэтгэл зүрхээ өгчихөөд, Очирт цэцэн ханы хатан болон мордохдоо дотуур цагаан пансан цамцаа түүнд бэлэглээд хагацсан билээ. Хадамд гарсан эхний саруудад суугуул нутаг хөх усан мяралзуулсан үзэсгэлэнт Ижил мөрнөө, өдөр шөнөгүй аманд элч зууран, хатаж байдаг Алшаагийн говиор, сэтгэлт сайхан эрээ, насаар олон ах Очирт ханаар арилжчихсан мэт санагдан нууцаар гуниглан, сэм сүүрс алдсаар Галдмаа хүүгээ төрүүлж байж сая хувь тавилантайгаа эвлэрснийг нь шадар шивэгчин Жангаагаас нь өөр хэн ч үл мэдэх ажгу. Чухам ахайтан өөрөө тэрхүү томоогүй гэнэн, зүрх сэтгэлийн хайр, биелшгүй мөрөөдөлдөө үнэнч арван долоон насаа мартаагүйн учир охиндоо юу ч үл хэлэн, юу ч үл анзаарагчин болохыг илүүд үзсэн нь оножээ.

Аливаа хэрэгт ямагт хошуу дүрэн, хангинаж явдаг эх нь “Авдар дүүрэн дээл лавшигтай байж юунд шинэ торго голж шилээв?” гэх вий хэмээн яс нь хавталзаж асан Ану эхийнхээ тийнхүү нам жим буйд туйлаас их талархав.

-Мандарваа! Энэ их эдээс чухам аль торго надад илүү зохиролтой сайхан лавшиг болох бол? Алив чи нааш ирээ! хэмээн Ану шивэгчин охиноо эд уурсын гэр рүү чирэн орлоо. Түүнийг гуйгаад байх ч хэрэг байсангүй.

-Пээ, базарваань гэж. Энэ их торго, хоргойгоор цам майдарт ирэх энэ хөндийн бүх сэвгэрт лавшиг хийж хүрэх байх шүү. Алив үзье хэмээн сэтгэл хөнгөн, хэрэгт дуртай Мандарваа ханцуй шамлан ороод явчихав.

-Та их цайвар царайтай, шингэн ягаан хацартай болохоор ягаан, цагаан эд зохимж тааруухан юм билээ. Аль дээр Хөх нуурт байхад Галдан хувилгаан ирнэ гээд л та нэг их хөл болж гоодсон доо. Мандарваа хэзээний зангаараа бодсоноо л хэлж буйг мэдсээр хэрнээ Ану “Галдан хувилгаан ирнэ гээд л нэг их хөл болж гоодсон доо...” гэсэн үгэнд нь палхийгээд явчихав. Гэсэн ч өөрөөсөө хүртэл нууж явдаг энэ зүрхний нууцыг нь мандарваа, Балсан хоёроор барахгүй, эцэг эх нь, бүр хожмын хадам эх Юм-Агас нь хүртэл гадарладаг болчихсоныг томоогүй бүсгүй мэдээгүй л байлаа. Анугийн царай түүний тэр бодлогогүй үгсээс болж хувьсхийхийг Мандарваа анзаарсан ч нэгэнт л дуулгаваргүй амнаас нь тэр ёсгүй үгс уначихсан тул цааш нь үргэлжлүүлэн:

-Тэгэхэд та алтан хатгамалтай тод цэнхэр лавшиг өмсөөд нэн хөөрхөн үзэгдсэн шүү. Аль, энэ хөх торго ямрав? гээд хуй хуйгаараа хураалттай торгон дундаас нэгийг сугалан гаргаж ирээд тоосонд нь их дуугаар найтаав. Тэр нь тод улаан удвал цэцгэн хуартай, алтан саатай, “тэр жил” өмссөнөөс нь илүү тод хөх өнгийн торго аж.

-Яг миний бэлзэгнийх шиг өнгөтэй юм аа. Надад зохих болов уу? хэмээн Ануг хэлэхэд бойдаа хар хүн урт иштэй, үзүүртээ үстэй гөвүүр гарган тэр торгоны захаар тогтсон өлөн тоосыг гөвөөд:

-Авхайн цагаан зүсийг энэ индранил өнгө тодруулж харагдах биз. Талийгаач Цэвээн хатантны дуртай эд байсан. Өдгөө ганцхан хуй үлджээ хэмээв.

-За тэгвэл энэ торгыг би өргөөндөө аваачлаа. Хөөе Балсан, охид сэвгэрүүдийн ажилд залхаа

юу? Орж ирээд энэ торгыг миний өргөөнд аваачиж өгөөд үйлчин эгчийг дууд хэмээн Ану тушаагаад гарч одов.

Тод хөх өнгөн дээр улаан удвал цэцгэн хуартай тэр торгоор урласан лавшиг маргааш нь бэлэн болов. Гадаа бороо уйлагнан, тэртээх Алтайн нуруунд их манан будан хөшиглөж, тэнгэр зузаан үүлэн хивнэг нөмөрсөн өтгөс мэт бүүдийсэн зуны өглөө. Ану сэрчихээд ирвэсэн хөнжлийн дулаан илчинд хоргодон хэсэг хэвтэв. Газарт шар тос хэмээн хөгшдийн хэлэлцдэг зуны эхэн сарын шиврээ бороо өргөөнийх нь дээвэр шавшин дусагнаж, хурын сайхан чийг хамар сэнгэнүүлэх нь таатай. Агаар чийглэг сэрүүн, гал асаагаагүй гэрт үүрийн өмнөх хүйт хоргоджээ. Гаднаас үнэртэх газрын хөрс, хурын чийгний таатай сэргэлэн үнэрийн зэрэгцээ норсон эсгийн эхүүн хамар цоргино.

-Гүнжтээн! Гэрийн зүүн талд байх орон дээрээсээ Мандарваа нойрмоглохон дуугарч буй нь тэр.

-Өөв!

-Та сэрчээ юу?

-Үгүй, нойрсч байна хэмээн Ану ийнхүү ямагт мэдээжийн зүйл асуудагт нь уцаарлаад хэвтрээ солин цааш эргэв.

-Балжидыг дуудан гал асаах уу?

-Үгүй ээ!

-Өргөөнд сэрүүхэн байна бус уу?

-Өл дээр идэр есийн хүйтэнд хоноглож буй биш дээ.

-Гэрт чийг хургажээ гүнжтэн.

-Зүгээр ээ гэж байхад...

Тэр хоёрыг ахайтны өргөөнд өглөөний умд уугаад байтал үйлчин Цэцэг бүсгүй лавшигийг нь авчирч өгөв. Хавьд үзэгдээгүй хуучин торгоны үлдэгдэл олж хийлгэсэн шинэ лавшигийг нь үзээд эх нь юм хэлсэнгүйд Ану дотроо залбирсаар шинэ дээлээ аван гарч одов. Өргөөндөө ирээд өмсч үзвэл Мандарваа дээлийн өнгө торго, хоргой шилэхдээ үнэхээр билгийн нүдтэй аж. Торгоны индранил өнгө охины царайн сүүн өнгийг тодруулаад час улаан удвал цэцэг нь цог золбоог нь илтгэх агаад Ану гоёл чимэглэлийн хайрцгаа уудлан шунхан улаан шүрэн унжуурга гарган зүүхэд, Мандарваа торгоны өөдөс, туушин, алчуур энэ тэрхэн хадгалдаг хөлийн жижиг үхэгээс час улаан тууз гарган шанхыг нь боовол үнэхээр үгээр илэрхийлэхэд бэрх гоо үзэмж төгс харагдахад хоёр залуу бүсгүй сэтгэл хөөрөн хөхрөлдөв. Тэр оройдоо Ану урьд хоёр жилийн өмнө оёх гээд амжаагүй тамхины хавтагыг тас хар пүүсүүгээр урлаад, дээр нь юуны дүрс хатгахаа мэдэхгүй баахан бодож бодож хос загас хатгамалдахаар шийдэж, шөнөжин оёж нойргүй хоножээ.

Тав зургаа хоноод Ану эцэг эхийн хамт өргөөнөөс олон зарц барлаг, цэрэг эрс дагуулан зүүншээ Алтан угалзын хийдийн зүг мордлоо.

-Майдар цам дээр хүргэнтэй тааралдах нь мэдээж тул удахгүй ёсолсон хатан нь болох хүний хувьд урьдынх шиг бүү тоомжиргүй царайлаарай. Бүсгүй хүн эр хүнийг ааш ялдам, эевэргүү зөөлнөөрөө л өөртөө татаж чаддаг нь жам шүү хэмээн эх нь сургаж сургаж замд гарлаа.

Эхийгээ тийнхүү үглэж байхад Ану өтгөн ширвээ сахалт Сэнгэ хааныг биш, алаг нүдтэй, уран хэлбэрт нүд булаам уруултай, номт улаан шаргал хувцастай Галдан хувилгаантныг л сэтгэлдээ зураглан сууж билээ.

Алтан угалзын хийд рүү явах аян замдаа сартай жороо хээрийнхээ хатираан дунд хайртай хүнийх нь бэлэг алтан дарь эх өвчүүн дээр нь төөнөх мэт аяар аяар санжганахыг мэдрэн, энэ олны дүйвээнээр хэрхэн аргыг нь олж түүндээ тамхины хавтагаа өгч, ганц хоёр үг солих билээ? гэхээс өөр бодол охины толгойд үл орж ирнэ. Ойрноос нурууны хууч нь хөдлөн царай дорой байгаа эцэг нь ахайтны хамт мухлагт тэргэнд суун, морьтон залуусын хойноос гэлдэрч байгааг хараад Ану ихэд өрөвдөн, ачлалт эцгээ асрахын оронд, хэзээд хувь тавилангаа үл холбох эрийн тухай санаашран яваадаа ичингүйрч, мориныхоо амыг татаад эцэг эхийн сууж яваа мухлагт тэрэгний зүг хатируулан очлоо. Сартай жороо хээр нь ялаархан уран толгой хаялж, хөл нь хөнгөн ч гэж жигтэйхэн хэд хатираад мухлагт тэрэгний дэргэд очив.

-Ойрд морь унахгүй номоо шагайж, оёдол хатгамал хийн шөнө дүл болтол суугаа харагдсан. Охин минь агсагадах вий. Зам нилээд хол шүү хэмээн эцэг нь санаа талбихад:

-Зүгээрээ ааваа. Та нээрэн эртүүд Алтан угалзын хийдээр орлоо гэсэн. Дуганууд нь гоё юм уу? хэмээн охин асуугаад амнаас нь Галдангийн тухай үг унаасай хэмээн горьдох атал тэр бодолдоо ичингүйрэн эмээлийн бүүрэг рүү харц шилжүүлнэ.

-Алтан ганжир гялалзуулаад, будаг шунх нь ч хатаагүй байна лээ. Гоё байлгүй яахав дээ. Төвдөөс сүм хийд байгуулж гаршсан хоёр лам залж авчирсан юм гэнэ лээ. Намайг очиход Галдан хувилгаан эзгүй байсан хэмээн Очирт цэцэн хэлээд “Хэрэв Галдан сахил хүртээгүй байгаад Сэнгийн оронд эцгийн суурь залгасан бол ч энэ дөрвөн Ойрадыг донсолгож байгаа вий. Бурхан таалж, түүнийг хувраг болгосон нь өлзий ч байж мэдэш. Түүн шиг үсчсэн хийморилор, ухаан холч хүн зарим үед цаг үеэсээ даван сэтгэснээс аюулд унахаа ч зүрх эс алдана. Тэгвэл энэ цөвүүн цагт дөрвөн Ойрадын түмэн олон дахиад л гал усны гашуун зовлонд унаж зүдрэх болно. Сэнгэ бол аливаад хүлээцтэй, далайлт нь чанга ч буулт нь зөөлөн юм” хэмээн охиныхоо бодлыг таасан мэт залуу хувилгааны тухай бодож явлаа.

-Энэ залуу лам хоёрхон жилийн дотор дөрвөн Ойрадын түмнийг араасаа дагуулан, энэ их хишиг өглөг цуглуулаад хоёр сайхан сүм барьчихаж байна гэдэг лут юм аа хэмээн Доржавдан ахайтан Галдан хувилгааныг магтана.

-Тэртээд Угалзын хийдийн алтан ганжир гялалзаж харагдана. Онъ хөтлийн орой дээрээс дурандаж хар, үр минь хэмээн эцэг нь хэлэхэд Ану өврөөсөө ганц нүдний дурангаа гарган дурандаад сэтгэл хөдлөн:

-Тийм байна. Юутай үзэмжтэй үзэгдэнэ вэ! За би морио давирлаа гээд мориндоо ташуур өгч хөсгийн тэргүүн хэсэгт бие биеэ гоочлон яваа Балсан, Мандарваа хоёрыг гүйцэн ирээд дурангаа Балсангаад сарвайн:

-Та хоёр нэг гэрийн эр эм хоёр мэт цагийн мөнхөд толхилцохоо больцгоо гэм. Тэр зүүн урагш дурандаад халиагаадах. Юу үзэгдэнэ? хэмээгээд морио давиран хөтлийн орой уруу давхин гарлаа.

Хойноос нь Мандарваа, Балсан хоёр ч гүйцэн ирэхэд эцгийн шадар зуутад албан хаах болсон бундир толгойн харуулд гарсан болтой бас давхин ирэв.

-Алив над өгөөтөх. Би бас үзмээр байна хэмээн Мандарваа үглээд Балсангаас дурангий нь авч алсад зэрэглээн дунд хөвөлзөн тодрох Угалзын хийд рүү хараачлаад:

-Ганжирууд нь алтран гялалзаад бурханы орон л ийм байдаг байх даа гэхэд Бундир, Балсан хоёр түүнийг шоолж, нирхийтэл инээлдэв.

-Наснаас нөхчиж байж л чи бурханы оронг үзэх байлгүй дээ. Бурханы оронг үзэх гэж яараад байвал бушуухан жанч халах хэрэгтэй бус уу? Усан нүдтэй, цусан зүрхтэй манд тэр газар ямар хамаа байхав хэмээн дуугүй дүмбэгэр атал далим гарвал Мандарвааг элдэвлэж байдаг Бундир хэлээд шувуун саарал хурдан хүлгийн нуруун дээр дүүхэлзэн хуяг, цээживчнийхээ ган тольтыг гялалзуулж, зэр зэвсгээ хангинуулан баруун гараар ташаа тулан ханхалзана.

-Бурхан минь, битгий үхэх, хатах тухай яриад байгаач хэмээн Мандарвааг тэрүүхэндээ аалиггүйтэн хөхрөхөд:

-За за, шинэ хийдийн цамд явж байж Бундир чи юунд билэггүй яриа өднө вэ! Аль Мандарваа дуран өгөөтөх гэж Анут зандрахад Мандарваа өөрийг нь эзэн авхай нь өмөөрсөнд баясан омогшиж:

-Ёстой. Амны билгээс ашдын билэг гэгчээр... гээд дуранг нь Ану руу сарвайлаа.

Уул ус тэгш, байгалийн гоо үзэмж бүрдсэн газарт барьсан Алтан угалзын хийд сүсэгтэн олны хөлд дарагдсан ч цам хараахан эхлээгүй байв.

Сүмийн горломын баруунтай барьсан найман ханат их өргөөнд Галдан хувилгаан заларч буй гэнэ. Очирт цэцэн хан заларч явааг дуулаад залуу хувилгааны илгээсэн хоёр лам хийдийн баруунтайх хөтөл дээрээс тэднийг угтан авч, цам эхлэхээс өмнө хувилгаанд бараалхуулахаар замчлан хөдлөв.

Хийдийн ойролцоо Сэнгэ хаан, түүний эцэг нэгт олон ахан дүүс, Ойрадын бусад ихэс дээдэс Цөхүр увш, Багабанди, Зоригт хошууч, Далай тайшийн хөвүүд ач нарын зэрэг ноёд олон өнгийн асар майхан шааж, хуарагнан буусан нь холоос талын цэцэг мэт өнгө алаглан нэн үзэсгэлэнтэй үзэгдэх ажгу.

Шар торгон хөлтрөгтэй, өндөр мөөрөн дээр барьсан их найман ханат өргөөндөө Галдан

хутагт ахынхаа хадам болох Очирт цэцэн ханыхныг хүлээн авч мутрын адис хүртээв.

Чухам өөрт нь зориулан оёулсан тод улаан цэцэгтэй, хөх торгон лавшиг, алтан утсаар зүү ороон чимсэн улаан залаат тоорцог, улаан тасам алчуур, зүүн чихэндээ шунхан улаан шүрэн унжуурга зүүсэн арван долоотой Ану охины зүг Галдан хоромхоноо шохоорхлын оч гийсэн харц илгээгээд, мутрын адисаа хайрлахдаа мэлмийгээ анисхийн дотроо ямархан нэг тарни шивших мэт аман дотроо гүнгэнэнэ. Залуу хувилгаантны зөөлөн мутар охины хүйтэн магнайд хүрмэгц хос залуусын зүрх нэгэн зэрэг уулга алдах мэт дэнслэн цохилоход, Галдан хувилгаан бурханы номоор хань хийн сэтгэлээ түвшитгэхийг оролдсон нь тэр байлуга.

“-Та минь амархан сайн сууж байв уу?”

“-Амгалаан. Үгүй, амгалан ч гэж. Ахын сүйт сэвгэр болсон чамайгаа санах бүрд сэтгэл өмрөн гуниглах юм.”

“-Би ч гэсэн. Таны хайрласан алтан бурханыг харж сэтгэлээ дэвтээдэг.”

“-Одоо намайг март даа.”

“-Үгүй чадахгүй нь. Өршөөж хайрла, өчүүхэн сэвгэр намайг!”

Гэр дүүрэн хүний дэргэд хоромхон зуур хос залуус ийн харцаараа ярилцлаа.

Гэвч булгилан цохилох зүрхээ аргадан, бурханы ном уншиж, хожмын бэргэн болох энэ сэвгэрт өгсөн сэтгэл зүрхээ эгүүлэн авчрахаар Галдан хувилгаан амандаа мааниа шившсээр байх зуур Ану охин гэрээс гарч одсон байлаа.

барлагууд нь асар босгож байх зуур Сэнгэ ханы асарт тэднийг урьсан залуу хиа ирж эцэгт нь бөхөсхийгээд:

-Сэнгэ хаантан чигээ уухаар морил хэмээн намайг илгээлээ гэв.

Өлзий хээт хөх торгон асрынхаа хойморт перс хивсээр бүрсэн сэнтийдээ морилон дэргэдээ ижийгээ суулгасан Сэнгэ хаан нүд алдам гоёж гоодсон Ану үзээд “мах идүүлгэн”-ий найрнаас хойш хэчнээн том болж, гоо үзэмж бүрдээ вэ? хэмээн гайхаж ширвээ сахлын үзүүрийг имрэн жоготой инээмсэглэж байхад, Ану гагцхүү дүү Галданг нь бодон том эрээн шаазан дүүрэн мэлтэлзсэн исч гүйцээгүй түүхийвгэр чигээгээ барьсаар суулаа.

Эцэг эх нь удахгүй хүргэн болох Сэнгэ хаантай мэнд ус мэдэлцэн, малын тарга хүч, зуслангийн ногооны гарц зэргийн хэв ерийн үг хэлэлцэн, тэдний ярианд ухаан хурц Юм-Агас хатан оролцон хөгжөөж байхад ч Ану Галдангийн тухай бодолдоо живэн дүмбийсээр суухад завшаан болж, цам эхлэх харанга дэлджээ.

Газар газраас цугласан сүсэгтэн олны хөл Алтан угалзын сүм байрласан үзэсгэлэнт ногоон дэнжийг хотойтол дарж, адуу мал янцгаах, хүмүүсийн чих дүлийрэм шуугиан, эрээн мяраан хувцастай, морьтон монголчуудын дунд цамын цагаан өвгөн гүйн гарч ирэх тэрхэн агшинд Ану тамхины хавтагаа Балсангаар Галдан хувилгаанд өгчилгөөд хүмүүсийн хөл үймээнээс

зайдуу ганцаар голын бургасны тийш очмоор санагдав.

Мандарвааг дагах гэхэд нь “Чишш...Цамаа үз.Би удахгүй...” гэчихээд шуугин урсах Или голын хөвөө рүү морио хөтлөн ганцаар одов.

Голын захаар үргэжлэх оюу өнгөт ногоон ширэг дээр их усны урсгал ширтэн суухуйд охины сэтгэлийн их давалгаан намжин, хүсэл, хясалд бачуурсан өвчүү цээж нь уужрах мэт сайхан.

-Охин минь, заяа тавилан чамд хатуурхахгүй ээ гэх эмгэн хүний дуунаар бүсгүй цочин давхийгээд толгой өндийлгөвөл ширэг өвснөөс ганц нэгийг хазлах чөдөртэй мориных нь дэргэд харь холын гэмээр навсгар хувцас, урт хар банзалтай, хар алчуур толгойдоо хулгавчилсан эмгэн инээвхийлэн зогсох аж. Хамар өндөрдүү, нүүр нь түмэн үрчлээст баригдсан атал хүнхэрдүү хар нүд нь жавхаа төгс гялалзах эмгэн:

-Чи хүсэл татсан эртэйгээ хуримлах болно. Энэ олны дунд тэр чинь чамайг бодон сууна. Тун удахгүй тэр хүн хаан болж,чи хатан суудалд суух боловч ид насандаа хорвоогийн амьдралыг түүнийхээ төлөө орхиж, дайны талбарт үхэх юм байна.

-Тэр хүн...тэр хүн чинь хэн юм бэ?

Эмгэн хариулсангүй, алмуур таягаараа голын ногоон ширэгний зөөлөн хөрсөнд хүчлэн тулж, толгой сэгсрэн алчуураа засаад:

-Тэр хүнтэйгээ чи тэнгэрт адислагдсан юм байна. Та хоёр хэдэн төрөлдөө хослон амьдарсан улс юм...Аз жаргал дэргэд чинь байна, бүсгүй минь гээд хүүе гэхийн завдалгүй цааш эргэн алхав.

Сартай хээр нь шилгээн үүрсээд эмгэний урдуур халхлахад гэнэтийн цочирдлоос гарсан бүсгүй сэхээ авч:

-Хүүе эмгээ! гээд ухасхийн бостол хэн ч дэргэд нь байсангүй. Харин Балсан майгадуу бахим хөлөөр хурдан хурдан алхлан ирж явснаа:

-Юун эмгээ? хэмээн гайхаад:

-Хувилгаантны шавиар дамжуулан хавтагыг тань өгчихлөө. Рашаан, энэ эрхиний хамт танд өгүүлсэн гээд ийш тийш гайхан харж:

-Та чинь энд ганцаараа юу хийж байна? Ганцаар ингэж бүү явж бай. Түрүүн та юун хүнийг ”Эмгээ!” хэмээн дуудаад байсан бэ? гэж асуулаа.

Хайртай түүнийхээ өгүүлсэн ягаан шүрэн эрихийг хоёр гардан авах зуураа Ану зүүн хөмсөг өргөн шадар бараа бологч энэ хөвүүний нүүрээд хянамгай харж:

-Чи ирж явахдаа нэг тийм...харь маягийн хар хувцастай эмгэн хүн үзэв үү? хэмээн асуулаа.

-Үгүй чишш...

-За тэгвэл энэ тухай ахин бүү ярь гээд Ану морь уруугаа очлоо.

Цам майдар дээр Ану, Галдан хоёр биечлэн уулзаж завдсангүй ч зүрх булгилуулсан харц солилцон, бие биедээ бэлэг солилцон санасан сэтгэлээ тайлсан тул цээж уужран хоёр тийш салан одлуга.

Анутаг голын хөвөөнд таарч учрыг нь тайлшгүй жигтэй үгс хэлээд зэрэглээ мэт сарнин алга болсон харь хийцийн хар хувцаст эмгэнийг мөргөлчдийн дунд хүн явуулж сэм хайлгаад ч олсонгүй. Тэрхүү эмгэн чингэж газарт мөргүй, чихэнд сураггүй алга босонд Ану ихэд гайхан, усан нүдтэй, цусан зүрхтэй хүмүүн бус, удган шидтэн байсан юм болов уу хэмээн удтал гайхшран бодсоор хэлсэн үг нь санагдаж, сэтгэл цэлмээх буюу эсвэл айдас түгшүүр төрүүлсээр л байлаа. Хоёр жилийн өмнөх зүүдээ тэр гэнэт эргэн саналаа. Сэнгэтэй бус шар шувтлан хар болсон Галдантай суучихсан, тэгээд түүнийгээ харийн дайсны сумнаас хамгаалан өмнүүр нь орон үхэж байна хэмээн зүүдэлсэн нь охины хожмын хувь тавилан байсан юм биш байгаа!

Галдан хувилгааны хувьд тэр оройдоо сүсэгтний хөл хөсөөн намжсаны хойно, ахынхаа Анутаг хийх хуримын явдлыг шоо орхин шинжих гэтэл “Хурим болохгүй” гэсэн төлөг хэд хэдэн удаа буухад гайхан бодлогоширч, амны тарниа уншаад, сэтгэлд уяатай Ану охины дотно дүр, өөрт нь зориулан өмссөн нь илт, гал улаан цэцгэн хуартай хөх торгон лавшиг, улаан залаат гоёмсог тоорцог, улаан тасам, шүрэн унжуурга ээмэг, адис авахаар дөхөхдөө шанхны үсээ илбэн эгдүүтэйгээр мишээснийг нь санан санасаар амтат нойронд умбалуга.

Ану охины баясгалант залуу насны билэгдэл, хадмынд мордоогүй охин сэвгэр үеийн сүүлчийн зун, намар нүд ирмэхийн зуур өнгөрч анхны цас хаялав. Галдан хувилгаан хоёр жилийн турш хөөцөлдөн байж бариулсан Алтан угалзын хийдийнхээ хурал номыг жигдрүүлээд намрын эхэн сард цастын орныг зорьсон сураг дуулдаад өнгөрсөн билээ. Зун нь хур арвин орж, газрын гарц сайхан байсан ч, хөрсөнд шингэсэн их чийг өвөлдөө хайран, урьд үзэгдээгүй хүйтэн хатуу өвөл болно хэмээн хөгшид хэлэлцсэн нь үнэн болов. Голын жавар цан хүүрэг татуулан чацарганын бут хөлдөөд тас тасхийн хугарч, хоттой хониноос захынх нь хөлдчихөөд өглөөтэй золгож байлаа. Хоньчин отгийн олон айл малынхаа талыг хүйтэнд хиаруулаад, дээшээ тэнгэрт өчихөд хол, доошоо газар эхэд айлтгахад хатуудсан цаг.

Цаг тавирах яагаа ч үгүй. Цагаан сарын өмнөхөн Сэнгэ хааны ордноос нэгэн элч довтолгон ирсэн нь “Хаантан орондоо хорлогджээ” гэсэн хар хэл байвай.

Очирт цэцэн хан яаравчлан Ховог сайрын ордны зүг өвлийн хүйтэн өдрийн бага үдээр чонон дах эгэлдрэглэн мордож, Доржравдан ахайтан уулгалан шогширч, сүйт бүсгүй нь гэгдсэн Ану цочин балмагдацгаав.

Айсуй хувь тавилангийн хүнд дарамтнаас ийнхүү чөлөөлөгдсөн нь цээж дотор цэлмээх авч, зун Алтан угалзын хийдийн дэргэд учраад галд хайлах мэт оргүй алга болсон харь хувцаст эмгэний “Хүсэл татсан эртэйгээ чи хуримлах болно...Тэр хүнтэйгээ чи тэнгэрт адислагдсан юм байна. Та хоёр хэдэн төрөлдөө хослон амьдарсан улс юм...Аз жаргал дэргэд чинь байна, бүсгүй минь” гэсэн үг нь сүйлсэн эрийнх нь гэнэтийн үхлийн тухай мэдээтэй зэрэгцэн санаанд нь бууж, сэтгэлгүй хүнтэй ураглахаас аврагдсандаа баясах авч, арай гэж хаантай

болж нэгэн тугийн дор нэгдэж эхэлсэн Зүүнгар улс ийнхүү эзэнгүй болж, нэгэнт хүчирхэг эзэнт төргүй болоод удсан монгол туургатны сүүлчийн хэлтэрхий Ойрад түмэн ийнхүү өнчрөн хоцорсон нь түүх сударт өгүүлдэг самуун цагийг авчрах вий гэдэгт Ану сэтгэл түгшин байлаа.

эртний заншлаар их хүүдээ хунтайжийн суудлаа залгамжлуулалгүй дөрөвдүгээр хатан Юм-Агасаас төрсөн зургаа дахь хүүдээ өгсөнд өс санасаар явсан Цэцэн тайж , Зодов баатар хэмээх зулай гишгэсэн ахан дүүс нь Сэнгэ хааныг хорлон алсан нь тодров.

Хэд хоногийн дараа эцэг нь Ховог сайраас ирэхдээ, өвлийн ид хүйтнээр хүүгээ алдан уй гашууд унасан Юм-Агас хатан Цастын орны зүг Галдан хувилгаан хүүдээ буухиа элч довтолгон яаравчлан ирүүлэхээр дуудуулсан, хоёр хүүтэйгээ хамсан Сэнгэ хааныг хорлосон буруд хатан Дарабалжийг хамсаатнуудынх нь хамт баривчлан хороосон тухай хэл чимээтэй эгэн ирэв. Энэ айлын хожмын хүргэн, Зүүнгарын хаан Сэнгийн цаг бусын үхлийн уйд дарагдсан цагаан сар ч хөл хөөр багатайхан болж өнгөрөв.

Очирт цэцэн ханы хувьд Сэнгэ хааны хорлогдсон нь дэндүү гэнэтийн явдал байлаа. Галданг бодвол сэтгэл зөөлөн, ахмадын үгийг сонсомтгой, удахгүй хүргэн нь болохоор завдаж байсан Сэнгэ таалал болсон нь дөнгөж нэгэн тугийн дор нэгдэж эхэлж асан Зүүнгарын төрд нүүрлэсэн гамшиг байлаа. Сэнгэтэй ор булаалддаг асан Цэцэн,Зодов хоёр цаазлагдлаа. Өдгөө Цоросын Баатар хунтайжийн хөвүүдээс орыг нь залгамжлах хүн сахил санваартай Галдан хувилгаанаас өөр хэн ч алга. Сэвдэнжал, Зоригт хошууч нарын хоншоор дутна. Онцон, Бум, Доржжав, Пунцагдаш энэ хэдэд ч эцгээ залгамжлах хэрийн сортоо үгүй. Шуудайд хийсэн үхрийн эвэр мэт дош дошин дээрээ хошгиролдсон Ойрадын ихэс тэднийг тоох ч үгүй. Чингээд Юм-Агас хатны бодсончлон Галдан хувилгаан шар шувтлан эцгийн ор суухаас өөр гарц үгүй мэт.Гэтэл Галдан хувилгаан сахил санваар, номт хувцаст баригдаад өдий зэрэгтэй амгалан дөлгөөн байгаагаас бус халуун цочмог, омголон дураар зангаар ахаасаа хол илүү хүн.

“Миний арван нэгэн хөвүүний дотор Галдан шиг цөс их, омголон догшин, сумны гичир мэт чигээрээ нь нэг ч үгүй. Тархи ч сэргэлэн. Энэ хөвүүнээ Бурханы шавь болгон тэр их омголон аашийг нь даръя. Ухаан сэргэг тул эрхбиш Зая багшийн зэрэгт дөхөх номтой ламтан болох биз гэж давхар горьдоно” хэмээн Баатар хунтайж анд нь Галданг цастын орны Дашлхүмбэ хийдэд шавилуулан суулгахын өмнө аминчлан хуучилж байж билээ. Нэгэн үе дөрвөн Ойрадын шашны тэргүүн их багш Зая гэгээнтний хэмжээнд сүсэгтэн олноор хүрээлүүлэн, түүнд өөрт нь болон Зүүнгарын бүхий л ихэс дээдэст адис хүртээж явсан залуу ламтан шар шувтлан хар болоод бүрлээч ахынхаа оронд суурь залгах юм бол Сэнгэ шиг номхон байхгүй нь лав. Залуу, омголон түүний бодлогогүй үйлдэл Зүүнгарыг Манжийн хоол болгох вий гэхчлэн түмэн бодолд дарагдан байлуга. Гэтэл бас Сэнгийн сүй тавьсан сэвгэр, голоос хайртай Ану охин нь шууд Галдангийн хатан болох нь. Тэрбээр Сахил санваартай байхдаа л охинд нь өлөн харц унагаж явсан хүн. Ану ч Галданд туйлаас талтай нь илт.

Хаврын дунд сар гарав. Или голын хөндий зузаан цасанд дараастай хэвээр ч эрхбиш ирж буй урин цаг ханх тавин, хүйтний эрч суларч, хахир хатуу өвлийг даван мэнд үлдсэн мал сүрэг захаараа ханзарч буй цасан дороос борог өвс ухан тааваараа бэлчинэ.

Ховог сайрын ордноос ирсэн сургаар бол Галдан хувилгаантан эхийнхээ дуудлагаар шар



шувтгаад Лхасаас гал голомтын зүг яаравчлан айсуу гэнэ. Далай ламтан түүнд шар шувтлан Зүүнгарыг захирах соёрхол олгож, Банчин богд удган эмийн гавлын ясаар үйлдсэн нандин шүтээн хайрлажээ.

Удалгүй Юм-Агас хатан тэднийх рүү элч зарж, тэнгэрт хальсан Сэнгэ хааны Ану гүнжтэй тавьсан сүй хэвээр буйг нотлоод, нэгэнт хадаг тавьж, “мах идүүлгэ”-ний найр цэнгэл үйлдсэн охиныг бэр буулган авч, Галдан хүүгээ ахын суудалд заларсан хойно хуримын ёслолыг зуны эхэн сард үйлдэх бодолтой буйгаа хэлүүлжээ.

-Энэ охин нэгэнт цоросын бэр болох тавилантай байж. Үнэн хэрэгтээ ёсолсон сүйт эрийнхээ дүү Галдан ламтанд сэтгэлтэй хүн шүү дээ. Заяа тавилан нь мэдэж дээ хэмээн хан Доржравдан хатандаа хэлэв.

-Тэгж л таарах нь дээ. Эзэн минь.Өнөөх билэггүй зүүд л бодогдоод байх боллоо хэмээн нас ахиж нулимс сул болоод байгаа ахайтан хэлээд нулимсаа арчина.

-Зүүд зөн ч яамай. Буянаараа л болог. Нэгэнт охин минь тэр хүнд сэтгэлтэй нь илт. Гэтэл харин ч заяа тавилан нь тэтгэж, Галдан хувилгаан сахил санваараа орхин хаан суудалд сууж, охиныг минь их хатан болгон буулгах нь байна шүү дээ. Эцгийн хувьд сэтгэлгүй хүнд нь богтлон, дөрөвдүгээр хатан болгож мордуулна гэхээс элэг зүрх эмтэрч л байлаа шүү дээ хэмээн бодлогшон хэлээд Уламнэмэх шивэгчнээр охиноо дуудууллаа.

Юм-Агас хатны элч ирсэн. Бодвол ургийн явдал хэлэлцэж буй хэмээн гадарлаад өргөөндөө сэтгэл тогтохгүй догдлон суусан Ану охин эхийнхээ шивэгчнийг хэл дуулгаар ирэхэд зүрх нь палхийгээд явчихсанд, эргүүлж суусан судраа тавиад ухасхийн бослоо.

Сүйт эрийнхээ гэнэтийн үхлээс хойш сэтгэл санаа нь дэнслэн, байж сууж чадахаа болиод байгаа эзэн авхай нь Юм-Агас хатны зараал ирснийг дуулаад бүр ч зүүн дээр суусан мэт босон суун буйг ажиглаж асан Мандарваа тийнхүү давхийн босоход нь цочин аягалж байсан цайгаа халиан асгачихаад “Хөх тэнгэр!” хэмээн уулга алдав.

-Цөг гэм. Яачихаад дав дув хийгээд байна хэмээн Ану зандарснаа:

-Чи өргөөндөө сууж бай. Би ижийн өргөөнд очоод ирье хэмээн тушаагаад гарлаа.

-Жаа,гүнжтээн хэмээн дорой дуугарах шивэгчнийх нь дуу эсгий үүдний цаана хоцорч Ану “Галдан хувилгаан... Үгүй ээ, одоо тэр минь санваартан биш хар болсон. Хэчнээн сайхан хэрэг вэ? Хайртай Галдан минь айсуу яваа. Аяны урт замд намайг л бодож яваа даа.Одоо аав, ижий хоёр бас л бидний ургийн хэргийг хэлэлцэх биз. Хацар халуу шатаад хэчнээн бэрх хэрэг вэ! Тэр нэгэн удган эм Алтан угалзын хүрээний тэндэх голын хөвөөнөө учраад бид хоёрыг тэнгэрт адислагдсан хос гэсэн шүү дээ” хэмээн баяр хөөр, гайхашрал, түгшүүр догдлолд автан эхийнхээ өргөө рүү алхалж явлаа.

Хоргой лавшигийн хормойн сүржигнэх, зүүлт чимгийн хөнгөхөн жингэнэх дуулдан арван долоотой, цог жавхлан төгс охин нь орж ирээд эцэг,эхдээ мэхийн хүндэтгэл үзүүлэхэд Очирт цэцэн сая л бодлын далайгаас бууж ирэх шиг болов.

-Суу даа, үр минь.

-Жаа, аав аа.

-Юм-Агас ахайтны довтолгосон элч ирээд буцлаа гээд эцэг нь буурал хөмсөг өргөн охин өөдөө бодлогошронгуй хараад аягатай цайгаа балган тавин байснаа:

-Сэнгэ хаан үгүй болсон ч чамайг бэр болгон буулгах санааг үл орхино. Нэгэнт сүй тавьж, ёслол цоросын бэр болгохоор гуйсан тул чамайг зуны эхэн сард Галдан... танд хатан болгон авах хуримын ёслолоо үйлдэх гэнэ. Үр минь чи Галданд хатан болон очих дуртай байна уу? хэмээн шулуухан асуулаа.

“Галданд хатан болгон авах хуримын ёслол үйлдэх гэнэ...” гэсэн үгийг сонсмогц сэтгэл түгшүүрлэн, зүрх нь түг үг цохилж асан охин халуу шатан улайх хацрын улааныг хоёр гараар даран хивсний хээг гөлрөх мэт сууснаа эцгийн үгийг төгсмөгц хоёр гар буулган элгэндээ аваад зориг шулуудан толгой өргөж:

-Анх намайг Сэнгэ агсанд очих дуртай, дургүй эсэхийг хэн ч асуугаагүй билээ. Өдгөө “Асраху” ёсны жамыг даган Галданд хатан болоход тухайлан чингэж асуух юун буй? Нэгэнтээ цорос, хошууд хоёр нь ургийн алтан аргамжаар холбоотой явсаар ирсэн. Юм-Агас хатны айлдсанаар миний бие тэдний бэр болохоос зайлах газар үгүй шүү дээ хэмээн ичих, догдлохоо даран зоримгоор өчөөд ёроолдоо доржпалам шигтгэсэн мөнгөн аягатай цайгаа авлаа.

“Цөс ихтэй, хүний сав хоосон буцаадаггүй, аймшиггүй охин шүү. Харин хүний ёсолсон хатан болсон хойноо энэ эрмэг зангаа дарах л болно доо, үр минь. Гэвчиг миний үр цаанаасаа л хийморилог заяа тэгш хүн юм. Сэтгэлтэй дуртай хүнтэйгээ дэр нийлүүлнэ гэж бүсгүй заяатанд ховорхон тавилан шүү дээ” хэмээн Доржравдан хатан бодоод хантны зүг болгоомжлонгуй харц илгээн үгийг нь хүлээв.

-За тийм дээ. Үрийг минь хөх тэнгэр харж яваг хэмээн эцэг нь хэлээд:

-Алив аав нь духыг нь үнэрлэе гэлээ.

-Ёстой доо. Арьяабал шүтээн минь өршөө гэж ахайтан хэлж, хойморт буй бурхан тахил өөдөө наманчлаад ир хэмээн хатан хошуу дэвслээ.

Дур сэтгэлтэй хүндээ очих болж, нүд нь аз жаргалаар гэрэлтэн буй арван долоотой гоо охиноо хараад үрээ насанд хүрч, хүний хүн болон одох болсныг сая л ухаарсан эцэг эх хоёрын сэтгэлд харамлах, хайрлах сэтгэл үерлэн байлуга. Энэ өдрөөс эхлэн Ану Балсантай хамт мэргэн харвах сургууль хийхээ орхиж, нүүр царайгаа ариглан ном шагайж гэртээ суух нь их болжээ. Балсан харвахдаа үнэхээр мэргэн болж, идэрмэг, гавшгай залуусыг цуглуулан өдөржин хөдөлгөөнтэй, хөдөлгөөнгүй бай харван сургуулилж, Ануд тэмүүлсэн сэтгэлээ аргацаадаг болсоор удаж байв. Харин Очирт цэцэн тэрхүү харвах, намнахад мэргэн, идэр сайхан эрсийг зуут болгон эмхэлж, охиноо хадамд мордоход дагуулан явуулахаар шийдсэн байлаа.

Ховог сайр, Сэнгэ агсаны өргөө.

Хаврын сүүл сар.Галдан хаан дөнгөж ургуулж буй сахлаа имрэн бодолд дарагдан сууна. Ард нь тэргүүндээ булган малгай асаан, өтгөн хөмсөг дорхи хурц алаг нүдээр үлдэгсдийг тас ширтэх эцгийн сүрлэг хөрөг залаастай.

Ахынх нь нэгтгэж эхэлж асан Зүүнгар улсын овог аймгууд дахин талаар нэг таржээ. Саяхан цастын орноо Бэрэвэн хийдийн цогчин дуганд залаастай байдаг хорин таван тохой Майдар бурханд залбиран, Зүүнгарын хаант улсын төрийн өлмий бат оршихыг даатгаж зогссон бурханы шавь түүний гарт эцгийн үлдээсэн цорос аймаг, шуурганд уруудсан адуу мэт жолоодлого үгүй хоцорсон дөрвөн Ойрадын төрийн жолоо атгаастай байна гэхэд сүрдмээр ч басхүү, сахил санваарын цаана хоригдон байсан төрөлхийн омголон догшин зан сэрж байх шиг. Цөхүр увшийн хүү Багабанди гурван жилийн өмнө хотгойдын Лувсан тайжийг дараад олсон олз ашгаас хувь үл хүртээв хэмээх шалтаг олж, зүг буруулан одоод Цэцэн тайж, Зодов баатар нартай үгсэн ах Сэнгийг нь хорлоход ханцуй дүрсэн нь илт. Гэтэл тэр Багабанди, башир мэхт авга Цөхүр увшийг зүй нь хатуу цээрлүүлбээс зохилтой авч, өнөөхөндөө Цоросын хамгийн ахмад ихэс авгын дэмжлэг түүнд чухаг буй тул зангидсан нударгаа ханцуй дотроо нуугаад найрсаг харилцахаас аргагүй. Харин Илдэч ноён, дөрвөн Ойрадын чуулганы хан Очирт цэцэн нар нэгэн дуугаар өөрийнх нь талд зогсч буй нь олз билээ. Чингээд зогсохгүй, Ануг хатан буулгаж буйн ачаар цоросоос үл дутах хүчирхэг аймаг хошууд бас түүний гарт гэсэн үг билээ. Гэвч Очирт цэцэн ханы тухай бодлыг дагалдан зүрхийг булаасан үзэсгэлэнт сэвгэр Ану нь ухаан тархийг нь эзэмдэн авлаа.

Ахдаа алдах нь ойлгомжтой байсан тэр бүсгүй өдгөө түүний их хатан болно. Алтан хатгамалт үнэт торгон лавшигний энгэр цээж түлхэн товойж асан хоёр алтан бумба мэт хөх, хээрийн салхинаас бусдыг нуруундаа хүргээгүй онгон танхил бие нь түүнийх, гагцхүү түүнийх байх болно гэхэд итгэмээргүй агаад гэнэтийн энэ аз жаргалын тухай бодоход эрхгүй л толгой эргэмээр.

Галдан хаан сахил санваараа орхин Ховог сайрын өргөөнөө ирсэн цагаас эхлэн багаасаа хатуу чанга дэг сахин хорвоогийн элдэв нүглийг цээрлэж явснаа нөхөх мэт эмс охидоор шаргуу хөөцөлдөн цэнгэх болсон ч сэтгэлт сэвгэр Ануг огтхон ч умартаж үл чадна.

Тэрээр эргэн ирснийхээ дараахан ахын өргөөний олон татвар эмсээс Жасмин нэрт хиргис хүүхнийг гойд таалан өвөртөлж эр хүний ид шидийг анхлан биеэр амталж билээ.

Гэтэл энэ агшинд залуу гоцго Хөхөлдэй хаалгаар чимээгүйхэн орж ирэн:

-Таны эх Юм-Агас ахайтан морилон айсуй хаантаан гэлээ.

“Тийм ээ.Хаантан хэмээн дуудуулж, сэвгэрүүдийн сайхныг өвөртлөн, төрийн хэргийг залах гэдэг хэдий нуруун дээр буух ачаа хүнд ч гэсэн эр хүний ааг омгийг шалгасан сайхан хэрэг ажгу” хэмээн бодоод:

-Залж оруулагтун! гэлээ.

Эр нөхрөө тэнгэр болмогц уй гашууд дарагдан нэг хэсэг туйлын хурдан өтөлж явснаа овоо тогтож байсан эх нь их хүүгээ цэл залуугаар нь алдан хувь тавилангийн дараагийн хүнд цохилт аваад хэдхэн сарын дотор бүр өтөл эмгэн мэт болсон билээ.

Юм-Агас хатан Асралт хэмээх шадар шивэгчнээрээ сугадуулан орж ирэхэд Галдан сэнтий дээрээ тухлан сууж түвдсэнгүй босч очин эхийн тохой дороос нь дэмнэлээ.

Эх нь хүүгийнхээ магнайг энхрийлэн үнэрлээд Сэнгэ хүүгээ бодож аяга дүүрч ирсэн нулимсаа унагалгүй цааш нь эгшээхийг Галдан ажиглан хараад гүн шүүрс алдан эхийгээ түшлэгтэй сэнтийд нь суулгав.

-Ижий минь Та амгалан морилж явна уу?

-Амны билэг бодвоос амгалан л гэж өчье дөө. Бурхан болж хөх тэнгэртээ заларсан сэнгэ хүүгийнхээ зам мөрийг нулимсан далайгаар боогоод юүхэв хэмээн сэтгэлээ тэвчих юм гээд шүлсээ залгин хоолойгоо засахад Галдан, хонх дуугарган шивэгчин дуудаж эхдээ цай аягалуулав.

-Насанжид өнөөдөр үсээ авахуулж сахил хүртэх гэнэ. Дунгаржал ч бас их хатныг дагаад сахил хүртэж чавгац болох юм байх. Хүү минь, эртнээс уламжлан ирсэн асраху ёсыг баримтлан ахынхаа бэлбэсэн үлдсэн бага хоёр хатныг чи авах ёстой шүү дээ. Их хоёр хатан нь ч яахав, чамаас насаар нилээд ахмад, тэгээд ч сахил хүртэцгээж байгаа юм чинь гэж эх нь хэлэв.

-Ижий минь, "асраху" ёсыг дагах нь эртний заншил ч гэлээ би чинь саяхан л сахил санваартай явсан хүн. Өчигдөрхөн ахынхаа өвөрт байсан тэр хоёр хатныг өнөөдөр би тэврээд хэвтэж үл чадна. Тэд чинь нас залуу улс. Үлдсэн өв хөрөнгөнөөс нь эцээхэн таслаад өгье. Хожмын амьдралаа өөрсдөө мэдэг. Насанжид хатны тухайд бол Цэвээнравдангийн хатгаас биз ээ. Шоо орхиж үзэхэд ч төрийн хэрэг залгуулахад надад хамгийн их цөвтэй хүн туулай жилтэй ойрын төрөл хэмээн бууж буй нь Цэвээнравдангаас ондоо хэн байхав.

- сэнгийн ахмад хүүгийн хувьд Цэвээнравданд эцгийн ор залгамжлах санаа байхыг үгүйсгэхгүй. Гэвчиг одоогоор дөнгөж эцгээ хөдөөлүүлээд удаагүй, өөрөө нас дэндүү нялхаараа хорь ч хүрээгүй байж төрийн хэрэгт санаархаад дэмий гэдгийг авга ахын хувьд чи сайтар ойлгуулж, ухуулах нь зүй хэмээн хүү, ач хүү хоёрын дунд эвийн гүүр босгохыг эрмэлзэнэ. Тэгснээ яриаг Галданд ашигтай, сонирхлыг нь татах сэдэв рүү залж:

-Хүү минь, өчигдөр чи тарианы газраараа явсан. Энэ жилийн газрын гарц дориун байх бололтой. Харин ойрын үед Данжилагийн хамт хадмын өргөөгөөр очвол ямар? Хурим тань болоход хэдхэн өдөр үлдэж гэлээ.

Тийнхүү Галдан хаан сэтгэлт бүсгүйтэйгээ учрахаар хуримаасаа арваад хоногийн өмнө Очирт цэцэн ханы өргөөнд морилов.

Или голын Дээд эргийн зуслан дахь Очирт цэцэн хантны өргөө. Хэдхэн хоногийн дараа эр нөхөр нь болох гэж буй зүрх сэтгэлийн эрхэм шүтээн болсон эрдээ үзэмж сайхан харагдах гэж Ану урьд хожид байгаагүйгээр хөл болон гоёж гооджээ.

Хаврын нэгэн налгар өдөр. Гүн хөх тэнгэрт хурган цагаан үүлс хөвж, өчигдрийн нүд чихгүй шороон шуурга ул мөргүй арилаад, энд тэндгүй хурга ишигний цангинасан дуу хадан, алсад хонин зэрэглээ цэнхэртэнэ.

-Галдан хаантан айсуй гэх толгойн харуулын дуугаар өргөөнийхөн ч бужигналдав. Урьдын адил дөрвөн Ойрадын шашны тэргүүн байхаа больсон энэ хүнээс ариун мутрын адис хүртэх аргагүй болсонд зарц барлагууд харамсах авч, басхүү номт хувцсаа халж, хаан хүний дүр төрхөнд хэр зохиж буйг нь үзэх сэн гэсэн сониуч зан нь цухалзана.

Ану урьд хайртай түүнийгээ морилон ирэх хэдхэн завшаанаар дувтан хөх цэнхэр лавшиг өмсдөг байснаа санан луун хээтэй, гал улаан дээл хийлгэж, нүд булаасан шижир алтан бадамлянхуа цэцгэн суурьтай мөрөө хүрсэн урт гурван эгнээ хөх ногоон оюу унжуурган ээмэг зүүж, ээмэгнийхээ ижил өнгийн тасмаар гоёж, алтан утсаар битүү хатгамалдсан гоёмсог тоорцог тэргүүндээ асаасан нь цоморлигоо дэлгэсэн үзэсгэлэнт улаан сараана цэцэг мэт үзэмж төгөлдөр харагдаж байлаа.

-Та үнэхээр гоё харагдаж байна. Галдан хаантан таныг хараад яах бол доо? хэмээн Мандарваа бүсийг нь бүсэлж өгөхдөө шагшихад Ану босоо толиноосоо нүд үл салган өөрийгөө шинжингээ:

-Хош! Битгий наадам хийгээд бай хэмээн зандрах аядавч эхийнхээ өгсөн уруулын шунхаар хөөрхөн жижигхэн уруулаа өнгөлөн, цээжинд үл багтах зол жаргалдаа баясан инээмсэглэхэд Доржравдан хатныг дууриасан орсгойдуу лавай цагаан шүд нь ярсхийнэ. Сэнгэ хаан таалал болсны хойно Галданийн хатан болох нь илт болж байж л Ану түүнд сэтгэлтэй гэдгээ хүлээсэн билээ.

Тэр хоёр гоодож гүйцээд хантны ёслолын өргөөний зүг хамтдаа гарлаа.

Хотны ноход шуугилдан эрхэм гийчид өргөөний гортиг даван орж ирлээ. Үлгэр домогт гардаг шиг их дэл сүүлтэй, багдад зүгийн угсаатай, ганган хөө хар хүлэг унаж, тэргүүндээ дуулга асаан, нум саадаг үүрч, эцгийнхээ алтан сэлмийг агсч, хормойдоо луу ороосон цасан цагаан лавшиг өмссөн цог жавхлан төгс Галдан хааныг үзээд өргөөнийхөн сүрдэн балмагдаж, гайхан шагширцгаав.

-Галдан хувилгаантан хэчнээн ганган эр болоо вэ?

-Бүрлээч Баатар хунтайж босоод ирээ юу хэмээн дүүрээ дэлбэртэл сочлоо байна.

-Дэргэд нь яваа сайхан эр хэн бэ?

-Онцон тайжийн хүү Данжила баатар бус уу? гэлцэн хантны шадар баатар эрс, барлагууд хоолондоо шивнэлдэхэд Очирт цэцэн хан ч тэнгэрт хальсан андтай нь усны дусал мэт адилхан, ирээдүйн хүргэнээ тосон мэнд мэдэхээр урагш алхав.

-Очирт цэцэн хан ах та амар амгалан морилж байна уу?

-Амгалаан.

-Галдан хаан та сайн явж байна уу?Хаваржаа тавтай юу?

-Тавтай гэхчлэн ерөөл билгийн үг хэлэлцэх зуур эцэг, эх хоёрынхоо дунд ичингүйрэн зогсох Ану руу Галдан хаан соронздох мэт цоргин ширтэхэд сэтгэлт хоёрын харц тулгаран, хос зүрх нь баяр хөөрөөр догдлон цохилоход, эх рүү нь нүд шилжүүлэн:

-Доржравдан ахайтан Та сайхан хаваржиж байна уу? хэмээн мэндчилээд:

-Ану гүнжтэн...хаваржаа тавлаг уу? гэлээ.

Гал улаан торгон лавшиг дээр хөх ногоон оюу зүүсэн үзэсгэлэнт сүйт бүсгүйгээсээ тэр үнэхээр нүд салгаж чадахгүй байлаа.

Ижийнхээ цаагуурхан зогсч байсан Ану түүнийхээ цээл баргил хоолойг сонсоод зүрх нь булгилан, нүүр өөд нь халуун цус мэлсхийх шиг болсон ч биеэ барьж чадаад харцаа дээшлүүлэн нүд рүү нь эгцлэн ширтэж байгаад мэндээ мэдэж чадлаа.

Ёслолын өргөөнд хүндэтгэлийн зоог хүртэх зуур Галдан хаан хэдхэн хоногийн хойно хадам нь болох хүнтэй дөрвөн Ойрадын өнөөгийн цаг төрийн байдал, цаашлаад Халхын тухай хэлэлцэж, зургаан сүүдэртэйдээ Манж Дайчин улсын хаан суусан нэртэй ч Ообой ноёнд төрийн эрхээ алдаад байсан Энх-Амгалан хаан өнгөрсөн жил авга ах Сонготугийн хамт Ообойг түлхэн унагасан ч мөн л хаан сэнтийд суусан нэртэй эрх мэдлийг гартаа оруулж чадахгүй буй энэ сүйхээнд Зүүнгарын хаант улсыг зарлан тунхаглаж болох тухай ярилцаж амжив. Зоогийн дараа Галдан хаан хөө хар мориндоо мордон Ануг хамтдаа Илийн хөвөөгөөр зугаалахаар урив. Охины тэртээ арван дөрөвгэйдээ хүсэн мөрөөдөж байсан нь ийнхүү биеллээ олох өдөр ирлээ гэж үү?

Өргөөнөөсөө зүрх сэтгэл догдлон гарч ирсэн Ануд хөтөч Мандах ороо цоохорыг барьж авчрав.Яргуй дэлгэрсэн ногоохон хөндийд сэтгэлт хүнтэйгээ салхи татуулан дөрөө харшуулж явах өдөр ийнхүү ирэх л байж дээ. Өргөөний тигээс дөнгөж гарав уу, үгүй юу Галдан бүсгүйн жижигхэн цагаахан гараас барьж нүд рүү нь эгцлэн ширтээд:

-Чи минь улам ч хөөрхөн сэвгэр болжээ хэмээхүйд Ану:

-Танд хар хүний энэ хувцас санваартны номт дээлээс илүү зохиж байна гээд хөөрхөн инээмсэглэнэ.

-Чамайгаа авч суух заяа надад байжээ гэнгүүт Галдан өврөөсөө өнөө Хөх нуурт байхдаа Анугийн хатгамалдаж өгсөн цэнхэр пансан алчуурыг гаргалаа.

-Таны хайрласан алтан дарь эхийг би үргэлж зүүж явдаг гээд Ану бурханаа гаргаж харуулав.

-Үнэрийг чинь сарничихна гээд би энэ алчуурыг агар зандан хайрцагт хадгалдаг юм. Одоо ч эзэн нь өөрөө миний өвөрт орлоо доо гээд Галдан морин дээрээсээ тонгойн бүсгүйн бэлхүүсээр тэвэрч цээжийг нь өөрийн зүг эргүүлээд цомбогор уруул дээр нь озон үнслээ. Анх

удаа эр хүнд уруул үнсүүлж буй Ану бүхий л судсаар цус дүүрэх шиг, толгой эргэн хацар халуу оргих шиг болсон ч цааш цахлан эсэргүүцсэнгүй халуун амраглалын амтанд мансууран байлаа.

Галдан хайртай бүсгүйнхээ уруул дээр ганц үнсэхдээ Ховог сайрын өргөөний татвар эмтэй шөнөжин цэнгээд ч амсч үзээгүй таашаалын дээдийг амтлан буйгаа мэдрэв. Сэтгэл зүрхний хайр гэдэг биеийн тачаалаас дээгүүрт байдаг байх нь.

-Санваараа орхисны хойно эгэл хүмүүний амьдрал ямар санагдах юм? хэмээн Ану асуулаа.

-Санваартан хүн хүсэл шуналаас ангид тул сэтгэлийн амгаланг эдэлж чаддаг. Алив мөнх бусын эд хөрөнгө, эрх мэдэлд үл шунаж, үр хүүхэд, гэргий гэж сэтгэл чилүүрдэх юухан ч үгүй. Харин хар толгойт эгэл хүмүүний амьдрал хүсэл шуналаас болж сэтгэлийн амгалангаа алддаг. Гэвчиг надад хар боллоо гээд харамсан гашуудах юу ч алга. Чамайгаа хатан болгож авна гэхээр эхэндээ итгэмээргүй санагдаж байж билээ хэмээн Галдан ярин сайхан хар морины усан жороо алхаанд хайртай бүсгүйнхээ хамт сэтгэлийн цэнгэл эдлэн явлаа.

Тэдний хойноос тус тусын хэвтүүл харуул нийлсэн хориод цэрэг эрс барааны газар дагалдан дөрөө харшуулж яваагийн дотор Балсан, Данжила тэргүүтэн баатрууд байлаа.

Тэр хоёр явсаар хүрхрэн урсах ширүүн урсгалт уулын бяцхан голын эрэг дээр ирж мориноос бууцгаав. Голын харгиаг чагнан, усны урсгалыг ширтэн толгой нийлэн суух гэдэг сэтгэлтэй хосуудад дэндүү жаргалтай мөчүүд байлаа. Урсгал усны мяралзахыг ширтэн, зүрх зүрхнийхээ эгшиглэнг анирдах мэт, юуг ч үл ярилцан хоёр биеийн илч, бие биедээ тэмүүлэх жолоогүй хайрын сэтгэл, урьд ханилан суухын тавилангүй байх үеийнхтэй адилхан үггүйгээр ярилцан, халуун гараа атгалцан суухын сайхныг үгээр өгүүлшгүй аж.

Ийнхүү хэчнээн удаан суусныг бүү мэд, нэг л мэдэхэд наран авхай баруун уулын толгойд ташсаныг хос хоёр сая л анзаарч өргөөний зүг яаран хөдөлцгөөв.

Дөрөө харшуулан хатирсаар өргөөний тигийн дэргэд ирээд Галдан хайртай сэвгэрийнхээ ягаахан хацрыг үнсээд “Хуримын өдрийг хүртэл өргөө гэрээ базаагаад санан санан хүлээ дээ, чамайгаа” гэхэд Ану цээжинд нь толгойгоо нааж, “Есөн хоног бүхэл бүтэн жил шиг урт санагдах юм.” хэмээн эрхэлнэ.

Галдан хааныг морилсноос хойш Очирт цэцэн ханы өргөөнийхөн хуримын бэлтгэлийг яаравчлан хийж, гүнжийн сүйд хошууд уламжлалаар “бэрийн бараа” хэмээн гэрийн доторхи тавилга, “бэрийн эд” хэмээн олон арван цэгдэг, ууж, гутал хувцас төхөөрөн хөл болж, хантан амин хайртай охиноо хүний хүн болоод одно гэдэгтэй эвлэрч үл чадан бие нь чилээрхсэн тул маарамба залж тан хүртэх болов.

Харин Ану, Галданг лам байхад түүний хатан болохыг тэсгэлгүй хүсдэг байснаа цаг нь тулаад ирэхээр төрж өссөн эцгийн халуун голомтыг орхино гэдэгтэй эвлэрэхэд бэрх болж, бие чилүүр буй аавыгаа өрөвдөн сэтгэл хоргодож эхэлж билээ.

Нэг л мэдэхэд зуны эхэн сарын шинийн тавны билэгт сайн өдөр болж, Ховог сайрын ордноос

бэр буулган хурим дэглэхээр айсуу их хөсгийн бараа харагдах нь тэр.

“Галдан хаан Очирт цэцэн ханы Ану гүнжид тухайлан зориулж цагаан булган гэр бариулж гэнээ.”, “ Очирт цэцэн ханы гүнж Ану хадамд гарахдаа инжиндээ мэргэн харваачдын зуут дагуулж очих юм байх” гэхчлэн айсуу хуримын дуулиан дөрвөн Ойрад даяар салхи мэт хурдан тарж байлаа.

Галданг ирээд явсны дараа цорос ёсоор хүргэн хүүгийн ээж “Эд хүргэх”-ээр өргөөнд хүрэлцэн ирэв. Их хүүгээ алдсанаас хойш турж эцэн, уй гашууд унасан Юм-Агас ахайтан Галдан хүүгийнхээ утааг нь үзнэ хэмээн нилээд сэргэчихсэн, Галдангийн авга талын төрөл Бодьхүү тайжийн хамт үйлчин бүсгүйчүүл, бараа бологч хориодыг дагуулан иржээ. Арваад мөнгөн цар дүүрэн овоолсон чихэртэй шүүрмэг, түүхий сүүний бяслаг, амтат еэвэн, үзэм, чавга, самнаа боов бүхий тавгийн идээ, зуун сав хар архи, зуун хөхүүр намрын хадгалсан сэнгэнэсэн сайхан чигээ, бэрийн дээл хувцсанд гэж зуун толгой хоргой, торго, ховор чамин хар, цагаан үнэг, минж, булганы арьсыг авчирсан байв.

Бэрийн талаас шинэ өргөөнд зориулан Хамигаас авчирсан цагаан хаш чимэглэлтэй ор, буйдан, үхэг авдар, мэлхий ширээ, толь тэргүүтэн тавьц, хогшил эсгийд боодолтой, тэмээнд ачихад бэлэн хүлээж байлаа. Эртний цоросын ёсоор хуримын өмнөх сүүлчийн ёслол нь “Эд хүргэх” энэхүү заншил агаад энэ өдөр худ ургийнхан билэгтэй сайхан үг хэлэлцэн, хүргэний талаас авчирсан эдээр бэрд зориулан шинэ лавшиг эсгэж, бэрийг өнөд ганган цэмцгэр, өмсөх зүүхээр дутахгүй элбэг дэлбэг явахын ерөөл талбиж, дээл оёх торгоо идээ цагаа, сүү тосоор мялаадаг ажгу.

Бэрд зориулсан лавшигийн хэмжээ авахаар Ануг дуудахад юм-Агас хатныг багадаа “Юмаа” эгч хэмээн дотносдог байснаа өнөөдөр хадам ижий нь болох хүн гэж бодохоос сүрдэн эмээж, ичингүйрэн үг цөөтэй байх атал, хоёр цоглог нүд нь аз жаргалаар гийж буй охиныг үзээд хатан ч өөрийнхөө залуу насыг үзэх шиг л болж билээ.

“Арван тавгайд минь ёсолж авах эр чинь энэ хэмээн гучаад насны сайхан эр, бүрлээч Баатар хунтайжийг үзүүлэхэд сэтгэл зүрх догдлон яг л энэ Ану шиг аз жаргалаар бялхан явж байсан сан. Сэтгэлтэй хүндээ очихын сайхныг эм хүн бүр эдлэх хувь дутдаг. Хүү минь ч энэ сэвгэрт дур сэтгэлтэй. Ану ч миний Галданд хайртай юм.Хөх мөнгөн тэнгэр минь энэ хоёрыг минь ивээж, харж яваг даа” хэмээн зовлон үзсэн эх бодож суулаа.

Юм-Агас ахайтны дагуулан ирсэн гурван үйлчин бүсгүй түмэн өлзий хээг алт, мөнгөн утсаар хатгамалдсан үүлэн цэнхэр торгоор шинэ бэрд зориулсан лавшигийг эсгэж, хэд хөшөөд худын талд өгч “Дутуу учгийг татаж, товч шилбийг нь хадаад гүйцээгээрэй” хэмээгээд мордоцгоов. Ийнхүү авч буй бэрийн гоёл дээлийн өнгө аваачин эсгээд, орхиж явах нь цорос, хошуудынхны хуримын сүүлчийн ёс дэгийн нэг бөлгөө.

Энэ нь бэрийн талд гүйцээх сүүлчийн ёслол байдаг агаад хүргэний талд “Гэр бүрэлгэ” хэмээх нэгэн ёсыг дэглэж байж сая хурим болдог ёстой ажгу. Энэ ёслолд бэрийн талаас мөн л ижий нь нэгэн дагуулын хамт очдог номтой тул нөгөөдөр нь Доржравдан ахайтан эр нөхрийнхөө үеэл дүү Чойнзон тайжийн хамт Ховог сайрын өргөөнөө “Гэр бүрэлгийн” ёслолд одлоо.



Мухлаг тэргээр хугас өдрийн газар явах зуур Доржравдан ахайтан гучин зургаан жилийн тоосон дундах дурсамжаа сөхөн, эцгийн гэрээс Алшаад мордсоноо санан дурсав. Холын хол элсэн далай Алшаа нутагт охиноо мордуулахдаа эцэг нь нүдэндээ гунигтай, харваас эр хүний харамч нулимсаа хүчлэн барьж байхад, билэг ерөөлийг бодон уйлахгүй тэвчих хэмээн чардаих хөөрхий ижий нь амаа өмөлзүүлэн, цацлаа өргөсөөр хоцорсон сон. Тэгэхэд Доржравдан эр нөхөртөө сэтгэлгүй, анхны хайраа өгсөн Хонхоту хэмээх нүд булаасан сайхан залууг санан санан мэлмэрч явж билээ. Аз түшиж, Арьяабал шүтээн нь ивээсэн юм уу, түүнд сайн хань таарч билээ. Сүйт сэвгэрээ үзээд л сэтгэл алдарсан Очирт хан тэгэхэд Доржравданд төдий хэмжээний хайр халамж тавиагүй сэн бол хөх уст Ижил мөрнөө, зүрхний хайрт хүнээ санагалзсан арван зургаатай жаахан бүсгүй хэчнээн шөнө дэрээ норгон уйлах байсан бол доо? Дурлал хайр тэгсгээд амьдралын эгэл бор өдрүүдийн тоосонд бүдэгрэн холдож, бүсгүй хүний эр нөхөртөө ээнэгшин дассан сэтгэл бас хайр болон дэлбээлж болдог ажгу.

Харин охин нь азтай юм гээч. Галдан бол Анугаас есхөн насаар ахмад, дөнгөж хорин зургаатай, эрдэм ухаан төгс сайхан эр. Хамгаас чухаг нь Ану түүнд сэтгэлтэй. Өөр шиг нь эр нөхрийнхөө өвөрт хэвтээ атал хайртай хүнээ мөрөөдөн шаналах хэрэг Ануд гарахгүй. Дөнгөж охиныг нь хэвлийдээ арвалзаж байхад зүүдэнд нь үзэгдсэн хэрмэл цыган эмийн хэлсэн билэггүй үгс сэрхийтэл орж ирэн сэтгэл чилээх боловч, хайртай хүнтэйгээ хуримлан жаргаж яваад тийнхүү амь үрэгдэх нь харин ч бүсгүй хүнд зол хувь мэт санагдах аж. Харин, өөрийнх нь тухайд гэвэл хэдий анхны хайрт хүндээ очоогүй ч заяа тавиландаа гоморхох өчүүхэн ч шалтаг түүнд үгүй мэт. Ийнхүү бодоод байхад хүн заяа тавилангийн эрхэнд явсаар орчлонг элээх жамтай ажгу...

Ахайтан мухлаг тэрэгний түжигнээнд тийнхүү бодолд дарагдан явсаар үд дундын үед Ховог сайрын газар дахь Галдан хааны ордны тоосгон хэрэмний бараа үзэгдлээ.

Хошууд, цоросынхны заншлаар хуримын өмнөх нэгэн билэгт сайн өдрийг сонгож, хүргэний талынхан шинэ гэрийн мод, бүрээс, дээвэр, цавгийг тааруулан барьдаг агаад энэ ёслолд бэрийн эх ирж оролцдог ёстой.

Доржравданг гучаад морьт баатрууд тосон авч орд өргөөний тоосгон хэрэм өөд дагалдан явлаа.

“Галдан хаан Очирт цэцэн ханы Ану гүнжид зориулан булган гэр төхөөрч буй гэнэ” хэмээн Ойрад даяар шуугисан нь ортой үг байжээ. Галдан сүйт бүсгүйдээ зориулан цасан цагаан булгаар хөшиг цавгийг нь хөвөөлсөн, уран сийлбэртэй найман ханат өргөө бэлтгэсэн байлаа.

Зун эхэн сарын шинийн тавны нарлаг сайхан өдөр. Очирт цэцэн хантны өргөө. Наран ургах цагаар тэртээ баруунтайгаас их хөсгийн түрүүч үзэгдсэн нь бэр буулгахаар ирж буй хүргэний талынхан байлуга. Хуучны Ойрад заншлаар хүргэн хүү хадам эцгийн гадаа буурь гуйж аваад шинэ гэрээ авчран барьж байж, худындаа орж сөн түшин хурим найр эхлүүлдэг билээ. Тиймээс нүүгэлтэн ирж буй хөсгийн тэндээс “Буурийн хүмүүн” гэх хоёр морьтон тасран ирж, Очирт цэцэн ханаас “Шинэ өргөө барих буурь” зааж өгөхийг гуйснаар хөлтэй хурим эхэллээ.

Их хөсгийн тэргүүнд эртний монгол заншлаар нум, саадаг агссан баатар эрийн хуяг дуулгатай, жавхаа төгс Галдан хаан хөө хар морио унан явна.”Буурийн хүмүүн”-д залуу хунтайжийн шадар жанжин Данжила, цавчилдах эрдэмд гаргуунаараа цууд гарсан Махан баатар хоёр тохоогджээ. Ойрад баруун монголчуудын заншлаар хуримын өглөө хүргэн хүү хадмынхаа гадаа шинэ гэрээ авчирч барьж байгаад бэрээ буулгаж авсны дараа шинэ өргөө гэрээ буцаагаад ачаалан буцдаг ажгуу.

Галдан тэргүүтэй хүргэний талынхан хантны ёслолын өргөөний баруунтай буурь заалгаж хоромхон зуур цагаан булган өргөө барьсны хойно, намхан намхан ширээнүүд нь мах шүүс, идээ цагаагаа дааж ядах мэт овоолсон найрын гэрт орж хадам эцэг, эхдээ их баранзад хадаг барин золголоо. Ийнхүү хуримын эхэнд гүйцэтгэдэг “Хүргэ цагаалах” ёс үйлдсэний дараа Галдан дагуулуудын хамт өргөөний баруун талаар сууцгаан, авчирсан тавгийн идээ, урд газрын ваартай хар архины дээжээ Очирт цэцэн хан, Доржравдан ахайтанд барьснаар хөлгүй их найр эхлэв. Найрын эхэнд хүргэн хүүг хонины чанасан өвчүү, шагайт чөмгөөр зочлоод, “Хүргэ хувцаслах” заншлыг даган Доржравдан хатан Галданд алтан бүс бүсэлж өгөв. Хантны найман ханатай ёслолын их өргөөнд икэл хуурын дуу уянгалан “Шарга морин”, ”Алаг Алтаан шил”, ”Хавтаа сайхан хээр” хэмээх хүлэг сайн морьдын тухай дуунуудыг түрлэг өргөн дуулалдаж, бий биелгээ бүжин найр жигдэрч байхад Ану охин өрлөг эхийнхээ гэрт Мандарваагийнхаа хамт шивнэлдэн догдолж суулаа.

Хошуудын эртний заншлаар хуримын өдөр хүргэний талынхныг ирж гэрээ барин найрлаж эхлэхэд нь бэрийг садан төрлийнхнийх нь айлд нуудаг тул Ануг тийнхүү “зугтаалган” өрлөг эхийнд нь суулгасан нь энэ санж.

Оройн нар уулын толгойд ташиж байхад найр өндөрлөж, хүргэний талынхныг гарцгаасан хойно Ануг сая ёслолын өргөөнд авчран олон салаа сэвгэр үсийг нь задалж, хоёр хагалан эхнэр гэзэг болгон самнаад, баруун чихнийх нь шүрэн ээмгийг авч, хоёр чихэнд нь луу ороосон алтан сүйх зүүж өгөөд, мөн л хуучны заншлаар маргааш хүний хүн болж төрхөмөө орхин эгүүрд харьд одохоос нь урьтан зочилж гарав. Ойрад охид, сэвгэрүүд хадамд гарахын өмнө гагц баруун чихэндээ ээмэг зүүдэг агаад хуримынхаа өдөр л хоёр чихэндээ ээмэг зүүдэг ажгу.

Өглөөнөөс хойш сэтгэл дэнсэлсэн Ануд энэ болж буй хөл ихтэй хурим найр өөрөөс нь үл шалтгаалан өрнөөд буй зүүд мэт санагдсаар байвай. Өчигдөр Хөх нуурын тэртээгээс эцэг нэгт ах нар Гартангомбо, Эрдэнэ тайж болон галдмаа ах нь их хатан Жамьянмядаг, гараасаа салгах дургүй хөөрхөн охин Ахай гүнжийн хамт ирцгээсний гадна, аавынх нь дүү Болод тайжийн хөвүүд буюу үеэл ах нар нь гээд ёслолын өргөө дүүрэн ах дүүс нь цуглан найрлаж байхад, бүсгүйн сэтгэл хадамд гарч буй бүх л сэвгэрүүдийн адил битүү айдас, учир нь үл олдох түгшүүр, бүхий л амар амгаланг нь эвдсэн догдлолоор дүүрч тархи толгой нь манаран байлаа. Хөөрхий өтөл настай аав нь сэтгэлээ чандлан барьж буй нь илт, үе үе царай барайлган, хуруувчин жүнзтэй хар архинаас байн байн хөнтрөн Анугийн духыг байсгээд л үнэрлэнэ. Ижий нь залуугийнх шигээ өмсгөл гоёлоо гайхуулан шилбэлзэхийн оронд өөрт нь огтоос үл зохих уймраа байдалтай самгардан суухыг ажиглан, хамгаас хайртай тэднийгээ орхин хүний хүн болж, гурван хаврын цас хайлан хадмын өргөөнд ирсэн мөрийг нь угааж арилгатал эцгийн халуун голомтонд ирэхгүй шүү дээ хэмээн бодохоор хамар ширхирам.

Хадамд мордуулах сэвгэрээ зочлох найр гурван марал гудайж байхад өндөрлөж, Ануг бэргэн эгч Жамьянмядаг нь өргөөнд хүргэн өгч, ижий нь хувцсыг нь тайлан оронд оруулав. Тооноор оройгүй тэнгэр мэлтийн, одот ертөнц зулай дээрээс нь ширтэх мэт.

Төрхөмдөө өнгөрөөх сүүлчийн шөнө шүү дээ гэхээр нойр нь хаа нэг тийш хулжин одоод Ховог сайрын өргөөнд өөрийг нь угтаж буй учир битүүлэг ирээдүйн амьдрал айдас түгшүүр төрүүлэх тул унтаж үл чадан эргэж хөрвөөсөөр байлаа. Хэдий Чилэдүтэй эр эм бололцсон ч Мандарваа эзэн авхайн хамт нойрсдог хэвээр байв. Угаас дэрэн дээр толгой тавингуут “давсанд яваад” өгдөг Мандарваа зүүдэндээ ямархан нэгнийг бувгнан нам унтаж буйг үзэхэд атаархмаар ч юм шиг.

Ану эргэж хөрвөөсөөр үүр тэмдэгрэхийн наахна түр дугхийгээд давхийн сэрэхэд гадаа гэгээ орж, үүр дөнгөж цайж байлаа. Цорос, хошууд аймгийнхны эртний заншлаар шинэ бэрийг нар цухуймагц мордуулдаг тул гадаа ижийнх нь хоолой засах дуулдан, хөлийн чимээ ойртоход Ану өндийтөл шивэгчин нь сэрж, нүд ирмэх зуур хувцаслаж байх хооронд ижий нь Жангараг, Уламнэмэх, бэр Жамьянмядагаа дагуулан орж ирцгээгээд :

- Энэ Мандарваа гэж хэчнээн алгуур үүлгэр амьтан гээч вэ! Бэр мордуулах гэж байхад санаа амар дугжирч хэвтдэг хэмээн өчигдрөөс хойш нэг л уцаар, бухимдуу явсан Доржравдан ахайтан ашгүй уураа гаргах хүн олдлоо гэсэн шиг хангинаж гарав.

-Ижий минь, Ануг хадамд мордуулах өглөө уур унтуу болбол билэггүй юм болох биз хэмээн бэр нь тайвшруулах зуур Ану босч, Мандарваагийн авчирсан мөнгөн гадартай усаар нүүрээ булхаад зүүн орон дээр тавьсан хатан хүний иж бүрэн хувцсыг үзээд бишүүрхэн зогслоо.

-Шалавлацгаа. Худынхан ороод ирнэ шүү хэмээн ахайтан шивэгчингүүдийг шавдуулан, Анугийн гэзгийг хоёр хагалан эхнэр хүний толгойн боолт хийж, өнөөх хадмын талаас өгчилгөсөн алтан мөнгөн хатгамалтай цэнхэр торгоор урласан бүс үгүй эхнэр дээл, энгэртээ алтан саан чимэглэлтэй цагаан цэгдэг өмсгөн, нүүрийг нь оодож, хацарт нь улаан энгэсэг тавиад, тэргүүнд нь хатан хүний өндөр оройт богтаг малгай өмсгөж байтал Очирт цэцэн хан ороод ирэв.

-Миний үр хэчнээн сайхан хатан болоо вэ! хэмээн шагших өвгөн хан урьд шөнө цурамхийгээгүй нь илт, дээд зовхи нь бүлцийсэн байхыг үзээд Ану:

-Аав та нойр муутай хоноо юу даа? Нүд тань сэмбийсэн байна. Охиноо мордсон хойно энэ алчуурыг минь дэрлэн унтаж байгаарай хэмээн Ану хэлээд тэр жил тод үсэгт тайлагдлаа хэмээн өрлөг эхийнхээ өгч байсан цагаан дурдан алчуурыг гарган эцэгтээ өглөө.

-За тэгнээ. Охиныхоо нялхын үнэрийг үнэрлэж явья хэмээн эцэг нь хэлээд духан дээр нь үнэрлэхэд Уламнэмэх, Мандарваа хоёр Ануг сугадан гарлаа. Бэргэн эгч Жамьянмядаг нь ёслолын өргөөний цаадах эд уурсын гэрийн гадаа зогсоод Галдангийн дагуулж ирсэн авга талын бэргэн Жуурай авгайд цагаан эсгий дээр тавьсан цагаан хаш, зандан модоор урласан гоёмсог тавьц, дөрвөн улирлын турш сэлгэн өмсөх хэдэн арван дээл, лавшиг, цэгдэг, давхац, булга, хар үнэгэн хүрэм, олон хайрцаг үнэт эдлэлээс бүрдсэн “бэрийн эд”-ийг хүлээлгэн өгч байтал Галдан бараа бологчдынхоо хамт шинэ өргөөнөөсөө гараад ирэв. Энэ хооронд Ану

ижийнхээ өргөөнд орж эцсийн удаа төрхөмийн цайг амсаад босоход цагаан торгоор толгойг нь бүтээж Гартангомбо, Эрдэнэ тайж хоёрын их хатан Сэндэнжамц, Долгорлхам хэмээх бэргэд хоёр талаас нь сугадан авч гарлаа. Цорос, хошууд аймгийн эртний заншлаар эцгийн гэрийн зүүн өмнө талд ширмэл эсгий ширдэг дэвсэн, бэр хүргэн хоёрыг “Шар наранд мөргүүлэх” ёслол үйлддэг тул Галдан, Ану хоёрыг ширдэг дээр суулган энэ насны амьдралаа эгнэгт холбож буйн тэмдэг хонины шагайт чөмөгний хоёр талаас атгуулж байгаад мандаж буй алтан наранд гурвантаа сөгдүүлэн мөргүүллээ. Ойрадууд хуримын энэ ёслолоо “Шар наранд мөргүүлмү. Шагайт чөмөг атгуулмуй гэлцдэг бөлгөө. Энэ хооронд хүргэн, бэрийн талынхан нийлж байгаад Галдангийн авчирч барьсан цагаан булган өргөөг буулган ачаалж дуусчээ. Ингээд цагаан торгоор толгойг нь бүтээсэн Ануг түүнтэй ивээл жилтэй Галдангийн ах Онцонд дүүрүүлэн хөдлөхөд өвгөн болсон Очирт цэцэн хан хүргэндээ “Эрдэнэ мэт өсгөсөн аминаас илүү хайртай отгон охиноо чамд өгөв. Муу үг хэлж, мод саваагаар жанчуузай. “ хэмээн захиад зүрхний нулимсаа эгшээн зогссоор хоцорч билээ.

Ануг хадамд гарахад нь шадар шивэгчин Мандарваа, Дархижав амь сахигч хэвтүүл Балсан тэргүүтэй зуугаад цэрэг эрсийг дагуулан явуулахаар болсны дотор Мандарваатай ёс гүйцэтгэн эр нөхөр нь болсон Жамьяндорж дарханы хүү Чилэдү бас багтжээ. Мөн бэрийн талын бэргэд ч сэвгэрээ хадмынд нь хүргэж өгөхөөр хамт морджээ. Цоросын хуучны уламжлалаар бэр мордуулагсад эцгийнх нь өргөө гэрийг нар зөв гурвантаа тойроод, Ховог сайрын ордны зүг хөдөллөө. Бэрийн дагуул албатууд, хүргэн, хэвтүүлүүдийн хамт ачаа хөсгөөс түрүүлэн довтолгосоор их үдийн хэрд Ховог сайрын өргөөнд ирлээ.

Алсад хөх тоосгон хэрэм бүхий Галдангийн ордон, сүм дуган эргэн тойрны борчуудын олон гэрүүдийн хамт бараантан үзэгдэхэд хуримын тосуулууд давхилдан айсуу үзэгдэв. Тосуулуудыг Юм-Агас ахайтны шадар хиа Буянтөмөр ахлан ирээд заншил ёсоор том мөнгөн цар дүүрэн овоолсон хурууд, шүүрмэг, мах, боов, өнгө өнгийн давс цацаад эргэн өргөөний зүг зугтахад бэрийн дагуулуудын нэг Балсан мориндоо ташуур өгөн хойноос нь элдэв.

-Манай Буянтөмөр хиа ч сайн эрийн хугархай юм гэсэндээ бэрийн дагуул залуу баатарт авсаар гүйцэгдэхгүй байна шүү!

-Ер өө, ер, хувилгаан хааны сүлд хийморь хаачихав! гэхчлэн бэр буулгахад мордогсод хөөрөлдөн, газраар нэг цацалсан идээн дээгүүр давхилдан өнгөрөхөд Балсан Буянтөмөрийг нэхэхээ больж эргээд инээмсэглэн цогиулж ирлээ. Энэ үйл нь элдэв барцад, шинэ хосуудад нүүрлэж мэдэх хар цагаан хэл амнаас цээрлэх ёс агаад, өнгийн давс нь замаас ирж байж мэдэх барцдыг зайлуулах бөгөөд газарт цацсан идээ нь тэр муу бүхний хамт хоцордог хэмээн цоросууд үздэг ажгу.

Ордныхоо баруунтайх гүвээн дээр ирээд Галдан, авга ахынхаа моринд дүүрүүлсэн Ану руу хандаж “Чи минь замдаа ядрав уу?” хэмээн асуунгаа, цагаан бүтээлгийг сөхөн духыг нь илнэ.

-Үгүй ээ. Хээрийн салхинд давхиж явах нь бүгчим гэрт байснаас дээр байна хэмээн замын тоосонд аяншсан царайтай ч нүд нь аз жаргалаар гэрэлтсэн бүсгүй хэлээд инээмсэглэв. Гэвч хүн гэдэг амьтан мэдэхгүй бүхнээсээ л айдаг болохоор гүвээн дээрээс ярайн харагдаж буй ордон өргөө, чулуун харш, хиймэл нуурууд бүхий энэ хэрэм дотор угтаж буй шинэ амьдралд өөрийг нь юу юу хүлээж буй нь оньсого мэт бүрхэг тул залуу бүсгүйн нүдэнд ирээдүйгээсээ

сүрдсэн айдас түгшүүрийн сүүдэр бас гялсхийх шиг болж байлаа.

Хуримын ачаа хөсөг араас ирэн нийлж, хүргэн, бэр, бараа бологчдын хамт Галдан хааны ордны хөх тоосгон хэрмийг нар зөв гурав тойроод хүнд дааман хаалгаар нь орж явчихад Анугийн сэтгэлд “Би ингээд хүний хүн болж, төрөл төрхөмөөсөө эгүүрд одох нь энэ үү?” гэсэн бодол орж ирэн, өргөөнийхөө гадаа саравчлан хоцорсон насан өтөл эцэг, тэднийг бараа тасран тасартал нь сүүн цацал өргөн зогссон ижийгээ санан самсаа нь шархирч, гашуун нулимс хацар дээгүүр нь бөмбөрөөд явчихлаа.

Тэртээ арван нэгэн жилийн өмнө цастын орны зүг аялж явахад аав нь амандаа исгэрсэн дууныхаа тухай “Гунан зээрд морин

Гучин агтын түрүүнд

Түрүүлсэн ч яахав

Кэтийн заяа мэдэм зэ...” гэсэн үгтэй дуу даа хэмээн тайлбарлаж байсан нь сэтгэл сэрхийтэл санагдаж, “Энд өнгөрүүлэх миний кэтийн заяа ч бас бүрхэг...” гэсэн бодол орж ирэхийн сацуу тэгэхэд Лхаст очсоныхоо орой ижий нь “Олон хоногийн аян замын шороо тоосноосоо сална” хэмээн асар том зэс гадарт бүлээн ус дүүргэн бяцхан Ануг угааж “Үр минь аянаас ирсэн хүн замын тоосоо үргээвэл бие лагшин тэнийж, чилээ гардаг...” хэмээж байсныг бас дурсаж гурван жил төрхөмсөх ёсгүйг санан гуниглаж зогстол

-“Үүд татах” ёс дэглэээ! хэмээх дуу сонсогдож, бэр бүсгүйг бодол дурсамжийн ертөнцөөс эгүүлэн хадмын ордонд авчирчихлаа.

Цорос, хошууд аймгийнхны хуримын нэг чухаг ёслол нь шинэ барих өргөө, гэрийн эсгий үүдийг “Бэрийн эд” буюу бүсгүйн гэрээс өгчилгөсөн инжийн эдлэл, хогшил тавьцыг ачаалсан тэмээдийн дээгүүр хөндлөн тохоод хүргэн, бэрийн талынхан хоёр талаас нь чангаан тэмцэлдэхээ “үүд татах” гэдэг ажгу.

Хүргэний талаас Данжила тэргүүтэн хэдэн баатар эр,бэрийн талаас Балсан, Чилэдү нарын зэрэг залуус найман ханат их өргөөний хүнд том эсгийн үүдийг уухайлан таталцаж байгаад хүргэний талд “алдсан” болж ёслол төгслөө. Чингээд Галдангийн одоо сууж буй хуучин номын өргөө байсныг “Түгээмэл баясах” хэмээн нэрийдсэн хоёр давхар чулуун харшийн зүүн талд Анугийн суух цагаан булган чимэглэлтэй өргөөг барьж эхлэв.

Харин Галдангийн бэргэд Цөхүр увшийн хатан хөгшин ахайтан Пагмадулам,бүрлээч Сэнгийн их хатан Насанжид нарын бэргэд толгойг нь цагаан эдээр бүтээж царайг нуусан Ануг сугадан Галдангийн “Түгээмэл баясах” харшид оруулан нүүрийг нь угаалгаж, хатан хүний иж бүрэн хувцас өмсгөн, “Бэр дархлах” ёслолд яаравчлан бэлтгэж эхлэх үеэр Юм-Агас хатан орж ирэв.

Хамгийн сүүлд “Мах идүүлгэний” найраас хойш уулзаагүй хадам эхээ үзээд толгойдоо дөнгөж шинэ богтаг өмсч байсан Ану хүндэтгэн босч амрыг нь эрэв. “Та амгалан морилж байна уу, ижий?” гэж хэлэхдээ хоолой нь өөрийн эрхгүй сааралтахыг ажсан ч төрсөн эхээсээ өөр хүнийг энэ эрхэм нэрээр анх дуудахын амаргүйг Юм-Агас ахайтан ойлгож буй шинжтэй:

-Суу суу, охин минь. Ижий нь амгалан сайхан байна. “Бэр дархлах” ёслолын үед бүү сандарч сүрдээрэй гэж захих гэсэн юм. Энэ хатан хувцас чамд их сайхан зохиж байна. Эхийгээ дууриасан гоо хатан болох нь миний бэр гээд духан дээр нь үнсээд гарч одов. Багадаа энэ ахайтанд их л дотно байснаа Сэнгийн сүйт сэвгэр болсноос хойш эмээн сүрдэх болчихсон Ану энэ дулаахан дотно үгэнд нь сэтгэл амран, гүнзгий шүүрс алдав.

Энхрий бага насандаа эцгийн голомтонд эрх дураар өсчихөөд ийнхүү нэг л өдөр харьд бэрлэн, танихгүй айлын босго даван орж, элдэв олон ёс заншлын хүлээсэнд баригдана гэдэг бүсгүй хүнд туйлын хүнд даваа байдаг ажээ. Хоёр талын дөрвөн бэргэн Анугийн гэрээсээ өмсч ирсэн хувцсыг тайлан хормойгоор нь мөнгөн саатай, үүлэн хээтэй хөх цэнхэр магнаг торгон лавшиг, гадуур нь хөх одтой цасан цагаан хоргой ууж өмсгөн орой дээрээ тогосын өдтэй, духан дээрээ очир эрдэнийн чимэглэлт хатан хүний өндөр оройт богтаг малгай асааж, алтан суурьтай гурван эгнээ сувдан ээмэг, шанхнаасаа бүсэлхийгээ хүрсэн тав таван эгнээ шанааны унжуурга зүүлгээд толгойг нь дахин цагаан гивлүүрээр бүтээж “Бэр дархлах” ёсон хийлгэхээр сугадан Юм-Агас ахайтны өргөө рүү авч одлоо.

-Очирт цэцэн ханы Ану гүнжийн гоо зүсийг үзье. Гэгээн өдөр нүд гялбамаар, гэрэлгүй шөнө гэгээнд нь товч шилбэ хадмаар гоо төрсөн сэвгэр юм гэнэ лээ.

-Байз, одоо л “Бэр дархлах” гэж байхад...

-Зүсний гоогоос илүү Галдмаа ахаасаа дутахгүй цэргийн эрдэмд гарамгай юм гэх нь билээ.

-Ай, мэдэхгүй эм хүн ирт мэсээр оролдоод ч...

-Энэ Ану гүнж тань бүрлээч Сэнгэ хаантай сүй тавилцаад байхдаа Галдан хувилгаантанд сэтгэлтэй байсан юм гэж үнэн үү?

-Хош..Галдан хаантан гээч.Амаа мэдэж ярь гэхчлэн Галдан хааны ордны олон түшмэл барлагууд, хуриманд ирсэн ихэс ноёдын хатад сэвгэрүүд ам уралдан хов ярилцана. Хаа газар ихэс дээдсийн төдийгүй эгэл ардын хурим найранд цугласан олон шинэ бэрийн зүсийг сонжин хэлэлцдэг нь жам юм хойно доо. Юм-Агас ахайтны өргөө хэрмийн баруун хойно,”Түгээмэл баясах” харшаас таван зуугаад тохой хол оршдог тул Галдан хантны шинэ хатандаа зориуд төхөөрүүлсэн цэнхэр магнаг бүрээстэй зөөлөн нумтай мухлаг тэргэнд Ануг дөрвөн бэргэний хамт суулган одов.

Зуны эхэн сарын сайхан өдөр байлаа. Бэрийн нүүрийг олны нүднээс халхлан бүтээсэн цагаан алчуурын цаанаас хэрэм доторхи байдал төдийлөн үзэгдэхгүй тул мэлмий сохор хүн мэт бэргэдийг сугадан нааш цааш ийнхүү зөөлгөх нь атар тал нутагтаа хүлгийн хурднаар давхиж, эрчүүдтэй дөрөө харшуулан тэнгэрт нисч яваа шувуу, газарт цахилан давхих гөрөөсийг нам харван, ид хаваа гайхуулж явсан эрмэг цовоо Анугийн хувьд түмэн бэрхтэй ч ёс ёмбогор, төр төмбөгөр тул яалтай билээ.

“Хуримын энэ олон тээртэй ёслол үтэр түргэн дуусаасай билээ.Шинэ өргөө гэрээ төвхнүүлэн хайртай түүнийхээ энгэрийг түшин эрхэлж, ном судраа дэлгэн уншиж суух сан” хэмээн хүсэмжилж явлаа.

-Миний дүү хадам эхийнхээ өргөөнд ороход тань гэрийн зүүн талд хонины нойтон нэхий дэвсээстэй буй. Түүн дээр сөхөрч суугаад эхэлж бурхан шүтээнд нь, дараа нь хадам аавдаа гурвантаа мөргөх ёстой ч Баатар хун тайж эдүгээ нэгэнт тэнгэрт хальсан тул хадам ижийдээ мөргөдөг юм шүү. Тэгээд нөхрийнхөө авга, нагац нарт мөн гурвантаа мөргөн ёслоод, гал голомтод нь өөх тос, бурхан шүтээнд нь хадаг, зулаа өргөөд хадмын талын ахан дүүсээ эдийн дээд хадгаар гар цайлгана. Энэ бүхний эцэст хадам эцгийн тань оронд нөхрийн хамгийн ахмад авга Цөхүр увш чиний нүүрийн бүтээлгийг сөхөн “Бэрийг үзэв үү?” гэж цугларсан зочдоос асууна. Тэгсэн хойно сая нүүр царайнаасаа гивлүүрээ авна хэмээн ууган ах Гартангомбын дунд хатан Сэндэнжав сургаад, богтаг малгайг нь тэгшлэн засч өгөөд гараас нь атган дотночилж явлаа.

Мухлаг тэрэг Юм-Агас хатны өргөөний гадаа ирж зогсов

“Бэрийг авчрав” хэмээн хүмүүс шуугилдах сонсогдон баруун талаасаа Галдангийн бэргэд Пагмадулам, Насанжид, нөгөө талаас өөрийнхөө бэргэн эгч нар болох Сэндэнжав, Долгорлхам хоёрт сугадуулсан Ану мухлаг тэрэгнээс буун, өргөөний үүдэнд ирэхэд сонжуу үстэй гурван охин гараа алдлан зогсоцгоосон нь хуримын ёсны дараагийн дэг болсон “Үүд дарах” ёс ажгу. Хоёр талын бэргэд зул асаан тэдгээр охидод хадаг, цай өргөн барьж байж өргөөний үүдээр орлоо. Өргөөний босго давмагц гэрийн зүүн багсанд \хаяа\ дэлгэсэн хонины нойтон нэхий дээр Ану сөхрөн суугаад бэргэн эгчийнхээ заасан ёсоор хадмынхаа бурхан шүтээн, хадам эх, нөхрийнхөө авга, нагац нарт гурав, гурвантаа сөгдөн мөргөж, ёсолсны хойно Цөхүр увш хоймроос хүрч ирэн нүүрний бүтээлэг цагаан бөсийг нь авч “Шинэ бэрийн царайг үзэв үү?” хэмээн сүрлэгээр хашгирахад гэр дүүрэн цугласан улс “Үзлээ” хэмээн уухайлцгаахад бүсгүй сая гэр доторхийг харж чадахтай болж, сэтгэл нь өчүүхэн ч гэсэн онгойж билээ.

-За шинэ бэр минь сууж цай идээ амс даа хэмээн сахил хүртэн үсээ хусуулсан мулзан толгой дээрээ хатан хүний ёслолын малгай өмссөн Юм-Агас хэлээд Ану гэрийн баруун хоймроор сууж буй эр нөхрийнх нь дэргэд урин суулгаж зочлов.

-Энэ их ёс дэгийг гүйцээх гэж чи минь ядарч байна уу? хэмээн Галдан асуугаад зүүн гараа явуулан хилэн нударга дороос нь бүсгүйн баруун гарыг олж атгаад энхрийлэн илбэлээ. Түүний мутарт гарт нь хүрмэгц аанай л нөгөө адис авахад төрж байсан шиг хамаг бие нь зарсхийснээ судаснууд нь халуун цусаар дүүрэх мэт лугшин, толгой эргэм сайхан мэдрэмжинд авгсан бүсгүй хайртынхаа зөөлөн дулаан алгыг өөдөөс нь зөөлхөн атгав. Тэгээд зориглон нүд рүү нь ширтээд:

-Зүгээр ээ. Санаа бүү чилээ хэмээн шивнээд Ану ичингүйрэн нүүр нь улсхийв. Олон хүн цугласан гэрийн дотор бүгчим, өргөө дүүрэн улс цөм шинэ бэрийг сонжин харцгаахын дээр хайртай хүндээ гараа бариулсандаа сэтгэл нь туйлын их догдолжээ. Түүний хажуугаар өнөө шөнө зайлшгүй болох ёстой “нөгөө юм” буюу үүл борооны явдлыг энэ хүнтэй үйлдэх ёстойг санан айдас төрөх атал бас хайртай хүндээ охин биеэ өгнө гэхээр сайхан ч юм шиг бодогдон улам ч ичингүйрнэ.

-Зэ, одоо шинэ бэр хадмынхаа нохойг хооллон, идээ цагаа арвин байхыг билэгдэн чигээн бүлүүр, шанаганы ишинд хадаг уяарай хэмээн Галдангийн бэргэн Пагмадулам зааварчлав.

Аягтай цайгаа барин тавин оочилж суусан Ану гадаа сэрүүн салхинд нүүрийн бүтээлэггүй гарч, цээж дүүрэн амьсгаа авахын мөн болж уухайн тас бослоо.

Гадаа наран таатайяа ээж, хүн малын зоо тэнийлгэсэн зуны дэлгэр сарын налгар сайхан өдөр болж байлаа. Ану эцгийн голомт төрхөм хоцорсон баруун хойд зүг рүү нэг хараачлаад аавынхаа захисныг санан, зоригоо чангалж зогсох зуур энэ өргөөний ахлах шивэгчин Асралт даган гарч ирээд:

-Манай ордны дотор тэжээдэг нохдын ихэнхийг төрүүлсэн Цагаадай гэж сайн нохой бий. Ахайтан та “Цагаадай!” гээд дууд хэмээн зааж өгөв. Ану:

-Цагаадай,Цагаадай! Нааш ир! хэмээн дуудахад хар зүстэй зүрх цагаан нохой гүйж ирсэн нь Анугийн багадаа мөн ч их тоглож ноолдог байсан Тайхар нэртэй хоточ нохойтой ширхэг солимгүй ижилхэн зүстэй амьтан байсанд нэг л нөөлөг дотно санагдаад явчихав. Бэргэн эгч Сэндэнжав нь нохой хооллох цартай чанасан мах барин хажууд нь зогсох агаад Мандарваа хүзүүнд нь уях цагаан бөс авчирч өгөхөд, Ану хуучны заншлаар сөхрөн сууж дотоод хормой дээрээ мах тавин Цагаадай хэмээх тэр бяруун чинээ нохойг хооллоод хүзүү сэрвээг нь илэн “Би одоо энэ гэрийн хүн боллоо. Тийм учраас чамайг хооллож байна” хэмээн ярих зуур Мандарваагийн сарвайсан цагаан торгоны цуудсыг нохойн хүзүүнд зүүж өгөөд босоход амттай сайхан хонины чанасан хавиргыг нүд ирмэх зуур идчихсэн Цагаадай, бүсгүйн нүүр өөд харж, сэгсийсэн сүүлээ зугаатай гэгч нь хөдөлгөн амаа том ангайн зогсох нь шинэ эзэндээ саймшран инээмсэглэх мэт.

Бэр дархалж, хадмынханд мөргүүлсний хойно Галдангийн Ануд төхөөрсөн булган гэрийг барьж гүйцсэн тул, хуримын олон зочдыг шинэ өргөөнд урьж, икэл хуурын дуу эгшиглэн найр жигдэрлээ.

Маш ховор үнэт арьстай амьтан цагаан булганы үсээр хөшиг цавгийг эмжин, цасан цагаан эсгий дээвэр дээр торгоор улаан хөлтрөг, угалз хээ мэтгэсэн битүү сийлбэртэй, унь тооныг мөнгөн товруугаар чимсэн найман ханат өргөөнд Очирт цэцэн хантны төхөөрсөн цагаан хаш өртэй мэлхий ширээ, хаш нүүртэй хоёр ор, сийлбэртэй цагаан зандан авдрууд, бүсгүй хүний чимэглэлийн босоо толь, үхэг тэргүүтэн тавьц хоршин нүд гялбам гоёмсог сайхан өргөө босчээ.

Гэрийн дотор тойруулан залгуулж тавьсан мэлхий ширээнүүдийг хотойтол өрсөн хонь, үхрийн чанасан мах, цагаан идээ, самнаа боов, хатаасан жимс, амтат самар, мөсөн чихэр, еэвэн овоолсон мөнгөн царнуудыг зогсолтгүй дүүргэн, архи, чигээ далай мэт цалгисан хөлтэй хурим үдэш гурван марал гудайхад сая өндөрлөж, бэрийг хүргэж ирсэн улс буцаж, зарц шивэгчингүүд найрын ширээ хураасан хойно, Ану эр нөхөртэйгээ хоёулхан хоцров.

-Энэ хурим гэдэг хэчнээн олон дэг ёслол, эрэмбэ дараатай эд вэ!Хөштөлөө суулаа.Чи минь хувцсаа хөнгөл дөө гээд Галдан баруун орон дээр сууж, очир эрдэнийн жинстэй сүрлэг малгайгаа авч, гэрийн эзний шинжтэйгээр толгойн үхэг дээр тавиад ган хөлтэй мөнгөн хонх авч жингэнүүлэхэд Мандарваа, Дархижав хоёр орж ирэн мэхэсхийв.

-Эзэн хатныхаа хувцсыг тайлалц хэмээн Галдан захираад өөрөө ёслолын дээл хүрмээ тайлан



бүсээ мөн л үхэг дээр эрхэмлэн тавьж буй харагдана. Мандарваа малгай, толгойн чимэг зүүлтийг нь авч, Дархижав хувцсыг нь тайлж байхад ичиж бишүүрхсэн Ану юу ч үл дуугаран, өөрт нь огт зохихгүй номой, дорой янзаар доош харан суусаар байлаа.

Мандарваа, Дархижав хоёр хувцсыг нь тайлж дуусаад том мөнгөн гадартай бүлээн усаар биеийг нь угаачихаад амгалан нойрсохыг ерөөн гарч одлоо. Найман ханат уужим өргөөний хоймроор Оросоос авч ирсэн их гэрэлтэй арван лааг намхан намхан мөнгөн сууринд суулган асаасан нь өдөр мэт их гэрэлтэй агаад нэг нэг орон дээр сандайлсан Ану, Галдан хоёрын сүүдэр гэрийн булган эмжээртэй хөшиг дээр үлэмж биетнүүд мэт үзэгдэнэ. Тэгсээр нэг үлэмж биетэн нь нөгөө рүүгээ очоод хумин тэврээд баруун орон дээр аваачин тавилаа. Баруун орыг хэдийдээ ч юм шивэгчин бүсгүй засаад цасан цагаан үен хөнжил, цагаан хоргой жинтүү зэрэгцүүлэн тавьжээ. Галдан бядтай гараар бүсгүйг өөр рүүгээ татан толгойг нь цээжиндээ энхрийлэн наав. Түүнээс хүж гүгэлийнх гэлтэй анхилуун үнэр, эр хүний хөлснийхтэй нийлэн үнэртэнэ.

-Таныг хэчнээн их санав аа! хэмээн Ану шивнэлээ.

-Би ч ялгаагүй. Чиний минь хүзүү хэчнээн энхрий үнэртэй юм бэ? гээд Галдан хайртай бүсгүйнхээ ганган цагаан хүзүүнд өнөөх уран хэлбэрт тачаангуй уруулаа наан озож байснаа, орон дээр зөөлнөөр даран унав. Түүний гар, уруул таалан хүрсэн газар бүр ирвэгнэн, хамаг бие нь биржийн хэзээ ч амсч үзээгүй таатай ч гэмээр сэрэл биеэр нь түгэхэд бүсгүй нүдээ анилаа. Эр хүний ширүүн гарт ийнхүү анх удаа энхрий биеэ таалуулна гэдэг үүлэн дээгүүр хөвөх мэт сэтгэл хөвсөлзүүлэн, оюун бодлын чагтага алдуурах адил ухаан алдмаар агшин ажээ.

Одоогоос гуравхан жилийн өмнө Хөх нуурт морь нь бүдрээд сандарсандаа налан унаж асан тэр хүдэр цээж чандаган цагаан өвчүүн дээр нь даран дотуур торгон цамцыг нь мулт татан тайллаа...Охин бие хөндөгдөн бүсэлхийнээс доогуур зад татчих мэт аймшигтайгаар өвдөхөд нь шүд зуун хашгиралгүй өнгөрсөн бүсгүй тэнгэрээс ямархан нэг юм шүүрсэн мэт аз жаргал, газраас нэгэн нандин цэцгээ тасдуулчихсан ч юм шиг харууслыг мэдрэн гиншээд хамаг бие нь чичирхийлж билээ.

-Миний үр хэчнээн азтай юм бэ?Хайртай хүндээ бэрлэн очно гэдэг бүсгүй хүнд тэр бүр заяадаггүй зол завшаан. Гэхдээ нөгөө талаар сэтгэлгүй хүнд богтлогдон очихоос илүү зовлон зүдгүүр ч байж магад. Ямар ч гэсэн эрийнхээ өмнө номхон дорой байлаа гээд бүсгүй хүнд алдах юм гэж үгүй. Хаан хүний хатан боллоо чи.Эрх ямба нь сайхан ч нөхөр тань нэг л өдөр дараагийн хатан, татвар эмсийг буулган авчрах болно.” Нууц товчоо”-д Бөртэ хатан эзэндээ юу гэж өгүүлдэг билээ, чи мэднэ. Хэлээ хазаж, наашаа харж инээн, цаашаа харж уйлах өчнөөн учрал тохионо гэдгийг бүү умарт хэмээн хуримын өмнөхөн ижий нь нэгэн үдэш захисныг саналаа.

Хайртай сэвгэрээ эзэмдээд сэтгэл нь ханасан Галдан нам унтаж байхад, хуримын анхны шөнөөр бүх л шинэ бэрүүдийн нойр хулжин оддогийн адилаар Ану тооноор цухуйх одот тэнгэрийн сэжүүрийг ширтэн, анивалзан гялалзагч аальгүй оддын гэгээнд түмэн бодолд ээрэгдэн хэвтсээр үүр тэмдэгрэхийн өмнө л нэг юм нам унтаж зөөлөн бөхөд дийлдсэн байлаа. ...Охин хонгор насаа үдсэн Алшаа нутгийн Хонгорын үзэсгэлэнт баянбүрдийн

дундуур хоржигнон урсдаг асан Чулуут горхи. Хөгжөөнт бяцхан горхины хөвөөнд Ану Галдантайгаа тэврэлдэн сууж хамтдаа усны урсгал ширтэж байв. Гэтэл горхины нөгөө эрэг дээр нэгэн тогос шувуу явж байгаад сүүлнээсээ солонгорсон гоёмсог өд унагачих юм. Ану хайртдаа тэр өдийг авчирч өгөхөөр горхины нөгөө эрэг рүү харайгаад эргэн харвал хайрт нь алга болсон байлаа. Тогосын өдөө орхиод бүсгүй хайртыгаа эрэн “Галдаан, Галдаан!” хэмээн хашгиран гүйх гэсэн ч хоолой нь гарахгүй шаналан, нэг мэдэхнээ эцэс төгсгөлгүй үргэлжлэх их элсэн манхан дундуур гүйсээр л гүйсээр л байлаа. Тэгтэл тооройн шугуй дунд хайртынх нь унадаг үлгэрийн хүлэг мэт хөө хар морин шилгээн үүрсэхийг үзээд баярлан ухасхийвэл тэр нь Ану хатнаа үл хайхран, олон салаа сэвгэр гээгтэй өөр нэгэн бүсгүйг хөтлөн цаашаа манхан дундуур алсран одох аж. Ану “Хайрт минь. Би чинь энд байна. Хайрт минь, Галдаан!” хэмээн уулгалан хашгирах гэтэл бас л дуу хоолой нь үл гарах аж. Хардах, харамлах сэтгэлдээ автан тарчилсан бүсгүй тэдний хойноос нь ухасхийн гүйх гэтэл хөл нь тушаатай мэт урагш гишгэхгүй аж. Гэтэл хайртай түүнийг нь булаасан залуу сэвгэр эргээд хартал нэг л танил зүс, гэтэл хэнийг нь огтхон ч тухайлж чадахгүй байтал тооройн төгөл дундаас хорон санаат дайсан гарч ирээд Галдангийн зүрх өөд чиглэн сумаа тавингуут Ану исгэрэх сумных нь урдуур орж цээжээ нэвт сүлбүүлэн амь тавилаа. Орчлонгоос одохын өмнө хүн эргэх хорвоогийн амьдралд хэчнээн их хоргодон татагддаг юм бэ?...

-Ану хонгорхон минь сэрэгтүн! Хэчнээн айхтар хар дарна вэ? гэх энхрий дуугаар бүсгүй сая тарчлаант зүүднээс сэрлээ. Гэрт гэгээ орж, үүр цайж байх агаад Галдан баруун тохой дээрээ өндийгөөд инээмсэглэн түүнийг ширтэн хэвтэх аж.

-Та минь! гээд бүсгүй цээжинд нь нүүрээ наалаа.

-Зүүд ариусгах тарни шившсэн. Чи минь ахин хар дарахгүй хэмээн Галдан хэлээд шанхных нь үсийг зөөлөн илбэх агаад “Нэг л өдөр эр нөхөр тэнь дараагийн хатан, татвар эмсийг авчрах болно.” Нууц товчоо”-нд Бөртэ хатан эзэн Чингист юу гэдэг билээ, чи мэднэ...” гэсэн эхийнх нь үг, Галданг нь булаан Алшаагийн элсэн манхнуудын дунд алсран одсон олон салаа хархан гээг, том алаг нүдтэй, нэг л танил юм шиг дүрт тэр нэгэн сэвгэрийн тухай бодоход зүрхэнд сэрүү татах шиг...

Харин хүслэнт сэвгэрээ хатан буулган өөрийн болгож авсан Галдан хааны хувьд эхлээд Зүүнгарыг, эцэст нь Халхыг мөн л хайртай бүсгүйгээ ийнхүү эрхшээлдээ оруулан эзэмдсэний адилаар өмнөө сөхрүүлэх хүчирхэг эр хүйстний ханашгүй шуналдаа авган бодлогоширч хэвтэвэй.

Ийнхүү хоёр биедээ эрхлэн хэвтэх нь зүйрлэшгүй их жаргал ч гэсэн хуримын дараахь анхны өглөөний ёс дэг хатуу тул бүсгүй өндийж, бяцхан мөнгөн хонх авч жингэнүүлснээр Мандарваа, Дархижав хоёр орж ирэн түүнийг хувцаслаж, аягачин галч эмс агар хувин дүүрэн цэлэлзсэн ус авчран, аргалын дөрөлжийг түлшээр дүүргэн шинэ бэрийн шинэ өглөө эхэлж билээ. Ану хэдийгээр хан хүний гүнж, эдүгээ Зүүнгарын хааны хатан болсон ч шинэ бэр өглөө эртлэн босч цай чанан хадмындаа оруулж өгдөг эртний ёсыг дагаж гараа гарган цай чанаж хоёр том мөнгөн домбонд уудлаад хадам эхийн өргөө рүү хоёр шивэгчнээ дагуулан очлоо.

Өчигдөр энэ ордны их дааман хаалгаар орж ирэхдээ нүүрээ цагаан гивлүүр дор нуусан

байсан тул хэрэм доторхи байдлыг сайн харж амжаагүй ажээ. Гэтэл энэ өглөө л хэрмийн төв дунд сүндэрлэх гурван давхар Дотоод ордон, өмнө нь байх хиймэл цөөрөмнүүд, цөөрмийг тойрсон бяцхан цэцэрлэг, зүүнтээ нь байх мөн л чулуугаар урласан хоёр давхар “Түгээмэл баясах” харш, тарнийн сүм дуган зүүн талаар нь үргэлжлэх олон гоёмсог өргөөнүүдийг баясан харж явлаа.

Ийнхүү харьд одон, цоросын бэр болсон Анугийн шинэ амьдрал эхэллээ.

Гурав хоногийн дараа түүнийг хадмынд нь хүргэж ирсэн хоёр бэргэн эгч нь нутгаа буцах болж, эх өөртэй хоёр ахынх нь хатан ч гэсэн цагаан сараар золгон, гарын бэлгийг нь авч жилдээ ганц уулздаг байсан дөч гарч яваа махлаг улаан Сэндэнжав, сэтгэл зөөлөн, овор том биетэй мөн л дөч шүргэж буй Долгорлхам хоёрыг эрхбиш өөрийн хүмүүс тул элэг нь татан явуулмааргүй сэтгэл хоргодоод байсан ч Ану хүчлэн биеэ барьж инээмсэглэж чадаад:

-Хоёр бэргэн эгч минь, газрын холд намайг хадамд хүргэн өгч үг сургаалиа хайрласанд гялайлаа. Замдаа сайн явж хүрээрэй! Ижий, аав хоёрт намайг шинэ гэр өргөөндөө дассан, ном судраа уншаад хоцорсон гэж дамжуулаарай хэмээгээд өргөөндөө хоцров.

Хоёр бэргэн нь ч “Саяхан л сэгсгэр даахьтай муухай амьтан эхээс мэндэлж байсан сан, чи минь.Одоо ч арван долоотой балчир л байна. Гэвч хадмын газар одож, хүний хүн болдог нь бүсгүй бидний заяа тавилан хойно, хадамдаа асралтай, ханьдаа халамжтай бэрлэхүйн ёсоо сахисан сайн эхнэр болоорой.Төрхмийн зүгт бүү сэтгэл хоргодоорой!” хэмээн ам уралдан захицгааж, хожим үнсэхээр баруун хацрыг нь үлдээж, зүүн хацарт нь хошуу хүрээд хуучны уламжлалаар хормой дээр нь чулуу тавиад гарцгааж билээ. Энэ нь шинэ бэрийн сэтгэлийг төрхмийн зүг татагдахгүй, насан эгүүрд энэ айлын хүн болж байгааг баталж буй хэрэг ажгу. Ийнхүү хошууд аймгийн тэргүүн, дөрвөн Ойрадын холбооны чуулганы хан Очирт цэцний отгон охин Ану хүчирхэг цорос аймгийн хүн боловой.

Цорос аймгийнхан өөрсдийгөө тэнгэрийн охидоос үүсэлтэй хэмээн үздэг ажгу.Эрт урьдын цагт Ойрадын газар нутагт орой нь хурмастын үүлийг шүргэн сүндэрлэсэн сүрлэг өндөр уулсын оргилд цэнгэг уст бяцхан нуур байдаг амой. Тэрхүү нуурын хөвөөгөөр саглагар модод тольдон ургажээ. Сүрлэг уулын оройд байх толь шиг тунгалаг нуурын эрэг хөвөөгөөр бэдрэн гөрөөлж явсан нэгэн анчин эр усны цалгих чимээтэй хоршин залуу охид сэвгэрүүдийн жаргалтай гэгч нь цангинан инээлдэхийг сонордов гэнэ. Эзгүй буйд газарт юун залуу охид явааг сонирхон нуурыг хөвөөлсөн өндөр моддын завсраар мань анчин сэмхэн шагайн харав. Тэгтэл тэр бяцхан нуурт тэнгэрийн үзэсгэлэнт охид бууж, усных нь мандлаар хөвөн зугаацаж, дээшээ огторгуйд хөвөн нисч цэнгэж байх юм гэнэ. Анчин эрд тэнгэрийн үзэсгэлэнт охидыг хүсэн тачаах сэтгэл төрж, гэрээсээ хэдэн алдын урт цалам авчран тэнгэрийн охидыг эрэг дээр гарахыг хүлээн зэгсэн шугуйд нуугджээ. Төдөлгүй тэнгэрт үүл хуралдахад хурмастын охид ч нуурын мандалд буун ирцгээж, хөвөн цэнгэж эхлэв. Залуу эр ч цалмаа шидэн нэгийг нь бариад авчихжээ. Ийнхүү нэгэн үзэсгэлэнт охиныг цаламдан бор гэртээ авчирч ханилан, бие шалтгаантай болгосон аж. Тэнгэрийн охин газрын эрийн хүүг төрүүлээд ууль шувуунд харуулан үлдээгээд тэнгэрийн орондоо нисэн одсон юм гэдэг. Тэгэхдээ хөвүүнээ өлсч цангуузай хэмээн бүдүүн модны ур огтлон цорготой аяга урлаж, хөхний сүүгээрээ дүүргээд ургаа модны мөчрөөс өлгийтэй нь дүүжлэн орхисон аж. Энэ хөвүүнийг Ойрадууд олжээ. Чингээд хөвүүнийг асрамжлагч шувууны нэр сунжирсаар өөлд, цорготой аяганы нэр цорос

Гэсэн аймгийн нэр үүсгэсэн ажээ.

## Арвандөрөвдүгээр бүлэг

Зуны дунд сарын нэгэн нохой гаслам халуун өдөр. Галдан төрийн хэрэг шийдэн, зочид гийчдийг хүлээн авдаг Дотоод ордныхоо зөвлөлдөх танхимд гүнзгий бодолд дарагдан сууна. Хойморт эцгийн хөрөг, цорос овгийн сүлд, богд Зонховын алтан шуумал болон Очирваань Жамсран зэрэг догшин сахиуснууд залаастай. Бурхан тахилын ширээн дээр Зая бандид Намхайжамцтаны удирдлагаар тод үсэгт буулган есөн эрдэнээр бүтээсэн Гаанжуур, Даанжуур судрыг талбижээ.

Хоёр жилийн өмнө намрын нэгэн өдөр энэ ордонд дуудагдан ирээд Сэнгэ ах нь сэтгэлт хонгор сэвгэр Ануг нь хатан буулгахаар болсныг дуулж, гэрэлт нартай өдөр тэнгэрийн аянга ниргэх шиг хүнд цохилтонд орж байснаа тэр санаад мушийв. Ахдаа сэтгэлт сэвгэрээ алдсантайгаа эвлэрчихээд байсан хүн өнөөдөр тэр бүсгүйгээ их хатан болгож аваад өвөртөө оруулчихсан сууж байна гэж бодохоос сэтгэл өөг. Одоо бол захиргаагүй болсон Ойрадын олон овог аймгийг ганцхан далайлтаар хураан гартаа оруулж авах бодол тархинд нь эргэлдэнэ.

Залуу гоцго шагайж :

-Хаан эзэн минь, таны дуудсанаар Данжила жанжин ирэв хэмээнэ.

-Оруулагтун! Шивэгчин дуудаж энэ гэгээвч нээлгээд хүйтэн чигээ оруул гэж хэл.

-Жа...

Хамгийн нимгэн дурдан лавшиг ч биед наалдан халууцуулж буй энэ үдийн наранд яахин тэсч байнав хэмээн гайхмаар цайвар магнаг дээл дээрээс хүнд гархин хуяг, хүрэл тольтой илгэн цээживч, алтан оройт дуулга агссан өндөр сүрлэг Данжила жанжин орж ирээд хаанд мэхийн хүндэтгэл үзүүллээ. Хэн ч харсан нуруулаг сайхан эр Галдан хаан өөрөөс нь сөөм шахуу өндөр Данжилаг сэнтий дээрээсээ хөмсөг өргөн хараад ургаж эхэлж буй ширвээ сахлынхаа барууныг нь имрэн доогтой гэгч нь:

-Сүүдэрт хэвтээ нохой гаслаад арьсаа эгээтэй хуулж тавихаа дөхөж буй нозоором энэ халуунд чи наад хүнд хуяг дуулгатай явж халшрахгүй юм уу? хэмээхэд:

-Хаантан минь амгалан морилно уу? Би саяхан цэргийн харвалгын сургуулилт дээрээс ирлээ. Зүүн хөндийд шадар мянгатаа харвалгын сургууль хийлгэж буй. Халуун гээд хуяг дуулгаас юунд халшрах буй. Хэрэв бид дайтаж буй бол дайсны сумнаас утсан чинээ улаан амиа хаацайлах үүднээс энэ хуяг дуулгаа эгэлдрэглэх л болно бус уу?

-Нээрээ тийм дээ. Чи мянгатаа ийнхүү ямагт байлдаанд бэлэн байлгаж буй нь туйлын сайшаалтай хэрэг. Сууж хүйтэн чигээ ууна уу?гэлээ.

Гаднаас Сэнгийн татвар эм байсан Жасмин шивэгчин тогосын зурагтай дунд гарын ваартай, газар зоорьт тавьж хөргөсөн цэл хүйтэн чигээ оруулж ирэн аягалав.

Өврөөсөө амсар ёроолыг мөнгөлөн түмэн наст хээлсэн том үндсэн тагш гарган цэл хүйтэн

чигээ нэгэн амьсгаагаар залгилж гүйцсэн Данжила урт сормуус сүүдэрлүүлсэн эрэвгэр нүдэн шивэгчний хойноос шохоорхлын харц шидлээд чигээнд норсон сахлаа шувтран:

-Танд дуулгах таатай сайхан сураг надад байна. Дөрвөд аймгийн эзэн Далай тайшийн ач хүү Алдар тайш цэрэг, албат аа аван таны захиргаанд орохоор айсуй. Маргааш гэхэд тэдний хөсгийн түрүүч хойд хөтлийн цаахна буух гэнэ гэлээ.

-Чихэнд чимэгтэй сайхан хэл дуулгасан чамайг хэрхэн хөхүүлж шагнах буй? хэмээн Галдан асуугаад чигээний аягаа өмнөх цасан цагаан гантиг ширээн дээрээ тавьсанаа сэтгэл таатай байх үедээ тэгдэг зангаараа баруун гараар ташаа тулан ханхалзаж:

-Саяын чигээ аягалсан шивэгчний хойноос ямархан харц шидлэхийг чинь би ажсан. Сэнгэ ахын өврийг бүлээцүүлж байсан хиргис сэвгэр байгаа юм. Надад ч бас салхи борооны явдлын цэнгэлийг харамгүй хайрлаж байлаа. Одоо би дөнгөж хатан буулгачихаад үүнийг ордонд үлдээж Анугийн сэтгэлд сэв хийгээд янав. Чи түүнийг өргөөндөө аваачлдаа хэмээн найр тавилаа. Данжила эзний хишигт талархсанаа илэрхийлсэн ч харцанд нь гуниг хураастай хэвээр. Учир нь тэр Галдан авгынхаа хатан Ануд хэзээнээс сэтгэл алдарч яваа ажгу.

Оройдоо нар тонгойн, үдийн нозоором халуун буух үеэр Галдан хаан хатнаа авч дөнгөж барьж эхэлж буй Хайнагийн дацангийн тийш цөөн хэдэн бараа бологч, хишигтэн эрсийг дагуулан хөдөллөө. Хэдийгээр Хайнагийн сүмийг барьж буй газар ордноос нэгэн өдөрчийн зайтай ч зам зуур Баатар зайсангийн айлчлан хоноглоод цааш одохоор төвлөсөн тул ачаа хөсөг дагуулсангүй.

Галдангийн унах дуртай араб угсааны ганган хар хээр морьтой ширхэг солимгүй ижил зүсмийн хээр үрээг Ану унаж явлаа. Бүсгүй тэртээ гурван жилийн өмнө Хөх нуурт байхдаа Галдантай ийнхүү зүс ижилсүүлсэн сайхан хүлэг унаад, хээр тал дундуур салхин сэвэлзүүлэн хатируулах сан гэж хүсэмжилж байснаа санан, мориныхоо согоо чих солбилцохыг ажин үе үе хайртынхаа царайг хажуугаас нь ширтэсхийсэн шиг явна. Хайртай хосууд хамтдаа байх цагт ганц ч үг солихгүйгээр зүрхээрээ ярилцан, сэтгэлээрээ ойлголцохын жаргал гэдэг юутай ч зүйрлэшгүй сайхан ажгу.

Тэр хоёр ижил зүсмийн усан тэлмэн жороо морьдоо хатируулсаар дагуулуудаасаа барааны газарт тасран, ордныхоо зүүн хойд хөтлийн орой дээр гараад овоо индэрт чулуу өргөхөөр буулаа.

-Өнөөдрийн халууныг ээ! Чиний хацар халууцаж ягаараад улам ч хөөрхөн болчихоо юу даа.

-Ер өө. Би өргөөнийхөө хаяаг шуугаад Их Юань гүрний түүхийн судар баахан уншлаа. Тэгэнгээ таныг хүлээгээд...

-Сэрүү унахаар чамайгаа дагуулаад ингэж хээр талаар дөрөө харшуулан давхих сан гэж бодоод л суулаа. Алив энэ шанхан дээр чинь...

-Яасан байна?

-Хөө түрхчихжээ гээд Галдан түүнийг нь арилгаж өгөх гэж буй хүн болон ойртоод хатнаа тэврэн авч уруул дээр нь озов. Аз жаргалдаа умбасан Ану хайртай түүнийхээ тэвэрт тас тас хөхрөн, тээр дээр тэнгэрт эргэлдэн буй элээ, зулсан ноос мэт хэсэг хэсэг хөвөн цагаан үүлс, амгаланаар мэлтийгч хөх огторгуйг ширтэн амрагийнхаа өвөр дээр хэвтэх ажээ. Дэргэдүүр нь ардаа гээгтэй юм шиг шовх унжуулгатай тод хөх өнгийн цэцэг бөөн бөөнөөрөө шүхэрлэн ургажээ.

-Энэ чинь бэрцэцэг үү дээ? хэмээн Галданг хэлэхэд:

-Биш ээ.Хараалч цэцэг гэдэг юм. Бас гэзэгт цэцэг ч гэдэг гэнэ лээ. Бэрцэцэг чинь тэр байхгүй юу гээд Ану нөхрийнхөө тэврэлтээс мултран өндийгөөд үүдэн хоймрын зайд ургасан, хараалч цэцгийг бодвол арай цайвардуу хөх ягаавтар өнгөтэй, жижигхэн жижигхэн дэлбээний голд шавсан өндөр өндөр дохиуртай дугуй хэлбэрийн цэцгийг заалаа.

-Өө, тийм үү?Би энэ гэзэгтэй юм шиг хөх цэцэгсийг л эдүгээ хүртэл бэрцэцэг юм байх гэж бодож явсан юм.

-Юуны учир бэрцэг гэдэг болсон тухай домгийг нь та мэдэх үү?

-Үгүй. Хараад ялган таних ч үгүй хүн, домгийг нь хаанаас мэдэх вэ. Юу ч гэсэн амраг хосуудын үнэнч хайрын билгэдэл гэж дуулсан юм байна.

-Би танд бэрцэцгийн домгийг хүүрнэж өгөх үү?

-Тэг л дээ. Гэхдээ Данжилаг хүрээд ирэхээс өмнө чамтайгаа сайн эрхлэлдэн ноололдьё гээд Галдан бүсгүйг тэврэн хүзүүн дээр нь үнсэхэд бүсгүй тас тас хөхрөн ногоон дээр ойчлоо.

Тэгтэл дөрөөн чимээ харшилдан орос адууны эрлийз өндөр саарал морь унасан аварга биет Данжила жанжин, улаан буурал морьтой Махан баатрын хамт давхин ирэв.

Залуу хосын тийнхүү эрхлэлдэн байхыг хараад хөмсөг зангидан барайж, алсыг ширтэн хоолой засах Данжилагийн зүг Галдан хаан:

-Данжила чи гэдэс базалсан хүн мэт юунд барайгаав?Хүйтэн чигээ залгилна уу гэхэд царайгаа хүрлийлгэснээ огт анзааралгүй явсан Данжила морио хантайрах зуур Анутай харц мөргөлдөөд балмагдан нүд буруулж, алсын уулсыг ширтэгчин болж:

-Өглөөнөөс хойш хуяг дуулгатай явж бага зэрэг бие харшсанаас өөр зүйлгүй хэмээв. Галдан:

-Жасминыг маргааш орой гэртээ аваачаарай. Чи хө хатан буулгахад яадаг хүн бэ? хэмээн асуунгаа Анугийн гэзэгний үзүүрээр өхөөрдөн оролдож, нүдний булангаар түүн рүүгээ хайрын харц илгээн их л жаргалтай суулаа.

-Талийгчаас хойш сэтгэлд таарах сэвгэр таарсангүй хэмээгээд Данжила тэдний дэргэд ирж суун ногоо тасалж амандаа хийнэ.

Ёсолж авсан гэргий нь жилийн өмнө төрөхөөс болж насан эцэслэсэн нь үнэн боловч, мань эр

түүнээс ч өмнө Сэнгэ хааныг дагалдан Хөх нуурт Очирт цэцэн ханыхаар айлчлахдаа Анугийн гоо үзэсгэлэнд сэтгэл алдарсан юм байж. Тиймдээ л өдгөө эзэн хатан, бэргэн нь болсон энэ сэвгэрийг эр нөхрийн хамт эрхлэлдэн жаргахыг үзээд өөрийн эрхгүй харамлах сэтгэл төрж царай барайсан нь тэр байж.

-Өө, Балсан айсуй. Алив хаантан минь, та миний хамгаалагч Балсанг өөрийнхөө хишигтэн харваачтай халз уралдуулан тэмцэлдүүлнэ гэсэн биш үү? Хэн нь дийлэх нь вэ, үзье гэхээс тэсэхгүй нь хэмээн Ану хэллээ.

-Нээрээ тийм шүү. Чи өнөөдөр Өлчир харваачаа дагуулсан уу? гэж Галдан хааныг асуухад Данжила

“Тээр доороос ирж яваа халиун морьтой чинь Өлчир шүү дээ” гэлээ.

Ийнхүү Галдан хаан, хатныхаа хамгаалагчийг, өөрийнхөө шадар мянгатын хишигтэн харваачтай тэмцэлдүүлэхээр болж эхлээд тэнгэрт нисч яваа хараацай, дараа нь дөрвөн зуун алд газарт ширэн бай харвуулахаар боллоо.

-Балсан чи мачийгаарай! Хөдөлгөөнт бай харвахдаа анзааргагүй шүү чи хэмээн Ану захирна.

-Жаа, хатантаан. Хичээеэ.

Тэнгэрт дүүлэн нисч яваа хос хараацайг хоёр харваач онилон хараачлав.

-Хос хоёр амьтны нэгийг харван нөгөөг өнчрүүлээд юүхэв. Та хоёр ганц, ганц сумаар тэр хоёр жигүүртэнг нам харваж ид хаваа үзүүл! хэмээн Галдан хаан тушаалаа.

-Жаа, эзэнтээн гэж хоёр харваач хоолой нийлүүлэн зэрэг шахуу өчөөд нумаа татан онилов.

Агаарт сум исгэрэн Данжилагийн хөл доор ганц хараацай тээр дээрээс хөсөр унаад ирлээ.

-Хэн нь алдчихав?

-Энэ чинь Өлчирийн сумны гилбэр байна гэлцэхэд Балсан онилсон шувуугаа оноогүйгээ мэдээд гэмшин нударга зангидан толгой сэгсрэхэд Өлчир харваач хаан, хатан хоёрын зүг мэхэсхийн харцаа бардмаар өргөлөө.

-Заяа нь хая гэж! Хоёр цийлэн чинь юугаа халиана вэ? Алив нум сумаа өгөөдөх гээд Ану Балсангийн гараас нум сумыг нь авч таван хором хараачлан онилоод эрхийгээ чивчрүүлэн байж сумаа тавьтал яг Өлчирийн хөлийн дэргэд тас харвуулсан жигүүртэн навсгасхийн унаад ирэв.

-Миний хатанг харав уу? Харвахдаа муу эрчүүд ичтүгэй! хэмээн Галдан сайрхах мэт хэлснээ сахлаа имрэн зальжнаар инээмсэглэн Балсангийн зүг хяламхийн:

-Гэвчиг эзэн хатан нь хараалснаа алдахгүй оносон ч манай Өлчир дийллээ. Дөрвөн зуун алдаас үхрийн ширэн бай харван тэмцэлдүүлье гээд Анугаа бүсэлхээр нь тэвэрнэ.



Хөдөлгөөнгүй байнд таван сум тавихад Балсангийн таван сум бүгдээр байны улаан зосон голд онож, гурвыг голд нь харвасан Өлчир харваачаас хол тасарсан тул, хоёр харваач хайнцсанд тооцон, дараа шовхоо хагалахаар болж цааш хөдлөв.

Оройн нар уулын цаагуур болсон тошлой жимс мэт час улааран шингэж байх үед алсад Баатар зайсангийн өргөө үзэгдэв. Өдрийн нохой гаслам халуун хаачив гэмээр сэрүүн сайхан салхи сэвэлзэн, хялганын толгой бөхөлзсөн зуны намуухан орой. Дагтан сайн хүлэг унасан залуу чийрэг хүмүүс аян замд өчүүхэн ч чилсэн янзгүй. Согоо чихээ солбиулан жороолох хүлэг морины явдал дунд Ану эр нөхөртөө бэрцэцэгийн домгийг хуучилна.

-Энэ цэцгийг амрагаасаа хагацсан бэрийн нулимс гэдэг юм гэнэ лээ. Эрт дээр цагт, эзэн Чингисийн үед гэнэ. Сартуул аймгийг дайлаар мордох их цэрэг хөдөлжээ. Арын их хэнгэргээ дэлдэн ай түмэн цэргээ хурааж, өврийн их хэнгэргээ дэлдэн үй түмэн цэргээ хурааж баатар эрс дайнд одоход саяхан хуримласан амраг хосууд хагацан салах болж гэнэ. Эр нөхрөө хүлээж, үүрд бат журмыг сахина хэмээн амраг залуу бүсгүй ам тангаргаа өргөн ханиа үдсэн юм санж.

Амраг бүсгүй хань нөхрөө хүсэмжлэн сарын сайныг саатан хүлээж, өдрийн сайныг өнжин хүлээж сураг чимээ чагнан байтал их цэрэг сартуул аймгийг байлдан дагуулж эрхшээгээд эх нутгийн зүг хүлгийн жолоо залсан тухай таатай сайхан сураг дуулав.

Амраг хань, хайртай хүү, дүүгээ угтахаар ялсан цэргийг тосох олны дунд өнөөх шинэхэн бэр бас байлаа. Гэтэл өглөөний ургах улаан нарнаас үдшийн саран гарах хүртэл хар нүдээ хөхөртөл харсан ч аян дайнаас эсэн мэнд ирэгсдийн дунд бүсгүйн амраг хайрт нь байсангүй гэнэ.

Бүсгүй уйлан хайлж “Ай алтан наран чи амраг түүний минь харах нь яав. Хараацай болон нисдэг ч болоосой. Харийн хүйтэн хөрсөнд хөсөр хаягдсан хайрт ханийнхаа хатан ясан дээр очиж хүний нутгийн шороог нь үлээгээд ч болов арилгах сан. Сэрүүн сэвшээ салхи чи сэтгэлт түүнийг минь харах нь яав. Хүүрзгэнэ болоод нисдэг ч болоосой. Хүний газар хаягдсан хөөрхий түүндээ очиж халуун нулимсаараа шархыг нь угаан уйлах сан. Уяраад босоод ирэх ч юм бил үү? хэмээн гаслан тэнгэр газар, алтан наранд гашуудлаа өчөөд халуун амраг сэтгэлтэнг хагацаан салгасан дайн дажин дахин бүү гараасай хэмээн ерөөхөд нулимс нь газарт унаж хөх өнгөтэй хөөрхөн цэцэгс болон ургасныг хөөрхий тэр бэрийн дурсгалд бэрцэцэг хэмээн нэрийдсэн юм гэнээ.

-Сайхан домог байна. Чи минь үлгэр хууч хүүрнэхдээ үнэхээр сүрхий юм аа. Өр нимгэн нэгний нулимс цийлэгнэмээр л юм. Гэвчиг эр хүн дайн тулааны газар ясаа тавихаас илүү эрхэм үхэл гэж үгүй шүү дээ.

-Дайн тулааны эцэст хэчнээн ийм олон бэр, хэчнээн эх нулимсаа асгаруулан өнчирч хоцордог болоо? Та хаан хүний хувьд басхүү үүнийг хэрхэвч мартаж үл болно.

-Зүүнгар улсыг төвшитгөн тохинуулахад надад дайсан олон байна. Тэдэнтэй бол цэрэглэн дайтахаас гарцаа байхгүй шүү дээ. Харин дайн тулаанд үрэгдэгсдийн ар гэрийг асран тэтгэх үйлийг чи минь эрхэлж болно шүү дээ хэмээгээд Галдан төрсөн ахыг нь хорлоход ханцуй шамлан оролцсон үеэл Багабандийг санан хөмхий зууна. Харин Ану тэртээ багадаа Дүүрэн

багшаасаа нэгэн удаа “ Багш аа,эр хүн дайн тулаанд юунд ингэж дурладаг юм бэ?” хэмээн асууснаа дурсаад бяцхан инээмсэглэв.Тэгэхэд багш нь нүүрэндээ хөгжөөнтэй инээмсэглэл тодруулснаа магнайгаа үрчийлгээд “ Шавь чи мунхаг миний хэрээс хэтийдсэн асуултаар мэд тавих юм даа. Эр хүмүүс дайнд дуртайдаа дайтдаг хэмээн би бодохгүй байна. Их эрх мэдэл, газар нутаг, эд баялгийн төлөөх шунал л хүмүүнийг дайн өдөөхөд хүргэдэг. Миний олж сонссоноор эртний Эллинд дан бүсгүйчүүдээс бүтсэн Амазонууд хэмээх улсын тухай домог буй. Амазонуудын улсад эр хүн үгүй. Ойролцоох арлын эрчүүдтэй жилд нэг удаа учраад буцан ирж,бие давхар болдог.Гарсан хүүхэд нь охин байх аваас авч, эр байвал амийг нь тасалдаг. Хатан хаантай улс байсан хэмээсэн домог буй. Тэр улсын бүсгүйчүүд дайн тулаанч, эрмэг зоримгоороо эрчүүдээс үл дутдаг агаад , ямагт ойролцоох хот балгадыг дайлан олз омгоороо амь зуудаг байсан тухай ном, сударт өгүүлснийг уншиж байлаа. Мөн Мандухай цэцэн хатан ч хаан төрд тэрслэн, Монголын их хаанд үл захирагдан том толгойлсон олон ноёд ихэсийг цэрэглэн хурааж байсан. Ер нь эр, эмдээ ч биш, эд хөрөнгө, эрх мэдлийн төлөөх шунал, өш хонзон л дайны үрийг тарьдаг хэмээн би боддог...” хэмээж билээ.

Багштайгаа юм уу, өөр бусад хэн нэгэнтэй байсан бол марган мэтгэлцэх эс бол, санаа бодлоо хэлмээр байсан ч Ану биеэ барьж чимээгүй боллоо.

“Эр нөхөртэйгөө бүү мөчөөрхөлцөөрэй. Зөөлөн нь хатуугаа дийлдэг жамаар эм хүн эрийнхээ үгийг хэзээд хүлцэнгүй дагаж явснаараа хождог юм.Ээ, дээ үр минь чи бухын хүзүү шиг хатуу зөрүүд. Эм хүнд хэтийдсэн эрх дураараа хүн шүү.Хадмын газарт очоод тэр зангаа хазаарлан татаж яваарай!” хэмээн ижийнхээ байнга захидгийг санаад тийнхүү амаа татсан нь тэр бөлгөө.

Төдөлгүй Галдан хаантан морилж айсуй хэмээн хэдийнээ хэл авалцаад байсан Баатар зайсангийн албатууд тэднийг хүндэтгэн тосохоор давхилдан ирэвэй. Сэнгэ ахыг нь сэрүүн тунгалагт цоросын төрийн хэрэгт үнэнчээр зүтгэн халхын Алтан хан хэмээх Шолой увшийг довглоход хүчин өргөж явсан Баатар зайсан өдгөө Галдангийн хамгийн итгэлт түншүүдийн нэг бөлгөө. Залуу хатнаа дагуулсан эзэн хаанаа Баатар зайсан хүндэтгэлийн дээдээр угтаж, үдшийн зоог барив. Чингээд сүүлийн үед санаа буруулаад буй Багабанди, түүнтэй сэм нийлэн нам хуйвалдаж буй Алдар хошууч, Эрдэнэ тайж нарыг хэрхэн нам дарах, манжийн бөгсийг долоогч Түшээт хан Чахундоржтой хэрхэн харилцах гэхчлэн нарийн чухаг зүйлсээ зөвшилцөөд өглөө нь гийчид Хайнагийн сүм өөд хөдөлжээ.

Хос залуус дөнгөж хуримласны дараахь зүү орох завсаргүй, эвийн цавуугаар наалдсан мэт үй зайгүй амраглалын үедээ байгаа тул ёстой л гаравч оровч хамтдаа, уйдаах, гуниглахыг үл мэдэх, ярьж хөөрөх юмаар арвин, харц солилцох бүрд баясан, хун цэн мэт хослон ижилдэхүйн жаргалд умбаж явлаа. Зам зуур Галдан хайрт хатантайгаа элдвийг хөөрөлдөн, идэр залуу, хөгжөөнт хүмүүсийн зангаар тоглоом наадам хийлцэн явсан нь хожим үл мартагдах дурсамжийн алтан хуудас болон үлджээ. Хайнагийн сүм дээр тэднийг очиход Төвдөөс тухайлан энэ сүмийг бүтээхээр залагдан ирсэн дунд насны хоёр лам, Алтан угалзын сүмийн хамба Ваанчиг гавьж тэргүүтэн хүндэтгэн угтацгаав. Сүмийн ажил урагштай, шүтээний дуганы дам нурууг босгоод уншлагын дацангийн оройг барьж байв.

Буцах замдаа Галдан хаан Ану хатантайгаа дөрвөн Ойрадын домогт баатар Эсэн хутагтын\* түүхийг хүүрнэлдсээр явж билээ.

Анугийн хувьд хүчирхэг, ухаалаг Эсэн тайш савнаасаа халин Их монголын хаан ширээнд санаархахын оронд, дөрвөн Ойрадын нэгдсэн төрөө бататган сахиж суусан сан бол өдгөө энэ төр улс хэчнээн хүчирхжиж чадах байсныг санан харамсдаг байтал эр нөхөр Галдан нь чухам эхлээд Ойрадын олон овог аймгийг нэгтгэн хураасны хойно халх руу санаархах бодолтой, ганцхан жил Монголын хаан ширээнд сандайлж үзсэн Эсэн хутагтын түүх тэрхүү их санаанд нь ташуур өгдөг нь энэ яриагаар ойлгомжтой болжээ.

Өргөөндөө ирсний дараа эр, эм хүмүүсийн оюун бодлын энэ их ялгааг Ану ихэд анзааран гайхашралд автжээ. Чингээд аливааг эс ухах, үгүй бол ийнхүү гайхашралд автах үедээ эцэгтэйгээ, эс бол өвгөн буурал Дүүрэн багштайгаа хэлэлцэн мэргэн үгийг нь сонсдог байснаа санан гуниглаж билээ.

Ану нэгэнтээ Дүүрэн мэргэн багштайгаа Эсэн тайшийн тухайд хүүрнэн ярилцаж байснаа эргэн санах.

“Чухам Эсэнгийн хувьд түүнийг хороосон нь халх монголчуудын зөв байсан гэж би боддог” хэмээн багшийгаа хэлэхэд:

-Юуны учир зөв гэж? Эсэн тайш Монголын нэгдсэн улсыг байгуулна гэж зорьсон хүн бус уу. Монгол улс эв нэгдэлтэй байвал хүчжинэ гэж та өөрөө хэлдэг, тэгээд бас өөрөө Ойрад хүн байтал?” тэгэхэд Дүүрэн мэргэн бичээч хүд хүд инээгээд шилээ авч торгоны өөдсөөр зүлгэн:

“Юуны учир Самар тайху түүхэнд мөнхрөв гэдгийг бод. Үймээн самууны тэр цагт Самар гүнж Чингисийн алтан ургийн сүүлчийн удмыг аварсан. Монголыг халх, Ойрадтай нь нэгтгэсэн Эсэн яагаад хороогдов? Монголын их хааны суудалд гагцхүү алтан ургийн хүн л залрах эрхтэй.

Гэтэл Ойрадын Эсэн тайш сууж болж байгаа юм бол Хавт Хасар, бөх Бэлгүтэйн удам хойчис, аль эсвэл Сүвээдэй жанжны үр ач бид монголын төрд бас эгэлгүй их гавьяатай, Эсэн хаан сууж болсон юм, бид яагаад эс суухав гээд дуртай нь хаан болохыг хүснэ. Хэдий халх, Ойрадууд эв нэгдэлтэй байх нь зүй ч алтан ургийн бус хүн хаан сууснаар тэр эв нэгдэл бутран унах байсан болоод Эсэн алагдсан биз ээ” гэж байж билээ.

Дараагийн удаад зуны сүүл сард Ану эр нөхрийн хамт тарианы газрыг эргэж билээ. Олон уйгар хотон айлууд Или голын үржил шимт хөндийд суурьшин тариалан эрхлэх ажээ. Намрын амьсгал тээсэн сэвэлзүүр салхинд өвдөгцөө өндөртэй ургасан халтар арвай, буудайн түрүү долгион шаргалтах нь хараад баймаар. Газрын өгөөжийг шүтэн, ургацаараа гэдсээ тэжээнэ гэдгийг үл мэдэх, гагцхүү мал адуулан амиа тэжээдэг хошууд аймгийн охин Ануд тарианы алтрах түрүү, өдөржин газар дээрээ тонголзох тариачин өрхийн хүмүүсийн аж амьдрал, эрхлэх аж ахуй нь гойдын сонирхолтой байлаа.

-Хатантан, Та шинэ тарвас амтал хэмээн тэднийг зочилсон тариачдын ахлагч Хожа хэмээх толгойдоо цагаан чалма ороосон уйгур өвгөн амтат улаан тарвас зүсэн дайлав. Хэдийгээр өсөх наснаас элдэв амттанд умбасаар өдий хүрсэн ч хатаасан жимс гэхээс ийнхүү шинэхэн жимс амтлах нь талын нүүдэлчин удмын авхайд нэн ховорхон олдох завшаан байсан билээ. Ану хатан:

-Ижий маань Турфан, Хамигаас шинэ жимс эсгийд боолгон авчруулдаг ч ихэнх нь замдаа муудаж ялзарсан байдаг байж билээ. Тэгээд ижий багадаа Ижилийн тэртээх нутагтаа час улаан алим туйван туйвангаар нь иддэг байснаа надад ярьдаг сан. Энэ тарвас чинь чихэрлэг, шүүс ихтэй хэчнээн сайхан амттай юм бэ? хэмээн шагшин идэхийг Галдан өхөөрдөнгүй ажиглан халуун цай оочлонгоо гэрийн эзэнтэй удахгүй хураах ургацын тухайд хөөрөлдөх аж.

Буцах замдаа Галдан тарианы газраа хатандаа үзүүлж, ордноос гарган салхилуулж сэтгэлийг нь баясгасандаа их л хөгжүүн явсан агаад нар бороо ээлжилсэн сайхан зун болсны ачаар энэ жилийн ургац урьд урьдынхаас арвин байх төлөвтэй хэмээн Хожа өвгөний хэлсэнд бүүр ч сэтгэл хангалуун байлаа.

-Тээр тэнд ногоорон буй хөндийд бас ногоо тариалж буй юм. Аавын минь үүсгэсэн үйлс юм даа. Өчүүхэн миний хувьд ухаан уужуу, бодол тавиун эцгийн эхэлснийг үргэлжлүүлж явах нь л эрхэм юм. Хүнс арвин базааж, цэргийн хүчээ зузааруулж байж л сая зүг зүг рүү харцгаасан олон овог аймгуудыг хурааж Зүүнгар улсыг түвшитгэх аян дайнд мордох болно шүү дээ хэмээн алсыг ширтэн ярихыг Ану чимээгүйхэн сонсохдоо дотроо “Бас л дайн өдөөх тухай ярих юм” хэмээн сэтгэл хөндүүр байлаа. Ануд омог бардам, зориг шийдэмгий энэ Галдан хаан, хайрыг нь булаасан эр нөхөр нь хэдхэн сарын өмнө номт хувцас эгэлдрэглэн, эрхи эргүүлж, ертөнцийг амарлингуйгаар тольдон, түмэн олон шавь нартаа адис авшиг хүртээн нүглийг тэвчин, буян хураахыг номлож асан дөрвөн Ойрадын бурхан шашны тэргүүн явсан гэхэд огт үнэмшмээргүй санагдана.

-Та сахилаа орхин, бурхан номын гэгээн үйлсээс хөндийрч нүгэлт орчлонгийн эргүүлэгт татагдан орсондоо харамсдаг уу? хэмээн Ану нэг л мэдэхэд асуучихсан байлаа.

-Харамсаад ч яах юм билээ. Төөрөг тавилан ингэж л зурагдсан юм байлгүй дээ. Уг нь би багадаа сахил хүртэж шавилан суух дургүй, эцгийн шийрийг хатааж сэлэм эргүүлсэн Эсэн хутагт мэт домогт баатар эр болохыг л хүсдэг байсан даа гэж Галдан хэлэв. Чингээд хатандаа юуны түрүүнд Алтайн урианхай, Тагнын урианхайг Зүүнгарын улсдаа нэгтгэхээр цагаан сарын дараа урин цагийг угтан цэрэглэх бодолтой буйгаа ярив.

Намрын эхэн сар гарлаа. Эр нөхөр нь арвай будаа, идэшний ногооны ургац хурааж буй тарианы газар руу одоод Ану цагаан булган өргөөндөө эцэгтээ захидал бичин хоймрын цагаан хаш ширээний өр дээр баруун гартаа бийрээ барьж, зүүн шанаагаа тулаад сууж байлаа.

Эцгийн бие лагшин ойрын үед чилээрхүү байгааг төрхөмийн тэндээс ирсэн элчээс сонордсон тул даралт бууруулах улаан чавгатай амтат цайны хамт, хадмын газар одсон надад санаа бүү зовоорой, Юань гүрний түүхийг уншин, шинэ орд өргөөндөө идээшин тухтай сайн сууж байна гэхчлэн захидалдаа бичээд эр нөхөр нь сайн дураар захиргаанд нь ороогүй Ойрадын овог аймгуудыг зэвсгийн хүчээр хураан авахаар цэргээ бэлтгэн, хүнсний нөөц базааж буй тухай эцэгтээ дуулгах эсэхийг удтал бодон эргэлзсэний эцэст түдгэлзэхээр шийдэв. Хэдийгээр Ану эцгийн хайртай охин үр ч гэсэн өдгөө цоросын бэр болон одож, Галдан хааны хатан болсон тул Ховог сайрын ордны дотоод үйл явдлыг илүү хошуулан төрхөмдөө дуулгах нь асралт бэрийн ёсонд үл нийцэх тул ийнхүү түдгэлзжээ. Хошуудын тайж, ноёд, тэдний тэргүүн эцэг нь яаран Галданд дагаар орох бодолгүй, харин ч дөрвөн

Ойрадыг нэгтгэн гартаа оруулж, нэгдсэн төр улс байгуулах эр нөхрийнх нь зорилго яваандаа дөрвөн Ойрадын холбоо, чуулгантай тэрсэлдэх нь зайлшгүйд бүсгүйн сэтгэл ихэд чилүүрдэн зовниж байлаа. Нэг талд дөрвөн Ойрадын чуулганы хан хайрт эцэг, уугуул хошууд аймаг нь нөгөө талд үүрдийн гэр орон нь болсон цоросын эрх ашиг, Зүүнгарын нэгдсэн төрт улс бий болгох гэсэн эр нөхрийнх нь хэтийн зорилго хоёр харшлах болсонд бүсгүйн сэтгэл өгүүлшгүй ихээр хямарч суугааг хэн ч үл ойлгох аж.

Чингээд дэргэдийн хиагаа хонхдон Балсанг, эцгийн элч Дугаррагчаа хиагийн хамт өргөөндөө дуудахыг зарлигдаад бодолд дарагдан суухад, дэрний уут хатгамалдан буй Мандарваа эзэн хатны зүг хулгай харц илгээн “Яагаад ийнхүү баргар байгаа юм бол? Галдан хаан тарианы газар одоод гурав хонож байгаад санаж үгүйлээ юу? Ойрдоо бас хоол унданд төдгүй болсон байх юм. Ер нь л хатан маань Хөх нуур, Эмильд төрхөмдөө сууж байснаасаа хоромхон зуурд их л өөрчлөгджээ” хэмээн өөрийнхөө охорхон ухааны хэрээр бодолд ээрэгдэнэ.

Гадаа баатар эрийн хуяг, зэр зэвсэг харшилдах чимээ гарч, Балсан, Очирт цэцэн ханы элч Дугаррагчаагийн хамт орж ирээд аргалын дөрөлжний хавьцаа зогтусан мэхэсхийж эзэн хатны амгаланг эрцгээв.

-Тийшээ сууж цай ууцгаа. Би аавд өчүүхэн захидал бичлээ. Даралт, зүрхний хуучид сайн хэмээн улаан чавганы хандтай нанхиад цайны хамт төрхөмдөө илгээе. Намайг сайн сууж, шинэ орд өргөөндөө идээшин буйг ижий, аав, өрлөг Даадаад минь дуулгагтун гээд Ану бийр, янтайгаа урдаасаа холдуулан түлхээд чигээ залгилав. Түүний төрхөмөөс дагалдан ирсэн шивэгчин Дархижав Дугаррагчаатай танимхайран сүйд болж, ар гэрийнхний амар мэндийг эрэх зуур сарлагийн өрөм, самнаа боов тавьсан уран сийлбэрт гуулин цар тавьж, аагтай хонгор цайгаар зочлов.

-Балсан чи Дугаррагчааг зүүн булангийн Улаан хадтай онь хөтөл хүртэл гаргаж өгөөд ир. Үдийн хойхно хамтдаа Шанхын горхи тийш цэргийн бэлтгэл дээр очье гэж Ану хэлэв.

Харин энэ үеэр Юм-Агас хатан дэргэдийн шадар хэвтүүл Буянтөмөрөө дуудан авчраад худын талаас ирсэн элчид бэрийн дайсан захидлыг булаан үзэх зүс буруулсан хувцаст хоёр хүнийг эчнээ араас нь явуулахыг тушааж байв.

“Өнөөдөртөө хошуудын Очирт цэцэн эр нөхрийн минь анд, шинэхэн худ ургийн хувьд хань нөхөр мэт байгаа ч цаашдаа юу ч болоо билээ? Хүүгийн хуримд Багабанди ганцхан удаа үзэгдсэн. Цөхүр увш тэр хоёр Эмилийн тийш Очирт цэцний харалдаа бараглан саахалт буусан сурагтай. Энэ чинь өөрийн биеийг цорос аймгийн хамгийн ахмад нь хэмээн ихэрхдэг хөгшин Цөхүр, хошуудын тэргүүн, хашир чоно Очирт цэцэн худтай холбоотон болж, цаашид Галдан хүүгийн минь эсрэг нэгдэхийн цондон бус уу? Тэгтэл бэр маань хадмын газар ирэнгүүт ийнхүү сэжигтэйгээр төрхөмтэйгээ бичиг захидлаар харилцахдаа хэдхэн сарын дараа эр нөхрөө Алтай, Тагнын урианхайг дайлахаар эр цэргээ яаравчлан бэлтгэж буй тухай эцэгтээ хэл мэдээ дуулгасан эсэхийг мэдэх хэрэгтэй” хэмээн хашир ухаандаа тунгааж суулаа. Гэхдээ бүүр сахил санваартай хувилгаан лам байх ахуйдаа Ануд сэтгэл зүрхээ өгсөн Галдан хүүдээ энэ тухай өчүүхэн ч сэжүүр мэдэгдэхгүйгээр үйлдэхийг Буянтөмөрт чандлан захиад гаргалаа.

...Торгуудын ихэс дээдсийн охин Юм-Агас хатныг алс Ижилийн тэртээгээс Ховог сайрт

цоросын бэр болж ирэхэд нь бүрлээч Баатар хунтайж энэ Буянтөмөрийг хатныхаа өргөөний амь сахигч хишигтэн цэргийн ахлагчаар тавьж билээ. Тэгэхэд арван наймтай Юм-Агастай насаар ойролцоо дөнгөж хорь шүргэж явсан цөс ихт цорос залуу өнөөг хүртэл эзэн хатандаа ийн хоёргүй үнэнчээр алба өргөж яваагийн нэг нууц учиг нь анх Юм-Агасын өргөөнд ирж “хөшиг тайлах” ёслол үйлдэн царайгаа олонд харуулах тэрхэн мөчид л бүсгүйн жоготой харцтай гүн хар нүдэнд нь үйчихээ алдан дурласан ажээ.

Харин Юм-Агас түүнийг удтал эм хүний нүдээр харж байсангүй. Гагцхүү эзэн, барлагийн харилцаатай явсаар ирсэн ч хуримаас арваад жилийн дараа, дөч гарсан Баатар хунтайжийг ес дэх хатнаа буулган авсан хуримын үдэш нь эрээ хардаж, ганцаардан цөхрөхдөө Буянтөмөрт ганцхан удаа өврөө нээчихсэн ажээ. Тэр үдэш... Дөнгөж гуч хүрч, гоо үзэсгэлэн нь улам цэцэглэж явсан Юм-Агас хатан гурван настай Галдан хүүгээ нойрсуулчихаад өнчин дэрэн дээрээ хэсэг уйлан хэвтэж билээ. Ийнхүү эм хүний гоо үзэсгэлэн, шим шүлт бүрэлдэж гүйцэх насандаа эр нөхөртэйгээ энгэр зөрүүлэлгүй хоёр сар өнгөрсөнд цээж давчдан ганцаардлын гунигт автан хэвтэхдээ л гэнэт өөрийг нь ямагт хайрын нүдээр нууцхан ширтэж явдаг Буянтөмөр баатрыг санав. Энэ өргөөнд алсын алс Ижил мөрний тэртээгээс хатан болж ирсэн цагаас хойш эр нөхөртөө үнэнч явсаар ирсний хариуд ийнхүү идэр залуу гучин насандаа өнчин дэр сахин хагсарч хэвтэх гэж үү? гэхээс дэндүү гомдолтой байлаа. Охин биеэ түүнд л өгч, хоёр сайхан нуган үр төрүүлж өгсөн Юм-Агасын энгүй их хайрын хариу энэ үү? Гадаахь хиймэл цөөрөмд шаргал навчис чимээгүйхэн унаж, намрын уй гуниг сэтгэл сэмрүүлсэн энэ үдэш ганцаардлыг нь хуваалцан, халуун амьсгалаараа танхил биеийг нь төөнөн амраглах эр нөхөр нь арван зургаатай залуу охин таалан хэвтэж буй гэхээс бачуурч үхмээр.

Тооноор төгрөг саран авхай шагайсан намрын сүүн цагаан үдэш байв. Баатар хунтайж торгуудын Хоо өрлөгийн охин арван зургаатай Дарь-Увсалжийг хатан буулган авч, хөлгүй их найр хурим үйлдээд, Ховог сайрын ордныхон хавтгайдаа хөлчүүрсэн тэр үдэш эр хүний халуун хайр, хавтай чанга тэврэлтийг үгүйлэн ганихарсан хатантан гэнэт Буянтөмөрийг өргөөндөө дуудмаар санагджээ.

Чингээд Ижилээс дагуулан ирсэн итгэлт өрлөг эхийгээ хишигтэн баатруудын гэр өөд сэмхэн илгээчихээд орноосоо босч, шинэ ягаан хоргой лавшиг, үүлэн хээтэй цагаан магнаг цэгдгээ гарган өмсч, балбын дархны хийцтэй сувд, тана хослуулан урласан шанааны чимэглэл, унжуурган ээмэг гарган зүүж, тольдон гоодож суухдаа сэтгэл нь үл мэдэг догдлон, эр нөхрөөсөө ондоо эр хүнийг анх удаа хүсэмжлэн сэтгэл зүрхэнд нь нэг л уянгалаг хөг аялгуу эгшиглэн байж билээ.

-Ахайтны үдшийн амгаланг айлтгая! гэсээр өндөр сүрлэг нуруутай, дөнгөж гуч шүүрч яваа идэрхэг сайхан эрийг ороод ирэхэд л түүнийг эзэн хатны бус эм хүний шохоорхлын нүдээр анх харжээ... Тэр хоёр, ордны хамгаалалтын шадар зуутын хамгийн итгэлтэй таван хишигтэн эр, хатны төрхөмөөсөө дагуулан авчирсан үнэнч шивэгчин Заяахайг өрлөг эх Балжидмаа самганы хамт гадаа харуулд гаргаад шөнөжин цэнгэлдэн хоносон ажгу.

Балын амтат тэр шөнө хэсэгхэн зуур нам унтаад, үүр тэмдэгрэхэд л сая Юм-Агас сэрж, торгон хөнжлөөрөө хус шиг цагаахан эгмээ далдлан хучаад өндийж, хажууд нь хатгамалтай хоргой дэрэн дээр буурынх мэт сүрлэг том толгойгоо тавиад урьд шөнийн завсаргүй

цэнгэлдээ сульдан нам дугжрах ид гучин насны сайхан эрийг хэсэг зуур ширтсэнээ бугалганых нь овойсон хатуу булчинг зөөлхөн илбээд гүнзгий шүүрс алдсанаа баруун хацар дээр нь үнсэн сэрээжээ.

-Өнгөрсөн үдэш болсон явдал эхний бөгөөд эцсийн удаагийнх болог. Чи бид хоёрын хооронд болсон салхи борооны явдлын нууцыг сүүдэртээ ч өчиж үл болно. Би үүнээс хойш, түүнээс цааш эрдээ үнэнч гэргийн ёсоор амьдарч, үхэн үхтлээ энэ нүглээ наманчлан явах болно. Чингээд хожим эр нөхрийнхөө хойно орох болбоос сахил хүртэн чавганц болно гэж өөртөө андгайлсан. Хэрэв чи энэ тухай сүүдэртээ ч болов ам алдсан байвал үхэж далд орно гэж мэдээрэй хэмээн Юм-Агас урьд шөнө энэ хүнтэй сэтгэл нялхран, үүл борооны явдлыг сульдаж унатлаа хийгээгүй мэт эрслэн тушаасан юм.

-Өчүүхэн боол надад хатан таны зарлигийг аймшиггүйгээр зөрчих бүдүүн зүрх үгүй билээ. Харин ч ангасан зүрхийг минь умдаалсан энэ үдшийн жаргалыг би амьсгал тасартал санан дурсч, таны өргөөний босгоны шороо мэт үргэлжид хамт, исгэрэх сумны тань ир мэт үнэнч явах болно хэмээн Буянтөмөр амлаж байжээ.

Тэгээд Буянтөмөрийг яаран хувцаслангуут хатан ч хөшигний араар орж лавшигаа өмсөөд, гадаа харуулд гарсан шивэгчин, өрлөг эх хоёроо дуудаж, тэр гурвыг энэ үдэш хатны өргөөнд болсон явдлыг үхээд эрлэгт очсон хойноо ч илчлэхгүй байх амыг нь авч, өндөгний цусаар нь тангараг тавиулж билээ.

Тиймээс ч энэ ордны түмэн нууцын нэгэн болсон тэргэл сартай үдшийн тэр тохиолдлыг хэн ч сэжиглээгүй өнгөрсөн агаад, энэхүү явдлын учгийг мэдэх таван баатар эр хожим Баатар хунтайжийн хасагийн хантай хийсэн тулаанд эрсдэхэд дэндүү хашир, алсын хараатай Юм-Агас хатны гар ч давхар оролцсон ажгу.

Энэ явдлаас хойш зургаан жилийн дараа, аргын 1653 онд эр нөхрөө зуурдын өвчнөөр үхмэгц, Юм-Агас хатан тэр үдшийн андгай тангаргаа сахиж эхнэр үсээ авахуулан, хорвоогийн нүглийг тэвчихээр сахил хүртсэний нууцыг мэдэх хүмүүн өдгөө ганцхан энэ Буянтөмөр бөлгөө.

-Жаа, хатантаан.

Зүрх сэтгэлийнх нь эзэн, үзэсгэлэнт хатан ахайтныхаа бэлэглэсэн тэр янагийн үдшээс хойш Буянтөмөр эдүгээг хүртэл эхнэр авсангүй. Юм-Агас ордны аятайхан шивэгчин бүсгүйчүүдээс сорчлон шилж гэргий ав хэмээн Буянтөмөрийг хэд хэдэн удаа ятгасан ч, мань эр нэгэнт сэтгэлийн угаас хайрлан энхрийлж чадахгүйгээс хойш хүний бүсгүй үрийг зовоогоод юуны хэрэг хэмээгээд ганц биеэр энэ хорвоог туулахаар шийдсэн ажээ.

Буянтөмөрийн илгээсэн хоёр баатар эр уйгар янзаар хувцаслан зүс буруулаад, Улаан хадны хөтөл дээрээс Балсанг буцсаны хойно Очирт цэцэн ханы элчийг гэнэт уулгалан дайрч, Ану хатны захидлыг олзлон авч Юм-Агас ахайтны бичээчид уншуулсан ч сэжигтэй юм юу ч гарсангүй тул элчийн нүдний боодлыг тайлаад буцаан явуулжээ.

Ану хатны даалгавраар хуучин хан эзнийхээ элчийг Улаан хадны хөтөл дээр үдчихээд буцаж

буй дүр үзүүлэн далдуур басхүү гурван тандуул тавьсан Балсан уйгар хувцастай, үл танигдах хүмүүс захидлыг олзлон уншаад буцааж өгснийг ч мэдэж аваад эзэн ахайтандаа илтгэхээр ордны хэрэм тийш морины хурдаар довтолголоо.

Тийнхүү Балсанг түгшүүрт мэдээтэй хурдлан давхиж ирэхэд хатны шинэхэн гоёмсог өргөөний хавиар хөл үймээн дэгдэж, үүдэнд нь дээс татсан байх агаад хадам эх Юм-Агас ахайтан нь Асралт шивэгчнээ дагуулан айсуй үзэгдэхэд гайхасхийн, орохоос түдгэлзэн хүлээзнэхээр шийдэв. Удалгүй бас ордны тэргүүн маарамба Дүвчин, залуухан шавь Гомборавдангаа дагуулан хатны өргөө рүү орчихлоо.

Учир юун гэвээс эцэгтээ захидал илгээчихээд бага үдийн умдаа хүртэх гэж байсан залуу хатан гэнэт өргөөндөө мууран унасан юм байж.

Найман ханат их өргөөний зүүн талд инжиндээ авчирсан цагаан хаш чимэглэлт өргөн орон дээрээ цонхийж цайчихсан хэвтээ хатны өмнө явган сандайлга дээр суун судсыг нь чагнаж гүйцсэн маарамбаган шарласан шүд гарган инээмсэглээд хадам эх Юм-Агас ахайтны зүг харж:

-Залуу хатантан хөл хүнд болжээ. Дөнгөж сар л болж буй болов уу. Та ойрын үед морь унаж хамаагүй бүү давхиарай. Биеэ хямгадах хэрэгтэй гэлээ. Магнаг хөнжлөөр хучуулан, мэлмийгээ анин, урт сормуус буулган хэвтэх Ану маарамбын үгийг сонсоод нүдээ нээж, хадам эхийн зүг хараад өндийж:

-Ижий минь! Юутай баяртай үг вэ? Нуган үр төрүүлнэ гэдгээ би мэдээд байна. Галдан хаанд дуулга гээд зүүн хөмсгөө өргөн Мандарваа, Дархижав, маарамба, хадам эх дөрвийг тойруулан хараад босохоор ухасхийхэд дөнгөж саяхан бэрээ хардаж, эцэгтээ илгээсэн бичиг захидлыг нь уулгалан булааж, уншуулсандаа гэмшин харц доогуурхан суусан Юм-Агас яаран орных нь дэргэд ирж сандайлан суугаад түүнийг буцаан хэвтүүлж санчигных нь үсийг илэн засах зуур:

-Тийм ээ. Үнэхээр сайхан мэдээ байна. Чамаас төрөх хүүхэд охин үр ч байсан сайхан шүү дээ. Та хоёр залуу улс. Дахиад хэчнээн ч үр хүүхэдтэй болоо билээ. Охин минь, чи одоо биеэ хайрла, хямгад. Маарамбын үгийг сонс. Би тарианы газар тийш Галдан хүүдээ элч илгээе. Царай тань цонхигор байна. Маарамба та, бэрд минь тан хүртээ. Хордлого ихтэй байх шиг байна гэлээ. Маарамба ч манхагаа ухан тан гаргах зуур:

-Жа тэгье, ахайтан минь. Цус багатай, ядруу байна. Ураг зулбах магад. Судасны цохилт нь сульдуу байх юм. Цус сэлбэх төмрийн агуулга ихтэй улаан тан хүртээе. Арав хоногийн турш тан хүртэхдээ хөдөлгөөн хязгаарлаж, толгой түрүү, гар хөлнөөс салхи авалгүй гам сахих нь зүй. Хонины элэг шүүрхий шарж, сорс хийж идүүлж бай гэхчлэн баахан заавар өгөөд, тан орхиод явжээ.

-Ану, охин минь эр хүн шиг цэргийн эрдмээр хөөцөлдөх, морь унан давхих дуртайг чинь би мэднэ. Өнөөдөр үдээс хойно Шанхын горхи өөд цэргийн бэлтгэлийн газар эргэх бодлоо орхигтун хэмээн Юм-Агас хэлээд Мандарваад “Чи өдгөө эзэн хатнаасаа гадна миний үр удам болж мэндлэх ачийг минь бас харгалзан асрах үүрэгтэй боллоо. Хатныг тан хүртсэнийх нь дараа хэвтүүлж сайтар асар. Тан хүртээд хөлөрч, сульдах тул хэсэг хэвтүүлэхэд гэмгүй”



хэмээн заавардаад гарав.

Тарианы газраа эргэх зуур, өөрт нь төлдөрхөн дагаар ирсэн торгуудын Гомбо ноёнд намаржааны нутаг зааж өгөнгөө уулзахаар цааш хөдөлсөн Галдан хаан ч ордны зүгээс буухиалан довтолгосон элчээс хатныхаа хөл хүндтэй болсны баярт мэдээг дуулаад тэр оройдоо нар шингэхийн өмнөхөн яаравчлан ордондоо буцаж иржээ.

Эр нөхрөө барааны газар айсууг дуулаад, усан жороо хээр морио унан хэрмийн гадаа тосохоор яаран боссон Ануг Мандарваа хорьж:

-Таныг тангаа хүртээд гам сахих хэрэгтэй гэж маарамба зааварласан. Мөн тан уусны тань дараа хэвтүүлж бай хэмээн ахайтан зарлигдсаныг та сонссон шүү дээ. Хэрэв та үгийг минь дуулгахгүй бол би Юм-Агас ахайтанд хэл өгөх болно шүү гэж Мандарваа дургүйцлээ.

-Ухай, чи хадам ижийд хов хүргэх нүү? Эр нөхөртөө удам залгах хүү төрүүлж өгнө. Хөөрхөн нялх үртэй болох нь хэмээн баярлаж байсан чинь хөл хориотой гэмтэн мэт болох нээ. Чи хүртэл намайг хадам ижийд ховлоно гэдэг юу гэсэн үг билээ. Хөл хүнд болохоос би чинь эрүүл саруул, зарим нэгэн эрээс ч илүү эршүүд хүн биш үү? хэмээн Ану ундууцсан ч арга буюу шивэгчнийхээ үгэнд орж, магнаг хөнжлөө нөмрөн гадаа хөлийн чимээ гарч хайртыгаа орж ирэхийг хүлээж догдлон хэвтлээ.

Тийнхүү хэвтэх зуур Балсангийн түрүүхэн өчсөн явдлын тухайд эргэцүүлэн бодож “Аавд бичсэн миний захидлыг замаас нь булаан авч үзэх хэрэг хэнд байдаг байна? Хөх нуур тийш нүүсэн зарим ноёдын тандуул гэвэл Галдан хааныг гэхээс өчүүхэн эм миний бичиг захидлаас юугаа эрэх вэ? Эс бөгөөс энэ ордны дотроос гарсан явуулга уу? Сэнгэ хаантны татвар байгаад нэг хэсэг намайг энд ирэх хүртэл Галданг зугаацуулж байсан Жасмин одоо энд үгүй. Түүний ард хиргис, уйгар ноёд байсан л байх. Гэтэл одоо түүнийг Данжилад өгч зайлуулсан шүү дээ. Эсвэл, эсвэл...арай ч хадам эх минь ингэмээргүй. Гэвч тэр чинь ижийн минь хэлснээр “Юм-Агас ахайтан гэж гэмгүй царайлж байгаад бурхан болсон Баатар хунтайжийн арван хатны дотроос хайрыг нь онцгойлон татаж чадаад, их хүү нь эцгийн ор залгамжилдаг ёсыг тэрслэн тав, зургадугаар хөвгүүд нь болсон Сэнгэ, Галдан хоёроо цоросын эзэн болгож дөнгөсөн овгой эм” биш гэж үү? Энэ тухай одоогоор юу ч гэсэн таг чимээгүй өнгөрвөөс дээр болов уу? Хэрэв энэ тухай эр нөхөртөө хэлчих аваас элдвийн хүмүүсийг асуун байцааж, ордонд хэрүүл маргаан, хэл ам дэгдээх болно. Түрүүхэн миний бие муудлаа гэж дуудуулахад өргөөний босгоор алхахдаа хадмын байдал урьдынхаас өөр, гэмшсэн ч юм шиг, гэмгүй царайлсан ч юм шиг нэг л биш байсан даа. “За үр минь, аливаа ордон гадна өнгөндөө амгалангаар оршивч, цаанаа дотоод хэл ам, хэрүүл тэмцэл, хов жив, хорт явуулганд умбаж байдгийг бүү март. Хана, хаалга хүртэл нүдтэй чихтэй. Хамжааргагүй хэлсэн үг бүр тань дайсны тавьсан гилбэрт сум мэт чам руу чиглэнэ гэдгийг бүү мартаарай. Цайлган, эршүүд зангаа төрхөмдөө орхиод мордоорой доо.” хэмээн ижий нь түүнийг хадамд мордохын өмнөх нэгэн үдэш гэзгийг нь самнаж суухдаа хэлж захисныг бүсгүй эргэн саналаа.

Тэгтэл гадаа олон хүмүүний хөлийн чимээ гарч :

-Ижийд намайг маргааш бараалхана хэмээн дуулга гэх эр нөхрийнх нь баргил дуу хадахад бүсгүй бодлын манангаас дуртайяа сугаран өндийлөө.

-Алив, миний хайрт хөл хүнд болсон гэв үү? Юутай баяртай хэрэг вэ! гэсээр Галдан Ану руу хүрч ирээд цээжиндээ тэврэн авлаа.

-Та минь сайн явж байна уу? Гуравхан хоног бүтэн жил мэт удах шиг санагдах юм. Би таныг бэтгэртлээ хүлээлээ гэж Ану шивнэн түүнийхээ энгэрт наалдаж, аяны шороо, хээрийн салхитай холилдсон танил дотно үнэрийг нь шунаглан сороход Галдан том зөөлөн алгаараа шанхных нь үсийг энхрийлэн илж, эрүүг нь өлийлгөн уруул дээр нь озон үнсээд царайг нь нэг сайн харснаа хэвлий дээр нь гараа тавьж:

-Энд миний үр үндэс, надаас хойш газар тамгалах үр минь буй гэж үү? гээд толгой сэгсрэн дуулгаа авч үхэг дээр тавих зуур:

-Цастын оронд, чанд хатуу Дашлхүмбийн хийдэд шавилан суухдаа хожим хойно ийн үр үндсээ үлдээхийн чинээ санасангүй. Чамдаа би хэчнээн хайртай юм бэ дээ гэхэд Ану түүнийхээ гөхөл үсийг энхрийлэн илж инээмсэглэн:

-Үдийн хойно цэргийн бэлтгэлийг очиж үзэнгээ ганц нэг сум тавьюу гэж байтал ийм болсноо мэдлээ. Даанч ойрмогхоноос махан хоолонд дуршилгүй болсноо би гайхаад байсан юм аа. Чигээнд тийм дурладаггүй атал юм л бол исгэлэн хүйтэн чигээ уумаар хорхой хөдлөн хоёр жавьжны шүлс асгараад байсан чинь хөл хүнд хүн тэгж гашуун, нясуун идээнд дурладаг юм гэж ижий хэллээ. Одоо ингээд морь унаж, салхинд гарч ч болохгүй, өргөөнд хориотой гэмтэн мэт суух нь уйтай л юм даа хэмээн гоморхлоо.

-Тэгж болохгүй! Маарамбын үгнээс бүү гарагтун. Энд миний үр байгааг бүү умарт гээд Галдан хэвлийг нь илсээр байхад Ану дүрсгүйтэн тас тас хөхөрч:

-Одоо махан бие нь бүрэлдээ ч үгүй, өчүүхэн улаан нөж л байгаа шүү дээ. Гэтэл би өмнөхийн адил морь унан давхиж, цэргийн бэлтгэл, тарианыг газрыг эргэмээр байх юм. Эм хүн байх ч бэрх юм аа гэлээ.

-Хэдхэн сарын дараа хөнгөрчихөөд л чи минь урьдынхаараа дуртай хүлгээ барин унаж, хүссэн газартаа очиж болно шүү дээ хэмээн Галдан аргадаж билээ.

Тэр үдэшдээ Галдан хатныхаа өргөөнөөс гарсангүй. Шөнөжин хоёулаа эрхлэлдэн ноололдож, хойч ирээдүйн талаар ярилцан хонов.

Маргааш нь Галданг эхийнхээ өргөөнд дуудуулан байж очиход үртэй болж буй магнай хагарам үйл явдлын баярыг хуваалцан, хадмынх нь тэндээс Ануд захидал ирж, амрыг нь эрсэн, Очирт цэцэн ханы бие чилээрхүү байгаа гэхчлэн сонин хачныг хүүрнэсний эцэст Юм-Агас нэгэн ноцтой яриа хөнджээ.

Энэ нь ах Сэнгийнх нь үхэлд хуруу дүрсэн нь илт авга Цөхүр увш, хүү Багабандийн хамт Эмильд суугаа Очирт цэцэн ханыг бараадан буусан нь алсдаа тэд хамтдаа Галдангийн эсрэг зогсох холбоотон болж буйн дохио. Тиймээс хадмын өргөөнөөс нутаг холдон нэг хэсэгтээ Ховог сайрын ордныг орхин нүүх нь зүйтэйг эх нь сануулсан явдал байлаа.

Тийм ээ. Юм-Агас хатан ямагт ийнхүү хол ойрыг эргэцүүлэн бодсон шийд гаргадаг ухаан холч хүн. Галдангийн хадам эцэг зөвхөн Цөхүр увштай нам нийлээд байгаад ч гол учир байгаа юм биш, Эсэн тайшаас хойш эргэж нэгдэж чадаагүй Зүүнгарын нэгдсэн төр улсыг нэгэн гарт оруулан захирах гэсэн Галдангийн зорилго дөрвөн Ойрадын холбоог үгүйсгэх агаад, эл чуулганы хан Очирт цэцний суудал үгүй болж, хүч нөлөөгөө алдах нь тодорхой. Иймээс яваандаа хадам эцэг нь Галдангийн дайсан болох нь илт гэдгийг Галдан ойлгож байлаа.

-Ануг хөл хүндтэй байхад их нүүдэл хийх нь зохимжгүй юм даа. Ер нь ч ордныг хүрээлсэн тоосгон хэрэм зарим хэсгээрээ элэгдэн нурж, Дотоод ордны дээврээс хуртайд дусаал гоожих нь их болсон тул хөрөнгө төвлөрүүлэн засвар хийж, шинэ орд барьж байгуулах бодол надад байсан юм. Дараа хавар шинэ орд өргөө байгуулах нутаг сонгоод зуны эхээр нүүвэл ямар? хэмээн Галдан эхтэйгээ зөвшилцөхдөө хатныхаа сэтгэлд юм хийлгүйгээр хадам эцэгтэй харилцах харилцаагаа хэрхэн тайлбарлахаа бодож суулаа.

-Тэгье ээ. Энэ орд өргөөний эзэн, нэгтгэн хурааж буй Зүүнгар улсын хааны хувьд эцсийн шийд чиний гарт шүү дээ, хүү минь. Харин Ануд одоохондоо энэ тухай цухуйлгаад дэмий биз дээ. Бичиг үсэгт гаргуун, биеэ эр хүн шиг авч явдаг, дэндүү шийдмэг энэ бүсгүй яваандаа төрийн хэрэгт тэнь хэтийдэн оролцоод байх юуны магад. Ер нь ч тэгээд бөөр нь бөгсөндөө, цэр нь цээжиндээ байвал амар байдаг хэмээн дотроо бодож явдаг санаагаа хөвөнд боосон чулуу мэтээр хүүдээ эвтэйхэн цухалзуулаад авлаа.

Энэ үгийг сонсоод Галдан царай барайлган хөмсөг зангидлаа. Хос залуусын зүү орох завсаргүй эвтэй харилцаанд сэв оруулах анхны үрийг ийнхүү хатан эх нь тавьсныг харин тэр гадарласангүй.

## Арвантавдугаар бүлэг

Аргын 1672 он гарлаа. Үүнээс гучин есөн жилийн тэртээ бичин жил Цахарын Лигдэн хаан манжид цохигдсоноор Их Монгол улсын төр бутран унаж, Юань гүрний үеэс уламжлан ирсэн Хубилай цэцэн хааны хасбуу тамга эдүгээгийн Энх-Амгалан \Сюанье\ хааны дээд өвөг Абахайн гарт орж, ертөнцийг хагасыг эрхшээж явсан монгол угсаатны төр улс мөхлийн замдаа ороод байхад, Манж Чин улс өглөө хөөрч буй наран адил өдрөөс өдөрт хүчирхэгжин мандаж байсан цаг. Арван жилийн өмнө Манж\* Чин гүрний хаан ширээнд долоон насандаа суусан Энх-Амгалан хаан өөрийнх нь нэрээр төрийн эрхийг барьсан Ообой ноёныг авгай ахтайгаа хавсран түлхэж унагаад хоёр жил болж байв. Дөнгөж арван долоо хүрч байсан Энх-Амгалан хааны нэрээр авга ах Сонготу төр барьж, өвөрлөгч нарын дараагаар Халхыг дотроос нь хагалах, цол хэргэм, бэлэг сэлтээр ноёд ихэсийг угжих башир аргаар Монголыг бүрэн “идэх” эхлэл тавигдаж байлаа.

Ану цорост бэрлэн ирсний дараахь анхны цагаан сар. Хөл хүндтэй Ану өвлийн тэсгим хүйтнээр орд өргөөнөөсөө бараг л толгой үл цухуйлган, их тулганд аргал, харгана өрдсөн дулаахан гэртээ Манж чин гүрний түүхийн бичиглэлийг уншин, Ховог сайрын ордны номын өргөөн дэх олон ховор сонин ном судрыг бүртгэх зэргээр сатаарсаар хаврын тэргүүн сартай золгов. Хоёрхон настайгаасаа хүлэг сайн морины нуруунд анхлан мордож, ид хаваа гайхуулан цавчилдах, харвах эрдэм заалган, хөдөөгийн уул талаар салхи мэт эрх дураар дарцаглаж явсан Ану ийнхүү хадмын газар ирээд, бэрийн сахих элдэв ёс заншилд хүлэгдэн, хөх тоосгон хэрмийн дотор хөл хоригдон сууж, өдрөөс өдөрт гоо биеийг нь эвдэн томрох гэдсэндээ түүртэн байхтай эвлэрнэ гэдэг тийм ч амаргүй байв. Хайртай хүнийхээ удам угсааг үргэлжлүүлэх үртэй болсноо мэдээд баярлан догдолж асан эхний мөчүүд өнгөрөх тусам эрүүл чийрэг бие нь гэнэтийн энэ хувирал, өөрчлөлт, дотор нь үүсээд буй нэгэн шинэ махбодийн түрэмгийлэлтэй чадлын хэрээр тэмцэх мэт ямагт тархи толгой нь эргэн, хоол хүнсний үнэрээс дайжин, энэ нэгэн хэмийн амьдралыг орхиж, ертөнцийн хязгаар хүртэл ганцаар давхин одох буюу даль жигүүртэй сэн бол хязгааргүй уудам огторгуйн мандалд халин нисмээр ч юм шиг сэтгэл санаа нь тогтворгүйтэн жирэмсний хордлогоор гурван сар гаруй тарчилжээ.

Тэгсээр хэвлий дэх үр нь сарын өмнөөс хөдлөх болж, гэдэс нь мэдэгдэхүйц томорсон хойно сая л нэг хордлого илаар болж сэтгэл тэнийв. Ийнхүү хөл хүндэрсэн эхний гурван сарын аймшигтай хордлого аажимдаа саарч, хүүхэд нь хөдөлж эхэлснээс хойш бие махбодь нь илүү амарлингуй болсон ч хэвлийд нь үүссэн тэр харь хөндлөнгийн биет болсон үр хүүхэддээ дөнгөж саяхнаас л ээнэгшин дасч эхэлжээ.

Битүүлгийн өмнөх өдрүүдэд Ховог сайрын ордны дотоод хэргийг гартаа атгасан Юм-Агас ахайтан их бойдаа Жамсрангийн хамт “Гэр гүвэх” үйлийг эхлүүлж зарц барлагуудыг цуглуулан их хэрэм доторхи хогийг нэгд нэгэнгүй цэвэрлүүлэн, орд, өргөөнүүдийн тоос шороог арчуулж, дэвсгэр, ширдэг, өнгийн хивснүүдийг гүвүүлж гарлаа. Энэ нь хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг уур унтуу, хир буртаг, хог шороогүй угтдаг монгол туургатны нэгэн сайхан заншил ажгу. Ийнхүү өвлийн адаг сарын хорин есөнд Ховог сайрын ордон хур их хог шорооноосоо салж, гадна, доторгүй цэмцийж, овоорсон их хогийг өөх тосны үлдэгдэлтэй холин шатааж “хиншүү” ханхлуулан байснаа уламжлал ёсоор наран жаргах зүгт

үнсгийг нь аваачиж хаяв. Ийнхүү өнгөрөн одсон хуучин оны хур хогтой хамт тэр жилийн муу муухайг зайлуулан холдуулдаг хэмээн монголчууд үздэг билээ.

Олон жилийн өмнө сахил хүртэн, энэ ертөнцийн элдэв явдлаас холдоод ордон өргөөний дотоод үйлийг эрхлэхээс өөр санаа тавих, сатаарах юмгүй болсон хөөрхий хөгшин ахайтны хэрэгт Галдан хаан, Ану хатан хоёр ч үл оролцон зөнгөөр нь орхихыг илүүд үзсэн ажээ.

Чингээд шинэ сар гарахын өмнөх үдэш тарган иргийн баруун хаа, хуйхалсан өвчүү чанаж, үлдсэн махыг нь модон тэвшинд тавьж “сацлын махан” бэлтгэдэг агаад үүнийгээ шинийн нэгний өглөө овоо индрээ тахихдаа галдаа өргөдөг аж.

Хаврын тэргүүн сарын шинийн нэгний өглөө Ойрадуудын заншлаар ордныг хүрээлсэн их хэрмээс урагш орших багашиг толгой дээр байх овоо индэр өөд нар битүүгээр өргөө хотлоороо хөдөлцгөөв. Ингээд наран ургахтай уралдан овоондоо чулуу овоолон шинэчлэн засаад гал асаан, “заваа залам” хэмээх таван өнгийн бөс даавуу, хадаг, халуун хошуут мал, цагаан хонины ноосны хамт харганад бэхлэн хатгаад “Дээр мөргөх” хэмээх мөргөл эхлэхэд наран авхай баруунаас мандаж байлуга. Чингээд Галдан хаан өөрөө хангай дэлхийгээ аргадах тарни уншсаны дараа, Алтан угалзын хийдээс залагдан ирсэн хамба ламтан Ваанчиг гавьж, Ховог сайрын өргөөн дэх мөргөлийн дацангийн ширээт Ялгуусан лам тэргүүтэн санваартнууд их уншлагаа эхлэв. Уншлагын дараа овооны ич этгээдэд өрдсөн их галд том цартай тахилын идээ, асар том модон тэвштэй өнөөх “Сацлын махан”-аа өргөөд хотлоороо овоо-индрээ нар зөв гурав тойрч, мөргөн залбирцгаав. Хошууд элхэний ёсонд овоо индэрээ махаар тахих бүү хэл, гал голомтныхоо галд ч “Улаан идээ” хэмээх махны зүйл оруулах нь цээртэй тул Анугийн хувьд өчигдөр үдшийн бэлтгэсэн том модон тэвш дүүрэн “Сацлын махан”-г ийнхүү овоо тахилгын галд өргөж буй нь нэн гайхалтай заншил байлаа.

Дээд хурмаст хөх тэнгэр, Баян алтай, хангай, Цагаан аав-аа дуудан гарч буй хөх хулгана жилдээ Ховог сайрын орд өргөө, бүхэл Зүүнгар улс даяараа энх амгалан, эрүүл эсэн оршиж, хур бороо элбэг, мал сүрэг өсч, газрын шим их, ургац арвин байхын ерөөл талбин залбирцгаах зуур Галдан дэргэдээ зогсоо хатнаа таалан харж, дөрвөн жилийн өмнө туулай жилийн өвөл Хөх нуурт эцгийнх нь өргөөнд учирч байхад сэтгэлд нь хадагдсан цасан цагаан үнэгэн малгай дороос оч хаялан гялалзсан нүдтэй үзэмж төгөлдөр сэвгэр ийнхүү хатан нь болоод үрийг нь хэвлийдээ тээж, овоо индрээ хамтдаа тахиж буй нь зүүд мэт санагдана. Ану хатан хадмын газарт угтаж буй анхны сар шинийн ёслол, овоо индрийн тахилгад зориулан хийлгэсэн мөнгөн сортой хар үнэгэн малгай, хар булган хүрэмтэй, халиу нударга\* ухаа ягаан дээл өмссөн нь Галданд пансан алсуур бэлэглэж явсан бяцхан сэвгэрээс илүү буурь сууж, хатан хүний намба төгөлдөр харагдах ажээ.

Мөргөл төгссөний дараа Галдан гэргийнхээ дэргэд ирж дээлийн халиу нударга дотор халуу дүүгэн буй жижигхэн алгыг нь энхрийлэн илбээд нүд рүү нь хайр бялхсан харцаар ширтэн:

-Чи минь жиндээгүй биз? хэмээн халамжлахад Ану хариу инээж:

-Ердөө даараагүй. Миний гар хав халуун байгаа биз дээ? Харин “Сацалын махан” галд өргөдөг нь таатай санагдахгүй юм. Учир юун гэвэл манай хошуудад галдаа мах оруулахыг цээрлэдэг шүү дээ.

-Тийм гэсэн. Цорос аймгийнхан бол галдаа, Цагаан аавдаа махаар тахил өргөдөг заншилтай. Чи минь нэгэнт цоросын бэр болсон болохоор өөрийгөө цорос хүн болсон гэж мэдтүгэй. Тиймд манай ёс заншилд суралцах нь зүй болж дээ.

-Тэгэлгүй яахав. Гэсэн ч бүсгүй дотроо бол “Чи минь цоросын бэр болсон болохоор өөрийгөө цорос хүн болсон гэж бод” гэсэн эр нөхрийнхөө үгийг хүлцэнгүйгээр хүлээн авч огтхон ч чадахгүй байлуга. Учир нь тэр бол хошуудын хан хүний үр. Хавт хасарын удам хойч болсон энэ овог аймгийн тэргүүний гал голомтод мэндэлж, ёс заншил, бахархал бахдалыг нь цусандаа шингээж, тархиндаа угжуулж өсчихөөд харийн бэр болмогц тэр аймгийнхаа хүн болж төрөлх овог аймгаасаа эгүүрд нүүр буруулна гэдэг удам судраасаа татгалзаж буй мэт санагдуулна. Гэтэл бүсгүй хүн эцгийн төрхөмд мэндлээд эр нөхөр даган хүний хүн болдог тавилан заяанд төрсөн бус уу?

-За чи минь үхэг тэргэнээ суу. Хөл хүнд хүн чингэж удаан хөл дээрээ зогсч үл болно гээд Галдан хаан хатнаа сугадан ухаа дээрээс уруудахад нөгөө талаас нь Мандарваа шивэгчин дэмнэлээ.

Тэр хоёрын ийнхүү дотночлон шивнэлдэж инээлдэн зогсохыг харсан Юм-Агас хатан хүүгийнх нь эрх мэдэл ихэсч, санваартны амарлингуй төрхөө гээх тусам “Ану тэгээд, чингээд”, “Анугийн сэтгэлд юм хийчих вий”, “Ану ордны номын сангаас эртний нанхиадын төрт ёсны ном судар олж үзтэл тэгсэн байна гэнэ”, “Юань гүрний хууль цаазаас Зүүнгарын төрд хэрэгтэй тийм цааз зарлиг буйг авч хэрэглэвэл зүй хэмээн Ану өчив” гэхчлэн ярих нь нэмэгдэж эхээсээ аажим аажмаар хөндийрч, эхнэр хатантайгаа улам дотносон, гэргийнхээ эрх нөлөөнд нь хэтийдтэл орж байх шиг бодогдон бяцхан цухалдаж байлаа. Түүнчлэн эр хүн л эмийн өнгийг шилэн таалалдаа нийцүүлэн авдаг байтал Ану хүүг нь аль тэртээ санваартан байх тэр цагаас эхлэн өөртөө татчихаад, дур сэтгэлт хүнтэйгээ хуримлан ийнхүү эм хүнд олдох ёсгүй хувь тохиолоор жаргаж байгаа нь ч түүнд нэгэн бодлын эгдүүцэл төрүүлнэ.

Юм-Агас хатан хэдий ухаантай ч өөрөө эрээ алдаж, хэдийн сахил санваар хүртэн хэнд ч хэрэгсэгдэхгүй өтөл чавганц болж яваадаа бачимдах, идэрхэг хүчирхэг хөвүүд төрүүлэн тэднийхээ нэрээр эрх сүрээ хадгалан явах далд хүсэлд нь бэр Ану нь саад тотгор болоод байх шиг муу бодолд автах, залуу гоо эмээс хүүгийнхээ хайр халамжийг харамлан жөтөөрхөх энэ бүгд цугаар нийлээд бэртэйгээ арцалдан тэмцэлдэх, өөрийнхөө залуу насанд амсч асан эр нөхрөө бусад эмс хатдаас харамлах, хардах, хадмын газарт сахих бэрийн элдэв хатуу ёс журамд хүлэгдэхийн зовлонг Ануд илүү их амсуулж ааг омгийг нь дармаар санагдах болжээ. Түүнийхээр бол эм хүн яаж амьдрахаар заяагдсан юм, тийм л жамаар энэ хорвоог элээх ёстой. Гэтэл Ану эцгийнхээ насны наран хэвийж явахад нь хэнз отгон охин нь болж мэндлэн эрх дураар өссөнөөрөө далимдуулах мэт эр хүн шиг өөрийгөө авч явж, эм заяагаа умартсан ихэрхүү зантай байх нь яавч хорвоогийн жамд үл зохицох ажгу. Гээд Ану ийм бэрийн ёс алдлаа, тийм заншлыг үл тоомсорлов гэх эндэгдэл огт гаргахгүй, орд өргөөн доторхи элдэв жижиг аар саар хэрэг явдалд хошуу дүрэн, өөртэй нь илт арцалдаад байхгүй нь бүүр ч гачлантай байлаа. Ануг ийн их гэдэстэй байх үеийг нь завшаанчлан хүүдээ өөр татвар эм, эс бөгөөс бага хатан авч өгөн, энэ ихэрхүү эмийн нөлөөг багасган дарж авах юм хуна хэмээн тэрхүү цагаан сарын овоо тахилгын үеэр Юм-Агас хатан шийджээ.

Цагаан сараас хойш удалгүй хаврын урь орж, урин амьсгал ханхийх хаврын дунд сарын нэгэн

өдөр Юм-Агас хатан орд өргөөг нүүлгэх тухай эртний яриа дахин Галдантай өдөв.

Галдан хаан цаашид өөртэй нь шөргөөцөлдөх нь илт болсон хадмынхаасаа холдон нүүх гэж буйгаа хатандаа хэрхэн яаж эвтэйхэн хэлэхээ мэдэхгүй явсаар байжээ. Энэ нь мөн л хөгшин хатны сэтгэлд нийцсэнгүй. Тэнгэрт хальсан Сэнгэ хүү нь хэдий шийдмэг зоримгоороо Галдангийн энд үл хүрэх авч, хэзээд ийнхүү хатад, эмсийн нөлөөнд гүнзгийрэн орох буюу, санасан бодсоноо хатандаа хэлэхээс халгаж яваагүй шүү дээ.

Хүүдээ гарынхаа цайг уулгана гэсэн нэрийдлээр өргөөндөө дуудуулсан Юм-Агас, Галданг орж ирэхэд энгүүн яриа өдөн Анугийн бие сайжран, өнгө зүс орж буйг хүүрнэж байснаа:

-Хүү минь Ховог сайраас орд өргөөгөө нүүлгэх ажил цалгардах нь. Хүмүүс явуулж нутаг ус шинжүүлэн, өргөөлөн буух буурийн газраа лусаас гуйх хэрэгтэй байна. Ану хатандаа энэ тухай дуулгасан уу? хэмээн шахамдуулан асуулаа. Ядаргаа тайлах увьдистай хэмээн хушгатай цай чанаснаа уулгах нэрээр эх нь ийм яриа хөндөх гэснийг сая гадарласан Галдан энэ үгийг дуулмагц хөмсөг зангидан барайж:

-Хаана орд өргөөгөө төвхнүүлэх талаар онцгойлон бодсон юм алга. Анугийн бие саяхнаас л сайжирч буй тул төрхөмөөс нь алслан нүүнэ гэдгийг цухуйлгахын завдал болсонгүй, ижий минь.

-Хэвлийдээ үр тээнэ гэдэг өвчин бус. Эм хүний заяа тавилан. Ану тийм идэрхэг чийраг биетэй хүн атал ураг тээсний хордлогод юунд тийм гүнзгий автсан юм бол мэдэхгүй. Миний бодоход Алтайн өвөр өөд ордноо нүүлгэвэл нөмөр нөөлөг, газрын байршил ч ашигтай мэт.

-Ану миний үр удмыг тээж явна шүү дээ, ижий минь. Та ч нэгэн цагт хэвлийдээ үр тээж, бүсгүй хүний зүдүүр амсч явснаа бүү умартагтун. Орд өргөө нүүлгэхийн тухайд таны санааг дэмжиж байна. Алтайн өвөр гэдэг тань одоо цэрэглэн хураах гэж буй Алтайн урианхай, Тагнын урианхайтай ойр дөхөм, алба татвар өгөхөөс гэдийгээд буй Хиргисүүдийн нутгийг захирахад ч газар дөхүү юм. Миний бодоход Алтайн өвөр Хар Эрчис мөрний хөвөөнөө буурь сонговол ямар? хэмээлээ.

Хоёр хөвүүн нь эхээ бурхан мэт дээдлэн, ямагт өөрийнх нь хэлсэн зөвлөснийг нь үг дуугүй дагасаар ирсэн байтал Галдан хүү нь ийнхүү хатнаа өмгөөлөн царай барайлгаж, “Та ч нэгэн цагт хэвлийдээ үр тээж, бүсгүй хүний зүдүүр амсч явнаа бүү умартагтун.” хэмээж буйг үзэхэд бяцхан хошууд сэвгэр хүүгийнх нь зүрхэнд “мигуйн хумсаа” хэр гүнзгий шигтгэж амжсан нь илт байх шив. Юм-Агас ахайтны торгон ухаан энэ байтугай адармаатай амьдралыг туулсны хэрэг юу сан билээ. Хөгшин хатан намрын навч мэт үрчийж борлосон гараа ширтэн, том сувдан бэлзгээрээ оролдож сууснаа, толгой өндийн нүүрэндээ ядрангуй инээмсэглэл тодруулан:

-Тэгэлгүй дээ. Хар Эрчис мөрөн тийш ордноо нүүлгэх нь үнэхээр мэргэн санаа байна, хүү минь. Алив ижий нь хөгшин замд хэлж чиний багадаа амтархах дуртай асан эззгий, үзэмтэй шарвин хайруулсан юм сан гээд хонхдоход дөч хол гарсан Асралт шивэгчин нь бус өндөр нуруутай, сиймхий нимгэн хувцас өмсгөлтэй залуухан хөөрхөн хотон бүсгүй орж ирэн :

-Галдан хаантны амрыг айлтгая. Ахайтан таны амгаланг айлтгая хэмээн зулзган хус шиг нахилзав.

Ану хатан нь давхар биетэй болсноос хойш сүүн цагаан царай нь сэвхтэн нилээд барайж, сүүлийн саруудад бэлхүүсээрээ бүдүүрэн бие нь урьдын уян налархай байдлаа алдсаны гадна ор хөнжлийн цэнгэлээс хөндийрөөд буй тул Галдан тэр цасан цагаан царайтай, бүжигчин мэт уян хөнгөхөн хөдөлгөөнтэй залуу охиныг хараад харц нь сэргээд ирлээ.

-Амгалан байна. Чи замын бэлтгэсэн үзэмтэй шарвинг дахин нэг тунхуу хушгатай цайны хамт авчирч бид хоёрт үйлчил гэж хатан хэлээд тэр шивэгчин өөд хүүгийнхээ тийн өлөн харц шидлэхийг эс анзаарагчин царайлав.

-Жаа ахайтаан хэмээгээд охин хараад баймаар уран хөдөлгөөнөөр нахисхийхдээ гүн ухархайд мэлтэгнэх том алаг нүдээрээ Ануд огоот байдаггүй сэртэндсэн харц илгээгээд гарч одоход, эмстэй ойр мөд ойртоогүй Галдан хааны дур сэрэл хөдлөн араас нь шунаглан харсаар үлдээд гэнэт биеэ мэдэж хоолой засан аягатай зэлгээрсэн цайгаа балгав.

Хөгшин хатан ч Галдангийн асуусан, шохоорхсон харцанд хариулах мэт :

-Асралт ойрноос бие нь чилээрхүү байгаа. Тарианы газрын уйгур даамлын энэ охин Майяг би саяхнаас өргөөндөө авчраад буй. Нүд, шүд, нуруу туруу гэж аргагүй л зэрлэг гөрөөс мэт гоо амьтан шиг байгаа биз? Зүгээр нэг аягачин шивэгчин хийлгэж гар хөлийн үзүүрт зарахад хайран л бүсгүй. Хүү минь чи үүнийг “Түгээмэл баясгах” өргөөндөө аваачин татвар эм болгож авахгүй юу. Ану хатан амаржаад тэнхэртэл төдгүй хугацаа байна хэмээн улаан цайм хэлчихээд :

-Маргааш гэхэд Хар эрчис тийш явуулах хүмүүсээ бэлтгүүлж, буйрын газар гуйхад явах лам санваартнаа бодоорой хүү минь гэлээ.

Тийнхүү Галдан хаан хайртай сэвгэрээ хатан буулган авчирснаасаа хойш анх удаа өөр эм өвөртөлж, Юм-Агас хатан ч Ану хатныг хорлох далдуур санаагаа гүйцээж авчээ.

Харин Хар эрчис мөрний тийш одсон хүмүүс шинэ орд өргөө барих газраа товлон, Ховог сайрын ордон дахь тахилын сүмийн тэргүүн Ялгуусан лам “буйрын газар” гуйн газар лусыг аргадсаны хойно, сая л Галдан хатандаа өргөөгөө Ховог сайраас нүүлгэн алс хол Алтайн өвөр тийш одох гэж буйгаа айлтгажээ. Ойрноос эр нөхөр нь төрийн хэрэг их, гадуур хөөцөлдөх ажилтай гэх шалтгаанаар хатныхаа өргөөнд хоноглох нь ховордсоор буйд далдуур гомдон хардах, харамлах адын бодолд ээрэгдэн шаналж, улам улам томорсоор буй гэдсэндээ түүртэн уцаартай байсан Ану энэ үгийг сонсоод ууж суусан аягатай цайгаа мэлхий ширээн дээрээ алдчих дөхөв.

Энэ өдөр өргөөнд нь морилон орж ирэхдээ аргадангуй аашлан, харц тулгарахаас зайлсхийгээд байх шиг байснаа, гэнэт ийм яриа хөндөх гэж. Саяхнаас л энэ ордонд дасч идээшин өөрийн гэр шиг үзэх болсон Ану ухаасаа зайрмагтан хайлж буй цөөрмүүдийн эргээр зугаалан, зуны найртай улиралд хүүгээ энэ цөөрмийн усанд булхуулан тоглуулна хэмээн мөрөөдөж байсан ажээ. Тэгээд ч төрхөмтэйгээ бичиг захидлаар харилцахад газар



дөхөм, насан өндөр болсон эцгийн биеийг асуун, эхийнхээ амар мэндийг мэдэж, ах нартайгаа холбоотой байхад ойр, ер бусын тохилог суурьшмал энэ ордноос хаа байсан алс Хар Эрчис мөрний тийш “сүүлээ хавчин” нүүх болсны учир юу вэ? Хуримын маргааш өдрөөс хойш төрийн хэргийг өөртэй нь зөвшилцөн, ямагт санаа бодлоо хуваалцдаг асан амраг нөхөр нь юуны учир ийнхүү чимээгүй байж байгаад гэнэт нүүх болсноо өчдөг билээ?

-Эцгийнхээ үүсгэсэн энэ сүрлэг сайхан орд өргөөгөө орхих болсны учир юу болохыг танаас аймшиггүйгээр асууж болох уу?

-Бололгүй дээ. Төрхөмийн газраас тань холдон нүүж буйд бие тулгар чи минь бүү гуниглагтун. Зүүнгарын хаант улсын төрийг түвшитгэхэд надад хийх ажил хэчнээн их буйг ухаант чи минь ойгож буй биз. Нэг хэсэгтээ л бууриа сэлгэх хэрэг байна. Хар Эрчис мөрний тэндээс удахгүй цэрэглэн хураах гэж буй урианхай овгууд, эртнээс нааш манд алба гувчуур өргөсөөр ирсэн хиргис аймгийг захирахад газар ойр, нөгөө талаас Далай багштай харилцахад дөхөм, цастын орны зүг одох зам шулуун шүү дээ. Энэ сайхан ордноо Данзан-Омбын шадар мянгатаар харгалзуулан үлдээвэл ямар? хэмээн асуух нь хатантайгаа энэ чухаг асуудлыг зөвшилцөлгүйгээр эхтэйгээ хавсран шийдсэн, сүүлийн үед Майя бүсгүйг ордондоо аваачин цэнгэх болсон зэрэгтээ далдуур эвгүйцэх тул эв эеийг хичээн түүнийхээ аяыг дагах гэснийх байв.

-Хаан таны л таалал мэдэх хэрэг шүү дээ. Гэдсэндээ түүртсэн надад амар амгалан шиг хоёр яс хагацахаас илүүд хошуу дүрэх бодол алгаа. Уул усны ойр нь, ураг төрлийн хол нь гэгчээр Эмил дэх төрхөмөөс минь холдон нүүх нь зүй гэдгийг би ухварлаж байнаа. Харин Данзан – Омбо ноёны хувьд танд үнэнчээр хүчин өргөж яваа ач тань билээ. Түүгээр Ховог сайрын их ордоо сахиулах нь хамгаас зөв шийдвэр гэж мунхаглаж байна гэж Ану өчихдөө “Гэдсэндээ түүртсэн надад...” гэсэн үгэн дээр гомдол, тунирхал тээснээ нуусангүй. Орд өргөөний дотуур тэнүүчлэх явган ховын үзүүрт Галдан хаан Түмэн баясгалант ордондоо амьтны нүднээс далдуур нэгэн уйгар эмийг аваачин цэнгэж хонох болсныг дуулсан ч эхийнхээ аминчлан захисныг санан зүрхэнд шаасан өргөс мэт тэр сэдвийг хөндөлгүй тэвчиж чадлаа. Сураг сонсохноо тэр уйгур сэвгэрийг Юм-Агас хатан шадар шивэгчин Асралтдаа туслуулах нэрээр өргөөндөө авчирсныг нь Галдан хаан үзээд таалсан аж. Үүнээс үзтэл хөгшин ахайтан бэрээ бие давхар болсныг далимдуулан хүүгийнхээ өвөрт татвар эм авчирч хийсэн байж болох талтайг ч Ану гадарлаж л байлуга.

-Тэнд хашаа хороо барих, төрийн хэрэг эрхлэх хоёр давхарлаг сэрүүн харш, мөргөлийн дацан барих хүмүүс удахгүй тийшээ илгээх болсон. Чингээд чамайгаа амаржиж, хүүхдээ бойжсон хойно зуны адаг сард их нүүдэл хөдөлгөнө. Харин дархцуулын багт Чилэдүг илгээвэл чи дургүйцэхгүй биз дээ?

-Миний инжинд дагаж ирсэн албатууд мөн л Таны барлаг болсонтой агаар нэгэн бус уу? Чилэдү төмрийн сайн дархнаас гадна, модон урлалд ч дөнгүүр ур сайтай тул Хар Эрчисийн зүг илгээх нь зүй.

-Алив, миний хүү хэвлийдээ хөдөлж байна уу?

-Та хүү хүү л гэх юм. Охин ч юм бил үү?

-Надад ялгаа үгүй ээ. Охин ч бай, хөвүүн ч бай миний л үр үндэс. Хүү гээд байгаа нь охин, хөвүүн алиныг нь ч эцэг эх нь “миний хүү” гэж дууддагийнх шүү дээ хэмээн Галдан хэлээд хэвлий дээр нь алгаа тавилаа. Тэгснээ хүүхдээ гэнэт хөдлөхөд цочих шиг болоод нүүрэндээ жаргалтайяа инээмсэглэл тодруулан “Хүү минь эцгээ таниад баясч байх шиг байна. Чи минь хэрэм дотуур алгуурхан салхилан зугаалж бай. Хэтэрхий хөдөлгөөнгүй ном судар шагайн суугаад байх аваас хүүхэд хэвлийдээ томроод хожим хоёр яс салах гэж зүдэрдэг гэнэ. Даан ялангуяа чи минь жижиг биетэй хүн. Хэтийдсэн том ураг төрүүлэх гэж зовох болно” хэмээн сургав.

Түүнийхээ том зөөлөн алгыг хэвлийдээ хүрмэгц, бүсгүйн сэтгэлд шуурч асан гомдлын салхи хаашаа ч юм шурган алга болоод, тэртээ бага насандаа энэ хүний мутраас адис авахад хэчнээн их догдолж байснаа гэнэт санажээ.

Тэгээд бүсгүй “Хүмүүн гэдэг амьтан оюун ухаантай мөртөө зарим үед адгууснаас ч дор аашлах юм. Тиймдээ ч хүн зовлон зүдүүрийг шүд зуун гэтэлгэж чаддаг атал аз жаргалыг болохоор даадаггүй амьтан юм уу” хэмээн гэнэт өөртөө ч ундууцах шиг. Саяхан л сахил санваартай, хувилгаан явахад нь зүрх сэтгэлээ өгчихөөд, ахтай нь дэр нэгтгэхээс аргагүйд хүрч явснаа умартсан мэт ялигүй юманд гоморхон суух гэж. Түүх шастирт үлдсэн тэр Эзэн Чингисийн хатан эх Өэлүн, Есүй, Есүгэн, гүнж Алахи бэхиэс эхлээд олон олон хатад эртний заншил, эцгийн тааллыг даган огтын танихгүй хүнд богтлогдон очиж байснаас бус өөр шиг нь ийнхүү багын дурлалт хүнтэйгээ хуримлан жаргаж байсан нь үгүй бус уу?

Чингээд ”Ану хатан та тогтож айлд. Даварч цаашлахын оронд заяа тавиландаа залбирч явбал таарах буй за” хэмээн өөртөө доогтойхон сануулж, алтан сампинт сүрлэг малгайгаа үхэг дээр тайлж талбиад хэвлийд нь гараа тавьж явган суусан хайртай хүнийхээ эрхэм тэргүүнийг илбэн нүүрээ үсэнд нь наалаа.

Залуу хос дорхиноо эвлэрч, тийнхүү хайрт хатантайгаа эв эеэ олсон Галдан хаан маадгархан алхалсаар Дотоод ордныхоо зүг одовой.

Хаврын адаг сар гэхэд морьд нилээд өнгө зүс орж, тарга хүч сэлбэж, хүнсний нөөц ч чамлахааргүй байсан тул Галдан хаан удахгүй амаржих хайрт хатандаа сэтгэл хоргодон хоргодсоор шадар жанжин Махан, Данжила, Баатар зайсан нарын мянгатыг тэргүүлэн Алтайн урианхайг уулгалан захирахаар хөдөллөө.

Галдан хаан цэрэглэн Алтайн урианхай, цаашлаад Тагнын урианхай аймгийг дайлахаар мордохын өмнөх үдэш Ану хатныхаа өргөөнд хоноглов. Тэр шөнө Галдан өнөө маргаашгүй хөнгөрөх тулсан тогоон чинээ гэдэстэй хатныхаа бугалга, хөлийн булчин, хүзүү далыг барилан, биеийнх нь чилээг гарган эрхлүүлж, сэтгэлийн үгээ хэлэлцэн усны шувууд шиг л ижилсэхийн жаргал эдлэн хонож билээ.

-Та дэргэдээ Балсанг аваад яв. Хараа хурц, харвахдаа мэргэн тул таныг тэнэсэн сумнаас найдвартай хамгаална.

-Үгүй дээ. Өлчир бий шүү дээ. Хэдий орд өргөөндөө үлдэж буй ч би чинийхээ амь сахигч шадар зуутын ахлагчийг авч яваад яахин сэтгэл тавиун тулалдах буй? Төрхөмийн газраас

дагуулан ирсэн шадар хэвтүүл тэнь чиний л дэргэд үлдэг.

-Тэгвэл Бундирыг заавал авч яв.

-За тэгье дээ.

-Ашгүй сэтгэл хөнгөрлөө. Та өчүүхэн шалбархай ч үгүй эгэн ирвэл миний сэтгэл тэнүүн сайхан байх болно.

-Чи минь хэзээ хөнгөрөх билээ?

-Юмгүй багахан хугацаа үлдсэн. Арваад хоноод хөнгөрнө гэж Дүвчин маарамбатан айлдсан. Доод борчуудын дундаас туршлагатай эх баригч авчирч өргөөнд суулга хэмээж байна билээ.

-Жалбуу бариач гэж ахын хөвүүдийг эх барьсан авгайг би авчраад ижийн өргөөний дэргэд суулгасан буй. Баавгайн сарвуу авчруулж, Мандарваад өгчилгөсөн. Дараагийн хүүхдээ төрөхөд би хойд газар явж балар их хөвчөөс өөрөө агнасан баавгайн сарвууг чамдаа өгнөө хэмээн Галдан хэлээд хатныхаа духан дээр үнслээ.

-Та юм л бол дайтах, тулалдах, авлах, агнах тухай ярьдаг боллоо. Гэтэл саяхан л та өчүүхэн жижиг хорхой шавьжны амийг ч өршөөн нигүүлсэх, зургаан зүйл хамаг амьтны тусын тулд залбирч явсан хувилгаан хүн шүү дээ.

-Тийм байсан. Бурханы сургааль энэ орчлонгийн явдлыг бясалган ухаж ойлгох оюуны мэлмийг минь нээсэн. Харин эдүгээ би бол дөрвөн Ойрадын шашны тэргүүн бус, харин төрийн жолоо атгасан хаан хүн. Бас удам угсаагаа үлдээж, өрх гэр тэргүүлсэн эр хүн. Тиймд атаат дайсантайгаа тулалдаж, ан гөрөө авлах л болно хэмээлээ.

-Тэр тийм байж. Тэгвэл та миний нэг хүслийг сонсох уу?

-Тэгье л дээ.

-За тэгвэл дараа хөнгөрөхөд минь таныг баавгай агнан сарвууг нь авчраасай гэхээс илүү дэргэд минь гэгээн дүрээрээ байж байгаасай л гэж хүсэх байна.

-Тэгнэ дээ. Одоо ч бие минь Алтайн урианхайг зүглэхээс бус сэтгэл минь чинийхээ дэргэд л хоргодоод байгаа шүү дээ.

-Та миний төлөө залбирч яваарай.

-Зонхов шүтээндээ залбирч, зүрхэн тарнийг буман удаа унших болно.

-Тэгвэл миний сэтгэл хөнгөн байна.

-Амаржиж үр хүүхдээ төрүүлнэ гэдэг бүсгүй хүний тавилан. Энэ хорвоогийн хэчнээн буман бүсгүйчүүд энэ давааг давсаар ирсэн гэж сэтгэлээ хатуужуулаарай, хайрт минь.

-Жа...

Маргааш нь Галдан хааны их цэрэг, хөсгийн түрүүч нар битүүгээр баруун хойд зүгт хөдлөхөд Ану хатан эр нөхрөө Зүүнгар улсыг түвшитгөх анхны аян дайндаа эсэн энх яваад ирэхийн ерөөл талбин “Миний төлөө шалбархай ч үгүй эргэн ирээрэй” хэмээн шивнэж, эртний монгол ёсоор дөрөөн дээр нь цагаан сэтгэлийн билгэдэл идээний дээж сүү дусаан, шивэгчний хамт хойноос нь сацал өргөсөөр хоцорлоо. Санаа нь хайртай түүнээ их хэрэмний гаднаас үдмээр байсан ч юу юугүй амаржих дөхөж, гэдэс нь томроод морь унах, үхэг тэрэгт суух бүү хэл, ширүүхэн хөдлөхөд тээртэй болсон тул Галдан хаан хоригложээ.

Ану хатан “Мандухай цэцэн гэж энгийн мах цусанд төрсөн мань мэтээс аргагүй ангид төрсөн хүн байжээ. Хэвлийдээ Батмөнх хааны хоёр ихэр нуган үрийг тээсэн атал ойн иргэдийг хураан тохинуулахаар их цэрэг хөдөлгөн тулаанд яваад, хээрийн асарт хөнгөрч байсан гэдэг. Гэтэл би суурин иргэншилтэй танхил авхай нарын адил моринд мордож ч чадахгүй, орд хэрмийн дотор бүгэн биеэ чагнаж суух юм” хэмээн дотроо дурамжхан, их гэдэстэй болсондоо харамсмаар ч юм шиг санагдан, алсын аянд сэтгэл татагдан тогтож ядан байлуга.

Тэгээд эр нөхрөө алсад бараа тасарсан хойно өргөөндөө орж, Мандарваадаа “Хэрэв би тулгар биетэй байгаагүй бол Мандухай хатан шиг саадаглан аян дайнд мордон, ид хаваа гайхуулж явахгүй юу. Ингэж орд өргөө сахин суух нь туйлаас уйтгартай юм” хэмээхэд ор дэр хураан түнтгэнэж байсан Мандарваа цочин :

-Үгүй, та чинь арай шилрээгүй байгаа даа? Хэвлийгээр тэнь өвдөөгүй юу? хэмээн сандчаад гоцго дуудан бариачид явуулав.

-Зүгээр ээ, зүгээр. Сүртэй гэдэг нь. Өвдөж хавдсан юм л алга. Энэ их гэдэс тээх үйлтэй үүргээн ацаглаж болдог сон бол чамд тээлгэчих юм сан гээд тас тас хөхөрч билээ.

-Алдас болно, хатантан минь. Гэхдээ нээрэн, тэгж болдог бол би таны төлөө тээгээд л өгнө дөө хэмээн Мандарваа том нүд эргэлдүүлэн бодолхийлэхэд:

-Чи өөрөө Чилэдүгийнхээ үрийг тээхдээ яах болж байна? Будаач будаач гэхээр сахлаа будав гэгч болох нээ энэ чинь. Зүгээр наадам хийж байхад гээд Ану шивэгчнийхээ гэнэн, итгэмтгийг тохуурхан баахан хөхөрчээ.

Галдан хааныг Алтайн урианхайг дайлахаар мордсоноос хойш тавхан хоногийн дараа Ану шөнө дөлөөр гэнэт дуншин өвдөж эхлэв. Тэр үдэш Ану орондоо ганцаар элдэв бодолд автан эргэж хөрвөсөөр арай гэж нойрсоод шөнө дунд нэг сэрээд эргэн дугхийхдээ багадаа цастын орон явах замд зүүдэндээ үзсэн намуухан урсгалт Туул хэмээх голын хөвөөнд Галдантайгаа морьтой зугаалж явтал манж цэргийн луут туг намируулсан их цэрэг гэнэт довтлов. Ану “Балсаан, Бундираа! “ хэмээн хашгирах гэтэл хоолой нь гарахгүй. Эр нөхрийг нь барихаар уулгалан ирэх манжийн хоёр баатрын зүг сумаа тавьчихаад эргэтэл хэвлий рүү нь халуун зэвсгээр буудах шиг болж тэсэхүйеэ их өвдөж байна хэмээн зүүдлэв. Чингээд Галдангаа, нялх үрээ орхиод энэ ертөнцөөс одох гэж үү? хэмээн гол харлан харамсч буйгаа ухаарсаар өвчиндөө шаналан сэртэл хэвлийгээр нь эвгүй гэгч нь хатган өвдөж, тооноор хавирган саран

шагайж байлуга. Тэгснээ өвчин нь хэсэг намжсанаа гэнэт шээс ч хүрэх шиг, хамаг бие нь сулран эвгүйрхэхэд ёолон яраглав.

Эзэн хатныхаа яраглах чимээнээр Мандарваа сэрж, Оросын элч нарын бэлэглэсэн гурван салаа мөнгөн суурьтай, их гэрэлтэй лааг тэмтрэн олж хэт цахин хоромхон зуур гэрэл гаргаад :

-Хөх тэнгэр гэж! Хатан та дуншаад эхлэх нь энэ үү? Хонх хаачив? Балсанг дуудья хэмээн сандчив.

-Одоо зүгээр болчихлоо гэм дээ. Шөнө дөлөөр хүн амьтан үймүүлж, шуугиан тарьж яах нь вэ? хэмээн Ану хорьсон боловч гэнэт хэвлийгээр нь дахин улам ч хүчтэй час часхийн хатгуулахад бондгосхийн цочоод, дахин ёолж, энэ өөрөөс нь үл хамаарах түрэмгийлэл мэт аймшигтай өвчиндөө балмагдан чимээгүй эвхрэв.

-Хэлээгүй юу, хатантан минь .Омголон бардам зантай ч гэсэн та чинь бүсгүй хүн гэдгээ бүү умартаж бай хэмээн Доржравдан ахайтан мундахгүй л их сургасан даа гэхчлэн эршүүд зантай, өөрөөр нь дувт даажин хийж байдаг эзэн хатнаа ганц эз дийлж авья гэсэн мэт үглээд хонх цохин Балсанг дуудав. Анугийн өргөөний зэргэлдээ зочдын гэр нэрээр барьсан өөрийнх нь хуучин гэрт өдгөө Балсан сууж буй билээ.

Төдөлгүй өвдөлт нь ч ширүүсч, Балсан Юм-Агас хатны өргөөний хажууд суулгасан Жалбуу бариач, их маарамба Дүвчин, хадам эх Юм-Агас хатан, Асралт шивэгчний хамт дорхиноо цугларч гэрийнх нь зүүн хаяаг зайчлан хоёр том сэгс\* хөмөрч Ануг түшүүлэн суулгав. Дуншиж буй бүсгүйг ийнхүү явган суулгах нь төрөх хүүхэд хэвлий дотор доошлох замд саадгүй, эхийн биед эвтэйхэн хэмээн монгол туургатнууд хэдэн зуун жилийн туршид бүсгүйчүүдээ араг, сэгс түшүүлэн суулгаж амаржуулсаар ирсэн билээ.

Үүр цайх үеэр өвдөлт ширүүсч Ану яс яйртал ойр ойрхон дунших өвдөлтийг тэсч чадахаа болино хашгирч эхэллээ.

-Бүү хашгир, охин минь! Дүлэх тэнхэлгүй болчихдог юм хэмээн хадам эх нь хэлээд гэрээс эрэгтэйчүүдийг гаргаж эх баригч Жалбуу авгайгаас:

-Ураг хэр доошилж байна? Хүү юм уу, хүүхэн юм уу, Жалбуу? хэмээн асуув.

-Одоо жаахан тэсчихвэл хүүхдийн толгой цухуйх нь. Хатантан минь, хүчээ нөөж байгаад дүлээрэй. Хөвүүн болтой. Түргэн доошилж байна хэмээн Жалбуу хэлээд ханцуй шамлан бүсгүйн савны амсрыг нээнэ.

-Ёо, ёо, ижий минь. Амаржина гэдэг чинь ийм тамын тарчлаан байдаг гэж үү? Ёооё, би тэсэхгүй нээ хэмээн Ану тарчлан хөлстэй толгойгоо савлана.

-Хатантан минь. Бяцхан тэвчигтүн. Та чинь бүсгүй хүн гэхэд эр хүнээс илүү тэвчээр, зоригтой шүү дээ хэмээн Мандарваа аргадан толгой тушаа нь сууж духыг нь илнэ.

-Галдан хаантан таныг нярайлахад хэвлийг нь илээрэй хэмээн энэ маахайн сарвууг надад үлдээсэн юм гээд Мандарваа баавгайн том сарвуугаар хэвлийг нь илэх авч, өвчин шаналалдаа тарчилсан бүсгүй хөлсөндөө норсон хоёр салаа гээгээ савчин ёолсоор байлаа.

-Хатантаан ёолохоон больж, хүчээ нөөж үз. Хүүхдийн толгой цухуйх гэж байна. Та дүлэх тэнхэлгүй болчихвол ургийн амьсгал бүтчихдэг юм. Уухайс, уухай хэмээн эх баригч сандчин бөгтөгнөнө.

Өвдөж байна. Аа-аа хэмээн Ану яс янгинатал хашгирахад хүүхдийн нярай хонгор дуу часхийгээд явчихлаа.

-Харж байна уу? Хэчнээн чанга цовоо дуутай хүүхэд байна. Хүйг нь боох юм өгөөтөх гэж Жалбууг захирахад бүрлээч Сэнгэ хаантны хатдыг амаржихад ямагт Жалбууд дэм болдог асан Дэлгэржаргал хэмээх аягачин бүсгүй хүүхдийн хүй боох имхэрдэж бэлтгэсэн угас авч өгөхөд дотуур цагаан пансан цамцаа нэвг норсон Ану толгой өндийлгөн:

-Хөвүүн үү, эгч минь? гэлээ.

-Хөвүүн, хөвүүн. Цоросын гал голомтыг бадрааж явах эрүүл чийраг нуган үр төрлөө гэж хадам эх нь урьтан хэлээд эх баригчийн том улаан гарт арвалзан чарлах нярай амьтныг угаах бүлээн шөл хийсэн мөнгөн тунхуу авч өгөөд, бэрийнхээ хөлсийг зөөлхөн дурдам алчуураар арчиж өгөв.

-Юутай их баяр! Балсанг баруун хойш эр нөхөрт минь хэл дуулгахаар мордуул хэмээн Ану өчөөд эх баригчийн бардмаар тэврэн авчирсан хурган манцуйтай ядруу доройхон үрээ нэг харж, өчүүхэн духан дээр нь үнэрлээд:

-Хэчнээн хөөрхөн амьтан бэ? Уруул нь яг эцгийгээ хуулжээ. Бусад нь ч мэдэгдэх юм алга гэснээ түшин сууж буй том сэгс дээрээ толгойгоо унаган налаад:

-Мандарваа зэлгээн цийдэм аваад ир. Ам ангах нь гээд турь муутайхан инээмсэглэлээ.

Саяхан уа,уа чарлаж байсан дөнгөж төрсөн хүүг хонины бүлээн шөлөөр угааж, дулаан зөөлөн хурганы арьсанд манцуйлах зуур бөндийтөл унтаад өгчээ. Ану ч шивэгчнийхээ аягалж өгсөн том модон тагш дүүрэн зэлгээн хярмыг залгилаад өндийн сууж хормой хотоо эмхэллээ. Дөнгөж мэндэлсэн нярай хөвүүний дээрээс тонгойн шинжиж зогссон Мандарваа:

-Хөмсөг нь таных шиг хэлбэртэй, тэгээд бас зүүн хөмсгөө өргөөд байна хэмээн баясав.

-Алив, Дархижав, Мандарваа, эзэн хатнаа дэмнэж оронд нь хэвгүүлээд, энэ хөглөрсөн юмсыг эмхэлж, цэвэрлэ хэмээн Юм-Агас хатан зарлигдаад бэрийнхээ хөлс нь эврээгүй байгаа духанд цагаан дурдан алчуур боож өгөөд:

-Эр хүн шиг эрдэм ухаан ихтэй ч эм хүний хатан тэвчээр муутай хүн юм чи. Харин ч эрүүл чийраг биетэйн ачаар сайхан хөнгөрлөө. Манай Жалбуу ч туршлагаар арвин эх баригч байгаа юм. Харанхуй шөнөөр нүдээ аниад ч хүүхэд эх барьж аваад хүйг нь тасалж боочихоо ядахгүй

хүн дээ. Ер нь ч тэгээд эр хүн харах бараа сүрлэг ч гэсэн, эмгэг өвчин даахдаа эмс биднээс тэвчээргүй байдаг. Бүсгүй заяатан бидний хоёр яс салахдаа амсдаг тэр зовлонг эр хүн гэтэлгэж дийлэхгүй л болов уу гэж би боддог юм хэмээн ярингаа дотроо бэрээ өрөвдөж, “Хөвүүний минь үр үндсийг таслахгүй гэж хүүхдийг нь төрүүлэн, эм амьтны үйлийг эдэлж буй хар нялхаараа энэ амьтныг би юунд зовоож тарчилгах гэж зүтгэн, хар толгойдоо нүгэл хурааж байв даа” хэмээн гэмших сэтгэл төрж, үсийг нь аяар аяархан илбэж суулаа.

Гаднаас зам хонины усан шөл авчрав. Үүр шөнөөр нойргүй дуншиж ядарсан Ану хонины гуяны өөхгүй зөөлөн мах хярж хийсэн сайхан шөл уугаад толгой нь маналзаж сульданд унаад өгөв. Чингээд мэлмийгээ анин “Ижий минь, дөч шахаж явахдаа намайг төрүүлэх гэж бас л ингэж ясаа яйртал өвдсөн байх даа. Тэгтэл би гэж мунхаг толгой төрхөмөөс мордон мордтолоо эхийгээ адалж явдаг.” хэмээн өөрийгөө зүхэх гэмшил, хүү төрүүлж эх болсондоо баярлахаас илүү хөдөлж явахад тээртэй, давсаг дээрээс чулуу зүүчихсэн мэт зовоож асан их гэдэс одоо алга болсон шүү дээ гэхээс хөөрөх залуу бүсгүйн томоогүй бодол, эл чухаг мөчид эр нөхрөө үгүйлэн гуниглах, хар элгийн хадмын газарт эцэг, эх элгэн саднаа үгүйлэхтэй нийлэн уйлмаар ч юм шиг, гунигламаар ч юм шиг олон янзын сэрэл мэдрэмжид автан байснаа ядарсандаа нам унтаад өгчээ.

Хүүхдийн эг маггүй чарлах дуугаар хөх нь чинэрэх шиг болж бүсгүй нойрноос гэнэт сэрлээ.

-Эр хүн өлслөө гэж ундууцаж байна. Хөхөө амлуул даа. Эцэгт нь элч довтолгосон, Эмилийн зүгт төрхөмд тэнь хэл өгүүлсэн хэмээгээд хөгшин ахайтан хурган манцуйтай тохойн чинээ амьтныг эхэд нь авч өгөөд шивэгчний аягалж өгсөн цайг оочлон:

-Хэд хоногтоо ангир уургаа хөхүүл, охин минь. Борчуудын хорооноос сарын өмнө хөнгөрсөн овоо сүү сайтай бүсгүй олсон. Хүү цаашдаа өрлөг эхээ хөхөж өснө биз хэмээлээ.

Хүүгийнхээ үрчгэр улаан царайг харан, өхөөрдөн хайрлахаас илүүтэй, арчаагүй, алгын чинээг нь гайхан гайхан хөхөө амлуулж суусан Ану савны агшин базлахыг шүд зуун тэсээд тэртээ есөн жилийн өмнө Галдмаа ахынхаа нярай охиныг үзэх гэж ижийтэйгээ айлчлаар очоод дөнгөж төрсөн хүүхдийн турь муутай, хөгшин хүн шиг үрчгэр, царай муутайг гайхан байснаа санан инээд нь хүрэв. Тэгээд хүүд өрлөг эх олж өгөх тухай хадам эхийн яриаг чихний хажуугаар өнгөрүүлчихсэнээ гэнэт анзааран:

-Ижий минь. Би өөрөө хөхүүлнээ. Өрлөг эхийн хэвлийд бус миний биед бүрэлдэн, амь амьдралыг нь би хайрласан юм хойно өөрөө л хөхүүлж өсгөмөөр байна хэмээн зөрүүдлэв.

“Ийм л дураараа хүн дээ. За яахав, юу сайхан дур сайхан гэдэг” хэмээн Юм-Агас дургүйлхэн бодсон ч басхүү, ихэс дээдсийн хатад авхай нар шиг ямбалан ихэрхэхийн оронд өөрийнх нь мах цусны тасархайд ийн амин хайртай байгаад баярлах ч шиг болж:

-Хүүхэд шөнө уйлж бархирна. Амтат сайхан нойрон дунд чинь хөхөө нэхнэ. Тэр тоолонд өндийж хөхүүлэх гэсээр нойроо хугаслан ядрах сульдах вий гэхээс чадна гэж таалж байгаа бол яахав дээ, охин минь гэлээ.

Хүүгээ хөхүүлэн нялхарч хэвтээ Ану хадам эхийн зүг урьд урьдынхаас илүү ухаажиж,

зөөлөрсөн харц илгээн:

-Та хөвүүдээ өөрөө хөхүүлээгүй гэж үү? хэмээн асууснаа:

-Би багадаа эхийн хөх үлгээгүй болохоор Даадаадаа ижийгээс илүү хайртай гэж боддог байсан. Одоо би хүүгээ тэгж өөрөөсөө хөндийрүүлмээргүй байна гэлээ. Юм-Агас хатан мушийн инээмсэглээд бодолд дарагдан нүдээ сүүмийлгэсэнээ:

-Сэнгэ, Галдан хоёрын дунд нэг охин заяасан ч ой хүрэлгүй эндчихсэн юм. Бас Галдангийн өмнөх хүүгээ төрөхийнх нь өмнө азгүй тохиолдоор зулбаж байлаа. Би чинь бүтсэн бүтээгүй дөрвөн үр төрүүлсэн хүн. Галдан ахаасаа илүү өвчин ороож сандаргасан болохоор нилээд удаан ой хүртэл нь өрлөг эхийнх нь хажуугаар өөрөө хөхүүлсэн юм. Сэнгэ бол шууд өрлөг эхээ амласан даа гээд “Нээрээ Анугийн хэлдэг үнэн ч юм уу даа. Одоо бодоод байхад ангир уургаа шимүүлж өсгөсөн учраас л би Галдандаа бүрлээчээс илүү амь байдаг байсан юм байна шүү. Энэ Ануг гурван настайд Алшаад сэвлэг үргээлгийн найранд нь очиход сонжуу гэзгээ хяргуулахгүй хэмээн бархирахдаа эхээ ойшоохгүй өрлөг эх өөдөө л тэмүүлж байж билээ. Нээрэн тэр цагаас хойш арван зургаан жил нисэх мэт өнгөрч дээ. Тэр жил би Алшаагаас цааш явсаар, цастын оронд хүрч Галдан хүүгээ эргэсэн сэн.” хэмээн бодол дурсамж хөврүүлж суулаа. Он цагийн тоос хүний амьдралыг хэчнээн алгуур алгуурхан дарж, олон сайхан дурсамжууд сүмийн хуучин дээвэр мэт тэр он цагийн тоосонд дарагдан мартагддаг юм бэ?

Түрүүн бэрээ амаржих гэж тарчлан ёолж байхад л Юм-Агас хатан өөрийнхөө цэл залуу насыг, бас л ингэж эм хүний үйлт тавиланг эдлэн хэдэнтээ хөнгөрч байснаа, басхүү Ану сая хүүгээ амлуулахаар цагаан пансан цамцныхаа энгэрийг ярахад өөрт нь бүрлээч эр нөхрийнх нь бэлэглэсэн шиг алтан бурхан зүүлттэй байхыг харж эр нөхрийнхөө энхрийлэл хайранд умбаж, бусад эмс хатдаас харамлан хардаж байснаа эрхгүй санагалзаж, хүүдээ татвар эм олж өгөн, бэрийнхээ өмнө хуншгүй авирласныхаа учрыг гайхаад барсангүй.

Хэд хоногийн дараа Галдан хаанд элчээр одсон Балсан дайны газраас эгэн ирэв. Галдан хаан Алтайн урианхайг ядах юмгүй эзлэн захираад Тагнын урианхайн зүг хөдөлсөн агаад хумсын толион чинээ ч шалбархай үгүй хийморь ихтэй яваа аж. Удам залгах хөвүүнтэй болсондоо туйлын их баярласан хаантан хээрийн цацартаа өөрөө шоо орхин, заяа төөрөг, жил мэнгийг нь үзээд Сэвдэнбалжир хэмээх нэр хайрлах аман зарлиг хэлүүлж, хатандаа аян дайны олзноос зуун булганы арьс, зуун лан алт илгээсэн байв.

Галдан хааны зүг довтолгосон элч ирснээс гурван өдрийн хойно Эмиль дэх төрхөмийн газраас нь эх Доржравдан хатан нь хориод хэвтүүл бараа бологч, тэмээн ачаа хөсөгтэй бэлэг сэлт ганзгалан ирж, охиноо эргэж, зээгээ үзээр айлчлав.

Очирт цэцэн хан мориор явахад бие чилүүр, тулаанд олсон хуучин шарх сэдрэн хэвтэж байсан тул саяхан хөнгөрсөн охиноо эргэж чадсангүй ажээ. Хэдий биедээ аригтай байдаг ч Ануг хадамд мордсоноос хойш эх нь нилээд өтөлж, давжаарсан мэт, бяцхан зээгээ үзээд уярлын нулимс цийлэгнүүлэхийг үзэхүл нас өтөл хүмүүст тохиолддогчлон сэтгэл нь зөөлөрч яваа бололтой санагдаж, духаа өгч үнэрлүүлэхдээ бүсгүй өөрөө золтой л мэлмэрүүлчихсэнгүй биеэ барьжээ.



Доржравдан хатныг ийнхүү биеэр айлчлан ирсэнд Юм-Агас худ ургийн хувьд хөл алдан дайлж, гэртээ буй мэт тухлан хагас сар охиноо харж хандан саатахыг урьсан ч ардаа хоцорсон өвгөнөө асрах ажилтай, гэр өргөө эзэнгүйднэ гэсэн шалтаг заан гурав хоноод яаравчлан буцжээ.

Доржравдан хатны Ховог сайрт гийчилсний цаад шалтгаан нь төрж хөнгөрсөн охиноо эргэн, санасан сэтгэлийн чилээг гаргах, бяцхан зээгээ үзэхээс гадна хүргэн нь орд өргөөгөө алс Алтайн өвөр тийш нүүлгэн хадмын нутгаас дайжин буруулах гэж буй нь үнэн эсэхийг тандах санаа ч байжээ.

Чингээд охиныхоо амнаас “Зуны адаг сард хөвүүнээ бойжоод ирэхээр Алтайн өвөр Хар Эрчис мөрний тийш орд өргөөгөө нүүлгэхээр болж буурь товлон, газар лусыг аргадан гуйчхсан. Өдгөө тэнд Чилэдү тэргүүтэн мужаан, дархчуул очин, мөргөлийн сүм, орд, хашаа хэрэм барьж эхэлсэн. Эр нөхөр нь тийнхүү эцгийн бий болгосон энэ суурьшмал ордоо орхин нүүх болсноо өдгөө хураан захиргаандаа оруулж буй Алтай, Тагнын урианхай аймаг, алба гувчуур хураадаг хиргис овогтнуудыг захирахад дөхөм, цастын орныг зорих их замын бэлчирт байх нэн ашигтай байршил нутаг хэмээн тайлбарласан” гэсэн үг сонсоод сэжиг таамаг нь батлагдсанд төдий л гайхсангүй. Ану ч эхийнхээ царайг хянуур ширтэн харцаараа ойлголцоод төрсөн төрхөм, хайрт эцэг, насан турхруу ханилах эр нөхрийн алиныг ч гэхэд хэцүү ацан шалаанд орох цаг айсууг ухааран сэтгэл тавгүйтсэн ч эх, охин хоёрын хэн нь ч энэ тухай ам нээсэнгүй.

Доржравдан хатан хөнгөрсний дараа хэрхэн нүүрний сэвхийг арилгах, хоёр сар гаруй гам сахисны хойно төрснөөс болоод унаж шингэрсэн үс гэзгээ яаж шуухан шүүгээр угааж, цэцгийн хандаар зайлан эргээд өтгөн сайхан болгож, өнгө зүсийг нь сэргээх, сунаж томорсон гэдэс хэвлийг яаж бүслэн нарийсгах гэхчлэн гоо үзэсгэлэнгээ хадгалан аригладаг олон аргаа, хэдийд үр тогтож бие шалтагтай болох магадлал их байдаг тухай нанхиад эмч нарын бичиглэсэн тухай гэхчлэн урьд Анугийн хэзээ ч ойшоон сонирхож яваагүй ч хадмын газар ирсэн хойно нь зайлшгүй мэдэх хэрэгтэй чухал зүйлсийг ярьж хэлж өгөв. Чингээд арван алд гяраг бүс авчирснаа гарган өргөөн доторхи хар элгийн барлагуудыг гаргаж байгаад мандарваа, Дархижав хоёртой элбэн Анугийн бүсэлхийг тасам болтол ороож өгчээ.

-Ижий минь. Амьсгаа ч ихээр авч болохгүй шахамдуулаад байна. Энэ бүсээ арай суллаж болохгүй юу? хэмээн Ануг асуухад сая тэр бүсийг бүсэлж өгөх гэж хүчлэн халууцаж, ядран бяцхан цухалтай байсан Доржравдан ахайтан цай оочлонгоо охиныхоо зүг хяламхийж:

-Гэдсээ татаж бүслээгүйгээс сав тэнь муу агшсан байна. Ганц хүүхэд төрүүлээд гүзээ давсгаа унжуулчихвал эрдээ тоогдохгүй болдог юм. Чингээд биеэ ариглаагүйгээсээ эрдээ гологдчихоод өнчин дэр тэвэрч хэвтэх гээгүй бол тэвчээр заагтун. Наад нүүрнийхээ сэвхэнд нар бүү үзүүл. Улам борлоод шавчихдаг юм. Өглөө оройдоо бүлээн сүүгээр бигнэж, зөөхийтэй тараг самбайнд түрхээд тавьж бай гэхчлэн бас баахан зөвлөгөө өгөөд морджээ.

Галдан хааныг аян дайнд мордсон хойгуур тэр зун нэг хэсэгтээ л зочин гийчний даллага авсан мэт хөлд дарагдсаны дотор Доржравдан хатныг Эмилийн зүг мордсоны хойно Зүүнгартай эртнээс найрсаг харилцаатай явсаар ирсэн Засагт хан Цэнгүний элч, Оросын Томск балгадаас яваа худалдааны төлөөлөгч Ростов нэртэй ноён Ижилийн торгууд Дашцэрэн

нэрт хэлмэрчийн хамт гийчлэв.

Засагт хан Цэнгүн урьд Чуу мэргэний үед хан ширээний төлөөх үймээн бужигнааны үед халх руу дайжин одсон албат, харьяатуудаа Түшээт хан Чахундоржоос нэхэмжлээд авч чадаагүй тул Зүүнгарын тусламжид горьдлого тавьж буй бололтой элч илгээсэн нь Галдан хааныг эзгүйд таарсан тул Юм-Агас ахайтантай уулзан байр байдлаа хүүрнээд оджээ. Чуу мэргэнийг Засагт ханд өргөмжлөхөд хүчин хавсарсан Лувсан тайж Түшээт ханд цохигдоод Ойрадын нутагт орж ирснээс Сэнгэ ханд ялагдан “идүүлсэн” билээ. Гэтэл одоо Чуу мэргэний оронд Энх-Амгалан хааны дэмжлэгээр Засагт ханы ширээ залгамжилсан энэ Цэнгүн албат иргэдээ Түшээт ханаас эгүүлэн авч хүчрэхгүй Зүүнгарт хандаж буй нь Галдан хааны хүчирхэгийг нийт Монгол даяар хүлээн зөвшиж байгаагийн дохио боловч, Анугийн хувьд энэ сэжүүрийг эр нөхөр нь өлгөн авч Халхын хэрэг явдалд хутгалдан орсноор эцэстээ Эсэн хааных шиг эмгэнэлт төгсгөлд хүрэх вий гэсэн болгоомжлол төрж байлаа. Энэ тухайгаа ч элчийг буцсаны хойно хадам эхтэйгээ зөвшилцөн, сэтгэл зовниж буйгаа хэлэв.

Засагт хан Цэнгүн хүүгээс нь дэмжлэг эрэн элч илгээж буйд их л маадгар байсан Юм-Агаст бэрийнх нь болгоомжлол үнэхээр бодууштай санагдсан ч өнгөн дээрээ “Өнөөхөндөө Зүүнгарын төр улсаа төвхнүүлэх, олон хууль цаазыг шинэчлэх, Орос, манж Чин улстай харилцах, том толгойлсон Ойрадын аймгуудыг дайлан хураах, шинэ нутагт орд өргөөгөө засах гээд Галдан хүүд минь эрхбиш оролдох ажил толгойтой үснээс нь их буй тул халхын хэрэг явдалд тэгтлээ их татагдахгүй биз. Тиймийн тулд дэмий бүү мууг зөгнөн бодож үз” хэмээн бэрдээ хэлжээ.

Засагт ханы элчтэй шил даран Ховог сайрын ордонд хүрэлцэн ирсэн холын элч Ростов ноён Галдан хааныг Алтайн урианхайг дайлаад Тагнын урианхайн зүг хөдөлснийг дуулаад дөрвөн Ойрадын хүчирхэг ноёдын нэг Очирт цэцэн ханы үзэсгэлэнт охиныг хатан буулгаж авсныг хэлмэрчээсээ дуулсан тул залуу хатантай нь уулзах хүсэлт тавьжээ.

Зуны эхэн сарын цэлмэг агаар дэндүү тунгалаг, хөх номин тэнгэрт хараацай, ураацай шувууд өндрөө аван нисэлдсэн сайхан өдөр байлаа. Ану хатан хаяаг нь шуусан өргөөндөө босоо толины өмнө суугаад их үдэд Дотоод ордонд хүлээн авч уулзах Оросын худалдааны төлөөлөгч эрхэмтэй учрахын өмнө биеэ бэлтгэн сууна. Бяцхан Сэвдэнбалжир хүү нүгэлт орчлонгийн хар хор, шунал, хүсэл, үймээн бужигнааныг үл мэдэх гэмгүй ариухан нялхсын гүн нойронд автан нам унтаж, дэргэд нь асрагч Сэндэм хэмээх залуухан сэвгэр тогосын өдөн дэвүүр бариад ялааг нь үргээн суух аж.

Ану ижийнхээ яриаг сонссоор багаасаа нүдээр үзэх мөрөөдөл тээж ирсэн Орос орны элчин төлөөлөгчтэй биеэр уулзах завшаан тохиосонд туйлаас баясан тэрхүү уулзалтанд хичээнгүйлэн бэлтгэв. Хүү төрүүлснээс хойш биеэ хайхралгүй орхисноо энэ өдөр улам ч илүү анзаарч ижийнхээ зааж өгснөөр блэхүүсээ арван алд гяраг бүсээр тасартал ороон, үүлэн хормойтой үнэт цагаан магнаг дээл, алтан шаргал түвд хоргой лавшиг өмсч, алтан утас ороож, жижиг сувдаар хээ хуар хатгамалдсан богтаг малгай тавин, эхийнхээ өгчилгөсөн ягаан туяат энгэсгээр хацраа гоодох зуур харь холын зүс буруу, заншил өөр тэр ноёнттой яажшуухан яриа өдөх тухайд бодлогошрон суулаа. Толинд туссан үлмэдэг сэвхтсэн царай, урьдынхаас арай л илүү махалсан биедээ санаа зовнихоос илүү эр нөхрийн эзгүйд хойд зүгт орших хүчирхэг хөршийн элчин төлөөлөгчтэй уулзах болсон эл завшааныг хэрхэн найрсаг, хоёр тал

сэтгэл дүүрэн үлдэхүйц ашиглах вэ? гэдэгт сэтгэл талбиж байлаа.

“Ану минь чи огт ярих хэлэлцэх юмгүйгээр харийн тэр элчтэй учирвал энэ Ойрадаар тогтохгүй гадаад гүрэнд элэг доог болох биз. Элчтэй их үдэд уулзахаар товлосон буй. Түүнээс наана насан өтөл Бэрх түшмэл хүрэлцэн ирж амжих нуу? Бурхан болсон хадам эцэг Баатар хунтайжид алба өргөж, удаа дараа Оросын зүг илгээсэн элчин төлөөлөгчдийн багт оролцон явж асан насан буурал түшмэлийг эртхэн ордондоо залан хуучилж байх минь яв даа. Ухвар мөчид л байна даа, чи Ану минь” хэмээн бодож сууснаа хонх авч жингэнүүлээ.

Гаднаас өргөөнийх нь шадар хиа Цогбадрах орж ирэн мэхийв.

-Балсанг дууд!

-Жаа.

Цагийн мөнхөд хуяг дуулганаас салдаггүй хянуур харцтай, дунд хэрийн нуруу, шагай дөрвөлжин биетэй Балсан орж ирээд асуухаас нь урьтаж:

-Хатантаан, Бэрх түшмэл зүүнтэйгээс айсуй бараа нь үзэгдэж байна. Та сэтгэлээ бүү чилээгтүн. Бичгийн түшмэл Саян таныг уншиж танилцагтий хэмээн Эрдэнэбаатар хунтайжид Их Оросын хаанаас илгээж асан захидлын тод үсгийн хадмалыг өгүүллээ хэмээгээд хуучирч шарласан муутуу цаасан дээр бичээстэй хэдэн захидал өгөв.

-Саян түшмэлээс эдгээр хуучин захидлыг авах санаа хэрхэн чамд төрөв өө? Аргагүй ухаан сийрэг байна шүү. Гялайлаа хэмээгээд захидлыг авах зуур өргөөний зүүн хатавчинд хатгамал хийн суух Мандарваа руу хяламхийн “Балсанд чигээ аягалагтун” гээд захидлыг хичээнгүйлэн уншиж эхэлвэй.

Балсан хүйтэн чигээ тааламжтайхан залгилах зуур зүүн орон дээр нойрсох нярай хүүгийн зүг өхөөрдлийн харц илгээн асрагч охин руу нүдээр дохиж “Сэвдэн хөвүүн нойрондоо сайн юм аа?” хэмээн асуух аж. Орд өргөөний элдэв хов жив, хорт явуулгыг үл мэдэх сэтгэл нь хиргүй цэвэр юм хэмээн Эмилийн эхэнд суух өөлд албатын дундаас олж ирсэн дөнгөж арван тавтай тэрхүү хөдөөх бор сэвгэр сүрлэг баатар эрээс ичингүйрэн газар шагайгаад дуугүйхэн толгой дохино.

-Жаа, би хэрмийн дааман хаалган дээр Бэрх түшмэлийг тосон авьюу даа? хэмээгээд Балсанг аягаа өвөртлөн босоход хүү өмөлзөн уйлж, Ану ч толгой өндийлгөн шадар хэвтүүлдээ “гарагтун” гэсэн дохиог нүдээрээ өгөхдөө түүний босоо хөмсөг, хөнхөр дух хайрт өрлөг эхийг нь санагдуулсанд бяцхан гуниглав.

Хатан бэлхүүсээ ороосон өргөн бүсэндээ түүртэн нуруу цэхлэн сууж хүүгээ хөхүүлэх зуур Балсангаас үүдэн төрхөмийн тухай бодож, “Муу Даадаа минь зүрхээр хатгуулдаг нь яаж буй бол доо? Энэ Балсан эцэг, эхээ хааяа ч гэсэн санадаг л байх даа? Он жил өнгөрөх тусам ижийтэйгээ улам төстэй болоод л байх юм. Сая тэр дух нь хөнхийгөөд насаар залуу, эр хүн л болохоос яг л Даадаа шүү. Бүсгүй хүн хадмын газар бэрлэн одохдоо шадар зарц барлагаа хүртэл ч хөлдөө чирэн нутаггүйдүүлэх юм даа “ гэсэн бодол орж ирэн Мандарвааг ч бас

өрөвдөнгүй харав.

Хүү нь сэрэнгүүт өчүүхэн улаан нүүрээ чинэрүүлэн зүтгэлсээр хоёр гараа хурган манцуйнаас гаргаад мээмээ барьж ховдоглон хөхөж гарав. Эр нөхрөөс нь ондоо хэн ч хүрч байгаагүй танхил цагаахан цээжин дээгүүр нь нялх үрийнх нь бяцхан хөөрхөн гар тэмтчин ирвэгэнүүлэх, хоёр жавьжаараа хөөс цахруулан гувшаа хурга мэт ховдоглон хөхөх, хүүхэд сүүгээ гуд гуд залгилахын тоолонгоор хөх нь улам саамшин цаанаасаа сүү түрэн чинэрэхийг мэдрэнэ гэдэг гайхамшиг ажээ.

“Дөнгөж сая ертөнцөд мэндэлсэн энэ алгын чинээхэн амьтан хүртэл хоёр гараа манцуйлуулахгүй хэмээн тэмцэлдэхийг яана вэ? Өнөөдөр чи гараа гаргах гэж манцуйтайгаа үзэлцэж байна. Маргааш эцгийн ор залгах, эрх мэдлээ батжуулах гээд аав шигээ зүтгэх болно. Ингэхэд миний алгын чинээхэн хүүг ямархан хувь тавилан хүлээж буй юм бол доо? Хаад, ноёдын үр, тэр дундаа ор залгах ууган хүү болон заяах гэдэг хүсмээр хувь тавилан мөн үү? Эзэн Чингисийн дүү Бэгтэр, Хубилай сэцэн хааны дүү Аригбөх, за тэгээд наашлах юм бол Эсэн тайш, хүүгийн минь авга Сэнгэ хан бүгд л төрсөн ах дүү нарын эрх мэдлийн төлөөх тэмцэл, эх өөртэй хөвүүдийн өрсөлдөөний золиос болон үхэцгээсэн. Одоохондоо Галдан хаанд бага хатан алга. Их бодоход хоёр гурван жилийн дараа гэхэд энэ өргөөнд шинэ шинэ хатад эмс ирж, хоорондоо уралдан хөвүүд төрүүлж гарна. Эцэст нь юу болох в? Өнөөдөр эхийнхээ энгэрийг бяцхан гараараа тэмтчин, ангир уургаа ховдоглон хөхөж буй энэ амьтныг эрийн цээнд хүрмэгц, эрх мэдэл, эд хөрөнгө, газар нутгийн төлөөх цуст тэмцлээр дүүрэн нүгэлт амьдрал угтах болно”. Үр хүүхэд төрүүлнэ гэдэг нэгэн бодлын аз жаргал, нөгөө бодлын үйлийн үр л юм даа. Саамшин чинэрсэн хоёр хөх нь суларч, хөхөндөө цадсан нярай хөвүүн хацраа бумбайлган нойрсмогц, асрагч Сэндэм нь ирж хүүг авлаа.

-Хоёр гарыг нь манцуйлаарай. Цочоод дав дувхийхээрээ өөрийгөө сэрээгээд байдаг юм хэмээн Ану шивнэн хэлээд босч дээл хувцасныхаа үрчлээ хуниасыг толийлгон янзлахад Мандарваа ирж, хоёр чихэнд нь урт алтан унжуурга зүүж өгөөд урдуур хойгуур нь тонголзон хувцас чимгийг нь засна.

Оросын элч Ростовгой уулзахын өмнөхөн Ану хатан Балсангийн олж ирсэн хуучин захидлыг гүйлгэн харж амжаад, урьд Эрдэнэбаатар хунтайжид алба өргөж, олон удаа Орост элчээр явж асан насан буурал Бэрх түшмэлийг Дотоод ордны бичгийн жижиг танхимд хүлээн авлаа. Тэрхүү хоёр захидлын нэг нь тахиа жилд \аргын 1645\ Оросын цагаан хаанаас Тобольскийн амбан захирагчаар дамжуулан илгээсэн хунтайжийн элчийг Москвад бүдүүлгээр үл саатуулах, Ойрадын худалдаачид Тобольск болон бусад хот балгадад гааль татваргүйгээр чөлөөтэй арилжаа, наймаа эрхлэхийг зөвшөөрсөн тухай агуулгатай байв.

Үе мөчний хүнд өвчинд нэрвэгдэн албанаас чөлөөлөгдөөд гэртээ ганц нэг ноёдын хүүхдүүдэд бичиг эрдэм заан суух болсон тэр настан, Галдан хааны Ану хатан өөрийг нь ихэд хүндлэн тоож төрийн хэрэг зөвшилцөхөөр дуудуулсанд туйлын их догдлон хөөрсөн нь илт. Урьд Эрдэнэбаатар хунтайжийн үед олонтаа орж гарч босгыг нь элээж асан Дотоод ордны бичгийн энэхүү бага танхимд залагдан ирсэндээ итгэж чадахгүй байх шиг.

Хатан хүний зүүсгэл чимэг, хоргой хувцасны сүрчигнэх чимээнээр түшлэгтэй сандал дээрээс босон дөрвөн Ойрадад цуутай Очирт цэцэн ханы охин, гоо үзэмж, ухаан саруулаараа

шагшигдсан залуу хатныг угтахдаа ёс алдахгүйг хичээн дор бөхийн амрыг нь айлтгав.

Ийм өндөр настай, Дүүрэн мэргэн багштай нь хамтдаа Ойрадын төрийн үйл хэрэгт хүчин өргөж явсан бичгийн хүмүүн өөрт нь тийн гүн хүндэтгэл үзүүлсэнд Ану хатан ч бас догдлон баярлахын хажуугаар, санаа зовж дэргэд нь шаламгайлан ирээд баруун тохой дээрээс нь дэмнэн босгож:

-Тэнгэрийн ивээлээр амархан сайн сууж байна даа. Та амар амгалан морилж байна уу? Зуслан сайхан уу? Болно, болно. Та сууж хайрла хэмээн суудалд нь залан суулгалаа.

Ану юуны түрүүнд Зүүнгарын хаан эр нөхрөө төлөөлөн хатан хүний хувьд тэрхүү элчтэй уулзахад хэрхэн яриа өдөх, биеэ яаж авч явах тухайд мэргэн түшмэлээс асууж лавлалаа.

-Хатантан минь, тэдний ёсонд хоол зоогийн үеэр эмс, хатад, авхай нар нь эр нөхрөө дагалдан ирж, зочид төлөөлөгчтэй эн тэнцүү яриа хөөрөө үүсгэдэг. Энгэр цээж задгай даашинз өмсч, үнэт эдлэл зүүж ирсэн хатдын гарыг эрчүүд, зочид эрээлэхгүйгээр үнсэн хүндэтгэл илэрхийлдэг ёсон байдгийг би олонтаа үзсэн. Тиймд та өрнийхний ёсоор, хаан хүний хатны хувьд тэр төлөөлөгчтэй эн тэнцүү, сонирхол татам яриа хөөрөө өдөж, оросын цагаан хааны гэр бүл, бие лагшин амгалан эсэхийг асууж, мэндийн найрсаг сайхан үгээр ам хагалаад, хадам эцгийн эхлүүлсэн найрсаг хөршийн харилцааг эр нөхөр тань хэвээр үргэлжлүүлэх бодолтой буйг түүний хатны хувьд уламжлах нь зүй. Аа, тийм тэднийхний зочин гийчиндээ хэлдэг нэгэн найрсаг ёсны үг нь “Та манайд гэртээ буй мэт тухлан саатна уу” гэдэг.

-За мэдлээ. Үгүй, тэр төлөөлөгч орос ноёнтон тань миний мутрыг арай үнсэж, үнгэхгүйм байгаа биз дээ? хэмээн Ануг гайхан хэлээд тас тас хөхрөн зүүн хөмсгөө өргөн харахад өвгөн түшмэл буурал тэргүүнээ сэжлэн мушийгаад:

-Харь орны ёс заншлыг тэд заавал урьдчилан судалж байж харилцдаг улс. Үгүйдээ л дагуулж яваа Ижилийн торгууд хэлмэрч нь хэлж сануулсан байх учиртай. Тиймд хатан та бүү сэтгэл чилүүрдэгтүн. Сэнгэ хантнаас хойш Орос улс, манай Ойрад Зүүнгарын харилцаа бага зэрэг царцанги байдалд ороод буй. Нэн ялангуяа худалдааны ашигтай хэлэлцээрийг нэн даруй шинэчлэн хийх цаг шахамдаад байна. Зүүнгарын төрийг түвшитгэх, цаашлаад Манж чин улсын зүгээс нүүрлэх аюулд бэлэн байхын тулд бидэнд төмөр эдлэл, зэр зэвсэг, гунан буу, галт зэвсэг шаардлагатай. Аж ахуйн хувьд ч тэр, Эрдэнэбаатар хунтайжийн эхлүүлсэн гахай, тахианы аж ахуй сүйрлийн байдалтай байгаа тул дахин үржлийн гахай авах хэрэгтэй байгаа гэхчлэн Ану хатанд туйлын тодорхой, мэргэн зөвлөгөө өгчээ.

-Мэргэн түшмэл танд туйлын их талархаж буй өчүүхэн миний сэтгэлийн илэрхийлэл болгон бяцхан бэлэг өгч буйг хүлээн авна уу гээд Ану хонх цохин гоцго дуудаад идээний дээж хар архи, шар цай, даралт буулгах улаан чавганы цай, Ховог сайрын ордонд ирснийхээ дараахан тод үсэгт буулгуулсан Түшээт хан аймгийн ван гүн нарын шастирын хураангуй хэмээх судрыг өргөн барилаа.

-Номд мөргөн хүмүүжсэн өчүүхэн бичгийн хүмүүн надад энэ судар тань хэдэн өдөр оюун тархиа баясгах амтат умдаан л гэсэн үг. Хатан танд гялайлаа. Галдан хаантанд болон Танд өчүүхэн миний хэрэгцээ гарах юм бол даруйхан элч довтолгож байгаарай. Хэрэгцээнээс

гарсан хөгшин толгой би төрд хүчин өргөх завшаан тохиолдох бүрийд чадлын хэрээр зүтгэх болно хэмээн хүндэтгэл илэрхийлэн бөхөлзөх нь бэлэг шангаас илүү Зүүнгар улсын хааны залуу хатан өөрийг нь тоож үгийг нь сонссонд хамгаас баярласан нь илт.

Удалгүй хэрмийн их харанга цохиж үд болсныг илтгэлээ. Дотоод ордны ёслолын түшмэл Чинхай орж ирэн Ану хатныг элчин төлөөлөгч хүлээн авч, төрийн хэрэг хэлэлцдэг зөвлөлдөх танхимд залан орууллаа.

Ану хатныг танхимд ороход хаан, хатны сэнтийн наагуур зэрэглэн өрсөн матмал түшлэгт сандлуудын эхэнд торгууд элчийн хамт сууж асан өндөр хянга хамар, хүрэн үс, хөнхөр хөх нүдтэй залуувтар орос ноён хүндэтгэн босч, наманчлан залбирах мэт алга хавсран мэхийгээд оросоор хэдэн үг хэлэв.

Нахиу хамартай, булиа биетэй өвгөжөөр хэлмэрч нь оросын элчийн амар мэндийг үгс, өөрийгөө танилцуулсныг орчуулж өгөхөд Ану суудалдаа очин цэмцгэрхэн суугаад Бэрх түшмэлийн зааварласнаар биеэ ихэд чөлөөтэй байлгахыг хичээн инээмсэглэж:

-Эрхэм ноён та холын замд алжаалгүй сайн явж ирэв үү? Та манайд гэртээ сууж буй мэт тавтай байхыг миний бие хүсч байна гэлээ

Энэ үгийг хэлмэрч нь хөрвүүлмэгц орос ноёнтны ухаалаг хөх нүдэнд талархлын болон ихэд тоож ойшоож буйн шинж бололтой нэгэн дулаахан гэрэл тусах шиг болж, суудал дээрээ мэхийн алга хавсраад:

-Найрсаг сайхан үгэнд тань би туйлын их талархаж байна. Хэдийгээр уулзахаар зорьж ирсэн Галдан хаан эзгүй буй ч үзэсгэлэнт залуу хатан нь намайг ийнхүү хүндэтгэн хүлээж авсанд машид сэтгэл хангалуун байгааг минь хүлээн авна уу гэхчлэн уулзалт цааш өрнөлөө.

Ану насан буурал түшмэлийн зөвлөсөн ёсоор талийгаач хадам эцэг болон Сэнгэ ханы үеэс Томскт Ойрадын худалдаачид гааль татваргүйгээр худалдаа наймаа эрхэлж байсныг сэргээх, үржлийн гахайг адуугаар солих, төмөр эдлэл, тэр дундаа гунан буу, галт зэвсэг Оросоос авах боломжийн талаар ярилцав.

Ноён Ростов Галдан хааны залуу хатныг энэ том хүсэлтэд тоглоом ч үгүй сүрдэн гайхширчээ. Чингээд Томск хотын амбан захирагч бээр Эрдэнэбаатар хунтайжийн үед эхлүүлсэн худалдааны харилцааг өргөжүүлэх хүсэл ихтэй буйг дуулгаад, манай хотоос Ойрадын худалдаачдад ахуйн хэрэглээний төмөр эдлэл наймаалахад хязгаар үл тавих бөгөөд, гунан буу, галт зэвсгийн тухайд өчүүхэн миний мэдэл үл хүрэх тул цааш амбан захирагчаар дамжуулаад Оросын эзэн хаанд энэхүү хүсэлтийг нь уламжлан дамжуулах болно хэмээгээд ганзагалан ирсэн бэлгээ гардуулжээ. Орос элчийн гардуулсан их боодолтой хоёр том хайрцаг бэлгийг аваад Ану гүнээ талархсан үг хэлж, хариу бэлэг бариад дэргэдийн хиа Цогбадрахаар шууд задлуулав.

Бага байхад нь ижий нь орос хүмүүс бэлгийг аваад шууд задалдаг ёстой хэмээн хуучилсныг санажээ.

Томск балгадын амбан захирагчаас Галдан хаанд чамин сийлбэрт модон бөгстэй галт буу, уран хийцтэй чичлүүр хутга, ширээний цаг, хатанд нь тагийг нь нээмэгц хөгжим эгшиглэн өрнийн хувцастай эр, эм хоёр бүжиглэн нааддаг мөнгөн хайрцаг, бадмаараг эрдэнийн бэлзэг, хайрцагтай чихэр жимс тэрүүтэн илгээжээ.

Тэрхүү хөгжимт оньсон тоглоомыг Ану хатан сонирхон таалж дуугаргаж үзсэнээ хажуу тийш тавин, үнэт бадмаараг бэлзгийг нэг харснаа сийлбэртэй галт буу, хөнгөн чичлүүр хутгыг ихэд сонирхон үзэж:

-Би багадаа нум сум харвах эрдэм заалгасан. Харин галт бууг төдийлөн эзэмшиж сурсангүй. Энэ хутга төмөр сайтай юм. Ир сайн авах байх. Таны үнэт бэлгэнд эр нөхрийнхөө өмнөөс болон хувийнхаа зүгээс туйлын их талархаж байна гэлээ.

Галдан хаан эзгүйг сонсоод Ану хатантай нь уулзах шийд гаргахад түүний хэлмэрч торгууд Дашцэрэн нь энэ бүсгүйг дөрвөн Ойрадад асар их нөлөөтэй хан хүний охин агаад эр хүнтэй адил бичиг, цэргийн эрдэмд гаргуун, ухаан уужуу хэмээн хэлж танилцуулсан ч авчирсан бэлгээс нь ийнхүү зэр зэвсгийг онцгойлон таална гэж бодоогүй Ростов ноён түүнийг улам ч ихээр тоож, уулзалтын эцэст хуучин танилууд мэт дотно яриа өдүүлэв.

-Эрхэм ноёнтон, илүүд дурламтгай занг чинь өршөөн соёрхоно уу. Миний бие багадаа номын багшаасаа өрнийн орнуудад бүсгүй хүн төрийн эрх барьж хаан ширээнд залардаг хэмээн сонссон юм. Танай орос оронд эмэгтэй хүн хаан ширээнд залрах ёсон бий юу? хэмээн Ану хатан зочиндоо хүндэтгэлийн зоог хонины хуйхалсан өвчүү, элэгний сорс барих үед асуулаа.

Ил гал дээр сорслон шарсан элэг амтархан зооглож байсан орос ноёнтон энэ асуултанд их л баясан:

-Дэлхий ертөнцийн талаар хатан таны ийм гүнзгий мэдлэгтэйд тань би үнэхээр биширч байна. Харин өчүүхэн миний бие эрдэм номын хүн биш. Тиймээс таны энэ асуултанд хариулахад энгүүн худалдааны түшмэл миний мэдлэг даанч хомсдох буй хэмээн эмээж байна. Миний дуулж сонссоноор өрнө дахинд эмэгтэй хүнийг хаан ширээнд залдаг зарим улс гүрэн бий. Пийлэн улсын хаан ширээнд одоогоос далаад жилийн өмнө насан хутаг болсон Елизавета Тюдор хатан хаан заларч байсан. Энэ улсад хааны үр удам эрэгтэй, эмэгтэйг үл харгалзан хаан ширээ залгамжилдаг ёстой хэмээн дуулсан юм. Мөн Испани, Франц гэсэн их гүрнүүдэд ч бас хатан хаан төрөө барьж байсан. Харин манай Орос оронд одоогоор төрийн эрх барьсан хатан хаан үгүй. Хөрш зэргэлдээ Гүрж хэмээх гүрэнд бүүр танай Чингис хаантай ойролцоо үед Георг хэмээх хаан нь хүүгүй тул гүнж Тамарадаа хаан ширээгээ залгамжлуулсан гэдэг юм.

-Тэгэхээр бүсгүй хүн төрийн жолоог атгаж болдог байх нь. Багш минь надад эртний Эллиний дан гагц эмэгтэйчүүд амь зууж, хатан хаанаар удирдуулдаг их далай дундах Амазонуудын арлын тухай домог хүүрнэж байсан юм. Харин таны нэрлэсэн тэдгээр хатан хаад улсыг удирдах ухаанаар эр хүнээс дордохгүй байж чадсан болов уу?

-Та мөхөс миний хэрээс хэтэрсэн асуулт тавин балмагдуулж байна шүү. Миний бие гимнази хэмээх сургуульд сурч байх ахуйдаа хатан таны өгүүлж буй Амазон бүсгүйчүүдийн домгийг

уншиж байснаа одоо л санаж байна гээд орос ноён Ану хатны нүүр өөд хүндэтгэнгүй харж толгой сэгсрэн:

-Их Пийлэн улсын Елизавета хатан хааны тухай миний бие тэгтлээ сайн мэдэхгүйгээ зүрхлэн өчье. Харин Гүржийн Тамара хатан хааны тухайд гэвэл энэ бүсгүй ер бусын ухаантай, мэргэн удирдагч байснаараа домог түүхэнд мөнхөрсөн байдаг. Гүржид баригдсан их хэрэм, аварга гүүр, сүр бараатай орд харш бүхнийг тэрхүү ухаант Тамара хатан хаан удирдан бариулсан гэлцэн шагшсаар байдаг юм. Гүржүүд анхлан эмэгтэй хүнээр төрөө удирдуулахдаа хэрцгий догшин эцгээс нь эмээхийн эрхэнд “Барын үр зулзага л бол эр ч бай, эм ч бай ялгаа үгүй” хэмээж байсан юм гэдэг. Харин Тамара хатан хаан хот балгад олныг байгуулаад зогсохгүй дайн тулаанд удаа дараалан ялалт байгуулж байсны дотор лал мөргөлт Персийн эзэн хаан Абубакарыг устгаад, туг сүлдийг нь загалмайн сүмдээ олзлон авчирч байсан гэлцдэг.

-Үнээр гайхалтай эрмэг дайчин хатан хаан байжээ. Манай монголд хэдийгээр таны өгүүлсэн Тамара хатан хаан шиг эцгийн ор залгамжлан төрийн хасбуу тамга барьсан бүсгүй хүн үгүй ч эзэн Чингисийн отгон хүү Толуйн хатан Сорхагтань, Гүюүг хааны хатан Огул Хаймиш гэхчлэн хэсэг зуур төр барьж байсан ухаант хатад бий. Түүнчлэн нуган үр үгүй Мандуул хаан тэнгэр болж, хаант төр ганхсан цөвүүн цаг дор алтан ургийн удам Батмөнхийг олж авчран хаан суулгаж, Монгол төрийг түвшитгэсэн Мандухай цэцэн хатны түүх ч домог болон мөнхөрсөн буй хэмээн Ану хүүрнэлээ.

Ану хатны харь гүрний элчинтэй хийсэн анхны уулзалт туйлын сайхан болж өнгөрөв.

Тэр өдөр толгой нь эргэн, дотор муухайрч архаг хууч нь хөдлөн хэвтсэн Юм-Агас хатан энэ тухай ёслолын түшмэл Чинхай, ордны гоцго, зоогойд үйлчилсэн шивэгчингүүдээс сонсч, нэг бодлын энэ ордонд ирсэн залуу хатан ийнхүү аажмаар эрх мэдэл, зарц барлагуудын хүндэтгэлийг өөртэй нь хуваалцаж эхэлсэнд дургүйцэх, уужим ухаанаар бодоод үзэхэд амьдралын их замын дөнгөж эхэнд зогсч буй Галдан хүүгийнх нь төрийн хэрэгт түшиг болж чадахуйц ухаант бэртэй болсондоо баярлах зэрэгцэн байв. Тэр өдрөөс хойш бие нь чилээрхүү байх болсон хөгшин хатан дахин бэртэйгээ тэрсэлдсэнгүй. Жаран гурван сүүдэр зооглосон, бие сул, өвчин хуучтай хөгшин ахайданд цаашид бэртэйгээ үзэлцээд байх хүч чадал ч үлдээгүйн дээр хүч түрэн ургаж нахиалж буй залуу хүний зам дээр тийнхүү тээглэх нь ч утга учиргүй юм гэдгийг ухаарсан ажгу.

Тэр зуны дунд сард урианхайн хязгаарыг өөртөө хураан захирсан Галдан хаан ордондоо эгэн ирлээ. Гурван сарын турш эзгүй байх зуурт нь хатан нь хөвүүн төрүүлж, хол ойрын элчин төлөөлөгчидтэй харилцан, улс гэрийг төвхнүүлэх үйлст нь гар бие оролцох зуур Сэвдэнбалжир хүүгээ торниулж байсны дээр хөгшин ахайдны бие доройтон хэвтэрт орсон байлуга.

Ану хатан бие чилээрхүү байгаа хадам эхийнхээ өргөөнд орж, хэд гурван үг солин, сэтгэлийг нь засаад, ордны их бойдаа Жамсран хэмээх эр дунд насны хар хүнд удахгүй болох нүсэр нүүдэлд бэлтгэх тухайд заавар өгөөд өргөө рүүгээ эргэтэл нэгэн хишигтэн цэрэг гүйж ирээд мэхийн ёслоод нүд нь гялалзан баярт мэдээг анхлан дуулгаж буйдаа сэтгэл хөөрсөн нь илт:

-Хатантаан, Галдан хааны их цэрэг айсуу хэмээгээд гүйн одов.



-Хэнгэргээ дэлд. Толгойн харуулынхныг идээ умдааны дээж, чигээ ганзгалуулан тосуулаар мордуул хэмээн Ану туслах бойдаад зарлигдаад Балсанг дуудан хилэн хар морио эмээллүүлэв.

Бодоод байхнаа хүү төрүүлснээсээ хойш бяцхан үрээ хөхүүлэх, ордны хэргийг эрхлэх, сүүлд нь хэвгэрт орсон хадам эхээ асрамжлах зэрэг элдэв үйлд дарагдан хөх тоосгон хэрэмний дотор суусаар ганц ч удаа хүлэг сайн морь унан хөдөө талаар давхин малгайн үс сэргээж, хээрийн анхилуун агаар амьсгалсангүй байсаар зуны дунд сартай золгосон байжээ.

Ану хатан ам булаалдан дүүхэлзэх хүлгийнхээ нуруунд гараад сая сэтгэл сэргэн хийморь сүлд нь хөгжөөд ирэх шиг болж, хэрмийн дааман хаалган дээр нэгэн амьсгаагаар шуугин хүрч харуулын шовгор дээр гарч, аавынхаа өгсөн дуранг гарган дурандав.

Тэртээ баруун хойд Улаан хадат уулын онь хөтлөөр бараантан нүүгэлтэх их хөсгийн түрүүнд Зүүнгарын их хар сүлд, цоросын сүлдэт туг хиураа мандуулан яваа эр нөхрөө наранд гялалзах алтан дуулга, өндөр хээр мориор нь төвөггүй таньж зүрх сэтгэл амар амгалангаа алдаж догдлон цохилж, нүд нь нь хайрын очоор гийгээд дэргэдээ зогсоо Балсанд дурангаа өгөв.

Эзэн хатнаа догдлон баяссанд дагаж хөөрсөн Балсан ч дуранг аваад хараалан:

-Тэр Данжила баатар баруун гартаа шархтай явна. Манай Бундир өрөөсөн нүдээ боочихож гэхчлэн тоочиход Ану гараас нь дурангаа аваад яаран доош буухдаа:

-Чи мөн хараа хурцтай хүн шүү. Надад ч хаантнаас бусад нь ялгагдаж үзэгдсэнгүй хэмээгээд эр нөхрөө тосон уулзахаар мориндоо ташуур өгөн хурдлав.

Ордны хөх тоосгон хэрэмнээс гаран тийнхүү хурдлан давхих зуур хүү нь өргөөнд уйлах шиг совин татаж, зүүн хөх нь чинэрээд, цайвар цэнхэр магнаг дээлийнх нь энгэрийг нэвт норгочихов. Ануг анх хадмын газар бэрлэн ирж, хөшиг тайлах ёслол үйлдсэний дараа Юм-Агас ахайтны бэлэглэсэн тахийн удамт хар хээр морь салхи мэт хурдлан Балсан тэргүүтэй дагуул баатруудаас хол тасран их цэргийн толгой хэсэг рүү очив.

Өөдөөс нь тоос манарган хурдлах хатнаа өмссөн тод өнгийн хувцас, хурдан хар хээр мориных нь зүсээр ялган таньсан эр нөхөр нь ч цэргийн цуваанаасаа тасран тосч давхилаа.

Амраг хайртыгаа давхин ирж явааг үзээд Ану агсам хээр моринхоо жолоог татасхийн нүүрэндээ учралын баяр тодруулна. Гурван сарын турш хоёр биеэ санан мөрөөдсөн амраг хос хоёр талаас учран золголоо.

-Ану! Хонгорхон минь!

-Галдаан, хаантан минь!

Ану мориныхоо амыг татан цулбуураа атгаад өвдгөө ороосон урт хормойгоо засахын зуурт нар салхинд борлон, хацар нь осгоруутсан Галдан хаан мориноосоо үсрэн бууж хатнаа эмээл дээрээс нь сэвхийтэл өргөн тэвэрлээ.

-Тавь л даа. Хүмүүс ирлээ гэх Анугийн адтай дуу хадан эр нөхрийнхөө энгэрт нүүрээ наахад Галдан түүнийхээ хүзүү, хацрыг энхрийлэн үнсч “Чи минь сайн сууж байв уу?” хэмээн шивнэхэд бэтгэртлээ санан хүлээсэн эр нөхрөө эсэн мэнд, эрүүл саруул эргэн ирсэнд баярласан бүсгүйн нүднээс сувдан дуслууд тасран ягаахан хацрыг нь даган урсч, түүнийхээ нүүр, толгой, нүд, хацрыг тэмтчин зай завсаргүй үнсэх зуур “Сайн. Чи минь сайн явж ирэв үү? Миний төлөө шалбархай ч үгүй эгэн ирсэн биз?” хэмээн шивнэхэд Галдан тас тас хөхрөөд хатнаа газарт буулган:

-шалбархай ч үгүй л ирсэн байгаа биз дээ? Харин хүү минь эрүүл энх бойжиж байна уу? Чи минь амар жимэр хөнгөрөв үү? гээд дахин хатнаа тэвэрч өргөөд:

-Арай ч хүнд лагс болоо юу даа? гэхэд Ану газар буух гэж хөлөө тийчигнүүлэх зуур:

-Хүү минь эрүүл саруул байгаа. Уруул, хамар нь тан шиг. Харин нүд хөмсөг нь надтай ижилхэн, хэчнээн хөөрхөн гээч хэмээн хөөрөн ярив.

Тэр өдөр Галдан хааны эсэн мэнд олз омогтой эргэн ирсэн, бяцхан хаан хөвүүн мэндэлснийг хамтатгасан их найр цэнгэл үйлдсэн нь үдэш сар дээр хөөрсөн хойно сая өндөрлөж, хоёр биеийг бэтгэртэл санасан хаан, хатан хоёр өргөөндөө унтахаар хэвтжээ.

Ану хатан эхэндээ хадам эхийн үгнээс зөрөн хүүгээ өөрөө хөхүүлж өсгөхөөр зүтгэсэн ч үүр шөнөөр хэдэнтээ сэрж хөхүүлэх, нярай хүүхдийг ёс юм шиг дайрдаг халуурч бүлээрэх, чихээр нь хатгуулах зэрэгт нь нойроо хугаслан асарсаар хоёр сар хүргээд өрлөг эх авчран хавсруулж билээ.

Эр нөхрөө эргэн ирсэн тэр шөнө ч өргөөнийхөө дэргэд барьсан таван ханатад суулгасан өрлөг эхэд хүүгээ өгөөд санаа амар үүл борооны ажлаа хийн цэнгэж хоножээ.

Хоёр биеийг мөрөөдөн санасан энэ гурван сараас өмнөх хөл хүндэрсэн сүүлийн саруудтай нийлээд хагас жил хэртэй урт хугацаанд эрийн энхрийллийг амсаагүй Ану хайрт нөхөртэйгээ амраглан цэнгэсний дараа орд өргөөг юуны учир нүүлгэх болсон тухай ярилцав.

-Хайрт минь, хэзээ Хар Эрчис тийш нүүх вэ? хэмээн Ану асууж тохой дээрээ өндийн нөхрийнхөө нүүр өөд харна. Тооноор тусах тэргэл сарны туяанд өргөөн дотор өдөр мэт саруул ажээ.

-Тэнд барьж буй сүмийн ажил дуусч байгаа. Арваад хоноод нүүдлийн эхний хөсөг хөдөлнө. Ижийн биеийн байдлыг харж байгаад зуны адаг сард тийшээ нүүе гэж бодож байна.

-Та надад чин үнэнээ хэл л дээ.

-Юун тухай?

-Юуны учир Ховог сайрын энэ сайхан ордноо орхин хаа хол Алтайн өвөр өөд нүүх болсон тухай?

-Алтай, Тагнын урианхайг захирахад хялбар...

-Чишш... хэмээгээд Ану нөхрийнхөө уруулыг нарийхан хуруунуудаар дарж:

-Ингэж бүү өчигтүн. Энэ бол зөвхөн халхавч шүү дээ. Би таны ёсолж авсан хатан. Намайг хошуудын Очирт цэцэн ханы охин гэж үзээд цаад санаагаа ийн өнгөлөн халхавчлах хэрэггүй ээ. Аав маань Зүүнгарын нэгдсэн төр байгуулах таны бодлыг дэмжихгүй, авга Цөхүр увш, үеэл Багабанди нартай тань эвсэн зогсч мэдэшгүй байгаа учраас л та Эмилиэс холдон нүүж байгаа бус уу?

Түрүүхэн хатантайгаа хөгжилдэн байсан Галдангийн царай хоромхоноо барайж сахлаа имрэн байснаа:

-Нэгэнт чи өөрөө ухаж ойлгож буй бол надаас асуун шахамдуулах юун. Ураг төрөл барилдан охиныг нь авсан хадамтайгаа ийн тэрсэлдэх нь чиний сэтгэлд сэв суулгах вий гэсэн зовиур үүсгэж буй тул ам нээн өчихгүй байсан билээ. Өнөөхөндөө төрхөмөөс тэнь нутаг холдон нүүхээр завдан буй нь бага хэрэг. Хэрэг явдал даамжирсаар хадам эцэг минь гэлтгүйгээр цэрэглэн дайлах өдөр ирэхэд чи минь сэтгэлээ барьдаг юм шүү гэлээ.

Ану их сүүрс алдаад жинтүү дээрээ хэвтэж тооноор шагайх очир эрдэнэ мэт оддыг ширтэн:

-“Чи минь цоросын бэр болсон болохоор өөрийгөө цорос хүн болсон гэж мэдтүгэй” хэмээн та цагаан сарын шинийн нэгэнд овоо индэртээ сацлын махаар тахил өргөж байхдаа надад өчсөнөө умартаагүй биз дээ? Тиймд таны хатан болж, цорос хүнд тооцогдох болсон надаас Та хэтдээ санаа бодлоо бүү нууж бай хэмээн гуйх гэсэн юм.

-Нууж хаах бодол байсангүй. Давхар биетэй чинийхээ сэтгэлийг бодсон юм аа.

- Аавыг дайн тулаангүйгээр тантай эв зүйгээ ололц хэмээн ятгахыг би Галдмаа ахад гуйж захидал илгээмз.

-Тэг дээ. Галдмаа баатар амин хувиа хичээхээсээ илүү дөрвөн Ойрадын эв нэгдлийг бодож, хэтийг харж чаддаг хүн. Тагнын урианхайг дайлахад минь элч илгээж, хүчин хавсрах уу хэмээн найр тавьсан хэмээн Галдан хэлээд хатнаа өөртөө наалдуулан тэвэрлээ.

Эр нөхөр нь Алтай, Тагнын урианхайг дайлсны дараа авчирсан олз омогт Ану сэтгэл хөхин баясахаас илүүтэй тэр тулаанд үрэгдсэн хоёр зуугаад цэрэг эрсийн ар гэрийнхэнд сангаас арвай будаа, замбайн гурил, идэшний хонь, тус бүр тавин лан мөнгөөр хишиг түгээж, хэрэм доторхи мөргөлийн дацан, Алтан угалзын хийдэд талийгаачдын хойноос алтан гэрэл ном хуруулав.

Галдан хаан хатныхаа эрхэлж буй энэ үйлд оролцсонгүй. Тарианы газраа эргэн, Хайнагийн сүмийн барилга дээгүүр очих, Далай ламтанд элч илгээн захидал явуулах зэргээр гадаа гэртгүй амжуулах ажил ихтэй байсаар Хар Эрчис мөрний зүгт хийх нүүдэл эхлэв.

Алтайн урианхайг дайлаад ирсэн Галдан хаан Сэнгэ ахынхаа хүү Цэвээнравданг ойр төлдөр ирж уулзсангүй, даруйхан ирж бараалх хэмээн хэл өгч авчраад, нүднээс далдуур хөгшин авга Цөхүр увштай нийлэн цэргээ бэлтгэж буй гэсэн шалтгаар ял асуух санаатай элч илгээв. Салхи

дамжин тархсан хов ярианаас улбаалан дуулахад Цэвээнравдан нь Сэнгэ хааны ууган хөвүүний хувьд тэнгэр болсон эцгийн орыг залгамжлах санаатай, түүндээ Цөхүр увш тэргүүтэн ноёдыг хамсаатан болгон өөртөө татаж буй нь сүүлийн үед илт болжээ.

Өдрөөс өдөрт хүчирхэгжин буй Галдан авга нь сайн санаалж дуудаагүйг сэжиглэсэн Цэвээнравдан хаяаг нь бараадсан эцгийнхээ хоёр дахь хатан болон эхээ цөөн хэдэн үнэнч албатын хамт аваад Турфаныг чиглэн дутааж алга болов. Түүнчлэн Галдан цастын орноос дуудагдан нутагтаа эгэн ирэхийн өмнө Далай ламын дэргэдийн мэргэн зурхайчаас хэтийн зам мөрөө асуухад “Насны нэртэй хүн замд нь садаа болно” хэмээн айлдсан нь ахынх нь их хүү Цэвээнравдан юм гэнэ лээ гэсэн цуу үг ч түүнийг зулбан одоход ташуур өгчээ.

-Та ач дүүтэйгээ эв эеийг эрхэмлэвэл сайн сан. Ургаж буй ногоо мэт залуу хүнтэй ийнхүү дайсагналцах нь хожмын өдөр бидний толгой дээр аянга болон буух вий хэмээн Ану хатан хорих санаатай байсан ч галдан хэний ч үгийг дуулсангүй. Цэвээнравданы хойноос нэхүүл илгээгээд гүйцсэнгүй алджээ.

Галдан хаан ач дүүдээ халдахыг завдсанд айж сүрдсэн Цөхүр увш ч нутаг дайжин албат харьяатаа авч Эмилийн цаадтай зулбан оджухуй.

Юм-Агас хатны бие илааршин хэвтрээс боссон ч нэгэнт урьдын тэр их цог заль, эрч хүч нь эргэн ирэхээс өнгөрсөн нь илт байлаа.

Зуны адаг сард эхэлсэн их нүүдэл хориод хоног хөвөрсөөр Намрын эхэн сар шувтарч, дэлхий ертөнц алтран налайж байхад Хар Эрчис мөрний дээд хөвөөнд байх Хар хайрханы бэлд байгуулсан шинэ орд өргөөнөө хүрэлцэн иржээ.

## Арванзургаадугаар бүлэг

### Аргын 1773 оны намар.

Эмилийн тал дахь Очирт цэцэн ханы намаржаа. Хантных үрс гаргах найр хийгээд үдэш цагаан гэгээ тасарч байхад таржээ. Сэнгэ ханыг таалал болсны дараа Галдан хувилгааныг цоросын эзэн болоод зогсохгүй, Зүүнгарын нэгдсэн төр улс байгуулна хэмээн бужигнуулж эхэлснээс хойш Ховог сайрын тэртээгээс наашлан Очирт цэцэн ханыг бараадсан Цөхүр увш, Багабанди болон Равдан зайсан тэргүүтэй Хөх нуурын хошууд ноёд, Хойдын Алдар тайш нарын зэрэг ихэс болон гурван хүү нь Очирт цэцэн ханы ёслолын өргөөнд цугларан бага шиг чуулган хийж, цаашид цөс ихт Галдан хаантай хэрхэн харилцах талаар хэлэлцэв. Сүүлийн жилүүдэд огцомхон өтөлж, охиноо хадамд мордуулснаас хойш дун цагаан сахал, үстэй болсон Очирт цэцэн үзээд өгье ч гэсэн хар үс олдохоо больсон цагаан сахлаа имрэн бодолд автан сууснаа зүүн хөмсгөө өргөж өргөөн доторхи ихэс ноёдыг тойруулан хараад:

-Галдан хунтайжийн хувьд \зориуд түүнийг хаан бус хунтайж хэмээн цохон тэмдэглэж байгаа нь илт\ хэдий миний хүргэн ч гэсэн аймшиггүйгээр Дөрвөн Ойрадын чуулганыг үл тоомсорлон дуртай цагтаа цэрэг хөдөлгөн ийш тийш дайлаар морддог болж. Хэдий Эсэн хутагтаас хойш нэгэн төрд нэгдэж чадаагүй дөрвөн Ойрадыг зангидан Зүүнгарын улс болгон түвшитгэх санаа нь зөв ч өнөөдөр Ойрадын дээд эрхийг барьдаг чуулганыг үл тоомсорлож, дагаар ирсэн ноёдод дур мэдэн газар нутаг зааж өгөх, цэрэг дайчлан ийш тийш дайлаар мордох зэргээр зоргоор аашилсаар хүзүүн дээр минь хутга тавихад хүрэх нь.

Тиймд юуны түрүүн Галдан хунтайжид дагаар орлоо хэмээн тойрон шавж буй ноёдыг Булган, Өрөнгө, Чингэл голын бэлчрээс буцаан авах нь зүйтэй юм хэмээхэд Галдмаа хүү нь чимээгүйхэн толгой сэжин суух аж. Том мөнгөн аяга дүүрэн чигээ залгилаад хөөс цахарсан жавьжаа арчих Цөхүр увш:

-Галдан цастын орны заавраар хөдөлж байна. Тиймээс эцгийн байгуулсан орд, балгадыг хүртэл орхин алс Хар Эрчисийн газар нүүдэллэж буй нь нэг талаар хадам таны өргөөнөөс алслах, нөгөө талаар цастын орны зүг одох их замыг бараадаж буй хэрэг. Ойрмогхон Алтай, Тагнын урианхайг дайлан хурааж захираад, барын хүч амтагдаж бид бүхнийг бас нэгэн амьсгаагаар цэрэглэн дайрахад бэлэн суугаа биз гэхэд хүү Багабанди нь:

-Барын зулзагыг бага дээр нь гэгчээр хүчин хамсраад Галданг цохьё гэвэй. Очирт цэцэн хан:

-Яаран Галданг дайраад дэмий биз. Харин миний бие дөрвөн Ойрадын чуулганы ханы хувьд албат иргэдээ мэдэх нь зүй тул Галданг даган одож, Өрөнгө, Булган, Чингэлд суурьшсан ноёдыг буцаан авч уугуул нутагт нь суулгаж алба татварыг чуулганы санд хураах саналтай байна гэв.

-Энэ хэрэгт миний бие хагас түмэн цэргээ дайчлан хүчин өргөхөд бэлхэн хэмээн Алдар тайш хошуу нэмлээ.

Очирт цэцэн ханы их хүү Гартангомбо эцгийн санааг дэмжихэд ямагт ахыгаа аялдан дагалддаг Эрдэнэ тайж үг дуугүй түүнтэй нэгэн талд орлоо.

Өргөөнд суусан бүх ноён удтал чимээгүй суусан Галдмаа баатрын амыг харж санаа сэдлийг нь хүлээнэ.

-Эцэг таны сэдсэн энэ хэрэг эцэстээ дөрвөн Ойрадын овог аймгууд дунд хэдэн жил үл зогсох цуст дайн тулааныг өдөөх бий дээ хэмээн сэтгэл зовниж байна. Нэгэнт нумнаас тавьсан сумыг хэн ч зогсоон эгүүлж үл болмуй. Ард олны дунд Эсэн хутагтын хойд дүр хэмээн шүтэгдэж, өдрөөс өдөрт олон ноёд ихэсийг өөртөө татан Зүүнгарын төрт улсыг байгуулахаар зориг шулуудсан Галданг бид зогсоож дийлэхээс өнгөрчээ. Монголын их хаан Элбэгийг хальсны хойно Мөнхтөмөр ноёны хөвүүдээс эхлэн Ойрадууд Монголын хаанд үл захирагдана хэмээн салнаас хойш дөчин түмэн монгол, дөрвөн түмэн Ойрад хагаралдсаны сайны үр гэж үгүй. Тэгтэл атгын чинээ дөрвөн Ойрадыг ингэж дахин хагалах юм бол Манжийн идэш болж дуусах бус уу гэлээ. Дүү Ану хатан нь хэд хоногийн өмнө элч довтолгон эцэг, нөхөр хоёрын дунд цаашлаад дөрвөн Ойрадыг бутрааж мэдэх хагарал үүсч буйд санаа сэтгэл чилүүрдэн, Галдмаа ахыгаа энэ хэргийг зохицуулахыг гүйсан байжээ.

Хүүгийнх нь энэ үг байгаа олж харвасан сум мэт үнэнийг голоор нь хэлснээс гадна насан өндөр болсон Очирт цэцэн хан өвчин хууч хөдлөн хэвтсээр дахин хоёр жил цаг төр амар жимэр байлаа.

Хойтон жилийнх нь зун Хар Эрчисийн газраас хайрт охин Ану нь хүүгээ аваад төрхөмдөө айлчлав. Монгол туургатны эртнээс сахиж ирсэн бэрлэхүйн ёсыг сахин, эцгийн гэрээс хадмын газарт ирсэн зам мөрийг гурван хаврын цас угаан арилгасан хойно тийнхүү Ану хатан төрхөмчилсөн ажгу. Хоёр ойтой Сэвдэнбалжир хүү нагац өвгийн хөмсөг, хамрыг дууриан, Очирт цэцэн хантай адил баярлах, хөөрөх, ундууцахын алинд ч зүүн хөмсгөө өргөн хардаг нь насан өтөл хантны сэтгэлийг туйлаас их хөдөлгөжээ.

Залуу цагийн гоо үзэсгэлэн гундаж, сэмбэлзсэн цэмцгэр зангаас өөр юм үлдээгүй шахуу Доржравдан хатан зээгээ үзээд урьд тэгдэггүйгээрээ хөл алдан уярч буйг харсан өвгөн хан “Өөрийнхөө төрүүлсэн үрсээс Галдмаагаас бусдад нь ингэж хөл алддаггүй сэн. Хөөрхий минь, цагийн эрхээр өтөлж, сэтгэл нялхарч дээ” хэмээн өрөвдөж байлуга. Нуран хатны өргөмөл охин Хойдын нэгэн тайжийнд бэрлэн одож, хөөрхий бага хатан ч хэрээний даль шиг тас хар үсэнд нь буурал сор суусан хижээл авгай болжээ.

Ану хатан тэндээсээ хоёр өртөө хол зусч асан Галдмаа ахынхаараа айлчлав. Ахынх нь хөвүүд хэдийнээ бэр буулган өрх тусгаарлан одоцгоож, бяцхан Ахай охин нь арван нэгэн нас хүрч, их хатан Жамьянмядаг нь төрөх дөхсөн тулгар биетэй байх аж. Ах нь хоёр жилийн өмнө бага хатан буулгасан сурагтай байсан нь Гүүш хааны угсааны төвд цус холилдсон Рэнцэнханд нэртэй Анутай нас чацуу туранхай бор сэвгэр байлаа. Галдмаагийн энэ бага хатан Улж нэрт нэгэн охин төрүүлсэн нь Сэвдэнбалжиртай нас чацуу ажээ.

Ану хатан ахындаа нэг хоног саатан гийчлээд бие чилээрхүү буй сурагтай Дүүрэн мэргэн багштайгаа золгоод гэрийн зүг одовой.

Аргын 1675 он, туулай жил гарлаа. Галдан хааны өргөө алс хол хар Эрчис мөрний газарт суурьшин төвхнөж, үржил шимт хөндийд нь олон уйгар, өөлд тариаланч өрх суулган хөх арвай, хүнсний ногоо тариалан арвин ургац авч хоёр жил цэрэг тэжээх нөөц базааж авчээ.

Жилийн өмнө Галдан хааны эх Юм-Агас хатан талийгаач болжээ.

Нарийнтах гэгч хоолойгоор нь юм орохоо больдог хүнд өвчинд нэрвэгдэн хэвтсэн хөгшин ахайтан үхэхийн өмнөх шөнөө хүүгээ дуудан ирүүлж хаан төрийн долоон эрдэнийн нэг хатан эрдэнэ болсон Анугаа хайрлан халамжилж явах, хэдий эхнэр хатан олныг буулгах нь хаан, ихэс хүний сүр хүчийг илтгэдэг авч, тэр тоолонгоор олон хөвүүдтэй болж, олон өөр эхтэй хүүдүүд эцгийн ор булаалдан алалдаж, хатан бүр хорт явуулга хийн зарим үед хааныг хөнөөсөн гунигт түүх ч буйг сануулаад ёсолсон гэргий олныг бүү аваарай хэмээн гэрээслээд эцгийн үүсгэсэн орд өргөөг бүү эзгүйрүүлж шувууны үүр болгогтун хэмээн захисан ажгу.

Чингээд эх нь эцсийн хүчээ шавхан өндийж хүүгийнхээ духыг үнэрлээд “Зүүнгарын төрт улсыг байгуулах хэмээн эцгийн гүйцэлдүүлээгүй их үйлст зорьж буйд тань ижий нь баярлан бахархдаг. Гэвчиг холыг харж хүчээ зөв нөөж яваарай. Алдар хүндэд хэтийдэн дурласан хүн эргээд сул дорой болдгийг бүү март” хэмээн захисныг Галдан хаан хожмоо хорин нэгэн жилийн дараа халхын нутагт манжийн цэрэгт битүү бүслүүлчихсэн үхэл амьдралын зааг дээр амь тэмцэн явахдаа эргэн санаж билээ. Чингээд намар оройн уйт нэгэн өглөө жаран зургаан сүүдэртэй хатан ижий нь тэнгэрийн орноо одовой.

Сэнгэ ахыгаа хорлогдсоны дараа цастын орноос дуудагдан ирж байсан цаг сая мэт авч хэдийнээ дөрвөн жил яах ийхийн зуургүй харван одоод, хөөрхий эхээ асран тэтгэж, үг сургаалийг нь тогтон сууж сонсч үрийн ачлал үзүүлээгүй мэт санагдаж Галдан хаан орных нь өмнө эмгэнэн уйлж суулаа.

-Ижий минь та бурханы оронд төрөөрэй. Аль эсвэл үр наддаа эргэн заяавал сайн сан. Таныхаа хойноос буян болгож, би Хайнагийн хийдэд насны өлмий бататгах дуган бариулах болно. Эцсийн амьсгалаа татахдаа өчсөн гэрээсийг тань насан элтэл үл умартан сахиж явна хэмээн дал мөрөө чичрэгнүүлэн уйлах хаантны ард хөлийн чимээ гарч хайрт хатан нь чимээгүйхэн орж ирээд амандаа талийгаачийн хойноос залбирал уншин, хойморт буй Очирваань, Зая бандид Намхайжамцын алтан шуумал шүтээнд мөргөөд зул асаан талбилаа.

Элбэрэлт буурал эхийн хойноос эмгэнэн харамсахдаа хэн хүнд үл үзүүлдэг ховор нулимсаа зоргоор тавин гашуудсан Галдан хаан хатнаа орж ирмэгц босч, өөрийн гараар зулын гол имхэрдэн талийгаачийн зам мөрийг нь гэрэлтүүлэх зул асаан тавих зуур маань шившсээр байвай.

Маргааш нь Хар Эрчисийн өргөөний тахилын сүмийн ширээт лам Ялгуусан гавьж тэргүүтэн лам нар цуглан бүрлээчийн хойноос Алтангэрэл хурж, өргөө даяар гашуудал зарлав. Чингээд намрын дунд сарын манант нэгэн өглөө ахайтны шарилыг хайлж, чандрыг нь алтадсан бумбанд хийн шүтээний дуганд тахижээ.

Эхийнхээ алтан шарилыг тийнхүү нандигнан хадгалсны цаад учир нь урьдны Галдан хувилгаан байх үедээ Илийн урд хөвөөнөө барьсан Хайнагийн сүмийнхээ горломд хайрт ижийн дурсгалд зориулсан хорин нэгэн тохой өндөр суварга бүтээж, чандрыг нь шүншиглэхээр шийдсэнийх буй за.

Хар Эрчисийн сав нутгаар өнтэй сайхан өвөл болж мал тарга тэвээрэг сайтай өвөлжсөн тул

Галдан хаан эхийн захиасыг даган Ховог сайрын ордон руугаа хавар эрт нүүдэллэхээр шийдэвэй.

Гурван жилийг өнтэй сайхан үдсэн Хар Эрчисийн газар лус ээлээ хайрлаж, адуу мал нь өсч үржин, ургац арвин хурааж байсандаа баярлан цагаан сарын шинийн нэгэнд орд өргөөнийхөө баруун талд орших Хар хайрханыг тахин лус баясгаад хаврын дунд сард Галдан хааны их нүүдэл зүүн өмнө зүгт чиглэн хөдөлвэй.

Тэр жилийн өвөл цас татруу орсны ачаар сөл өвсөнд цадсан мал тарга тэвээрэг алдаагүй тул холын нүүдэлд төдийлөн өөөдөхгүй, харин ч бэлчээрийн соргогыг сорчлон адгуулсаар Ховог сайрыг чиглэхэд оторлосноос дутуугүй тааваараа явсаар сарын дараа хүрэх газартаа очиход хэдийнээ урин цаг айлчлан ирж, яргуй цэцэглэн, нялх ногоо цухуйсан байлаа.

Гурван жилийн туршид эзэнгүй орхигдсон Ховог сайрын ордыг сахисан албатууд бүтэн сарын турш Дотоод ордон, Түгээмэл баясгах харшийг шинэчлэн засч, сүм, дуганы дээвэрт тогтсон шувууны сангасыг зайлуулан, хэрэм доторхи үнс, хогийг цэмбийтэл цэвэрлэжээ.

Галдан хаан эцгийн үүсгэсэн гал голомтдоо эргэн нүүж ирснийхээ дараахан шадар түшмэл, жанжингуудаа Ану хатны хамт зөвлөлдөх танхимдаа цуглуулан Эмильд суугаа хадам эцэг нь, Хөх нуурын хошууд ноёд, авга Цөхүр увштай нь эвсэн цэрэг хуримтлуулж буй мэдээг дуулгаж, хэрхэхийг зөвшилцөв.

Данжила жанжин сүрлэг дөрвөлжин цээж ханхалзуулан:

-Хаан ах минь, Очирт цэцэн хан хэдий таны хадам эцэг ч өдгөө Зүүнгарын төр улсыг байгуулах их үйлсэд тань хөндөлсөн зогссон дайсан болоод байна. Нэгэнт та Зүүнгарын нэгдсэн төрийн эзэн хэмээн өөрийгөө зарлаж, Манж чин гүрний Энх-Амгалан хаан, Оросын цагаан хаан, цастын оронд суугаа Далай ламтанд бичиг захидал илгээгээд гурван жил өнгөрч байхад дөрвөн Ойрадын чуулган хэмээх нэгэн илүү хуруу байхын хэрэг юун. Иймд хаан эзэндээ үл захирагдан том толгойлсон ноёдыг яадаг билээ, тэр ёсоор цэрэглэн хөдөлж цохилт өгье хэмээгээд Ану хатны зүг нууцхан эмээсэн ч юм шиг, болгоомжилсон ч юм шиг сэмхэн хараад авлаа. Үүнийг нь Ану ч зориуд анзаараагүй дүр үзүүлэхийг байдгаараа хичээж буй нь илт. Хэдий цоросын бэр болон ирж, хувь тавилангаа эгүүрд Галдан хаантай холбосон нь үнэн ч ийнхүү эр нөхөр, элбэрэлт эцэг хоёрын дайсагнал, зөрчилдөөн дунд орж, арга буюу төрөлх овог аймгийн эсрэг яриа хэлцээг сонсч суух нь түүнд туйлын хүнд хэрэг байв.

Биеэр Данжилагаас бэсрэг ч байлдааны арга ухаан сийлэхдээ хосгүй чадмаг Махан жанжин бол хатны эцгийг дайлах гэж буйдаа түүн шиг эвгүйцсэн шинж огтоос үгүй гэлтэй сэлмээ эрүүгээр тулан танхимд суугаа хүмүүсийг догшин нүдээр тойруулан ширвээд:

-Миний түмт Очирт цэцэн ханы цэргийг хялбархаан бут цохино. Гэхдээ цаана нь Цөхүр увш, Эрдэнэ хошууч, Хойдын Алдар хошууч нарын цэрэг хавсарч буйг тооцох нь зүй гэхэд Данжила:

-Миний бодоход одоо буй цэрэг дээр Алтай, Тагнын урианхай, хиргис аймгаас нэмж цэрэг дайчлаад, луу жилийн эхээр Эмильд бүгэн эвсээд буй Очирт цэцэн тэргүүтэй бүлэглэлийг



дайल्या.

-Галдмаа баатар эцэгтэйгээ хавсрах болов уу? хэмээн Онцонг асуухад дуугүйхэн суусаар байсан Ану хатан үгээ өчихөөр эрслэн толгой өргөж:

-Та бүхэн өчүүхэн миний амин хувийн хэргийг хэлэлцээгүй. Хэдий би Очирт цэцэн ханы охин ч одоо цоросын бэр тул төрсөн төрхөмөө гэхээс илүүтэй хадмын талд зогсохоос ондоо гарц үгүй. Нөгөөтэйгүүр түүхэнд Эсэн тайшаас хойш эргэн нэгдэж, төр улс болж чадаагүй дөрвөн Ойрадыг Зүүнгарын хаант улс болгон түвшитгэн тохинуулах үйлс миний амин хувийн эрхээс хэд дахин эрхэм үйлс билээ. Миний ах Галдмаа баатар ч худ ураг, цус нэгтнүүдийг хооронд нь хагаралдуулсан энэ тулаанд оролцохгүй хэмээсэн билээ гэв.

Галдан баруун гараар ташаа тулан ихэмсгээр тэргүүн өргөж танхимд цугларсан ноёд, түшмэлүүдийн зүг эрхэмсгээр харах нь “Хатан минь хэчнээн уужим саруул ухаантайг харцгаав уу?” хэмээсэн бардамнал илт.

Галдан хааны эх өөртэй ах Доржжав:

-Алтай, Тагнын урианхай, хиргисээс цэрэг эрсийг нэмж татах Данжилагийн санааг дэмжиж байна. Тийшээ цэрэг дайчлах хүмүүс томилон илгээж, хүнсний нөөц, зэр зэвсгээ базаах зуур басхүү Очирт цэцэн ханы хашир ухаан дөрвөн Ойрадын эв нэгдлээ бодоод сайн дураар даган ирэх эсэхийг харзная гэлээ.

Ийнхүү Галдан хаан хойтон жил гарах хүртэл хадам эцгийн бодол нааш эргэх эсэхийг харзнаад луу жилийн эхээр Эмильд цуглаад буй Очирт цэцэн хан тэргүүтэй ихэсийн бүлэглэлийг дайлахаар эцэслэн шийдэвэй. Харин Ану хатны хувьд эцэг нь хэрхэвч сайн дураар хүргэндээ дагаар орохгүй, харин ч удахгүй сөргөлдөөний галыг дүрсхийлгэх нэгэн алхам эхлүүлэх нь тод байсан тул хань нөхөр, хайрт эцэг хоёрын дунд үүссэн хагарал цус урсгахаас нааш эцэс болох нь үгүй болсонд өгүүлшгүй их шаналсан өдрүүд эхлэв.

Галдан хаанд ч эцгийн эрхэм анд, ахыг нь хунтайжийн ор залгахад хүчин харамгүй тусалсан, хайрт хатныхаа эцэг, хадамтайгаа атаатан дайсны ёсоор алалдахаас илүү хэл үгээ ололцчих юм сан хэмээсэн найдлага тасрахгүй л байлаа.

Гэвчиг эцгийнхээ занг дэндүү сайн мэддэг Ану хатны дотроо эмээн болгоомжилж байсан ёсоор болжээ. Учир юун гэвээс тэр намар өвгөн Очирт цэцэн нэгэнт Ойрадад нөлөөгөө алдаад буй чуулганы ханы хүчээ үзүүлэх гэсэн оролдлого хийж сүүлийн жилүүдэд Галдан хааны Зүүнгар улсад дагаар орж ирээд Өрөнгө, Булган, Чингэлийн голоор суурьшиж асан Алдар тайш, Данжин хунтайш, Торгууд Гомбо нарын ноёдыг цэрэглэн дайрч, хүчээр Ховог сайр, Тарвагатайн нуруугаар тархаан суулгажээ.

Хадам эцэгтэйгээ эцсийн мөчийг хүртэл эв эеийг сахисаар байсан Галдан хаан Эмилийн зүгт элч довтолгон Зүүнгарын улсын харьяат тэдгээр ноёдыг албат иргэдийн хамтаар нэн даруй эгүүлэн өгөхийг шаардсан ч өвгөн хан хөдөлсөнгүй. Дамын үгээр бол Лхас зууд мөргөлөөр одоод эгэн ирсэн Доржравдан хатан ч “Одоо л хаан хэмээн биеэ нэрлэх болоод буй тэр омог ихт залуу хувилгаанд чуулганы ханы эрх мэдлээ зүгээр найр талбин бүү өгөгтүн.

Эртнээс багш шавийн барилдлагатай явж, хошуудаар тогтохгүй дөрвөн Ойрадад шашныг дэлгэрүүлэхэд зүтгэсэн гавьяаг тань бодож, Далай багш тэргүүтэн таныг минь дэмжих нь дамжиггүй “ хэмээн хөөрөгдөн хатгасан нь үнэний хувьтай ажээ.

Туулай жилийн намрын дунд сард ногооны сөл тасраагүй, нүүдлийн цувууд буцаж амжаагүй байтал анхны цас оров. Анхны цастай уралдан Ховог сайрын өргөөнөө Лхасаас Далай ламтны элч довтолгон ирж, хошуудын Очирт цэцэн ханыг цэрэглэн дайлж эзлээд дөрвөн Ойрадыг яаралтай хураан захирагтун гэсэн зарлигийг дамжуулснаар Галдан хааны эцсийн эргэлзээг тас цохисон юм.

-Хайрт минь. Би чинийхээ сэтгэлийг бодон, басхүү өндөр насыг нь, дөрвөн Ойрадын төрд байгуулсан гавьяа зүтгэлийг нь бодоод хадмын зүг их цэрэг хөдөлгөлгүй эв эеэ хичээхийг хүлээзнэн нилээд суусан билээ. Гэтэл хантан Цөхүр увш авгыг илгээн миний албат иргэдийг цэрэглэн дайрч хүчээр уугуул нутагт нь буцаан аймшиггүйгээр надад тэрсэлсэн тул маргааш Эмилийн зүгт би дайлаар мордлоо хэмээн анхны цас хаялсан тэр үдэш Галдан хаан, хатандаа өчсөн ажгу.

Түүнээс хойш дөрвөн сарын дараа тэсгим хүйтний ам цаашилж эхлэхэд цагаан сарын шинийн гурванд Галдан хаан цорос, урианхай, хиргис гурван түмэн цэргээ гарамгай жанжин Маханаар удирдуулан өөрийн биеэр Эмиль дэх хадам эцэг, болон түүний холбоотон хэдэн ноёдын хамт дайлахаар хөдөллөө.

-Энэ байгуулж буй улсын эзэн таны л мэдэх хэрэг шүү дээ. Өдий болтол эв найрамдлыг хичээж байсныг тань би мэднээ. Гэвчиг тэр хүн хайртай үрийн тань нагац өвөг юм гэдгийг бүү умартаарай хэмээгээд Ану гурван ой өнгөрч буй Сэвдэнбалжир хүүгээ хөтөлсөөр цацал өргөн үдлээ. Төрсөн эцгийнх нь өөдөөс цэрэглэн мордож буй ханиа үдэн зогсоо залуу хатны хэвлийд хоёр дахь үр нь тийчлэн хөдлөв.

Халуун намраар эр нөхрөө тариалангийн газраа эргээд ирэхэд нь Ану хөл хүнд болсноо өчиж билээ.

-Одоо яг чамайг хуулсан хөөрхөн охин төрнө хэмээн тэгэхэд Галдан хаан баярлан хэлжээ.

их цэргийн түрүүч Сайр уулыг даван одоход Ану хүүгээ хөтлөн өргөөндөө мориллоо. Эр нөхөр нь Ану хатны шадар зуутыг энэ удаа дагуулсангүй. Хуучин эзнийхээ өөдөөс зэвсэглэн дайрах нь тэдгээр хошууд угсааны цэрэг эрсэд овог удмаасаа урван тэрсэлсэнтэй агаар нэгэн хэрэг гэдгийг ч бодолцсон биз.

Харин мэргэн харваач Бундирыг Махан жанжны хүсэлтээр авч явжээ.

Бундир ч хөөрхий настай ижий болон, хадам эх Шигшрэгтэй уулзан золгож, гэргийнхээ амар мэнд буйг дуулгах хүсэлтэй байсан аж.

Сураг дуулбал Галдмаа баатар Ойрад ахан дүүсийнхээ цусыг урсгах тулаанд оролцохгүй гэсэн тул Очирт цэцэн ханы хоёрдугаар хөвүүн Эрдэнэ хунтайж цэргээ удирдаж буй аж. Эрдэнэ хунтайжийн цэрэгт Цөхүр увш, Багабанди, Эрдэнэ хошууч нарын цэрэг бас хүчин хавсарч

байлаа. Эрийг нас, уулыг цас гэгчээр энэ жил далан дөрвөн сүүдэр зооглож, моринд мордоод өртөө газар ч шогшуулж дөнгөхгүй болсон өтөл эцгээ хэрхэн байлдана? хэмээн Ану сэтгэл чилүүрдэн шаналахын хамт, эр нөхрөө зорьсон хэргээ бүтээгээд үтэр түргэн өргөөндөө морилоосой гэж давхар хүснэ. “Эрх мэдэл, эд хөрөнгийн төлөөх жолоогүй шунал л дайныг өдүүлдэг” хэмээн хөөрхий бүрлээч Дүүрэн багшийн өчиж байсан нь хэчнээн үнэн үг байж вэ?

Нэгэнт хөгшин хонины насгүй болсон Очирт цэцэн ханд залуу идэр цагийн андынхаа хүү, отгон охинтой нь дэр нэгтгэсэн хүргэнтэйгээ тэрслэн ийнхүү олон сайхан эрсийн цус урсгах хэрэг юу байв?

Энэ насыг барсан хойно нь хэдэн үеийн үр хойчид нь ч хүрэлцэхээр мал хөрөнгө байсаар атал төрсөн дүүгээ хөнөөж, эцгийн суудал булаалдаад бас нэг дүүгийнхээ гарт үрэгдэхийн хэрэг Цэцэн тайжид бас байсан гэж үү?

Нэгэн цагт өөрийн гэсэн бичиг үсэг ч үгүй, элчилгүй уудам нутагтаа нааш цааш нүүдэллэн амь зууж, монголчуудтай холбоотон болж, монгол бичиг үсгийг зээлдэн хэрэглэж явсан манж-тэлэнгэдүүд Мин гүрний хаант төрийг эзлээд хавь ойрын овог аймгуудыг, өмнөд монголын хамт “идэж” дуусгасан атал ханаж цадахаа мэдэхгүй Их монгол улсын голомт Халх руу шуналт сарвуугаа сунгаж буйн учир юу вэ?

Үдэш бүхэн Сэвдэнбалжир хүүгээ нойрсуулчихаад Ану хатан ийнхүү түмэн бодол хөврүүлэн удтал нойр нь хулжин хэвтэх болжээ.

Галдан хааны цэрэг Эмиль тийш хөдөлснөөс хойш сарын дараа очирт цэцэн ханы цэргийг бут цохиж, хантан хоёр хатан цөөн ойр шадар хүмүүсээ авч эд хөрөнгө, албат иргэдээ орхиод Хөх нуур тийш амь зулбан одсон сураг дуулдав. Энэ тухай дуулаад Ану хатны сэтгэл бага ч гэсэн онгойлоо. хөөрхий нас дээр гарсан эцэг нь тулаан дунд үхээгүй л бол ийнхүү ялагдаж, сульдсан хадмынхаа өчүүхэн амийг эр нөхөр нь хэлтрүүлнэ гэдгийг тэр мэдэж байлаа. Хөх тэнгэр өршөөжээ. Нэгэн цагт энэ дөрвөн Ойрадын төрийн жолоог атгалцаж явсан, хүчирхэг Байбагас ханы удам Очирт цэцэн хүргэнийхээ гарт үрэгдэх нь байж болшгүй зүйл. Хөгшин хан Хөх нуурт зулбан очиж хоргодсон бол энэ нь мөшгин хөөгч Галдан хааны хувьд бас нэгэн завшаан боллоо гэсэн үг билээ.

Энэ дашрамд эртнээс Галдантай тэрсэлдэн хөх нуурт шивээлээд байсан Гүүш ханы удмын ноёдыг уулгалан дарж авах, авгатайгаа нэгдэн Зүүнгарын хаант улсын төрийг түвшитгэхийн оронд их толгойлон зугтаж одсон ач Цэвээнравданд ч сануулга өгөх хэрэгтэй байлаа. Хөх нуурын Пунцаг далай хан Очирт цэцэн ханд цэргийн тусламж үзүүлэх зэргээр Галданд тэрсэлсээр буй билээ.

Хаврын дунд сарын зэрэглээ мяралзсан цэнхэр өдөр байв. Хөх нуураас Галдан хааны элч довголгон ирлээ. Хатандаа илгээсэн захидалдаа тэрээр хадам эцгийнхээ өндөр нас, урьдын найрсаг харилцаа, ураг төрлийн хэлхээгээ бодож амийг нь өршөөн хэлтрүүлж, Бор талд нутаг олгосон гээд, очирт цэцэн ханы дагаар орохоо илэрхийлсэн Сайрам нуурын өмнө этгээд дэх Өлзийт Бум гэдэг газрын дурсгалд шинээр мэндлэх үрдээ Бум нэр өгөхийг захисан байлаа. Мөн удаа дараа өөрт нь тэрслэн эвсэл байгуулж, хадам эцгийг нь хүргэнийх нь эсрэг

турхиран ялт хэрэг өдүүлсэн авга ах Цөхүр увшийг хорьж шийтгээд, ах Сэнгийнх нь амийг хорооход гар бие оролцсон хүү Багабандийг нь цаазаар аваачсан аж. Чингэхдээ Очирт цэцэн ханыг мөн л хүргэнийх нь эсрэг турхирсан Доржравдан хатны ялыг хэлтрүүлэн нигүүлссэн агаад очирт цэцэний хүү Эрдэнэ хун тайж Алагшааг зүглэн зугтсан байв.

Амаржих дөхсөн Ану хатан амраг ханийхаа энэхүү захидлыг уншиж дуусмагц хэнхдэг цээжээ саруулстал хүндээр сүүрс алдаад өөрийн эрхгүй хацар даган урсах сувдан нулимс бөмбөрүүлэв.

Эхийнхээ дэргэд хивсэн дээр шагайгаар наадаж суусан дөрвөн настай Сэвдэнбалжир хүү шугшран уйлах эх рүүгээ гайхан хараад гүйн очиж нулимсыг нь арчин:

-Ижий та юунд уйлаав? Аавыг санаад уйлаад байгаам уу? Аль эсвэл аавд хиар цохигдсон өвөг аавыг өрөвдөөд байгаам уу? Битгий уйл хэмээн аргадаж байтал гаднаас Мандарваа орж ирэхэд Ану нулимсаа яаран арчиж, хүүгийнхээ духыг үнэрлэгчин болов.

Удтал сэтгэл зовиуртай явсаар, гэнэтийн сэтгэлийн хөдлөлд цочирдсон Ану тэр үдэшдээ төрөхөөр дуншиж эхлэв. Уг нь амаржих хугацаа нэг сар дутуу байсан аж. Хэдий сарын өмнө дутуу төрж байгаа ч хоёр дахь төрөлт нь юм гэсэндээ эрхбиш анхныхаас арай л түргэн, арай л бага өвдөх шиг түүнд санагджээ. Шөнөжин дуншсаар үүр цайж, наран мандахтай уралдан хэдий сар дутуу ч цовоо чанга дуу часхийлгэсэн бадируун чийраг охин мэндэллээ.

-Хүү юу, охин уу? Эгч минь! хэмээн яс яйрам өвдөлтөөс дөнгөн данган ангижирсан Ануг асуухад Жалбуу эх баригч доод талын үүдэн шүд нь унасан эмсгий амаа ангайн инээж:

-Охин. Тан шиг уужим магнайтай манхайсан цагаан охин хэмээгээд хүүхдийн хүйг таслан боож Мандарваад өгөөд:

-Хатантан минь наад баавгайн сарвуугаа доош нь тавиад эцээхэн дүлээрэй. Эхэснээсээ ангижирчихвал болчихно хэмээн тушаав.

Шөнөжин өвдөж хүч тамираа барсан Ану нүүрээ мэлсхийтэл нэг хүчтэй дүлж байж эхэсээ гаргаад, түшиж буй том сэгсээ налан унаад өгөв. Ов товхон сэвхэтсэн шингэн царай нь дэлбээлж буй сараана цэцгийнх мэт ягаахан өнгөө алдан цонхийжээ. Бурхан эм амьтанд үр үндсээ залган эх болох заяа тавиланг хэчнээн хүнд өвчин зовиуртайгаар оноосон юм бэ дээ. Энэ ертөнц дээр төрөхөөс үхэх хүртэлх өчүүхэн энэ хугацаа Бурхан багшийн сургаснаар үйлийн үр юм бол эм заяатанд илүү их өр төлөөс оноосон нь юуных юм бол? Угаас цус багатай, дээр нь энэ охиноо хугацаанаас нь сарын өмнө төрүүлэхдээ цус их алдсанаас цонхийж тамирдсан Ануг зарц барлагууд нь өргөөний зүүн хаяанаас өргөн орон дээр нь тавьж байхад ч, цус бялдсан өтөг бууцыг цэвэрлэн, цэгцэлж байхад ч, маарамба судсыг нь барин “Төрөхийн халуун. Хөл хүндтэйдээ сэтгэл санаа чилүүр байсных” хэмээн намдуухан ярьж байхад ч хамаг бие нь дагжин халуурсан бүсгүй юуг ч үл мэдрэн ухаан балартах, их нойронд автахын дунд оюун санаа нь дэн дун хэсэг болжээ. Тийнхүү халуурч дагжин, ухаан санаа нь орон гаран байтал дөнгөж сая үхэх төрөхийн зааг дээр аминаасаа амь, махнаасаа мах таслан төрүүлсэн алгын чинээ улаан охины чарлахад л сая хамаг хүчээ шавхан нүдээ нээлээ.

Тэгээд тохой дээрээ өндийн:

-Тэр бяцхан улаан охиныг аваад аль. Ижий нь үзье хэмээлээ. Орных нь дэргэд сандайлга дээр суун духан дээр нь хүйтэн усанд базсан алчуур тавьж байсан Мандарваа ухасхийн босч орон дээрээ үл мэдэг найгалзан ганхах эзэн хатнаа түшин аваад зангирсан хоолойгоор:

-Өрлөг эхийг нь дуудъя хатантан минь. Та мөөгтэй шөл оочлон, маарамбын өгсөн танг хүрт хэмээгээд санчигнаас нь садран унасан хэсэг үсийг нь илбэнэ.

-Зүгээр, зүгээр. Ишщямар ерөөл тавилангаар надад охин үр болж заяасан амьтан юм бол доо? Бүрлээч хадам ижийн зүүн хацар дээрх мэнгийг хуулаад төрсөн байх юм хэмээн Ану охиноо өхөөрдөн үнэрлэх зуур хар уургаа амлуулав.

-Тийм байна. Юм-Агас ахайтны сүнс биш байгаа, базар дар! хэмээн Дархижав залбирав.

-Яг л тан шиг нарийхан хөмсөгтэй атал, Галдан хааных шиг алаг нүдтэй юм. Хаантан морилон ирээд нэр хайрлах болбуу? гэж Мандарвааг өхөөрдөхөд Ану тамирдангуй ч жаргалтай инээмсэглэн:

-Аав нь өчигдрийн илгээсэн захидалдаа шинэ хүнд хайрлах нэрийг бичсэн байна лээ. Охиндоо Бум нэр өгнө гээд зүүн чихэнд нь гурвантаа “Бум” хэмээн шивнэв. Ийнхүү нагац өвөг нь хүргэнтэйгээ эвлэрч дагаар орохоор ирсэн Өлзийт Бум хэмээх газрын дурсгалыг бодож хайрласан Бум нэртэй нэгэн гүнж хорвоод мэндэлжээ. Энэ дутуу төрсөн алгын чинээ улаан амьтан мөдхөн нас биед хүрээд харь газар бэрлэн одож, хадмын газар идээшин дасах, төрсөн төрөл төрхөмөө үгүйлэн санах, эгээ л над шиг эх болох гэж алтан заадал салтал өвдөн зовох гэхчлэн бүсгүй хүний үйл, лай ланчгийг бас л эдэлнэ шүү дээ хэмээн бодохоор өр өмрөм. Ану зүрх сэтгэлийн эмзэг нэгэн цэг болсон охиноо “Над шиг төрсөн эцэг, төрөлх овог аймаг, хадмын ураг төрөл, хайрт нөхөр хоёрын дунд хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага мэт байдалд бүү ороосой” хэмээн Арьявал шүтээндээ ямагт залбирч байлаа.

Ингээд бодоод байхад Татар аймгийн Есүй бүсгүй төрөлх овог аймгийг нь хиар цохисон Чингис хааны хатан болж, эр нөхрөө хороохыг нүдээр үзэж байхдаа юу бодон шаналж байсан бол? Саяхны түүхээс л үзтэл Монголын хаан Элбэг Өлзийт гоо хатныхаа үгэнд хууртан дөрвөн Ойрадын Хутха Таюуг хилсээр хороочихоод хүү Батула чинсанд нь өгсөн Самар гүнж мөн л тийм гашуун зовлон амссан билээ. Батула чинсан Элбэг хаанаас чинсан цол, гүнж Самарыг нь гэргий болгон авсан ч эцгээ хороолгосон өш хонзонгоо мартсангүй, хожмын нэгэн өдөр хадам эцгээ хөнөөсөн шүү дээ. Тэгэхэд хөөрхий Самар гүнжид юу бодогдож байсан бол? Бүсгүй заяанд мэнэдэлснээс бус мах цусных нь тасархай үр нь л юм хойно, насны хань эр нөхөр минь миний эцгийг хороох нь түмэн зөв хэмээн санаа амар, гашуудан уйлахгүй байж чадна гэж үү? Харин ч түүх шастирт гардаг тэр олон хатад, гүнж нарын гашуун хувь тавилантай харьцуулан жишихэд эр нөхөр, эцэг хоёр минь алалдаж төгссөнгүй, би үнэхээр азтай хүн юм хэмээн залбирч байжээ.

Охин мэндлээд сар болж, Ану хатан ч нилээд тэнхэрсэн хойно Галдан хаан орд өргөөндөө эгэн ирлээ.

Хошуудын тэргүүлэгч ихэс ноёдын нэг, дөрвөн Ойрадын чуулганы хан Очирт цэцэн хан нэгэнт Галдан хаанд дагаар орсон сургаар өөлд, торгууд, дөрвөдийн олон овгууд түрхрэн ирж, шинэ тулгар Зүүнгарын захиргаанд орж эхэллээ.

Галдан хаан тийнхүү эцгийн гүйцэлдүүлж амжаагүй үйлсийг биелүүлэн Эсэн тайшаас хойш эргэн нэгдээгүй дөрвөн ойрадыг атгасан гар мэт нэгтгэн хурааж буйдаа туйлын магнай тэнүүн эгэн ирэхдээ дараагийн амьсгаагаар Хөх нуурыг, Төвдтэй хамт эзэгнэн буй Гүүш ханы угсааныхныг бут цохих бодолтой байлуга.

Амаржих хугацаанаас бүтэн сарын өмнө дутуу төрсөн Ану хатандаа ч тэрээр сэтгэл чилэн, урьд амласандаа хүрч хоёр яс хагацахад нь дэргэд нь байж чадсангүйдээ их л гэмшингүй буцаж ирэв. Алсад орд өргөө нь зэрэглээн дунд хөвөлзөн үзэгдэхэд Галдан хаан морины жолоо татан дэргэдээ яваа Данжилад хандаж:

-Урьд дөрвөн жилийн өмнө урианхайг хураан эзэлж захиргаандаа оруулаад ирэхэд минь бурхан намайг нуган үрээр мялааж билээ. Өдгөө их толгойлсон хадам эцгээ дагаар оруулаад эгэн ирэхэд ууган гүнжээр мялааж байна. Атаа таван тэнгэртээ баясан чигээ гарах цагаар Сайр уулаа тахидаг хэрэг хэмээгээд сахлаа шувтрав.

Чингээд араасаа нүүгэлтэх их хөсгийн зүг сэтгэл дүүрэн, яг л хандгай унагасан чоно олзоо үзээд бахдах шиг хараад ташаа тулан ач дүүгээ харж:

-Эрдэнэ тайшийн охин Хишигжаргалыг чи хатан буулган ав.Хэчнээн жил гон бие, элдэв зам зуурын эмс охидоор зугаа хийж явах гэв хэмээн эзний ёсоор захиран тушаах, авгын хувьд халамжлан хайрлах хоёрын завсарт хэлээд “Миний хатан Ану руу өлөн харц унагаж явдгийг чинь эс мэдэгчин биш. Гэвчиг гоо үзэсгэлэнгийн өмнө харц юуны буруу байх билээ? Хэрэв үхэх үйл нь ирж би нэг л өдөр талийж одох юм бол эртнээс уламжлалт “асраху” ёсыг далимдуулан миний хатанг авах гэж Доржжав ах, энэ Данжила,Цэвээнравдан мэт ач дүү нар яс булаалдах ноход мэт ноцолдох болбуу” гэж бодохоос цухал нь төрж, их дэл хийсгэсэн агсан хээр мориндоо ташуур өгөн ордныхоо зүг хурдлан давхилаа. Их цэргийн магнайд хавар цагийн хөгжөөнт салхинаа дэрвэн хийсч буй цорос овогтны сүлд шигээ мандан бадарч яваа эр хүний хувьд үхэл мөхлийн тухайд бодохыг ч хүссэнгүй. Хөх тэнгэрт дүүлэн хисэх хүчит бүргэд хэзээ нэгэн цагт хөрст газар ясаа тавих тухай боддог гэж үү?

Гэргий хүүхдээ асрах сөхөө үгүй, Алагшаа тийш ум хумгүй хулжин одсон Эрдэнэ тайшийн охин алаг нүдэн Хишигжаргал эхэндээ Галдан хааны дурыг булааж, хээрийн асартаа хэд хоног аваачин цэнгэж, бага хатнаа болгон буулгадаг ч юм уу хэмээн бодож байснаа орд өргөөнийхөө барааг үзээд, эцэг, эр нөхөр хоёрын цуст тэмцэлд сэтгэлээр шаналан зовсны улмаас дутуу төрсөн хайрт хатан нь бодогдмогц, басхүү “... хаан төрийн найман эрдэнийн нэг хатан эрдэнэ болсон Анугаа хайрлан халамжилж явах, хэдий эхнэр олныг буулгах нь хаан, ихэс хүний сүр хүчийг илтгэдэг авч, тэр тоолонгоор олон хөвүүдтэй болж олон өөр эхтэй хүүдүүд эцгийн ор булаалдан алалдаж, хатан бүр хорт явуулга хийн зарим үед хааныг хөнөөсөн гунигт түүх ч буйг санан ёсолсон гэргий олныг бүү аваарай” гэсэн хөөрхий эхийнхээ гэрээсийг ч эргэн санажээ.

Ховог сайрын ордын баруунтайх онь хөтөл дээр Ану хатных нь илгээсэн Балсан тэргүүтэй

толгойн харуулынхан хаан эзнээ угтахаар давхилдан ирлээ.

-Балсан! Сайн сууж байв уу?Орд өргөө амгалан уу?

-Хаантан, хөх тэнгэрийн ивээлээр амгалан сайхан сууж байна.Хатантны бие сайн.

-Ану минь тэнхэрч байна уу? Шинэ төрсөн бяцхан гүнж?

-Хатан тэнхэрч байгаа. Амаржихдаа нилээд сульдаж ядарсан тул маарамба морь унаж таныг угтахыг хорьсон.Гүнж торниж байна гээд Балсан багын анд Бундирын давхин ирэхийг хараад хаанд мэхийн:

-Жаа, хаан эзэнтэн!Би Бундирын амар мэндийг эрж ар гэрийн тухай сураг ажиг тавьж болох сон болбуу? хэмээв.

-Тэг,тэг.Танайхан сайн сууж байна гэнэ лээ гээд Галдан хаан замын илгээсэн цартай идээнд ам хүрээд хатантайгаа учран золгохоор яаран мориндоо мордож ташуур өглөө.

Уул даваа дамнан нүүгэлтэж айсуй их цэргийн цувааны магнайд яваа багын анд руугаа давхин очсон Балсан баруун гараа сойсныг нь сая л ажиглав.

-Хөхөгчин баатарт халти цавчуулчихлаа. Булган үзээд уйлна даа хэмээн Бундир анддаа хэлээд тэврэлдэн золгов.

-Амьд мэнд гарсан нь яамай. Атаа таван тэнгэртээ залбирч яв гэж гэж Булганд хэлэхгүй юу. Хуучин цагааг нь ууж явсан хан эзнийхээ өмнөөс зэвсэглэн одох хэцүү байв уу?Ижий маань сайн сууж байна уу? гэхчлэн хар багаас дээлээ урагдтал ноцолдож явсан хоёр анд хээрийн хойморт хууч хөөрөн сууцгаалаа.

-Ижий тэнь бие тэнхээ сайнгүй байна лээ. Гэхдээ эгч тэнь ижийгээ сайхан асарч буй. Сая хаад, ноёдын тулаан, нүүдэл суудал, үймээний хөлд л ижий тэнь их ядарсан байна лээ. Энийг чамд өгүүлсэн хэмээгээд онгож хуучирсан улаан дурдан алчуурт боосон юм гаргаж өгөхдөө, бундир сойлттой гарынхаа шархыг хөндчихөөд өрөөсөн өвдгөө нугалан суув.

Энэ алчуурыг эх нь залуудаа үе үе гарган духан дээгүүрээ цэцэглэн зангиддаг байсан аж. Тэгээд энэхүү алчуурыг аав тань анх танилцаад бэлэглэж билээ...” хэмээн хуучилдаг байсныг санаж яаран задалбал гурван ширхэг мөлийсөн чулуу гарч ирлээ.

-Эр хүмүүний замын хүзүү урт гэдэг юм. Халхын Түшээт ханы нутагт очвол энэ гурван чулууг аваачин шороонд нь талбиарай хэмээн ижий тэнь захиж байна лээ. Байрнаасаа хөдөлсөн чулуу гурван жил зовдог юм гэнэ лээ.Эх нутаг Өрөмийн голынхоо энэ чулууг гучин жил өвөртөлж явна. Эргээд эх шороондоо очиг, нутгийнхаа чулууг харьд орхин үхээд яахав гэж ижий тэнь хэлүүлсэн хэмээн Бундир захиасыг нь дамжуулав.

Хөөрхий ижий нь. Харц ядуу, бүсгүй хүний заяа тавилан юутай хатуу вэ? Гучин жилийн тэртээ эцгийг нь даган алс холын Алшаа нутагт бэрлэн одсоноос хойшхи, энэ олон жилд төрсөн нутгийнхаа барааг ганц ч удаа харсангүй. Эдүгээ хадан гэртээ очих ойртсоноо мэдээд

унасан газар, угаасан нутаг, төрөл төрхөмийнх нь цорын ганц дурсгал, эх нутгийнхаа гурван чулууг эгүүлэн тавихыг хүүдээ захиж хүнээр өгчилгөн явуулж байдаг.

Ийнхүү хайрт ижийгээ санан нүдэнд нь ганц дусал нулимс цийлэгнэн ирэхэд хаврын цэнхэр зэрэглээнд мяралзан хөвөлзөх алсын уулсыг ширтээч болж цааш нь залгиад Балсан босч мориныхоо олмыг чангалангаа:

-Гялайлаа чамд! За хэрэмний зүг явцгаая даа. Булган чамайг харуулдаад сүйд биз хэмээлээ.

-Чамайг хошууд бүсгүйтэй дэр нэгтгээрэй гэж ижий тэнь захиж байна лээ.

-Тийм үү?

-Хаантны олзолсон өрхүүд дунд сайхан бүсгүйчүүд бий шүү гэхчлэн анд хоёрын ярианы чиг эрчүүдийн шохоорхдог сэдэвг шилжив.

Хайрт хатныхаа өмнө эрхгүй тэргүүн гудайлган, харц буруулахад хүргэж байсан хүзүүн дээрх хатиг мэт хөндүүр эмзэг хэрэг болох хадамтай өдүүлсэн тэмцэл тийнхүү эв эеэр шийдэгдээд ирснийг мялаан тас хар сэвлэг намируулсан, өөрийг нь өвчсөн мэт ижил, ижийнх нь зүүн хацар дээрх мэргийг дууриасан тохойн чинээ нярай охин Ану хатны зүүн орон дээр нойрсч буйг үзээд Галдан хаан нэрэлхэлгүй өгүүлэхэд дөрвөн жилийн өмнө анх нуган үртэй болж байснаасаа ч хэдэн хувь илүү баяр хөөрийн оч сэтгэлд нь харвах шиг санагджээ.

-Таны соёрхсон Бум гэдэг нэрийг охиндоо хайрласан. Тэнгэрт одсон ижийн мэнгэ яг тэр газраа байж байгаа биз? хэмээн ердийн байдгаасаа ялимгүй махалсан Ану хатан нялх үрээ ширтэн орны өмнө сөхөрсөн нөхрийнхөө мөрийг түшин эрхлэнгүй асууна.

-Ижийн минь сүнс үр наддаа эгэн ирээ юм болов уу? Би хойноос нь насны ерөөл их л уншсан даа хэмээн Галдан хэлээд тохойн чинээ тэр амьтны эрхий дарам өчүүхэн зулайд үнэрлээд баруун хойроо суух зуур:

-Үр үндсээ үзнэ гэдэг нэг талаас сайхан, нөгөө талаас дэндүү сэтгэлийн чилүүр юм. Ийм өчүүхөн тохойн чинээ амьтан яажшуухан хүн болно доо. Цагаан, улаан бурхан, хамрын шуухинаа ч холуур яваасай гээд л Сэвдэнг манцуйтай ахуйд ямагт би ар гэр тийш сэтгэл аргамжаатай явдаг сан. Чингээд одоо хоёр халуун амь надаас тасарсан тул, сэтгэл бас л хоёр дахин их чилж явах нь. Сахил санваартай, гэргий хүүхэд үгүй явах бас нэгэн бодлын амар юм даа хэмээн бодлогошрон хэлэв.

-Тийм шүү. Ер нь таныг бурханы шавь байсан амар амгалан амьдралаа ямагт эгэн дурсдаг байх даа гэж би боддог. Зарим үед сахил санваараа хэрэггүй ч орхин, энэ ертөнцийн нүгэлт эргүүлэгт оров уу даа гэж бодогддог л биз дээ? гэж Ану асуухад

-Энэ амьдрал гэдэг үйлийн үр шүү дээ. Хэн ч бурханы зурсан төөрөг тавилангийнхаа боол нь л болж амьдардаг. Миний хувьд Зая бандид багшийг дагалдан эцгийнхээ үгэнд орж Цастын орныг зорихдоо дотроо үнээр дурамжхан байсан. Намайг бурханы шавь болохоор алсын аянд долоон настайдаа мордоход арван наймтай Сэнгэ ах хүлгийн хурдныг унан давхиж, ижий



аавынхаа дэргэд хоцроход би түүнтэй солигдоод гэртээ үлдэх сэн гэж хэчнээн хүсч байсан бэ! Тиймд харамсан хар буух юм надад үгүй ээ. Зүгээр нялх нялзрай үрсээ үзээд эр хүнд үүсдэг айдас л тэгж хэлэхэд хүргэв биз хэмээн Галдан хэлж хатнаа энхрийлэн ширтлээ.

- Тээр жил таныг хувилгаан байх ахуйд Угалзын хийдэд цам харайхад манайхан цугтаа очиж байсныг санаж байна уу?

“Үгүй нээрэн, Сэнгэ ах амьд мэнд, би хар болоогүй дөрвөн Ойрадын шашны тэргүүн, номын их багш хэвээр явсан бол өдийд ямархан заяа төөрөгтэй байх байсан бол оо?” хэмээн оюун бодлын ертөнцөд эгээрэн суутлаа хатныхаа эл асуултыг сонсоод тулгамдсанаа нуух мэт:

-Саналгүй дээ гэчихээд сэхээ орж:

-Юу билээ? Тэр зун чинь нээрээ ах амьд, би сэтгэлт сэвгэрээ түүнд алдах нь хэмээн ухаан санаа дэн дун явсан биш үү? гээд Галдан хүд хүд инээхэд Ану гаднаас хавчаахай нум бариад чавхдан орж ирсэн дүрсгүй хүүдээ хүйтэн цийдэм аягалангаа:

-Тэгэхэд би нэг зүүд зэрэглээ мэт хачин явдалтай тохиож, түүнээ өнөөг хүртэл хэнд ч ам нээж хүүрнэлгүй өдий хүрсэн юм. Тэр тухайгаа танд хүүрнэж бодлыг тань сонсмоор санагдлаа ...Хатныхаа яриаг сонсох байхын завсарт дахиад оюун бодлын ертөнцөөр ухаан санаа нь дураар сэлгүүцэх мэт элдэв бодолд ээрэгдэн суусан Галдан сая сэхээ орох мэт болж:

-Яалаа гэнээ? Юун зүүд зөн билээ? гэхэд

-Цамын дундуур бил үү,би гэнэт Илийн тохой руу очмоор санагдаад ганцаараа олноос тасарч голын хөвөөн дээр ирсэн юм.Тэгтэл алмуур таяг тулсан харь хувцастай эмгэн ирж “Чи хайр сэтгэлтэй хүнтэйгээ гэрлэх юм байна. Тэр хүнтэйгээ чи тэнгэрт адислагдсан юм байна. Та хоёр хэдэн төрөлдөө хослон амьдарсан улс юм...Аз жаргал дэргэд чинь байна,бүсгүй минь” гээд хүүе гэхийн завдалгүй цааш эргээд алхсан юм.

-Уухай...нөхрийнх нь байдал төрх ихэд сонирхсон шинжтэйд урамшсан Ану:

-Чингээд би “Тэр хүн чинь хэн юм бэ?” хэмээн асуухад эмгэн хариулсангүй. Харин “Тун удахгүй тэр хүн хаан болж,чи хатан суудалд суух боловч ид насандаа хорвоогийн амьдралыг түүнийхээ төлөө орхиж, дайн тулааны талбарт үхэх юм байна” гэсэн. Тэгснээ намайг алмайран зогсох чөлөөнөөр өнөөх алмуурт эмгэн тэнь газарт шингэж, тэнгэрт хөөрөх мэт ул мөргүй сарнин алга болсон юм...

-Жигтэй л юм. Тэнгэрийн бошиг үзүүлэгч таарсан гэлтэй. Миний санаанд бас нэг юм орчихлоо. Тэр цам харайсан үдэш чи надад Балсангаар тамхины хавтага явуулсан шүү дээ. Сахил санваар хүртсэний улмаас сэтгэлт сэвгэрээ зулай гишгэж төрсөн ахдаа алдав хэмээн би их л гашуудаж суусан санана. Чингээд нэгэнт өөрөө санваартан хүн тул ахынхаа болон , зүрхний хайрт чинийхээ хувь тавиланг шоо орхин үзье хэмээн сэтгэл шулуудан шоо орхитол “хурим болохгүй” гэсэн төлөг бууж билээ.

Энэ тухай би ч бас хэн хүнд хүүрнэлгүй өөртөө л хадгалсаар ирсэн юм.

-Бурхан ч бай, буг ч бай тэр эмгэн та бид хоёрыг тэнгэрт адислагдсан хоёр гэсэнд би ямагт билэгшээж явдаг юм.

-Тэнгэрт адислагдсан гэнээ? Тэр эмгэний зарим хэлсэн нь харин ч билэг ерөөл муутай юм биш үү?

-Намайг хаан хүний хатан болж, хатгалдах дайсны халуун зэвсгийн суманд үхэх тавилантай гэж бас ижий, аав хоёр маань бүр намайг дөнгөж эхийн хэвлийд байхад зүүдэлсэн юм гэнэ лээ...

Очирт цэцэн ханыг эрхэндээ оруулсны хойно Галдан хаан ордондоо Ойрадын нэр нөлөөтэй ноёд ихэсийг цуглуулан чуулж, хэд хэдэн зарлиг гаргасны дотор Дөрвөн Ойрадын чуулганыг буулгаж, их аймгуудын ноёдын тайш, хан хэргэмийг хасч, аймгуудын толгой даасан эрх мэдлийг үгүй хийн жижиг отгуудад хуваарилан өөрчлөв.

Үүнээс цааш, түүнээс хойш ноёд ихэс биеэ хан ван өргөмжлөхийг Галдан хаан тийнхүү цаазлан хорьж, гагцхүү хааны зарлигаар л отгуудын зайсанг томилж байх тухай журам гаргажээ. Түүнчлэн хадам эцгийн хатгалгаар дэгдсэн үймээн самууныг дарахаар яваад ордондоо эгэн ирэхэд нь Ану хатан нь “Таныг их цэрэг хөдөлгөн одсоны сургаар Ойрад даяар дээрэм, тонуул ихсэж, хэмжээгүй их цуу яриа дэгдсэний уршгаар айлууд нутгаа орхин нааш цааш эмх замбараагүй бутран нүүж, зарим нь харьд хальж одсон ахан дүүсээ бараадна хэмээн эд хөрөнгө, мал хуйгаа зарж үрэх зэргээр бужигнацгааж байна. Та зүүн гарын хаан эзний хувьд энэ их үймээн самууныг арилгахын тулд хатуу цааз зарлиг гарган, нурманд үлдэж хоцорсон цог руу ус цацан унтраах цаг болжээ” хэмээн сануулсны дагуу “Дөрвөн зүйлт зарлиг бичиг” хэмээх цааз гаргав.

Галдан хааны энэхүү цааз зарлигт “Нэгд, Овог аймаг бүрийн бүрийн ахлагч нар буснин тарж одсон харьяат иргэдээ цуглуулан суурьшуулах, эс дагаваас хатуу цээрлүүлнэ. Хоёрт, Хулгай дээрмийг чандлан хориглоно. Хулгайн хэргийг дээш үл мэдүүлбээс аравтын даргын гарыг тас чавчмой. Гутгаарт, Заргын хэргийг гурвантаа мэдүүлсээр атал үл тасалбаас заргын түшмэлээс ял асууна. Дөтгөөрт, Хулгайчийг тавьж явуулсан этгээдийг торгож шийтгэн, барьж ирснийг хөхүүлэн шагнана” хэмээжүхүй.

Тийнхүү дөрвөн Ойрадын холбооны чуулган хэмээгч нь төрийн эрх мэдэж байсан цаг хулжин одож, Ойрад түмэн Галдан хааны мэдэлд бүрэн захирагдах болж, Зүүнгар улсын төрийн голомт галаа өрдөж эхэлсэн билээ.

Дараа жил нь Ану хатан дахин нэгэн охин төрүүлснийг Юмчихай хэмээн нэрийдэвэй. Галдан хааныг Зүүнгар улсын эзэн хаан хэмээн хүлээн зөвшөөрч дагаар орох овог аймгууд улам их болж, ноёд ихэс охидоо ураглуулах гэж санаархах, өнгө үзэсгэлэнт сэвгэрүүдийг илт авчран өргөх болсон тул Ховог сайрын ордон дахь татвар эмсийн өргөө байсан хэсгээр хоёр ч гэр шинээр барьжээ. Галдан хаан хэдий шинэ бага хатан буулгаагүй ч гурван татвар эмтэй болж, нэгэнт төрийн их хатанд өргөмжлөгдсөн Ану эхийнхээ сургаснаар эр нөхрөө хардан, харамлах сэтгэлийн албингаа дарах гэж шүдээ зуун явах болов. Галдан хааны хатнаа гэх хайр хэвээр юм шиг атал байсгээд л ордны татвар эмсийн өргөө байрлах зүүн өмнөд хэсэгт шинэ өргөө нэмэгдэн, эр нөхөр нь хэдэн шөнө дараалан шинэ татвараа амтлахаар алга болоход Ану

хатан шөнийн уртыг судар ном эргүүлэн хулжсан нойроо дуудан арай ядан барах агаад , зарим үед дэрээ нэвтэртэл уйлж хонох нь ч байлаа.

Загалмайтны тооллын 1677 он, улаагчин могой жилийн хавар эрт Юмчихай охиныг ой өнгөрч байхад Бор талд суусаар байсан Очирт цэцэн хантны өргөөнөөс охин Анудаа “Хадан гэртээ очих цаг ирэв. Яаралтай ирж уулзан, эцсийн удаа зүсээ үзүүл” гэсэн хэл ирүүлжээ.

“Аав, насан буурал аав минь. Заяа муут охин үр намайгаа довтолгон очтол сэрүүн тунгалаг байж, эцсийн гэрээс үгээ айлдаарай. Эцэг таны минь элбэрэл хайрын халуун илч л энэрэн өршөөхийг үл мэдэх хатуу хахир энэ хорвоогийн амьдралыг туулах хүчийг надад хайрлах юм. Ёсолж авсан хайрт нөхөр минь өтөл буурай таны зүг цэрэглэн хөдлөхөд элэг минь хаачих билээ, би хэчнээн их энэлэн шаналав. Тэглээ гээд энэ хорвоогийн шар наран, бор хоног ээлжлэн сар жил хөвөрсөөр ахуйд эцэг таныгаа эрүүл эсэн явахад халуун голомтдоо гийчлэн очиж гангар гунгар хөөрөлдөж ч завдсангүй. Мунхаг үр намайгаа өршөө, аав минь” хэмээн Ану хатан замын туршид бодолд дарагдан довтолгож явлаа.

-Чи минь хөнгөрөөд жил ч болоогүй шахам. Орос газраас авчирсан зөөлөн нумт пийлэн тэргээр тухтай тавтай явагтун хэмээн нөхөр нь халамж тавьсан ч Ану дал хол гарсан эцгийнхээ амьдад очихоор туйлаас яаран адгаж байсан тул Балсан тэргүүтэй цөөхөн бараа бологч дагуулан сэлгээний хэдэн сайн морьтой яаран гарчээ.

Бүтэн хоёр өдөр довтолгосоор Бор тал дахь эцгийн өргөөнд ирээд Ану хатан эргээд л шийр цагаан унаганы нуруунд ааваараа түшүүлэн мордож байсан эрх бяцхан гүнж болон хувирчих мэт санагдав.

Эрх хонгор бага нас...Элбэрэл хайр дүүрэн эцгийн голомт...

Урьдын хүчирхэг явсан үетэй нь жишихийн эрхгүй илт доройтон буурсан ганц найман ханат өргөө, тойроод цөөхөн хэдэн албатуудын бор гэрүүд, морины уяаны дэргэдэх гадаснаас аргамжаатай ганц ботгоны буйлах уйтай дуу...

Ануг айсуй хэмээн алсаас барааг нь харсан бололтой эх нь уян дээрээ Ануг угтав. Доржавдан хатан дөрвөн Ойрадын чуулганы хан эр нөхрөө ид чадалтайд Алшаад өргөөнийхөө эргэн тойрон мод бут суулгуулах зэргээр тухалж, хаа холын Хами, Самаркандаас ховор нандин жимс зөөлгөн ямбалж, Алшаа,Хөх нуур, Эмильд хаана ч нутагласан төрийн их хэрэг хэлэлцдэг ёслолын өргөө, бичгийн гэр, хатдын олон өргөөнүүд, хоолон гэр тойрон буусан асар том тиг гортигтой их өргөөнд сууж, ганган чамин бүхнийг өмсч зүүн, өнгө үзэсгэлэнгээ гайхуулж явсан гэхээргүй зүдрэнгэ царайлсан туранхай авгай болсныг үзээд Балсан ч ихэд цочжээ.

- Ишш, үр минь хүрээд ирэв үү?Аян замдаа сайн явж байна уу? Амжлаа шүү, амжлаа хэмээн ахайтан хэлээд охиноо тэврэн баруун хацар дээр нь үнсэхэд Ану хатан ингэж их өтөлж ядарсан байхын чинээ санаагүй хөрхий эхийгээ өрөвдөн:

-Сайн, явж ирлээ, ижий. Та сайн сууж байна уу? Аавын бие ямар байна? хэмээн хоолой чичрүүлэн асуухдаа нулимсаа арай ядан барьж чадав. Эх нь:

-Аав нь тааруухан. Чамайг хүлээгээд л хэмээснээ өөрийнхөө өмссөн шинэхэн үйтэнхуар дээлийн хормойг засан толийлгоод:

-Ижий нь толиотой харагдаж байна уу? гээд тэр жил Лхаст мөргөлөөр явахдаа авсан урт танан ээмгээ засахыг үзсэн Ану “Өтөлсөн болохоос үхсэн биш гэгчээр ээж минь бас л зан ааш хэвээрээ байна шүү” хэмээн бодоод мушийн инээмсэглэж, сэтгэл бага зэрэг сэргэн:

-Ижий, та яг л хэвээрээ залуухан ахайтан мэт гялалзаж байна гэж урьдных шиг хөнгөхөн тохуутай хэлээд эцгийн хэвтэж буй өргөөнд орлоо.

Тавилга сэлт нь хуучирч муудсан өргөөний баруунтайх агар зандан орон дээр хэвтэж, Жангарагийн аманд нь дөхүүлсэн аягатайг арай ядан ганц нэг оочих Очирт цэцэн хан охиноо үзэнгүүт аягыг хажуу тийш түлхэн өндийгөөд ирэв.

-Аав аа, аав минь!!!...

-Миний үр! Хүрээд ирэх гэж... Сайн явж ирэв үү? гээд өвгөн хан сэтгэлийн хөдөлгөөнөө дийлсэнгүй амьсгаадан хоргой жинтүү дээрээ уначихлаа.

-Сайн явж ирлээ гэх Ану багынх шигээ гүйн очиж эцгийнхээ энгэрт наалдав.

-Хэнз үрийнхээ барааг хараад үхэхэд гомдолгүй хэмээн шүтээндээ залбирч байлаа гээд хан амьсгаадан охиныхоо хацар, духыг үнэрлэн толгойг нь элгэндээ наасан хэвээр:

-Аав нь тээршааж, бушуухан энэ орчлонгоос одох сон гэмээр урт насалж, энэ бие минь элэгдэн доройтож байна. Одоо хадан гэртээ очиход өчүүхэн хугацаа үлдээ биз. Үр минь Ховог сайрт сайн сууж байв уу? Нагац өвгөө дууриан зүүн хөмсгөө өргөдөг бяцхан зээ хүү, ойр төлдөрхөн мэндэлсэн зээ охид цөм сайн уу? хэмээн асууж жинтүүгээ налан гэдрэг хэвглээ. Эхтэйгээ гадаа учрахдаа нулимсаа барьж чадсан атал өвчин хууч нь сэдрэн доройтсон эцгээ үзсэн Ану тэссэнгүй. Ганц хоёр сувдан дусал өөрийн эрхгүй хацар даган урсахад нь арчсан ч үгүй.

-Сайн цөм сайн, аав минь. Алив тэр цийдмийг нь би өгье хэмээн Жангарагийн гараас дунд гарын мөнгөн тагштайг авлаа.

-Хэрэггүй, Та цай зоог хүрт. Би өөр шивэгчин дуудъя хэмээн Жангараг хэлэв.

-Хүн өвдөх өвчингүй, эрх дураар морин дэл дээр хийсгэж явахын сайхныг өдөржин гэрийн мухарт хэвтэх цагтаа л сая ухаардаг юм байна. Алив бүхэнд зорьж, тэмүүлж, их үйлс бүтээж явахад хугацаа дэндүү давчуу хэрнээ, хорвоо цаг дээрээ санаснаас хэтийдсэн уйтан байдаг юм байна, үр минь гээд эцэг нь овоо сэргэж өндийн хэзээний зангаар цал буурал зүүн хөмсгөө өргөн:

-Аав нь урьдынх шиг баян тарган, нэр сүр ихтэй явах чадал үгүй болж. Гэвч үзсэн туулсан амьдрал, бурханы над оноож зурсан хувь тавиланд сүслэн талархаж явдаг. Ану охиноо үзээд үхье гэсэн эцсийн хүсэлтийг минь ч бурхан шүтээн минь гээд хоймор дахь Арьяавал бурханы

алтан шуумал өөд сэжээд:

-Сонслоо гэснээ санаа амрах мэт хэсэг ухаан балартчихлаа.

Тэр үдэш нь цагаан гэгээ тасраагүй байхад хан ухаан орж, Ану хатныг төрхөмдөө гийчлэн ирэв хэмээн гаргасан бор халзан иргийн гуяны мах хярж, мангираар амталсан сайхан хар шөл нэг тагшийг оочлон хар хөлс нь асгарч, охиноо дуудан дэргэдээ суулгаад зүүн хөмсөг өргөн энэрэн нигүүлссэн эцэг хүний зөөлөн харцаар харж:

-Анхлан хорин таван жилийн өмнө чамайг эхээс унаж байх ахуйд тавь гарчихсан байсан би “Энэ улаан нялзрай амьтан хэзээ хүн болж, хүлгийн нуруунд мордож, хүний газар бэрлэн одно?” хэмээн шаналж, эмзэглэж байсан. Өдгөө охин үр минь хүний зэрэгт хүрч, Зүүнгарын хааны хатан боллоо. Одоо надад энэ орчлонд хоргодон саатах юм үгүй. Эргээд эд хөрөнгө, орд өргөөгөө урьдних мэтээр босгож чадах байсан ч би мачийсангүй.

Галдан хаанд, эр нөхөртөө дамжуул. Эсэн тайшаас хойш алтан ургийн бус Ойрадын хэн ч бүх Монголыг захирах ёсгүй хэмээн чиний багаасаа сүслэн дээдэлж ирсэн Мандухай цэцэн хатан өчсөн юм гэнэ лээ. Галдан хаан хэрэв эрх мэдлийн төлөөх шуналаа барьж эс чадан халх руу санаархах бол үхлийн даллагаа авахуулна гэсэн үг.

Алдагдсан алт эрдэнэсийг эгүүлэн олж авч хэзээд болдог. Харин харьд алдсан газар шороо эгнэгт хүнийх болдог юм. Санаж яваарай үр минь. Хошуудын Байбагас ханы удам, Очирт цэцэн ханы охин үр гэдгээ санаж, ураг удмынхаа нэр сүрийг дээдэлж, алд биеэ гамнаж явахыг захъя даа... хэмээн хэлж амжаад насан зүг болов.

Галдмаа ах нь эцгээ амьсгал хураасан хойно шөнө дөлөөр хүрэлцэн ирэв.

Амьдрал хүнд өгсөн бүхнээ хайр найргүй эгүүлэн авдаг аж. Өвгөн буурал эцгээ алдах агшинд Ану өнчин хүний нулимс хэчнээн гашуун байдгийг мэдрэв. Хэнз төрсөн отгон үр минь хэмээн энхрийлж, алдрай багад нь хүлэг сайн морь зүсэлж, нуруунд нь түшин мордуулж, алс тэртээ цастын орон, түмэн хүмүүн хөлхөлдсөн Бээжин, Хөх хотод дагуулан аялж, ав хоморгод авч мордон, эрдэм, номд шамдуулан эрхлүүлж өсгөсөн удам сайт, ухаан уужуу элбэрэлт эцгээ байхад хаа холын хадмын газар сууж ахуйдаа ч омогших сэтгэлдээ нөмөртэй, оюун бодол тавиун явж дээ.

Маргааш нь ойролцоох хийдээс нэгэн өвгөжөөр лам залагдан ирж, бүрлээчийн алтан савыг нээн, өдрийн сайныг шилэн цогцсыг нь галд хайлуулан чандарлах нь зохистой хэмээн айлдав.

Оочин цоочин хайлж, цоохортон тарлантсан цастай элчилгүй уудам хээр тал ааваан алдаж өнчирсэн сэтгэлийнх нь хов хоосорсныг илтгэх мэт. Хааяа жихүүн салхи үлээж, алсад хонин зэрэглээ мяралзана. Толгодын энгээр танан цагаан хонин сүрэг бэлчинэ. Хаврын урин амьсгалтай тэрслэх мэт жихүүн салхи үе үесхэн хавирга нэвт үлээж, сэтгэл жаварлуулсан өдөр Ану хайрт ааваа хадан гэрт нь үдээд хүлгийн хурдаар Ховог сайрын ордноо зүглэн довтолгож явлаа. Энэхэн хорин таван насандаа тэрбээр хайрт өрлөг эхээ, хадам ижийгээ, насан буурал эцгээ алдан хорвоо мөнх бус юм гэдгийг ясандаа тултал ухаарч, сэтгэлийн амар амгаланг эрхгүй эрэлхийлэн шаналж явлаа. Заяа төөргийн шоо цаашид хэрхэн буухыг хэн ч

үл мэддэг нь сайхан ч юм уу даа.

“Алдагдсан алт эрдэнэсийг эгүүлэн олж авч хэзээд болдог. Харин харьд алдсан газар шороо эгнэгт хүнийх болдог юм. Санаж яваарай үр минь. Хошуудын Байбагас ханы удам, Очирт цэцэн ханы охин үр гэдгээ санаж, ураг удмынхаа нэр сүрийг дээдэлж, алд биеэ гамнаж явахыг захъя даа...” хэмээсэн буурал эцгийн гэрээсийг насан турхруу санаж явья даа хэмээн бодоход тэгтлээ бусдад үзүүлэхийг үл хүсдэг харамч нулимс нь хээрийн салхинд бүрэлзэх нүднийх нь аягаар дүүрэн ирж байлуга. Аав, ачлалт аав гэдэг хүмүүний дээд буюу. Эр нөхөр, үр хүүхдээ асарч, хадмын газар бэрийн ёс журмыг сахих тухай л өдий олон жил залхтал дуулж сонсч явтал “...алд биеэн гамнаж яв” гэж насан туршид сэтгэлд гал болон дүрэлзэх бүлээн дулаан үгийг аав нь л хэлдэг байна шүү...

## Арвандолоодугаар бүлэг

Загалмайтны 1678 он, шар морин жилийн эхээр тэсгим хүйтний эрч буураагүй байх цагаар Галдан хааны ордонд холын гийчин айлчлав.

Тэр нь цастын орноос Далай лам, Дэрсид Санжаажамц нарын илгээсэн Жиргун хутагт лам бөлгөө. Тэрбээр хүйтэнд тэсвэр сайтай цастын орны хүмүүн гэсэндээ ид өвлөөр алс газар аялан явсаар тийнхүү Ховог сайрын өргөөнд ирэхдээ Далай ламтны соёрхсон “Галдан Данжүн бошгот хаан” цол олгосон зарлигийг авчирчээ.

Эр нөхрийн хамт Дотоод ордны их танхимд алс холын бурханы орноос ирсэн гийчнийг хүлээн авч байхдаа Ану хатан төвдөөс илгээсэн тэрхүү цол хэргэмд эр нөхөр нь хэрхэн хөхин баясч, царай нь гэрэлтээд ирэхийг анзаарав. Гэтэл үнэн хэрэгтээ Далай ламтны соёрхолтой, соёрхолгүй Галдан хаан цэрэг эрсийнхээ халуун амь, бүлээн цусаар, эцэг, эхээс заяан хурц оюун, эр зориг, ид хавын хүчээр энэ Зүүнгар улсын төрийг түвшитгэн, хаан сууринд суусан биш үү?

Урьд Ануг багад бас л Далай лам эцэгт нь дөрвөн Ойрадын чуулганы хан цолыг соёрхож, хан хүний ёслолын малгай, дээл гардуулж байсныг хатан эргэн санах. Хошууд угсааны Гүүш ханы удмынхны эрхшээлд байдаг атал төвдүүд яахаараа чингэж, монголчуудад цол хэргэм хүртээж суудаг буй? гэсэн тэрсүүд бодол түүнд төрсөөр байсан ч “Бошгот хаан” цол зүүх болсондоо хөхин бахдаж буй эр нөхөртөө энэ бодлын сэжүүрээ үл цухуйлгасан аж.

Далай ламаас Галданд “Бошгот хаан” цол соёрхсоны хойно урин цаг наашлах үеэр Энх-Амгалан хааны элч Ховог сайрт хүрэлцэн ирж мөн л “хаан” цол олгосон зарлигийг авчирлаа.

Тийнхүү цол хэргэмд дарагдсан Галдан хаан хөх нуур, цаашлаад дорнод Түрэгстаны зүгт дайлаар мордоно хэмээн цэргээ бэлтгэн сургуулилж эхэллээ.

Ану хатан энэ удаа бие шалтгаангүй байсан тул Сайр уулын баруун бэлд гарсан цэргийн бэлтгэл дээр үе үе хилэн хар усан тэлмэн жороо морио унан, алтан өнгөөр гялалзсан хөө хуяг, сүмийн алтан ганжир мэт наранд үзэсгэлэнтэйгээ гэрэлтэгч алтан шармал дуулгаа агсан очиж галт буугаар бай онох сургууль хийдэг байлаа.

Ану хатан Оросын Томскт одсон худалдаачдад захиж өөрийнхөө шадар зуутын Бундир, Балсан тэргүүтэн баатруудад галт буу авчруулжээ.

Морин жилийн хаврын дунд сард урин дулаан цаг нэгэнт наашилсан хойно Галдан бошгот хаан олон жилийн турш зам дээр нь хөндөлсөн их толгойлж буй Хөх нуурын хошууд ноёдыг хурааж захиргаандаа оруулахаар их цэрэг хөдөлгөв. Ану хатан эр нөхрийн хамт тулаанд мордох хүсэл их байсан ч отгон охин Юмчихай хөхнөөс гараагүй, орд өргөөний хавиар халдварт томуу элбэг тул хараахан завдсангүй. Урьдын адил Ойрадын эрэлхэг баатрууд, хайрт нөхрөө дайны тэнгэрт нь даатган, сүүн цацал өргөсөөр үдэв.

Энэ үеэр Ану хатны сэтгэлийг бүлээсгэсэн нэгэн үйл явдал төлдөрхөн тохиосон нь хайрт ах Галдмаа нь сарын өмнө Ховог сайрын ордонд ирж, хүргэн дүү Галдан бошготын хошуудын

Гүүш ханы үр хойчистой хийх дайнд хүчин өргөх болсон хэрэг билээ. Тийнхүү Ану хатан энэ удаа гагц эр нөхөр, шадар баатруудын амийг дайны тэнгэрт даатгах бус, төрсөн ах Галдмаагаа эсэн мэнд эгэн ирээсэй хэмээн атаа таван тэнгэр, цагаан дарь шүтээндээ мөргөн залбирч байлуга.

Галдан бошготыг цэрэглэн Хөх нуур тийш мордсон хойно Ану хатан Хөх нуур дахь хүргэн ахынхаас ирсэн таа муутай сураг дуулбаас Галдан бошгот цэрэглэн айсууг сонордсон Энх-Амгалан хаан хязгаарыг захирагч сайд Чжан Юнд нийслэлээс цэргийн хүчин илгээсний дээр Эрх жонон Хорлоо, Лувсангомбо ноён нар хошуудын тайж нартай хавсран хүчээ нэгтгэсэн ажээ. Үүнийг дуулаад түгшсэн Ану хатан буухиа элч илгээн эр нөхрөө цэргээ татаж, энэ удаа хошуудыг дайлан эзлэхээ хойшлуулахыг гуйсан захидал илгээгээд хариуг тэсч ядан хүлээж эхэллээ.

Тэгтэл ч Хөх нуур орох замдаа явсан Галдан бошготын тэндээс Хөх нуурыг зорьсон 10 дахь хоногт Дэрсид Санжаажамцаас мөн л цэргээ буцаах тухай зөвлөлгөөн сонсоод буцах замдаа орсон тухай сураг дуулдаж, хатны сэтгэлийг амсхийлгэв.

Ийнхүү Ойрадын Галдан бошгит хаанд ямагт заавар зөвлөлгөөн өгч, далдуур удирдах болсон Дэрсид Санжаажамц нь аргын 1653 онд төвдөд мэндэлсэн, Ану хатантай нас сүүдэр чацуу, энэ морин жилд хорин таван сүүдэр зооглож буй хүмүүн ажгу. Олны дунд түгсэн цуу яриагаар түүнийг Далай ламтны “Сувдан дусал”-аас бүрэлдсэн бутач хүү ч гэлцдэг. Энэ нууцгай явдал галдан бошготын багш тавдугаар Далай лам Лувсанжамц бээр Эеэр засагч хааны заллагаар Бээжин явах зам зуурд тохиосон бөлгөө. Хожим тэрээр найман насандаа Будалин ордноо” эцгийн” дэргэд хүргэгдэн ирж, шашны ухаанд шамдан суралцсан гэдэг. Бутач хүү нь тийнхүү бичиг үсэгт билгүүн авьяастайгаа харуулж уран зохиол, шүлэг дуулал, одон орон судлахуй, цаг тооны бичиг, оточ маналын ухаанд шамдан суралцсаны хүчинд Далай ламын хайр, ивээлийг олж Дэрсидийн өндөр тушаалд суусан гэдэг. Тэрхүү Санжаажамц лам нь цастын орон дахь хошуудын үе дамжсан ноёрхлыг халах далд зорилгодоо Галдан бошгит хааныг ашиглах алсуур санаатай ажгу.

Ану хатны хувьд Дэрсид Санжаажамцын далд санааг төдийлөн сайн ухаж мэдээгүй ч бүсгүй хүний зан совингийн увьдисаар энэ ламтны дохио зангаагаар эр нөхөр нь зам мөрөө шийдээд байх ахул сайны үр дагуулахгүйг зөгнөн дурамжхан байлаа. Нөгөөтэйгүүр аливаа гадны хатгаасанд орох, өндөр цол хэргэмд дурлах зэргээс болж халх, Ойрадын түүхэнд цөөн бус эмгэнэл тохиолдож байсныг түүх шастираас чадах чинээгээрээ уншсаны хувьд сэтгэлийн далд мухарт нэг л сэрэмж төрөөд байжээ.

Зуны эхэн сар гарчээ. Ану хатан хэрмийн дунд орших холбоо гурван цөөрмийн хөвөөн дэх сэрүүн асарт суун судар уншина. Таван настай Сэвдэнбалжир хүү нь гүйн ирж эхийн хүзүүгээр тэврэн эрхлэх зуур:

-Ижий, би хэрэмнээс гарч морь уная тэгэх үү? хэмээн гуйлаа.

-Хэнтэй тэр вэ? Уржигдар чи ам авч давхидаг ороо саарлыг унасан байсан. Бүү дэггүйтэн сэтгэл чилээж үз хэмээн өхөөрдөх, зандрахын хооронд өгүүлэхдээ өөрөө ч тэртээ Алшаагийн говьд өнгөрсөн эрх бага насандаа мөн л ингэж цаг ямагт морь уная хэмээн хорхойсч явдаг



байснаа эргэн дурсав.

-Балсан ахтай явнаа.

-За, Балсантай бол тэг дээ хэмээн Ану зөвшихөд хөвүүн дэвхцэн гүйж одно.

-Хайрт минь, энд юуг хийж бодлогошрон суунам?Гоо үзэсгэлэнт сэвгэр хатад чам шиг ном сударт хэтийдэн дурлах аваас духанд нь цаг бусын атираа суудаг хэмээн дуулсан уу? хэмээх дуу гарч Галдан бошгит сэрүүн асар өөд инээмсэглэн орж иржүхүй.

-Цагийн эрхээр духанд суух атираа, санчиганд буух цагаан хяруу ном судар уншсан уншаагүй л эгэл хүмүүнийг ялгахгүй биш үү? гэж Ану хэлэхэд:

-Ямар судар уншин сууна?

-Эртний нанхиадын их сурталч Хүнз авгайн сургаалиас...гэхэд нь Галдан хаан, хатныхаа дэргэд ирж суун, судрыг нь хааснаа:

-Дорнод Түрэгийн улсын цагаан малгайтныхны зонхилогч Аппак Хожа нэрт эрхэм манай ордноо гийчлэн ирж яваа гэнэ. Далай ламтнаас намайг түүнд цэргийн тусламж үзүүлэхийг зөвлөсөн захидал авч яваа юм байна гэлээ.

Эр нөхрийнхөө өөдөөс инээмсэглэн харж суусан Ану хатан харцаа эгцлэн:

-Тэгэхээр Та дорнод Түрэгийн зүгт дайлаар мордох нээ? хэмээн тулган асуулаа.

-Далай лам тэгж соёрхсон байна. Тийшээ зүглэн алба татвар төлөхөөс цааргалах болсон зарим эзэмшлээ сэргээх бодол бас надад буй хэмээн Галданг хэлэхэд тэр зүгт өдрөөс өдөрт хүчирхэгжин өндийх Манжийн аюул хол гэдгийг хоромхон зуур эргэцүүлэн бодсон Ану зүүн хөмсөг өргөн цөөрөм рүү харах зуур:

-Таны энэ бодлыг дэмжиж байнам. Нэгэнт Хөх нуурыг дайлах хэмээн бэлтгэсэн их цэргийг урин дулааны цаг дор барууншаа Самарканд балгадын зүгт хөдөлгөн хуучин эзэмшлээ эгүүлэн сэргээх нь Зүүнгарын улсын сүр хүчийг үзүүлэх, сан хөмрөгөө арвижуулахад тустай хэрэг хэмээн сэтгэнэ хэмээгээд:

-Ахын минь охин Ахайг таны ач Цэвээнравдан сүйлсэн байна хэмээн нэгэн шинэ сонин дуулгавай.

Бухарын зүг цэрэглэн мордож, эртний баялаг уйгар орныг эзлэх амтат бодолдоо автсан Галдан бошгитод хатных нь ач дүү, өөрийнх нь ач хоёрын сүйлсэн хэрэг төдий их сонихон санагдсангүй.

Морин жилийн зун Галдан бошгит хааны их цэрэг Магнай захирагч ноёноор удирдуулан Дорнод Түрэг улсын зүг дайлаар мордоход, Ану хатан бас л сүүн цацал өргөн хоцорсон амуй.

Айраг чигээ дэлгэрэн, Ховог сайрын ордны хэрэм доторхи цэнхэр цөөрмүүдэд хүртэл усны

шувууд чуулан дэлхий дэлэгнэсэн сайхан зуны эхээр мордсон их цэрэг намрын адаг сард дорнод Түрэг улсын Исмайл хааныг олзлон, дайны олз омгоо дааж ядсаар буцан ирэв.

-Хайрт минь би Дорнод Түрэгийн Исмайл хааныг барж идмээргүй их алт эрдэнэсийн хамт олзлон ирлээ. Харин нэгэнт надад ялагдан эрхшээлд минь орсон Исмайл хааны охин Фатимаг татвар эм болгон авчирсанд чи минь ундууцахгүй хэмээн найдна. Чи минь ухаантай шүү дээ хэмээн Галдан аян дайнаас эгэн ирэхдээ хэлж, Ану хатны найман ханат өргөөний баруун талыг олзны алт эрдэнэсээр дүүргэж орхиж билээ.

-Энэ их алт эрдэнийг улсын сан хөмрөгт хадгалах нь зөв болов уу хэмээн сэтгэнэ. Хаан таны ивээлээр өчүүхэн эм би өмсөх, зүүхээр үл дутан тансаг сайхан сууж буй билээ. Харин танд би Өэлүн эхийн төрхөм Хонгирад угсааны Чимбай хатны тухай хүүрнэх үү? гэж Ану асуухад

-Чи минь энэ их алт эрдэнэсийг эзэмшихгүй юунд улсын санд тушаа хэмээн зөрнөм бэ? Ийм их эрдэнэс чамд хэрэггүй гэж үү?Бас тэр Чимбай хатан энд юуны хамаа буй? хэмээн нөхрөө шахамдуулахад Ану:

-Чимбай хатан бол Хубилай цэцний хайртай хатан, ухаан уужим, хараа холч хүн байсан хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Нэгэн удаа Хубилай хаан Өмнөд Сүн улсыг эзлэн бүх Хятадыг нэгэн тугийн дор нэгтгэж авчээ. Чингээд тэрхүү Өмнөд Сүн улсын эрдэнэсийн санд байсан бүх үнэт эдлэлийг хэдэн зуун хасаг тэргээр тээж авчран хатад, гүнж нартаа дэлгэн үзүүлэхэд Чимбай хатан онц анхаарсангүй халти тойрон үзчихээд яваад өгчээ. Гайхсан Хубилай хаан хойноос нь гоцго илгээн Чимбай хатнаас тэр их баялгаас чухам аль эрдэнийг өөртөө авах саналтайг нь асуулгав. Ухаант хатан хариуд нь “Тэр их эрдэнэ баялгийг Сүн улсын хаан чухам өөрийнхөө үр хүүхдэд хэмээн үлдээн хадгалсан. Гэтэл үхээнц дорой үр удам нь эцэг өвгөдийн өвлүүлсэн их эрдэнэс баялгаа хамгаалж үл чадан бидэнд ялагдаад эдэлж чадсангүй болохоор эдүгээ манай гэрт овоорон байна. Иймд хүний эд баялгийг би аваад юу хийхэв” хэмээн Хубилай хааныг дуугүй болгож байсан гэдэг. Түүнтэй адилаар би энэ их эрдэнэсээр биеэ хучмааргүй байна. Хаан эзэн эрхшээж буй тул багахан хэсгийг аян дайнд үрэгдсэн баатар эрсийн ар гэрт нь тэтгэмж болгон өгчилбөл ямар? Таны мэргэн оюун мэднэм зэ хэмээхүйд Галдан хаан инээх, ярвайхын завсар үрчийгээд сурсан зангаараа сахлаа шувтран ханхалзсанаа:

-Тийм шүү. Эзэн болж чадахгүй хүнд их эрх мэдэл, эд уурсын хэрэг байхгүй. Тийм арчаагүй амьтад хар амиа хоохойлж явбал барав. Тэр дайнд үрэгдсэн баатар эрсийн ар гэрийг халамжлан тэтгэх нь чиний эрхлэх хэрэг хэмээн хэдийн би соёрхсон тул дураараа бологтун. Харин зэвсгийн агуулах өөд хамтдаа явбал ямар? хэмээн асуулаа.

Галдан хааны Бухар, Яркендаас олзолсон хоёр зуун галт буу, арваад охор гунан буу, таван зуун торх дарь зэрэг олз омог Ану хатны сэтгэлийг түрүүчийн их алт эрдэнэсээс илүүтэй хөдөлгөжээ. Хатныхаа хүсэлтээр Бошгит хаан олзны зэвсгээс тавин галт бууг зуун торх дарьны хамт Анугийн мэдлийн шадар зуутад өгөв.

Аргын 1679 оны зун. Галдан хаан Ану хатнаа хирдхийлгэн цочоож, сүүлийн үед өөртэй нь эв эеийг сахих санаачлага гарган наашлах болсон ач дүү Цэвээнравдангаа эгнэгт гомдоосон хэрэг өдүүлэв. Хонин жилийн хаврын дунд сард газар хагалахын өмнө талбайгаа дэрвэлэх

Цэвэрлэх\ цагаар Эмилийн газарт тариалангийн өрхүүдийг эргэн явахдаа Галдмаа баатрынхаар айлчилсан Галдан бошгот Ахай охинд нь дур татагдан, эртний уламжлалт цорос, хошуудын ургийн алтан аргамжийг үргэлжлүүлэх нэрээр түүнийг бага хатан болгон авахаар шийджээ.

Галдмаа баатрынхан сандралдан, Ахай гүнж бээр таны ач Цэвээнравдантай эсэргэнэ жил сүй тавьсныг бид хүлээн авсан, энэ зуны дунд сард өдрийн сайныг шилэн хурим дэглэхээр тохиролцсон буй хэмээн өчицгөөсөн ч Бошгит хаан үг сонсохыг хэрхэвч хүссэнгүй. Орд өргөөндөө морилон ирээд Ану хатандаа ач дүү Ахайг нь бага хатан буулгаж ёслол авахаа мэдэгдэв.

Ач дүүтэйгээ нэгэн эрийн өвөр хуваалцах болсонд цочрохын зэрэгцээ, авга ахын оронд эцгийн суудлыг залгамжлах санаа өвөрлөж явдаг Цэвээнравдангийн сүйт сэвгэрийг булааснаар ахан дүүсийн хооронд үл тайлагдах цусан өш хонзонгийн үрийг тарих энэ шийд цэлмэг тэнгэрээс аянга буухын адил хатны сэтгэлийг ниргээд авчээ.

Аягатай цайгаа оочлон нүүр царайдаа хувирал үзүүлэхгүй таг дуугүй суугаа хатныхаа юу гэхийг хүлээн Галдан хаан хэсэг хүлгэлзсэнээ:

-Их хатны хувьд чамд дуулгах нь зүй болов уу хэмээн ам нээж байна. Түүнээс бус буруу зөвийн тухайд зөвлөмж эрээгүй билээ. Цус хөлсөөрөө байгуулж буй Зүүнгар улсын хаан миний хувьд сэтгэлд таарсан сэвгэрээ хатан буулган авахад минь саад хийх хэн ч байх ёсгүй хэмээн сэтгэнэ гээд уурсан гарч оджээ.

Дараагийн шөнө нь үүлэн борооны хэргийн хойно эр нөхрийнхөө хатуу булчинтай бугалгыг дэрлэн хэвтсэн Ану:

-Хайрт минь, энэ улсын хаан бүү хэл өчүүхэн зайсангууд ч тав зургаан хатантай байхад харин ч өнөөдрийг хүртэл бага хатангүй явсан хаан та дахин хатан буулгах нь зүй билээ. Гэвчиг Бөртэ хатны хэлсэнчлэн мухлаг бүрд хатад байсаар атал ач дүүгийнхээ сүйлсэн сэвгэрийг ... гэтэл Галдан хатныхаа толгой дороос гараа угз татан авч:

-Энэ тухай надад бүү ухуулан ятгаж үз. Ану чамайг бусад эмс сэвгэрүүдээс илүү ухаан уужим, эр хүмүүний адил холч сэтгэдэг хэмээн санаж явсан минь эндүүрэл бололтой. Чи Цэвээнравданг гэсэн шалтгаар ач дүүтэйгээ бүү жөтөөрх. Долоон жил ханилсны хувьд миний ааш араншинг чи эрхбиш гадарлах болсон байлтай. Ахайгаас бусад хэнийг ч би бага хатан буулгахгүй гэдгийг мэдтүгэй хэмээн хилэгнэснээр энэ хэрэгт эцсийн цэгийг хатгажээ.

Эрчүүд салхи борооны хэргийн хойно нам унтчихдаг ёсоор саяхан хилэгнэн цухалдаж байсан нөхөр нь хэдийнээ “давсны аян”-нд мордоход, сэтгэл үймрэн шаналсан Ану хатан үүр цайтал цурамхийсэнгүй. Сэтгэлд нь гомдол цөхрөл, нөхрийнх нь оноод хэлчихсэн залуу бага ач дүүгээсээ эрээ харамнах эм хүний жөтөөрхөл, басхүү Галдан Бошгот Ахайг Цэвээнравдангаас булаан авахаас үүдэн ойр ясан төрлийн ахан дүүсийн хооронд үүсэх цусан өшөө хорслын үр уршгийн тухай бодол цээжний махыг нь барж байлуга.

Тийнхүү эр нөхрөө татвар эмтэй бус анх удаа өөр хатантай хуваалцах болсны дээр, тэрхүү

бага хатан нь өөрийнх нь ач дүү байх болсонд шаналан хэвтсэн Ану хатан тэртээ хориод жилийн өмнө эцгийнх нь бага хатан Нуранг үртэй болов хэмээн хөөр баяр болж байх ахуйд ижий нь орондоо уйлан хилэн цухал дүүрэн байх болсны учрыг өнөөдөр л зүрх сэтгэлээрээ ойлгон мэдрэв. Тэгэхэд зургаан настай Ану их бага хатдын жөтөөрхлийг үл мэдэх балчирхан ухаанаа цуцтал бодоод Нуран хатныг үртэй болов гээд ижийнхээ юуны учир хилэгнэх болсны учрыг хайрт өрлөг эхээсээ шалгааж билээ. Тэгэхэд нөхрийнхөө хуучин оймсны харааг нөхөж суусан өрлөг эх нь их шүүрс алдан “Ихэс дээдэс олон хатан авдаг юм. Гэтэл хатан бүхэн эр нөхрөө харамлана. Намайг л илүү хайрлаасай хэмээн бодно. Ухаандаа өрсөлдөнө өө дөө.

За тэгээд хатан бүр үр хүүхэд гаргана. Миний л хүүхэд бусад хатдынхаас илүү байгаасай гэж бодно. Харин эзэнд бол аль ч хатнаас мэндэлсэн бай өөрийнх нь үр хүүхдүүд нь л юм чинь адилхан хандана. Ижий чинь бага хатныг давхар биетэй боллоо гэдэг нь хан эзний хайрыг түүнтэй хагаслахгүй гэж, бас төрөх хүүхэд нь эцгийнхээ хайрыг чамтай хуваачихна гэж ундууцаж байгаа юм. Ойлгов уу?” хэмээн охиноос асууж билээ. Чингэхэд нь Ану:

-Лувсан ахад танаас өөр авгай байхгүй тийм ээ? хэмээн адтай гэгч нь асууж байсан сан.

-Байхгүй. Лувсан ах чинь харц хүн. Ноёд ихэс л олон хатан авдаг юм шүү дээ.

-Тэгвэл харц хүний авгай болбол сайхан юм байна. Өөр эхнэр авна гэхгүй. Их, бага хатан байхгүй, тийм ээ? гэж Ану асуухад өрлөг эх нь:

-Гэсэн ч харц хүний зовлон бас их шүү дээ, охин минь. Амьдрал гэдэг үйлийн үр гэж бурхан багш сургасан юм гэнэ лээ, базардар гэж байж билээ.

Нээрээ ч Ану энэ Балсангийн эхнэр болсон бол дархан Бундирын гэргий Булган, эс бол Мандарваа шиг өөр эмстэй жөтөөрхөлцөхийн зовлон мэдэхгүй жаргалтай ч байх байж уу? хэмээн бодоод тооноор тусах оддын бүдэг гэгээнд хажуудаа хэвтэх эр нөхрөө таалан ширтэж, удахгүй энэ хүнийг бага хатантай, тэр дундаа төрсөн ач дүү охинтойгоо хуваалцах болсонтойгоо яагаад ч эвлэрч чадамгүй санагдан дэрэндээ толгой шигтгэн уйлж гарлаа.

Сэнгэ ах шигээ төдийлөн хүүхэмсэг биш боловч, нэг сэвгэрт сэтгэл татагдвал бурхан, чөтгөр хэний ч үгийг үл сонсон дурладаг, шийдсэн алив хэргийнхээ төлөө дэндүү чигээрээ зүтгэдэг Галдан Бошготыг зогсоох нь нэгэнт өнгөрсөн байлаа.

Чингээд зуны эхэн сард Галдмаа баатрын охин Ахайг Галдан Бошгит хааны бага хатан болгон буулгах их хурим дэглэв. Энэ жил хорин зургаатай Ану хатан хэдий гурван хүүхэд төрүүлсэн ч өнгө үзэсгэлэн төдийлөн гундсангүй. Харин сүүлийн хоёр охиныг жил дараалан төрүүлж, орд өргөөндөө хөдөлгөөнгүй ном судар шагайн суусаар бэлхүүсээр нилээд махалснаа сая л мэдэж, эхийнхээ захиснаар амаржсаны дараа гэдэс давсгаа чангалан боосонгүйдээ амаа барин харамсч, өргөөндөө толины өмнүүр эргэлдэн гоёж гоодох болов.

Эр нөхөр нь үнэнийг хэлжээ. Ану хэдий гоо үзэсгэлэнтэй ч нас хорь хол гарч, хэдийн долоон жил хамт амьдран үнэрээ гээж, гундаж эхэлсэн цэцэг мэт болсон буй. Гэтэл арван зургаахан настай алаг нүдэн Ахай гүнж Галдан Бошгитод хээрийн анхилам цэцэг мэт шинэ, уулын согоо шиг гоо үзэгдэхээс яах билээ?

Яг л Анууг хэрхэн гуйж, эртний ёс заншлыг мөрдөн хуримласан билээ. Тийм ёс дэгийг мөрдөн Ахайг буулгав. Хүргэний эцэг буюу авга талын хамгийн ахмад хүндтэй хүн бэрээ гуйдаг ёсоор хоёр жилийн өмнө хальж одсон Цөхүр увшийн оронд Галдан Бошгитын ах Сэвдэнжал Галдмаагийн очин Ахайг гуйж хадаг тавин, долоохон хоногийн дотор зүс хадаг, “эд” хүргэх ёсыг хийж, “Гэр бүрэлгэн”-ний найр дэглэн, хуримын ёслолыг дараалан гүйцэтгэсээр нэг л өдөр Ахай гүнжийг Ховог сайрт буулган авчрав.

Ану хатан сэтгэл зүрхийг нь хэсэгчин тасчих мэт зовиур, цээж уран тамлах хар хор, атаа жөтөөгөө ухааны уужмаар тэвчин барьж “бэр дархлах” ёсны дараа цагаан торгон гивлүүр дороос гарч ирсэн хайрт ахынхаа охин Ахай гүнжийн гэрэвшиж, бэргэсэн царайг үзэн, авга эгч, басхүү төрийн их хатны ёсоор золгон, хоёр хацар дээр нь үнсч чадсан ажгу.

Сүй тавьсан залуугаасаа хүчээр салж, Галдан Бошгит хаанд богтлогдон авга эгчтэйгээ нэг хүний хатан болж буй нялх балчир Ахай гүнжийн гэнэхэн харцтай алаг нүдийг үзээд Ану хатан гэнэт найман жилийн өмнө Сэнгэ хаантай сүйлж байсан өөрийгөө харах мэт болж, дэмий л түүнийг нөхөртэйгээ хардан цухалдаж байснаа ухаарав.

Бэр дархлах ёс гүйцэтгэн Ахай гүнжийн өтгөн хар хөмсгийн доороос алаг нүд тормолзуулсан, талын цэцэг мэт цэвэрхэн бор царайг зочид гийчин, хадам талынханд үзүүлсний хойно хуримын их найр цэнгэл эхлэн, икэл хуурын эгшгэнд уламжлал ёсоор “Сав их ертөнц” хэмээх уртын дуу уяангалан байхад Ану хатан өөрөөс нь тэс өөр гоо үзэсгэлэнг илтгэсэн ачийнхаа гирэвшин зовсон царайг харан “Ахайд юуны буруу байхав. Надаас арван жилийн хойно төрж, өнөөдөр өнгө үзэсгэлэн нь дөнгөж ургаж төлжиж буйгаараа л буруутдаггүй юм бол. Ихэс дээдэс хүн олон хатан, татвар авдаг өнө эртний ёсыг ч эр нөхөр нь бий болгоогүй бус уу? Эцгийн өргөөнд байхдаа Дүүрэн мэргэн багшийнх нь хүүрнэсэн Монголын түүхэнд мөнхөрсөн олон ухаант хатад цөм энэ зовлонг дайч өнгөрсөн.

Тиймээс ч эзэн Чингисийг Дайр үсүний охин Хуланг хатан болгон авч ирэхэд нь ухаант Бөрт хатан

“Эрэг мөрөнд

Хун галуу олон гэнэм

Эрхийгээ чинэртэл намнахаа

Эзэн минь мэдэм зэ

Энэ их улсад

Эмс охид олон гэнэм

Эрж явахаа

Эзэн минь мэдэм зэ хэмээсэн буйза.” хэмээн бодож цээж уужирсан ажгу.

Галдан Бошгит хаан ийнхүү ачийнхаа сүйт сэвгэр, их хатныхаа ач дүү Ахайг бага хатан

болгон авснаар эцгээсээ хойш ууган хүүгийн хувьд цоросын хунтайжийн сууринд ямагт санаархсаар ирсэн Цэвээнравданд авга ахынхаа эсрэг үүрдийн өс өвөрлөхөд хүргэсэн билээ.

Хөл ихтэй хуримын дараагийн арваад хоногт Галдан хаан Ану хатныхаа өргөөнд ганц ч удаа ирж хоноглон таалсангүй. Энэхэн охор амьдралынх нь утга учир болсон эр нөхрөө төрсөн ачаасаа харамлан зүрх сэтгэл урагдаж, өнчин дэр сахисан энэ урт шөнүүдэд Ану хатан нулимсаа цээжиндээ эгшээн, ухаан бодлоо саруулсан уужрахыг хичээх гэж бүхий л хүч чадлаа барж байлаа.

Чингээд Галдан Бошгит бага хатан буулгаснаасаа хойш арван нэг дэх шөнөө их хатныхаа өргөөнд морилон хоног төөрүүлэхдээ :

-Хайрт хатан чамайг олон хоног өнчин дэр сахиулан гомдоосон намайгаа өршөөн нигүүлсэхийг хичээгтүн. Залуу шинэ хатнаа таалан хэдэн шөнө бал амталсан зөгий мэт цэнгэсний эцэст, эр хүний хөнгөн шохоорхлын мананг нэвглэн зүрхээ чагнахуй Ану чамдаа насны хайртайгаа мэдлээ хэмээн гэмшил дүүрэн өгүүлж билээ.

Үүний маргааш өдөр нь гэхэд урьдынх шигээ зүс нь гэрэлтэн туяарч, хур амссан цэцгийн дэлбээ мэт илт сэтгэл сэргэсэн Ану хатан ордны их зам Луузангаар нарийн тансаг идээ, амтат боов зэхүүлж, бага хатан Ахайг өргөөндөө зоог хүртэхийг урилаа.

Анугаас сөөм илүү өндөр чилгэр нуруутай, өтгөн хар хөмсөг, нялх тугалынх шиг эргэлдсэн алаг нүдтэй Ахай их хатнаас эмээн сүрдэхийн зэрэгцээ, авга эгчийн хувьд улам ч их аюун зүрхшээсэн шинжтэй мятрангуй шинжээр доогуур харан орж ирээд үүдний хавьцаа зогсон дорой дуугаар мэнд мэдэв.

-За дүү минь, тэгтлээ сандран хормой чичрэгнүүлэх хэрэггүй. Намайг Галдан Бошгитын их хатан гэж бүү эмээгтүн. Харин авга эгчээ хэмээн дотночилбол би ихэд баярлах болно хэмээн Ану хэлж дулаахан инээмсэглэв.

-Ижий надад таныг ердийн нэгэн эм хүнээс илүү уудам ухаантай хүн тул бүү эмээн ширвээдэгтүн хэмээн захиж байсан л даа хэмээн Ахай чичирхийлсэн уяхан ялдам хоолойгоор хэлэхэд чихнээ эгшиглэнт хонхны дуун жингэнэх мэт нэн таатай сонсогдох аж.

Яг үнэндээ Галдан Бошгит хаврын тарианы газар эргэхээр явахдаа санамсаргүй Галдмаа баатрын хаваржаатай таарч тэднийхээр ороод гарахдаа Ахай гүнжийн энэ уяхан дуу, тугал алаг нүд хоёрт л сэтгэл татагдсан байжээ.

-Тийм үү?Бэргэн минь мөхөс намайг даваадуулан магтсан үг хэлжээ. Гэвч дүү чамаас арван жилээр илүү оймс элээсний хувьд, ясан төрлийн хэлхээтэй авга эгчийн хувьд энэрэн нигүүлсэх нь миний үүрэг буй за. Энэ орд өргөөнд дасан, төрөл төрхөмөө мартагнах гэж зовж буй бяцхан ач чамайг би яахин хавчин хяхна? Сэтгэл гундуу байх, хэн нэгэн чамайг гомдоох зэрэгт энэхүү шивэгчнээ над руу явуулаад хэлүүлж байгаарай. Чи бид хоёр чинь ерөөсөө ясан төрлийн эгч дүүс. Ингээд нэг хүний их бага хатан болж хувь төөрөг нэг боллоо гэснээ тэртээх арван зургаан жилийн өмнөх дурсамж амилан сэргэж тас тас хөхрөн “ижий бид хоёр чамайг мэндэлсний дараа танайд хонуутаар гийчилж билээ.Тэгэхэд Жамьянмядаг

эгч “Хар даа, дүү чинь хөөрхөн байна уу?” гэхэд чи нээх их өрвийсөн хар даахьтай үрчгэр улаан царайтай их муухай харагдсан болохоор “Том болоод хөөрхөн болох байлгүй” гээд гараад явчихаж байсан юм хэмээн хуучилснаа Ахайн ядам хуруун дахь хөх индранил эрдэнийн бэлгийг сая л анзаарч:

-Нэг л танил харагдаад байсан чинь чамайг төрөхөд ижийн бэлэглэсэн бэлзэг байна. Үүний ижил нь надад буй гээд Ану босч, орны толгой дахь цоожтой үхэгээс дөрвөн буланг нь алтан угалзаар чимэглэсэн улаан модон хайрцаг авч нээн Ахайн зүүсэнтэй ширхэг солимгүй ижил индранил бэлзгээ гарган зүүн гарын ядам хуруундаа зүүв.

-Тийм ээ. Би бүр багаасаа л зүүдэг байсан. Амтай бөгж болохоор хуруунд багтахаа болихын зовлон үгүй. Харин таныг энэ бэлзгээ яасан юм бол оо? хэмээн хуримын өдрөөс хойш гайхаж суусан юм хэмээн Ахай намуухан хэлснээ:

-Өндөр ижий тэнь чамайг мэндлэхэд арван нас хүрэхээр нь зүүлгээрэй гээд Ану эгчтэй чинь ижил индранил эрдэнийн энэ бэлзгийг өгчилгөсөн юм гээд ижий надад аравгайд гаргаж өгснөөс хойш би хуруунаасаа огт салгаагүй юм хэмээн ярина.

-Би зүүсгэл чимэг олноор нь зүүх дургүй. Уг нь бас чам шиг арван зургаа хүртлээ зүүсэн юм. Тэгээд л нэг мэдэхэд энэ гоёл чимэглэлийн улаан модон хайрцаг руу тайлж тавиад мартаж. Одоо бодоход Сэвдэнг төрүүлэх гээд хуруу, чихнээсээ зүүсэн бүхнээ ав гэж Жалбуу эгчийг шаардахад уухайн тас тайлаад л тэр чигтээ болсон байх шүү гэж Ану ярин тас тас хөхөрснөө царайгаа төв болгон ач дүүгийн нүд рүү ширтэн:

-Дүү минь чи урьдны сүйт эр Цэвээнравданд сэтгэлтэй юү? хэмээн шахамдуулан асуухдаа энэ бүсгүйн төлөө ачтайгаа дайсагналын үрийг тарьсан эр нөхрөө Цэвээнравдантай эвлэрүүлэх арга замыг дотроо сүвэгчилж байлаа.

Хар хорын өчүүхэн ч бодолгүй дэндүү цайлган Ахай хацраа ягааруулан ичингүйрч газар ширтээд:

-Цэвээнравдантаны хувьд хэлж мэдэхгүй юм. Бодвол надад дуртай болоод л хоёр жилийн өмнөөс манайхаар эргэлддэг болоо биз. Надад өчихдөө одоогийн хатнаа эх Насанжид ахайтан, авга Цөхүр увшийн зөвлөснөөр халхын Засагт хантай ураг барилдахыг эрхэмлэх бодлын үүднээс авсан. Засагт хан Шарын эгч Буджавт сэтгэлгүй, сүй бэлэг хэлэлцэх гэж очихдоо л зүсийг нь анх үзсэн. Харин чамд л анх удаа ингэж их дур сэтгэл татагдаж байна. Зүрхний хайртай чамайгаа бага хатан болгон аваад хос хоёр шувуу мэт ижилдэн жаргахыг хүснэ хэмээдэг байсан юм... гэхдээ нөгөө сонсоод баймаар эгшиглэнт хоолой нь чичирхийлэх аж.

-За тийм байж. Охид сэвгэрүүд хэзээ л дур сэтгэлтэй хүндээ очиж байлаа даа. Сэтгэлээ хатамжил. Энэ ордны хана нь хүртэл чихтэй гэж мэд хэмээхдээ өөрийнх нь хуримын өмнөх шөнө ижий нь бас чингэж захиж байсныг санах.

-Жаа, хатантаан.

Ану дахиад л тас тас хөхөрч Ахайг өөртөө татан тэвэрч:

-Эгч ээ гэж болохгүй юу? Юун ч сүржин юм бэ дээ гэхэд Ахай шанхны унжуурга чимэглэлээрээ оролдогчин болж газар ширтэн:

-Ижий, таныг ямагт хатантаан гэж бай. Ёс ёмбогор төр төмбөгөр гэсэн хэмээлээ.

-Айхтар ёс төртэй хүн байх нь. За, яахав.Хүссэнээрээ л бол. Нэгэнт чи бид хоёр нэг хүний их бага хатан болсноос хойш гэснээ эхнэр үс болгон хоёр хагалан самнасан тас хар гэзгийг нь илбэснээ урьдчилан зэхэж тавьсан үнэт бэлэг өгчилгөж, өргөө рүү нь үдэж өгөв.

Ахайг гарч явсны дараа өөрийнх нь сэтгэлээс ч гэсэн нэг хүнд бул хар чулуу гаргаж чулуудчихсан мэт, эс бөгөөс сэтгэлийн мухарт нуугдсан албинг хөөгөөд гаргачих мэт цэлмээд ирж билээ.

Чингээд өргөөндөө ганцаар үлдсэн хойноо Ахайн ярианаас үзэхүл Цэвээнравдан энэ сэвгэрт үнэхээр сэтгэлтэй байсан бололтой. “Зүрхний хайртай чамайгаа бага хатан болгон аваад хос хоёр шувуу шиг ижилдэн жаргахыг хүснэ...” хэмээж байсан хүн эцгийн хунтайж суудлаа алдсан анхны өс дээр сэтгэлт сэвгэрээ алдсаны хоёр дахь хонзон нэмэгдэж хожмоо нөхөрт минь дийлдэшгүй нэгэн дайсан болох нь илт. Яадаг юм билээ. Тиймд Цэвээнравданд нэн яаралтай өөр сэвгэр олж өгч өш хонзонгийн хуй салхийг бага ч гэсэн сааруулах нь зүй гэхчлэн ээдрээт түмэн бодолд ээрэгдэхэд тэрсхэн хоёр охин нь тус тусын асрагч, өрлөг эхийн хамт орж ирэн эхээ хормойдон шулганацгаав. Бум, Юмчихай хоёр охин нь хоёул эцгийн талыг дууриаж, хөмсөг өтгөн, нүд том, нэг нь бурхан болсон Юм-Агас хатны зүүн хацар дээрх мэнгийг, бага нь өвөг эцэг Баатар хунтайжийн шөнө зүүдэндээ дүнгэнэтэл ярьдгийг дууриан төрсөн тул Галдан эцэг эхийнх нь сүнс гүнж нар болон хүүдээ заяасан хэмээн ихэд эрхлүүлдэг ажээ.

Нэн ялангуяа өвчин ороомтгой сул биетэй, гал шаттал халууран хэд хоноод, одоо ч энэ хүүхэд тэсэхгүй нь гэтэл сэхээд ирдэг, олон жилийн өмнө тэнгэрт хальсан эцэг хунтайжтай нь жил нэгтэй Юмчихай охиндоо бүүр ч амиа тавьдаг байлуга. Тэгээд нэгэн удаа отгон гүнжээ эрхлүүлэн алтан боронзоор шагай будаж өгч сууснаа :

-Ану, чи чинь надад Хайду ноёны Хотол цагаан ч бил үү, нэг гүнжийн түүх хүүрнээд байлуу? Эцэг нь охид сэвгэрүүдийг хүчээр богтолдог ёсыг зөрчин, дур сэтгэлтэй хүнтэйгээ хуримлахыг зөвшөөрсөн ч гэх шиг. Би ч мөн адил Юмчихайгаа тэгж дуртай хүнд нь өгнө. Үгүй, бүр төрхөмд нь хүргэн оруулаад авсан ч яах вэ. Миний охин дэндүү бие султай юм. Нүдэн дээр минь л байж байг гэж билээ.

-Юмчихайг тэгдэг юм байж. Бумыг яах болж байна?

-Эгч нь яахав. Эрүүл чийраг биетэй юм чинь. Эртний уламжлалаа дагаад эцгийн зааж өгсөн хүнд л бэрлэнэ шүү дээ хэмээн Галдан хаан хэлжээ.

-Та төрсөн хоёр гүнжээ ийнхүү алагчилж болно гэж үү гэж Ануг асуухад: Галдан хаан:



-Энэ хорвоо өөрөө алаг эрээн шүү дээ хэмээн булзаж билээ.

Ану хатан эрх хоёр гүнжтэйгээ хуруу гарган тоглож, оньсого таалцан хэсэг хөгжсөнөө, өрлөг эх, асрагч шивэгчдэд нь өгч гаргаад аанай л өнөөх Цэвээнравданд Ахайн оронд өөр сүйт бүсгүй олж өгөх тухай бодолд автан дөрвөн Ойрадын том ноёд ихэсийн нас биед хүрч яваа өнгө зүстэй охидыг хуруу даран бүртгэж гарлаа.

Чингээд Турфан хавиар нутаглаж буй Цэвээнравданд цастын орныг захирагч Пунцаг далай ханы Цэцэнхорол охиныг нь буулган авч өгвөл зохилтой юм уу хэмээн бодогдоод явчихлаа. Тэгмэгц Галдан хааны шашны хэргийг эрхэлдэг Ялгуусан ламыг дуудуулан сэм зөвшилцөв.

Далай багш болон Галдан хааны төвд дэх номын багш нартай уулзах, бичиг захидал, бэлэг сэлт хүргэх, ховор нандин шүтээн залах ажлаар ямагт Лхас явж, Пунцаг далай ханыхаар гийчилдэг Ялгуусан хутагт охиных нь тухай мэдэж л байгаа хэмээн боджээ.

Сэм, сэмхэн алхлан, аяс намуухан ярьдаг дөч эргэм насны Ялгуусан ламтан Ану хатны өргөөнд төдөлгүй хүрэлцэн ирлээ.

-Мандарваа, ламтанд цай идээ дөхүүлээд бид хоёрыг орхи хэмээн Ану хатан захираад өргөөнд нь үйлчилдэг залуу гоцго Жамсранг дуудан:

-Хүүхдүүдийг болон өөр хэнийг ч нааш бүү оруул хэмээн тушаав.

Ялгуусан ламтны айлдсанаар Пунцаг далай ханы дөрөвдүгээр охин Цэцэнхорол энэ жил нас арван тав, ухаан сэргэлэн, үзэмж гоо сэвгэр агаад одоогоор сүй бэлэг хүргүүлсэн хүн үгүй аж.

-За Ялгуусан ламтан минь. Бэр гуйхад хэрэгтэй бүхнийг зэхээд маргааш гэхэд Төвд рүү морд. Тэр сэвгэрийг Цэвээнравданд гуйх хэрэгтэй байна хэмээн Ану хэлээд Сэнгэ хунтайжийн бэлэвсэн хатан Насанжидэд өөрийн гараар захидал бичин, их хүү Цэвээнравданы сүйлсэн сэвгэр Ахайг эр нөхөр нь бага хатан болгон богтолж гомдоосонд их хатны хувьд хүлцэн өршөөхийг хүсэн, тийнхүү булаагдсан бүсгүйн оронд Пунцаг далай ханы охин Цэцэнхоролыг хүүд нь гуйж, сүй бэлэг болоод хуримын бүхий л зардлыг хариуцахаа илэрхийлэв.

“Насанжид хатан ухаантай хүн. Хүүгээ өдрөөс өдөрт хүчирхэгжиж буй авгатайгаа өс өвөрлөн явсаар нэг өдөр няц гишгэгдэх вий хэмээн зовинож л суугаа. Тиймээс Цэвээнравданг ятган, тэр Пунцаг далай ханы охинтой гэрлүүлж, авгадаа өширхөхөө зогсоохыг ятгаж дөнгөх биз хэмээн Ану бодож байсан нь талаар болсонгүй.

Хэдэн өдрийн хойно Ану хатны илгээсэн элч Насанжид ахайтнаас нааштай хариутай ирж, Цэцэнхоролыг бага хатан буулгахад Цэвээнравдан дургүй бус байгааг дуулган, уужим сэтгэлд нь талархаж буйгаа бичсэн хойно сая эр нөхөртөө өөрийн сэдсэн хэргээ өчив.

Галдан хаан бас л сүүлийн тав зургаан үдэш алгасалгүй Ахайн өргөөнд хоноглондоо гэмэрхсэн шинжтэй Ану хатанд нүүр тал олох гэсэн нь илт, өвч алтаар шарж, есөн эрдэнэ шигтгэн урласан гайхалтай гоёмсог хуяг, дуулга хийлгэсэнээ нүүрэн дээрээ тавьсаар өргөөнд нь орж иржээ.

Өөрийг нь үзээд нарийхан хөмсгөө атируулан, зүүн талынхыг нь өргөн зэмлэнгүй харах болбуу гэтэл хатан нь харин ч хөхин баяссан царайтай байхыг үзээд Галдан хаан сахлаа шувтран асуунгүй харсаар:

-За хайрт минь.Хэд хоног чиний өргөөнд хоноглох завдал гарсангүй. Чамдаа алталсан хуяг дуулга хийлгэсэнээ авчирлаа. Энэ шигтгээнүүдийг бухар дархан Абдулла чингэж ур гарган шигтгэсэн юм шүү гээд хөх маалингаар ороосон том юм авчруулав.

-Юун сайн юм? Миний төрхөмдөө өмсч байсан хуяг дуулга бачуудах болсон байна лээ гээд Ану баяр хөөрөөр гийсэн харц чулуудаж яг л арав гаруй жилийн өмнөх тэр нэгэн үдэш алтан дарь эх бэлэглэхэд нь хөөрч догдолж байсан шигээ харц нь гэрэлтэхийг үзээд Галдан хаан их л уярчээ.

Тиим ээ.Хүн дандаа л болохгүй юм руу шунан тэмүүлдэг атлаа, тэр хүссэн зүйлээ гартаа оруулж өөрийнх болгочихоороо тоохоо больдог амьтан юм. Галдан хувилгаан тэр цагт оч хаялсан жижигхэн нүдтэй энэ сэвгэрт хэчнээн их тачаадан тэмүүлж явлаа даа.Ёстой л хүн алганыхаа хонхрыг хаздаггүй шиг. Очирт цэцний хонгорхон Ану гүнж гэдэг сахил санваар сахисан Галдан хувилгааны хувьд хазаж үл чадах алганы хонхорхой байгаагүй гэж үү?

Гэтэл түүнийгээ хатан болгож аваад, үр үндсээ төрүүлүүлж, охин хонгор биеийнх нь уран галбирыг баахан эвдчихээд ач дүүг нь богтлон авч хэдэн шөнөөр бараагаа ч харуулалгүй алга болж байдаг. Сахил санваартай байхдаа ийнхүү өдөр өнжилгүй хатад эмст тачаан шунах бүү хэл, бүсгүй хүнтэй хоёулхан үлдэж, бие махбодид нь хүрэх, сэтгэлээрээ ч шунал хүслээс ангид байсан биш үү? Үгүй тэгээд бурханы номонд Ертөнцийн өвөг эцэг,гурван орны эзэн гэдэг Лэгдэнванчигчинбуу Махсуваарыг эх Умаадивийтэй хурьцан буйгаар дүрсэлсэн байдаг бус уу? Санваартан явахад хүсэвч хүршгүй мэт байсан сэвгэрээ хатан буулгаж авсны хойно, дахиад л хараа булаам гоо сэвгэрүүд учран дур тачаал хөдөлгөөд байдаг. Ёстой л нөгөө Өэлүн эхийн хэлдгээр “мухлаг бүхэнд эмс бий...” гэдэг үнэн үг юм даа..

Эгэл хүмүүний амьдрал гэж ийм л үл гүйцэлдэх хүсэл шуналд баригдсан нүгэлт тавилан байх юм. Магадгүй Галдан ийнхүү Зүүнгар улс байгуулан хаан нь байснаас Цастын орны Галдан хийдийн ширээт лам болчихоод Цэвээнравдан ачийгаа хаан ор суулгаж, өөрөө хааяа сэтгэлт сэвгэр Анугийн дүрийг санан халхын өндөр гэгээн шиг Дарь эхийн шуумал дүрд хайртыгаа буулгуулан суух нь ч жаргал байж уу? хэмээсэн бодол эргэлдэнэ.

Мөн л гүйцэгдэшгүй хүсэл шунал нь түүнийг шар шувтран хар болгож, эрх мэдлийн төлөөх чивэлт тэмцэлд татан оруулсан бус уу?

Үгүй, ээ. Хайрт эцгийн гүйцэлдүүлж амжаагүй хүслийг биелүүлэх нь нуган үр миний үүрэг бус уу?

-Хаантан минь. Би тантай зөвшилгүй дур мэдэн нэгэн хэрэг сэдсэнээ танд дуулгах гэсэн юм.Өршөөн нигүүлсэнэ буй за хэмээн Ануг хэлэхэд Галдан тийнхүү бодолд дарагдсан байснаа сэхээ орж:

-Юун хэрэг буй? Чи минь ухаан төгөлдөр хүн тул яавч буруу хэрэг сэдэхгүй гэдгийг би

МЭДНЭМ.

-Таны ач Цэвээнравдан сүйт сэвгэрээ булаалгасандаа хорсон яваа нь ойлгомжтой. Миний олж сонссоноор зулай гишгэсэн дүү Сономравдан нь “Эцгээ алдсан өнчин биднийг Галдан авга хэтийдтэл дээрэлхэн доромжилж буй нь энэ ...” хэмээн хилэгнэж явна гэнэ. Тиймд хатан сэвгэр булаалдсанаас үүдэн авга, ач нарын хооронд буй болоод буй хагарлын үүд цаашлах тусмаа их өс хонзон өдөөхөд хүргэх вий гэж эмээх үүднээс Цэвээнравданд Ахайн оронд Пунцаг далай ханы дөрөвдүгээр охин Цэцэнхоролыг бэр гуйхаар хүмүүн илгээж яв цав тохиролцоод байна. Таны бэргэн Насанжид ахайтны өчих нь Цэвээнравдан дургүй бус байгаа гэх хэмээгээд Ану нөхрийн нүүр өөд эгцлэн ширтэнэ.

Түүнийг Сэнгэ ахынхаа оронд хунтайжийн ор суухад арван зургаа л хүрч явсан Цэвээнравдан цаанаа их л дургүйцэн, цоросын тэргүүн болох санаатай байсан агаад өчүүхэн шалтаг олж эх дүү нараа аваад Турфан руу зулбан одсон. Цэвээнравдангийн сүй бэлэг тавьсан сэвгэрийг богтлон авахдаа Галдан, хаан авгынх нь гар хэр чанга болох, өнөөдөр засаглаж буй түүний өөдөөс хэн бугай нь ч сөрөн тэмцэх толгой үгүйг ачдаа давхар сануулах гэснийх буй за. Гэтэл Ану хатан нь ач нартай нь түүнийг эвлэрүүлэх гээд өмнөөс нь бэр гуйгаад сууж байдаг.

Бухараас олзлон авчирсан алт эрдэнэсийн дээжээр өргөөнийх нь талыг дүүргэхэд “Зүүнгар улсын санд тушаагтун. Өчүүхэн надад энэ их эд уурс хэрэг үгүй” хэмээн цааргалж байсан атал, өөрийнх нь хэтийн замд хөндөлдөх төрсөн ач нарын өс хонзонг арилгах гэж сэтгэл чилж байгаа нь энэ.

-Таныг цаашид ийш тийш дайлж явах хооронд Цэвээнравдан ар хударгаар тань ширээ булаан авах аюул ямагт отох болно гэдгийг бүү умартагтун.

Галдан хаан хатныхаа толгойг цээжиндээ авчран тэвэрлээ.

-Чамдаа талархах сэтгэлээ хэрхэн илчилдэг билээ. Өдгөө Цэвээнравдан нас залуу, цус шингэн, хүчин сул учраас номхон суугаад буй. Цаашид барын зулзага томрох тусам надад дайсагнах нь илт тул чиний минь сэдсэн үйл түр ч гэсэн омгийг нь сулруулахад хэрэг буй гэснээ хатны зүг асуунгүй харц илгээн:

-Ану, хайрт минь. Чамд дэмий ч нэг хуяг дуулга авчирсангүй. Энэ намар Хасагийн хаант улс руу давголж, эртний “даагаа нэхдэг” юм уу хэмээн бодож байна. Чи юу гэж тунгаанам? гэлээ.

Түшээт ханд алдсан албат иргэдээ авч чадахаа больсон Засагт хан Цэнгүний хүсэлтээр бамбай хийн эр нөхрөө Халх руу довглох вий хэмээн далдуур түгшин, тэгэх аваас Эсэн тайшийн түүх давтагдаж, далиманд нь Энх-Амгалан хаан Халх Ойрадын зөрчил дундаас завшаан эрж цэрэглэн халх руу довглох нь ойлгомжтой хэмээн болгоомжилж байсан Ануд энэ нь таатай зөв шийдвэр мэт санагдсан тул дуун дээр дэмжиж, намрын эхэн сард Хасагийн хаан Янгир султаныг дайлахад хамтдаа мордохоор тогтоцгоов.

Ургац хураалтын ажлыг ордны их бойдаа, бусад дотоод хэрэг эрхэлсэн түшмэлүүдэд даатгаад намрын эхэн сарын билэгт сайн өдөр Галдан хаан Махан, Данжила жанжнаар удирдуулсан Зүүнгарын их цэргээ авч, алтан шармал хуяг дуулгаа гялалзуулсан Ану хатнаа дагуулан эртний

өст хасагийн хаант улс руу дайлаар мордлоо.

Ойрадын гурван түмэн цэрэг их хэнгэргээ дэлдэн сүрлэгээр жагсч, хойноос нь идэшний мал, хоол хүнс, дарь ачсан тэмээн хөсөг хөдлөхөд найман настай Сэвдэнбалжир хүү ам булаамтгай шувуун саарал морио унаж, бяцхан илд зүүчихсэн “Би ч бас дайтмаар байна.Бургас цавчихдаа би энэ өргөөний бүх нусгайг урдуураа гишгүүлдэггүй шүү дээ” гэхчлэн эцэг эхээ дагаж байснаа асрагч Сэндэм , цэргийн эрдэм заалгадаг өвгөн баатар Шишгэд нарт хоёр гараасаа хөтлүүлэн урам муутай үлдэв.

Ану хатны хамгаалагчийн хувьд ямагт орд өргөө сахин хоцордог Балсан цог хийморь нь сэргэчихсэн хатны мэргэн харваач, буучдын шадар зуутын тэргүүнд агсам буурал морио унан явна. Харин Ану хатны шадар зуутын ахлагч Бундир харваачийг гэргий Булган нь хүзүүдэн тэвэрч, бэрцэцэг болтой цэнхэр цэцэг өвөр рүү нь хийж, салж ядан нялуурцгаахыг харсан Балсан “Дайн тулаанд мордоход гэргий хүүхэдтэй хүн яасан бэрх юм? Энэ Булган хэзээний омог шартай охин байсан болохоор муу Бундирыг зуурчаад тавихгүйнээ. Өнөөх нь Булганы үгнээс нь гарах биш. Их хэнгэрэг дэлдээд байхад эхнэртэйгээ зууралдаад...Нус нулимс болоод тээртэй гэдэг нь. За тэгээд тулааны үеэр үхье үхэж болохгүй гэргий хүүхэд нь голоос гогодоод байдаг биз. Гэтэл эсгий гэртээ насанд дарагдан хэвтсээр үхсэнд орвол, дайн тулааны газар хийморьтойгоор ясаа тавьсан нь жинхэнэ эр хүний төгсгөл бус уу? “ хэмээн бодож байлаа.

Урьд Галдан хааны эцэг Эрдэнэ Баатар хунтайжийн үед ойрадын зарим ноёд хүчин хавсраагүйгээс дийлж чадаагүй Хасагийн ханыг бут цохих нь хол Ойрад сүр хүчээ үзүүлэх, газар нутгаа тэлэх, алба татвараа нэмэгдүүлэхэд туйлын чухал байлаа.

Галдан бошгитын цэрэг Алтайг өвөрлөн баруун хойд зүгт зогсолтгүй урагшилсаар Хиргисийн нутагт орж ирлээ.Зүүнгарын их цэрэг дайлаар айсуй сургаар Хасагийн хан цэргээ аваад тосон ирж яваа сураг сонсогдов.

Галдан түргэн урсгалт Чуйн голын хөвөөнд буудаллах тушаал өгөөд, аяны цацартаа Ану хатнаа байлгаж байгаад гурван түмэнгийн жанжин Данзан-Омбо,Данжила,Махан гурваа дуудаж авчран Янгир султантай хэрхэн тулалдахаа хэлэлцэв.

-Янгирыг орд өргөөнд нь очин цохих тийм ч санаснаар хэрэг бус.Чоно үүрэндээ өлзийтэй гэдэг.Тэгтэл үхлээ эрэх мэт өөрөө биднийг угтан ирж яваа бол туйлын завшаантай хэрэг.Эзэн Чингис хааны олонтаа хэрэглэж асан дайснаа хууран давшуулсаар гэнэдүүлэн дайрах аргаар Янгиртай тулалдах нь зүй хэмээн бодно хэмээн Галдан хаан хэллээ.

-Янгир султаны хөөрүү зан хөдөлсөн бололтой.Ойрадуудын таргийн савыг бүтэн үлдээхгүй хэмээж байна гэсэн. Тэд орос улсаас төлдөрхөн ихээхэн хэмжээний галт буу, дарь худалдан авсандаа эртэй байгаа бололтой. Гэнэдүүлэн цохилт өгөх юм бол холын тусгал муутай галт буундаа найдсан хасагуудыг хиар цохиж болноо хаантан минь хэмээн Данжила нухацтайхан хэллээ.

Алив дайн тулалдаанд юунаас ч аюухыг үл мэдэх Махан жанжин хэзээний үг цөөтэй тул чимээгүйхэн сууна.

-Бид гунан бууны тоогоор хасагийг бас л гүйцэхгүй. Харин галт буу цөөн ч, дарины нөөц хангалттай тул наашаа давшиж яваа Янгирын цэргийг хүлээнгээ тэсэрдэг бөмбөг олныг зэхэж авцгаая хэмээн Ану хатан өчив.

Галдан хааны хатандаа бэлэглэсэн алтан нарны өнгөт гялалзсан хуяг дуулга нь залуу жавхаалаг хатны гоо үзэсгэлэнг улам ч нэмэх мэт гэрэл ойлгон гялалзах нь туйлын зохистой харагдана.

-Бид хасагийн нутаг руу аажмаар дөхнө. Тэр зууртаа хүлэг морины туурайд шигтгэх өргөст од, тэсрэх бөмбөг зэргийг аль болох ахиухныг бэлтгэх нь зүй хэмээн Галдан хатныхаа зүг өхөөрдөнгүй харц шагнан хэлээд Данжила руу хандан:

-Данжила чи түмтээ аваад давшиж буй Янгирын их цэргийн ард гарч буцан зулбах замыг нь хаа. Хасагийн цэрэгтэй тулгармагц Данзан-Омбын хошууч түмт дайралт хийгээд гэдрэг ухарна. Янгир хөөрүү сагсуу хүн учир бүх цэргээ авч хойноос нь уулгалан дайрах биз. Тэгтэл Махан чиний түмт баруун зүгээс нь гэнэтийн цохилт хийнэ гэхэд Ану хатан дэргэдээ суугаа Бундирын зүг ширвэн:

-Тал хувь нь галт буутай мэргэн бууч, харваачид бүхий миний шадар зуут тэр үед хасагийн галт буутай давших ангийг сөрөн тулалдаж болно шүү дээ гэхэд Галдан инээвхийлэн:

-Намайг хайрт хатнаа дагуулан дайтахаар явааг Янгир мэдсэн байх учиртай. Ану хатан алтлаг хуяг дуулга агсан, хошууч түмний магнайд яваа гэнэ хэмээн цуу тараасан ч яахав. Тэгвэл Янгир султан миний хатныг олзлоод авчих санаатай ухаангүй давшсаар гэнэтийн цохилтонд бүр ч хурдан орж ирэх юм уу гээд хүд хүд инээн сахлаа шувтрахад Ану хатан:

-Нээрэн би шадар зууттайгаа Янгирын цэрэг рүү хошуучлан байлдахад тэд улам шунан дайрах биш үү? хэмээхэд нь Галдан царайгаа хувьсхийлгэн:

-Тэгж хатныхаа амиар тоглохоо болих уу даа. За, чингээд Махан жанжны тэсвэрлэхэд бэрх цохилтонд өртөж туйлдан ядарсан хасаг цэргийг буцан зулбах гэхэд өмнөөс нь Данжилагийн түмт угтан бут цохиход бид урьдын даагаа нэхэж хасагийн туг сүлдийг олзлон авах байлгүй дээ хэмээлээ.

Тийнхүү хасгийн их цэрэгтэй тулалдах арга, мэхээ гурван түмтийнхээ жанжингуудтай тохиролцоод маргааш нь Галдан хааны их цэрэг гурав хуваагдаж, Данжилагийн түмт зүүн чиглэлээр шөнөдөн хөдлөв. Үлдсэн хоёр түмт нь морь, тэмээ, хүнсний малынхаа тааваар аажуухан урагшилж эхэллээ. Хиргисийн уудам тэнүүн тал нутгаар ойрадын их цэрэг, ачаа хөсөг, идэшний хонь туусан хүмүүстэй нийлээд халуун орны аварга могой мэт мушгиралдсан цуваа хөвөрнө.

Нутгаас гараад арваад хоног намрын шар наранд тийнхүү мориор явсан Ану хатан нилээд аяншиж, цасан цагаан царай нь борлосон ч, алтан шармал хуяг дуулгаа гялалзуулан эр нөхөртэйгээ дөрөө харшуулж явахдаа сэтгэл нь аз жаргалын эгшгээр аялгуулан байлаа.

-Чиний хас цагаан царай аяншин борложээ. Урьд нь чингэж олон хоног мориор явж байсан

биш. Аяншиж, зүдэрч байна уу? хэмээн Галданг асуухад Ану хатан дуулгаа толгойноосоо авч намрын аяс зөөлөн салхинд сэрүүцэх зуур нөхөр өөдөө харан цагаан шүд яралзуулан инээмсэглэж:

-Би чинь дөнгөж зургаан настайдаа цастын орны зүг үүнээс ч хол газар мориор давгүй явчихаж байсан хүн шүү. Одоо бол тантайгаа хамт л байх юм бол хэчнээн зүдрэвч надад жаргалын дээд гэсэн үг. Хэрэв та бид хоёр тэнгэрт адислагдсан хоёр юм бол хорвоогийн тоос хөдөлгөх эцсийн мөч ирж, нүд аних цагт намайг түрүүнд нь оруулаасай гэж би бурхан шүтээндээ залбирдаг шүү гэлээ.

-Тэгж яахин болох билээ. Чи чинь гурван үрдээ харагдаж явах, хөлийг нь дөрөөнд гарыг нь ганзганд хүргэх эх нь биш үү?

-Бурхан өршөөвөл тэр гурваа өсч томруулж байж талийх байлгүй дээ хэмээгээд Ану тас тас хөхрөхөд намрын шар наранд борлож, аяны тоосонд борогшсон царайд нь лавай цагаан шүд нь улам ч тодхон гялалзах нь нэн үзэсгэлэнтэй.

-Царай чинь борлосноос Самаркандын хөөрхөн сэвгэрүүд шиг үзэгдэх юм. Тэгээд энэ борхон царайд лавай цагаан шүд сувд мэт өнгө хоршоод гэнгээ Галдан хатныхаа бэлхүүсээр тэврэн хацарт нь үнсэв.

Ану гурван хүүхэд төрүүлснээс хойш урьдын хээ шаагүй зан нь өөрчлөгдөхийн хамт, Ахайг бага хатан болон ирсэн үеэс эхлэн гоо үзэсгэлэнгээ хадгалах гэж хичээн, эхийнхээ зааж өгсөн олон аргыг нууцхан хэрэглэх болсон аж. Чингээд ямагт хушны нүүрсээр шүдээ өнгөлөн зүлгэх болсон тул ерөөс цагаан шүд нь улам ч сувд мэт гялалзан байх болжээ.

Тэр орой Галдан хааны их цэрэг Хиргис аймгийн нутгийг нэвтлэн Хасагийн хил дээрх Ишиг хөл нуурт дөхөж ирээд нэгэн их хадат уулын бэлд буудаллав. Эндээс ганцхан өдөрчийн газарт Янгир султаны цэрэг хуарагнан буйг толгойн харуулынхан мэдэгдсэн ажгу.

Галдан хаан Ану хатнаа дагуулан явсаар дархчуулын отогт хүрэлцэн очив. Гурван майханд хуваагдсан арваад дархан эрсийн захад суух Чилэдүгийн гутлын ангархайг Мандарваа оёод сууж байв. Дархчуудын ахлагч Барс нэрт хиргис цус холилдсон өтгөн хар хөмсөгт дөчөөд насны чийраг бор хүн хаан хатан хоёроо үзээд ухасхийн босч сөгдөөд:

-Жаа, хаантан, хатантан та хоёр амгалан сайн морилж явна уу? хэмээхүйд Галдан:

-Амгалан сайхаан. Та бүхэн аяны замд зүдэрч явна уу. Зам зууртаа морины туурайд хаях өргөст од хэчнээнийг хийв дээ, Барс дархан минь гэх зуур хээрийн цай пурхийлгэн амарч суусан дархчууд бүгд хаан эзнээ үзээд сөгдөн мэхийж амар мэнд эрцгээхийн дунд хөл нүцгэн Чилэдү байхыг үзэн сахал дороо мушийна.

-Жаа, хаантан минь авч гарсан төмрийн нөөц шавхагдах тийшээ байна. Бид зам зуур есөн зуугаад од хийж талыг нь Данжила жанжинд өгөв хэмээн Барс дархан өчив.

-Зарим дархан гэргийтэйгээ яваа нь өнчин дэр дэрлэн хээрийн хойморт яваа бидний бяцхан

агаархлыг төрүүлнэм. Бид тийнхүү хэлэлцээд хэн бусдаас олон өргөст од хийн, хугарч эвдэрсэн сэлэм жад заснав, тэр этгээд хаан эзнээс соёрхол гуйн гэргийгээ дайны газар дагуулж явцгааж байя хэмээн тогтов хэмээн ямагт хүмүүсийг инээлгэж явдаг, алиа хошин зантай гучаад насны Жанчив дарханыг өчихөд Мандарваа шивэгчний хацар намрын болсон тошлог шиг улайж, Чилэдү гэргийн зүг ичингүйрэн хялалзсаар гутлаа гараас нь шувт татан авч өмсөгчин болж суух аж.

-Тэгж болохгүй гэсэн цааз үгүй шүү дээ. Маргаашийн тулааны хойно дархчуулын дунд хэн илүү олон сэлэм, жад засч, ирлэн гэргийгээ тулаанд дагуулан явахыг тодруулах сорил хийгтүн, би шүүе хэмээн Ану хатан ч инээд наргианд оролцов.

Дархан эрчүүд халуун хөөргийн гал, намрын шар наранд давхар давхар түлэгдэн харласан царайнд хасын цагаан шүд яралзуулан инээлдэцгээхэд, мөн л зан ааш сайхан, маргааш болох тулалдаанд цэрэг эрсийхээ сэтгэл санааг өргөн зоригжуулах бодолтой яваа Галдан хаан:

-Хэдий хаан ч гэсэн миний бие тийм сорилгод оролгүйгээр хатнаа дагуулан гарсан нь шударга бус явдал болой. Намайг хатнаа авч аян дайнд гарсны далимаар зарим этгээд олон эрсийн дунд тийнхүү арцалдах бодол төрүүлж байх шиг байна. Тиймд Чилэдү бид хоёр ч тэр тэмцээнд оролцох нь зүй биз гэхэд дархчууд бүр ч хөгжин инээлдэцгээхэд Галдан хаан тоглоом шоглоомоос хоромхоноо гарч царайгаа төв болгоод:

-Бид Янгирыг бут цохиж, галт буу олныг олзлох болно. Тэр цагт Барс чамд сум цутгах, төмөр хайлах ажил үйл дийлдэхээргүй их болох вий хэмээгээд цааш харуул манааны зуутыг шалгахаар хөдлөв.

Хаан хатан хоёр харуулын зуут руу очих замдаа оточ лам нарын цацраар дайрав. Галдан хааны дайн тулаанд авч явдаг дөрвөн оточ, гурван шавийн хамт шарх эдгээхэд онцгой сайн хойлог шувууны борцолсон мах ууранд нүдэж хэсэглэн савлаж суулаа.

Оточ лам нарын ахлаач Гомборавдан маарамба чулуун шилээ зүүчихсэн өмнөө хятад жин тавиад, нүдэж нунтагласан хойлгийн мах нямбай гэгч нь жигнэж сууснаа хаан, хатан хоёрыг үзэнгүүт ухасхийн босч сөгдөн мэндчилэв.

-Гомборавдан маарамбатан, ажил үйлээ бүү орхигтун. Маргаашийн тулалдаанд оройлон дайрах Булад жанжны хошууч мянгатын цэрэг эрст хойлгийн мах хүрэлцэх нүү? хэмээн Галдан хаан асуулаа. Маарамбын шавь арваад насны ламхай эм борц савлах ажлаа орхин хаан, хатан хоёрт чигээ аягалав.

-Хүрэлцэнээ, хаантан минь. Харин шарх боох самбай даавуу хүрэлцэхгүй байх вий хэмээн зовж байна хэмээн маарамбыг нүдний шилээ засан аядуухан дуугарахад Ану хатан:

-Би тэгнэ байх гэж бодоод ордны үйлчдээс нэг тэмээн ачаа дүүрэн цэвэр торго, дурдан, даалимбын өөдөс зэхүүлэн авч гарсан. Харуул манаа эргэчихээд танд хүргүүлье маарамбатаан хэмээлээ.

-Гялайлаа, хатантан минь.

Тэр хоёр харуулын зуутыг эргээд аяны цацартаа ирэхэд сар дээр хөөрсөн байлаа. Намрын нам гүмхэн шөнө үе үесхэн салхи сэрчигнэн, чөдөрлөж тавьсан хоёр мориных нь шир шир хийн өвс хазлах, хааяа тургилах, шөнийн түнэр харанхуйд ууль шувуу хаа нэг хүүг хүүг дуугарахаас өөр чимээ аниргүй. Саяхан икэл хуур наадан “Жангар” хэмээх баатарлаг тууль хайлан, зарим нь “бух ноололдоон”-оор барилдаан хөгжилдөж асан цэрэг эрс маргааш болох амь дүйсэн тулааны өмнөх гүнзгий нойронд автжээ.

Нөхрийнхөө цээжийг түшин хэвтэх Ану:

-Та тулалдааны өмнөх шөнө юу боддог вэ? хэмээн шивнэн асуухад цэрэг эрсийнхээ хийморь сүрийг дуудан үйлс бүтэхүйн тарни амандаа шившиж хэвтсэн Галдан хаан:

-Догшин Жамсран сахиус, эцэг өвгөдийн хийморь лундаа оршсон цоросын сүлд, есөн хөхөлт хар сүлдэндээ залбирдаг даа.

-Уншлага номоо шившдэг үү?

-Тэгэлгүй дээ. Цэрэг эрсийнхээ амь насыг даатган залбирдаг. Харин тулааны дараа бол амь эрсэдсэн баатар эрсийнхээ сүнсийг даатган ном уншина. За, хайрт минь, өглөө нар битүүгээр босч, найр цэнгэл биш харин хүнд хэцүү тулаанд орохоо бодон нойрс доо хэмээгээд хатныхаа нүдэн дээр үнсэв.

Маргааш нь нар битүүгээр цэрэг эрс хэдийн босч, зуут мянгатаараа жагсан, дайн тулааны хийморь дуудсан их хэнгэрэг дэлдэх чимээнээр Ану хатныг сэрэхэд Галдан хаан хэдийн босоод цайлж суулаа.

Тэртээ баруун хойд зүгт нуурын хөвөөгөөр шивээлэн буусан хасагийн их цэрэг ч байлдааны бүрээ үлээн сүрийг үзүүлж буй дуулдана.

Ойрадын эрэлхэг жанжин Данзан-Омбын түмт Ишиг хөл нуурын зүг уулгалан давшив. Өөдөөс нь шар шувууны өдөт дуулгатай хасаг цэргийн хошууч анги мөн дайран орж ирэвэй.

Тийнхүү хасаг, ойрадын их цэргийн хошууч түмтүүд намрын салхинд намуухан долгио наадуулсан үзэсгэлэнт цэнхэр Ишиг хөл нуурын зүүн эрэг дээр үлгэрийн мэт үзэсгэлэн төгөлдөр байгаль цогцолсон Алатау уулын бэлд тулгаран байлдаж эхэллээ.

Гунан буу, галт бууны галаар хамгаалуулсан хасаг цэрэг эхэндээ илүүрхэн давшиж эхэлмэгц, Данзан –Омбын эхний мянгат нилээд олон хүнээ алдаад нуурын баруун эрэг даган ухарч эхлэв. Энэ нь урьд Галдан бошгит хааны боловсруулсан мэх байсан болохоос, юунаас ч үл шантрах ойрадын эрэлхэг цэргүүд давуу хүчтэй дайснаасаа ч төдийлөн ухарч зүрхшээдэггүй билээ.

Алатау уулын хормой дахь багахан өндөрлөг толгой дээр цацраа босгон хээрийн сэнтийдээ сууж, тулалдааны явцыг сунадаг дурангаар ажиглаж буй Галдан хаан:

-Хасагууд уухайлан дайраад их хөөрч байх шиг байна. Нэгэнт ялагдах дүр үзүүлэн ухарч буй



цэргийн хойноос нэмэлт хүчин гаргаж яах нь бол оо? хэмээснээ дэргэдээ суугаа Ануд дурангаа өгөв.

Ану хатан өөрийнхөө дуранг гарган барьсан байснаа нөхрийнхөө сарвайсныг авч сэтгэл ихэд хөдлөн догдолсон байртай:

-Тийм байна. Данзан-Омбо жанжин ухарч яваа цэргийнхээ түрүүнд явна. Та харж байна уу? Тэр улаан нөмрөг нь хийсээд хулсан шаргал морьтой давхиж явааг нь. За, тэр тэр. Хасаг цэргүүд мориноосоо холбирон унацгаахыг үзэхэд манай цэргийн хаясан өргөст од морьдынх нь туурайд шигж байх шиг байна хэмээн ганцаараа ярих шиг амандаа гүвтнэн зүүн гараа зангидан зангаж байлаа.

Ухрах зуураа эргэн эргэн тулалдаж, ойртож ирсэн хасагуудтай эрэлхэгээр цавчилдаж буй цэргүүдийн дунд час улаан нөмрөгөө намируулсан Данзан-Омбо жанжин энгийн нүдэнд ч үзэгдэхгүй тодроод ирлээ. Хүлэг морьдын янцгаах, баатар эрсийн уухайлах, үхлийн шарх аваад ёолон уулга алдах, "Хасагуудыг хүйс тэмтэрцгээе!" хэмээн хашгиралдах, сэлэм жад хавиралдан, тээр цаанаас буудах гунан бууны нүргэлэх зэрэгцэн чих дүлийрэм чимээ ойртон дөтлөв.

Галдан хааны хамгаалагч Өлчир баатар:

-Хаантан, таны морийг авчрая. Одоо энд байх нь хатан, та хоёрын амь насанд халтай гэхэд Галдан сэнтийгээсээ босч цацраа хураахыг тушаагаад хилэн хар мориндоо мордов.

Тулалдаан нар хэвийтэл үргэлжлээд ойрад цэргүүд яаравчлан ухарч, хасаг цэргийн хошууч анги, нэмэгдэл хүчний хамт ачаа хөсгөөсөө холдон тасрахад харуй бүрий болж байлаа.

Маргааш нь ойрадууд мөн л ухарсаар л байлаа. Тулалдааны гурав дахь өдрөөс намрын усан бороо шаагиж эхлэв. Азарган бороонд хувцас, зэр зэвсэг, нэн ялангуяа дарь, сум нь нэвт норж, хүнсний нөөц, ачаа хөсгөөсөө тасран хоёр хуваагдсан хасаг цэрэг рүү баруун талаас нь гэнэт Махан жанжны хиргис голдуу цэргээс бүрдсэн давшигч түмт уулгалан дайрлаа.

Өвөлдөө үл хөлддөг, талимаарсан цэнхэр нүд мэт үзэсгэлэнт Ишиг хөл нуурын баруун эрэг даган хасаг, ойрад цэрэг зууралдан тулалдлаа.

-Одоо хасагуудын зүрхийг хөөргөх цаг төгсгөл болов. Бүх хүчээрээ дайрч, их цэргийнхээ тэргүүнд туг сүлдээ хийсгэн яваа алтан дуулгатай тэр хүн Янгир мөн үү? хэмээн Галдан бошгитын асуухад дэргэд нь байсан Хожуу баатар мориныхоо амыг татах зуур:

-Тийм байна. Гуурстай мэт хурдалдаг гэлцдэг цуутай цагаан хүлгээ унасан байна хэмээхүйд Галдан хаан "Би ч их цэргээ магнайлан тулалдаанд орох цаг болжээ. Цоросын их сүлдээ мандуулаад хасагийн их цэргийг бут цохёе!" хэмээгээд сэлмээ сугалан давхилаа.

Галдан хааны шадар мянгат тулаан болж буй бэл рүү уухайлан дайрав. Ану хатан ч алтан хуяг дуулгаа гялалзуулан нөхрийнхтэйгээ ижил зүсмийн хөө хар морио унаж уухайлан дайрч явна. Түүний шадар зуутын дарга Бундир сэлмийн эрдэмд гарамгай хориод цэрэг авч хаан, хатан

хоёрыг тойрон хүрээлсэн маягаар давшихад, Балсан тэргүүтэй цэц мэргэн эрс ашигтай байрлал эзлэхээр хэдийн давхин одсон байлуга.

Бороо цутган орсоор, тулалдаж буй баатар эрсийн уухайлах, морьд норсон газар халтиран янцгаах, бороо шаагих зэрэгцэн чих дөжрөм их дуу шуугиан хадах агаад, харин урьд өдрүүдийнхийг бодвол шороо тоос манарах, утаа май тэнгэрт хөшиглөх нь арай л татуу байсан нь хур ихтэйнх байв.

Их цэргээ зоригжуулахын тулд Галдан хаан, Ану хатны хамт хасаг цэргүүд рүү давшин ороод цавчилдан байлдахад тэр хоёр руу ойртож ирсэн дайснуудыг Балсан, Өлчир баатар тэргүүтэн цэргүүд галт буугаар нам буудан унагаж байв. Тэрлэг дээлний нь хормой шалба норж, морио давирсаар гуяных нь дотор талын мах зулгарах мэт тэсэхүйеэ бэрх хорсохын хажуугаар, өмнөөс түрэн ирэх хасагуудтай цавчилдан баруун гар нь даагдахаа больтлоо сульдаж, хацрыг нь даган борооны ус гоожих хатнаа харсан Галдан:

-Одоо чи минь хойшоо ухарч үз. Үзтэл муурч унатлаа сульдсан байна. Балсан эзэн хатнаа тулалдааны талбараас аваад гар! хэмээн захирав.

-Одоо нар уулын толгойд ташиж буй бололтой. Тулалдаанаа завсарлавал яасан юм, хаантан минь. Хамтдаа л амсхийе дээ гэж Ану хэлж норсон гээгнийхээ усыг шувтрав.

-Бүрээгээ татаж, тулаанаа зогсоо. Хүн, морьдоо амраах цаг болж. Бодвоос бүгд усан шалхнаг болтлоо норсон биз хэмээн Галдан хаан тушаалаа.

Тийнхүү цагаан гэгээ тасрахын хэрд тулаан зогсч, хоёр тал цэргээ татав.

Модны хаяанд хаан, хатан хоёрын цацрыг босгож, аянд явж гаршсан залуухан зам \тогооч \хонины гуяны нарийн мах хярж, битүү шөл хийн тавьжээ.

-Пээ, хатантан минь. Наад дээл гутал чинь нуороод даагдахын аргагүй болсон биш үү? Хувцсаа сольж үз гэсээр Мандарваа цацрынхаа үүдэнд хуурай дээл барин угтав.

Бороо зүсэрсээр л байлаа.

Норсон гэзгээ задлан усыг нь шавхрах зуур хөвөнтэй ногоон торгон давхац нөмөрсөн Ану хатан:

-Хуурай хувцас чинь ийм хөнгөн дулаахан байдаг бил үү? хэмээхэд хувцсаа ч солилгүй халуун цай оочлох Галдан хаан хатнаа өрөвдөнгүй нүдээр ширтэн:

-Тулаанд явах хэмээн дурлалтгүй л баймаар юм даа, чи минь. Алив, гараа гээд жижигхэн шөрмөслөг гарынх нь алгыг барьж эргүүлэхэд сэлэм тас атган цавчилдсаар баруун алга нь цэврүү үсрэн шархалсан байлаа.

-Зүгээр ээ. Үхэвч сэхэвч тантайгаа хамтдаа л байх сан гэж бодох юм. Эцсийн амьсгал татах цагт намайг таны өмнө нь оруулаарай хэмээн бурхан шүтээндээ залбирдгаа би танд өчсөн шүү дээ. хэмээн Ану хэлээд зүдрэнгэ царайдаа жаргалтай инээмсэглэл тодруулж билээ.

Маргааш нь ойрад цэргүүд үүр цүүрээр хасагийн хүрээ рүү уулгалан дайрч, хэвтэрээсээ босч амжаагүй байхад нь сандралд оруулсны хүчинд арваад гунан бууг нь олзлон авлаа. Бороо үргэлжлэн шивэрсээр л байлаа.

Энэ өдөр хасагийн цэрэг Данзан-Омбо, Данжила хоёрын түмтэд хайчлуулах мэт хоёр талаасаа тас цохигдон ухарч гарав.

Газрын бартаа даган өдөр шөнөгүй ухрах хасагуудын хойноос ойрад цэрэг мөшгин тулалдсаар хасагийн хил даван цаашлахад нь Данжилагийн түмт гэнэт урдаас нь тосон байлдаж бут цохилоо. Орой нь Янгир султан энэ тулалдаанд алагдсаныг олж, туг сүлдийг нь олзлов.

Толгойдоо хасагийн сүлдэт алтан дуулгатай Янгир султаны үхдлийг харан зогсох Галдан:

-Дайны газар алалдах дайсантайгаа тэмцэлдэж яваад ийнхүү үхэх нь эр хүний бахархал мөн авч, хаан хүн үхсэн хойноо ч хүүрээ дайсныхаа гарт өгч үл болно. Хасаг цэргүүдээр эзэн хааныг нь өөрсдийнх нь ёс заншлын дагуу хөдөөлүүл хэмээн тушаавай.

Тийнхүү Галдан хаан эртний тооцоотой хасгийн хааныг бут цохин, нутгийнх нь ихэнх хэсгийг, Сырдарьяа мөрний үржил шимт хөндийн хамт эзлэн авч, эд баялаг, галт зэвсгийг нь олзлоод нутгийн зүг хүлгийн жолоо залав.

Ану хатан эр нөхрийн хамт анх удаа ийнхүү аян дайнд мордон дайснаа бут цохихын ид хавыг үзсэндээ омогшин баясч, багадаа “Эр хүн юунд дайн тулаанд дурладаг юм?” хэмээн гайхаж байсныхаа учирьг одоо л олох мэт болов. Өдгөө хүчирхэг Бошигт хаан эр нөхрийнх нь өлмий дор дөрвөн ойрадаар барахгүй, хиргис, буруд, хасгийн нутаг, хотонгийн Самарканд, Бухар, Яркенд, Кашгар, Сайрам, Турфан, Хами балгадууд сөгдөн бууж өгөөд байна бус уу?

Гэвчиг Манж чин улсын Энх-Амгалан хаан, суган дор нь Зүүнгар улс ийн хүчирхэгжиж буйд баясахгүй нь лав.Өнөөхөндөө Чин гүрэн дотоодын бослого үймээнээ дарж төрөө амарлиулах гээд Зүүнгарт анхаарал хандуулах завдал үгүй энэ завшааныг ашиглан цэргийн хүчин тэнхэрч авах нь зүй хэмээн аян дайнаас буцах замд Ану хатан бодлогоширч явлаа.

Аргын тооллын 1682 оны намрын адаг сар. Хасагийг дайлсны дараа Манж чин улсын Энх-Амгалан хаан Дотоодын сайд Сэдэд, тэргүүн зэргийн тавнан Очир нараар толгойлуулсан элч илгээж, үлэмж их бэлэг сэлтийн хамт Зүүнгарын Галдан бошгитын “Хаан” цолыг хүлээн зөвшиж буй тухай жуух бичиг явуулсныг дуулгасан элч Ховог сайрт ирсэн нь ойрадын түүхэнд үзэгдэж дуулдаагүй дуулиант явдал байв.

Ану хатныг Сэвдэн хүүгийнхээ тод үсэг хэр нүдэлж буйг шалган өргөөндөө суутал Ахай хатныд урьд шөнө хоноглосон Галдан хаан Магсар хиаг илгээн түүнийг Дотоод ордонд дуудуулав.

Эр нөхрөө бага хатнаас нь харамлан хардах сэтгэлээ хатамжлахыг хичээхдээ хүүгийнхээ номыг давтуулан сатаарч суусан хатан өргөөнийхөө том босоо толинд яаравчлан үс зүсээ засч янзлан, урьд шөнө ном судар эргүүлсээр нойр муухан хоносны тэмдэг нүдэн доогуураа татсан хөх толбыг энгэсгээр дараад Дотоод ордны зүг гарахдаа эр нөхөр нь юуны тулд

дуудуулсныг тааж ядан явлаа.

Ану хатныг төрийн хэрэг хэлэлцдэг Зөвлөлдөх танхимд ороход эр нөхөр нь ганцаар бус Данжила, Данзан-Омбо, Махан жанжин, Доржжав тайж, Магнай ноён, Цэрэн зайсан, ёслолын түшмэл Чинхай нарын олон сайд түшмэд шадар ноёдоо цуглуулсан байлаа.

Тэгтэл Манж чин улсын Энх-Амгалан буюу Сюанье хаан Зүүнгарын Галдан бошгот хааны эрх мэдлийг хүлээн зөвшиж тусгаар эрхэт элчээ илгээж буйгаа айлтган мэдүүлсэн Самдан гэлэн хэмээгчийг ирүүлсэн байв.

Тийнхүү Манж чин гүрний шар луут туг намируулсан төрийн элчин төлөлөгч зүүнгарын хааны ордонд анх удаа морилон ирж буй завшаант үйл явдлыг олон сайд түшмэлийн хамт хэлэлцээд хэл хүргэж ирсэн Самдан гэлэнг дагуулан Гэсэр түшмэлийг томилон мордуулахаар тогтоцгоов.

Үдэш нь сэтгэл ихэд хөгжин сархад ханхлуулсан Галдан хаан Ану хатныхаа өргөөнд морилов.

-Урьд шөнө Ахайтай хоносонд чи минь гомдоогүй биз? хэмээн саймшрах Галдан хаан:

-Өмнө зүгт орших миний хамгийн том дайсан Энх-Амгалан хаан намайг Зүүнгарын хаант Улсын эзэн хэмээн хүлээн зөвшиж соёрхол илгээнэ гэдэг хэчнээн баярт үйл явдал билээ? Гэтэл энэ болбоос дан ганц надад хамаатай бус, цастын орноос ирж хаан сууринд суусан цагаас дэргэд минь түшиж, тулж, үр үндсийг минь төрүүлэн өсгөхийн завсар төр түвшитгэх хүчир үйлст мөр зэрэгцэн зүтгэсэн хатан чиний минь ч гавьяа хэмээн мунхарна хэмээсэн нь чин зүрхнийх нь үг байлаа.

Ану хатны өргөөний их ган тулганд аргалын гал илчтэйгээр дүрэлзэн, Галдан хаан хатантайгаа Манжийн элчийг хэрхэн хүлээж авах тухай удтал хэлэлцэв.

-Нэгэн цагт монголчууд бидэнтэй холбоотон болсны хүч дэмээр нанхиадыг цохин, дотоод аймгуудын эвдрэлцлээ дарж, манай бичиг үсгийг ч зээлдэн хэрэглэж явсан зүрчид, тэлэнгидүүд өнөөдөр ийнхүү хүчирхэгжээд буйг бид мартах учиргүй билээ. Элчдийг хүндлэхийн дээдээр хүндлэхийн хамт хаан та хүчирхэг монголын нэгэн тасархай, өнөөдөр туурга тусгаар Зүүнгарын төрт улсын эзэн гэдгээ бас зүрчид манж нарт үзүүлэх нь зүй. Тиймд Манжийн элчдийг ирэх замд хоёр дараалан томоохон ноёдоор толгойлуулсан хүмүүс явуулан угтуулахын хамт, уналгын морь, ачлагын тэмээ, хүнсний хониор бэлэг шан хүртээвэл ямар? хэмээн Ану өчив.

-Чиний мэргэн ухаанд ямагт авууштай санаа бодол орж ирэх юм. Манжийн элчин төлөөлөгчид миний орд өргөөнд даруй сар болж байж хүрэлцэн ирэх юм байна. Харин миний бодоход Манжийн элч нарыг ирсэн даруй би хүлээн авахгүй хэсэг хүлээлгэн, Хөх нуураас Сырдарьяа, Самарканд Бухар хүртэлх уудам их газрыг эзлэн захирсан, Энх-Амгалангаас дутах юмгүй эзэн хааны эрх сүрээ үзүүлэх нь зүй хэмээн бодно гэж Галдан ярив.

-Таны бодол туйлын зөв. Миний олж сонссоноор хаан ширээнд суусан цагаас хойш төрийн

эрхийг гартаа бүрэн оруулж үл чадсаар дөнгөж сая хонин жилд л авга ах Сонготугаа замаасаа зайлуулан Чин гүрний төрийн жолоог атгасан ч нанхиадуудын бослого самуунтай зууралдсаар ирсэн Энх-Амгалан хаан ийнхүү манай Зүүнгарт тусгай элчээ илгээж буй энэ завшааныг сайн , муу хоёр талаас нь харах хэрэгтэй байна. Нэг талаас дорнод Туркестан, хасаг, хиргис, бурудын уудам нутгийг эзэлсэн Бошгит хаан таныг Манж нар хүлээн зөвшөөрч буй нь сайн хэрэг.Нөгөө талаас нь үзвээс ийнхүү бидний сэтгэлийг амарлиулан хөхүүлж байх завсарт далдуур цэргийн хүчээ нөөж байгаад Халх манай хоёрын хооронд яс хаян доройтуулах бодол ч бий байх. Тиймд, та элч нарыг ирсэн даруйд хүлээн авч хөл алдахгүй байх нь тун мэргэн санаа хэмээн мунхаглана гэж Ану хэлэх зуур Галдан хаан тамхилах гэж өврөө тэмтрэн Ахайн урлаж өгсөн мандарваа цэцгэн дээр суусан хос эрвээхийн дүрстэй тамхины пүүсүү хавтагаа гаргахыг үзээд сэтгэл нь хямарч “Муу ижий минь хатад, татвар эмсийн жөтөөрхөлцлөөс болж дэрээ нэвтэртэл уйлан, гомдож байснаа аавыг өргөөнд нь ороод ирэхэд, хэрхэн юу ч болоогүй мэт царайлан , сайхан инээмсэглэл, эелдэг наалинхай аашны баг зүүж чаддаг байгаа вэ?За,тэгээд бурхан болсон хадам эх ч гэсэн тэр олон хатад дундаас яажшуухан эр нөхөр Баатар хунтайжийн хайр энхрийллийг дан өөртөө татаж, хоёр хүүгээ эцгийн ор суулгаж чадсан байнам?Мөхөс миний л ухаан үл хүрэх юм байна” хэмээн бодож суув.

Тийнхүү Манжийн элч төлөөлөгчдийг Зүүнгарын хааны ордонд хүрэлцэн ирэх хүртэл замд нь Цэрэн зайсан, Цэцэн зайсан нарыг илгээн их хурим найр дэглэсээр өвлийн дунд сар гарахад сая л Чин гүрний шар луут туг хиурыг намируулсан ачаа хөсгийн цуваа Галдан хааны ордонд ирж билээ.

Хатантайгаа хэлэлцсэн ёсоороо Галдан хаан Манжийн элч нарт “Чин гүрний элч нарыг даруй найрсгаар хүлээн авах бодол их ч билэгт сайн өдрийг өнжин хүлээнэм” гэсэн шалтаг хэлэн тав хоног саатуулж байж сая Дотоод ордондоо хүлээн авч хүндэтгэл илэрхийлэв.

Хоймортоо Богд Зонховын алтан шармал асар том шуумал дүр,эцэг Баатар хунтайж агсны сүрлэг хөрөг, цоросын сүлд, дайны их хар сүлд залсан энэ танхимын шалыг перс газрын үнэт хивсээр бүрхэж, эзэн Чингисийн сүлд алтан шонхор сийлсэн сэнтийдээ тухалсан идэр залуу Галдан бошгит хаан зүүн талдаа төрийн хатан эрдэнэ их, бага хоёр хатнаа суулгажээ.

Манжийн элч нарын тэргүүн Сэдэд сайд тэлэнгидүүдийн нийтлэг төрх, шингэн хөмсөг, сахалтай, жийтгар нүдтэй тавь эргэм насны хүн аж.

Хоёр талаас найрсаг үг хэлэлцэн, Сэдэд сайд Энх-Амгалан хааны жуух бичиг, бэлэг сэлтийг өргөсний хойно Манж чин гүрний тусгай элч нарыг хүндлэн барьсан зумыг хөндүүлж, яриа хөөрөө задгайрах үеэр Галдан хаан:

-Идэр залуу Энх-Амгалан хааны өлмий бат оршиж буй биз ээ.Миний олж сонссоноор Чин улсын төрийг эсэргүүцэн боссон У Сяньгүй, Ян Цилунь нарын этгээдүүдийн дэгдээсэн бослого үймээн олон жил үргэлжлэн сунжирсан нь тоогүй. Төлдөрхөн Энх-Амгалан хаан тэдгээр босуул хулгай нарын үймээн самууныг дарсан сурагтай ч, дахин бусад мужаар бас л тэрслүүд этгээдүүд өндөлзсөөр буй нь үнэн үү? гэх мэтээр асууж шалгаасан нь “Танай Манж чин гүрэн хэдий хүчирхэг ч дотоодын самуунаа яая даа хэмээж буй бус уу?” гэж ам асуух, та нарын сул талыг би мэдэж буй шүү гэдгээ үзүүлэх гэсэн давхар санаа агуулж буйг Сэдэд сайд

мэтийн хашир түшмэл юу эс андах билээ.

Чингэтэл Манжийн элч нарын ахлагч ч мөчөөгөө өгсөнгүй:

-Танай монголын халх, өвөрлөгчдийн олон ихэс, дээдэс манай Чин улсын гүнж нартай дэр нэгтгэн хааны ураг төрөл болж “Эфү” цол шагнуулан богд эзний ивээлд орсоор байна.

Галдан бошгит хаан ч гэсэн та богд эзний төрсөн дүү үзэсгэлэнт Чангай гүнжийг буулган авч болох бус уу? хэмээн тулгав.

Галдан хаан сахлаа шувтран хүд хүд инээж:

-Найрсаг сэтгэл гарган дайлж буй идээний дээдийг хүндэтгэн тогтооно уу хэмээн хатуу сархадаар шахахын хамт:

-Манж чин гүрний богд эзэн Энх-Амгалан хааны төрсөн гүнжтэй нь хуримлахыг л хааны ураг боллоо гэх биз, харин дүү нь хэдий хааны үр ч одоогийн хааны гүнж биш билээ. Тиймд би вээр хааны дүүтэй ураглан тавнан болох бодол алга хэмээн өдгөө дөнгөж гучин насны сүүдэр зооглож буй Энх-Амгалан хааныг цаагуураа ихэд бодохгүй буйгаа илэрхийлэн амыг нь таглав.

Галдан хааны ордонд сар шахуу саатан гийчилж, хүйтний эрч сулрахыг хүлээсэн Манж чин гүрний элч нарыг буцахад Галдан бошгит хаан авчирсан их бэлэг сэлтийнх нь хариуд дөрвөн зуун агт морь, жаран тэмээ, гурван зуун булганы арьс, ховор үзэмжтэй цагаан хэрэмний арьс таван зуу, хярсны арьс зуу, үнэгний арьс хорь, амьд тас шувуу нэг, алталсан булигаар тав, өөлд галт буу дөрвийг өгчилгөв.

Тэр жил Галдан хааны багш тавдугаар Далай лам 68 сүүдэртэйдээ жанч халсныг Дэрсид Санжаажамц нуун дарагдуулж нууцаар хөдөөлүүлээд, бурхан болсон түүний нэрийг барин зарлиг шийд гарган шашин төрийн хутгуур хийх болсон билээ.

## Арваннаймдугаар бүлэг

Аргын 1686 он, улаагчин бар жилийн зуны тэргүүн сар. Ану хатан өргөөндөө бие сул, ураг зулбаснаас тамирдан хэвтэж байлаа. Дөрвөн жилийн өмнө, нохой жилийн намраар хасагийн хааныг дайлаар мордоход усан бороонд олон хоног тух алдан доороосоо даарснаас өвчин олсон нь ургаа бүрэн тээх чадваргүй болгожээ хэмээн Гомборавдан маарамба айлдаж, дотор халууныг дарах тан уулгаж буй ажээ.

Энэ жил нас гучин гуравтай Ану хатны хувьд тийнхүү цаашид дахин үр төрүүлж, эх болохын жаргал болоод зүдүүрийг амсах тавилангүй болсондоо сэтгэл чилүүрдэн хэвтэж байв. Найман ханат их өргөөнд өөрөөс нь өөр хэн ч үгүй. Хүүхдүүдийг зэргэлдээ байдаг бага өргөөнд оруулж, гав ганцаараа дотоод хүнтэйгээ хөөрөлдөн сэтгэлээ чагнамаар байлаа.

Чингээд хатан бүр бага, Хөх нуурт байх үед Галдмаа ахынх нь Оросоос авчирч өгч байсан ногоолин чимэглэлт гарын толио авч нүүрээ тольдов. Зовхи, жавьжных нь орчмоор, мөн магнай дээгүүр нь бүдэгхээн үрчлээс бий болж, харц нь амьдралыг танин хатуужсаныг илтгэх мэт хашир хянамгай болсныг сая л ажиглав. Бас санчгандаа намрын хяруу мэт ганц нэг цагаан үс цайрах болсныг олж, гүнзгий санаа алдсанаа зулгааж хаяв.

Саяхан л тэрээр арван дөрөвгэй, уулын тунгалаг горхи мэт цэвэр, ариухан цовоо цолгин охин Хөх нуурын тал хөндийгөөр хүлгийн хурд шалган давхиж, харааны мэргэнийг сорин тэнгэрт эргэлдэх тас шувууг алдалгүй харваж, эцэг эхийн энхрий үр яваагүй гэж үү? Одоо тэгтэл хан буурал Алтай мэт түшигтэй эцэг нь ч дэргэд алга. Хатан гоо ижий нь ч тэнгэрийн оронд буцан одоод нэг жилийн нүүр үзчихжээ. Орчлонг эрхшээгч цаг хугацаа авхай та хэчнээн хүчирхэг агаад хахир хатуу юм бэ?

Ижий нь нэгэнтээ бүсгүй хүний залуу нас, гоо үзэсгэлэн гэдэг цэцгийн зун шиг охорхон, агаад их үдийн нар мэт хоромхон зуур цаашлан оддог юм. Нэн ялангуяа гучин наснаас хойш цаг хугацаа ороо хулан шиг тоосноос ч хурдан цахилан өнгөрдөг хэмээн ярьж байсан нь гэнэт санагдав.

Өргөөний гадаах харуулын цэрэг эр ханиах дуулдан Мандарваа шагайж:

-Хатантаан, хаан эзэн Магсар хиаг илгээжээ хэмээлээ.

Энэ жил гучин тав хүрч буй Мандарваа ганцхан хүү төрүүлсэн болоод ч тэр юм уу, уур уцааргүй амар амгалан зантайдаа тэр юм уу, дүү Булганыхаа дэргэд хавьгүй овор багатай, гуч хэтрээгүй мэт үзэгдэх аж.

Гоо үзэсгэлэнгээ тордох тухайд ихэнхдээ хайхрамж муутай, ном судар шагайж, төрийн хэрэгт өөрийн эрхгүй оюунаа чилээж суудаг Ану хатныг Мандарваа л сайн дураараа ариглан арчилдаг байлаа. Саяхан тэрээр талийгч Доржравдан хатны жороор шүү, үхрийн хайлсан өөх, үнэр ялдам сараана цэцгийн ханд найруулан үйлдсэн савангаар Анугийн өтгөн гэзгийг угаан, хараалч цэцгийн хандаар зайлж самнан гөрж өгөөд гарсан билээ. Тэгэхдээ:

-Энэ саванг зэхэж суухад Хөх нуурт өнгөрсөн хүүхэд нас санагддаг юм. Таныг бүсгүй хүний

төрх үгүй, эр хүмүүний үйлд шохоорхдогийг хэрхэн багасгах билээ? Ядаж чи миний жороор саван бэлтгэж, цаад авхайнхаа үс гэзгийг угааж, зүсийг нь ариглан тордож, өөртөө ч анхиатай явж үз хэмээн бүрлээч ахайтан маань захидаг сан. Хатуу ч гэсэн үнэн үгтэй, хайр нь дотроо хүн байж дээ гэхчлэн хүүрнэж алаг зүрхний нь нэгтээ нуугдан хоцорсон эрх бага насны дурсамжийн утсыг хөвөрдчихөж билээ.

-Оруулагтун! гээд Ану хатан өндийж, нимгэн ногоовтор дурдан дан дээлийн энгэрийг эмхлэн цэмцийлгэв.

-Жаа, хаан эзэнтэн таны биеийг асуун лавлаад тэнхээ дээрдсэн бол яаравчлан уулзах хэрэгтэйг илтгэ хэмээн намайг илгээлээ гэж өндөр гооногор биедээ чамлалтай гонгиносон дуутай идэрхэн хиа дамжуулаад хатны төлөв түвшин царай өөд хүндэтгэнгүй ширтэнэ.

-Миний бие илааршин засарч байна. Өргөөнд минь морилон ирнэ үү хэмээн хүсч буйг хаанд дамжуул гээд хатан орны дэргэдэх үхэг дээрээс хонхоо авч жингэнүүлэв.

-Жаа, хатантаан.

-Явж болно.

Хиаг гарангуут Мандарваа зөрөн орж ирэв.

-Миний өргөөг яаравчлан цэгцлүүлж, анхилуун үнэрт хүж асаа. Өвчтэй хүний хэвтрийн үнэр, эм тан ханхлуулан эр нөхрөө угтах хүсэл алга. Авдраас шинэ ухаа ягаан магнаг дээл, усан ягаан маньн өнгөт цэгдэг гарга хэмээн саяхан хүйтэн хөлс дааварлуулан халуурч хэвтээгүй мэт цовоо цолгин дуугаар захирамжлаад, гоёл чимэглэлийн хайрцгаа гарган дээл, цэгдэгтэйгээ өнгө хорших ягаан болор зүүсгэл, ээмэг гарган зэхэв. Энэ ээмгийг тэртээ найман жилийн өмнө морин жилд Галдан хаан дорнод түрэгстаныг дайлаад эгэн ирэхдээ хатандаа авчран бэлэглэж билээ.

Тооноор хоймор дүүргэн тусах зуны тэргүүн сарын илч гэрэл дүүрэн наран авхайн мишээлд тэрхүү болор зүүсгэлээс гэрийн унь хана дагуулан туяа ойлгох нь туйлын үзэсгэлэнтэй. Тийнхүү гэрээр нэг гэрэл ойлгох болор ээмэг, зүүсгэлийн өнгө хатны ядрангуй царайд өнгө чимэг нэмэн гийгүүлэх аж.

Гаднаас Галдан хаан өөрийнхөө аминчлан эрхлүүлдэг отгон гүнж Юмчихайгаа хөтлөн орж ирэвэй.

-За, Анухан минь бие нь яаж байна? Маарамбын хэлснээс илүү үтэр илааршиж байна уу даа, энэ чинь? хэмээн Галдан асуух зуур урьдынх шигээ хойморт бус хатныхаа орны дэргэдэх явган сандайлга дээр суулаа.

-Тийм шүү, дээрдэж байна. Таны уншсан номын хүч, бурхан шүтээн минь, бас энэ гурван үрийн минь заяа харж үзсэн юм байлгүй гээд Ану охиноо дуудан:

- Алив ижий нь үнэрлэе дээ гээд охиныхоо олон салаа хархан гэзгийг илбэн духан дээр нь



ҮНСЭВ.

Есөн настай Юмчихай томрох тусам талийгч Юм-Агас хатантай адилхан болж, хацар дээрх мэнгэ нь тодрон хар бэхээр зурсан юм шиг харагдах агаад Галдан энэ охиноо эхийн сүнс гэж бодон бусад хоёроос нь илт илүү хайрладаг ажээ.

-Ижий, аав надад “Цаасан шувуун”-ы үлгэр уншиж өгсөн гэж охиныг хэлэхэд эцэг, эх хоёр нь өхөөрдлийн харц солилцов.

-Ижий нь чиний насан дээр тэрийг тэнь өөрөө л уншдаг байсан юм даа гэж Ануг хэлэхэд охин хошуу цорвойлгон эцгийн энгэрт наалдах зуур духан доогуураа эх рүүгээ ууртай хараад:

-Номын өргөөнд тэр судар тань тод бичгээр байхгүй шүү дээ. Тэгээд ч та биеэ бүү ихэд өргөмжил.Өөрөө биднийг биеэ бүү ихэд бодож, магтаж бай гэж сургадаг байтлаа, би чам шиг байхдаа чингэдэг байсан, ингэдэг асан гээд байх юм гэлээ.

Галдан хүд хүд инээн охиноо омогшуулаад:

-Гэвчиг ижийнхээ өмнөөс үг хэлж бас болдоггүй юм.Тэгвэл чи бас биеэ ихэд өргөмжилдөг, нэмээд эхийн ачийг үл мэдэгч асралгүй үр хэмээгдэх болно. За, одоо гарч тоглож наад даа охин минь хэмээв.

-Хатан минь.Чамтай нэгэн зүйлийг зөвшилцөх нь зүй хэмээн бие тэнь төдгүй байхад чирэгдэл түвэг болж ирлээ. Юун гэвээс Далай багшаас эрдэмт ламтан Цэцэг хамбыг манай Зүүнгарт илгээсэн нь өнөө маргаашгүй ордонд ирэх юм байна. Халхын дотоод эв нэгдлийг хангаж, шуудайд хийсэн үхрийн эвэр мэт зүг зүг тийш зүтгэн юм л бол зэвсэг барин тэмцэлдэхэд хүрдэг хан, ноёдыг цуглуулан чуулган хийлгэхээр болж. Цэцэг хамбын морилон ирж буйн учир нь манай Зүүнгар улсаас тэрхүү чуулганд элч төлөөлөгчөө илгээхийг ятган сэнхрүүлэх зорилготой юм байх.Гагцхүү сайхан зорилгоор хучсан энэ чуулганы цаад эзэн нь манж чин улс байгаад миний урам хугарч байна. Гэвчиг тэрхүү чуулганд элч төлөөлөгчөө илгээхийг Далай багштанаас таалж буйн учир чухам яавал зохихыг бодож сууна. Энэ тухайд Ану чи юу сэтгэнэ? хэмээгээд Дархижавын аягалж өгсөн аагтай хонгор цайг оочлов.

Өнгөлөг шинэ дээл хувцас өмсөн, цог хийморь дүүрэн байхыг хичээх Ану хатны цонхигордуухан царай энэ үгийг сонсмогц сэргээд ирэв.

-Хаантан минь. Цаанаа Энх-Амгалан хааны гар орсон ч бай цус нэгт монгол ахан дүүс Түшээт хан,Засагт ханаар талцан алалдах нь мөхлийн дохио буй. Тиймд халхын ноёд чуулж, манай Зүүнгар элчээ илгээхэд магнай атируулах юун? Харин тийш хэнийг илгээх нь таны таалал бизээ хэмээв.

-Хатан чи ямагт элэг нэгт монголчуудын эрх ашиг хэмээн дээдэлдэг нь зөв ч, тэдэн дунд Чахундорж мэтийн манжийн гар хөл буй цаг дор алалдах л болно. Харин хэнийг илгээх вэ гэдэг тухайд чамтай зөвшилцмөөр байна.

Ану эр нөхрөө тийнхүү Халхтай сөргөлдөх шалтаг ямагт олж чаддаг, түүндээ Түшээт хан

Чахундоржийг хавчуулдагт эвгүйрхэн царайгаа үлмэдэг барайлгаад:

-Миний бодоход аливаад эв эеийг сахихдаа гаргуун тул Цэцэн увшийг Данжилагийн хамт илгээвэл ямар? гэлээ.

Тийнхүү Цэцэн увш, Данжила тэргүүтэй Зүүнгарын төлөөлөгчид Галдан бошгитын зараалаар халхын ноёдын чуулганд оролцоод ирэв.

Бар жилийн намрын эхэн сард Заг-Байдрагийн Хүрэн бэлчир хэмээх газарт болсон тэрхүү чуулганд Энх-Амгалан хаан Халхын хэрэг эрхэлсэн сайд Арнайг илгээсэн агаад, Түшээт хан Чахундоржийн өмнөөс Өндөр гэгээн Занабазар, Цэцэн хан Норов, Засагт хан Шар, түүний төрлийн ноён Саран ахай, Сайн ноёны Шамба засаг, Түшээт ханы дүү Сэдшир бэйл, Пунцагравдан нарын зэрэг жараад ихэс ноён хүрэлцэн очиж долоон өдөр чуулсан ажгу. Нэгэнт Халхын дотоодын эв нэгдлийг батжуулах нэрийн доор Энх-Амгалан хааны гар оролцсон чуулган тул манжийн элч Арнай сайд Богд эзний зарлиг хэмээгчийг өндөр дуугаар уншаад сүүлчийн өдөр нь зүүн, баруун гарын хан, жонон, тайж нарыг хооронд нь “найрамдуулах” ёслол гээчийг үйлдүүлж, зүүн баруун гарыг төлөөлсөн Саран ахай, Сэдшир бэйл нараар эвийн тангараг өргүүлжээ.

Мөн чуулган дээр шашныг төлөөлөн Төвдөөс тарнийн ухаанд нэвтэрсэн Галдан Ширээт ламыг илгээж, Халхаас Өндөр гэгээн Занабазарыг түүнтэй эн тэгш суудал засан залж, ном айлдуулсан ажгу.

Тэрхүү чуулганаас элч төлөөлөгчдөө ирж болсон явдлыг айлтган мэдүүлсний хойно Галдан бошгит хаан “Энх-Амгалан хаан өвөрлөгчдөд хэрэглэсэн башир аргаа Халхад ашиглан эв нэгдлийг сахиулах нэрээр өөртөө хуурмаглан татаж цус нэгт Ойрад бидэнтэй эвсэх найдлагыг үгүй болголоо. Тэр хэрэгт Түшээт хан Чахундорж хорыг нь хамсан найруулсны тул өөрийн биеэр Хүрэн бэлчирт ч хүрэлцэн очсонгүй. Цаашид миний эсрэг ханцуйдаа хутга шургуулан арцалдах дайсан ар Халхад Түшээт хан л байнам” хэмээн Ану хатандаа ярьжээ.

Тийнхүү Хүрэн бэлчирийн чуулганы дараа ямагт Ану хатны болгоомжлон сэрэмжилсээр ирсэн Халх, Ойрадын хагарлын эх нэгэнт тавигдсан нь тод болжээ.

Дөрвөн Ойрадыг нэгтгэн гартаа аваад, хиргис, хасаг, буруд, дорнод Түрэгстаныг эрхшээн, Манж чин улстай эрх тэгш харилцан хүч бяр амтагдах болсон Галдан бошгит хаан ч хойшид Халх, Ойрадыг нэгтгэн хаан суух бодолд нэгэнт авгаад байлаа.

Тэрхүү улаан бар жилийн намар Ховог сайрын Дотоод ордон үл мэдэгдэх шалтгаанаар галд хайлсны далимаар Галдан бошгит орд өргөөгөө хэзээнээс найртай харилцаж ирсэн Засагт ханы нутагт дөтлүүлэн зүүн тийш Гурван хээр хэмээх газарт нүүлгэн очив.

Засагт хан Шар ч эртний түнш Галдан бошгитын тийш өргөөгөө ойртуулан суурьшаад, үе үе элч илгээн Халхын байдлыг тандан дуулгах боллоо.

Ураг зулбуулснаас хойш бие нь төдийлөн дээрдэхгүй, их нүүдэл суудлын хөлд улам ч туйлдсан Ану хатан өргөөндөө нам суун, хүүхдүүддээ уншуулах үлгэр туульсыг тод үсэгт

буулган сийрүүлэхийг чухалд үзэн, эр нөхрийн хэрэгт төдийлөн оролцохыг түвдэх болжээ. Бага залуу насандаа цоросын бэр болон ирснээс хойш идээшин дассан Ховог сайрын тохилог ордыг орхин, зүүн тийш суурьшсан нь хөлгүй их үймээн, самуун, нүүдэл суудлыг ёрлох мэт санагдан сэтгэл тавгүйрхэхэд хатан “Миний бие төдгүй байгаагаас л ийнхүү мууг зөгнөн ёрлож буй биз. Эр нөхөр минь энэ Зүүгарын хаан хэвээр. Эрдэнэ баялаг, мал сүрэг, буудай тариагаар дутагдах юмгүй, идэрхэг хүчирхэг гурван түм илүү цэрэг эрс байхад мөхөс эм би юунд мууг зөгнөнө вэ?” хэмээн өөрийгөө зэмлэж байлаа.

Галдан бошгитын хувьд тэр намар нүүдлийн дараахан арван дөрөв хүрсэн хүү Сэвдэнбалжир, отгон гүнж Юмчихайгаа, бага хатан Ахайн хамт дагуулан Ховд голын сав нутгаар аялан явж ирээд “Ховдын тийшээ үржил шимт газар арвин болохыг үзлээ. Тийшээ хавраас тариаланч хотон, уйгар өрхүүдээс хоёр зууг таслан нүүлгэж арвай, буудай тариална. Тариа будаа арвин байхад албат иргэд ч цэрэг эрс ч гэдэс цагалан байх болно. Цэрэг эрсээ тэжээж чадаж буй цагт төр улс бат бэх болно” хэмээн Ану өчиж байхдаа “Түшээт хантай байлдан Халхыг Зүүнгартай нэгтгээд, цааш Энх-Амгалангийн өөдөөс ухасхийхэд надад цэргийн арвин их хүнс хэрэгтэй” хэмээн бодож байлуга.

Галдан бошгитыг Ховдын газар одсон байх үеэр Ану хатан бие сул байсны харгайгаар салхинд цохиулан томуу тусч халууран бас хэд хоног хэвтжээ. Ану хатныг хоёр дахь өдрөө Гомборавдан маарамбатны өгсөн халуун танг хүртэн хэвтэж байтал Мандарваа орж ирэн:

-Данжила жанжин таны бие лагшинг асуун, орж болох уу гэж асуулгалаа хэмээв.

Тэртээ арван таван жилийн өмнө сүйлсэн эр Сэнгийг тэнгэрт хальсан хойно, өөрийг нь Галдан хаан буулган авахаар ирэхэд анх үзсэн цэл залуу Данжилагийн дүрийг тэр нэхэн санаж, орноосоо өндийн яагаад ч юм яаран сандран үс зүсээ тольдон засах зуур, зүрх догдлон булгилах ч шиг сонин болоод ирэв.

Галданг бодохноо илүү өндөр хамартай, хөмсөг ихгүй ч урсгал харцтай сайхан дүрлэгэр нүдтэй эрүү тууш өргөн бяр тэнхээ их болбуу гэмээр энэ эрмэг сайхан эр хаа нэг тааралдахдаа өөрийг нь эгэл бус шохоорхон дурласан нүдээр сэмхэн ширтдэгийг нь Ану хатан гадарладаг л байлуга.

Орны хөл дээр хайхрамжгүй шидчихсэн байсан шинэ цайвар ногоон дээлээ мөнгөн хоргой цэгдгийн хамт углан, хатан хүний ёслолын малгай тэргүүндээ асаан, уруул, хацраа шунхадсан Ану хатан бага зэрэг турж цонхийсон нь харин ч залуужсан мэт өөртөө санагдаж, ойр зуурын юм хийж урдуур хойгуур нь бөгтгөнөх Мандарваад:

-Данжилаг оруул! хэмээн тушаав.

Ямагт хуяг дуулга өмсч явдаг Данжила энэ удаа хормойгоороо үүлэн хээтэй цав цагаан магнаг дээл өмсч, ташаандаа алталсан илдээ зүүн, булган тоорцог асаасан нь хараад баймаар дэгжин байлаа.

-Хатан таны амгаланг айлтгая. Таныг ханиад шуухинаа хүрээд халуурч байна гэж сонсоод бие лагшинг тань асуух гэж ирлээ хэмээн Данжила хэлж Мандарваагийн аягалж өгсөн цайг хоёр

гардан авах зуур Ану хатны зүг нөгөө урсгал сайхан нүдээрээ урьдынх шигээ шохоорхсон биш, харин энэрэн нигүүлсэх мэт хачин харц илгээв.

Авга ах Галдан бошгитоосоо даруй долоон насаар дүүмэд Данжила энэ жил дөнгөж гучин тав л хүрч эр хүний ид гялалзаж, эмээл дээрээ эрвэлзэж явах насан дээрээ яваа билээ.

-Миний бие өнөөдрөөс халуурахаа больсон.Хавраас хойш би нэг л хийморь сүлд муутай, өвчин ээрэмтгий болоод байна даа. Амны билгээс ашдын билэг гэж.Өвчин зовлон яриад ч яахав дээ.Танай жаал банди хөлд орж байна уу? хэмээн Ану хүүгийнх нь тухай асуулаа.

-Тэнтэр тунтар алхаж л байгаа хэмээн Данжила хэлээд хатны царай өөд нөгөө л нигүүлсэн хайрласан дулаан харцаа илгээж:

-Царай тань их цонхигор байна.Гэвч надад бол улам залуужсан мэт үзэгдэх юм хэмээчихээд Мандарваад гадаа зогсоо Бирвааг ороод ир гээ хэмээв.

-Гуч гарчихсан хүн гоо үзэмж хорогдоно уу гэхээс нэмэгдэх биш дээ хэмээн Ану яагаад ч юм сэтгэлдээ тороод байсан чин үнэн үгээ хэлчихсэн байлуга.

-Алт хуучрах тусам өнгөлөг болдгийн адилаар надад бол хатан та улам л сэтгэл татам гоо болсоор байх юм хэмээн нам дуугаар хэлээд гаднаас нум сум барин орж ирсэн Бирваа хэмээх дагуулынхаа гараас тэрхүү уужим хөвчит нум сумыг авч хоёр гардан Ануд барив.

-Юун нум билээ? Энэ чинь хэмээн Ану гэнэт сандран асуув.

-Өл бугын эврээр элгэн бие хийж, ирвэсийн шөрмөсөөр хөвч хийсэн нум сум. Үлбэгэр сул эрчүүдийг ардаа орхин цэц сорьж явдаг эрмэг дайчин хатан та бие лагшин чилээрхэхээ больж, хийморь лундаа тэнь сэргээд ирэхээр энэ нум сумаар хараалснаа алдалгүй харван сэтгэл сэргээнэ биз. Саадагт нь тасын өдөт найман сум бий. Цөм тэмдэгтэй. Торго хоргой, алт эрдэнэст умбан суудаг хатан танд үүнээс өөр юу ч өгчилгөн сэтгэлийг тэнь сэргээх билээ хэмээн гайхашран байгаад энэ нум сумыг хийлгэсэн юм хэмээснээ Данжила аягаа өвөртлөн гараад явчихаж билээ.

Гагцхүү өөрт нь гэж сэтгэл гарган хийлгэсэн тэр сайхан нум сумыг барьсаар удтал суусан Ану гэнэт сэхээ орж Данжилагийн өчсөн “Алт хуучрах тусам өнгөлөг болдгийн адил надад бол хатан та улам л сэтгэл татам гоо болсоор байх юм” гэсэн үгийг санан сэтгэл баясч, гарын толио авч зүс царайгаа удтал тольдон сууж билээ.

Галдан бошгит хаан орд өргөөгөө зүүншүүлэн нүүлгэснээс хойш нэгэн жил дорхиноо улиран одож хөхөгчин туулай жил гарлаа.

Эртнээс Зүүнгарын Галдан бошгиттой өштөн болоод буй Түшээт хан Чахундорж тэр жилийн эцсээр Алагшаа дахь хүргэн Лувсангомбо, Баатар эрх жонон Хорлоо нарт “Галданг өмнөд этгээдээс нь цохигтун” хэмээн хэлүүлжээ. Чингээд луу жилийн хавар эрт өөрийн биеэр цэрэглэн мордож, гэнэгүй байсан Засагт хан Шарын өргөөг гэнэт уулгалан дайрч амийг нь хороов. Галдан бошгит хаан тэр жил өвсний соргогыг харж, Гурван хээрээс цааш Өвгөн

толгойт хэмээх өнтэй нутагт өвөлжиж байв.

Тийнхүү нутаг алсарсны улмаас “Хоёрын эвсэл” байгуулан холбоотон болсон Засагт хан Шар эртний өшөөт Чахундоржид хороолгосныг Галдан бошгит дуулаагүй алгуурлан суух хооронд Лувсангомбо хэдийн Хөх нуураас давшин ирж хадам эцгийнхээ цэрэгтэй нийлсэн байв.

Энэ мэдээг сонсох үеэр Ану хатныхаа өргөөнд байсан Галдан бошгитын царай аадрын хар үүл мэт барайж үсрэн босов.

-Данжилаг зөвлөлдөх өргөөнд дууд! Доржжав ахад хэл дуулга. Гүнсэнгийн мянгатыг тийшээ илгээнэ хэмээн Галдан хэлээд гарч одов.

Чингээд Галдангийнхтай ойрхон өвөлжиж асан ах Доржжав тайж нь дорхиноо давхин ирж, төрийн хэрэг хэлэлцдэг их өргөөнд түшмэл жанжингууд зөвшилцсөний эцэст Засагт ханы өргөөний тийш дөрвөн зуун цэрэгтэй тандуулын хэсэг илгээхээр тогтов.

Тандуулын цөөн цэргийг Доржжав тайж, Гүнсэн ноён хоёроор ахлуулан илгээсэн хойно Галдан Ану хатны өргөөнд эргэн орж ирсэнгүй. Ахай хатан руу ч очсонгүй. Номын өргөөндөө орж олныг бясалган суумаар санагджээ.

Догшин сахиус Ямандаг тэргүүтэн олон бурханы хөрөг, шуумал тахиж, Гаанжуур, Даанжуур, Алтангэрэл Зая бандид багш таны туурвисан “Сарны гэрэл хэмээх тууж оршвой” зэрэг бурханы ном судар өрсөн байдаг тэр өргөөндөө сүүлийн үед эр нөхөр нь ганцаар бясалган суух дуртай болсныг Ану ажиж мэдсэн тул саад хийхийг бодсонгүй. Эрдэмт санваартан хувилгаан явснаа, гэнэтийн тохиолдлоор эзэн хаан болж, хараа гүйцэмгүй уудам нутгийг эрхшээн эзэгнэж, өштөн дайсан, өрөөл хань болсон нөхдөөр нэгэн зэрэг хүрээлүүлэн хувь тавилангийн хүрд хэрхэн эргэхийг ажиглан суугаа эр хүний сэтгэлд юу эс бодогдох билээ? Үнэндээ Засагт ханы тийш илгээсэн элч нарын юу өчиж ирэхээс Галдан бошгит Халхтай хэрхэх эсэхээ шийдэх байлаа.

Элэг нэгт халхын эсрэг зэвсэг барин дайрахыг ямагт эсэргүүцдэг Ану хатан ч, Түшээт хан Чахундорж гэхээр дарьтай торхонд гал авалцах мэт дүрсхийдэг Галдан бошгит ч Засагт ханы тийш илгээсэн элч нарын тухайд сэтгэлдээ мууг зөгнөөд байсан тул хоорондоо энэ тухайд төдийлөн ярилцаж төвдөхгүй байжээ.

Өвлийн дунд сар гарлаа. Эргэн тойрон нүд алдам цасан далай цэлийнэ. Зузаан цасан хучлага дор гүн нойрссон байгаль дэлхий дүлий дүмбэ оргин дүнсийж, сэтгэлд уй төрүүлэх тул Ану хатны зөвлөснөөр Галдан бошгит шадар мянгатаа дагуулан өвөр Алтай тийш чонын их авд мордлоо.

Хөглөгөр хадат их уулын суганд өвөлжиж буй Галдан хааны өргөө, олон гэрүүд их цасан дунд нойрмоглон үзэгдэнэ. Эр нөхрөө авд мордсон хойно Ану хатан нэгэн өдөр өөрийнхөө өргөөнд Ахай хатныг дуудуулан цайлав.

Ахай арван зургаатайдаа Галдан бошгитын бага хатан болж богтлогдон ирж байснаас хойш есөн жил өнгөрч, энэ жил хорин зургаа хүрч байлаа. Өнгөлөг бор царай нь идэр залуугийн

үзэсгэлэнгээр гэрэлтэн, хэрээний даль шиг хилэн хар гэзэгт нь ганц ч цагаан үс үл үзэгдэх авч Ахай хатны торомгор нүдний буланд ямагт гуниг шингээстэй, харц доогуур явна.

Хэдий нэгэн эрийн өвөр хуваалцан, их бага хатан гэгдэж яваагийн хувьд заримдаа хардах сэтгэл, атаа жөтөө асаадаг ч төрсөн ач дүүгийн хувьд Ахай хатан Ануд өрөвдөх сэтгэл төрүүлнэ. Учир нь Ахайд үнэрлэх үр заяасангүй. Анхандаа амраг нөхрөө харамласан эм хүний жөтөөч зангаар Ану, түүнд үр заяахгүй буйд нууцхан баярлах үе байсан ч өдгөө өөрийнхөө яс махны тасархай болсон ач дүүгээ ихэд өрөвдөн, гараасаа хөтлөх ганц үр ч болтугай заяагаасай хэмээн бурхан шүтээндээ залбиран суух болжээ.

Бүсгүй хүнд заяасан ганц жаргал, үрийн зулай үнэрлэхийн баяр хөөрийг амтлаагүй, түүнээсээ болоод эр нөхрийн хайрыг татах найдлага улам ч хорогдсоор буй Ахай, Ануд яг л эцгийнх нь бага хатан асан хөөрхий хотон бүсгүй Нуранг эрхгүй санагдуулдаг байлуга. Хүсээд хүсээд үр заяахгүйн хяслангаар Ахай хатан энэ өргөөний хамгийн бага хоёр охиныг эрхлүүлэн өөртөө наалдуулах хүсэлтэй байдаг ч шазруун зантай Юмчихай түүнийг өөртөө ойртуулах нь үгүй. Нэгэн удаа “Гэзгийг нь гөрж мөнгөн оосор зүүж өгье” хэмээн Ахайг дуудахад Юмчихай “Яршиг, чамаас болж миний ижий ганцаараа унтдаг. Аав чамд дургүй мэдэв үү! Би ч чамд дургүй. Чи Эмилийн ийш тонилж, төрхөмдөө очвол таарна” хэмээн уйлуулж, Ану ч эрх дураар шазруун отгон охиноо дотроо өхөөрдсөн атал, өнгөн дээрээ “Бага ижийгээ тэгдэггүйм” хэмээн зандарч билээ. Харин өр зөөлөн Бум охин л түүнийг Ахай ижий хэмээн наалинхайтан сэтгэлийг нь дэвтээнэ.

Тэр өдөр Ану хатны өргөөнд ирсэн Ахай цай уух зуур мөнөөх л үрийн хүслэн болж яваагаа хуучлан “Ойрноос хаан эзэн намайг баахан ойшоохгүй болсон байна лээ. Аргагүй биз дээ. Үр заяадаггүй хоосон өвөртэй эмээс зэнзийдэх нь зүй. Бумаас өөр намайг гэх хүн энэ өргөөнд алга даа, эгч хатан минь. Зүс минь ч гундаж байна.” гэхчлэн нулимс дуслуулан гомдоллов.

-Чиний нас залуу байна. Дөнгөж хорин тавтай. Бурхан ивээж удахгүй үртэй болно биз. Гагцхүү бурхан шүтээндээ сайн залбирч, сэтгэл зөвгэй байж, итгэл найдвараа бүү орхи хэмээн Ану хатан ачийгаа ятган өтгөн хар гэзгийг нь илж тайтгаруулахад Ахай:

-Авга эгчийнхээ сэтгэлийг сэмлэн эрийг нь хуваалцах болсны үйлийн үр нь энэ юм байлгүй дээ. Би ямар тан шиг эрдэм номтой, төрийн хэрэгт зөвлөх ухаан уужим ч биш дээ. Эм хүний заяа тавилангаар ганц ч болсон үр төрүүлсэн бол сэтгэл тэнүүн байхгүй юу. Урьд хаан эзнийг над дээр хоног дараалан ирэхэд би дотроо баярлан “Би Ану хатнаас залуу, илүү гоо үзэсгэлэнтэй болохоор л энэ биз. Хойшдоо түүн дээр дахин бүү очиж байгаасай” хэмээн боддог байсныг яана. Энэ мунхаглалын хариуд тэнгэр намайг шийтгэж буй нь юм биз хэмээн ярьж гуниглан уйлав. Энэхэн мөчид Ану хатан олон жилийн өмнө хуримын анхны шөнө Галдангаа нэг их олон элсэн манхнуудын дундуур олон салаа сэвгэр гэзэгтэй бүсгүйтэй хөтлөлцөн одов хэмээн зүүдэлж гуниглан уйлсаар сэрснээ гэнэт санаж, тэр нь нэг л үзсэн танил царайтай сэвгэр мэт барин тавин санагдаад байсан нь одоо санахад Ахай байсныг ухаарч сэтгэл ширвээдэн гайхав. Түүний зүүд зөн юуны учир ийнхүү ихэн гол нь биелээд байдаг юм бол? Тийнхүү олон жилийн өмнө үзсэн зүүднийхээ тайллыг олсон Ану ачийнхаа тас хар гэзгийг илбэн:

-Галдан хаан чамайг богтлон авсанд чиний буруу үгүй шүү дээ, дүү минь. Насаар ахмад би ч

зарим үед чамтай аль жөтөөрхөлцөж явсныг тэр гэхэв. Эм хүний ухаан богиных юм байгаа биз. Сэтгэл зөв байсан цаг дор үйлс ямагт өөдрөг байдаг хэмээн аргадаж билээ.

Галдан бошгитыг их ав хоморгод мордсоны дараахан Засагт ханы тийш мордсон хүмүүсээс хар мэдээ чих дэлдэн Ану хатны муу зөн ёсоор болов.

Доржжав тайж, Гүнсэн ноён хоёрын ахалсан баг цэрэг Засагт хан Шар хорлогдон, албат иргэд нь олзлогдсоныг мэдээд буцаж явах замдаа Түшээт ханы цэрэгт гүйцэгдэн бут цохигджээ. Чингээд Доржжав тайж, Гүнсэн ноён хоёр Түшээт ханыханд алагдсанаар ч барахгүй, Галдан бошгиттой нийлэхээр явж байсан баруун гарын Дэгдээхий мэргэн ахай ноёныг Чахундоржийн их цэрэг хөнөөн, албат иргэдийг нь талаад, ойрад нутгийн гүнд орж ирж буй мэдээ сонссон Ану хатан тэсгим өвлийн хүйтнээр чихээ хөлдтөл морины хурдаар довтолгон ирсэн цэрэг өөд үсрэн босч:

-Чих сонсч түвдэхээргүй хар мэдээ дуулгасан чиний хэл чинь тасраг! Чааваас гэж, чих чинь нь ч хөлдөөд тасрах нээ. Гомборавдан маарамбад очиж үз гээд өргөөний харуулд гарсан Балсанг дуудуулав.

-Өвөр Алтай тийш урагштайхан эрийг элч болгон довтолго! Засагт ханы зүгт илгээсэн Доржжав тайж, Гүнсэн ноён хоёрыг Чахундорж барьж хороосон байна гэж Ану ууртай өчөөд бийрнийхээ арыг хэмлэн толгой сэгсэрнэ.

Өчнөөн жилийн турш болгоомжлон түгшиж, холуур явуулагтун хэмээн бурхан шүтээндээ залбиран гуйж байсан аюул нь хаяанд ирчих гэж! Түшээт ханы энэ өөдгүй явуулга Халх, Ойрад ахан дүүсийн хооронд эгнэгт эвлэршгүй цуст дайны үрийг цацлаа.

Галдан бошгитод Түшээт ханаар далимдуулан Халх руу дайрахаас том шалтаг хэрэг ч үгүй билээ. Элбэг хаан, Батула чинсан, Эсэн тайш Тогтохбух хааны хооронд болсон элэг бөөрний тасархай халх ойрадын дайн Монголын түүхэнд цусан мөр татуулаагүй гэж үү? хэмээн бодохоос Ану хатны сэтгэл эмтэрч байлаа.

Одоо Галдан бошгитыг Халх руу их цэрэг хөдөлгөхийг хэн ч зогсоож чадахгүйг Ану хатан мэдэж байлуга. Арван зургаан жил ханилсан эр нөхрийнхөө зан аашийг Ану хатнаас өөр хэн илүү сайн үзэглэхсэн билээ дээ.

Муу мэдээ аваад ав хомрогын газраас яаран буцаж ирсэн Галдан бошгит ахынхаа хойноос харамсаж нударга зангидан хилэгнэж, “Манжийн бөгсийг долоогч Чахундоржтой би эрэгчин эмэгчинээ үзэлцэнэ! Монгол туургатны өлгий нутгийг Манжийн улан дор гишгүүлэхийг үзсэнээс үхтэл байлдаад ясаа тавьсан нь дээр” хэмээн тангараглав.

-Та нэгэнтээ чингэж шийдсэн тул их цэргээ бэлтгэж, дайны онгодоо дуудаж үз дээ. Түүхнээ эзэн Чингис хаан, Өгөдэй хаан нар Зүрчидийн Алтан улсыг мөхөөсний хойно “Манж нар нуугдаж байгаад хэзээ нэгэн цагт толгой өндийлгөхөөс сэрэмжлэгтүн” гэсэн байдаг хэмээн Ану хатан тэгэхэд өчиж билээ.

Өвлийн адаг сарын тэр нэгэн өдрөөс хойш Галдан бошгит хаан их цэргээ дайнд бэлтгэн,

Ховдоос хүнсний нөөцөө татав. Авга ах нь халхыг дайлаар мордох гэж буй сураг сонссон Цэвээнравдан хүчин өргөхөө мэдэгдсэн элч илгээжээ.

Ховдод буй хүнсний нөөц, цэргийн бэлтгэл хүчийг ач Цэвээнравдандаа даатгахаар Галдан хаан шийдэв. Ану хатны хувьд, урьд сэтгэлт сэвгэр Ахайг нь Галдан хаан богтлон авсан явдлыг цайруулах гэж чадлаараа хичээн Пунцаг далай ханы охиныг Цэвээнравданд авч өгсөн ч, залуу эрийн сэтгэл дэх өс хонзонгийн гал тийм ч ахархан хугацаанд унтарч амжсан гэдэгт төдийлөн итгэхгүй байж билээ. Гэлээ гээд саяхнаас эв найрамдлыг эрхэмлэн дөтөлж буй авга, ач хоёрын хоорондуур ховын үг гүйлгэж төвдсөнгүй. Харин Цэвээнравданг авгадаа хүчин өргөхөөр хэл өгүүлснийг сонсоод Ахай хатны нүүр хувьсхийн, цочихыг ажиглахгүй өнгөрсөнгүй.

Тийнхүү бар жилийн хаврын адаг сард Галдан бошгит хаан итгэлт жанжин Данжила, Данзан-Омбо, Дугарравдан нарын хамт гурван түмэн цэргээ хөдөлгөн Халх руу цөмрөн орохооор мордоход, Ану хатан дайны тэнгэр нь ивээсүгэй хэмээн ерөөж, ойрадын их цэргийн цувааны хойноос сүү өргөн хоцорлоо.

Галдан бошгит анх Зүүнгарын төрт улсыг төвхнүүлэхийн тулд Ойрадын их толгойлсон аймгуудыг хураахаар цэрэглэн мордож, тэр ч бүү хэл дөрвөн Ойрадын холбоог хэвээр авч үлдэх, өөрөө чуулганы хан суудалдаа үлдэх өчүүхэн эрх ашгийн төлөө Галдангийн эсрэг зогсч асан хайрт эцгийг нь дайлахаар явахад ч Ану хатан чингэж сэтгэл чилүүрдэн уймарч байсан удаа үгүй ажээ. Монгол туургатан ийнхүү өөр хоорондоо цус асгаруулан тулалдсанаар, эв нэгдэлгүй, үхрийн эвэр мэт байсны уршгаар л харийн дайсны өгөөш болдог шүү дээ. Санаагаар болдог бол Түшээт хан Чахундорж, Галдан бошгит хаан хоёр урьд өмнөх өс хонзонгоо огоот умартаад хамтдаа цэргийн хүчээ нэгтгэн Энх-Амгаланг бут цохих юм бол Монгол туургатан тусгаар төр газар шороогоо эгнэгт сахин хамгаалах сан билээ. Гэтэл өдгөө үйл явдал хэрхэн яагаад тийнхүү эсрэгээр өрнөж, атаат дайсныхаа эсрэг мөр зэрэгцэн тулалдах ёстой монгол эрс өөд өөдөөсөө сэлмийн ир зөрүүлэн, эвэр нум татахаар мордож буй юм бэ?

Ойрадын баатарлаг цэргүүд дайн тулааны туршлага зузаан, цөс ихтэйн учир эхлээд Галдан бошгит Түшээт ханыг хялбархан ялах нь магад. Харин дараа нь? Үүгээр далимдуулан Халхыг Ойрадаас хамгаалах нэрээр манжууд түрхрэн орж ирэхдээ, өвөрлөгчидтэй хавсран, дээрээс нь халхын цэргийг дайчлан Ойрадыг нам дарж, эцэст нь монголыг монголоор нь хядуулаад Манж өөрөө эзэн суух биш үү?

Үүнд л Ану хатны сэтгэл хамгийн их түгшин, дэмий л Халхаас ирэх хэл чимээг чагнан суулаа.

Галдан бошгитын цэрэг эзэнгүйрэн хоосорсон Засагт ханы нутгаар дамжин Халх руу цөмрөн орж, хотгойдын Гэндэн дайчин, Гүнчин тайж нарын цэргийг цохиод, Түшээт ханы нутаг руу оржээ. Хан эзэн нь алагдаж, газар сайгүй дээрэм тонуул, үймээн бужигнаан болсон Засагт ханы нутгаар онцын эсэргүүцэлгүй нэвтэрсэн ойрадын цэргийг их монголын голомт Түшээт хан аймаг алга дэлгэн угтсангүй, ширүүн эсэргүүцэн тэмцсэн нь Ану хатны аюун болгоомжилж байснаар элэг нэгт монголчуудыг цусан далай болтол хядалцахад хүргэсэн ажгу.



Түшээт ханы хөвүүн Галдандорж нэг түмэн цэрэг авч Төмөрт хэмээх газар Галдан бошгитыг тосон байлдаж, есөн мянган хүнээ алдаж Онгийн голын зүг зулбан одсон тухай мэдээ авсан Ану хатан шүтээний өргөөндөө орж, мянган зул асаан ойрад, халх олон монгол цэргийн сүнсийг даатган ном хуруулав.

Харин Түшээт ханы хөвүүн Галдандоржийн цэргийг хиар цохисон Галдан бошгит их цэргээ хоёр хуваан Данзан-Омбод захируулсан хэсгийг Эрдэнэ зуугийн зүг давшуулав. Данзан-Омбын цэргээс зугтсан Өндөр гэгээн Занабазар ахынхаа гэргий хүүхэд, шадар шавь нараа дагуулан Их говийн өмнөд этгээд рүү алга болж өгчээ.

Харин Түшээт хан Чахундорж Манжийн Энх-Амгалан хаанаас цэргийн тусламж гуйгаад эс бүтсэн тул намрын тэргүүн сард Олгой нуурын хөвөөнд цус асгаруулсан тулалдаан хийсэн ч ойрадын цэрэгт хиар цохигдож, өөрөө Сөнидийн зүг буруулан одож, дүү Өндөр гэгээнтэйгээ нийлэв.

Халх дахь дайн тулааны газраас ирэх чимээг чих талбин хүлээж, сэтгэл дэнслэн суусан Ану хатанд эр нөхрийнх нь ялгуусан ялалтын дуулиан баяр хөөрөөс илүү айдас түгшүүр төрүүлж байлаа. Элэг нэгт монгол ахан дүүсийн цус асгаруулсан тулаанд ялагч үгүй хэмээх гашуун үнэн л хатны сэтгэлийг тийнхүү дэнслүүлж байсан аж. Түшээт хан, Өндөр гэгээн хоёрын эх Ханджамц өөрийнх нь ижий Доржравдан, хадам эх Юм-Агастай бүгд ясан төрлийн эгч дүүс. Мөн Түшээт хан өөрийнх нь ах Гартангомботой худ ургийн холбоотой гээд бодоод байхад аль ч талаас нь үзсэн Галдан бошгит, Чахундорж хан хоёрын хооронд болж буй цус асгаруулсан энэ дайн Монголын түүхэнд эмгэнэлт нэгэн хуудас болон үлдэнэ шүү дээ.

Галдан бошгитод хиар цохигдон өвөрлөгчдийн нутагт зугтан одсон Түшээт хан Энх-Амгалан хаанаас дахин цэргийн тусламж гуйгаад “Түшээт хан хэдийнээ манай улсад дагаж, дөчин есөн өвөрлөгч хошуудын нэгэн адил байсан ахул Галдан аймшиггүйгээр халдан довтлохгүй байсан. Хэрэв халдах аваас бидний Чин улс дув дуугүй эс суух билээ...” хэмээсэн хариу авчээ.

Тийнхүү нэг талаас ойрадын Галдан бошгит хаанд ялагдан хүчин мөхөсдсөн, нөгөө талаас Энх-Амгалан хаан хавчигдсан халхын гурван хан, нөлөө ихтэй ноёд Сөнид аймгийн Ар элстэйн газар чуулж, Манж Чин улсад даган орох бодрол бичиг үйлдсэнээр, монгол туургатны голомт нутаг манжид эзлэгдэв.

## Арванесдүгээр бүлэг

Халхад Галдан бошгитын дайлаар явах зуурт Ховд дахь цэрэг, хүнсний нөөцийг захирч асан Цэвээнравдангийн сэтгэл хувирчээ. “Урьд авга Галдан таны авах гэж сүйлсэн сэвгэрийг булаан авч дээрэлхэн, эцгээс хойш гурван хүү нь байсаар атал цоросыг ганцаар эрхшээн захирч буйн учир юу вэ? Та хэрэв зоригловол бид алдсан бүхнээ булаан эзэлж, ах таныг Зүүнгарын хаан сууринд суулгахад хүчин зүтгэмүй” хэмээн Сэнгэ агсны хоёрдугаар хүү Сономравдан ахаа ятгасаар Ховдын газрыг эзлэн цэрэг, хүнсний нөөцийг талж одоход түлхсэн амуй.

Аргын 1689 оны хавар, шарагчин могой жилийн эхээр халхын нутагт Түшээт ханыг мөхөөгөөд эргэн ирж явсан Галдан бошгитод Ану хатнаас “Ач Цэвээнравдан тань санаа буруулан Ховд дахь нөөц зөөрийг эзлэв” гэсэн хэл авч яаравчлан довтолгосоор түмэн бээрийг туулан хаа холын өвөрлөгчдийн тэндээс Зүүнгарын нутагт тэмцэн иржүхүй. Галдан бошгитын айсууг дуулсан Цэвээнравдан итгэлтэй хүмүүсээ шөнөдүүлэн явуулж Ану хатны суугаа Эрчис мөрний тэндэх өргөөнөөс Ахай хатныг орлуулан авч явжээ.

“Халхыг дайлах гэж буйг дуулаад Цэвээнравдан ач минь надад хүчин өргөхөө илэрхийлэв” хэмээн намрын тэр нэгэн өдөр Галдан бошгитыг өгүүлэхэд Ахай хатны царай хэлмэгдэн цочиж, хувьсхийж байсны учир тэр байж.

Галдан бошгит зам зууртаа Ховдын зүг буухиа элч довтолгон урвалгын үрийг тарьсан Сономравданг сэм хорлон алах тушаал буулгажээ.

Дүүгээ Галдангийнханд алуулсныг мэдмэгц Цэвээнравдан хатад хүүхдээ авч, албат иргэдийн хамт Ховдод байсан шилдэг таван мянган цэргийг дагуулан Хар Азаргын шил дэгүүр даван Улаан ус хэмээх газарт одов.

Нэгэнт ар талаа итгэн даалгасан ач нь хүнсний нөөц, шилдэг цэргийг нь хулуун авч, хатныг нь булааж зугтан одсон тул Галдан бошгит орд өргөөгөө Ховдод нүүлгэн аваачиж, тариалан, төмрийн дарх хөгжүүлэн суухаар шийдсэнийг Ану хатан нь ихэд дэмжсэн ажгу. Учир нь халхад хийсэн дайнд хэдий ялсан авч, хурааж нөөсөн зэр зэвсэг, хүнсний нөөцөө барж, сан хөмрөг нилээд дундарсан байлаа. Холын нүүдэл суудал, аян дайны хөлд үлэмж их эд баялаг зарлагадан, үрэгдэж алга болсон тул Ховог сайрт ид хүчирхэгжин, Бухар, Самарканд, дорнод Түрэгийг эзлэн хэдэн зуун тэмээн ачаа алт эрдэнэс, эд бараа олзлон авчирч асан үеийн тансаг амьдрал улиран одсон байлуга.

Агт морьд цуцан, аян дайн, нүүдлийн хөлд мал хөрөнгө маш их үрэгдсэн тул Галдан бошгит тийнхүү аж ахуйн хэргээр оролдон тэнхэрч байж, Манжтай тулалдах хүчээ нөөхийг чухалд үзсэн аж. Тэр зуур “Халхын долоон хошуу хэнд захирагдах нь хамаагүй. Гагцхүү Богд хаан та Түшээт хан Чахундорж, түүний дүү Өндөр гэгээн нарыг надад найр тавин өгөх аваас хамаг хэрэг гүйцэх нь тэр” хэмээн Энх-Амгалан хаанаас удаа дараа шаардсан ч хариу эс өгөв. Тиймд “Өндөр гэгээнийг Далай ламын дэргэд хүргэхийг нэхэмжилж буйг шийдвэрлэнэ үү” гэсэн илүү аядуу шаардлага ч тавьж үзэв. Галдан бошгит хааныг ямагт дэмжих далимд Зүүнгарыг цэргийн тулгуур хүчин хэмээн үздэг Дэрсид Санжаажамц ч Энх-Амгалан хаанд Шагнадорж ламыг элч болгон зарж, Галдан бошгитын шаардсанаар Халхын Өндөр гэгээнийг

Төвдөд ирүүлэхийг гуйгаад нэмэр болсонгүй.

Аргын 1689 оны намар Ховдод суугаа Галдан бошгитын өргөөнд Энх-Амгалан хааны элч тэргүүн сайд Арнай, сул сайд Убаш, Тэргүүн дэсийн хиа Ананд нар хүрэлцэн ирж Чин гүрний эзэн хааны захидлыг гардуулав.

Галдан хаан найман ханатай хар булган чимэглэлтэй аяны өргөөндөө манж чин улсын элчдийг хүлээн авч, бяруун чинээ тарган иргийн махыг арьстай нь хуйхлан хүндэтгэлийн идээ шүүс зум бэлтгэн дайлсан ч “Энх-Амгалан хаан миний хүсэлтийг ёсчлон биелүүлж Түшээт ханыг дүү Өндөр гэгээний хамт буцаан өгөөгүй цагт ямар ч яриа хэлэлцээ бидний хооронд байх нөхцөл үгүй” хэмээсэн хариу өгөв.

Манжийн элч нарыг хүлээн авахад Галдан хааны дэргэдэх хатны сэнтийдээ сууж байсан Ану хатан байдлыг ажиглах зуур тэртээ нохой жилийн намар Ховог сайрын ордонд Энх-Амгалан хаанаас Галдан бошгитын “Хаан” цолыг хүлээн зөвшөөнөө илтгэх жуухыг авчирсан Дотоодын сайд Сэдэд нартай уулзаж байсан тэр цаг үе эргэлтгүй улиран одсоныг гашуунаар ухааран өөрийнх нь болон эр нөхөр, үр хүүхдийнх нь хойшдын тавилан юу болж дуусах бол? гэхээс сэтгэлдээ нэг л эмээн ширвээдэж суувай. Манж чин гүрний эзэн хааны илгээсэн элч нарыг буцсаны дараахан Ховд дахь Галдан бошгитын өргөөнд дараагийн элч нар довтолгон ирцгээв.

Цастын орноос Дэрсид Санжаажамц Ялгуусан хутагтыг Жирун хутагтын хамт илгээн “Үтэр түргэн Халхын нутаг руу одож, Манжийн суганд шургалсан Чахундорж, Өндөр гэгээн нарыг эргүүлэн авчрах нь зүй. Тиймийн тулд Манжийн хойд хилээр буюу өвөрлөгч хошууд, Хөх нуурын зүгт их цэрэг хөдөлгөн очиж дарамт үзүүлэгтүн” гэсэн захиас байлаа. Далай ламын тааллаар л хөдөлсөөр ирсэн Галдан хаанд цастын орноос ийм болчимгүй заавар ирсэнд Ану хатан туйлын ихээр шаналан зовсон ч хориг саад хийж түвдсэнгүй.

Халхад өдүүлсэн дайны “шарх” бүрэн аниагүй, агт морьд тэнхрээгүй, хүнсний нөөц хоёр түмэн цэргийг тэжээж хүчрэхээргүй буйд тийнхүү Ану хатан сэтгэл зовж байгааг Галдан бошгит гадарлаж байсан ч алгуурлахыг бодсонгүй. Галдан хаан:

-Цоросын эзэн сахиус, догшин Жамсран, Ямандаг бурхан, Цамбагарав хайрхан минь намайг эрхбиш ивээх буй за. Ану, чи шүтээндээ залбиран суу хэмээснээс өөр үг өчил сонсохыг үл хүсэн Халхын зүгт цэрэглэн мордов. Ану хатан:

-Эр хүн зорьсондоо гэдэг. Санаж зорьсон хэрэг тэнь сэтгэлчлэн бүтэх болтугай. Аминчлан захих ганц л юм надад байна. Та минь амьд мэнд л эргэн ирээрэй хэмээгээд нулимсаа хатамжлан хоцроход нь арван хоёртой эрх хонгор Юмчихай гүнж л “Аав аа! Намайг аваад яваач. Би ижийтэй хоцрохгүй. Би нум сумаар харваж чадна шүү дээ” хэмээн хашгирч их цэргийг даган гүйсээр хоцорч билээ.

Галдан бошгит ар тал, хатан, үр хүүхдээ итгэлт ач Данзан-Омбодоо захин үлдээгээд хоёр түмэн цэргээ хоёр жигүүр болгон хувааж, нэгийг өөрөө, нөгөөг Дугар Равдан жанжнаар захируулжээ. Могой жилийн хуучдаар тийнхүү халхын газар дайлаар одсон Галдан бошгит цагаан морин жилийн шинэдээр Сэлэнгийн дээд урсгалаар нутаглаж асан Гэндэн Дайчин, Цэвээн Эрдэнэ ахаа, Сартуулын Цэцэн хунтайж, Манзшир хутагт нарыг довтлон хураагаад

зуны тэргүүн сард Дугар Равдангийн цэрэгтэй нийлсэн мэдээг Ану хатан хүлээн авч нэг хэсэгтээ сэтгэл амирлав. Монгол нутгийн алс баруун Ховдын хязгаараас могой жилд гарсан Галдан бошгитын их цэрэг түмэн бээрийн газрыг туулан Үзэмчин аймгийн зүүн захаар явсаар Соёлз хэмээх уулын зүүн эрэгт хороолон буув. Харин Энх-Амгалан хаан Зүүнгарын их цэргийн өмнөөс Цэцэн хан аймгийн засаг тайж Намжил, Түшээт ханы хүү, урьд нэг удаа ойрадад бут цохигдсон Галдандорж, засаг жүн ван Гүршир, сайн ноён Шамба нарын халх ноёдын цэргийг, Арнай сайдын захирсан өвөрлөгчдийн сөнид, авга найман хошууны цэрэгтэй хүчин хавсруулан хөдөлгөсөн нь монголыг монголтой нь алалдуулах гэсэн түүний өөдгүй далд муу бодлого байлаа.

Ховдын газар хоцорсон Ану хатан энэ тухай дуулж мэдээд урьд өөрийнх нь таамаглаж байснаар Галдан бошгитын өмнөөс халх, өвөрлөгч ноёд манжтай хүчин хавсран тулж буйд туйлын ихээр сэтгэл чилээн түгшүүрлэв. Урьд Галдангийн өөдөөс гагц манжийн Энх-Амгалан хаан ганцаар зогсч асан бол өнөөдөр өвөрлөгч дөчин есөн хошуу, халхын их цэрэг түүнтэй нэгдэн ганц Зүүнгарын өөдөөс эсрэгцэн дайсагнах цаг ирэв.

Эр нөхрөө их цэргийн хамт Халхаар дамжин өвөрлөгчдийн тийш мордсон цагаас хойш Ховдод үлдсэн Ану хатан ганц ч шөнө бүтэн нойртой хоносон удаа үгүй.

Дайны газраас ирэх мэдээ чимээг сэтгэл түгшүүрлэн хүлээсээр нэгэн он улирч, цагаан морин жил гарав. Тэр жилийн зуны тэргүүн сард тэнгэр ивгээж Галдан бошгитын цэрэг Улахуй голын орчим Арнай сайдын удирдсан манж, халх, өвөрлөгчдийн цэргийг бут цохисон мэдээ Ховдод дуулдан Ану хатан хөгшин хөвөө, өвчтэй ядуус, хүүхдүүдэд их хишиг тараан баяраа хуваалцав.

Санаагаар болдог сон бол Галдан хааныг Улахуй голоос цэргээ татан яаралтай Ховдод ирүүлмээр байлаа. Гэсэн ч Бошгит хаан буухиа элч илгээн хатандаа дуулгаснаар “Түшээт хан, Өндөр гэгээн хоёрыг гарган өгөхийг Манж чин улсын Энх-Амгалан хаанаас шахамдуулан шаардсаар байна. Энэхүү хэрэгт Далай багшийн үг зааврыг харзсан сууна” хэмээн хэлүүлсэн нь Ану хатны урмыг хугалав.

Энх-Амгалан хаан Галдан бошгитод ялагдлаа гэж гар хумхин суухгүй нь гэрэлтэй өдөр мэт илт зүйл атал байдлыг тунгаан бодож өөрийн ухаанаар шийдэхийн оронд урьдын адил цастын орны зааврыг хүлээн авч буруудах вий хэмээн хатны сэтгэл төвдөнгүй буйгаа Данзан-Омботой хэлэлцэн сураг чимээ чагнан суух зуур нөхөртөө буухиа элч илгээн “Нэгэнт хаан та манжийн цэргийг Улахуйн голд бут цохисон тул Ховдын газарт өргөөндөө хүрэлцэн ирж, цэрэг, морьдоо амраан хүчийг сэлбэсэн нь зөв амуй” хэмээн хэлүүлсэн аж.

Тийнхүү Галдан хааныг Улахуйн голын орчмоор цэргээ хуарагнуулаад урьдын адил Түшээт ханыг гарган өгөхийг шаардан суухын хооронд залыт Энх-Амгалан хаан хоёрдугаар ах хошой чин ван Чан Яньд “Умард дахиныг амаржуулагч их жанжин” цол шагнан, таван түмэн цэрэг захируулан Бээжингээс үдэхдээ хотлыг шагшуулсан нүсэр их ёслол үйлдэн мордуулжээ. Чингээд “Улаан буданд Халх, Өвөрлөгч ноёдын чуулган хийж, Галдан бошгит хаанд Түшээт хан Чахундорж, Өндөр гэгээн нарын бурууг хүлээлгэн эвлэрүүлнэ” гэсэн худал цуу тараан, ойрадын цэргийг гэнэдүүлэн цохих ов мэх зохиосон ажгу.

Энэ нь манжийн заль мэх гэдгийг Галдан бошгит таамаглан мэдээд, шадар ноёд, жанжингуудаа хээрийн цацартаа цуглуулан “Улаан будангийн газар манжийн их цэрэгтэй тулалдах уу, гэдрэг буцах уу? “хэмээн хэлэлцэв.

Данжила, Дугар Равдан нарын итгэлт жанжин сайдууд нь холын замд цэрэг, агт морьд ихээхэн сульдсан тул умар зүг буцацгаая хэмээн нэгэн дуугаар өчицгөөснийг Бошигт хаан хаан сонсч “Ану ч намайг цэргээ эргүүлэн Ховдын газар ирж хүчээ нөөцлөн суух нь зүй” хэмээж буй тул умар зүгт хөдөлбө хэмээн бодож байтал тотгор гарч ирэн Улаан будангийн тийш хөдлөхөөс аргагүйд хүргэжээ. Учир юун гэвээс цастын орны элч Жирун хутагт, Ялгуусан хутагт нар ирж, “Далай багштан Таныг Улаан буданд очин Манжтай хэлэлцээр хийхийг соёрхов” хэмээжээ. Цаг ямагт Далай ламын үг соёрхлыг дагадаг Галдан бошгит тийнхүү бодлоо өөрчлөн Улаан буданд очсоноор Зүүнгар улсын хувь заяаг хутганы ирэн дээр аваачсанаа хожим мэдэж амаа барьсан ажгу.

Манжийн таван түмэн цэргийн өөдөөс тулалдсан ойрадын хоёр түмэн цэрэг, газрын бартаа өндөрлөгийг түрүүлэн эзэлсэн, ачлагад хэрэглэсэн хэдэн зуун тэмээгээ холбон хэвтүүлж, нойтон эсгийгээр хучин тэмээн хаалт ашигласан нь тус болж хэдэн өдөр зууралдан тулалдсаны эцэст Галдан бошгит хаан Манжийн цэргийн олон давхар бүслэлтэнд орж гарах гарцгүй болсноо ухаарав.

Галдан бошигт тийнхүү нэгэнт бүслэгдсэнээ мэдмэгц энэ занганаас эсэн мэнд мултрах арга сүвэгчлэв. Түүнийг Халхын зүгт дайлаар одоход нь Ану “Аминчлан захих ганц л юм надад байна. Та минь амьд мэнд л эргэн ирээрэй” хэмээн захиж, Юмчихай охин нь их цэрэг, ачаа хөсөг даган гүйж “Аав аа!Намайг аваад яваач...” хэмээн хашгирч асан тэр өрөвдөм дүрийг мартаж эс чадах агаад “Заавал Манжийн цэргийн бүслэлтнээс гарч, гэргий хүүхэддээ бараагаа харуулах юм хуна” хэмээн шүд зууж байлуга.

Оройгоороо хавтгай, бэлээрээ их модтой, хадтай энэ ууланд манж, өвөрлөгч, халхын хамтарсан таван түм илүү цэрэгтэй гурван хоног эрэлхэгээр тулалдсан ойрадын цэрэг нэг түм илүү хүнээ алдсан хойно, Галдан бошгит арга эвээр мултрах арга сүвэгчлэн Жирун хутагтыг “Төр шашны тулд хэлэлцээр хиймой” гэсэн үгтэйгээр Чин улсын цэргийн их хүрээ өөд илгээх нь зөв гэсэн арга олжээ. Чингээд “Ану хатныхаа тэр цоглог жижигхэн нүдийг дахин нэг харж, Юмчихай охиныхоо духыг үнэрлэвэл болох нь тэр. Хэрэвзээ Ану дэргэд минь байсан бол Далай ламын зөвлөснөөр ийнхүү Улаан буданд давуу хүчтэй Манжийн цэрэгтэй тулалдахыг дэмжихгүй байсан даа.” хэмээн Галдан бошгит бодолхийлсээр Жирун хутагт манжийн жанжин Элбэг чин ван, ханхүү Юнь Ти, Хооби, Арнай сайд нараас ямар хариу авч ирэхийг сэтгэл дэнслэн хүлээвэй.

Төдөлгүй манжийн цэргийн эрхтэнүүд Галданд хариу элч зарж, Чин улсын Богд эзэн хаанд тэрсэлсэн бүх буруугаа хүлээн түүнийгээ баталсан бодрол бичиг үйлдэх, Манж Чин улсад дагаар орохоо тангараглах, Улаан будангаас дураараа одохгүй байх шаардлага хүргүүлжээ.

“Эндээс эсэн мэнд л мултарч байвал чөтгөрт тангараг тавьсан ч яахав” хэмээн шийдсэн Галдан хаан шаардлагыг хүлээн авснаа элчээр дамжуулжээ. Чингээд Галдан бошгит цэргийн хүрээндээ Арнай сайдыг хүлээн авч, магнай дээрээ бурхан шүтээнээ өргөж байгаад, тангараг очин үзүүлээд агт морьд, атан тэмээндээ соргог бэлчээр, устай газар нутаг сэлгэн бууж Богд

эзний зарлигийг хүлээхийг хүсэв. Чингэхдээ дотроо бурхангүй хоосон гуу өргөж тангарагласан ажгуу.

Ойрадын хаан нэгэнт бурхан шүтээнээ барин ам тангаргаа өгсөнд итгэсэн Арнай сайд тэргүүтнийг буцмагц Галдан хаан яаравчлан цэргээ хөдөлгөж манжийн бүслэлтийн нүх сүвийг олж, хойд зүгийг барин одохдоо Ану хатныхаа “Та минь амьд мэнд л эргэн ирээрэй...” гэсэн үгийг санан санан өдөр шөнөгүй довтолгосоор Халхын нутагт орж иржээ.

Намрын дунд сар гарч байхад Ану хатан сая нөхрийнхөө илгээсэн элчийн амнаас Галдан бошгит өмнөд газар Улаан будан хэмээгч ууланд Энх-Амгалан хааны илгээсэн таван түмэн цэрэгтэй тулалдан хагас цэргээ алдан байж, Халхын нутагт Онон мөрний хөвөөнд ирж, “Ховдоос наашаа нүүн ирж өвөлжигтүн” гэсэн хэл өгүүлснийг дуулж, яаран их нүүдэлд бэлтгэв.

Монгол нутгийн алс баруун хязгаараас Онон мөрнийг хүртэлх нүүдлийн урт зам хялбаргүй байлаа. Намрын дунд сар гарч, өглөөд хангай дэлхий мөнгөн хяруунд хучигдан, газар эх алтан шар нөмрөгөө нөмрөх цагаар өмнийг зорин ганганах нүүдлийн шувуудтай зэрэгцэн Халхын төв нутаг руу нүүдэллэж яваа Ану хатны сэтгэлд түмэн бодол эргэлдэнэ.

Ховдоос намрын дунд сарын эхээр гарсан Галдан хааны өргөөний нүүдэл ачаатай тэмээний дэнхэн донхон алхааны аясаар сар гаруй явсаар анхны цаснаар хоосорч эзгүйрсэн Түшээт хан аймгийн нутагт орж ирлээ.

Луу жилийн Галдан бошгитын дайралтаар эвдэрч сүйдсэн сүм хийд, эзэнгүй орхигдсон өвөлжөө бууц үргэлжлэн, цасан буданд дунд зүүрмэглэсэн Булган хангай гашуудан дүнсийх мэт...

Түшээт хан аймгийн нутаг Өрмийн голд ирэв хэмээн Данзан-Омбыг өчихөд л Ану хатан ангир уургаа хөхүүлж хүн болгосон хайрт өрлөг эхээ санав.

“Даадаагийн минь төрсөн нутаг. Өрлөг ижий минь, та уул, ус хосолсон бурханы орон болбуу гэмээр энэ сайхан хангайгаа орхин өдөр шөнөгүй элсээр шуурсан, Алшаагийн улаан говьд бэрлэн очоод нутгаа хэчнээн их санадаг байсан бол?”

Нэг удаа зургаан насай Ануг “Даадаа та халх нутгаа санаад байгаа юм уу даа?” хэмээн асуухад нь:

-Төрсөн нутгаа санахгүй хүн гэж байдаггүй юм. Гэхдээ нутгаа орхин алсад бэрлэдэг нь бүсгүй хүний заяа тавилан юм даа гэснээ духан дээр нь үнэрлээд босч билээ. Тэгэхэд нь гэнэн хонгор Ану:

-Үгүй. Би л лав хошууд аймгаа, Алшаа нутгаа орхихгүй.Ижий, аав, Даадаа таныг санана гээд шинэ дээлээ найзууддаа үзүүлэхээр гүйн одсон сон.

“Аа, тийм, Даадаа надад хэл ам, гай барцдаас сэргийлэн халх заншлаар буруу энгэртэй дээл хийж өгөөд мялааснаас үүдэн тэр яриа гарсан юм байж шүү дээ.” гэж бодоод Ану хатан

хөсгийн түрүүнд явсан Балсанг дуудуулав.

-Жаа, хатантаан...

-Балсан минь. Даадаагийн минь төрсөн нутгаар явж байна. Чамд төрсөн бууцнаасаа авч гарсан чулуугаа нутагтаа эгүүлэн тавиарай гэж гэрээслээд өгчилгөсөн байх аа?

-Нээрэн тийм. Тэрүүнийг нь самбайнд боогоод түрийндээ хадгалж явдаг юм. Энд орхиё доо хэмээгээд Балсан мориноосоо бууж түнтгэнэн хоцров.

Бага хүүхэд бодох санах юмгүй хэчнээн сайхан байдаг юм бэ? Би тэгэхэд хошууд аймгаа, Алшаа нутгаа орхихгүй хэмээн Даадаад хэлээд гүйн одсон сон. Өнөөдөр тэгэхэд Зүүнгарын сайхан нутгаа энэ төрөлдөө үзэх үү, үгүй юү гэдгээ мэдэхгүй л хүний эзгүйрсэн нутаг дундуур тэнүүчлэн нүүж явна шүү дээ хэмээн бодоход дэндүү гунигтай байлаа.

Ихэнх мал хунар, гэр өргөөгөө Ховдод орхиод яаран сандран хөдөлсөн хөсөг, намрын адаг сарын хуучдаар сая Онон мөрний дээд урсгалд цэргийн хамт шивээлэн буусан Галдан бошгиттой нийлэн тэндээ зутруухан өвөлжив.

Онон мөрний хөндийн хацар хайрам хүйтэн жаварт хоол хүнс муутай олон айлаар халуун томуу дэгдэж, Улахуй гол, Улаан буданд эрэлхэгээр байлдсан баатар эрс дайн тулаанаас дутахгүй өлсгөлөн, өвчнөөр нилээд хиарав.

Анх Ануг бэр буулган авч ирэхдээ барьж өгсөн цагаан булган чимэглэлтэй сайхан өргөөг Ховдод орхисон тул Галдан бошгит, Ану хатан гурван хүүхэд, зарц шивэгчинтэйгээ хамт зургаан ханатай гэрт чихэлдэн сууж байлаа. Хоол хүнс ч нэн хомс тарчиг байв.

Орой бүхэн адууны хатсан махаар хийсэн шөлөнд хар гурил бантагнасан бааздуухан хоолны үнэр гэр дүүрэн түгж, аргагүйн эрхэнд тэр заваан хоолыг хатан, гурван хүүхдийн хамт идэж суухдаа Галдан бошгит хатнаа өрөвдөн “Жаргал зовлонгийн алинд ч дэргэд минь байж, хоосорсон халхын нутгаар намайг хэмээн тэмцэж ирсэн Анугаа ингэж зутраах гэж. Мэдээ орсон цагаасаа газар газрын амтганд умбаж өссөн хайртай охиноо ингэж явааг Очирт цэцэн хан тэнгэрийн орноос үздэг бол надад хилэгнэж буй болов уу?” хэмээн гэмшил дүүрэн бодож, эр хүнд доройтох өдөр байхад мандан бадрах цаг ирэх биз ээ хэмээн билэг ерөөл бодон өөрийгөө хурцалж байлаа.

Тийнхүү Онон мөрний газар хүнд хэцүү өвлийг чүү гэж барсан Галдан бошгит хаврын адаг сард агт морь, цөөн хэдэн аган тэмээгээ шинэ ногоонд бага зэрэг тэвээрмэгц Завхан, Хүнгүй голоор дайран Ховдыг тэмцэв. Халхыг эзлэн Манжийн эсрэг тэмцэх бодолтойгоор их цэрэг хөдөлгөөд өөрөө тийнхүү мөхлийн замдаа орсон Галдан бошгитыг Ховдын хязгаар руу замд гарч байх үеэр Долоннуурт нэгэн сүржин ёслол болов. Тэр нь ов ихт Энх-Амгалан хаан Халхыг Манж чин улсад дагаар оруулсны ёслолын чуулган үйлдэхээр болж Түшээт хан Чахундорж, Өндөр гэгээн Занабазар, Цэцэн хан Өмхэй, Засагт ханы төрлийн ноёдын зэрэг таван зуу илүү ноёд, тайж нарыг цуглуулаад өөрийн биеэр хүрэлцэн очжээ. Ийнхүү Долоннуурын чуулганаар Халх Монгол Манжийн өлмийд эгнэгт сөгдөв.

Аргын 1691 он, цагаагчин хонин жилийн зуны дунд сар. Галдан бошгитын их цэргийн үлдэгдэл, өргөө гэрийн нүүдэл Ховдод хүрлээ.

Галдан бошгит Ховдод ирсэн хойноо Хөх нуур дахь түнш Баатар эрх жонон хорлоогоос Долоннуурын чуулганы тухай нарийн ширийнийг дуулж мэдээд аягтай цайгаа шидэх шахам тавьж баруун нударгаа зуун “Халх, Ойрадын цус асгаруулсан дайны буруутан, урвагч Чахундорж Манжийн шар луут тугийн дор сөгдөн, монголчуудын заналт дайсан Энх-Амгалан хааны шар торгон асарт мөргөж байгаад зарлигийг нь хүлээн авсан байна! Тэр алтан ургийн удам гэсэн хийрхэлээ умартаад манай ойрадын цэрэгтэй эвсэн Манжийг дайлсан бол өнөөдөр Энх-Амгалан өөрөө монголчууд бидний өмнө сөгдөх байсан юм!” хэмээн хашгирахад Ану хатан шатрын хөлөг дээрх шалдан ноён мэт болсон амраг нөхрийнхөө цөхрөлийн үгийн гашууныг зүрхэндээ мэдрэн “Монгол туургатны дотоодын хагарал ямагт ялагдалд хүргэсээр ирсэн...” хэмээн үргэлж ярьдаг асан Дүүрэн мэргэн багшийнхаа үгийг санах.

Хэдий элэг нэгт монголчуудын цус урсгахыг эсэргүүцэж байсан ч эр нөхрөө “Дэмий л Түшээт ханы нутгийг дайлав, Халх руу хэрэггүй л цэрэглэн хөдлөв” хэмээн зэмлэсэн үг ганцыг ч амнаасаа унагаж байгаагүйдээ Ану тэр мөчид баярлаж суулаа.

“Өөрийн бодол өөртөө зөв, өрөөл даавуу өмдөндөө зөв” гэдэг сэн. Нэгэн үе Зүүнгарын хүчирхэг хаант улсын төрийг түвшитгэн Хасаг, Буруд, Дорнод Түрэгстаныг эрхшээж, Самарканд, Бухар, Яркенд, Кашгар, Сайрам, Турфан, Хами зэрэг мянга илүү хот балгадыг эрхэндээ оруулж явсан эр зориг, эрдэм ухаан төгөлдөр эр нөхөр нь монгол туургатны халуун голомт Халхыг Манж чин улсад идэгдэх вий гэсэндээ тийнхүү дайн өдөөсөн.

Зулзаган хус шиг сэвгэр явахдаа энэ хүнтэй ураг холбон шар наранд мөргөж, шагайт чөмөг атгалцсан тул үхсэн ч сэхсэн ч хамтдаа энэ амьдралыг туулах ёстойгоо улам гүнзгий ухаарч дэргэд нь очин энгэрийг нь түшлээ.

Ану хатан цоросын бэр болон ирж байснаас хойш даруй хорин жил өнгөрч нас гучин найм хүрчээ. Нэгэнтээ ижийгийнх нь хэлж байснаар гучин наснаас хойш цаг хугацаа унтаад сэрэх мэт хурдан цахилан одож буйг тэр нэгэн өглөө толины өмнө суун Мандарваагаар үс гэзгээ самнуулж байхдаа ухаарав. Санчигт нь хаа нэг цагаан үс үзэгдэх авч, алтлаг хүрэн гэзэг нь нилээд шингэрснээс бус тэгтлээ бууралтсангүй.

-Самнах бүрд таны үс шингэрээд байх юм. Залуу цагтаа атганд багтамгүй өтгөн байсан сан хэмээн Мандарвааг ярихад “Орост одсон элч явсаар хоёр сар гаруй боллоо. Хэл сураг үгүй чингэтэл саатах нь яавч сайны ёр биш дэг. Хэрхэн нөхрийнхөө сэтгэл санааг өчүүхэн ч болов сэргээх билээ? Зуны эхэн сард Цамбагарав хайрханаа тахихад хийморь лундаа нь эрхбиш сэргэх болов уу? гэхчлэн хүнд бодолд дарагдан суусан Ану хатан шивэгчнийхээ үгийг анзааралгүй өнгөрсөнөө сая сэхээ орж хөмсөг өргөн инээмсэглэсэнээ:

-Харин ч гучин гуравгайд анхлан цагаан үс үзэгдэж эхэлсэн атал өнөөдрийг хүртэл тэгтэл нэмэгдээгүйд би баяртай байхад. Гэзэг минь тэр жил ураг зулбаснаас хойш атга атгаар унасаар олигтой нөхөж ургаагүй шүү дээ. Харин ч энэ хэртэй самнаж, гөрчихмөөр хэдэн хялгас үлдсэн нь яамай гээд Ану хатан гунигтай инээвхийлэв.



Үс зүсээ самнаж янзлан биеэ тордоод аливаа тааламжтай зүйлийг ярин, Оросоос тусламж хүссэн захидлын хариу хүлээж буй эр нөхрийнхөө сэтгэл санааг нь өргөн сэргээхийг л тэр хүсч байлаа.

Эцэг Эрдэнэ Баатар хунтайжийн үеэс өнөөг хүртэл найрсаг хөршийн харилцаатай явсаар ирсэн Оросын их цагаан хаанаас цэрэг зэвсгийн тусламж хүссэн бичиг үйлдэн, цорос овгийн болон Зүүнгарын хаант улсын тамга дарж илгээсэн Галдан хариуг нь сэтгэл дэнслэн хүлээх зуур цэрэг эрсийн хүчийг дайчлан, тариалан эрхлэгч хоёр зуугаад хотон айлыг Улаангомын газар суурьшуулан тариа услах урт суваг ухуулах ажил эрхлэв.

Арван гурван жилийн тэртээ Оросын цагаан хаанд элчээр одож асан Сэбэди Хожатай хамт явж байсан Дархан зайсан цагаан хаанаас ямар хариу авчрах нь цаашид Энх-Амгалантай зайлшгүй хийх дайнд Галдан бошгитын үхэх, сэхэхийг шийдэх байлаа.

Сар гарангийн өмнө Дархан зайсанг Орос газар цагаан хаанаас цэргийн тусламж хүсэх бичиг хүргэх элчээр томилох тухайд Галдан хаан шадар ноёд, жанжингуудаа цуглуулан хэлэлцэхэд, аливаад ухаан сэргэг, хэний ч ая эвийг олохдоо сайн Цэцэн увш:

-Миний сонссоноор могой жилийн хуучдаар Амур мөрний хөвөөнд орших Нэрчүү сууринаа Манж чин улс, Орос улстай “Найрамдах гэрээ” байгуулсан. Тэгээд тэрхүү гэрээ хэлэлцээрийг сахихын үүднээс Зүүнгар улсад цэрэг зэвсгийн болоод бусад тусламж үзүүлэх бололцоогүй хэмээсэн бичиг шийтгэн ирүүлж байсныг хаан та эс санана уу? хэмээн няцаасан ч эртний найрсаг харилцааг бодон, Зүүнгар улсын энэ нөхцөлийг эрхбиш харгалзан туслах нь магад хэмээсэн горьдлого өвөрлөн элч илгээсэн билээ.

Харин Ану хатны хувьд өөр бодолтой байжээ. Тэрбээр Галдан бошгит хэдий Түшээт хантай хийсэн тулаанд эд хөрөнгө, хүн хүчний гарз хохирол амсч, хойгуур нь ач Цэвээнравдан Ховдын газарт үлдээсэн нөөцийг шавхан одсоноор урьдын хүчирхэг байдал сулраад буй ч хүн ам нь дүрвэсэн Халхын ихэнх нутгийг эрхшээлдээ авсныг эрхбиш Оросын хаан харж үзэн туслах болов уу хэмээн нөхрөө дэмжин элчийн эгэн ирэхийг хүлээж горьдлого тавьж суугаа билээ.

Намрын эхээр Дархан зайсан Орос улсаас тусламж авч чадалгүй хоосон ирснээр Галдан бошгит хаан хар толгойдoo найдахаас өөр арга тасрав.

-Ану минь, Орос улс цэргийн тусламж ирүүлэхгүй хэмээжээ гээд Галдан бошгит хуучирсан найман ханат өргөөнийхөө хойморт бодолд дарагдан хүрлийн сууна.

Баруун тийш Зүүнгарын нутгийнхаа гүн рүү одъё хэмээхэд тэнд хэдийн Цэвээнравдан ач нь эзэн суусан. Зүүншээ халхын өргөн уудам нутгийг гурван жилийн өмнө дайлж эзэмшилдээ авсан ч хүн ард нь мал хуйгаа аваад өмнө зүг рүү зулбан одож Манжид дагасан тул хоосон шатрын хөлөг гэсэн үг. Хөх нуур, Лхаст одъё гэхэд манжийн цэргүүд тэнд хэдийнээ хулгана отсон муур мэт гол гол зангилаа замуудыг сэргийлэн суугаа билээ.

Тэр намар Улаангомын газар татуулж асан тариа услах сувгийн ажил дуусч, Галдан бошгит Цамбагарав хайрханаа тахисных юм уу, зундаа тэнгэр хур бороо гомдохооргүй хайрласны

хүчинд арвай, хөх тарианы ургац сайхан байсан нь бага ч гэсэн сэтгэл тэнийлгэв.

Тийнхүү Ховдод арвай, будаа тариалан, хоёр идэхгүй, хоосон хонохгүй дөрвөн жил наашаа ч үгүй, цаашаа ч үгүй суусан Галдан бошгитод аргын 1695 оны хөхөгчин гахай жилийн шинэдээр төвдөөс Далай лам элч илгээн “Манжийг дайлахаар Халх руу одоход билэг ерөөлтэй” хэмээн хэлүүлсэн нь санаа шулуутгажээ.

Чингээд Далай ламын элч Дархан Гомбо ламтныг байлцуулан Данжила, Данзан-Омбо, Дугар Равдан, Дархан зайсан, Баатар зайсан, Жирун хутагт, Ану хатан нараа цуглуулан Далай ламын соёрхол болон өөрийн зөн совиндоо итгэн Халхад цэрэглэн орж, Манжийн цэрэгтэй тулалдахаар болноо өчив. Ану хатан нам гүмийг эвдэн:

-Бид Зүүнгар сайхан нутгаа орхисоор зүдүүрт арван оныг үдэв. Халх,Зүүнгарын энэ дайнд олон сайхан баатар эрсээ алдав. Монгол туургатны голомт Халхын нутаг манжийн эрхшээлд орж, бид нааш ч үгүй цааш ч үгүй дөрвөн жил энд суулаа. Өөх ч биш, булчирхай ч бус чингэж суухаар үхэх сэхэхээ үзнэ хэмээсэн хаан таны бодлыг би дэмжиж байна хэмээн зоримгоор өчсөн нь энд цугласан ноёд, жанжингуудын сэтгэлийг эрслэн шулууудахад хүргэв.

Тийнхүү Галдан бошгит Улаан будангийн дайн, түүний дараачийн хүнд бэрх өвлийн хүйтэн, өвчин тахлаас амьд мэнд үлдсэн цэргээ авч, өргөө гэрээ нүүлгэн Халхын нутгаар Хүнгүй, Завхан голыг уруудан явсаар намрын эхэн сард Тамирын хөндийд орж ирж, шивээлэн буув.

Уртын урт хөх усан тууз мэт мушгиралдан урсах Тамирын шугуй алтан шар, шунхан улаан өнгөөр алаглан, буцах шувуудын цуваа тэнгэрт зэллэнэ.

Дөрвөн жилийн өмнөхийг бодвол халх зон олны зарим нь эзгүйрсэн нутгаа тэмцэн ирж энд тэнд ганц нэг хот айл үзэгдэх болж, хаа нэг уулын суга, ухаа толгод дунд хонин сүрэг цайран харагдах нь Тамирын үзэсгэлэнт хөндийг амь оруулсан мэт.

Тийнхүү Галдан бошгит Тамирын голоор шивээлэн суух зуур халхын ихэс бүгд Чахундорж шиг өвөрлөгчдийн зүг зулбан одоогүй, Гэндэн тайж, Намжил тайж, засаг тайж Арьяа, Арслан тайж зэрэг зарим ноён албат иргэдийн хамт Орхон, Туул, Тамирын хөндийгөөр нутаглан суугааг олж мэдэв.

Чингээд шадар жанжин Дугар Равдан, Данжила нарт гурван мянган цэрэг өгч, тэдгээр ноёдод “Зүүнгарын цэргээс аюун ширвээдэх хэрэг үгүй. Харин ч мал хөрөнгө, нутаг бууцаа орхин өмнөд этгээдэд зугтахын оронд элэг нэгт ойрад ахан дүүстэй нэгдэн манжийн эсрэг дайтах нь зүй” хэмээн ухуулахыг тушаан мордуулав.

Гэвч “Галдан бошгит зам зуур тааралдсан айл өрхийг тонон дээрэмдэж, ариун номын орон сүм хийдийг түйвээн шатааж явна” гэсэн цуу үгэнд итгэсэн Намжил тайж мал хөрөнгөө орхин зугтсан байв. Нэгэнт эзэн нь орхин нүүсэн мал хөрөнгийг Галдан бошгит хураан аваад, байгалийн сайхан тэгширсэн, өвс бэлчээр арвин баялаг,урьд эзэн Чингисийн их цэрэг шивээлэн сууж асан хэмээх домогтой Хэрлэнгийн Баян улаанд өвөлжихөөр нүүн очлоо.

Хэрлэнгийн Баян улаан уулын өвөрт өвөлжихөөр буусны дараахан Ану хатан:

-Та энэ хавиар нутаглаж буй зарим тайж нарт тамгатай бичиг шийтгэн тарааж, өвлийн тэсгим хүйтнээр дэмий үймэн бужигнаж амин зуулга, мал хөрөнгөө орхин зугтахгүй байх нь зүй хэмээн тайвшруулагтун. Эс тэгвээс мөн л Тамирын хөндийд мал хөрөнгөө хаян зулбасан Намжил тайж шиг юм болох вий хэмээн сэрэмжлүүлсний ачаар Хэрлэнгийн орчимд өвөлжиж буй халхчуудын сэтгэл амирлаж билээ.

Баян улаан уулын хөглөгөр их хөвчөөс түлшээ бэлтгэн, буга гөрөөс авлан хүнсэндээ сэлбэг хийж өнтэй сайхан суусаар хавартай золгосон тэр өвөл Галдан хааны амраг хатантайгаа хамтдаа үдсэн сүүлчийн өвөл байлуга.

Аргын 1696 он, баригч хэмээх улаагчин гал хулгана жилийн хаврын дунд сар.

Мөсөн хуяг нөмөрсөн Хэрлэн голын ус зайрмагтах цагаар Энх-Амгалан хаан өөрийн биеэр их цэрэг хөдөлгөн заналт дайсан Галдан бошгитыг дарахаар Халхын нутаг руу айсуй сураг гарав.

Энх-Амгалан төв халхын Хэрлэн голын хөвөө Баян улаан уулыг эзэгнэн шивээлж өвөлжсөн Галдан бошгитыг үүрэнд нь “намнахын” тулд Хөх хот, Бээжин, Хар мөрний чигт гурван замын чиглэлд их цэргээ хувааж, өөрөө дундад замын цэргээ удирдан ирж явлаа.

Өрнийн цэргийн зөвлөхүүд урин, галт буу, гунан буугаар зэвсэглэсэн Энх-Амгалан хаан Галдан бошгитыг хоёр талаас нь хавчин цохихоор төлөвлөсөн ажгу. Зүүнгар нутгаасаа тасран Халхын хоосорсон уудам уул талаар олон жил нааш цааш холхин аялж, хөрөнгө баялаг, хүнс хоол хомсдон туйлдсан Галдан бошгитын цэрэг албатыг сүрдүүлэх зорилгоор Энх-Амгалан хорин түмэн цэргээ дөчин түм хэмээсэн цуу тараажээ.

Хэрэг явдал бишдэн өшт хүн өлийн даваан дээр гэгчээр олон жил “муур хулгана бололцсон” Энх-Амгалан хаантай эрэгчин эмэгчнээ үзэлцэх цаг хоолойд тулж ирснийг ойлгосон Галдан бошгит өргөөндөө шадар ноёд, жанжин, лам нар, Ану хатнаа цуглуулан манжийн их цэрэгтэй хэрхэн тулалдахаа хэлэлцэв.

Энх-Амгалан хааны өөрийн биеэр удирдан ирж яваа дундад замын цэргийг Галдан хаан баруун, зүүн замынхтайгаа нэгдэхээс түрүүлж цохих бодолтой байсан ч Данжила “Бид дөнгөн данган гуравхан түмэн цэрэгтэй. Гэтэл Энх-Амгалан хааны удирдаж яваа дундад замын цэрэг гэхэд арван түм. Гунан буу гэхэд гурван зуу гэж тандуулууд өчиж буй билээ. Тиймд Мүгдэнгийн Субасу жанжны авч яваа баруун замын цэргийг отон байлдах нь оновчтой мэт” хэмээснийг цугларсан жанжин, зайсангууд түрхрэн дэмжлээ.

Чингэхдээ Галдан бошгит хаан хойноосоо Энх-Амгалан хааны удирдаж яваа дундад замын цэрэг мөрдөн хөөхөөс сэргийлэн өртөө бүхэнд зуун цэрэг орхин давшсаар баруун замын цэргээс урьтан очиж тосон байлдахаар хөгшин хөвөө, хүүхэд нялхсыг Баян улаан ууланд түр үлдээгээд яаравчлан Туул голын зүг хөдөлцгөөв.

Цас бараантан хайлж, сэвхтэй халтар нүүр мэт цоохортсон хаврын даржин, бараан байгаль үргэлжлэнэ. Манжийн зүүн замын цэргээс урьтан ашигтай байрлал эзлэхээр өдөр шөнөгүй довглох их цэргийн магнайд Ану хатан арилжаа явдалтай, хилэн хар хүлгээ унан эр нөхөртэйгээ дөрөө харшуулан явна. Эцэг, эх хоёрын зүүн талд хорин дөрөвгэй хүү

Сэвдэнбалжир нь жороо цавьдир морь унан явах аж.

“Аав аа, ижий! Дайснаа дараад үтэр түргэн эргэн ирээрэй! хэмээн нүдэндээ нулимстай ч сүүн цацал өргөн хоцорсон хоёр охиных нь хонгорхон дүр Ану хатны цээжинд нь хадаастай. Тэднийхээ олон салаа сэвгэр гээгтэй толгойг үнэрлэн, үрсийнхээ хонгорхон даахины үнэрийг сүүлчийн удаа татаж буйгаа ухамсарлавч, сэтгэлээ хатамжлан нулимсаа цээжиндээ эгшээж хагацан одоход юутай бэрх байв даа.

Хажуугаас нь харахад хайрт нөхрийнх нь эрэмгий царайд айдас түгшүүрийн ул мөр огт үгүйг үзээд хатны сэтгэл уужирна. Галдан бошгитын орой дээрээ алтан сампин зангидан улаан залаа унжуулсан ган дуулга дороос үзэхүл тэртээ гучин зургаан жилийн өмнө адис авахдаа анх нүүр тулгарч зүрхэнд нь нэвтэрсэн нөгөө хурц хар нүднийх нь гал буураагүй атал уужим магнайд нь гурван эгнээ гүнзгий атираа тогтжээ. Баатрын хуяг дуулга өмсч, хүрлийн бодлогоширч аяншиж гандсан царайтай, яваа тавь гарсан энэ хижээл эрийг цагтаа сүсэгтэн олон бишрэн хүрээлж “Зулай дээр нь Базардарь, магнайд дээр нь Зонхов гэгээн, нүүрэнд нь Махгал бурхан, хоолойд нь Хоньсонбодьсатваа, хоёр мөрөн дээр нь хорин нэгэн дарь эх тодорсон, бар арслангийн хүчтэй хувилгаан гэнэ лээ” хэмээн амьд бурхан мэт тахиж, мутраас нь адис хүртэх гэж үхэлдэн хошуурцгааж байсан гэхэд итгэмээргүй.

Юунаас ч аюухыг үл мэдэх зоригт шонхор шувууны дүрс цутгасан, алтадсан тольтой цээживч, ган утас хэлхсэн хуяг, Хасагийн Янгир хааныг ялан дийлж явахдаа олзолсон алтан хуйт илдээ агссан энэ сүрлэг эрийн дэргэд өнгөрүүлсэн хорин таван жилийн амьдрал нь Анугийн нүдний өмнүүр жирэлзэн өнгөрөх шиг.

Өдрөөс өдөрт хүчирхэгжсээр буй Манж чин гүрний хорин түмэн их цэргийн өөдөөс гуравхан түмэн цэрэгтэй тулалдана гэдэг үхэл мөхлийн зам ч байж мэднэ гэдгийг Галдан бошгит ч, Ану хатан ч ухаарч байсан замын туршид тул ялах, ялагдахын тухайд ганц ч үг ярилцсангүй.

Онон, Хэрлэнгийн шугуй дундуур яаравчлан урагшлах их цэргийн зэр зэвсэг харшилдах, агт морьдын тургилах, эрэгчин эмэгчинээ үзэлцэх эцсийн тулалдаанд явж буй баатар эрсийн инээлдэн хөгжилдөх, хошин үг хэлэлцэхтэй зэрэгцэн морьдын хөлд хуурай бургас тас нясхийн хугарах нь дуулдах ажээ.

Галдан бошгитын цэрэг ганц өдөр ч саатан амсхийлгүй, өдөртөө хоёр удаа зогсоогоороо шахуу ундалсаар Туул голын хөндийд орж ирэв.

-Аав аа, тэр Туул гол үзэгдэж байна бус уу? Бас Өлчир тэргүүтэн толгойн харуулынхан айсуй хэмээн Сэвдэнбалжирыг ташуураараа зангахад Галдан бошгитын их цэрэг Заан тэрэлжид дөхөж явлаа. Араас нь нэхсэн манжийн дундад замын цэрэг амь хайрлалгүй үхэлдэн тулалдах ойрадын зуутуудтай зууралдан байлдах зуур, Галдан бошгитын гол хүч сугаран давшсаар Туулын хөндийд орж ирсэн нь энэ.

-Тийм байна. Хөхрөн цэнхэртээд ёроол нь нэвт үзэгддэг тунгалаг уст гол байгаа юм. Эрт дээр цагт эзэн Чингисийн цэрэг харьд дайлаар мордохдоо Туулын тунгалаг уснаас магнайдаа хүргэн хүндэтгэж, алгандаа утган амсаад оддог байсан гэдэг юм хэмээн Галдан бошгит хүүдээ ярьж явахад Анугийн сэтгэлд зургаан настайдаа эцэг, эхийн хамт цастын орны зүг

явах замд таарч, хүзүүний хуван зүүлт бэлгэнд өгчилгөж асан халхын нэгэн ноёны залуу хатан Норжин авхайн ярьж өгч, тэр шөнө зүүдэнд нь үзэгдсэн хөвөөгөөрөө бургас, хайлаасан шугуй ногоорсон их уст мөрөн энэхүү Туул гол байсан юм гэж үү? гэсэн бодол сэртхийв.

Толгойн харуулд илгээсэн Өлчир баатар тэргүүтэй цэрэг эрс давхилдан ирж, Галдан бошгит хааныг хүндэтгэн тэргүүн мэхийлгээд:

-Хаантан, Заан Тэрэлжийн цаад уруу Манжийн их цэрэг шивээлэн буусан байна. Бодвол баруун замын цэрэг буй за. Манжийн цэрэг олон зуун үхэр буутай, мөн зүс буруу орос царайт сургагч нартай яваа ажээ. Нутгийн зарим өрхөөр ороход Түшээт хан бас цэрэглэн манжид хамжихаар дөтлөн айсуй гэнэ хэмээн илтгэв.

-Ландарма гэж! Манж нараас хоцорчихлоо. Манжийн улыг долоогч муу хулгай Чахундорж бас хээрийн чонотой нийлсэн нохой мэт цэрэглэн ирж яваа бий хэмээн Галдан хаан өөрийн эрхгүй хараал урсгав.

“Ландарма” гэж барагтай л бол хараадаггүй нөхрөө тийн уулга алдахад Ану цаг хожиж, манжийн баруун замын цэргээс өрсөн Туулын хөндийд ирж үл завдсан тул ялан дийлэх өчүүхэн ч найдлага үгүй боллоо гэдгийг ойлгон зүрх нь ёгхийгээд явчихлаа.

Хөглөгөр их ойтой хангайн сайхан уулын хойгуур баруунаас зүүн тийш мяралзан урсах хөх уст энэ голын хөвөөнд миний сүүлчийн шороо пурхийх ёстой байжээ хэмээн Ану хатан өчүүхэн ч айхгүйгээр бодов.

Маргааш болох тулалдааны өмнө баатар эрс, агт морьдоо амраахаар Галдангийн их цэрэг модтой уулын бэлээр шивээлэн буулаа. Жаргах нарны туяа тэнгэрийн баруун хаяаг цусан өнгөөр тунаруулах нь маргааш болох цуст тулалдааны өнгийг илтгэх мэт.

Цэрэг эрс модны хаяагаар майхан, жодгороо босгон, гал түлж утаа май тавин цайлж эхлэв. Бошгит хааны хамгаалалтын шадар зуутын цэрэг эрс шивээ хүрээний хүйс дунд эзнийхээ өлзий хээт цэнхэр торгон цацрыг босгон төвхнүүлэх зуур, хааны цацрын өмнөд этгээдэд барьсан бяцхан гэрт хоёр зам борцтой шөл пор пор буцалган суух аж. Галдан бошгитын цацрыг тойруулан Данжила, Данзан-Омбо, Дугарравдан, Махан жанжнуудын асрууд хүрээлэн бослоо.

Цэргүүд хааны цацрыг барьж, зам оройн гүнцэг зэхэх зуур Ану хатан Мандарваа шивэгчнээ дагуулан боржин хадат өндөрлөг дээрээс манжийн цэргийн хүрээг дурандав.

Ану “Манжууд биднийг баруун талаас Туулын хөндийн зүүн тал руу голд шахан хөөхөд, Халхын цэрэг зүүнээс хавчин цохих аваас зайлшгүй бүслэгдэх аюулд орох юм байна даа. Тиймд би Балсан, Бундир хоёрын зуутууд дээр нөөц нэгэн зуутыг дайчлан шилдэг гурван зуун цэргийн хүчээр тэр зүүн талд буй элсэн зурвасын чигт гэнэт дайрч бүслэлтийг сэт цохин Галдан, хүү хоёртоо зам гаргаж өгөөд үхье. Дөчин гурван насыг зооглон хорвоогийн амьдралаас жаргал, зовлон бүгдийг амсч ханав. Галдан минь Хасагийн Янгир султан шиг алтан шарилаа ч дайснуудынхаа олз болгох ёсгүй. Миний нөхөр, Зүүнгарын бошгит хаан бол Янгир биш. Тэр минь үхсэн ч, амьддаа ч муусайн манж, зүрчидүүдийн гарт орох ёсон үгүй”

хэмээн эрс шийдээд модны захад цэргийн хүрээний зүүн тал руу байх хэдэн гандмал хөх майхан бүхий дархцуулын отогт очив.

Мөн л асар майхнаа босгон гал түлж, халуун цай чанан хошуу бүлээцүүлэхээр шуугилдан хөгжилдөж байсан дархцуул өөрийг нь үзмэгц хүндэтгэн, тоглоом наргианаа намжаан, амрыг нь айлтгахад Ану хатан:

-Та нар минь таван өдөр зогсолтгүй довтолгосоор алжаасан биз. Цайлахад тань би саад тотгор учруулахыг үл хүснэ. Харин Чилэдү чамд захих нэгэн даалгавар над буй хэмээгээд миний моринд бугын мөнгөн баг хийж маргааш өглөө бэлэн болгогтун хэмээн тушаалаа.

Дүүрэн мэргэн багш нь нэгэнтээ “Эртний монгол баатар эрс эцсийн шийдвэрлэх тулалдаанд орохдоо халуун амиа золин үхлээс үл шантрахын билгэдэл болгон мориндоо мөнгөн эвэрт бугын баг зүүлгээд уухайлан дайрдаг байсан юм гэнэ лээ” хэмээн хүүрнэж байсныг үхэл сэхлийн ирмэг дээрх энэ орой Ану хатан өнөөдөр эргэн санасан нь энэ ажгу.

Чингээд тэрээр маргаашийн шийдвэрлэх тулаанд манжийн цэрэгтэй үхлээс үл эмээн алаалдан тулалдаад урьд амраг нөхөртөө хуучилж байснаар эцсийн амьсгал татах цагт эрийнхээ өмнүүр орохоор эргэлтгүй шийджээ. Манжийн дунд замын цэрэг л гэхэд Галдан бошгитын бүх цэргээс даруй гурав дахин их байх агаад, маргааш тулалдах баруун замын таван түмэн цэрэг, Түшээт ханы цэрэгтэй нийлээд Зүүнгарын цэргийг хэдэн давхар бүслэн ороох нь магад. Тэр цагт Энх-Амгалан хаан бүслэлтэнд орсон заналт дайсан Галдан бошгитыг амьдаар нь олзлохыг хичээх нь усан тэнэг хүмүүн ч ухааж ядах юм үгүй байлаа.

Хоёр охиноо Баян улаан ууланд найдвартай газар орхисон тул үхэхэд хоргодох юм түүнд үгүй бодогдоно.

Чингээд Мандарваагийн хамт цацрынхаа зүг явж ахуйдаа “Бум, Юмчихай хоёрыг минь чи эхийн хайраар харж хандаж яваарай. Зүүнгар сайхан нутгаа орхисноос хойшхи энэ жилүүдэд тэр хоёроо ёс төртэйгээр ураглуулан мордуулж ч завдсангүй. Нүүдэл, суудал, аян дайн, эцгийг нь эсэн мэнд ирдэг болов уу? гэсэн түгшүүр дунд арван жил нисэх мэт өнгөрчээ” хэмээн хүүрнэж явлаа.

Багаасаа аливааг ямагт өөрийнхөө бодсоноор байлгах гэдэг, хэний ч үгийг эс сонсон зүтгэдэг зоримог хатуу зантай эзэн хатнаа маргаашийн тулаанд манжийн эсрэг амиа золин дайрахаар эрслэн шийдсэнийг Мандарваа ойлгон, аяга дүүрэн мэлтэлзэн ирэх нулимсаа барьж үл дийлэх атал толгой дохин зөвшинө. Цацрынхаа үүдэнд ирмэгц Ану тас тас хөхрөн:

-Бүү уйлан усан нүдэлж үз. Одоохондоо би үхээгүй л байна. Бүр бага байхын л сул нулимстай хүн шүү чи. Алив, нулимсаа эгшээж сэтгэлээ хатамжил хэмээгээд нум сум харвасаар эвэршсэн хоёр гарын алгаар шивэгчнийхээ нулимсыг нь арчиж өгөв. Чингээд цацартаа орж, нөхрийнхөө хамт цайлж суухдаа мориндоо зүүлгэх бугын баг хийлгэж буйгаа, шийдвэрлэх тулалдаанд шадар зуутаа манлайлан тулаанд орохоор эрслэн шийдсэнээ Галдандаа ам нээн өчсөнгүй.

Навчис гөлөглөж амжаагүй нүцгэн моддын мөчир сэрийлцэн, цагаан гэгээ тасарч байхад

Галдан бошгит, Ану хатан хоёр борцтой шөлөө зооглоод аяны цацартаа орж үүр тэмдэгрэх хүртэл түрхэн зуур амсхийхээр хэвтлээ.

Данжила, Данзан-Омбо, Дугар Равдан гурав маргаашийн тулалдаанд зэхэн тэмээн хаалт хийх, хамгийн эхэнд хошуучлан тулаанд орох мянгатуудын дарга нартай газрын бартааг зураглан хэлэлцэх, харуул манааг эргэхээр одоцгоов.

Галдан бошгит уужим зайтай хөх торгон цацрын баруун талаар зузаан эсгий давхац гудас давхарлан зассан орон дээрээ хөө хуягийн дотуур өмсдөг нимгэн цэнхэр дурдан хөвөнтэй дээлтэй бүхлээрээ ухаангүй нойрсох Анугийн хажуугаар орж нойр нь хулжин хэсэг хэвтэв. Тэгээд олон хоногийн нойр, хоолгүй аянд, идэр залуу цэрэг эрсийн аяар довтолгон явсаар алжаасан хатныхаа гарын алгыг сэмхэн энхрийлэн илбэвээс нумын хөвч татсаар хоёр гарынх нь долоовор, эрхий, дунд хуруунууд эгнэгт үл арилах эвэр урган хатуурсан нь тэмтрэгдэх ахуйд харанхуйд гагцаар инээмсэглэв.

Ануг арван дөрөвгэйд Хөх нуурт эцгийнх нь өргөөнд учран анх удаа бяцхан мутарыг нь илбэхэд л өнөөх дэгжин шаавай авхайн гар гэхэд итгэмээргүй нум, сум татсаар эвэршчихсэн байж билээ.

“Маргааш Ануг цэргийн хүрээндээ өөрийнх нь хоёр зуутын хамгаалалтанд үлдээе. Би үхлээ гэхэд Данжила хайрт хатныг минь манжийн гарт өгөлгүй тулааны газраас аваад гарчихна. Алтан шармал дуулга, хөнгөн хөө хуягаа зэхэн тавьсныг үзвээс үүр цүүрээр дайрах хошууч ангитай хамт манжтай алалдах нь ээ. Энх-Амгалан намайг амьдаар минь олзлох зарлиг буулгасан хэл чимээтэй. Тэртээ арван есөн жилийн өмнө хасагийг дайлж, ялагдсан Янгир султаны хүүрийг үзээд би хаан хүн үхсэн хойноо ч дайсныхаа гарт орох ёсгүй хэмээхийг сонссон болохоор Ану минь миний төлөө амиа золихоос зүрхшээхгүй хүн дээ” хэмээн бодсоор зүүрмэглэжээ.

Нэг л мэдэхэд амь өрсөн тулаанд цэрэг эрсийг дуудах бүрээ, дунгийн дуу хадаж, гадаа үүр тэмдгэрч байлуга. Галдан хааныг сэрхийн өндийхөд Ану хатан нь хэдийн босч өчигдрийн зэхсэн хөө хуягаа агсаад гарч одсон байлаа. Харин цацрын зүүн хаяанд арван хоёр салаа эвэрт бугын мөнгөн баг авчран орхисныг үзээд Галдан хаан хатнаа өнөөдөр амь эрсдүүлэн тулалдахаар эрслэн шийдсэнийг ойлгов.

Ану...Энэ бүсгүйгүйгээр амьдрал нь хов хоосрох юм гэдгийг Галдан бошгит өнөөдрийг хүртэл бүрэн ухаарсангүй явжээ. Хаан...улсгүй, төргүй бас газар нутаг ч үгүй хаан, хэрэв өнөөдөр Ану хатнаа алдчих юм бол бүр хатан ч үгүй хаан болох нь. Гэвч нутаг үгүй ч бас биш юм. Монгол туургатны ариун голомт болсон Туул голын энэ үзэсгэлэнт хөндий түүний газар шороо биш юм гэж үү? Энэ ариун хөрсөн дээр манжийн хөлийн мөр талхлахыг үзэхгүйн төлөө утсан чинээ улаан амиа мянгантаа өргөхөд ч харамсан бачуурах юун билээ?

Галдан бошгит хоромхон зуур ийн гунигласан ч төдөлгүй оюун бодлыг нь өнөөдөр болох хүч тэнцвэргүй тулалдаан, өөрийн биеэр их цэрэг хөдөлгөн заналт дайснаа дарахаар монгол туургатны ариун голомтыг гишгэлэн яваа Манж дайчин улсын Энх-Амгалан хаан, халх Ойрадын дайны галыг асаачихаад урван одсон Түшээт хан Чахундорж хоёртой хийх эцсийн тооцооны тухай бодол эзлэн авсан тул хэвтрээс шалавлан босч хонх дуугаргав.

Гаднаас шадар гоцго нь орж ирэн хуяг дуулгыг нь өмсгөж дуусахад Данжила ирээд өрөөсөн өвдөг дээр сөгдөн:

-Хаантан, манай цэрэг тулалдаанд бэлэн хэмээв.

-Их хэнгэргээ дэлд!

-Жаа.

Галдан бошгит хааныг цацраасаа гарахад хаяагаараа сэмжин үүлс хөвүүлсэн хөх огторгуйд үүр шөнийн цөөхөн хэдэн од гялалзан дорно зүгт үүр хаяаран гэгээ орж байлуга.

Баруун зүгт их хэнгэрэг дэлдэх, бүрээн дуу чих сонордох нь манжийн цэрэг ч дайралтад оров бололтой.

-Манжийн цэрэг давшиж айсуй.

-Мориндоо!

Галдан бошгитыг хөө хар хүлгийнхээ нуруунд мордох тэрхэн агшинд Ану хатан шивэгчнээ дагуулан цацрынхаа үүдэнд хүрч ирлээ.

-Хаантан...Галдаан! гэх Ануг хуяг дуулгаа өмсч, нум саадаг, хоромсгоо бүсэндээ зүүж, өөрийнх нь бэсрэгхэн бие, жижигхэн гарт тааруулан дархалсан авсаархан илдээ бүрэн агсаж тулалдаанд ороход биеэ бэлдсэнийг нь агшин зуур ажиглан, цацрын хаяанд тавьсан бугын багийг нь үзсэн атал Галдан бошгит морины амыг татаж түр зогсосхийн түүнийхээ духан дээр үнсэв.

-Чи минь их цэргийн хүрээндээ үлд. Балсан, Бундир, Манал нарын зуутууд чиний мэдэлд буй...Биеэ бодоорой! Чи минь үгүй бол энэ амьдрал миний хувьд хов хоосон цөлтэй л агаар нэгэн...

-Галдан минь...

Ану хатан хайртай түүндээ энэ эцсийн мөчид хэлэх үг олдсонгүй. Хэлье ч гэсэн хүчин хэд дахин давуу дайсныхаа өөдөөс эрэгчин эмэгчнээ үзэлцэх тулалдаанд орох их хэнгэргийн дуу дэлдэж буй энэ түгшүүрт мөчид насны хайртай хүндээ хэлье гэсэн бүхнээ хэдхэн өгүүлбэрт багтаан хураангуйлах чадал хаанаас тэр олох билээ?

Зургаахан настай нялх балчирхан охин ахуйдаа энэ хүнтэй анх учран мутрын адис хүртэж байхад нь хөвөн шиг зөөлөн байснаа эвэр нум татаж, илд эргүүлэн хуй салхин мэт хурдлах эмнэг догшин хүлгийн амыг татан, нар салхинд явсаар одоо бол хуурай мэт ширүүн болсон хоёр гараас нь атгачихаад тавимааргүй байв.

-Таны өгсөн бурхан энэ, хүзүүнд минь зүүлттэй яваа. Дайны сүлд хийморь тань ивээг...хэмээгээд Ану хайрт нөхрийнхөө хоёр гарыг тавьж, Мандарваагаас бяцхан борвитой сүү, цацал хоёроо авч дөрөөн дээр нь сүү дусаан үдлээ. Цорост бэрлэн ирж, энэ хүний хатан



болсон тэр цагаас өнөөдрийг хүртэлх хорин зургаан жилийн турш алсын аян замд ч, саахалтын газар одоход нь ч ийнхүү дөрөөн дээр нь сүү дусаан, хойноос нь сүүн цацал өргөн үддэг байснаараа л тэр өнөөдөр эр нөхрөө үхлийн тулаанд эцсийн удаа гаргаж өглөө.

Эрэлхэг баатар эрс тулалдаанд орохдоо алтан амиа аймшиггүйгээр золихын тэмдэг мөнгөн эвэрт бугын баг мориндоо зүүлгэдэг асан эртний заншлаар баг хийлгэсэн Ану хатан манжийн түмэн цэргийн хэдэн давхар бүслэлтээс эр нөхрийнхөө амь насыг аврахаар эрслэн шийдсэнийг хэн хэн нь ч эс мэдэх мэт тийнхүү урьдынх шигээ л салах ёс хийж чадлаа.

-Ижий!

Хүүгээ Ану умартсан юм гэж үү? Түүнд бас хүү бий шүү дээ. Дайсны суман мөндрийн өмнөөс дайран орж, эцэгтэйгээ мөр зэрэгцэн байлдах эр ганц хүү нь...Сэвдэнбалжир тулалдаанд орохын өмнө эхдээ үнсүүлэхээр давхин ирэв.

-Ааваасаа бүү холдоорой, хүү минь! Алдагдсан алт эрдэнэсийг эгүүлэн олж авч хэзээд болдог. Харин харьд алдсан газар шороо эгнэгт хүнийх болдог юм. Санаж яваарай миний хүү. Цоросын Эрдэнэ баатар хунтайж, хошуудын Очирт цэцэн ханы удам угсаа гэдгээ бүү мартаарай! Хүүгийнхээ духан дээр эцсийн удаа үнэрлэн энэ хэдэн үгийг захиад Ану хатан аавыгаа алдсан тэр мөчийг эргэн санав. Бурхан түүнд хайрласан бүхнээ бүр мөсөн эгүүлэн авах нь энэ гэж үү? Өмнө этгээдэд манж, халх, өвөрлөгчдийн цэргүүд уухайлах, үхэр буу нүргэлэх сонсдон эр нөхөр, хүү хоёр нь элэг нэгт ойрад баатар эрсийн хамт үхлийн өөдөөс хүлгийн хурдаар давхин одлуга.

-Хатантан минь. Та үнэхээр энэ бугын багийг мориндоо зүүлгээд үхлийн тулалдаанд орох юм гэж үү?

-Энэ тухай надаас бүү шалгааж үз, Мандарваа минь. Надад өөр бусад зам гэж үгүй. Балсанг дууд!

-Жаа...

Хаврын бүрхэг саарал тэнгэрт одод шуугдан Тэрэлжийн хадат уулсын дээгүүр наран авхайн анхны алтан сацраг гялалзах цагаар Манж, ойрадын цэргийн түрүүч тулгаран байлдаж эхлэв.

-Балсан!

-Жаа...

-Бундир, Манал та гурвын зуутууд тулалдаанд бэлэн үү?

-Бэлээн, хатантаан!

-Би тэр баруун ухаагийн орой дээрээс тулалдааны байдлыг хэсэгхэн дурандаадахья. Манжууд биднийг баруун, баруун хойноос ороон бүслэх байдалтай байна. Сүүлчийн мөчид зүүн чиглэл барин гурван зуутаараа гэнэдүүлэн дайрч бүслэлтийг сэт цохино шүү!

-Жаа.

Нэгэн эхийн ангир уураг хуваан хөхөж өссөн, баатар эр Балсангийн нүдэнд өөрийнх нь төлөө сүүлчийн дусал цусаа үл хайрлах шийдэмгий зориг буйг Ану олж харлаа.

Их цэргийн хүрээний баруун талд байх босоо хүний дайтай боржин хаднууд бүхий модот ухаа дээрээс Ану хатан тулалдаан хэрхэн өрнөж буйг хэсэг дурандав.

Зэвсэг сайтай манжууд цөс ихт ойрадын морьтон баатруудын өөдөөс үхэр буугаар галлаж байснаа давшилтанд орж, галт буугаар буудан, нумаар харваж эхэллээ. Махан жанжны эрэлхэг зоригт хошууч анги үхэр буу, галт буу, нумын суман мөндөр өөд уухайлан дайрав.

Гэтэл Манжууд мэх хэрэглэж буй бололтой аажмаар зүүн зүг рүү ухарч буй үзэгдэнэ.

Цус үзэн, дайснаа ухарч буйд цөс нь хөөрсөн ойрад цэрэг манжийн их цэрэгтэй холилдож, улайран тулалдсаар Туул голын зүүн эрэг даган байлдаан улам зүүн тийш уруудан үргэлжлэх аж.

Энэ нь тийнхүү ойрад цэргийг хэтэрхий зүүн тийш давшуулж байгаад гэнэтийн цохилт өгөх зальт Энх-Амгалан хааны тавьсан занга байсан бололтой. Энэ өдрийн хонин цаг дуусах дөхөж, нар тонгойж эхлэхэд давшиж байсан ойрадын их цэргийн баруун, зүүн гар талаас нь гэнэт асар олон үхэр буу нүргэлэн, галт буугийн тугалган сум балбаж гарах нь тэр!

Галдан бошгит хаан манж цэргийн бүслэлтийн хүйс дунд нь орчихжээ. Цаг болжээ. Атаатан дайсыхаа өмнөөс аймшиггүйгээр алтан амиа золихын тэмдэг бугын мөнгөн багтай хүлгийг нь Ану хатанд авчирч өглөө. Тэрбээр үнэнч шивэгчин Мандарваагаа эцсийн удаа тэврэн салах ёс гүйцэтгээд мориндоо мордов. Үхлээс айлгүй гартаа оруулж чадсан хүмүүн гэдэг газарт дэлхий дээрх хамгийн том эрх мэдлийг атгасан мэт болдог ажгу.

-Манайхан бүслэгджээ. Манжийн цэргийн гол хүчин Туул голын адаг, Улхын булангаас наана бөөгнөрч байна гэсэн тандуулын мэдээ худал ташаа байж. Балсаан, бүрээгээ тат! Уухай, тулалдааны газар өөд уухайлан дайръя! хэмээн Ану хатан тушаалаа.

Хаврын адаг сарын, илч гэрлээр мишээсэн нарны туяанд алтан шармал хуяг дуулга гялалзуулсан Ану хатан арван хоёр салаа эвэрт бугын баг зүүсэн хилэн хар мориныхоо хурдаар шадар гурван зуун цэргээ магнайлан байлдаанд уухайлан орж явчихав.

Хоёр талын цэрэг эрсийн уухайлан орилолдох, ёолон хашгирах, бурхан шүтээнээ дуудан залбирах, морьд янцгаан, тэмээ орилох, буу пижигнэн, сум исгэрэх, сэлэм, жад харшилдах чимээ чихний хэнгэрэх хагалах алдан нүргэлж, тэнгэрт дарийн утаа хөшиглөнө.

-Тэр зүүн жигүүрээр уухайлан дайръя! хэмээн Ану хатан тэр их чимээн дундуур хашгираад дайсны өөдөөс дайран оров. Ойрад цэргийнхээ цусыг үзээд хатан ч улайрчээ. Тэртээ баруун талд цорос, Зүүнгарын туг сүлд намирах үзэгдэх нь Галдан бошгит, хайрт нөхөр нь тэнд алалдаж буй бололтой.

-Манал аа! Хатантныг хараанаасаа бүү алдаарай. Илдэнд гарамгай аравгуудаараа хатныг хамгаал! гэж Балсан хашгирах зуур зай завсаргүй сум тавин Ану хатны баруун гар талыг хамгаална.

Ану хатныг тойрон илдний эрдэмд гарамгай хошууд, өөлдийн баатар эрс баруун солгойгүй цавчилдаж, цусан зам татуулан манжийг хиар цохиж гарав.

-Хатантаан хойшоон болооч! Манжийн мэргэн харваачид наашаа буудаж эхлэв хэмээн Балсанг орилоход үс гээг нь дуулган дотроо садран асгарч, нүүр нь хөлсөнд халгартан оч хаялсан цоглог нүдээ гялалзуулсан Ану хатан цавчилдаж байснаа, баруун гараа түр амсхийлгэн буулгаж мориныхоо амыг татан:

-Урагшаа! Манжууд саарч байна. Бундир мэргэн буудагчдаа нааш нь хэмээгээд дахин дайран орлоо.

Ану хатны гурван зуутын цэргээс тал нь л үлджээ. Хөлөөр нэг манж, монгол, ойрад цэргийн хүүр хөглөрөн, дутуу үхсэн морьд тарчлан янцгааж, галт буун дуу нүргэлнэ. Ану хатны цэрэг манжийн цэргийн эгнээг хага яран зүүн зүгт урагшилсаар хэсэгхэн шинэс модод ургасан элсэн тасархайн шил дээр гарч ирэв. Энэ нь Заан тэрэлжийн зүүн урд байх Зуун мод хэмээх газар амой. Гэтэл тэрхүү цөөхөн шинэс моддын баруун урдаас галт буу, гунан буутай манжийн хэсэг цэрэг нэмэгдэн давшиж ирээд наранд гялалзсан алтлаг өнгийн хуяг дуулгатай Ану хатныг овоо хараандаа авсан бололтой тасралтгүй галлаж эхлэв.

-Хатны урдуур хамгаалаарай! хэмээгээд Балсан хэдэн цэрэг дагуулан тэр манжууд руу амь хайргүй дайран орлоо.

Ану хатан ч үлдсэн зуугаадхан цэргээ авч элсэн тасархайн хэсэг модонд шивээлсэн дайсны зүг дайран ороход Бундир баруун хойшоо нэг хараад “Манайхан айсуй!” хэмээснээ Ану хатныг хамгаалан дайрлаа.

Ойртон үзвэл ёнхор хамартай харь хувцастай хоёр зааварлагч, зуугаад манж цэрэг, цаана нь хэдэн халх болтой цэрэг байлдаж буй үзэгдэх аж.

Тийнхүү дайсны цэрэгтэй гар сунгахад хүрэхүйц үүдэн хоймрын зайнд тулалдаж эхэлмэгц эрх биш угсаа нэгтэй юм гэсэндээ халхууд Ану хатны сүүлчийн зуут руу харваж буудахаа больж, манжийн мэргэн буучид л галлаж гарах нь тэр.

Галт буугаар буудаж буй манжууд руу Бундир арваад цэргийн хамт сэлмээ сугалан халз дайрахад Ану хатны өөдөөс давшин орж ирсэн арваад манжтай Балсан, Баваасан нарын цэргүүд цавчилдаж гарав.

-Бүслэлт сэтэрлээ! хэмээгээд Ану хатныг суманд оногдож, үхэдхийн унахад ар өвөргүй сум зоолгоостой Балсан гар дээрээ эзэн хатнаа тэврэн авч, Манал баатар хатнаа буудсан манжийг жадлан хөнөөв.

Зүрхний тус газраараа галт бууны хоёр суманд оногдсон Ану хатны тэргүүнээс алтан дуулга

нь мултран унаж, хуягных нь завсраар нэвгэрсэн цус элсэрхэг хөрсөн дээр гоожих авч хоромхон зуур шингэн алга болж байлаа.

Галдан бошгит, Данжила жанжин тэргүүтэй ойрадын хэсэг цэргийг давхилдан ирэхэд Ану хатан дөнгөн данган амьсгаатай байв

-Хаантан минь! Ану хатантныхаа амийг би сахиж чадсангүй ...хэмээгээд үхлийн шархтай Балсанг үхэдхийн унахад Галдан бошгит мориноосоо үсрэн бууж, Манал баатрын өвдөг дээр дөнгөн данган амьсгаатай хэвтэн буй хатан руугаа ухасхийн очиж тэргүүнийг нь гар дээрээ болгоомжтой авлаа. Санчигтаа хэсэгхэн газар бууралтсан Ану хатны сайхан алтлаг хүрэн гэзэг нь задарч Зуун модны элсэрхэг хөрсөн дээгүүр сул асгаран унжина.

-Ану...Хайрт минь! Ану хатны үлмэдэг чийг даасан урт сормуус чичирхийлснээ мэлмийгээ алгуурхан нээж, амраг нөхрөө танив бололтой бүүдийсэн харц нь нэг сэргэсэнээ:

-Ашгүй...Та минь мэнд үү?...Манжийн бүслэлтээс гар...Амьдаараа бүү олзлогдоорой...хэмээгээд сулхан инээмсэглэсэнээ:

-Би тантайгаа сайхан...жаргалтай амьдарсаан... үхэхэд гомдох юм алга хэмээгээд хөх тэнгэрийг ширтээстэйгээ амьсгаа хурааж билээ.

Эрэлхэг зоригт ойрад бүсгүйн амьсгаа хураасанд эмгэнэх мэт үүлэн сүүдэр нарыг хоромхон зуур халхлан, сэржигнэх хаврын салхи ч хүртэл тогтчих шиг болов. Арван хоёр салаа эвэрт бугын баг бүхий хүлэг сайн морь нь ч эзнээ амьсгал хураасанд гашуудах шиг үүрсэн янцгаах мөчид баруун гартаа шархтай Сэвдэнбалжир хүү нь давхин ирж:

-Ижий минь! хэмээн эмгэнэн гашуудахад, амь өрссөн тулаанаас мэнд үлдсэн ойрадын таван зуугаад цэрэг хатнаа тэвэрсэн хаанаа тойрч, тэргүүн гудайлган зогсоцгоох амой.

Их ой хөвчөөсөө тасран энэ хэсэгхэн зурвас элсэн дээр ургасан шинэс модод хаврын адаг сарын сэрчигнэх салхинд үлмэдэгхэн шуугих нь, ойрадын эрэлхэг хатны хойноос эмгэнэлийн дуу аялах мэт...

“Галдан хаанд, эр нөхөртөө дамжуул. Эсэн тайшаас хойш алтан ургийн бус Ойрадын хэн ч бүх Монголыг захирах ёсгүй хэмээн чиний багаасаа сүслэн дээдэлж ирсэн Мандухай цэцэн хатан өчсөн юм гэнэ лээ. Галдан хаан хэрэв эрх мэдлийн төлөөх шуналаа барьж эс чадан халх руу санаархах юм бол үхлийн даллагаа авахуулна гэсэн үг.

Алдагдсан алт эрдэнэсийг эгүүлэн олж авч хэзээд болдог.Харин харьд алдсан газар шороо эгнэгт хүнийх болдог юм...” гэсэн эцгийнхээ гэрээсийг л эр нөхөртөө дамжуулж хэлээгүйдээ Ану хатан харамсах мэт алтлаг хүрэн гэзэг нь хаврын салхинд намиран хийснэ. Данжила жанжин далдхан сэтгэлтэй явсан бүсгүйнхээ тэргүүнд дуулгыг нь өмсгөөд, алтан шарилыг нь өргөн авч тэмээн тэргэн дээр тавилаа...

Цэл залуу насандаа хасагийн Янгир султаныг дарах тулаанд хамтдаа явхдаа “Эцсийн амьсгал татах цагт намайг таны өмнө нь оруулаарай хэмээн бурхан шүтээндээ залбирдгаа би танд

өчсөн шүү дээ” хэмээн Ану хэлээд зүдрэнгэ царайдаа жаргалтай инээмсэглэл тодруулж байсныг нь Галдан бошгит тэрхэн мөчид дурсан санасан агаад хатныхаа алтан шарилыг авч, түүнийхээ амь үл хайрлан сэт цохиж гаргасан замаар манжийн бүслэлт дундуур гарч Тамирын гол хүрэв.

\* \* \*

Тийнхүү эрэлхэг хатныхаа ачаар манжийн гараас зугтан гарч чадсан Галдан бошгит Ану хатнаа одоогийн Архангай аймгийн нутагт хөдөөлүүлээд Сэгс дүүрэн гэдэг газар очин суужээ. Аргын 1697 он, шаргачин хонин жил буюу Зуун модны тулалдаанаас жилийн дараа Галдан бошгитын хүү Сэвдэнбалжир Хамигаас цэрэг зэвсэг, хүнсний тусламж авахаар яваад Абдул дархан бэки хэмээгчид баригдан Бээжинд хүргэгдсэн ажээ. Энх-Амгалан хаан эхэндээ Сэвдэнбалжирыг Горой чиндай гүнгийн охинтой гэрлүүлж нутаг заан суулгаж байгаад хожим цаазалжээ.

Галдан бошгит хэнээс ч, хаанаас ч тусламж авч чадахгүй байсаар хүндээр өвчлөн, аргын 1697 оны хавар 54 сүүдэр дээрээ таалал төгсөхдөө “Миний нутгийн газар шорооноос бурхан гуйсан ч бүү өг” хэмээн гэрээсэлсэн ажгу.

Харин чин зоригт Данжила жанжин нь Галдан бошгитын чандрыг отгон охин Юмчихайн хамт Манжид өгөлгүй, ач Цэвээнравдан хаанд хүргүүлсэн амой.

2010 оны 4 дүгээр сарын 31.

Улаанбаатар, Зайсан